"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн үүсгэн байгуулагчид болох Б.Чулуунсүх, Д.Даваа нар нь 2013 оноос эхлэн хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд өөрсдийн мэдлэг туршлагаа ашиглан Монгол Улсад онлайн үйлчилгээний шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санаачлан нэвтрүүлэх зорилгоор төрөл бүрийн бизнес санаа, санаачилга дэвшүүлэн ажилласан ба 2013 оноос бараа бүтээгдэхүүн онлайнаар арилжаалах цэг болох 'www.avzara.mn' вэбсайтыг санаачилж, ажиллуулж эхэлсэн. 2014 онд Япон Улсаас онгоцоор ачаа тээвэрлэх үйлчилгээ бүхий 'www.tabi.mn' вэбсайтыг санаачлан нэвтрүүлж байсан ба Б.Чулуунсүхийн Япон Улсад ажиллаж байсан туршлага дээр үндэслэн 2015 оноос 2016 он хүртэл Японы хөрөнгө оруулагч компанитай хамтран бизнес эрхэлж байсан боловч хөрөнгө оруулагчийн үндсэн бизнес доголдсоны улмаас Монгол Улс дахь үйл ажиллагаа нь зогсолтод орсон түүхтэй.

Энэ үед буюу 2016 оны эхээр дэлхий даяар Финтек компаниуд цахиур хагалж байсан тул үүсгэн байгуулагчид нь тэдгээр бизнес болон Финтек үйлчилгээг судалж, өөрсдийн программ бичих мэдлэг, чадвараа ашиглан бага хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа эхлүүлэх боломжтой гэж үзэн Төлбөр тооцооны QR кодын бизнест хөл тавьсан. 2014 оноос Монголбанк бага дүнтэй төлбөрийн системийг 24/7 бодит цагийн горимд шилжүүлж, 2016 оноос банк хоорондын интернэт худалдаа "eCommerce" үйлчилгээ нэвтрүүлж, Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын хувьд өөрсдийн хөгжүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглаж, бүрэн нэвтрүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн юм. 2017 онд Монгол Улсын Их Хурал (УИХ) "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль"-ийг хэлэлцэн баталсан бөгөөд ингэснээр Монгол Улсад хууль эрх зүйн зохицуулалт болон техник технологийн боломжийн хувьд бэлэн бус төлбөр тооцооны зах зээл хурдацтай хөгжих үндэс суурь тавигдсан ба үүсгэн байгуулагчид нь зах зээлийн энэ боломжийг оновчтой ашиглан QPay үйлчилгээг эхлүүлсэн байна.

Үүсгэн байгуулагчид нь ийнхүү "ККТТ" ХХК-ийн үндсэн үйл ажиллагааг эхлүүлж, QPay үйлчилгээнийгарутсандсуурилсан демо программ боловсруулан хэд хэдэн нөлөө бүхий арилжааны банкнууд, төрийн үйлчилгээ, томоохон хувийн хэвшлийн байгууллагуудад санал болгож, хамтран ажиллах санамж бичиг үйлдэж чадсан юм. Тухайн жилийн 06 дугаар сард "Хаан Банк" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Жон Беллд QPay үйлчилгээг танилцуулах завшаан олдож, амжилттай танилцуулсны үндсэн дээр "ККТТ" ХХК болон "Хаан Банк" ХХК нь хамтран ажиллах гэрээ байгуулан, 2016 оны 07 дугаар сард үйлчилгээгээ нийтэд нэвтрүүлэх хэлэлцээрт хүрсэн. Ийнхүү 2017 оны 01 дүгээр сард "Хаан Банк" ХХК-д QPay үйлчилгээг нэвтрүүлээд зогсолгүй, "Скайтел" ХХК-ийн нэгж борлуулалт болон Замын хөдөлгөөний торгууль төлөх процессыг QPay үйлчилгээгээр шийдвэрлэн, олон нийтэд анх хүрч чадсан. Тухайн үед Б.Чулуунсүх, Д.Даваа нар нь Үнэт цаас гаргагчийн одоогийн Технологи хариуцсан захирал Д.Жанчив, Бизнес хөгжил хариуцсан захирал О.Хонгор нарыг багтаа элсүүлэн нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 CTC2420

СЗХ
2023 .11. 08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -07- 20
БҮРТГЭВ-03



Үүсгэн байгуулагчдын анхны санааг дэмжин Б.Дондовдорж, болон Япон Улсаас аяллаар ирээд танилцсан Окоши Масанори нар дөнгөж үүсэж байсан QPay үйлчилгээнд анхны хөрөнгө оруулалтыг хийсэн юм. Мөн тухайн үед "Могул" ХХК нь компанийн үйл ажиллагааг дэмжин 2 төрлөөр хөрөнгө оруулалт хийж анхны хөрөнгө оруулагчдын нэг болсон. "Могул" ХХК нь хөрөнгө оруулалтынхаа 40 орчим хувийг мөнгөн хөрөнгөөр оруулсан ба үлдсэн 60 орчим хувийг QPay үйлчилгээг өргөжүүлэхэд шаардлагатай байсан мэргэжлийн хүний нөөцийн баг аутсорсинг хийх хэлбэрээр оруулсан байдаг.

Үүнтэй мөр зэрэгцэн QPay үйлчилгээг "Худалдаа Хөгжлийн Банк" ХХК нь ТиДиБи Пэй (TDBPay), "Төрийн Банк" ХХК нь Гялс Пэй (GyalsPay) нэрээр зах зээлд таниулж, өдөр ирэх тусам цар хүрээ тэлж, нийтэд танигдаж эхэлсэн ба аажмаар QPay ашиглан төлбөр тооцоо хийх нь иргэдийн хувьд өдөр тутмын хэрэглээ болж хөгжсөн.




*Зураг 2. "Худалдаа Хөгжлийн Банк" ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч Б.Баярмаа, Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх QPay 2.0 буюу дотоодын карт, Олон улсын ЮнионПэй картын токенжуулах үйлчилгээг нэвтрүүлэх тухай санамж бичиг зурсан нь, 2020 он*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч:

Андеррайтер:

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
5021031195 СТС2420

СЗХ
2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03




*Зураг 3. "Богд банк" ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Саруул болон Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх нар Төлбөрийн картын токеноор төлбөр хүлээн авах болон гүйлгээ эхлүүлэх үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ үзэглэсэн нь, 2020 он.*




*Зураг 4. "Төрийн банк" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ө.Гантөр болон Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх нар Би-Пэй үйлчилгээ буюу нэгдсэн биллингийн үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулсан нь, 2021 он*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЗХ
2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-25
БҮРТГЭВ-03




*Зураг 5. "ZeroPay" (Korea easy payment foundation) Гүйцэтгэх захирал Чой Тонг Жү , Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх, ZeroPay болон QPay үйлчилгээ хамтран ажиллах санамж бичиг зурсан нь, 2023 он*

Үнэт цаас гаргагч нь олон улсын төлбөр тооцооны шийдлүүдтэй хамтран ажиллахаар зорьж, 2023 оны 03 дугаар сард БНСУ-ын QR бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд тэргүүлэгч ZeroPay-тэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

2017 онд QPay үйлчилгээгээр нийт 20.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 201.2 мянган ширхэг гүйлгээ хийгдэж байсан. Үнэт цаас гаргагч нь 2022 оны байдлаар гүйлгээний тоог 314.8 дахин өсгөж 63.3 сая ширхэгт хүргэсэн бол үнийн дүнг 132.2 дахин өсгөж 2.8 их наяд төгрөгт хүргэн амжилттай ажилласан байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЗХ 2023.11.08 сар өдөр БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-2 БҮРТГЭВ-03

## 4.2. "Инновэйшн Инвестмент" ХХК-ИЙН ТҮҮХ

Үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс 2017 оны эхээр Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид Япон Улсад зохион байгуулагдсан, IBM, Deloitte олон улсын компаниуд болон орон нутгийн 30 банк хамтарсан "Finnovation Challenge"-д оролцож, эхний шатанд нийт 108 баг оролцсоноос шилдэг 18 багт шалгарч байсан түүхтэй. Уг тэмцээн нь орон нутгийг хөгжүүлэх санхүүгийн оновчтой шийдлүүдийг шалгаруулах, гарааны бизнесүүдийг дэмжих үндсэн зорилгын хүрээнд финтек компаниудын хооронд зохион байгуулагддаг. Энэхүү тэмцээний үр дүнд Монгол Улсад өөрсдийн салбараа нээн ажиллуулж байсан Японы мэдээллийн технологи, хөгжүүлэлтийн компани болох "Юнимедиа Солюшнс" ХХК-ээс дараагийн шатны хөрөнгө оруулалтаа татах боломж үүссэн бөгөөд үүнийг тохиолдуулан "ККТТ" ХХК-ийн толгой компани болох "Инновэйшн Инвестмент" ХХК-ийг үүсгэн байгуулсан юм. Ийнхүү үйл ажиллагаа, удирдлага болон засаглалын зохистой бүтэц хөгжүүлэх үүднээс групп компанийн бүтцийг байгуулсан ба Үнэт цаас гаргагчийг ирээдүйд QPay шиг ижил төрлийн инновацлаг үйлчилгээнүүдэд хөрөнгө оруулах үүднээс байгуулжээ. 2023 оны 06 дугаар сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдах "ККТТ" ХХК, Мерчантуудад чиглэсэн үйлчилгээнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах "Дижитал Мерчант Сервисэс" ХХК гэх хоёр охин компанитай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь группийн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, одоогийн бэлэн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжил, тэлэлтийг удирдан ажиллаж байна.

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн хувьд дотоодын болон гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас амжилттай хөрөнгө оруулалт татсаны үр дүнд зөвхөн мөнгөөр хэмжих боломжгүй олон давуу талуудыг бий болгосон бөгөөд мэргэжлийн туршлага, зөвлөгөө, харилцаа холбоо, техникийн хувьд олон дэмжлэг туслалцаа хүлээн авсан. Мөн засаглалын хувьд нээлттэй байх зарчим, эрсдэлийн удирдлага зэрэг байгууллага урт хугацаанд тогтвортой, амжилттай ажиллахад шаардлагатай олон хүчин зүйлсийг нутагшуулсан. 2023 оны 06 дугаар сарын байдлаар "Инновэйшн Инвестмент" ХХК болон түүний охин компаниуд нь мэргэшсэн удирдлага болон мэргэжилтэн нийлсэн нийт 32 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183940

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 5031195 СТС2420

Андеррайтер

Үнэт цаасны танилцуулга
2023.11.08 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 4.3. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал




ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ КО ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023 оны 08 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03




*Схем 1. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

# 5. Үнэт цаас гаргагчийн тухай

## АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.

## ҮНЭТ ЗҮЙЛС

**PASSION** (Тэмүүлэл)

**TEAM WORK** (Багийн ажиллагаа)

**INTEGRITY** (Хариуцлага)

**SMART** (Ухаалаг)

**WELL-BALANCED** (Тэнцвэртэй байдал)

**STRONG PARTNERSHIP** (Хүчтэй түншлэл, харилцаа)

**DIGITAL EMPATHY** (Хэрэгцээг ойлгодог)

**SUSTAINABILITY** (Тогтвортой хөгжил)

## УРИА ҮГ

Дижитал шийдэлд хөрөнгө оруулагч





ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 6183855 9021031195 СТС2420

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 5.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн ууган хөрөнгө оруулалт нь QPay үйлчилгээ бөгөөд Үнэт цаас гаргагч нь дотоодын мэргэжлийн удирдлагын баг, инженерүүдийн ур чадвар болон гадаад хөрөнгө оруулалт ашиглан өнөөдөр Монгол Улсын төлбөрийн зах зээлд түүчээлэгч дэд бүтцийг бий болгосон билээ.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь технологи, цахим төлбөр тооцооны хөрөнгө оруулалтын компани бөгөөд төслийн онцлогоос хамааран зөвхөн санхүүжилт бус мэргэжлийн зөвлөгөө, удирдлага, инженерийн ажиллах хүчин, шийдэл зэрэг мэдээллийн технологийн салбарт амжилт гаргахад шаардлага бүхий хүмүүн капиталаар хөрөнгө оруулдаг онцлогтой юм. Уг хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхийн тул Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээнээс гадна мерчантуудад чиглэсэн үйлчилгээ зэрэг TechFin чиглэлд хамрагдах шинэ үйлчилгээнүүд нэвтрүүлэхээр ажиллаж мэдээллийн технологи, инженерчлэл, санхүү, удирдлагын мэргэжлийн багаа улам чадавхжуулж чадсан. Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хэрэгжүүлж буй төслүүддээ зохистой засаглал, удирдлагын систем нутагшуулах зорилгоор групп компанийн бүтэц бүрдүүлж, охин компаниудаараа дамжуулан зах зээлд бэлэн бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж ирсэн.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь цаашид хөрөнгө оруулалтын бодлогоо баримтлан доорх 3 чиглэлд нийцэх төсөл, үйлчилгээнүүдийг хөгжүүлэх, санхүүжүүлэх, удирдан чиглүүлэх замаар зах зээлд нэвтрүүлэн амжилтад хүргэхээр ажиллаж байна:

1. **Нийгмийн дэд бүтэц** –Нийгмийн дэд бүтэц – Нийгмийн дэд бүтэц буюу иргэдийн өдөр тутам ашигладаг бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хялбар, хүртээмжтэй болгож өөрчлөх бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж хүн бүрд мэдээллийн технологийн хөгжлөөс өгөөжийг тэгш хүртэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Энэ хүрээнд уламжлалт эдийн засгийг өөрчлөх, хялбар байдал болон хүртээмжийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлнэ. Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь эдийн засгийн салбарын оролцогчдыг түнш болгон тэдний асуудлыг шийдвэрлэх, хамтын тогтвортой, найдвартай, аюулгүй хөгжлийн гарц нээх технологийн дэд бүтэц хөгжүүлэхийг зорьдог. Нийгмийн дэд бүтцийн чиглэлд Финтек, Онлайн худалдаа, Хиймэл оюун ухаан, Интернэт үйлчилгээ, Жижиглэн худалдаа үйлчилгээ зэрэг эдийн засгийн салбарууд хамаарна.
2. **TechFin** - Үнэт цаас гаргагчийн ач холбогдол өгч буй чиглэл нь TechFin бөгөөд уг ойлголт нь 2019 оноос хойш Санхүү, мэдээллийн технологийн салбаруудад дэлгэрч байна. TechFin нь дэлхийн улс орнуудад үйл ажиллагаагаа эрхэлж буй банкнууд нийтэд хүртээмжтэй, техник технологийн давуу талыг бий болгохын тул маш их хэмжээний хөрөнгө оруулалт оруулж өөрсдийн үйлчилгээндээ ахиц дэвшлийг бий болгосон хэдий ч технологийн гарааны бизнесүүдээс болж хүний нөөц, шинэ санаа, инновацын хомсдолд орж байгаагаас үүдэлтэй салбар юм. TechFin салбарын үйлчилгээ нь технологийн давуу талыг ашиглаж банк, санхүүгийн байгууллагад шаардлагатай инновац, төлбөр тооцооны нэмэлт үйлчилгээ бүтээгдэхүүнүүдийг хүргэдэг давуу талтай. Харин FinTech үйлчилгээ нь санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшлийг ашиглан эцсийн болон дундын хэрэглэгчдэд хүргэдэг үйлчилгээ юм. Жишээ нь, цахим зээл, зуучлалын үйлчилгээ байна.
3. **Нийгмийн тогтвортой хөгжил** – Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн олон шийдэл аливаа үйлчилгээг цахимжуулж илүү хялбар, хямд, нээлттэй, мөн байгаль орчинд ээлтэй болгон өөрчилсөн. "Инновэйшн Инвестмент" ХХК нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхдээ нийгэмд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж байгаа эсэх, нийгмийн бүлгүүдийн оролцоог нэмэгдүүлж буй эсэх, ямар эерэг нөлөө үүсгэж байгаад нь онц ач холбогдол өгч ирсэн.

Үнэт цаас гаргагчийн ууган төслүүд болох QPay үйлчилгээ болон Мерчантуудад чиглэсэн үйлчилгээ нь дээрх гурван чиглэлд нийцэх буюу уламжлалт үйл ажиллагааг технологийн шийдэл ашиглан цахимжуулсан, төлбөрийн шийдлийг хялбарчилж олон нийтэд илүү хүртээмжтэй болгосон, хувийн болон төрийн байгууллагуудад оновчтой шийдэл болсон. Үүгээр Үнэт цаас гаргагч нь цаашид бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн хөгжлийг дараагийн түвшинд хүргэх, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зах зээлд санаачлан нэвтрүүлэх бүрэн чадамжтай гэдгээ харуулсан байна.

Үнэт цаас гаргагч | Андеррайтер

СЗХ 2023 .11. 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

| | |
|---|---|
| Үнэт цаас олон нийтэд санал болгох үеийн онцлох бүтээгдэхүүн | • QPay үйлчилгээ<br>• QPay wallet/ Цахим хэтэвч<br>• Wechat Pay олон улсын төлбөр тооцооны гарц<br>• ЮнионПэй олон улсын төлбөр тооцооны гарц<br>• AliPay олон улсын төлбөр тооцооны гарц<br>• Олон улсын Wallet Top-Up үйлчилгээ<br>• Биллинг систем |
| Үйл ажиллагаа эрхэлж буй салбар | • Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл<br>• Санхүүгийн мэдээллийн технологийн зах зээл |
| Бүтээгдэхүүний ангилал | • Бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ<br>- Төлбөр төлөгч эцсийн хэрэглэгчид зориулсан үйлчилгээ<br>- Банкнуудад зориулсан үйлчилгээ<br>- Хэрэглэгчийн систем нийлүүлэгчид зориулсан үйлчилгээ<br>- Цахим мөнгөний зөвшөөрөл бүхий ББСБ-уудад зориулсан үйлчилгээ<br>- Олон улсын төлбөрийн гарцуудад зориулсан үйлчилгээ<br>• Мерчант буюу үйлчилгээ үзүүлж төлбөр хүлээн авагч байгууллагад зориулсан үйлчилгээ |
| Технологийн шийдэл | • QR код ашиглах цахим төлбөр тооцоо<br>• Deeplink холболт болон түүнд суурилсан үйлчилгээний төрлүүд<br>• QPay санхүүгийн институт борлуулалт, удирдлагын систем - Банканд зориулсан борлуулалт удирдлагын систем<br>• Биллинг нэгдсэн систем<br>• QPay цахим хэтэвч аппликэйшн<br>• Олон улсын UnionPay төлбөрийн систем<br>• Олон улсын Wechat Pay төлбөрийн систем<br>• Олон улсын AliPay төлбөрийн систем<br>• QPay мерчант ухаалаг гар утасны аппликэйшн<br>• QPay мерчант веб систем |
| Qpay гүйлгээний тоо<br>(2022 он) | • Нийт 2.8 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 63.3 сая ширхэг гүйлгээ |
| Хэрэглэгчдийн тоо (2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар) | • Давхардсан тоогоор нийт 2.8 сая орчим Хэрэглэгч |

*Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны тухай мэдээлэл*



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183945

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

| | |
|---|---|
| Мөрдөж буй мэдээллийн аюулгүй байдлын стандартууд | • Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо – ISO 27001:2013<br>• Төлбөрийн картын аюулгүй байдлын стандарт – PCI-DSS 3.2.1<br>• Үндэсний төлбөрийн системийн тухай хууль<br>• Банкнуудын мэдээллийн аюулгүй байдлын вендор байгууллагуудтай харилцах систем |
| Үндсэн Харилцагчид | • Арилжааны банкнууд<br>• Бүх төрлийн жижиг, дунд болон томоохон бизнес эрхлэгч<br>• Банк бус санхүүгийн байгууллагууд<br>• Үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд<br>• Цахим худалдаа, үйлчилгээ<br>• Финтек үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд<br>• Монгол Улсын төрийн цахим үйлчилгээний системүүд |

*Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны тухай мэдээлэл /үргэлжлэл/*

# 6. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд

## 6.1. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын тухай

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн дагуу анх гурван гишүүнтэйгээр (Монгол Улсын иргэн Д.Даваа, Б.Чулуунсүх, Б.Дондовдорж) үүсгэн байгуулагдаж "Инновэйшн Инвестмент" ХХК нэрээр 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн.

Б.Чулуунсүх болон Д.Даваа нар нь Япон Улсын "Юнимедиа Солюшнс" ХХК-аас нэмэлт хөрөнгө оруулалт татахаар болсонтой холбоотойгоор 2018 оны 04 дүгээр сард "ККТТ" ХХК-ийн тухайн үеийн хувьцаа эзэмшигчдийг хувь тэнцүүлэн шилжүүлэх замаар "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн хувьцаа эзэмшигч болгосон. Ингэснээр "ККТТ" ХХК нь үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани болсон.

## 6.2. Үнэт цаас олон нийтэд санал болгохын өмнөх хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2017 оноос хойш Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэлд нийт хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед 16 хувьцаа эзэмшигч (Монгол Улсын хуулийн этгээд 5, Япон Улсын хуулийн этгээд 3, Монгол Улсын иргэн 5, Япон Улсын иргэн 3), гурван тэрбум есөн зуун хорин найман сая есөн зуун мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

| | |
|---|---|
| Нийт гаргасан хувьцаа | 157,156,000 ширхэг |
| Нийт зарласан хувьцаа | 192,166,000 ширхэг |
| Хувьцааны төрөл | Энгийн хувьцаа |
| Нэгжийн нэрлэсэн үнэ<br>(2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар) | 25 төгрөг |
| Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө<br>(2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар) | 3,928,900,000 төгрөг |

*Хүснэгт 5: Үнэт цаас гаргагчийн хувьцааны мэдээлэл, олон нийтэд хувьцаа санал болгохын өмнө*

| Хувьцаа эзэмшигч этгээд | Регистрийн дугаар, байхгүй тохиолдолд улсын бүртгэлийн дугаар | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|---|
| "Ай Си Ти Групп" ХК | 9008001002 | 34,159,320 | 21.74% |
| Дамдинсүрэн Даваа | 112516771142 | 9,108,747 | 5.80% |
| Чойжоохүү Нарангэрэл | 111017471001 | 16,597,400 | 10.56% |
| "Юнимедиа Солюшнс" ХХК | 9019083045 | 15,560,000 | 9.90% |
| "Айкор Партнерс" ХХК | 9011846670 | 14,028,800 | 8.93% |
| "Рентракс" ХК | 011701010603 | 10,373,400 | 6.60% |
| Батзориг Чулуунсүх | 131180261414 | 8,900,267 | 5.66% |
| Шаравхорол Эрдэнэбилэг | 110775261282 | 8,370,200 | 5.33% |

*Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц, олон нийтэд хувьцаа санал болгохын өмнө,*

СЗХ
2023.10.06
БҮРТГЭВ
№ 01



| Хувьцаа эзэмшигч этгээд | Регистрийн дугаар, байхгүй тохиолдолд улсын бүртгэлийн дугаар | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|---|
| "Могул" ХХК | 9011387141 | 7,482,200 | 4.76% |
| Масанори Окоши | MU7386903 | 3,945,000 | 2.51% |
| "НОБ" ХХК | 011503002409 | 2,593,400 | 1.65% |
| "Глобал Траст Нетворкс" ХК | 013301022734 | 2,593,400 | 1.65% |
| Шоичиро Ичитани | TK5839731 | 2,593,400 | 1.65% |
| Такахиро Ичики | TK8332495 | 2,593,400 | 1.65% |
| Мөнхчулуун Мөнхбаяр | 450112131312 | 1,141,066 | 0.72% |
| ККТТ ХХК | 9011244113 | 17,116,000 | 10.89% |

*Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц, олон нийтэд хувьцаа санал болгохын өмнө /үргэлжлэл/*

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК нь Үнэт цаас гаргагчийн 17,116,000 ширхэг хувьцааг эзэмшиж буй бөгөөд энэ хувьцаа нь Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-т заасны дагуу "Хараат болон охин компани нь толгой компанийн хувьцааг эзэмшиж болно" гэх, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т зааснаар "охин компанийн эзэмшиж байгаа толгой компанийн хувьцаа нь саналын эрхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг тооцохдоо охин компанийн эзэмшиж байгаа хувьцааг хасаж тооцно" гэж заасны дагуу саналын эрхгүй байна. "ККТТ" ХХК-ийн эзэмшсэн хувьцаа, хувьцаа эзэмшилтэй холбоотой мэдээлэлтэй Үнэт цаасны танилцуулгын 19.7 дугаар бүлэгт орсон "Үнэт цаас гаргагчийн опцион эрхийн хэлцэл" хэсгээс танилцана уу.

СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

## 6.3. Үнэт цаас гаргагчийн түүхэн санхүүжилтүүд

| Огноо | Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт | Хөрөнгө оруулагчид | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|
| 2017 он | | | 100,000 |
| 2018 он | + 900,000 | | 1,000,000 |
| | + 1,000,000,000 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 1,001,000,000 |
| 2019 он | + 500,000,000 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 1,501,000,000 |
| | + 1,000,000,000<br>+ 1,000,000,000 | "Рентракс" ХК<br>"НОБ" ХХК<br>"Глобал Траст Нетворкс" ХК<br>Шоичиро Ичитани<br>Такахиро Ичики | 3,501,000,000 |
| 2023 он | + 427,900,000 | "ККТТ" ХХК | 3,928,900,000 |

*Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн түүхэн санхүүжилт, төгрөгөөр 2017 - 2023*

"Инновэйшн Инвестмент" ХХК нь 2018 болон 2019 онуудад эхний шатны хөрөнгө оруулалт болох 1.5 тэрбум төгрөгийг Япон Улсын "Юнимедиа Солюшнс" ХХК-аас амжилттай татаж чадсан. Үүний үр дүнд үйл ажиллагаагаа өргөжүүлж, хүний нөөцөө нэмэгдүүлж, шинэлэг үйлчилгээнүүдийг хөгжүүлэн нэвтрүүлэх боломжтой болсноос гадна мэдээллийн аюулгүй байдал болон серверийн тогтвортой ажиллагааны стандартыг сайжруулсан байна.

2019 онд Үнэт цаас гаргагч болон QPay үйлчилгээг дараагийн түвшинд гаргах зорилгоор Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид, гүйцэтгэх удирдлагын баг нь өмнөх жил нь хөрөнгө оруулалт амжилттай татсан туршлага дээрээ үндэслэн мэргэжлийн түвшинд шинэ хөрөнгө оруулалт татах ажлыг эхлүүлсэн. Үүсгэн байгуулагч Б.Чулуунсүх, анхны хөрөнгө оруулагч болох "Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Сүэдэ зэрэг хувьцаа эзэмшигчдийн тусламжтайгаар Японы хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоож чадсан бөгөөд тус улсад очиж 7 хоногийн дотор 35 мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт компанийн болон QPay үйлчилгээг танилцуулан тэдний анхаарлыг татаж чадсан. Үнэт цаас гаргагчийн компанийн үнэлгээ, бизнес төлөвлөгөө, QPay үйлчилгээг амжилттайгаар богино хугацаанд зах зээлд нөлөө бүхий байр сууринд хүргэсэн удирдлагын багийн туршлага, дотоод зах зээлийн цаашдын хандлага болон хууль эрх зүйн орчин нь итгэл хүлээхүйц байсан тул 2 дугаар шатны хөрөнгө оруулалт болох 2 тэрбум төгрөгийг Япон Улсын хуулийн этгээд "Рентракс" ХК, "НОБ" ХХК, "Глобал Траст Нетворкс" ХК мөн иргэн Шоичиро Ичитани, Такахиро Ичики гэсэн 5 хөрөнгө оруулагчдаас амжилттай татан төвлөрүүлсэн. Үүний үр дүнд QPay үйлчилгээнд тулгуурласан, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлж, компанийн үйл ажиллагаа улам өргөжих үндэс суурийг тавьсан юм.

2023 онд одоогийн хувьцаа эзэмшигч болох "Юнимедиа Солюшнс" ХХК өөрийн эзэмшиж байсан 17,116,000 ширхэг энгийн хувьцааны опцион эрхээ Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК-д худалдсан ба "ККТТ" ХХК нь тус опцион эрхийг худалдан авсны дараа хэрэгжүүлж, Үнэт цаас гаргагчийн 17,116,000 ширхэг энгийн хувьцааг эзэмших болсон. "ККТТ" ХХК-ийн эзэмшсэн хувьцаа, хувьцаа эзэмшилтэй холбоотой мэдээлэлтэй Үнэт цаасны танилцуулгын 19.7 дугаар бүлэг дэх Үнэт цаас гаргагчийн опцион эрхийн хэлцэл хэсгээс танилцана уу.

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 6.4. Хувьцаа эзэмшигчдийн тухай

### 6.4.1 Монгол Улсын иргэд

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид Батзоригийн Чулуунсүх (5.66%), Дамдинсүрэнгийн Даваа (5.80%) болон Монгол Улсын иргэд Чойжоохүүгийн Нарангэрэл (10.56%), Шаравхоролын Эрдэнэбилэг (5.33%), болон Мөнхчулууны Мөнхбаяр (0.72%) байна.

### 6.4.2 Япон Улсын иргэд

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд Япон Улсын иргэд Масанори Окоши (2.51%), Шоичиро Ичитани (1.65%) болон Такахиро Ичики (1.65%) нар байна.

**"МОГУЛ" ХХК /4.76%/**

Харьяалал: **Монгол Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **5679397**

"Могул" ХХК нь компьютер, тоног төхөөрөмжийн угсралт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

Тус компанийн Гүйцэтгэх захирлаар У.Наранбаатар, ТУЗ-ийн даргаар Н.Баттулга нар тус тус ажиллаж байна.

**"АЙКОР ПАРТНЕРС" ХХК /8.93%/**

Харьяалал: **Монгол Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **6964133**

"Айкор Партнерс" ХХК нь хөрөнгө оруулалт, бизнес, менежментийн зөвлөгөө өгөх болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2022 оны 12 сарын 12-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Тус компанийн Гүйцэтгэх захирлаар Б.Анхболд ажиллаж байна.

**"ЮНИМЕДИА СОЛЮШНС" ХХК /9.90%/**

Харьяалал: **Монгол Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **6123155**

"Юнимедиа Солюшнс" ХХК нь Япон Улсын "Юнимедиа" ХХК-ийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар нэртэйгээр 2013 оны 06 дугаар сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр "Юнимедиа Солюшнс" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Япон Улс дахь үйл ажиллагаагаа түшиглэн, Монгол улсад мэдээллийн технологийн салбарт хамтарсан төслүүд хэрэгжүүлж байна. "Юнимедиа Солюшнс" ХХК нь мэдээллийн технологи болон компьютер холбоот үйлчилгээ, зар сурталчилгаа, компьютерын программчлал, худалдааны зуучлал, программ хөгжүүлэлт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

"Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Хосакава Масахико, ТУЗ-ийн Даргаар нь Суэдэ Макато нар ажиллаж байна. Япон Улсын "Юнимедиа" ХК нь тус компанийн хувьцааны 100 хувийг эзэмшдэг.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021131195 СТС2420

Үнэт цаасны танилцуулга
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

### "РЕНТРАКС" ХК /6.60%/

Харьяалал: **Япон Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **011701010603**

"Рентракс" ХХК нь 2005 оны 05 дугаар сард үүсгэн байгуулагдсанаас хойш цахим зөвлөх үйлчилгээ, аффилиэтэд маркетинг үйлчилгээ болон интернэтэд суурилсан медиа чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Компанийн Гүйцэтгэх захирлаар Дайсүкэ Ямазаки, ТУЗ-ийн даргаар Канеко Эйжи нар ажиллаж байна.

### "АЙ СИ ТИ ГРУПП" ХК /21.74%/

Харьяалал: **Монгол Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **5721261**

"Ай Си Ти Групп" ХК нь 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд мэдээллийн технологи, бизнесийн зөвлөх үйлчилгээ, гадаад худалдаа, мэдээлэл технологийн үйлчилгээ, менежментийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

"Ай Си Ти Групп" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Г.Хатанболд, ТУЗ-ийн даргаар Г.Лхамсүрэн нар тус тус ажиллаж байна.

### "ККТТ" ХХК /10.89%, САНАЛЫН ЭРХГҮЙ/

Харьяалал: **Монгол Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **5395305**

"ККТТ" ХХК нь "Инновэйшн Инвестмент" ХХК- ийн 100 хувийн өмчлөлийн охин компани бөгөөд толгой компанийн 10.89 хувийн хувьцааг эзэмшиж байна.

### "ГЛОБАЛ ТРАСТ НЕТВОРКС" ХК /1.65%/

Харьяалал: **Япон Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **013301022734**

2006 оны 07 дугаар сард үүсгэн байгуулагдсан "Глобал Траст Нетворкс" ХК нь Япон Улс дахь гадаадын иргэдэд зориулсан батлан даалтын үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйлчилгээ болон амьжиргаа дэмжих үйлчилгээ үзүүлдэг байна. Түүнчлэн гадаадын иргэдэд чиглэсэн бүтэн болон хагас цагийн ажлын байранд зуучлах хөдөлмөрийн агентлаг, мөн аялал зуучлалын агентлаг ажиллуулдаг. "Глобал Траст Нетворкс" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Гото Хироюки ажиллаж байна.

### "НОБ" ХК /1.65%/

Харьяалал: **Япон Улс**

Байгууллагын регистрийн дугаар: **011503002409**

"НОБ" ХХК нь хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Япон Улсын компани юм. Тус компанийн үүсгэн байгуулагч нь Япон Улсын иргэн Такахаши Нобүаки ба одоогоор "НОБ" ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
9021031195 СТС2420

2023 11 08
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

## 6.5. Үнэт цаас гаргагчийн охин компаниуд




*Схем 2: Үнэт цаас гаргагчийн хараат болон охин компаниуд*

Үнэт цаас гаргагч нь 2 охин компанитай бөгөөд эдгээр компанийн 100 хувийн хувьцааг эзэмшдэг.

### 6.5.1. “ККТТ” ХХК /100%/

Үнэт цаас гаргагчийн 100%-ийн эзэмшлийн охин компани болох “ККТТ” ХХК нь программ хангамж, мэдээ боловсруулах, техник хангамжийн үйл ажиллагааны чиглэлээр 2010 оны 07 дугаар сарын 28-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь банкны дэд бүтэц дээр суурилсан Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэгч байгууллагуудын анхдагчдын нэг, цахим төлбөр тооцооны хамгийн том тоглогч QPay үйлчилгээг 2017 оноос нэвтрүүлэн ажиллаж байна.
QPay үйлчилгээний deeplink нэхэмжлэх болон статик/динамик QR кодыг Хэрэглэгч дурын арилжааны банк болон ББСБ-ын финтек платформ ашиглан уншуулж гүйлгээ хийх боломжтой.

“ККТТ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх 4 дахь жилдээ ажиллаж байна.

### 6.5.2. “Дижитал Мерчант Сервисэс“ ХХК /100%/

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр үүсгэн байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд тус компани нь Мерчант байгууллагуудад чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна. Ингэхдээ Мерчант тус бүрийн шаардлага, нөхцөл байдалд нийцэх найдвартай, хялбар, хурдан шийдэл санал болгохыг эрхэмлэдэг. Харилцагчаа халамжлах үйлчилгээг тогтмол үзүүлж, оновчтой шийдвэр санал болгосноор Мерчантуудын бизнесийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.

Мөн Мерчант байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх хэрэглээний хялбар, аюулгүй байдлын судалгаанд суурилсан бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилготой байна.

Түүнчлэн, QPay Мерчант болон Харилцагчийн үйлчилгээний төв (Customer care center) болж Network Operation Center (NOC), System Operation Center (SOC)-ийн буюу систем болон сүлжээний асуудал хариуцсан 24/7 горимд ажиллах дуудлагын төвийн үйлчилгээг үзүүлж Мерчантууд болон харилцагч байгууллагуудын асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж байхаар ажиллаж байна. “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар С.Гуржав ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

# 7. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

## 7.1. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо

Монгол Улсын Компанийн тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн Компанийн дүрэмд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) нь компанийн эрх барих дээд байгууллага байна. ХЭХ болон хувьцаа эзэмшигчид нь хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийг эдэлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж ажиллана.

Компанийн ХЭХ-ын чөлөөт цагт хууль болон Компанийн дүрэм, "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д заасан эрх хэмжээний хүрээнд ТУЗ нь үйл ажиллагаа хэрэгжүүлж ажилладаг болно. ТУЗ нь өөрийн дэргэд 3 (гурав) хороодтой бөгөөд тэдгээр хороод нь ТУЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тус тусын тусгайлсан чиг үүргийн хүрээнд холбогдох санал дүгнэлтийг боловсруулан ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлдэг.

Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх удирдлага буюу компанийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгч ажилладаг тусгайлсан чиг үүрэг бүхий хэлтэс, албадууд ажилладаг болно. Үнэт цаас гаргагч нь энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар нийт 5 (тав) хэлтэс, 11 (арван нэг) албатайгаар үйл ажиллагаа явуулж байна.

## 7.2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт




*Схем 3: Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт*

# 8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 03/2020 тоот тогтоолоор ТУЗ нь 7 ердийн гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 23/08 тоот тогтоолын дагуу дараах байдлаар томилогдон ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Монгол Улсын болон Япон Улсын мэдээллийн технологи, банк, санхүүгийн салбаруудад 10 - 30 гаруй жил ажилласан инженер, бизнес удирдлагаар мэргэшсэн арвин туршлага бүхий гишүүдээс бүрддэг. ТУЗ-ийн гишүүд нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед мэргэжлийн дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд, Гүйцэтгэх удирдлагын зөвлөх болон Монгол Улсын нөлөө бүхий технологийн компаниудын гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа чадварлаг боловсон хүчин юм.

## ТУЗ-ИЙН ДАРГА Д.ДАВАА



Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын нэг Д.Даваа нь 2002 онд ШУТИС-ийн Компьютерын ухааны инженерийн бакалаврын зэрэг хамгаалсан бөгөөд мэдээллийн технологийн салбарт болон төрийн албанд 20 гаруй жил ажилласан түүхтэй.

Д.Даваа нь 2001 оноос 2008 он хүртэл Эрүүгийн цагдаагийн газарт төлөөлөгч, ахлах төлөөлөгч, 2008 оноос 2014 он хүртэл Цагдаагийн Ерөнхий Газарт тасгийн дарга, хэлтсийн дарга болон төвийн даргын албан тушаал хашсан. 2014 оноос 2016 он хүртэл "Дайэй Пробис Монгол" ХХК-д менежер албан тушаал хашсан.

Д.Даваа болон Б.Чулуунсүх нар нь 2016 оноос цахим төлбөр тооцооны QPay үйлчилгээг санаачлан "ККТТ" ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. 2017 онд Үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК-ийг хамтран үүсгэн байгуулж, 2020 оноос 2021 онуудад Үнэт цаас гаргагчийн Технологи хариуцсан захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирлаар ажилласан. 2021 оноос 2023 он хүртэл "Ай Си Ти Групп" ХК-ийн Технологи хариуцсан захирлын албан тушаал хашсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Д.Даваа нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дарга, Технологи хариуцсан зөвлөхөөр ажиллаж байна.



## ТУЗ-ИЙН ГИШҮҮН У.НАРАНБААТАР

Наранбаатар нь Монгол Улсын банк санхүү, мэдээллийн технологийн салбарт 20 гаруй жил удирдлагын түвшинд ажилласан туршлагатай. Тэрээр 1998 онд ШУТИС-ийн харьяа КТМС-ийг Мэдээллийн технологийн менежмент, Бизнесийн удирдлагын бакалавраар төгссөн. 2000 оноос хойш "Хасбанк" ХХК-ийн Мэдээлэл технологийн газрын захирлаар 7 жил, 2007 - 2009 онд Африк тивийн Кени Улсад "Крафт Силикон" ХХК-ийн Чанарын удирдлагын захирлаар 2 жил ажиллаж байсан. 2009 - 2017 онуудад "Ай Ти Зон" ХХК-ийн Дэд захирал, 2017 оноос хойш Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

У.Наранбаатар нь ТУЗ-ийн 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлын 02/06 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байсан 2023 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч      Андеррайтер



## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Б.ЧУЛУУНСҮХ

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын нэг Б.Чулуунсүх нь 2005 онд Япон Улсын Акаши хот дахь Акаши техникийн коллеж төгссөн. 2007 онд Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургуульд бакалавр, 2009 онд Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургуульд магистрын зэрэг хамгаалсан.

2009 - 2013 онуудад Б.Чулуунсүх нь Япон Улсын "ЭнТиТи Софтвэйр" компанид системийн инженерээр ажилласан ба 2013 онд Монгол Улсад буцаж ирэн "Дайэй Пробис Монгол" ХХК-д 2016 он хүртэл 3 жил менежерийн албан тушаал хашсан. Энэ хугацаанд Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид онлайн худалдаа, тээврийн чиглэлээр төслүүд хамтран хэрэгжүүлж 2016 оноос финтекийн салбарт хөл тавьж QPay төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2017 онд "Инновэйшн Инвестмент" ХХК-ийг үүсгэн байгуулж Б.Чулуунсүх нь 2018 - 2019 онуудад Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал, 2020 - 2021 онуудад Технологи хариуцсан захирал, 2021 - 2022 онуудад ахин Гүйцэтгэх захирлаар томилогдон ажилласан.

Б.Чулуунсүх нь 2022 оноос "Инновэйшн Инвтестмент" ХХК-ийн Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөхөөр ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН ХОСОКАВА МАСАХИКО

Хосакава Масахико нь 1990 онд Япон Улсын Саппоро хотын Хоккайдо Их Сургуульд инженерийн бакалаврын зэрэг хамгаалсан ба инженер, санхүүгийн чиглэлээр 30 жил, Монгол Улсад удирдлагын түвшинд 8 жил ажилласан түүхтэй. 1990 - 1999 онуудад Япон Улсын "Фужи Хэви Индастрис" ХХК-д агаарын хөлгийн материалын инженер, чанарын инженерээр ажиллаж 1999 - 2016 онуудад Япон Улсын "Ичитака" ХХК-ийн Монгол Улс дахь салбарт бизнес хөгжлийн менежер, Аудитын захирлаар томилогдон ажиллаж байсан.

Хосакава нь "Юнигаз" ХХК-д 2004 - 2006 онуудад Гүйцэтгэх захирал, 2010

- 2015 онуудад Гүйцэтгэх захирлын орлогч, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан.

Тэрээр 2016 оноос хойш Япон Улсын мэдээллийн технологи, сурталчилгааны групп компани "Юнимедиа" ХХК-ийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газарт Ерөнхий менежер, түүний охин компани болох "Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна



СЗХ 2023-11-08 өөр БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03



## ТУЗ-ИЙН ГИШҮҮН А.БАТТАМИР

ТУЗ-ийн гишүүн А.Баттамир нь 2003 онд ШУТИС-ийн харъяа КтМС-д Программ хангамжийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалж, 2019 онд ШУТИС-ийн харъяа ХоМТС-д Компьютерийн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

А.Баттамир нь 2002-2009 онуудад Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвд Программист, 2009-2011 онуудад Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх, 2011-2012 онуудад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх, 2011-2023 онуудад "АйТүүлс" ХК-д хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, 2013-2023 онуудуд "Ай Си Ти Групп" ХК-д хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Г. ЛХАМСҮРЭН

Г.Лхамсүрэн нь 2002 онд ШУТИС-д Хөнгөн үйлдвэрийн менежментийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2007-2009 онуудад "Лайфтайм Инвестмент" ХХК-д Дэд захирал, 2009-2010 онд "Хера Холдинг" ХХК-д Бизнес хөгжил, Маркетингийн албаны дарга, 2011-2018 онуудад "Стандарт Инвестмент" ХХК-д Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, 2011-2013 онуудад "Айтүүлс" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, 2013-2023 онуудад "Ай Си Ти Групп" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Г.Лхамсүрэн нь "Ай Си Ти Групп" ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Мөн Г.Лхамсүрэн нь 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ
2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Б.АНХБОЛД



Б.Анхболд нь 2004 онд Япон Улсын Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр, 2006 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан бөгөөд бизнесийн салбарт 15 гаруй жил ажилласан түүхтэй.

Тэрээр 2006 оноос 2012 оныг хүртэл Япон Улсын "Abeam Консалтинг" ХХК-д Менежментийн зөвлөх, 2012 оноос 2015 оныг хүртэл "Шунхлай Групп" ХХК-д Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан бөгөөд 2016 оноос хойш одоог хүртэл "Эс Ай Би Жэй Капитал" ГХОХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Б.Анхболд нь 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.АМАРЖАРГАЛ

Э.Амаржаргал нь 2005 онд Монгол Улсын Соёл Эрдэм Дээд Сургуулийг Олон улсын харилцааны сэтгүүлчийн мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2005 - 2006 онуудад "Жуулчин" ХК-д Япон зах зээлийн менежерээр, 2007 - 2013 онуудад "Бютик Монгол" ХХК-д 3D модел инженерээр ажилласан туршлагатай. 2013 оноос хойш "Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Захиргаа хүний нөөцийн менежерээр ажиллаж байна.

2020 онд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Андеррайтер

# 9. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагааны журам болон дэргэдэх хороод

Үнэт цаас гаргагч нь өөрийн засаглалын үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагааны журмыг зохицуулсан “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж байна. Тус журмын 2.1 дэх хэсэгт заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байх бөгөөд ТУЗ нь Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан энэхүү Үнэт цаасны танилцуулгын 9.1-т дурдсан бүрэн эрхийг эдэлнэ.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

## 9.1. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 11.7 дах хэсэг болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсэгт зааснаар ТУЗ нь Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх болон түүний бүрэн эрхийг тогтоох;
- Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- Бусад компанид хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;
- Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Компанийн тухай хуулийн 11-р бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх, 12-р бүлэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв бүтэц, орон тоо, хүний нөөцийн ерөнхий төлөвлөгөө болон үйл ажиллагааны үр дүнгийн хэмжих үзүүлэлтийг батлах;
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;
- Компанийн охин компани, хараат компани, салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Компанийн салбар компанийг үүсгэн байгуулах, татан буулгах, нэгдэх, хуваах зэрэг бүтэц өөрчлөх;
- Охин, хараат компаниуд дээр хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, нэмэлт өөрчлөлт оруулах, бизнес төлөвлөгөөг эцэслэн хянаж ХЭХ-д танилцуулах, төсвийг батлах, жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэх;
- Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Компанийн болон охин, хараат компанийн цалингийн сан, жилийн төлөвлөгөө батлах, өөрчлөх;

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

- Компанийн болон охин ба хараат компаниудын гүйцэтгэх захирал, дэд захирлыг томилох, чөлөөлөх, түүнтэй гэрээ, контракт байгуулах, цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Компанийн охин болон хараат компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн эрх мэдлийг хэрэгжүүлэх;
- Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлуудыг шийдвэрлэх;

Үнэт цаас болон хөрөнгийн удирдлагын хүрээнд ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгө болон хөрөнгийн эрхийн үнийг тогтоох;
- Ногдол ашиг хуваарилах эсэх санал боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захиралд олгох;

Компанийн үйл ажиллагааг зохион байгуулах, компанийн хэмжээнд явуулах хяналтын ажлын хүрээнд ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ТУЗ-ийн дэргэдэх хороод байгуулах, тэдгээрийн гишүүдийг томилох, тэдгээрийн эрх, чиг, үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах;
- ТУЗ болон түүний гишүүдийн ажлыг дүгнэх үзүүлэлт аргачлалыг тогтоох;
- Хөндлөнгийн аудиторыг сонгох, түүнтэй гэрээ байгуулах;
- Компанийн засаглал, бодлогыг тодорхойлж хэрэгжилтэд хяналт тавих;
- ТУЗ-ийн үйл ажиллагааг явуулахтай холбогдуулан Гүйцэтгэх захирал болон Үнэт цаас гаргагчийн охин, хараат компаниудаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

ТУЗ нь компанийн ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг хэрэгжүүлэх үүднээс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын үр ашигтай байдалд мониторинг хийх замаар хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах;
- Эрсдэлийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал, үндсэн үйл ажиллагааны өртөг зардалд мониторинг хийх тогтолцоог бүрдүүлэх;
- Компанийн хувьцаа эзэмшигч, удирдлага болон бусад оролцогч талуудын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд зуучлагчийн үүрэг гүйцэтгэн компанийн эрх ашиг болон сайн засаглалын зарчимд нийцүүлэн оновчтой зохицуулалт хийх;



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 5183855 9011031195 СТС2420

## 9.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 9.2 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна. Үүнд:

1. Аудит, эрсдэлийн хороо;
2. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо;
3. Стратеги ба хөгжлийн хороо;

Дээрх ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн гишүүд өөр өөрсдийн мэргэжил, ур чадварын онцлог байдлын хүрээнд орж ажилладаг бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангасан байна. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй хуулийн дүгнэлтээс танилцана уу.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаагаар тодорхойлогдох бөгөөд хороо тус бүр нь компанийн дотоод дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу шийдвэр гаргах, санал дүгнэлт боловсруулж ТУЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилладаг.




*Схем 4: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод болон гишүүдийн тухай мэдээлэл зохион байгуулалт*

Үнэт цаас гаргагч нь МХБ болон СЗХ-нд үнэт цаасаа бүртгүүлж, танилцуулгад заасан хэмжээгээр хөрөнгө татан төвлөрүүлж нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд ТУЗ-ийн анхны хурлаар хэлэлцүүлж батлуулахаар “Инновэйшн Инвестмент” Хувьцаат компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төсөл”-ийг боловсруулсан. Уг журамд ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дор дурдсан бүрэн эрхийг эдэлж, үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

2023 сар 08 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

### 9.2.1 АУДИТ, ЭРСДЭЛИЙН ХОРОО

Аудит, эрсдэлийн хороо нь бүтээгдэхүүнд учирч болохуйц эрсдэл болон дотоод серверийн найдвартай ажиллагаа, санхүүгийн хувьд учирч болохуйц эрсдэл, мөн аудитын дүгнэлтийг үйл ажиллагаатай зохицуулан ажиллах талаас чиглэх өгөх үндсэн зорилготой.

Аудит, эрсдэлийн хороо нь 3 (гурав) гишүүнтэй байх бөгөөд хорооны дарга болон гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна. Аудит, эрсдэлийн хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бүртгэл нь олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох талаар гүйцэтгэх захирлын саналыг хянах, санал дүгнэлт гаргах;
- Хөндлөнгийн аудитын байгууллагатай харилцах бодлогыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах, түүнийг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох, уг байгууллагаас хийх шалгалтын болон гаргах дүгнэлтийн чиглэлийг тогтоох талаар санал боловсруулах;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;
- Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
- ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.

Түүнчлэн Аудит, эрсдэлийн хороо нь компани хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа, хууль, журам болон "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий байгууллагад хэрхэн хүргэж байгаа байдалд хяналт тавих үүргийг хэрэгжүүлдэг. Мөн компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаагүй байна гэж үзвэл хариуцсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа ТУЗ-д дэвшүүлэн хэлэлцүүлдэг.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
2023 11 08
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 07 20
БҮРТГЭВ-03

### 9.2.2. ЦАЛИН УРАМШУУЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭЛТИЙН ХОРОО

Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлох, хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн цалин урамшууллын бодлогыг тодорхойлж, шийдвэр гаргах үндсэн чиг үүрэгтэй байна.

- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо нь 3 (гурав)-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна.
- ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна. Үүнд:
  - Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, тэдний ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
  - ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагад үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан болон нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшүүлэхээс татгалзах, тийнхүү татгалзсан бол нэр дэвшигч болон нэр дэвшүүлэхээр санал болгосон этгээдэд мэдэгдэх;
  - ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;
  - ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зарчмыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх;
  - Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг, түүний дотор цалин, шагнал урамшууллыг тогтоох;
  - Компанийн ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээтэй танилцаж, дүгнэлт гаргах;
  - Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тогтмол судалгаа хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
  - ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
  - Компанид мөрдөж буй ажлын үр дүнтэй холбосон аливаа урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
  - Ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх;
  - ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.

### 9.2.3. СТРАТЕГИ БА ХӨГЖЛИЙН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Стратеги ба хөгжлийн хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд өөрийн харьяалах асуудлын хүрээнд ТУЗ-д санал, дүгнэлт боловсруулан танилцуулна. Үүнд:

- Компанийн үндсэн стратегид зөвлөмж өгөх, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;
- Компанийн бүтээгдэхүүн хөгжлийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- Компанийн судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг, сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;
- ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

Үнэт цаасны танилцуулга
2023 11 08
он сар өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 07 20
БҮРТГЭВ-03

# 10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТАНИЛЦУУЛГА



### Г. ЭРДЭНЭМӨНХ
### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

## БОЛОВСРОЛ

**2016**
Австрали Улсын Сиднэй хотын Macquarie Их Сургууль - Олон улсын харилцаа, Магистр;

**2016**
Австрали Улсын Сиднэй хотын Macquarie Их Сургууль - Олон улсын бизнес менежмент, Магистр;

**2013**
Австрали Улсын Сиднэй хотын Charles Sturt Их Сургууль - Бизнесийн удирдлага, Бакалавр;

## АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
“Инновэйшн Инвестмент“ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2019-оноос**
“ККТТ“ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2019**
“ККТТ“ ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал

**2017-2019**
“Моником Экспресс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2015-2017**
Австрали Улсын Сиднэй хотын Маквайри (Macquirie) Их Сургуульд Судлаач

**2015-2016**
Reed Exhibitions – Эвент төлөвлөлт, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн

**2014**
Швейцар Улсын Хөгжүүлэлтийн Агентлагийн Бизнесийн шинжээч

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Андеррайтер

СЭХ 2023 -11- 08 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 20 БҮРТГЭВ-03



## Б.ЭНХБОЛД
## САНХҮҮ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2010**
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль - Санхүүгийн менежмент, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2021 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал

**2020-2021**
"Худалдаа Хөгжлийн Банк" ХХК
Ахлах дилер

**2014-2020**
"Худалдаа Хөгжлийн Банк" ХХК
Ахлах шинжээч

**2010-2014**
"Худалдаа Хөгжлийн Банк" ХХК
Шинжээч

## Я.ОЮУНХАНД
## ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

### БОЛОВСРОЛ

**2014 он**
Мандах Бүртгэл Дээд Сургууль – Нягтлан бодогч

**2006**
Удирдлагын Академи – Бизнесийн удирдлага, Магистр

**2003**
Олон Улс Судлалын Дээд Сургууль – Гадаад харилцаа, Бакалавр;

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2019 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

**2013-2019**
"Мибостар" ХХК-ийн Нягтлан бодогч

**2007-2013**
Техник, Технологийн Дээд Сургуулийн Ерөнхий нягтлан бодогч, хүний нөөцийн менежер, тооцооны нягтлан бодогч



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420



## Д.ХҮРЭЛТОГОО
## ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2005**
ШУТИС – Эдийн засгийн математик загварчлал, Бакалавр

**2008**
International Institute for Learning - Төслийн удирдлага, Магистр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
2022 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал

**2015-2022**
"Голомт Банк" ХХК-ийн Төслийн удирдлагын хэлтсийн ахлах

**2012-2015**
"Оюутолгой" ХХК-ийн Төслийн менежер

**2008-2012**
"Интерактив" ХХК-ийн Төсөл хариуцсан захирал

**2005-2008**
"Ньюком Системс" ХХК-ийн Төслийн менежер

## Ц. ГОМБОДОРЖ
## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



### БОЛОВСРОЛ

**2006 он**
МУБИС-ийн харьяа Компьютер мэдээллийн технологийн сургууль – Багш, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал

**2019-оноос**
Мэдээллийн аюулгүй байдлын ахлах инженер, МАБ

**2016-2019**
Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газрын Ахлах ажилтан

**2009-2016**
ЦЕГ – системийн ахлах инженер

**2007-2009**
"Инфокон" ХХК-ийг Техникийн орчуулагч

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-08-09 БҮРТГЭВ-03



## Д. ЖАНЧИВ
## ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2013 он**
ШУТИС-ийн харъяа КТМС – Программ хангамжийн инженер, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан захирал

**2017-оноос**
"ККТТ" ХХК-ийн Ахлах программ хөгжүүлэгч, Технологи хариуцсан захирал

**2013-2017**
"Интерактив" ХХК-ийн Ахлах программ хөгжүүлэгч

## О. ХОНГОР
## БИЗНЕС ХӨГЖИЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2008 он**
БНХАУ-ын Бээжин хот дахь Яни ЖиЯао Технологийн Дээд Сургууль – Хятад хэл судлал

**2007 он**
ОХУ-ын Байкальский государственный университет экономи и права – Орос хэл судлал

**2006 он**
Монгол Олон Улсын Дээд Сургууль (MIU) – Бизнесийн удирдлага, Бакалавр



### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал

**2017-2022**
"ККТТ" ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер, Бизнес хөгжил хариуцсан захирал

**2014-2017**
"Нэгдүн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2012-2014**
"Страйп Пэймэнт" ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО ХХК

СЗХ 2023 . 11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 20 БҮРТГЭВ-03



## С. ГҮРЖАВ

## “ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2002 он**
Отгонтэнгэр Их Сургууль – Эдийн засагч, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2019 оноос**
“Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2018-2019**
“ККТТ” ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер

**2003-2018**
Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсийн Байцаагч, Тасгийн дарга

**2001-2003**
“Ти Эл Зэт” ХХК-ийн Менежер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 10.1. Үнэт цаас гаргагчийн мэргэжлийн зөвлөхүүд



### ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ Д.ДАВАА

**БОЛОВСРОЛ**

- **2002 он**
  2002 – ШУТИС – Компьютерын ухааны инженер, Бакалавр

**АЖЛЫН ТУРШЛАГА**

- **2021 оноос**
  "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан зөвлөх
- **2021-2023 он**
  "Ай Си Ти Групп" ХК-ийн Технологи хариуцсан захирал
- **2019-2021 он**
  "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирал
- **2014-2016 он**
  "Дайэй Пробис Монгол" ХХК-д Менежер
- **2008-2014 он**
  Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын Тасгийн дарга, Хэлтсийн дарга, Төвийн дарга
- **2001-2008 он**
  Монгол Улсын Эрүүгийн Цагдаагийн Газар – Төлөөлөгч, Ахлах төлөөлөгч

### ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ Б. ЧУЛУУНСҮХ



**БОЛОВСРОЛ**

- **2009 он**
  Япон Улсын Цахилгаан холбооны их сургууль – Мэдээлэл холбоо, Магистр
- **2007 он**
  Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургууль – Мэдээлэл холбоо, Бакалавр
- **2005 он**
  Япон Улсын Акаши хот дахь Акаши техникийн коллеж

**АЖЛЫН ТУРШЛАГА**

- **2022 оноос**
  "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөх
- **2018-2019; 2021-2022 он**
  "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- **2020-2021 он**
  Инновэйшн Инвестмент ХХК-ийн Технологи хариуцсан захирал
- **2013-2016 он**
  Дайэй Пробис Монгол ХХК-ийн Менежер;
- **2009-2013 он**
  Япон Улсад "ЭнТиТи Софтвэйр" ХХК-ийн Систем инженер.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 СТС2420

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ



### МАСАНОРИ ОКОШИ

Япон Улсын иргэн Масанори Окоши нь 1987 оноос хойш андеррайтер, хөрөнгө оруулалт, санхүү, борлуулалт, менежмент чиглэлээр 30 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээг 2016 онд хөгжүүлж эхлэхээс эхлэн санхүү, удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үүрэг гүйцэтгэж ирсэн. Түүний амжилтуудаас дурдвал, "Вако" (Мизухо) ҮЦК-д андеррайтераар ажиллах хугацаанд гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийх, бойжуулах төслүүдийг удирдан ажилласан. Үүний дараа, 1998 онд өнөөдөр Viber аппликэйшнээр олон нийтэд танигдсан "Ракутен" ХК-ийн IPO-г хариуцан ажиллаж эхэлсэн ба 2000 онд амжилттай гүйцэтгэж 49.5 тэрбум иений хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. Түүнчлэн, "Ракутен" ХК-ийн Борлуулалтын газрыг үүсгэн байгуулж хариуцсан захирлаар нь ажиллаж, Захирлын алба болон Аудитын албаны даргын үүрэг гүйцэтгэх хугацаандаа бизнесийн хамтын ажиллагаа, M&A үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан туршлагатай.

Масанори Окоши нь "Ракутен" ХК-ээс 2007 онд гарж, тухайн жилдээ нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийн бизнесийг үүсгэн байгуулсан ба 2020 онд бизнесээ амжилттай үнэлэн зарсан.

2007 онд "Эксперт Аллайнс Даатгалын Бэлтгэл" ХХК (Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй)-д зөвлөх болон хувийн хөрөнгө оруулалт хийсэн. 2008 онд "Ракутэн" ХК-д Амь насны даатгалын бизнесийг санал болгож, Эксперт Аллайнс Даатгалын бизнес (Аирио Амь насны даатгал)-ийг 100% амжилттай худалдсан ба түүний дараа тус компани нь "Ракутэн Лайф Иншюранс" ХХК болж нэрээ өөрчилсөн.

### БОЛОВСРОЛ

**1987 он**
**Япон Улсын Чиёода хотын Нихон Их Сургууль**

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2021 оноос**
**Япон Улсын "Конверш Технологи" ХХК-ийн Хараат бус ТУЗ-ийн гишүүн бөгөөд Менежментийн зөвлөгөө өгч ажилладаг**

**2020 оноос**
**Япон Улсын "ИСи Сервис" ХХК-д Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Борлуулалт, харилцагч хариуцсан захирал**

**2016 оноос**
**"ККТТ" ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан зөвлөх**

**2010 оноос**
**Япон Улсын "Сатера" ХХК-ийн Хараат бус ТУЗ-ийн гишүүн, зөвлөх**

**2007-2020 он**
**Япон Улсын "Фүл Корпораци" ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал**

**1998-2007 он**
**Япон Улсын "Ракутэн" ХК (хуучин "ЭмДиЭм" ХХК байсан)-ийн Борлуулалт хариуцсан захирал, Захирлын албаны дарга, Аудитын албаны дарга**

Үнэт цаас гаргагч Андеррайтер

## 10.2. Эрх бүхий албан тушаалтнуудын эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн хувьцааны талаарх мэдээлэл

| № | Овог нэр | Албан тушаал | Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | Д. Даваа | ТУЗ-ийн дарга, Хамтран үүсгэн байгуулагч, Технологи хариуцсан зөвлөх | 9,108,747 |
| 2 | Б. Чулуунсүх | ТУЗ-ийн гишүүн, Хамтран үүсгэн байгуулагч, Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөх | 8,900,267 |
| 3 | Х. Масахико | ТУЗ-ийн гишүүн | - |
| 4 | У. Наранбаатар | ТУЗ-ийн гишүүн | - |
| 5 | Б. Анхболд | ТУЗ-ийн гишүүн | - |
| 6 | А. Баттамир | ТУЗ-ийн гишүүн | - |
| 7 | Г. Лхамсүрэн | ТУЗ-ийн гишүүн | - |
| 8 | Э. Амаржаргал | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | - |
| 9 | Г. Эрдэнэмөнх | Гүйцэтгэх захирал, "ККТТ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал | - |
| 10 | Б. Энхболд | Санхүү эрхэлсэн захирал | - |
| 11 | Я. Оюунханд | Ерөнхий нягтлан бодогч | - |
| 12 | Д. Хүрэлтогоо | Үйл ажиллагаа хариуцсан захирал | - |
| 13 | Ц. Гомбодорж | Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал | - |
| 14 | Д. Жанчив | Технологи хариуцсан захирал | - |
| 15 | О. Хонгор | Бизнес хөгжил хариуцсан захирал | - |
| 16 | С. Гүржав | "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал | - |

*Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаасны танилцуулга
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

# 11. Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд Компанийн дүрэмд заасны дагуу дор дурдсан үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

## 11.1. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

- Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж, ХЭХ-аар хэлэлцүүлж батлуулан, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, албан тушаалтантай харилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах;
- Шүүх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, бусад аливаа этгээдийн өмнө компанийг төлөөлөх;
- Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;
- Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, биелэлтийг хангах;
- Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бараа материал, ажил үйлчилгээг худалдан авах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах;
- Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зөвшөөрөл, гэрчилгээ зэргийг хууль тогтоомжийн дагуу авах ажлыг зохион байгуулах;
- Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулж ТУЗ-ийн хуралд танилцуулах;
- Монгол Улсын хууль тогтоомж болон ХЭХ-ын шийдвэрийн биелэлтийг хариуцан зохион байгуулах;
- Компани, түүний бүтэц, зохион байгуулалт, цалингийн сангийн хэмжээний талаар санал боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдыг авч ажиллуулах;
- Компанийн хөрөнгө устгах, үрэгдэх, алдагдал, дутагдалд орох зэргээр аливаа хөрөнгийн эрсдэлээс боломжит бүх арга хэрэгслийг ашиглан сэргийлэх;
- Хувьцаа эзэмшигчдийг компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах;
- Компанид бий болсон үйл ажиллагааны болон санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал, эрсдэл, зөрчлийг хувьцаа эзэмшигчдэд нэн даруй хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан бусад эрх, үүргүүд.

## 11.2. Гүйцэтгэх захирлын дэргэдэх удирдах албан тушаалтнууд

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус тусын харьяалах асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий дор дурдсан удирдах түвшний албан тушаалтнууд ажилладаг. Тус албан тушаалтнууд нь өөрийн харьяалах хэлтсүүдийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж ажилладаг.

- Үйл ажиллагаа хариуцсан захирал
- Санхүү эрхэлсэн захирал
- Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал
- Бизнес хөгжил хариуцсан захирал
- Технологи хариуцсан захирал

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9011031195 СТС2420

## 11.3. Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороод

Гүйцэтгэх захирал нь өөрийн дэргэд тухайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх хороодтой байх бөгөөд тус хороод нь Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт бичигт заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Гүйцэтгэх захирлын өмнө үйл ажиллагааны тайлангаа танилцуулж, хариуцлага хүлээдэг бүтцүүд болно. Хороодын гишүүдийг Гүйцэтгэх захирлын тушаалаар 2 (хоёр) жилийн хугацаатай сонгож томилдог байна. Танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар дор дурдсан хороод үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

### 11.3.1. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХОРОО

Судалгаа хөгжүүлэлтийн хороо нь компанийн алсын хараа, эрхэм зорилго, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний хүрээнд компанид хэрэгжүүлж болох бизнесийн үйл ажиллагааны чиглэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, компаниас санал болгох бүтээгдэхүүнүүдийн үндсэн концепцуудыг тодорхойлох бөгөөд шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн бизнесийн үндэслэгээ болон суурь судалгааг холбогдох мэргэжилтнүүдээр хийлгэх, хяналт тавих, хамтран ажиллах, төслүүдийг үнэлэх болон хэрэгжүүлэх эсэх шийдвэрийг гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### 11.3.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

Үнэлгээний хороо нь компанийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмын хүрээнд ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээг жилийн эцэст хянах, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлэх, урамшууллалтай холбогдсон аливаа харилцаанд маргаан таслах чиг үүргийг хүлээнэ.

### 11.3.3. ЭРСДЭЛИЙН ХОРОО

Эрсдэлийн хороо нь компанийн бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа, салбарын онцлог байдлын хүрээнд нийт компанийн үйл ажиллагаа болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, үүсэж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, түүнийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах бодлого тодорхойлох, арга хэмжээ авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилладаг болно.

## 11.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХЭЛТЭС, АЛБАД

"Инновэйшн Инвестмент" ХХК нь үндсэн 5 хэлтсээс бүрдэх бөгөөд хэлтэс бүр өөрийн үйл ажиллагааны чиг үүргийн дагуу 11 албад хуваагдана.

| № | Хэлтэс | Удирдлага | Алба |
|---|---|---|---|
| 1 | **Санхүү удирдлагын хэлтэс** | Санхүү эрхэлсэн захирал,<br>Ерөнхий нягтлан бодогч | Санхүү бүртгэл, тайлагналын алба |
| | | | Санхүүгийн шинжилгээ, хөрөнгө оруулалтын алба |
| 2 | **Бизнес хөгжлийн хэлтэс** | Бизнес хөгжил хариуцсан захирал | Бизнес хөгжил, судалгаа шинжилгээний алба |
| | | | Маркетинг, борлуулалтын алба |
| 3 | **Үйл ажиллагааны хэлтэс** | Үйл ажиллагаа хариуцсан захирал | Харилцагчийн үйлчилгээний алба |
| | | | Төслийн удирдлагын албан |
| | | | Захиргаа хүний нөөцийн алба |
| 4 | **Дэд бүтэц мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс** | Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал | Системийн дэд бүтцийн алба |
| | | | Мэдээллийн аюулгүй байдлын алба |
| 5 | **Программ хангамж хөгжүүлэлтийн хэлтэс** | Технологи хариуцсан захирал | Системийн шинжилгээ чанарын алба |
| | | | Программ хангамж хөгжүүлэлтийн алба |

*Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн үндсэн таван хэлтэс, хэлтсүүдийн удирдлага, албад тухай мэдээлэл*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023 -11- 0 ...
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

## 11.4.1 Санхүүгийн удирдлагын хэлтэс

Санхүү удирдлагын хэлтэс нь компанийн санхүүгийн удирдлага, бүртгэл тайлагнал болон мөнгөн урсгалыг хянах хүрээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг ба дараах орон тооны бүтэцтэй байна.

| № | Алба нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | **Санхүү удирдлагын хэлтэс** | Санхүү эрхэлсэн захирал | 1 |
| 2 | **Санхүү бүртгэл тайлагналын алба** | Ерөнхий нягтлан бодогч | 1 |
| 3 | | Нягтлан бодогч | 1 |
| 4 | **Санхүүгийн шинжилгээ, хөрөнгө оруулалтын алба** | Тооцооны нягтлан бодогч | 1 |
| 5 | | Санхүүгийн шинжээч | 1 |

*Хүснэгт 10: Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн удирдлагын хэлтсийн тухай мэдээлэл*

**Хэлтсийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлох, түүнд нийцүүлж санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Санхүүгийн гүйлгээнүүд буюу орлого, зардлын бүртгэл хийх, хяналт тавих;
- Банк, мерчантуудтай хийх тооцоог бэлтгэх, хянах;
- Үндсэн хөрөнгө, хангамжийн зүйлсийн ашиглалт, зарцуулалт, хяналт;
- Мөнгөн хөрөнгийн урсгалыг удирдах, хянах;
- Санхүүгийн тайлан, холбогдох тодруулга мэдээллүүдийг боловсруулж, тайлагнах;
- Татварын тайлан, бүртгэл, тооцоонуудыг бэлтгэж, тайлагнах;
- Компанийн богино, дунд, урт хугацааны бизнес төлөвлөгөө, төсөв түүний хяналт;

## 11.4.2 БИЗНЕС ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

Үнэт цаас гаргагчийн бизнес хөгжлийн хэлтэс нь компанийн болон группийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түншлэл, хамтын ажиллагаа, борлуулалт ба маркетинг, судалгаа шинжилгээ болон шинэ төсөл хөгжүүлэлт ба хайгуулын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.

| № | Алба нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | **Бизнес хөгжлийн хэлтэс** | Бизнес хөгжил хариуцсан захирал | 1 |
| 1.1 | **Бизнес хөгжлийн алба** | Бизнес хөгжлийн менежер | 1 |
| | | Дизайнер | 1 |
| 1.2 | **Борлуулалтын алба** | Маркетинг борлуулалтын менежер | 1 |
| | | Борлуулалтын ажилтан | 2 |

*Хүснэгт 11: Үнэт цаас гаргагчийн Бизнес хөгжлийн хэлтсийн тухай мэдээлэл*



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ
... ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2023 .. сар .. өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

**Хэлтсийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

- Одоогийн болон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний функционалиудыг тодорхойлох, хөгжүүлэх;
- Борлуулалтыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг сайжруулах тал дээр харилцагч байгууллагуудтай ажиллах;
- Зах зээлийн болон орчны судалгаа шинжилгээг хийж бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ашиглах;
- Бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд сурталчлах, компанийн имижийг бүрдүүлэх ажиллагааг хариуцах;
- Шинэ бизнес шинэ бүтээгдэхүүн шинэ технологийг нэвтрүүлэх шинэ төслүүдийг олон улсын төслийн удирдлагын процессын дагуу хэрэгжүүлэх;

### 11.4.3 Үйл ажиллагааны хэлтэс

Үйл ажиллагааны хэлтэс нь компанийн бүтэц зохион байгуулалт дагуу удирдлага хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай бичиг баримт болон журмуудыг боловсруулж, группийн хэмжээнд хүний нөөцийн бодлого хэрэгжүүлдэг. Түүнчлэн, Үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Хүрэлтогоо нь олон улсын Төслийн удирдлагын Project Management Professional (PMP) зэрэглэлтэй бөгөөд группийн үйл ажиллагаанд төслийн удирдлагын олон улсын стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

| № | Алба нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | **Үйл ажиллагааны хэлтэс** | Үйл ажиллагаа хариуцсан захирал | 1 |
| 1.1 | **Харилцагчийн үйлчилгээний алба** | Харилцагчийн үйлчилгээний менежер | 1 |
| | | Харилцагчийн үйлчилгээний ажилтан | 1 |
| 1.2 | **Захиргаа, хүний нөөцийн алба** | Хүний нөөцийн менежер | 1 |
| | | Бичиг хэрэг, нууцын ажилтан | 1 |
| | | Ресепшн, оффисын ажилтан | 1 |
| 1.3 | **Төслийн удирдлагын алба** | Төслийн менежер | 1 |
| | | Төслийн ажилтан | 1 |

*Хүснэгт 12: Үнэт цаас гаргагчийн Үйл ажиллагааны хэлтсийн тухай мэдээлэл*

**Хэлтсийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

- Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг захирлуудтай хамтран тодорхойлж, тодорхойлогдсон зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;
- Хүний нөөцийн бүрдүүлэлт болон хөгжүүлэлт, дотоод зохион байгуулалтыг төлөвлөлтийн дагуу гүйцэтгэх;
- Үйл ажиллагааны процедурыг хариуцсан захирлуудтай нь хамтран тодорхойлж, хэрэгжилтэд туслалцаа үзүүлэх;
- Дотоод үйл ажиллагаанд шаардлагатай журам заавруудыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төслийн удирдлагын арга хэрэгсэл процессыг нэвтрүүлэх;
- Дотоод үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, сайжруулалтын процессыг гүйцэтгэх;



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9011031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -07- 20
БҮРТГЭВ-03
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ

### 11.4.4. Дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс

Дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс нь Үнэт цаас гаргагчийн сервер, дэд бүтэц, төлбөр тооцооны системийн аюулгүй байдал ба тасралтгүй үйл ажиллагааг хангах үүрэгтэй бөгөөд Үнэт цаас гаргагчийн нэвтрүүлсэн мэдээллийн аюулгүй байдлын стандартуудын хэрэгжилтийн хангаж ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй төлбөр тооцооны зах зээл нь өндөр зохицуулалттай салбар тул тусгай зөвшөөрлийн шаардлагыг биелүүлж ажилтнуудаа аюулгүй байдал, нууцлалыг мэргэжлийн түвшинд дээдлэн баримтлуулж удирдан ажилладаг.

| № | Алба нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | **Дэд бүтэц мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс** | Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал | 1 |
| 1.1 | **Системийн дэд бүтцийн алба** | Системийн инженер | 1 |
| | | Сүлжээний инженер | 1 |
| 1.2 | **Мэдээллийн аюулгүй байдлын алба** | Эрсдэл комплайенсын мэргэжилтэн | 1 |
| | | Кибер аюулгүй байдлын инженер | 1 |

*Хүснэгт 13: Үнэт цаас гаргагчийн Дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн тухай мэдээлэл*

**Хэлтсийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

- Төлбөр тооцооны систем, түүний дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, төлөвлөлт хийх;
- Сервер, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;
- Байгууллагын хэмжээнд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (ISO 27001)-г нэвтрүүлэх, сайжруулах
- Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлыг хангах олон улсын стандарт (PCI DSS) -ыг тогтмол хханган ажиллах;
- Компанийн тусгай зөвшөөрөл болон харилцагч байгууллагуудын хүрээнд тодорхойлсон системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаанд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
2021031195 СТС2420

## 11.4.5. Мэдээллийн технологийн хэлтэс

Мэдээллийн технологийн хэлтэс нь программ хангамж хөгжүүлэлт, системийн судалгаа шинжилгээ, хяналт, чанарын баталгаажуулалтыг хийдэг. Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл ажиллагааны Бизнес хөгжлийн хэлтэстэй хамтран ажилладаг бол программ хангамжийн мэдээллийн аюулгүй байдлыг Дэд бүтэц мэдээллийн аюулгүй байдлын хэлтэстэй хамтран ханган ажилладаг.

| № | Алба нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | **Мэдээллийн технологийн хэлтэс** | Технологи хариуцсан захирал | 1 |
| 1.1 | **Системийн шинжилгээ чанарын алба** | Системийн ахлах шинжээч | 1 |
| | | Системийн шинжилгээний мэргэжилтэн | 1 |
| 1.2 | **Программ хангамж хөгжүүлэлтийн алба** | Ахлах програмист | 1 |
| | | Программист | 6 |

*Хүснэгт 14: Үнэт цаас гаргагчийн Мэдээллийн технологийн хэлтэс тухай мэдээлэл*

**Хэлтсийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг**

- Программ хангамж хөгжүүлэлт, засвар үйлчилгээ;
- Системийн бүх төрлийн судалгаа шинжилгээ гүйцэтгэх;
- Чанарын удирдлага, тест - Системийн бүх төрлийн тест чанарын баталгаажуулалт гүйцэтгэх;
- Тест кэйс чанарын баталгаажуулалтын баримтууд болон гарын авлага боловсруулах;
- Нэвтрүүлэлтийн үйл ажиллагааг удирдан хамтран ажиллах;
- Программ хангамж хөгжүүлэлт болон системийн үйл ажиллагааг аюулгүй байлгах шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, хяналтыг тогтмол тавих.

# 12. Эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээний хүрээнд доорх тусгай зөвшөөрлүүд болон стандартуудыг нэвтрүүлээд байна. Тус зөвшөөрөл болон стандартуудыг QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшил дахь охин компани болох “ККТТ” ХХК нь эзэмшдэг. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй төлбөрийн зах зээл нь өндөр зохицуулалттай зах зээл тул доорх зөвшөөрлүүдийг эзэмшиж буй цөөн байгууллагуудын нэг болж байна.

Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээг анх нэвтрүүлсэн цагаас хойш шаардлагатай тусгай зөвшөөрлүүд болон стандартуудыг нэвтрүүлсээр ирсэн бөгөөд цаашид тус зах зээл дахь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ зах зээлд үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд мөн адил зарчмыг баримтлан зохих тусгай зөвшөөрлүүдийг зохицуулах мэргэжлийн байгууллагуудаас шинээр авах, сунгах ажлуудыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж, үйлчилгээний болон мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг тогтмол мөрдөх зорилттой ажиллаж байна.


МОНГОЛ УЛС

МОНГОЛБАНК

ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2019 оны 11 сарын 29 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 11 сарын 29 өдрийн А-291 дугаар тушаалаар ККТТ ХХК-д төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.

Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй!

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

*Зураг 6: Зөвшөөрлийн гэрчилгээ*

Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:
**Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл**

Олгосон байгууллага: **Монголбанк**

Олгосон огноо: **2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр**

Хүчинтэй хугацаа: **4 жил**

Төлбөрийн картын процессор нь карт гаргагч, хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр техник технологи, мэргэжлийн боловсон хүчин, мэргэжлийн үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэгч байгууллага байх бөгөөд Монголбанк нь холбогдох хууль, журмын хүрээнд тус байгууллагад хяналт тавьж ажилладаг. Энэхүү зөвшөөрлийн хүрээнд тус байгууллага нь гэрээ байгуулсан банкны картын системтэй холбогдох боломжтой болдог.

QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг “ККТТ” ХХК нь энэхүү зөвшөөрлийг 2019 оноос хойш эзэмшиж буй бөгөөд үр дүнд нь Харилцагч банкнуудын картын системтэй холбогдож Хэрэглэгчдийн картыг токенжуулж буй аппликэйшнд цахимжуулах, цахим гүйлгээ хийх, QR худалдан авалтын гүйлгээг хийх зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлэх нөхцөл бүрдсэн.

Тус зөвшөөрлийг одоогоор “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн охин компани болох “ККТТ” ХХК-аас гадна арилжааны банкнууд, зарим финтекийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд гэх мэт 8 байгууллага Монголбанкнаас авсан байна.



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 06 сарын 11 өдөр Дугаар А-459 Улаанбаатар хот

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал
бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл олгох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ККТТ” ХХК-д хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

*Зураг 7: Зөвшөөрлийн гэрчилгээ*

Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр: **Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл**

Олгосон байгууллага: **Монголбанк**

Олгосон огноо: **2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр**

Хүчинтэй хугацаа: **4 жил**

Хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбогдуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь үйлчилгээ үзүүлэгч банктай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.17 дугаар зүйлд заасан техник технологи, мэргэжлийн боловсон хүчний болон Монголбанкнаас тодорхойлох бусад мэргэжлийн үйлчилгээгээр дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү зөвшөөрлийн хүрээнд “ККТТ” ХХК нь Харилцагч арилжааны банкнуудын хооронд аппликэйшн суурьтай дансны цахим төлбөрийн үйлчилгээг үзүүлж нийт хувийн хэвшил, төрийн байгууллагуудын төлбөр тооцоог найдвартай, хяналттай, аюулгүй гүйцэтгэж байна.

Тус зөвшөөрлийг 2023 оны 05 дугаар сарын байдлаар нийт 2 хуулийн этгээд Монголбанкнаас авч эзэмшсэн нь “ККТТ” ХХК болон “Мост Финтек” ХХК байна.



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 06 сарын 11 өдөр Дугаар А-459 Улаанбаатар хот

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал
бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл олгох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ККТТ” ХХК-д хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

*Зураг 8: Зөвшөөрлийн гэрчилгээ*

Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:
**Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл**

Олгосон байгууллага: **Монголбанк**

Олгосон огноо: **2022 оны 12 дугаар сарын 27-ний өдөр**

Хүчинтэй хугацаа: **4 жил**

Үнэт цаас гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкнаас баталсан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын дагуу шаардлагыг хангасан тул аутсорсингийн үйлчилгээ авах эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэхүү зөвшөөрлийн хүрээнд “ККТТ” ХХК нь төлбөрийн системийн шинэ шийдлийг олон улсын болон дотоодын компаниудаар боловсруулуулах, худалдан авах болон тэднээс зөвлөх үйлчилгээ авах эрхтэй болсон юм.

2023 оны 05 дугаар сарын байдлаар уг зөвшөөрлийг зөвхөн “ККТТ” ХХК нь Монголбанкаас авч эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагч Андеррайтер



QPay | SISA

| | |
|---|---|
| Name of Company | KKTT LLC |
| Certificate Number | PCI/CSAQ-D/KKTT03822 |
| Address | #6, Shuren Building, Embassy street, 1st Khoroo, Sukhbaatar, Ulaanbaatar, Mongolia. |
| Scope | QPay Card Payment System |
| Type of Certification | PCI DSS SAQ-D v3.2.1 |
| Category | Service Provider |
| Certification Status | Active |

SISA PCI DSS SAQ Validated

Disclaimer:

SISA Information Security makes no representation or warranty as to whether the validated or certified company systems are secure from either an internal or external attack or whether cardholder data is at risk of being compromised. SISA Information Security makes no representations or warranties on the business activities or operations of the said company. Please contact the company displaying the seal if you have questions about their products, services or customer support.

Copyright © 2023 SISA. All Rights Reserved. info@sisainfosec.com

*Зураг 9: Зөвшөөрлийн гэрчилгээ*

Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:
**Олон улсын картын гүйлгээний PCI-DSS стандарт PCI-DSS 3.2.1**

Олгосон байгууллага: **SISA Information Security**

Шинэчилсэн огноо: **2023 оны 02 дугаар сар**

Хүчинтэй хугацаа: **1 жил**

Олон улсын картын гүйлгээний PCI-DSS стандарт нь төлбөрийн картын мэдээлэл хадгалах, дамжуулах, боловсруулахтай холбоотой нууцлал, аюулгүй байдлын олон улсын стандарт юм. Энэхүү стандартын шаардлагыг анх 2020 онд "КKTT" XXK нь бүрэн хангаж БНЭУ-ын "SISA Information Security" байгууллагаар баталгаажилт, аудитыг хийлгэсэн. Уг хугацаанаас хойш жил бүр тасралтгүй амжилттай сунгуулан энэхүү сертификатыг эзэмшиж байна.

PCI-DSS стандартыг нэвтрүүлснээр картын мэдээлэлтэй мэргэжлийн түвшинд ажиллах хүний нөөц болон техникийн дэд бүтцийн орчин, нууцлал, аюулгүй байдлыг олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн дор хангаж үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал хэрэглэгчийн картын мэдээллийг дамжуулах, хадгалах, боловсруулах процессууд нь олон улсын стандартын дагуу хийгдэж байна.

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-07-20 БҮРТГЭВ-03


CERTIFICATE • CERTIFICADO • CERTIFICATE • CERTIFICATE • CERTIFIKAT

UNICERT

INFORMATION SECURITY MANAGEMENT SYSTEM CERTIFICATE

Universal GmbH

This certificate is granted to the organization,

KKTT LLC

#6, Shuren Building, Embassy Street, 1st khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar city, Mongolia

by review of IA2-16-7237 numbered report for the scope

Payment Gateway
Statement of Applicability Doc. No: A 21/0910
Statement of Applicability Date / Rev. No: 30.09.2021 / 1.0

to certify that a management system in accordance with standard's clauses is established and being implemented

ISO/IEC 27001:2013

Certificate No : ISMS 0622 009023
Original Certification Date : 30.06.2022
Issue / Revised Date : 30.06.2022
Expiry Date : 29.06.2023
Certification Period : 3 years (1st year)

IAF DAkkS Deutsche Akkreditierungsstelle D-ZM-16058-01-00

*Зураг 10: Зөвшөөрлийн гэрчилгээ*

Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:
**Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандарт**

Олгосон байгууллага: **"Юниверсал" ХХК (Universal GmbH)**
Шинэчилсэн огноо: **2022 оны 06 дугаар сарын 30-ний өдөр**

Хүчинтэй хугацаа: **2 жил**

Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээг анх олон нийтэд хүрэх цагаас тус үйлчилгээг мэргэжлийн, олон улсын түвшинд хэрэгжүүлэхийг зорьсон бөгөөд энэхүү зорилгын хүрээнд 2018 онд уг үйлчилгээг хэрэгжүүлж буй "ККТТ" ХХК-д Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож өдөр тутмын үйл ажиллагаанд олон улсын ISO 27001:2013 стандартыг мөрдөн ажиллуулахаар нэвтрүүлсэн.

Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2013 стандарт, Олон улсын төлбөрийн картын гүйлгээний PCI-DSS стандарт, "ККТТ" ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлого болон Үнэт цаас гаргагчийн холбоотой журам, бодлогууд нь Харилцагч болон Түнш байгууллагуудад найдвартай, аюулгүй үйлчилгээг тасралтгүй хүлээн авах боломжуудыг бүрдүүлэхэд өндөр ач холбогдолтой байдаг.

Энэхүү ISO 27001:2013 стандартыг нэвтрүүлснээр компанийн цахим болон цаасан суурьтай мэдээллийн нууцлал, аюулгүй байдал өндөр түвшинд хангагдаад байна.

Энэхүү стандартын сертификатыг ХБНГУ дахь "Юниверсал" ХХК (Universal GmbH) нь 2 жилийн хугацаатайгаар олгодог бөгөөд Үнэт цаас гаргагч нь шинэчлэн авахаар 2021 оны 03 дугаар улирлаас эхлэн ажиллаж эхэлсэн ба Монгол Улс дахь албан ёсны эрхтэй "Монсертф" ХХК-аар баталгаажуулалтын аудит хийлгэж, стандартын холбогдох шаардлагуудыг 2022 оны 02 дугаар сард бүрэн хангасан. Шаардлагатай материалуудыг "Юниверсал" ХХК-уруу хүргүүлэн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр ISO 27001 стандартын шинэчилсэн сертификатыг гардан авав.

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК нь дээрх тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаануудын хүрээнд олон улсын стандарт, горим, хэм хэмжээнүүдээс гадна Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах, зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам, Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам, Төлбөрийн картын журам зэрэг төрийн эрх бүхий байгууллага, Монголбанкнаас батлан мөрдүүлж буй бусад шийдвэр, зааврuудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн ажиллаж байна.

"ККТТ" ХХК нь үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам, Хүний нөөцийн бодлого, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Ажилтны ёс зүйн дүрэм, Албан бичиг хэрэг хөтлөлт, архивын журам, Сургалт хөгжлийн журам, Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам, Ур чадварын түвшин тогтоох журам, Цалин хөлс, урамшуулал тооцон олгох журам, Албан томилолтын журам, Ажил хүлээлгэх журам, "ККТТ" ХХК-ийн хамт олон, ажилтнуудыг шагнах, урамшуулах, шагнал олгох журам зэрэг дотоод журмуудыг баталж мөрдөн ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК УЛААНБААТАР ХОТ



ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХК

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

INNOVATION
INVESTMENT

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ




УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2023.11.08 он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



# 13. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

2023 оны 06 дугаар сарын байдлаар Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь TechFin концепцийн хүрээнд багтах ба доорх 4 ангилалд хамаарч байна.

1. QPay төлбөрийн шийдэл - Бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ
2. Мерчант буюу үйлчилгээ үзүүлж төлбөр хүлээн авагч байгууллагад зориулсан үйлчилгээ
3. Картын төлбөр тооцоо
4. Олон улсын төлбөр тооцоо

| | Зах зээлд нэвтрүүлсэн огноо | Хураангуй мэдээлэл |
|---|---|---|
| **QPay төлбөрийн шийдэл - Бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ** | 2016 | • Үнэт цаас гаргагчийн хамгийн анхны бүтээгдэхүүн, үйлчилгээ<br>• 2022 онд нийт 2.8 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 63.3 сая ширхэг гүйлгээ хийгдсэн<br>• Гүйлгээний тоо 2017 оноос хойш жилд дунджаар 216 хувиар нэмэгдсэн<br>• Нийт 11 арилжааны банктай хамтран ажилладаг<br>• Монголбанкны 3 тусгай зөвшөөрөлтэй<br>• Үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК нь Qpay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. |
| **Мерчантуудад чиглэсэн нэмэлт үйлчилгээ** | 2019 | • Үнэт цаас гаргагчийн охин компани "Дижитал Мерчант Сервисэс" ХХК нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.<br>• Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой |
| **Картын төлбөр тооцоо** | 2020 | • Qpay Wallet (цахим хэтэвч)<br>• Bank Wallet (Банкны аппликэйшнд карт токенжуулан хадгалж QR уншуулан картын гүйлгээ хийх)<br>• Reccuring payment<br>• Үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК нь энэхүү үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна |
| **Олон улсын төлбөр тооцоо** | 2020 | • UnionPay<br>• WechatPay<br>• AliPay<br>• ZeroPay<br>• Олон улсын Wallet Top-Up үйлчилгээ<br>• Үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК нь энэхүү үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна |

*Хүснэгт 15: Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн ангилал, товч тайлбар*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



# 13.1. QPAY ТӨЛБӨРИЙН ШИЙДЭЛ - БЭЛЭН БУС ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

## 13.1.1. QPAY ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ БУЮУ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

***"Хамгийн өргөн сүлжээтэй төлбөрийн гарц"***

QPay үйлчилгээ нь Монгол Улсын хэмжээнд дотооддоо хөгжүүлсэн хамгийн анхны QR бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ юм.

QR төлбөр тооцоонд оролцогч үндсэн талууд:

- Банк/Финтекийн байгууллагууд
- Үнэт цаас гаргагч болон группийн охин компаниуд
- Үйлчилгээ үзүүлэгч буюу Мерчант байгууллага
- Төлбөр төлөгч эцсийн Хэрэглэгч

Банк/Финтекийн байгууллагууд:

Хэрэглэгч төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн зөвшөөрч гүйлгээний нууц үгээр баталгаажуулахад Банк нь өөрийн системээр гүйлгээг хийнэ.

Үйлчилгээ үзүүлэгч буюу мерчант:

Үнэт цаас гаргагч нь хувийн хэвшлийн бизнесийн байгууллагууд болон төрийн үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудтай системийн түвшинд интеграци хийж динамик QR код үүсгэх, хэрвээ ямар нэгэн кассын систем ашигладаггүй бол мерчант байгууллагын дансны мэдээлэл (дансны нэр, дансны дугаар)-д үндэслэн статик төрлийн QR кодыг холбож идэвхжүүлэн зайнаас, аюулгүй, найдвартай төлбөр хүлээн авах үйлчилгээг Монголын зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна.

Төлбөр төлөгч эцсийн хэрэглэгч дараах үндсэн төрлөөр Qpay гүйлгээ хийнэ. Үүнд:

QR код уншуулан гүйлгээ хийх:

- Банкны болон финтекийн аппликэйшн дахь Qpay цэсээр данс суурьтай гүйлгээ хийх;
- Qpay wallet болон картын үйлчилгээгээр хамтран ажиллагч банк болон финтекийн аппликэйшн дахь цахим хэтэвчнээс картын гүйлгээ хийх.

Deeplink ашиглан гүйлгээ хийх:

- Мерчант байгууллагын аппликэйшн дотроос буюу QR код уншуулах боломжгүй үед;
- Short Message Service (SMS)-ээр ирсэн нэхэмжлэхийн link ашиглах үед.

QPay гэдэг үг нь компьютерын гар (keyboard)-ны хамгийн зүүн дээд талын "Q" үсгээс баруун дээд талын "P" үсгийг дараалуулан санамсаргүй байдлаар зохиосон эхлэлтэй үг юм.



*Зураг 11: QPay үйлчилгээний нэршлийн тухай*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч    Андеррайтер

2016 онд анхны гаргасан хувилбарыг version 0 гэж нэрлэсэн ба 2017, 2020, 2021 онуудад иж бүрэн сайжруулалтууд хийж 2020 оны 08 дугаар сард хамгийн сүүлийн хувилбар болох version 2.0. хувилбарыг зах зээлд нэвтрүүлсэн. Уг version 2.0 хувилбарын өмнөх version 0 болон version 1.0 хувилбаруудаас ялгаатай нь картын системтэй холбогдсон бөгөөд мерчантын интеграцчлалаар олон улсын EMVCo стандартын QR кодыг үүсгэж эхэлсэн юм.

Qpay үйлчилгээний таних тэмдэг буюу лого нь өнөөдрийг хүртэл 3 өөр хувилбараар ашиглагдаж байсныг танилцуулж байна.




*Зураг 12: QPay үйлчилгээний хувилбарууд, хөгжүүлэлтийн түүх*

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

### 13.1.2 QPay үйлчилгээний онцлог

- **HUB БУЮУ БҮХ БАНКНУУДТАЙ ХОЛБОЛТ ХИЙГДСЭН**

Анх "Хаан Банк" ХК, "Худалдаа Хөгжлийн Банк" ХК болон "Төрийн банк" ХК-уудтай хамтран тус арилжааны банкнуудын аппликэйшнд Qpay үйлчилгээг нэвтрүүлж QR кодоор төлбөр төлөх соёлыг Монголд анх түгээж байсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 11 арилжааны банкнуудын аппликэйшнд нэвтрүүлэн олон хэрэглэгчдэд Qpay үйлчилгээгээр төлбөр төлөх боломжийг бий болгосон.

- **МОНГОЛБАНКНЫ ЦАХИМ МӨНГӨНИЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ББСБ-УУДЫН АППЛИКЭЙШНД ХОЛБОЛТ ХИЙГДСЭН**

Зөвхөн банкнуудын аппликэйшн гэлтгүй Монголбанкнаас "Цахим мөнгөний зөвшөөрөл" авсан ББСБ-уудтай банктай ижил төрлийн системийн холболт хийж хэрэглэгчдэд Qpay үйлчилгээгээр төлбөр төлөх боломжийг бүрдүүлсэн.

- **QR КОД УНШУУЛЖ КАРТААР ГҮЙЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖТОЙ**

Аль ч банкны төлбөрийн картыг ухаалаг гар утасны аппликэйшнд цахимаар буюу биет бус болгон хадгалж, тухайн эрх бүхий аппликэйшнээр QR код уншуулж картын гүйлгээ хийх боломжтой болсон. Энэ системийг цаашид "Картын системийн процессинг" гэж нэрлэх ба QPay үйлчилгээ нь Монголд анх удаа хөгжүүлж зах зээлд нэвтрүүлсэн. Мөн QR код уншуулан картын гүйлгээ хийх боломжтой Qpay Wallet (Qpay цахим хэтэвч) ухаалаг гар утасны аппликэйшнийг Үнэт цаас гаргагч нь 2020 онд хөгжүүлсэн. Ингэснээр Мерчантад төлбөр хүлээн авах нэмэлт сувгийг нээж, Хэрэглэгч талд QR код уншуулан банк доторх болон банк хоорондын гүйлгээний шимтгэлгүй болгон өөрчилж чадсан.

- **QPAY ЦАХИМ ХЭТЭВЧЭЭР ДЭЛХИЙН 33 ОРОНД 2.8 САЯ ГАРУЙ МЕРЧАНТЫН QR КОДЫГ УНШУУЛАН ГҮЙЛГЭЭ ХИЙХ БОЛОМЖТОЙ**

Qpay цахим хэтэвчинд дотоодын банкны гаргасан олон улсын ЮнионПэй картыг цахимжуулан хадгалж Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-д ЮнионПэй QR кодыг уншуулан шууд гүйлгээ хийх боломжтой. Нөгөө талаасаа ЮнионПэй төлбөрийн аппликэйшн ашигладаг гадаад улсын иргэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын мерчант байгууллагын Qpay QR кодыг уншуулан гүйлгээгээ хийх буюу Монголын мерчант байгууллага гадаадын иргэдээс төлбөрөө авах боломжтой болсон.

- **БҮХ ТӨРЛИЙН МЕРЧАНТУУДАД БОЛОН ТӨЛБӨР ТӨЛӨГЧ ХЭРЭГЛЭГЧДЭД НЭЭЛТТЭЙ**

Мерчант: Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн төлбөр хүлээн авдаг бүх төрлийн байгууллага болон хувь хүн байх боломжтой.

Хэрэглэгч: Бүхий л төрлийн QR уншуулан гүйлгээ хийх боломжтой төлбөрийн аппликэйшнтэй хэрэглэгч нар Qpay үйлчилгээгээр төлбөрөө төлөх боломжтой.

Qpay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох "ККТТ" ХХК нь удирдан зохион байгуулж байна.

Үнэт цаас гаргагч

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

### 13.1.3 QR КОДНЫ ТУХАЙ

QR код нь физик ертөнцийг дижитал ертөнцтэй холбоход дэлхий даяар хэрэглэгддэг нээлттэй технологи юм.

Дэлгүүрт зарагдаж буй бараа бүхэн дээр байрладаг бид бүхний мэдэх баркод (barcode)-ыг анх 1951 онд Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-д Норман Вүдланд болон Бернард Силвер нь зохион бүтээж зохиогчийн эрхээ бүртгүүлсэн. Улмаар 20 жилийн дараа 1971 оноос хүнсний дэлгүүрт худалдан авалтын процессыг шуурхай, үнэн зөв гүйцэтгэхийн тулд босоо дөрвөлжин зураастай баркод болох 1D хэмжээст Universal Product Code (UPC)-ыг бараан дээр байршуулан уншуулах болсноор баркодын өргөн хэрэглээний үндэс суурийг тавьсан байна.

1D баркодын тусламжтайгаар худалдааны салбар хурдацтайгаар тэлж эхэлсэн ч баркодод агуулж болох мэдээлэл нь зөвхөн уншигчийн дата бааз дахь мэдээллээр л хязгаарлагдаж байв. Баркодод мэдээлэл нэмэх тусам босоо баганын тоо нэмэгддэг. Мөн баркодыг зөвхөн зориулалтын баркод уншуулагчаар уншуулдаг, уншуулсан мэдээллийг зөвхөн уншуулагчийн дата баазад бэлэн байгаа мэдээлэлтэй тохирсон тохиолдолд л задалж болдог зэрэг сул талууд бий.

Тиймээс дараагийн давлагаа нь 2D код (матриц бар код) буюу QR (Quick Response) код байв.

Япон Улсад төвтэй автомашины эд анги үйлдвэрлэгч Denso Wave компани нь автомашины үйлдвэрлэлийн явцад эд ангиудыг өндөр хурдаар сканнердах замаар хянах зорилгоор матриц бар код QR кодыг 1994 онд бүтээжээ.

QR код нь дүрс ашиглан жижиг зайнд линк, текст, тоо гэх мэт олон төрлийн мэдээлэл зэрэг агуулдаг давуу талтай байв.

**Хэрэглээ**

QR код нь биет холбоос юм. QR код гэж юу болох, түүнийг хэрхэн ашиглаж болохыг ойлгох хамгийн сайн арга бол түүнийг холбоос /URL link/ гэж үзэх явдал юм. Хүмүүс ухаалаг утсаа ашиглан вэб хаяг оруулахын оронд QR кодыг уншуулж контент руу нэвтрэх боломжтой. Үйлдэл нь хурдан бөгөөд энгийн. Зөвхөн камер эсвэл QR код уншигчтай хөдөлгөөнт төхөөрөмж хэрэгтэй.

**QR код үүсгэх**

QR нь код хямд бөгөөд үүсгэхэд хялбар. QR код үүсгэгч программд хэрэгтэй мэдээллээ оруулна. Үүний дараа QR код үүсгэгч нь тухайн кодыг хэвлэж эсвэл файл хэлбэрээр хадгалан түгээж болно.

**QR код уншуулах**

Уншуулахад сүлжээнд холбогдсон камер (гар утас) хангалттай. Аж үйлдвэрийн салбарт 2D код уншуулагч ашигладаг. Төлбөрийн нэхэмжлэх бүхий QR код уншуулахад Хэрэглэгч нь Мерчантын болон худалдан авалтын нэхэмжлэхийн мэдээллийг гараар бичих шаардлагагүй, мэдээлэл нь тухайн QR кодыг уншуулсан банкны аппликэйшнд автоматаар бичигдэн харагддаг.

**Сонголтууд**

QR кодын хүрээнд статик болон динамик QR кодууд байдаг. Статик QR кодын хувьд эх материал болон агуулгыг нь дараа өөрчлөх боломжгүй. Харин динамик кодын хувьд дахин хэвлэх шаардлагагүйгээр агуулгыг нь хүссэнээрээ өөрчлөх боломжтой байдаг.

2023.11.08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



### Хяналт

QR кодын олон давуу талуудын нэг нь QR кодын статистикийг хянах чадвар юм. Ингэснээр QR код үүсгэгч нь тус кодыг хэдэн удаа уншсан, зорилтот хэрэглэгчдэдээ хүрсэн эсэхэд байнга хяналт тавих боломжтой.

### Зохицуулалт/ Стандартчилал

Төлбөрийн нэхэмжлэхийн QR кодыг тухайн улсын төв банк болон холбогдох байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн тусгай стандарт, дүрэм журмын дагуу үүсгэх ёстой байдаг бөгөөд Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад төлбөр тооцооны зориулалтаар QR код үүсгэн нэвтрүүлсэн.

### Мэдээлэл дамжуулах

Төлбөр тооцооны зах зээлийн хувьд мерчант болон хэрэглэгч нь QPay QR кодоор төлбөрийн мэдээллийг найдвартай, алдаагүй, бодит цагийн горимоор солилцож байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031196 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

### 13.1.4 QR КОД АШИГЛАН ГҮЙЛГЭЭ ХЭРХЭН ХИЙГДДЭГ ТУХАЙ

Энгийн үгээр тайлбарлахад QPay үйлчилгээ нь хэрэглэгчийн банкны аппликэйшнээр уншуулсан Qpay үйлчилгээний QR кодыг задлах буюу QR кодод агуулагдах Мерчантын нэхэмжлэхийн мэдээллийг харуулах, мерчантын төлбөр хүлээн авах, дансны мэдээллийг баталгаажуулах, буруу QR код байвал буцаах, цуцлах гэх мэт процедурыг гүйцэтгэдэг. Ийнхүү банк нь гүйлгээнд систем талаас оролцогч талуудын баталгаажилтыг үндэслэн гүйлгээг хийж гүйцэтгэдэг.




*Схем 5: QR код уншуулах, тайлах процесс тухай*

**QR ТӨЛБӨРИЙН СИСТЕМД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ДУНД ОЙЛГОЛЦОХ HUB БОЛДОГ**




*Схем 6: QPay үйлчилгээ нь төлбөр тооцооны экосистемд дундын HUB дэд бүтцийн үүрэг гүйцэтгэж буй тухай*

- Банк бүр тусдаа QR кодын төлбөрийн систем хөгжүүлбэл их хэмжээний зардал гарахаас гадна мерчантууд хэд хэдэн төрлийн QR кодыг ашиглах шаардлага үүснэ.
- Мерчант нь аль ч банкны харилцах дансаар төлбөр хүлээн авах боломжтой. Мөн Үнэт цаас гаргагч нь мерчантуудыг хувь хүн, хуулийн этгээд гэж ялгалгүй гэрээ байгуулан үйлчилгээгээ үзүүлдэг.
- Мерчант болон "ККТТ" ХХК нь хамтран ажиллах гэрээ байгуулж бүх төлбөрийн аппликэйшн хэрэглэгчидээс төлбөр шилжүүлэх боломжтой.
- Qpay үйлчилгээгээр хийгдэх гүйлгээг банкнууд удирддаг тул банкны бүхий л аюулгүй байдлын стандартаар хангагдсан байдаг.

## 13.1.5 DEEPLINK ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Qpay үйлчилгээ нь зөвхөн QR код уншуулж гүйлгээ хийхээр хязгаарлагдахгүй. Deeplink технологийн үйлчилгээгээр дамжуулан банкнууд, финтекийн үйлчилгээ үзүүлэгч, аппликэйшн суурьтай бизнесийн байгууллагууд, зээл олголт болон зээлийн эргэн төлөлт хийгддэг ББСБ-удын аппликэйшн, үүрэн телефоны оператор байгууллагууд болон хэрэглээний төлбөрийн нэхэмжлэх илгээдэг Мерчант байгууллагуудад системийн түвшинд нэвтрүүлэн ажиллаж байна.

Deeplink технологийн тусламжтайгаар Хэрэглэгч нь QR код уншуулахгүйгээр, Мерчантын аппликэйшн, вэб хуудас эсвэл SMS-ээр хүлээн авсан тухайн Мерчантын нэхэмжлэх агуулсан линк ашиглан дурын банкны аппликэйшн руу дамжиж төлбөрөө төлөх боломжтой.




*Зураг 13: Deeplink технологийг ашиглан Мерчантын QR кодыг уншуулалгүйгээр банкны аппликэйшнд шилжин төлбөр төлөх жишээ зураг*

**ЦАХИМ ХЭТЭВЧ ЦЭНЭГЛЭХ**




Monpay аппликэйшн хэрэглэгч нь цахим хэтэвчээ цэнэглэхийн тулд Monpay аппликэйшн дотроосоо өөрийн дурын банкны аппликэйшн руу дамжин цэнэглэлт хийх боломжтой. Энэ үед Хэрэглэгч нь QR код уншуулах, цэнэглэх дүнгээс өөр мэдээлэл гараар шивэх шаардлагагүй тул гүйлгээний процесс хялбар, хурдан болсон.

*Зураг 14: QR код ашиглан цахим хэтэвч цэнэглэх нь*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

## 13.1.6 QPAY ТӨЛБӨРИЙН ШИЙДЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

**QR код уншуулан Peer-to-Peer (P2P) буюу данс суурьтай гүйлгээ хийх Жижиглэнгийн худалдаанд ашиглагдаж буй нь**



Зураг 15: QR код хэвлэн тараасан жишээ

Жижиглэн худалдаа, үйлчилгээний байгууллагуудад төлбөрийн Qpay QR код холбож байршуулснаар төлбөрийн аппликэйшн хэрэглэгчид мерчант бүрээс дансны дугаар асуух шаардлагагүйгээр, цар тахлын үед зайнаас гүйлгээ хийх, Мерчант нь төлбөрийн мэдэгдлийг нэмэлт төлбөргүйгээр харж үйлчилгээгээ үзүүлэх боломжтой болсон. Үнэт цаас бэлтгэх үеийн байдлаар нийт 180,000 гаруй QR код хэвлэгдэн тараагдсан нь хэрэглэгч болон мерчант хоорондын төлбөр тооцоог бодитоор хялбаршуулж чадсан.

**Dynamic QR - Автомат нэхэмжлэх / Тогтмол төлдөг нэхэмжлэхийн төлбөр төлөх нь**




Зураг 16: Мерчант "Юнивишн" ХХК

"Юнивишн" ХХК нь хэрэглэгчийн сар бүрийн төлбөр гарах үед зөвхөн тухайн хэрэглэгчийн нэхэмжлэх (нэхэмжлэх дүн, гүйлгээний утга)-ийн мэдээллийг агуулсан динамик QR кодыг хэрэглэгчийн дэлгэц дээр байршуулж хялбараар төлбөр төлөх боломжийг бий болгосон. Ингэснээр "Юнивишн" ХХК-ийн салбаруудад дахь ачаалал, үргүй зардлыг бууруулж мерчант болон хэрэглэгч сэтгэл хангалуун байх боломжийг бий болгосон.

**Биллинг (Billing)**

Мерчант нь эцсийн хэрэглэгчдэд дурын сувгаар тогтмол хугацаанд Qpay үйлчилгээгээр үүсгэсэн нэхэмжлэх (QR код эсхүл Deeplink) илгээж төлбөрөө цуглуулах боломжтой.




Зураг 17: Мобиком аппликэйшн дээр QPay ашиглан дараа төлбөрт үйлчилгээний биллинг төлбөр төлөх жишээ

**Webhook callback Unified Payments Interface (URL) - Төлбөрийн баталгаажуулалт (Payment notification)**

Webhook технологийн тусламжтайгаар Хэрэглэгчийн нэхэмжлэхийн төлбөр амжилттай төлөгдсөн тухай мэдэгдлийг автоматжуулснаар Мерчант байгууллага нь үйлчилгээгээ хэрэглэгчдэд бодит цагийн горимоор хүргэх боломжтой болсон.

**Онлайн худалдаанд төлбөрийн статус шалгах**



Зураг 18.1: Онлайн худалдаанд QR код ашиглах нь



Зураг 18.2:. Хэрэглэгч QPay ашиглан төлбөр төлсний дараа баталгаажуулалт хүлээн авч буй жишээ

Онлайн худалдаа, үйлчилгээний зах зээл өргөжин тэлж байгаа өнөө үед нөүтбүүк, компьютерын дэлгэцээр веб сайт руу хандаж байгаа бол динамик QR код, гар утсаараа хандаж байгаа бол deeplink ашиглан төлбөр төлөх боломжтой. Онлайн дэлгүүрийн сагсанд байгаа барааны төлбөр бүрд давтагдашгүй дугаартай нэхэмжлэх үүсдэг ба төлөгдсөн төлбөрийн мэдэгдлийг автоматжуулан мерчантын захиалгын системд мэдэгдэл дамжуулдаг.

**Үүрэн холбооны оператор байгууллагуудын төлбөрийн нэхэмжлэх**




Зураг 19: SMS-ээр нэхэмжлэх хүлээн авах, төлөх

"Скайтел" ХХК нь дараа төлбөрт дугаарын хэрэглэгчдэд сар бүр deeplink нэхэмжлэхийг хэрэглэгчдийн гар утасны дугаарт илгээдэг. Төлбөр төлөлт хийгдсэний дараа webhook төлбөрийн баталгаажуулалт автоматаар хийгдэж бодит цагийн горимоор хэрэглэгчдийн үйлчилгээний эрх сунгагддаг.




*Зураг 20: www.shoppy.mn онлайн худалдааны платформ дээрх QPay худалдан авалт*

2023.11.08

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## QPay version 2.0

Qpay version 2.0 нэвтэрснээр өмнөх хувилбар дээр нэмэгдэн Картын 3DS технологийг ашиглан дотоодын бүх арилжааны банкны картыг Qpay wallet (цахим хэтэвч) аппликэйшнд токенжуулан бүртгэх боломжтой. Үр дүнд нь Хэрэглэгч QR код уншуулан картын гүйлгээ хийх боломжтой болсон.

Энэ хүрээнд Үнэт цаас гаргагч нь "Хас Банк" ХК, "Худалдаа Хөгжлийн Банк" ХК, "Төрийн Банк" ХК, "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК, "Капитрон Банк" ХХК, "Ариг банк" ХХК болон "Богд Банк" ХК-тай системийн түвшинд хамтран ажиллаж байна.

## QPay Wallet аппликэйшн буюу QPay цахим хэтэвч

Qpay Wallet аппликэйшн ашиглан дурын банкны төлбөрийн картыг бүртгүүлэн, аюулгүй, шимтгэлгүй гүйлгээ хийх боломжтой.




| | | | |
|---|---|---|---|
| Үүсгэсэн бүртгэлээр нэвтрэх | Өөрийн ашигладаг банкны картуудаа токенжуулан хадгалах | Өөрийн карт бүрийн гүйлгээний түүхийг харах, хянах | QPay цахим хэтэвчээр QR код уншуулан бараа, үйлчилгээний төлбөрийг шимтгэлгүй төлнө |

*Зураг 21: Хэрэглэгч QPay Wallet цахим хэтэвчинд картаа токенжуулж хадгалан картаараа гүйлгээ хийх жишээ*

## Төлбөрийн картын бүртгэл, баталгаажуулалт

Хэрэглэгч Qpay Wallet (Qpay цахим хэтэвч) аппликэйшнд төлбөрийн картаа анх удаа холбоход картын 16 орон, картын дуусах хугацаа, CVV код болон интернэт пин кодыг 1 удаа оруулахыг шаарддаг бөгөөд олон улсын картын 3DES стандарт баталгаажуулалт хийгддэг. Мөн хялбараар картыг бутархай үнийн дүнтэй гүйлгээгээр баталгаажуулах боломжийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

## Картын токенжуулалт буюу нууцлал хадгалалт

Хэрэглэгчийн картын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс олон улсын нууцлал хадгалах, боловсруулах HSM /Hardware Security Module/ төхөөрөмжийг ашиглан хэрэглэгчийн оруулсан картын мэдээллийг Triple-DES алгоритмаар картын мэдээлэл, Device ID, User ID-г шифрлэн хадгалдаг.

## Токенжуулсан картаар гүйлгээ хийх

Хэрэглэгч Qpay Wallet аппликэйшнд холбосон картаараа QR код уншуулан худалдан авалт хийх боломжтой. Картын мэдээлэл нь Мерчантад ямар нэгэн байдлаар хадгалагдахгүй болно.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

### Qpay Reccuring Payment үйлчилгээ

Qpay үйлчилгээ нь олон улсын картын мэдээллийн нууцлал аюулгүй байдлын PCI-DSS стандартын шаардлагын дагуу вэб хуудас болон гар утасны аппликэйшн ашиглан төлбөр төлөх процессыг дэлхийн жишигт нийцүүлэн хүргэж байна. Ингэснээр Хэрэглэгч талд илүү хялбар, Мерчант байгууллага талдаа найдвартай төлбөрийн таталт хийхээр Qpay Recurring Payment буюу карт эзэмшигчийн зөвшөөрлийн дагуу автоматаар, тогтмол хугацаанд төлбөр таталт хийх үйлчилгээг нэвтрүүлсэн.

### Qpay Reccuring Payment үйлчилгээ ашиглахад тавигдах нууцлалын шаардлага:

Худалдаа, үйлчилгээний вэбсайт болон аппликэйшнээр үйлчилгээ үзүүлэгч Мерчант байгууллага нь Qpay Reccuring Payment үйлчилгээг ашиглах боломжтой ба Хэрэглэгчийн төлбөрийн картыг Мерчантын аппликэйшн/вебсайтад токенжуулан бүртгэж, Хэрэглэгчийн картын гүйлгээ хүлээн авах болон Хэрэглэгч буюу карт эзэмшигчийн зөвшөөрлийн дагуу автоматаар тогтмол хугацаанд төлбөр татах боломжтой.




*Зураг 22: QPay цахим хэтэвчинд токенжуулах боломжтой картууд (банкаар)*

### Олон улсын гүйлгээ хийх

Монголын дотоодын банкнуудын гаргасан олон улсын ЮнионПэй карт холбосон Qpay цахим хэтэвчтэй Хэрэглэгч нь ЮнионПэй үйлчилгээний гадаадын 33 улс дахь 2,800,000 гаруй үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын QR кодыг уншуулж гадаадын банкны данс руу төлбөр шилжүүлэх боломжтой.

ЮнионПэй QR кодын төлбөр нь P2P, Peer to Business (P2B), Business-to Business (B2B) санхүүжилтийг хүлээн авах, төлөх, QR кодоор дамжуулан нэмүү өртөг шингээх үйлчилгээг санал болгодог. Энэ нь голчлон худалдан авалт, шилжүүлэх, бэлэн мөнгө авах шийдлүүдийг хангадаг бөгөөд Push Mode (Хэрэглэгч төлбөрөө төлөхийн тулд Мерчантын үүсгэсэн QR кодыг өөрийн гар утасны төлбөрийн аппликэйшнээр уншуулах) болон Pull mode (Хэрэглэгчийн төлбөрийн аппликэйшнд үүсгэсэн QR кодыг Мерчант нь QR код уншигч төхөөрөмжөөр уншуулах) гэсэн хоёр горимтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## "Push" горимоор хэрхэн төлбөр төлөх вэ?




## "Pull" горимоор хэрхэн төлбөр төлөх вэ?




*Схем 7: ЮнионПэй QR кодын төлбөр төлөх Push болон Pull горим тухай*

UnionPay аппликэйшн хэрэглэгч гадаадын иргэн нь Монгол улс дахь дотоод бизнесүүдэд тараагдсан EMVCo стандартын Qpay үйлчилгээний QR кодыг уншуулан төлбөр тооцоогоо хийх боломжийг нэвтрүүлээд байна

2022 оны 01 дүгээр улиралд БНХАУ-ын Tencent группийн WechatPay үйлчилгээг "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлсэн. Ингэснээр WechatPay хэрэглэгч гадаадын иргэд нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын Мерчант байгууллагуудаас худалдан авалт хийхдээ WechatPay төлбөрийн аппликэйшнээр мерчантын үүсгэсэн Wechat QR кодыг уншуулан төлбөр төлөх нөхцөл бүрдсэн. Энэхүү төлбөрийн гарцыг ашиглан БНХАУ-руу экспортолж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр шилжүүлгийг найдвартай, шуурхай гүйцэтгэж байна.




*Зураг 23: WechatPay нэвтрүүлсэн тухай*

**WechatPay – Scan to pay /үндсэн үйлчилгээ/**

Дотоодын Мерчант байгууллага, хувь хүний QR кодыг БНХАУ-ын төлбөр тооцооны тэргүүлэх буюу 1.2 тэрбум хэрэглэгчтэй Wechat аппликэйшнээр уншуулан БНХАУ, Монгол Улс хооронд данс хоорондын гүйлгээ хийх боломжтой болсон.

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03



*Зураг 23.1: WechatPay ашиглан БНХАУ, Монгол Улс хооронд төлбөр гүйцэтгэх нь*

**WechatPay – In App Pay үйлчилгээ**

Дотоодын мерчантын аппликэйшн дотор Wechat Pay deeplink ашиглан гүйлгээ хийх буюу QR уншуулалгүй Wechat аппликэйшн нээж гадаадын хэрэглэгч төлбөрөө төлөх боломжийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн. Энэ шийдлийг гар утасны аппликэйшн болон вэб хуудсаар үйлчилгээ үзүүлэгч Мерчант ашиглах бүрэн боломжтой.




*Зураг 24: Шинээр нэвтрүүлж буй WechatPay– Mini App Pay*

**WechatPay – Mini App Pay үйлчилгээ**

WechatPay аппликэйшн дээр Монгол бараа, үйлчилгээ байршуулан борлуулах боломж бүхий WechatPay үйлчилгээний үндсэн нэг төрлийн үйлчилгээ.

WechatPay үйлчилгээний гадаад улсын хэрэглэгч нь MiniApp pay буюу аппликэйшн дотроосоо бараа, үйлчилгээний худалдан авалт хийх боломжтой байдаг. Энэ үйлчилгээнд Монгол Улсаас бараа экспорт хийх дотоодын Мерчант байгууллагуудыг оролцуулах боломжтой болсон. Ингэснээр Монгол нэрийн бүтээгдэхүүнүүдийг БНХАУ-д борлуулах шинэ боломж бий болж байгаа юм.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

### 13.1.7 ЦААШИД ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Qpay үйлчилгээ нь Дижитал эдийн засаг, нийгмийн томоохон дэд бүтцийн чухал хэсэг болсон байна. Qpay үйлчилгээний үндсэн QR код болон картын төлбөр тооцооны үйлчилгээ нь төр болон хувийн хэвшлийн цахим худалдаа, үйлчилгээний бүх төрлийн системтэй холбогдож нийт 180,000 гаруй харилцагч, давхардсан тоогоор 2.8 сая гаруй хэрэглэгчдийн төлбөр тооцоог цаг, минут тутамд гүйцэтгэж байна.

Мөн Qpay Wallet цахим хэтэвчээр дамжуулан картын токенжуулалт гүйцэтгэх, гүйлгээ хийх боломжтой болсноор биллинг үйлчилгээг дараах зорилтот Мерчантуудад үзүүлэх боломжтой болж байна.

- Үүрэн телефоны операторууд (сар бүрийн төлбөрийн автомат татан авалт);
- СӨХ (сар бүрийн төлбөрийн автомат татан авалт);
- Даатгалын компаниуд (даатгалын хураамжийн автомат татан авалт);
- ББСБ-ууд (зээлийн болон хүүгийн төлбөрийн автомат татан авалт).

Цаашид нэвтрүүлэх гүйлгээний модулиуд, шинэ функцүүдийн тухай дэлгэрэнгүйг Дунд хугацааны төлөвлөгөө хэсгээс танилцана уу.

## 13.2. МЕРЧАНТУУДАД ЧИГЛЭСЭН НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Үнэт цаас гаргагч нь охин компани "Дижитал Мерчант Сервисэс" ХХК болон "ККТТ" ХХК-аар дамжуулан Qpay үйлчилгээг нэвтрүүлсэн байгууллагуудад чиглэсэн нэмэлт үйлчилгээнүүдийг санал болгож байна. Цаашид үйлчилгээний төрлийг өргөжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.

### 13.2.1. МЕРЧАНТУУДАД ЧИГЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ



Зураг 25: QPay Мерчант аппликэйшн

Qpay Мерчант аппликэйшн нь доорх давуу талуудыг олгодог:

- Орлого хянах, орлогын мэдэгдэл хүлээн авах;
- Тайлан харах болон татах;
- Нэмэлт төхөөрөмж худалдан авах шаардлагагүй;
- Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-ийн баримт илгээх боломжтой.




Qpay Мерчант аппликэйшн нь Мерчант байгууллагад гүйлгээний мэдэгдэл болон орлогын түүхээ үнэ төлбөргүй харах/хянах, трендээ хянах, ПОС системгүйгээр төлбөр хүлээн авах боломжийг олгож байна.

Зураг 26 QPay үйлчилгээ нэвтрүүлсэн Мерчант нь QPay Мерчант аппликэйшн ашиглан орлогын түүхээ хянаж буй жишээ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

Үнэт цаас гаргагч нь Мерчантуудыг анхаарч Мерчантын ангилал, хэрэгцээ тус бүрд нийцэх, найдвартай, хялбар, хурдан үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчийн үйлчилгээг эрхэмлэж, Мерчантуудын бизнес өсөлт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

### 13.2.2. Цаашид хөгжүүлэх боломж

Үнэт цаас гаргагч нь цаашид мерчантуудад зориулан урамшуулал, лояалти систем хөгжүүлэх, судалгаанд суурилан төлбөр гүйцэтгэхэд хэрэглэхэд хялбар, аюулгүй бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилготой байна.

Түүнчлэн, данс суурьтай гүйлгээг Qpay үйлчилгээний банкин дахь түр дансаар дамжуулан гүйлгээний авто буцаалт хийх болон авто мэдэгдэл дамжуулах системийг сайжруулах, Монгол Улсад сошиал буюу онлайн худалдааны мерчант байгууллагуудад зориулан QR уншуулан бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийх шинэ боломж бүхий "Product QR" үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, "Төрийн Банк" ХК-тай хамтран нэгдсэн биллингийн үйлчилгээг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлуудаа хангаж байна.

2023 .11 .08 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03



# 14. Үнэт цаас гаргагчийн түншүүд, түншлэлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь аливаа нэгэн төрийн өмчит байгууллагын Монгол Улсад олон нийтийг хамарсан зорилтот төлбөр, төлбөр тооцоо болон финтекийн зах зээл дахь бүх тоглогчдыг Түнш гэж үзэн түнш хоорондын интеграцлал, холбоог хангах үйлчилгээ үзүүлж буй нь дижитал дэд бүтцийг үүсгэн хөгжүүлэх томоохон боломж болно., Эдийн засгийн салбар дахь тоглогчдыг дэмжин хамтарч ажиллана гэсэн зорилттой нийцдэг. Ингэснээр Мерчантууд болон эцсийн Хэрэглэгч хоорондын гүйлгээ, төлбөр хийх процесс хялбар, хямд, хурдан, найдвартай байх боломжийг бий болгодог.

## 14.1. Стратегийн түншүүд, хамтын ажиллагааны стратеги

### 14.1. 1 Арилжааны банк

Арилжааны бүх банкнуудтай B2B, Customer-to-Business (C2B), Customer-to-Government (C2G), Customer-to-Customer (C2C) харилцаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд бүрэн хамтран ажилладаг ба гүйлгээний төрлийн хувьд карт болон данс суурьтай гүйлгээний холболтуудыг хийж гүйцэтгэн хамтран ажиллаж байна.

### 14.1.2 ЮнионПэй

Үнэт цаас гаргагч болон түүний 100 хувийн эзэмшлийн охин компани нь дэлхийн хамгийн их төлбөрийн карт гаргагч ЮнионПэй брэндийн Монгол Улс дахь хамгийн анхны системийн оператор байгууллагаар ажиллаж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед системийн 3 банк, дэд 4 банкийг гадаадын ЮнионПэй цахим хэтэвчийн хэрэглэгчдийн төлбөр хүлээн авах боломжтой болгон холболт хийж, тус банкнуудын ЮнионПэй картыг дэлхийн 99 оронд UPI QR систем ашиглан төлбөр хүлээн авч буй гадаадын мерчантуудад төлбөр гүйцэтгэх боломжийг Монголын хэрэглэгч нарт бий болгон ажиллаж байна. Цаашлаад тус брэндийн хамгийн эрэлттэй үйлчилгээ болох U-Plan лояалти систем, Near-Field Communication (NFC) гэх шийдлүүдийг дотоодын болон олон улсын зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

### 14.1.3 WeChat Pay

2022 оны 01 дүгээр улиралд БНХАУ-ын Tencent группийн WechatPay үйлчилгээг "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлсэн. Ингэснээр БНХАУ-ын иргэн WechatPay төлбөрийн аппликэйшнээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын Мерчантын төгрөгийн данс руу, олон улсын гүйлгээ хийх нөхцөл бүрдэж байна.

Дараагийн төлөвлөсөн ажилд WechatPay үйлчилгээний нэг төрөл болох Mini Program Pay үйлчилгээ багтаж байгаа ба уг үйлчилгээг дотооддоо нэвтрүүлснээр экспорт хийх хүсэлтэй Монгол Улсын үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч нарт хамгийн ашигтай буюу WechatPay аппликэйшны худалдааны (онлайн дэлгүүр) хэсэгт Монгол бараа бүтээгдэхүүнийг байршуулан худалдах боломж бий болох юм. Ингэснээр БНХАУ-ын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ борлуулах томоохон гарц манай мерчантуудад бий болохоор байна.

### 14.1.4 Финтек ББСБ

2018 оноос хойш Финтек платформууд болон ББСБ-ууд олон төрлийн цахим зээлийн аппликэйшн, цахим хэтэвчүүдийг зах зээлд нэвтрүүлж байна. Эдгээр хэтэвчүүдийг цэнэглэх, дамжуулан худалдан авалт хийх, QR уншуулж төлбөр төлөх гэх мэт олон төрлийн төлбөр тооцооны дэд бүтцийн шийдлүүдийг QPay үйлчилгээ нь ханган нийлүүлж уламжлалт санхүүгийн зах зээлийг цахим, боловсронгуй болгон ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Андеррайтер

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

### 14.1.5. Сервер нийлүүлэгчид

Монголбанк болон олон улсын төлбөрийн түншүүдийн шаардлага, Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартын дагуу үндсэн, нөөцийн болон үүлэн (cloud) гэх 3 байршилд сервер хангаж нийлүүлэлтийн үйлчилгээг авч ажиллаж байна. Аливаа нэгэн системийн доголдол, техник тоног төхөөрөмжийн гэмтэл, цахилгаан интернэтийн тасалдал үүсэхэд тус серверүүд унасан серверээ 100 хувь нөхөн ажиллах тогтолцоог бий болгосноороо давуу талтай.

### 14.1.6 Брокер, Дилерийн компаниуд

Монгол Улсын хэмжээнд нийт 50 гаруй брокер, дилерийн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаагаас зарим нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн онлайн арилжаа, захиалгын платформ, систем хөгжүүлж эцсийн хэрэглэгчдэд хялбар байдлаар үйлчилгээ авах боломжийг бий болгож байна. QPay үйлчилгээ нь үнэт цаасны данс нээх төлбөр, хувьцаа худалдан авалтын гүйлгээнд том түшиг тулгуур нь болж хэрэглэгч болон брокер, дилерийн байгууллагуудын хувьд цаг хугацааг бодитоор хэмнэж чадсан байна.

Тухайлбал, "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн 1,072 ширхэг хувьцааны ногдол ашгийг Монгол Улсын нийт иргэн бүрд хуваарилж баталгаажуулах зорилгоор зарим брокер, дилерийн компаниудыг хамруулан хөгжүүлсэн цогц аппликэйшнд QPay системийн холболтыг хийж олон мянган иргэдийн үнэт цаасны дансыг богино хугацаанд нээж чадсан юм.

## 14.2. Хамтран ажиллагч банкууд

**МОНГОЛБАНК** — МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

QPay үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай "Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа", "Хөдөлгөөнт банк", "Аутсорсингийн үйлчилгээ авах" гэсэн 3 зөвшөөрлийг Монголбанкнаас авсан ба цахим төлбөрийн системийн хөгжлийг зорилгоо болгон Монголбанктай салшгүй холбоотой ажилладаг.

**Төрийн сан банк**

QPay үйлчилгээг Монгол Улсын төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төрийн үйлчилгээний бүх цахим платформуудад амжилттай нэвтрүүлэн хамтран ажиллаж байна. Тэдгээр төрийн байгууллагуудтай төрийн сангийн дансаар төлбөрийн болон картын гүйлгээ хүлээн авах тухай хамтран ажиллах гэрээг байгуулан холболтын ажлууд хийгдэж байна.

**ТӨРИЙН БАНК**

Төрийн сан банктай 2017 оны 02 дугаар сард хамтын ажиллагааны гэрээ байгуулж QPay үйлчилгээтэй холбоотой бүх төрлийн шийдлээр хамтран ажилласаар ирсэн. 2023 онд багтаан Төрийн сан банктай хамтран төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэгдсэн шинэ системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

**KHAN BANK**

Анх QPay үйлчилгээг үндсэн орчинд туршин нэвтрүүлж арилжааны банкнуудаас хамгийн анх "Хаан Банк" ХК-тай 2016 оны 11 дүгээр сард хамтын ажиллагааны гэрээг байгуулсан түүхтэй. Өнөөдрийг хүртэл "Хаан Банк" ХК-тай хамтран KhanPay, QPayNow зэрэг үйлчилгээг анхлан нэвтрүүлснээс гадна Монголд анх удаа данс суурьтай гүйлгээний сеттлемент нэвтрүүлсэн хамгийн найдвартай, сайн түншлэгч банк юм.

СЗХ 2023.11 сар өдөр БҮРТГЭв №
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар QPay үйлчилгээний бүхий л боломжит үйлчилгээг системийн түвшинд нэвтрүүлсэн хамгийн нээлттэй, үргэлж шинийг санаачлагч банк юм.

TransBank ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК

"Кредит Банк" ХХК, "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК-уудын нэгдлийн дараа үндсэн QPay үйлчилгээ, картынтөлбөрхүлээнавах,Трансбанкаппликэйшнд Хэрэглэгчийн картыг токенжуулж картын гүйлгээ эхлүүлэхтэй холбоотой гэрээ хэлцлүүдийг богино хугацаанд байгуулан системийн холболтуудыг хийсэн. Мөн энэ хугацаанд олон улсын Wechat-Pay үйлчилгээг хамтран Монгол Улсын зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

XACBANK

2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж өнөөг хүртэл боломжит бүхий л үйл ажиллагааг хамтран системийн түвшинд нэвтрүүлсэн. Токенжуулсан картын гүйлгээний сеттлементийг анхлан нэвтрүүлсэн банк юм.

КАПИТРОН БАНК

2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгуулж цаашид бүхий л үйлчилгээнд хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.

БОГД БАНК

2019 оны 08 дугаар сарын 20-ны өдөр анхны хамтран ажиллах гэрээ байгуулсан ба картын гүйлгээ гаргах, картын төлбөр хүлээн авах гэх мэт бүхий л үйл ажиллагаанд хамтран ажиллаж буй нээлттэй, ухаалаг банк юм.

NIBank

2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж, Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк (ҮХОБ)-ны хэрэглэгчдийн төлбөр төлөх боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

АРИГ БАНК

2019 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлсэн. 2022 оноос QPay үйлчилгээний бүх шийдлүүдийн хүрээнд хамтран ажиллаж байна.

ЧИНГИС ХААН БАНК

2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр гэрээ байгуулсан. "Чингис Хаан Банк" ХХК-ийн харилцагчдын төлбөр төлөх боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

M bank

2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр "М Банк" ХХК-тай QPay үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ байгуулж картын токен үйлчилгээгээр хамтран ажиллахаар зорин ажиллаж байна.

ГОЛОМТ БАНК SocialPay

Системийн томоохон банкнуудын нэг "Голомт Банк" ХК болон SocialPay үйлчилгээтэй хамтран ажиллах бэлтгэл ажлуудыг хийгдэж байгаа ба 2023 ондоо багтаан олон нийтэд танилцуулах төлөвлөгөөтэй байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 9021031195 6183855 СТС2420

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



## 14.3. Хамтран ажиллагч финтек компаниуд

**"Мост Финтек" ХХК"**

"Мост Финтек" ХХК -тай 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдөр анхны гэрээг байгуулсан. QPay үйлчилгээг нэвтрүүлснээс хойш Мост Money аппликэйшн хэрэглэгчдийн төлбөр төлөлтийг бодитоор хялбаршуулан хэрэглэгчдийн үнэт цаг хугацааг хэмнэж, талархлыг хүртэн ажиллаж байна.

**Лэндмн ББСБ" ХК**

Монголд анх удаа ухаалаг гар утасны аппликэйшнээр дамжуулан хэрэглэгчдийн зээлийн асуудлыг шийдэрлэсэн ББСБ. Lendmn аппликэйшн Хэрэглэгчийн зээлийн эргэн төлөлтийг QPay үйлчилгээгээр дамжуулан төлөх боломжийг нэвтрүүлэн тогтвортой хамтран ажиллаж байна. Мөн "Лэндмн ББСБ" ХК-ийн охин компани болох "Суперап Хэтэвч" ХХК-д данс суурьтай болон картын системийн гүйлгээний процессингийн үйлчилгээг үзүүлж байна.

**"Мобифинанс ББСБ" ХХК**

Монголбанкнаас хамгийн анх "цахим мөнгө"-ний зөвшөөрөл авсан финтек байгууллага. QPay QR код уншуулан гүйлгээ хийх, Monpay данс цэнэглэлт зэргээр хэрэглэгчдийн төлбөр тооцооны асуудлыг хялбаршуулан хамтран ажиллаж байна.

**"Инвескор Хэтэвч ББСБ" ХХК**

"Инвескор Хэтэвч" ХХК-тай QPay үйлчилгээний данс суурьтай гүйлгээ болон картын гүйлгээний холболтоор хамтран ажилладаг ба цахим хэтэвч цэнэглэлт болон зээлийн эргэн төлөлт хийх боломжуудыг QPay үйлчилгээгээр дамжуулан шийдвэрлэж байна.

**Монгол Чат**

2020 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгуулсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар QPay-ээс үүсгэсэн QR кодыг уншуулан гүйлгээ хийх боломжийг тус аппликэйшний хэрэглэгчидэд бий болгож, харилцагчийн бизнесийг дэмжин ажиллаж байна.

**"Ард Кредит ББСБ" ХК**

2022 онд QPay-ээс үүсгэж байгаа QR кодыг уншуулан гүйлгээ хийх холболтыг нэвтрүүлсэн. Цаашид мерчантын хувьд хамтран ажиллахаар төлөвлөн гэрээ байгуулах ажлууд хийгдэж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2023.11.08 БҮРТГЭЛ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 14.4. Монгол Улсын Засгийн Газрын байгууллагууд

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газраас зарласан "Цахим Үндэстэн" хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын гүйцэтгэгч агентлагуудын цахим төлбөрийн системийг хариуцан хариуцлагатай, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Монгол Улсын төв эмнэлгүүд болох 1, 2, 3 дугаар төвүүдийн нэгдсэн төлбөр тооцооны системийг "Хаан Банк" ХК-тай хамтран үнэ төлбөргүй шинэчилж эмнэлэгийн үйлчлүүлэгчдийн төлбөр төлөх боломжийг карт, цахим хэлбэрээр шийдсэн. Төлбөр тооцооны олон суваг, боломжууд нэмэгдсэнээр хэрэглэгчдийн цагийг хэмнэх, цахим төлбөр тооцоог нэвтрүүлснээр гар дамжих бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, бактер, вирусын эсрэг зохистой арга хэмжээг авсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

Төрийн сангийн данстай Төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэхэмжлэхийн төлбөрийг QPay үйлчилгээгээр төвлөрүүлэн төрийн үйлчилгээний бүх цахим платформуудтай хамтран ажиллаж үйлчилгээгээ тасралтгүй үзүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Гадаадын болон орон нутгийн жуулчдын дархан цаазат газраар түр зорчих, ан агнуур хийх, загасчлах гэх мэт тусгай зөвшөөрлийн хураамжийг төвлөрүүлэх зорилгоор Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны дэргэдэх байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар болон түүний сум, дүүргүүдэд байрлах нэгж, цэгүүдээр үйлчлүүлэх ард иргэдийн ачаалал, үйлчилгээний хүнд суртлыг багасгах зорилгоор цахимаар асуудлаа шийдвэрлэх боломжтой болгосон www.burtgel.gov.mn болон emongolia аппликэйшн дахь бүртгэлийн системтэй QPay системийг холбон төлбөр тооцоо болон үйлчилгээг 100% автоматжуулах боломжийг бий болгон ажиллаж байна.

УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ

Автомашинаар зөрчил гаргасан жолооч нарын мөнгөн торгуулийг QPay нэхэмжлэх болгон харьяалагдах оршин суух хаяг руу Монгол шуудангаар цаасан хэлбэрээр илгээж төлбөр барагдуулах үйлчилгээнд QPay системийг интеграцчлан Замын Хөдөлгөөний Удирдлагын Төв (ЗХУТ)-тэй хамтран ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЕЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

**e-mongolia** Цахим үндэстэн

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Улсын нэгдсэн цахим үйлчилгээний платформын үндсэн цахим төлбөр тооцооны оролцогч юм. Төрийн үйлчилгээний цахимжилтын үндсэн суурь хамтрагч нь QPay систем бөгөөд хэрэглэгчдийн цаг зав, бухимдлыг бууруулах бодитой үйлчилгээг нэвтрүүлж амжилттай ажиллаж байна.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нийслэлийн бүх төрлийн биет болон цахим үйлчилгээнүүдэд төлбөр тооцооны хамтрагчаар ажиллаж, нийгмийн цахим дэд бүтцийг сайжруулан ажиллаж байна.

**ebarimt**

Бараа, үйлчилгээний төлбөр төлөгдсөн баримтыг татварын системд бүртгэлжүүлэх боломж бүхий ebarimt аппликэйшнд төрийн зарим үйлчилгээ багтсан. Тэдгээрийн нэхэмжлэлийн төлбөр төлөлтөд QPay нь deeplink технологийг нэвтрүүлэн ажиллаж байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын татвар төлөлт, авто тээврийн хэрэгслийн татвар болон бусад татварын төлбөр төлөлтийг хялбаршуулах зорилгоор Тагнуулын Ерөнхий Газрын эзэмшлийн платформуудтай нэгдсэн системийн холболт хийж, нийт цахимаар хийгдэж буй татварын орлогын дийлэнх хувийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг тогтмол хийж гүйцэтгэдэг болно.

**МОНГОЛЫН ГААЛЬ**

Монгол Улсын тусгай чиглэлийн томоохон байгууллага болох Гаалийн ерөнхий газартай хамтран хэрэглэгчдийн гаалийн бүрдүүлэлтээс эхлээд бараа хүлээн авах хэсгийн төлбөр тооцоог 100% цахимаар шийдэх боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү шийдэл нь бизнес эрхлэгч, хувь хүмүүсийн импортоор орж ирж буй бараа, бүтээгдэхүүнд ноогдох татвар, хураамжийн төлбөр төлөлтийг цахимаар шийдэх боломжтой ба хүн цаг, цаасны хэрэглээг бууруулж буй бодитой, үр дүнтэй, нээлттэй хамтын ажиллагаа юм.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

Хөдөө орон нутгийн иргэн бүрийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа явуулж буй Биеийн Тамир, Спортын Улсын Хорооны харьяа байгууллагууд болох орон нутгийн биеийн тамир, спортын газруудад зайнаас QPay үйлчилгээгээр дамжуулан төлбөр тооцоо хийх боломжийг спортын газар бүрийн онцлогтой уялдуулан нэвтрүүлсэн.

Монголын даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагуудад нэгдсэн даатгалын системээр дамжуулан албан журмын даатгалын төлбөрийг төвлөрүүлэх үндсэн төлбөр тооцооны хамтрагчаар тогтвортой ажиллаж байна.

*Жич: Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч, тодорхойлогч агентлагууд, ТӨХК болон бусад төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хүсэл, шаардлагын дагуу нэмэлт хөгжүүлэлтийг тухай бүрд хийж нэвтрүүлэн тогтвортой, хариуцлагатайгаар үйлчилгээ үзүүлж байна.*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 5183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03



## 14.5. Хамтран ажиллагч томоохон үйлчилгээний байгууллагууд

Эдийн засгийн таван салбараас доорх түншүүдийг онцолж байна:

### Сүлжээ болон конвениенс дэлгүүр

Иргэдийн өдөр тутамдаа үйлчлүүлдэг сүлжээ супермаркетууд, кофе шопуудын кассын системд QPay төлбөрийн системийг холбож ашиглалтад оруулснаар банкны хэрэглэгчдийн сайшаалыг хүртсэн ба худалдан авалтын эргэц, хурд, хялбар байдалд эерэг нөлөө үзүүлж байна.

### Онлайн үйлчилгээ

АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Олон улсын стандартад нийцсэн такси, тээврийн үйлчилгээний платформ QPay системийг холбож эцсийн хэрэглэгчийн төлбөр тооцоог хялбараар гүйцэтгэх боломжтой болсон.

### Үүрэн телефон

Үүрэн холбооны хэрэглэгчдийн хэрэглээний төлбөр төлөлтийг бүрэн автоматжуулж үүрэн холбооны байгууллагуудын орлого төвлөрүүлэх үйл ажиллагааны зардлыг бууруулсан.

### Онлайн худалдаа

Онлайн бараа захиалгын үйлчилгээ авах, барааны төлбөрийг онлайнаар хийхэд зөвхөн картын мэдээлэл оруулдаг байсныг өөрчлөн QPay үйлчилгээг нэвтрүүлж, онлайн худалдаа эрхлэгчид төрөл бүрийн арилжааны банкаар дамжуулан төлбөр хүлээн авах хялбар шийдэлтэй болсон. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар QPay үйлчилгээ нь онлайн худалдаан дахь гүйлгээний 80 орчим хувийг дангаар эзэлж байна.

### Биллинг төлбөр

ТӨРИЙН БАНК

Иргэд банкны теллер, үүрэн холбооны байгууллагын хэрэглэгчдэд үйлчлэх төв, салбаруудад биечлэн очиж хэрэглээний төлбөр төлдөг байсан цаг үе өнгөрч, өнөөдөр гар утаснаасаа 2 үйлдэл хийгээд төлбөрөө төлж үйлчилгээгээ авч байна.

Төрийн банкны и-биллинг үйлчилгээнд QPay системийг нэвтрүүлснээр өмнө нь зөвхөн төрийн банкаар дамжуулан хэрэглээний төлбөрөө төлж үйлчилгээ авдаг байсныг шинэчилж QPay-д холбогдсон банкнуудын нийт харилцагчдын асуудлыг шийдвэрлэсэн юм.

2023.11.08
БҮР
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



## 14.6. Хамтран ажилладаг гадаад байгууллагууд

### Wechat Pay

WeChat Pay

Олон улсад тэр дундаа Зүүн Өмнөд Азийн Улс орнуудаар 1.2 тэрбум идэвхтэй хэрэглэгчтэй БНХАУ-ын Tencent Group-ийн WechatPay үйлчилгээний системтэй интеграц хийж эхний байдлаар БНХАУ-ын иргэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Мерчант байгууллагуудад байршуулсан QR кодыг уншуулан олон улсын гүйлгээ хийх боломжийг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн Wechat аппликэйшний үндсэн модулиудад интеграц хийн нэвтрэх боломжуудыг ярилцан хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болсон.

### ЮнионПэй

UnionPay International

Дэлхийн томоохон карт гаргагч банкнуудтай хамтрагч ЮнионПэй үйлчилгээний системтэй холболт хийж олон улсын ЮнионПэй аппликэйшн ашиглагч гадаад улсын иргэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын мерчант байгууллагуудад байршуулсан (static, dynamic) QR кодыг уншуулан олон улсын гүйлгээ хийх боломжийг хамтран нэвтрүүлсэн. Мөн Монгол Улсын банкнуудын гаргасан олон улсын ЮнионПэй карттай Монгол Улсын иргэд гадаад улсад ЮнионПэй стандартын QR кодыг уншуулан олон улсад гүйлгээ хийх боломжтой болсон.

zero Pay

Бүгд Найрамдах Солонгос Улсын засгийн газрын дэмжлэгээр Сөүл хотын захиргаа нь жижиг бизнес эрхлэгчдийн шимтгэлийн ачааллыг бууруулах зорилгоор QR код дээр суурилсан гар утасны аюулгүй төлбөрийн үйлчилгээ болох "ZeroPay"-ийг нэвтрүүлсэн. Энэхүү төлбөрийн шийдэл нь Солонгос Улсад өргөн хэрэглэгддэг хэрэгслүүдийн нэгт зүй ёсоор тооцогдож байна. Үнэт цаас гаргагч нь олон улсын төлбөрийн шийдлүүдтэй хамтран ажиллах стратегийн хүрээнд 2023 оны 02 дугаар сард "Korea Easy Payment Foundation" байгууллагатай түншлэлийн хүрээн дэх санамж бичгийг зуран хамтын ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Alipay

БНХАУ-ын өөр нэгэн томоохон хэрэглээ болох AliPay төлбөрийн системийг Монгол улсдаа нэвтрүүлэхээр хэлэлцээрийн ажлууд хийгдэж байна.

Ийнхүү Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд QPay үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд нэр бүхий байгууллагуудтай түншлэл үүсгэсэн. Цаашид TechFin чиглэлээр бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэхэд мөн адил түншлэлийн стратегиа баримтлан, дундын HUB бодлого баримталж түншүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ боломжууд нээж, Дижитал дэд бүтэц хөгжүүлэхийг зорин ажиллана.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЕЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
ЗЭНИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
6183855
9021031195 СТС2420

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



# 15. Эрсдэлийн хүчин зүйлс ба Эрсдэлийн удирдлагын бодлого

## 15.1. Эрсдэлийн хүчин зүйлс

Үнэт цаасыг худалдан авч эзэмшихээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг худалдан авч эзэмшихтэй нь холбогдуулан үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлсийг тусгав. Хөрөнгө оруулагч нь Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнө дараах эрсдэлийн хүчин зүйлстэй танилцсан байвал зохилтой.

Тус эрсдэлийн хүчин зүйлүүд нь Үнэт цаас эзэмшиж, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдад тулгарч болох бүх эрсдэлийн хүчин зүйлсийг дурдаагүй байж болох бөгөөд агуулгын хувьд тэдгээрт хамааралтай тал бүрийн, бүрэн хэмжээний тайлбар биш байж болно.

Андеррайтерууд болон Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас эзэмших хөрөнгө оруулагчийг Үнэт цаас худалдан авахын өмнөх шийдвэрээ гаргахад нь болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсийн талаар зөвхөн зөвлөмж хэлбэрээр сануулах, мэдээлэл хүргэх байдлаар тусгасан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлж, уг эрсдэлүүдийг таних, удирдах ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд эрсдэлүүдийг дараах байдлаар тодорхойлдог.

### 15.1.1. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн дэд бүтцийн сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл үүсэх, программ хангамж, системийн хэвийн ажиллагаа алдагдах, тасалдал үүсэх зэрэг эрсдэл тохиолдох магадлалтай. Үнэт цаас гаргагч нь эдгээр хүчин зүйлсийн тохиолдох магадлалыг нарийн тооцоолж, урьдчилан сэргийлэх, магадлалыг бууруулах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:

1. Тогтвортой ажиллагааг хангах үүднээс нөөц дата баазуудад серверээ хадгалдаг ба сервисүүдээ виртуалаар олон болгож, үйлчилгээний ачааллыг бууруулах;
2. Төлбөр тооцооны системийн найдвартай ажиллагааг тасралтгүй хангах үүднээс үндсэн болон нөөц дата центрийг үүсгэж өөрийн сервер, тоног төхөөрөмжийг байршуулах;
3. Группийн түвшинд ашиглагдаж буй мэдээллийн системүүд болон тэдгээрийг ажиллуулах хүний нөөц болон үйл ажиллагааг хамруулан мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэх;
4. Үйлчилгээний ачаалал, алдааг тогтмол хянан бүртгэл хийж, Мерчант байгууллага болон банкнуудтай холбоотой сүлжээний асуудлыг мэдсэн даруй асуудлыг шийдвэрлэх;
5. Сервер, системийн хурд гүйцэтгэл, ачааллыг 24 цагийн турш хянах мониторингийн системийг ашиглах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Мөн сүүлийн үеийн мэдээлэл технологийн хамгаалалтын шийдлийг нэвтрүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хөрөнгө оруулалтыг тогтмол хийж ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183348



УЛААНБААТАР ХОТ
ЛИЗИНГ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

### 15.1.2. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд Үнэт цаас гаргагчийн систем рүү халдах, хакерын халдлагад өртөх, санаатай болон санаандгүй байдлаар хөнөөлтэй программ хангамж суурилуулах, вирустуулах, харилцагчийн мэдээлэл алдагдах зэргээс үүдэн учирч болзошгүй эрсдэлүүд багтана.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлд чухал ач холбогдол өгч, шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийг худалдан авч үйл ажиллагаанд ашиглахаас гадна Олон Улсын ISO 27001:2013 стандартыг амжилттай баталгаажуулан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлээд байна. Мөн төлбөрийн картын PCI DSS стандартыг 3 дахь жилдээ амжилттай баталгаажуулсан.

### 15.1.3. БИЗНЕСИЙН ТАСАЛДАЛ, СИСТЕМИЙН ЗОГСОЛТТОЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Техник, технологийн хөгжил асар хурдацтайгаар урагшилж байгаа өнөө үед мэдээллийн технологийн салбарт техник, технологийн хоцрогдол болон гэнэтийн системийн зогсолт нь үйл ажиллагааны бүтээмж, зах зээлийн өрсөлдөх чадварыг бууруулах гол хүчин зүйлд тооцогддог.

QPay үйлчилгээний хэрэглээ өдөр ирэх тутам нэмэгдэж байгаатай холбоотойгоор шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийн сайжруулалт болон шинэчлэлийг тухай бүр хийдэг бөгөөд техник, технологитой холбоотой эрсдэлүүдээс сэргийлэх зорилгоор 2022 онд сервер, тоног төхөөрөмжийн шинэчлэл, өргөтгөлийг хийсэн.

QPay шийдэл нь үндсэн болон нөөц, үүлэн гэх 3 байршилд сервер ажиллуулж байгаа бөгөөд аливаа нэгэн системийн доголдол, техник тоног төхөөрөмжийн гэмтэл, цахилгаан интернэтийн тасалдал үүсэхэд 100% нөхөн ажиллах тогтолцоог бий болгосон.

### 15.1.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжих, үйлчилгээний чанар сайжрах, шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүрд хийхэд ажиллах хүчин чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс үйл ажиллагааны бүх түвшний ажилтнуудад тогтвортой, сэтгэл ханамжтай, аюулгүй ажиллах нөхцөлүүдийг бүрдүүлэх нь үйл ажиллагааны зардлыг хэмнэх болон ажилтнуудад бүтээмж өндөртэй ажиллах үндсэн нөхцөл болдог.

Энэ хүрээнд Үнэт цаас гаргагч нь боловсон хүчний тогтвортой байдал хангагдаж буй эсэх; ажиллах хүчний хомсдолоос зайлсхийх боломжтой эсэх; ажилтнууд ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд хангалттай мэдлэг, нөөц бололцоотой эсэх; удирдлага нь ажлын гүйцэтгэл мэргэжлийн түвшинд хэрэгжиж буй эсэхэд байнга хяналт тавин ажилладаг. Үнэт цаас гаргагчийн хувьд үйл ажиллагаанд шаардлагатай чадварлаг, мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх хүний нөөцийн цогц бодлого, хөдөлмөрийн дотоод журам болон бусад дотоод дүрэм, журмуудыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

### 15.1.5. ДОТООД ПРОЦЕССИЙН ЭРСДЭЛ

Дотоод процессын эрсдэлд бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэхтэй холбоотой хүний нөөц, үйл ажиллагааны тодорхойгүй, хангалтгүй байдлаас үүсэх эрсдэл; шаардлагатай дүрмээр зохицуулагдаагүй гэнэтийн эрсдэл; хяналтын систем зохистой түвшинд хангагдаагүйгээс үүсэх эрсдэл зэрэг зүйлс орно.

Үнэт цаас гаргагчийн Үйл ажиллагааны хэлтэс болон Мэдээллийн аюулгүй байдлын алба хамтран эрсдэлийг тодорхойлон хянах боломжтой эсэхээр ангилан шалтгаан нөхцөлийг судалсны үндсэн дээр эрсдэл бий болгож буй үйл ажиллагааг зогсоох, эсвэл цар хүрээг хязгаарлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

СЗХ
2023.11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03



## 15.1.6. НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандарт алдагдах, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, компанийн засаглал, удирдлага менежментийн баг ёс зүй, мэргэжлийн хариуцлага алдах зэрэг асуудалтай холбоотойгоор Мерчант байгууллага, Хэрэглэгчид, олон нийтийн итгэлийг алдах эрсдэлүүдийг уг эрсдэлд авч үзнэ.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлээс сэргийлж ажилтнуудын дунд мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулах; аюулгүй байдлын хяналт, шалгалтыг тогтмол явуулах; албан тушаал, чиг үүргийн хүрээнд мэдээллийн нууцлал болон мэргэжлийн ёс зүйг хангаж ажиллахыг тусгасан гэрээ байгуулан ажиллаж байна.

## 15.1.7. ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРСДЭЛ

Сүүлийн жилүүдэд олон улсад хэрэгжиж буй технологийн боловсронгуй шийдлүүд Монгол Улсад олноор нэвтрэн санхүүгийн зах зээл дахь технологийн шийдэл, Үнэт цаас гаргагчийн үндсэн үйлчилгээтэй өрсөлдөхүйц, хүмүүсийн эрэлт шаардлагад нийцсэн төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж байгаа нь Хэрэглэгч, Мерчант байгууллагын тоо буурах, үүнийгээ дагаад борлуулалтын орлогод сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлүүд үүсгэх магадлалтай байна. Мөн иргэдийн амьдралын хэвшил өөрчлөгдөж, мэдлэг мэдээлэл илүү хурдацтайгаар тархах болсон өнөө үед Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхэлж буй салбарт бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд зах зээлд өрсөлдөөн нэмэгдэх магадлалтай байна.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлээс сэргийлж түнш байгууллагуудтай хамтын ажиллагаагаа чухалчилж, бүтээгдэхүүн үйлчилгээ бүртээ зохих шинжилгээ, сайжруулалтыг тогтмол гүйцэтгэж; Мерчант байгууллагуудад тогтмол тусламж, үйлчилгээ болон дэмжлэг үзүүлж, тусгай зөвшөөрлүүдийн шаардлагыг бүрэн хангаж зах зээл дах оролцогчид болон Хэрэглэгчдийн итгэлийг алдалгүй ажиллаж байна.

## 15.1.8. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд макро болон микро эдийн засгийн тогтворгүй байдал, хямрал сөргөөр нөлөөлөх боломжтой. Тухайлбал, дэлхийн төлбөр, тооцооны зах зээлийн борлуулалтын орлого 2020 онд КОВИД-19 цар тахлаас үүдэж 1.9 их наяд төгрөг болж өмнөх оноос 5 хувиар буурсан үзүүлэлттэй байсан нь эдийн засгийн идэвхжил буурсантай холбоотой. Үүнээс үзэхэд эдийн засагт оролцогчдын хэрэглээгээ танах үзэгдэл нь Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогод шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна. Дараах хүчин зүйлс нь Монгол Улсын эдийн засагт өндөр нөлөөлөлтэй байна.

Үүнд:

1. Валютын ханшийн тогтворгүй байдал;
2. Үнийн өсөлт, инфляц;
3. Ажилгүйдлийн түвшин;
4. Түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, нийлүүлэлт;
5. Төсөв, мөнгөний бодлого;
6. Хил гаалийн хорио, хязгаарлалт.

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөө арвижуулж, үндсэн болон үнэнч хэрэглэгчдээ алдалгүй ажилласнаар дээрх эрсдэлүүдийн нөлөөг бууруулах боломжтой байна.

## 15.1.9.БУСАД САЛБАРТ ГАРАХ ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагч нь онлайн худалдаа, банк санхүү, финтек, жижиглэн худалдаа, телефон сүлжээ зэрэг олон салбар дахь Мерчант байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг. Үүнтэй холбоотойгоор харилцагч Мерчант байгууллагуудад үүсэх аливаа нэгэн эрсдэлүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, борлуулалтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
5021031195 СТС2420

Андеррайтер

Тиймээс Үнэт цаас гаргагч нь Мерчантуудад зориулсан үйлчилгээгээрээ дамжуулан Мерчантуудын бизнесүүдэд анхаарч Мерчантын ангилал, хэрэгцээ тус бүрд нийцэх, найдвартай, хялбар, хурдан үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчаа халамжлах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

## 15.1.10. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛ

Байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан үйл ажиллагаа, эрчим хүч, интернэт доголдох эрсдэлийн нөлөөлөл нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Эдгээр эрсдэлүүдийг үнэлж, эрсдэлийн түвшинд тулгуурлан авах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

## 15.1.11. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Үнэт цаастай холбоотой татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийг татаж чадахгүй байх; зах зээлд гаргасан хувьцааны үнэ хэт хэлбэлзэх, буурах; арилжааны идэвх, хөрвөх чадвар муу байх; ногдол ашиг олгох эсэх зэрэг эрсдэлүүд хамаарна.

Компанийн үйл ажиллагаа, цаашдын хэтийн төлөвтэй холбоотой аливаа мэдээ, мэдээлэл олон нийтэд хүрэх тэр үед зах зээлийн зарчмаар хувьцааны эрэлт нэмэгдэж, нийлүүлэлт багасан хувьцааны ханш өсдөг бол үйл ажиллагаатай холбоотой таагүй мэдээлэл, тайлан муу гарах, зах зээлийн орчин нөхцөл өөрчлөгдөхөд эрэлт багассанаар зах зээлийн зарчмын дагуу нийлүүлэлтийн илүүдлээс үүдэлтэй ханшийн бууралт явагддаг.

Нээлттэй хувьцаат компани болсноор үнэт цаастай холбоотой дүрэм, журмуудыг мөрдөж, шаардлагатай шимтгэл хураамжийг төлөх, тайлан мэдээллийг цаг тухайд олон нийтэд хүргэж байхаар Үнэт цаас гаргагч нь төлөвлөн ажиллаж байна.

Ногдол ашигтай холбоотой шийдвэрийг ТУЗ гаргаж, ХЭХ-аар баталдаг бөгөөд ирээдүйд ногдол ашиг тараах, хөрөнгө оруулагчдын хүлээлтийг давуулан биелүүлэх зэрэгт Үнэт цаас гаргагч нь баталгаа өгөхгүй болно.

## 15.1.12. ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Хөрвөх чадварын эрсдэлд компани ирээдүйн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж чадахгүйгээс үүдэн санхүүгийн тогтвортой байдал алдагдах, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж чадахгүй болох эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагч нь өр төлбөр, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах ажилладаг. 2019-2022 онуудын байдлаар нийт хөрөнгөнд эзлэх өөрийн хөрөнгийн хувь дунджаар 90 хувьтай, нийт эргэлтийн хөрөнгийн 70 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлж, 2019 онд жилийн эцэст хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгө оруулалт мөнгөн хэлбэрээр байршиж байгаа нь Үнэт цаас гаргагч өр төлбөрөө зохих хугацаанд нь барагдуулж чадахгүй байх эрсдэл харьцангуй бага байгааг илэрхийлж байна.

## 15.1.13. ЗАРДАЛ ХЭТРЭХ ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд аливаа тоног төхөөрөмж, серверийн үнийн өсөлт, хор хөнөөлтэй программаас үүдэлтэй болон бусад гадны хүчин зүйлсээс хамааралтай үүсэх гэнэтийн эвдрэл, эсвэл Мерчант байгууллагуудтай холбоотой үүссэн томоохон асуудал зэрэг гэнэтийн төлөвлөгдөөгүй эрсдэлээс үүдэлтэйгээр төлөвлөсөн зардал их хэмжээгээр нэмэгдэх магадлалтай.

Энэ төрлийн эрсдэлүүд тохиолдох магадлалыг бууруулах зорилгоор Үнэт цаас гаргагч нь ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтнуудад үйл ажиллагааны болон мэдээллийн аюулгүй байдлын журам, хор хөнөөлтэй программаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг тогтмол өгч, хэрэгжилтэд хяналт тавьдгаас гадна мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагын нууцлал, аюулгүй байдлыг хангах олон улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

### 15.1.14. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ БИЕЛЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛ

Үүнд эдийн засгийн нөхцөл байдал муудах; зах зээлд Үнэт цаас гаргагчийн үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг орлох бүтээгдэхүүн, үйлчилгээ гарч ирэх; гадаад өрсөлдөгч Монгол Улсын зах зээлд нэвтрэх; хэрэглэгчдийн итгэлийг алдах зэрэгтэй холбоотойгоор борлуулалтын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл хамаарна.

Үнэт цаас гаргагч нь зах зээл дэх анхдагчийн давуу тал, байр сууриа бэхжүүлж, Түншүүд болон гол Мерчант байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, Хэрэглэгчдийн дунд үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таниулж чадсан ба өнгөрсөн хугацааны түүхэн мэдээллээс Qpay ашиглан төлбөр тооцоо хийх гүйлгээний тоо хурдацтай нэмэгдэж буй нь энэ төрлийн эрсдэлийн нөлөөллийг бууруулах томоохон хүчин зүйл болж байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй ажиллагааны олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь аливаа харилцагчдын мэдээлэл алдагдсанаар харилцагчдын итгэл алдах аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэхэд ихээхэн түлхэц үзүүлж байна.

### 15.1.15. СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ

Стратегийн эрсдэлд оновчтой бус төлөвлөгөө, стратегийг баталж хэрэгжүүлэх, гадаад орчны нөлөөллөөс үүдэлтэйгээр бизнес төлөвлөгөөг цаг тухайд нь биелэхгүй, хойшлогдох зэрэг эрсдэлүүд орно. Үнэт цаас гаргагч нь бизнесийн стратеги, төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэхэд урьдчилан тооцоолсон болон тооцоолоогүй эрсдэлүүд, эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалт, улс төрийн нөлөө зэрэг олон төрлийн хүчин зүйлс сөргөөр нөлөөлж болно. Эдгээр хүчин зүйлсийн улмаас ирээдүйн бизнесийн стратегийг хэрэгжүүлэх боломжгүй болох нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь дээрх эрсдэлийг бууруулахын тул тухайн жилийн стратеги төлөвлөгөөг батлахдаа өнгөрсөн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэн, тухайн жилд тавигдах үндсэн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, гарч болзошгүй эрсдэл, тэдгээрээс сэргийлэх төлөвлөгөө зэргийг харгалзан үзэж баталдаг.

### 15.1.16. КОМПЛАЕНС ХУУЛЬ ЗҮЙН ЭРСДЭЛ

Комплаенс, хууль зүйн эрсдэл нь хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шинэчлэлт, тэдгээрийг мөрдөж ажиллаагүйн улмаас хуулийн хариуцлага, нэр бүхий байгууллагын торгууль, шийтгэл хүлээх санхүүгийн бодит алдагдалд орох зэрэг эрсдэл хүлээхийг хэлнэ.

Үнэт цаас гаргагч нь санамсаргүйгээр эсвэл өөрийн хяналтаас гадуурх хүчин зүйлийн улмаас ирээдүйд хамаарах хууль тогтоомж, зохицуулалтын нөхцөл, үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлтэй. Түүнчлэн, эрх бүхий байгууллагаас Үнэт цаас гаргагчид нэмэлт шаардлага, хязгаарлалт болон зардал оноогдуулж болно. Эдгээр нөхцөл, үүрэг даалгаврууд нь Үнэт цаас гаргагчийн орлогыг хязгаарлахгүй, зардлыг нэмэгдүүлэхгүй, зардлын үр өгөөжид хүрэх нөөц, бололцоог бууруулахгүй гэсэн баталгаа байхгүй.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль,Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрддөг ба тус хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, нээлттэй зохицуулж, холбоотой дүрэм, журмуудыг батлах, шинэчлэх, дагаж мөрдөн ажиллаж байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь холбогдох эрх бүхий байгууллагуудаас Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьж буй холбогдох хуулийн төсөл, шийдвэрүүдийг тогтмол анхаарч, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, санал боловсруулан өгөх, хууль тогтоомжуудын өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж, даган мөрдөж ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь дээрх эрсдэлийн хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг батлан, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй бөгөөд тус бодлогын баримт бичигт заасны дагуу зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэх болох эрсдэлийг хамгийн бага түвшинд тогтоох, эрсдэлийг удирдах, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 15.2. Эрсдэлийн удирдлагын бодлого

Үнэт цаас гаргагч нь TechFin чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Information Technology (IT) компанийн хувьд эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал нь онцгой ач холбогдолтой байдаг. "Инновэйшн Инвестмент" ХХК нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийг таних, удирдах, бууруулах ажиллагааг группийн бүхий л түвшинд авч хэрэгжүүлж байна.

Түүнчлэн эрсдэлийн нөлөөлөл, тохиолдох магадлалын хүчин зүйлсийг харгалзуулсан эрсдэлийн удирдлагын матрицыг баталсан.

| Эрсдэлийн түвшин | | | Магадлал | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | Ховор | Магадгүй | Боломжтой | Өндөр | Байнга |
| Нөлөөлөл | 5 | Аюултай | 5 | 10 | 15 | 20 | 25 |
| | 4 | Өндөр | 4 | 8 | 12 | 16 | 20 |
| | 3 | Дунд | 3 | 6 | 9 | 12 | 15 |
| | 2 | Бага | 2 | 4 | 6 | 8 | 10 |
| | 1 | Ач холбогдолгүй | 1 | 2 | 3 | 4 | 5 |

*Схем 8. Үнэт цаас гаргагчийн Эрсдлийн тоон үнэлгээний матриц*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөө*

| Нөлөөлөл | | | | |
|---|---|---|---|---|
| | Их | Эрсдэлийг удирдаж хяна | Эрсдэлийг удирдаж, хянах нэн шаардлагатай | Эрсдэлийг зайлшгүй өргөн хүрээнд удирдах |
| | Дунд | Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөр | Эрсдэлийг удирдах хүчин чармайлт хэрэгцээтэй | Эрсдэлийг удирдаж хянах нэн шаардлагатай |
| | Бага | Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх | Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөр | Эрсдэлийг удирдаж хяна |
| Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх шугам | | Бага | Дунд | Их |
| | | Тохиолдох магадлал | | |

*Схем 9. Үнэт цаас гаргагчийн Эрсдлийн хариу арга хэмжээний үндсэн матриц*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

2023 .11. 08 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагч нь дээрх матрицад заасны дагуу гол эрсдэлүүдийг үзүүлэх нөлөөлөл, тохиолдох магадлалаар нь ангилан авч боломжтой арга хэмжээнүүдийг тогтоон хяналт тавин ажиллаж байна.Тус матрицын дагуу дараах үе шаттайгаар эрсдэлийг удирддаг.




*Схем 10. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын үе шатууд*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээг удирдан зохион байгуулж буй охин компани "ККТТ" ХХК нь өдөр тутмын үйл ажиллагаандаа"Мэдээллийн аюулгүй байдлын бодлого", "Галт ханын журам", "Лог бүртгэл хөтлөх, удирдах журам", "Хор хөнөөлтэй программаас хамгаалах журам", "Өөрчлөлтийн менежментийн тухай журам" зэргийг баримталж, гарч болох эрсдэлүүдээс сэргийлэн ажиллаж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

## 15.3. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Үнэт цаас гаргагчийн QPay төлбөрийн систем нь Олон улсын болон Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагын нууцлал, аюулгүй байдлыг ханган үйл ажиллагаагаа явуулж байна.

**Олон улсын стандарт**




*Схем 11. PCI DSS стандартын баталгаажилт хийлгэх үйл явц*

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Охин компани "КKTT" XXK нь Олон улсын төлбөрийн картын нууцлал, аюулгүй байдлыг хангах PCI DSS стандартыг 2020 оноос хойш амжилттай баталгаажуулсан. Энэхүү стандартын баталгаажилтыг БНЭУ-ын "SISA Information Security" байгууллагаар жил бүр хийлгэдэг.



QPay SISA

| | |
|---|---|
| **Name of Company** | KKTT LLC |
| **Certificate Number** | PCI/CSAQ-D/KKTT03822 |
| **Address** | #6, Shuren Building, Embassy street, 1st Khoroo, Sukhbaatar, Ulaanbaatar, Mongolia. |
| **Scope** | QPay Card Payment System |
| **Type of Certification** | PCI DSS SAQ-D v3.2.1 |
| **Category** | Service Provider |
| **Certification Status** | Active |

SISA PCI DSS SAQ Validated

**Disclaimer:**

SISA Information Security makes no representation or warranty as to whether the validated or certified company systems are secure from either an internal or external attack or whether cardholder data is at risk of being compromised. SISA Information Security makes no representations or warranties on the business activities or operations of the said company. Please contact the company displaying the seal if you have questions about their products, services or customer support.

Copyright © 2023 SISA. All Rights Reserved. info@sisainfosec.com

*Зураг 27. PCI DSS стандартын батламж, 2023 он*

Мөн 2022 оны 02 дугаар сард Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2013 стандартыг бүрэн нэвтрүүлж, ХБНГУ-ын Юниверсал GmbH байгууллагаар амжилттай баталгаажилтыг хийлгэсэн. Тус стандартын сертификат 3 жилийн хугацаатай байдаг ба жил бүр Магадлах аудит хийж нэг жилээр сунгадаг. Тус байгууллагаас 2023 оны 07 дугаар сард Магадлах аудит хийх төлөвлөгөөтэй байна.




*Схем 12. ISO 27001:2013 стандартын баталгаажилт хийлгэх үйл явц*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*



CERTIFICAT • CERTIFICADO • CERTIFICATE • CERTIFICATE • CERTIFIKAT

UNICERT

**INFORMATION SECURITY MANAGEMENT SYSTEM CERTIFICATE**

Universal GmbH

This certificate is granted to the organization,

**KKTT LLC**

**#6, Shuren Building, Embassy Street, 1st khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar city, Mongolia**

by review of IA2-16-7237 numbered report for the scope

**Payment Gateway**
**Statement of Applicability Doc. No:** A 21/0910
**Statement of Applicability Date / Rev. No:** 30.09.2021 / 1.0

to certify that a management system in accordance with standard's clauses is established and being implemented

**ISO/IEC 27001:2013**

**Certificate No** : ISMS 0622 009023
**Original Certification Date** : 30.06.2022
**Issue / Revised Date** : 30.06.2022
**Expiry Date** : 29.06.2023
**Certification Period** : 3 years (1st year)

IAF
DAkkS Deutsche Akkreditierungsstelle D-ZM-16058-01-00

*Зураг 28: ISO 27001:2013 стандартын батламж, 2021 он*

2023 11 08 өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 07 20
БҮРТГЭВ-03

## Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Үнэт цаас гаргагч нь Олон улсын стандартуудын баталгаажилт хийлгэхээс гадна системийн нууцлал, аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах болон системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хийх мэргэжлийн багийг бүрдүүлэн ажиллаж байна. Төлбөр тооцооны системийн найдвартай ажиллагааг хангах үүднээс үндсэн болон нөөц дата центрийг үүсгэж өөрийн сервер, тоног төхөөрөмжийг байршуулан ажилладаг.

Кибер халдлагаас хамгаалах зорилгоор хэрэглэгчийн чухал мэдээллийг зориулалтын төхөөрөмж (Банкууд ашигладаг HSM төхөөрөмж) ашиглан шифрлэлт хийж хадгалдаг. Мөн сүлжээний дэд бүтцийг тусгаарлах (network segmentation), сүлжээний галт ханыг байршуулан халдлагаас хамгаалах арга хэмжээг авсан.

Сервер, системийн хурд гүйцэтгэл, ачааллыг 24 цагийн турш хянах мониторингийн системийг ашигладаг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Үнэт цаас гаргагч нь дараах арга хэмжээг авч гүйцэтгэдэг. Үүнд:

1. Тогтвортой ажиллагааг хангах үүднээс Үнэт цаас гаргагч нь нөөц дата баазуудад серверээ хадгалдаг ба сервисүүдээ виртуалаар олон болгож үйлчилгээний ачааллыг бууруулдаг.
2. Үйлчилгээний ачаалал, алдааг мониторинг хийж, тухай бүр мерчант байгууллага банкнуудыг сүлжээний асуудлыг мэдсэн даруй, асуудлыг шийдвэрлэх процессын дагуу үйл ажиллагаагаа эрхэлдэг.

Ийнхүү Үнэт  цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тул дараах үндсэн зарчим, бодлогод суурилан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.Үүнд:

1. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлэхдээ мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг чандлан сахих;
2. "ККТТ" ХХК нь харилцагчийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлалтай байдлыг бүрэн хангаж, зөвшөөрөлгүй этгээдэд дамжуулах, алдагдах эрсдэлээс бүрэн хамгаалах;
3. Харилцагч, хэрэглэгчийн хүлээлт, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг 99.8 хувьд хүргэсэн;
4. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд олон улсын сайн туршлага, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог /ISO27001:2013/ компанийн хэмжээнд оновчтой нэвтрүүлж, мөрдөн ажиллах;
5. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, гадаад болон дотоод аудитыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэх;
6. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжилт, үр дүнг жилд хамгийн багадаа нэг удаа тооцож сайжруулалт хийдэг байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Андеррайтер

# 16. Хүний нөөцийн бодлого

“Инновэйшн Инвестмент” ХХК нь 2022 оноос эхлэн группийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийг сайжруулан баталж, хэрэгжүүлж байгаа бөгөөд уг баримт бичгүүд нь бүх охин компаниудад ижил үйлчилдэг.



Зураг 29. Үнэт цаас гаргагчийн баг хамт олон, 2022 он

## 16.1. Хүний нөөцийн бодлогын үндсэн зорилго

Хүний нөөцийн бодлогын үндсэн зорилго нь компанийн Эрхэм зорилго, Алсын хараа, Стратегийн зорилго, зорилтууд, бизнесийн үндсэн чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, идэвхжүүлэх, хүний нөөцийн манлайллыг хангах, хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад оршино.

Хүний нөөцийн бодлогын үндсэн зорилтууд:

- Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх;
- Хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх;
- Удирдлагын манлайллыг хангаж, карьер хөгжлийн тогтолцоог бүрдүүлэх;

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хүрээнд дараах үндсэн зарчмуудыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Шударга ёс, ил тод, тэгш байдлыг эрхэмлэх
- Үл ялгаварлан гадуурхах,
- Жендерийн тэгш байдлыг эрхэмлэх;
- Хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах,
- Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах,
- Дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид байх;
- Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох;
- Мэрит тогтолцоо, мэргэшсэн тогтвортой байдлыг бий болгох;
- Сурч хөгжих боломжийг олгох;
- Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ урамшууллын тогтолцоог бий болгох.

## 16.2. Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт

Үнэт цаас гаргагч нь Хүний нөөцийн төлөвлөлт гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар батлуулж ажилладаг ба уг төлөвлөлтөд компанийн стратегийн зорилтуудад нийцүүлж, бүх шатны алба, хэлтсийн удирдлагуудын оролцоог хангаж ажиллана. Хүний нөөцийн төлөвлөлт дараах үе шатуудтай байна. Үүнд:

1. Компанийн хүний нөөцийн өнөөдрийн бодит байдлыг үнэлж тодорхойлох;
2. Ирээдүйн зорилго ба стратегийг тодорхойлох;
3. Санхүүгийн нөөц боломжийг тогтоох;
4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, аргачлалыг тогтоох. Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн төлөвлөлтөө богино, дунд, урт хугацаагаар (3-5 жилээр) төлөвлөн, Гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтэд хяналтыг тавих.

Үнэт цаас гаргагч　　　　Андеррайтер

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцөө бүрдүүлэхдээ ажлын байрны шинжилгээнд үндэслэн ажлын байр тус бүрийн гүйцэтгэлийн жишиг үзүүлэлтүүд (KPI)-ийг үндэслэн ажлын байрны тодорхойлолтод нийцсэн шалгуур бүхий ажлын байрны зарыг нийтэд нээлттэй зарлан ажилтан авахаас гадна компани дотроос тухайн албан тушаалд дэвшиж, сонгогдон ажиллах боломжийг олгоно. "Инновэйшн Инвестмент" ХХК болон охин компаниуд нь дээрх зарчмаар ажилтан сонгон шалгаруулахдаа мэрит зарчмыг баримталдаг ба хүний нөөцтэй холбоотой шийдвэрийг ил тод, батлагдсан бодлого, журамд нийцүүлэн гаргаж, ажилтнуудын хувьд таатай, баталгаатай нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлэн ажилладаг юм.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь жендерийн тэгш байдлыг баримталж ажиллахын зэрэгцээ нийгмийн хариуцлагын хүрээнд боломжит ажлын байрууд дээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажиллах нөхцөл боломжуудыг олгодог. Статистик үзүүлэлтээс харвал компани нь нийт 32 ажилтантайгаас 50 хувь нь эмэгтэй ажилтан, 50 хувь нь эрэгтэй ажилтнаас бүрдэх бөгөөд дундаж наслалт нь 34, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан 1 байна. Энэхүү үзүүлэлтүүдээс харахад Үнэт цаас гаргагч нь жендерийн тэгш байдлыг хангасан, нийгмийн хариуцлагатай, харьцангуй залуу хамт олонтой байна.



*Зураг 30-1. Үнэт цаас гаргагчийн баг хамт олон, 2022 он*



*Зураг 30-2. Үнэт цаас гаргагчийн баг хамт олон, 2022 он*

СЗХ 2023.11.08 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ...CHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

**Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн хүйсийн харьцаа**




*График 1. Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн хүйсийн харьцаа, 2023 он*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*




*График 2. Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн өсөлтийн үзүүлэлт, хувиар, 2014 - 2023*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

2023.11.08
он сар өдөр
СЗХ БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 16.3. Сургалт хөгжил

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн чадавхыг сайжруулах тал дээр анхаарч ажилладаг бөгөөд компанийн зорилго, зорилтуудаа хүрэхэд ажлын байр тус бүр дээр шаардлагатай мэдлэг, ур чадварын хэрэгцээ буюу Ур чадварын матрикс тодорхойлж, түүнд суурилсан сургалт хөгжлийг төлөвлөн ажилладаг. Сургалтын хэрэгцээг илрүүлэхдээ ажилтнуудын ур чадварын үнэлгээг жилд нэг удаа гүйцэтгэж, ажилтан тус бүрийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг тухайн ажилтантай хамтран гаргаж, сургалт хөгжлийн бодлогоор дэмжин ажиллана. Ажилтнуудын сургалт нь:

- Мэргэжлийн сургалт;
- Ерөнхий ур чадварын /Хувь хүний хөгжлийн сургалт гэсэн 2 үндсэн агуулгатай байна.

Үнэт цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй байдлын, төслийн удирдлагын зэрэг олон улсын сертификат олгох сургалтын хөтөлбөрүүдэд мэргэжилтнүүдээ үе шаттайгаар хамруулдаг ба 2022 онд батлагдсан хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтан бүр багадаа 20 цагийн сургалтад хамрагдах бөгөөд түүний 70 хувийг гадаад сургалт байхаар төлөвлөөд байна.

## 16.4. Уян хатан ажлын байрны нөхцөл

Үнэт цаас гаргагч нь 21 дүгээр зууны технологийн шийдлүүдийг бүрэн нэвтрүүлсэн TechFin компанийн хувьд ажилтнууддаа зайнаас болон уян хатан цагийн нөхцөлөөр ажиллах боломжийг бүрдүүлж ирсэн. Группийн хэмжээнд ажилтнууд өөрсдийн хүсэлтээр аль ч компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт оролцож ажиллах боломжтой бөгөөд шинэ ажлын байр, албан тушаалд групп дотроо шилжих уян хатан бодлоготой.

Технологийн, тэр дундаа TechFin, Финтек салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд асар хурдтай хөгжиж буй энэ үед компанийн хүний нөөцийн хурдтай, уян хатан, хөрвөх чадвартай байх нь компанийн оршин тогтнох, өргөжих, манлайлахад нэн чухал хүчин зүйл болсон. Иймд "Инновэйшн Инвестмент" ХХК нь уг зарчмыг баримтлан ажилтнууддаа хөрвөх чадвартай, уян хатан ажиллах ур чадвартай байх шаардлагыг тавьдаг. Үүний үр дүнд ажилтнууд нь цаг алдалгүй мэргэшил, чадвараа дээшлүүлж, төрөл бүрийн төсөл дээр ажиллаж туршлагаа нэмэгдүүлэхээс гадна Группийн бүхий л компаниуд нэгэн жигд хурдаар өсөж хөгжих нөхцөл бүрдсэн.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031795 СТС2420

Үнэт цаасны танилцуулга
2023.11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

# 17. Маркетингийн бодлого

“Инновэйшн Инвестмент” ХХК нь Алсын хараа болон Эрхэм зорилго, Үнэт зүйлс, бизнесийн үзэл баримтлалтайгаа уялдуулсан нэгдсэн маркетингийн бодлогыг группийн хэмжээнд хэрэгжүүлж байна. Уг бодлого нь Нэгдмэл (integrated), Цогц (holistic), Харилцан уялдаатай (relationship) байх зарчимтай.

Үнэт цаас гаргагчийн маркетингийн бодлого нь маркетингийн иж бүрдлийн элементүүдэд тулгуурласан (бүтээгдэхүүн, борлуулалт, идэвхжүүлэлт зэрэг маркетингийн уламжлалт үндсэн иж бүрдлийн элементийн хүрээнд) байна. Үнэт цаас гаргагч нь уг бодлогыг боловсруулахдаа бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал, өвөрмөц шинж чанар, үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдал болон Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдал, чадамжийг үнэлсний үндсэнд боловсруулсан. Цаашид мөн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхэд боломжит болон зорилтот зах зээлийн хэрэгцээ, хэрэглээний шинж чанар, хэрэглэгчийн үнэт чанарыг харгалзан зохих маркетингийн бодлогыг боловсруулж ажиллах болно.

## 17.1. Маркетингийн бодлогын зорилтууд

| | Passionate<br>Тэмүүлэлтэй | Empathy<br>Хүнлэг | Well-Balanced<br>Сайн хамтрагч | Expert<br>Эксперт |
|---|---|---|---|---|
| Бүтээгдэхүүн үйлчилгээ | Шинэлэг, содон, инновацлаг шийдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээр зах зээлд хүсэл тэмүүлэлтэй, шинийг санаачлагч гэх имижийг бүрдүүлнэ. | Харилцагчийн хүсэл шаардлагад нийцсэн, хялбар шийдлүүдийг бий болгоно.<br><br>Digital empathy | Харилцагчаа сонсдог,<br>Шаардлага, санал, хүсэлт, сонирхлыг нь бүтээгдэхүүнд шингээнэ. | Экспертүүдийн хөгжүүлсэн чанар, баталгаатай бүтээгдэхүүнүүд бий болгоно. |
| Ажилтнууд, удирдага, хувь оролцоо | Урам зориг өгөхүйц дотоод коммуникац хэрэгжүүлнэ. | Тэгш оролцоог дэмжиж, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, харилцан хүндлэл дээр тулгуурласан соёлыг бүрдүүлнэ.<br>Соёлын хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ. | Оролцогч талуудад харилцан өгөөжтэй бизнес модел хөгжүүлсэн байна. | Ёс зүй, хариуцлага, итгэлцэл,<br>залгамж халаатай байна. |
| CSV commu-nity<br>(Consumer Value Stores) | ESG холбоотой кампанит ажлууд гүйцэтгэнэ. | Нийгмийн дуу хоолой болсон кампанит ажлууд зохион байгуулна. Арга хэмжээнүүдэд оролцоно. | Хамтын үнэ цэнийг хамтдаа бүтээнэ. | Салбарын манлайлал<br>Үлгэр жишээ<br>Менторшип байна. |

*Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн маркетинг бодлогын зорилтууд*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

## 17.2. Маркетингийн албаны үндсэн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн маркетингийн алба нь Бизнес хөгжлийн хэлтэс хамаардаг бөгөөд доорх үүрэгтэй:

- Корпорэйт брэндийг хариуцах, брэнд стратегийн хэрэгжилтийг гүйцэтгэх, үнэлгээ хяналт тавих, процессыг тодорхойлох;
- Брэндийн үнэлгээг жил бүр тогтмол хийх;
- Маркетинг албаны гүйцэтгэл, үр дүнгийн тайлан боловсруулах;
- Визуал ялгарлыг тодорхойлох, брэндбүүк хөгжүүлэх, сайжруулах;
- Тодорхойлогдсон брэнд архитектурыг мөрдөн ажиллах;
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон коммуникац хоорондын уялдааг бий болгох;
- Touchpoints буюу коммуникац түүлүүдийг бэлэн байлгах, хөтлөх гарын авлагыг боловсруулах;
- Судалгаа гүйцэтгэх,  Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх ажилд оролцох;
- Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг эцсийн хэрэглэгчдэд таниулан сурталчилж харилцагчдыг татах;
- Мерчант, Түнш байгууллагууд болон Харилцагчдыг холбох.

## 17.3. QPay үйлчилгээний маркетинг

QPay үйлчилгээг зах зээл дээр хэрэглэгчид болон хамтрагчид дараах байдлаар дүгнэдэг.




*Зураг 31. QPay үйлчилгээг тодорхойлох нь, давтамж-хэмжээгээр эрэмбэлэв*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн судалгаа*

СЭХ 2023 11 08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн хугацаанд Мерчант болон Түнш байгууллагуудтай хамтран QPpay төлбөрийн системийн идэвхжүүлэлт сурталчилгааны ажлуудыг гүйцэтгэж ирсэн. Энэ нь Qpay үйлчилгээг тухайн Мерчант болон Түншийн хүсэмжит имиджид нийцүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Арилжааны банкнуудын хувьд өөрсдийн өнгө, лого, дизайн бүхий QR код хэвлэх боломжтой байдаг. Qpay үйлчилгээг анх зах зээлд нэвтрүүлснээс хойш өнөөдрийн байдлаар нийт 180,000 орчим статик QR кодыг улс даяар холбож нэвтрүүлэн, 7,300 гаруй мерчант байгууллагатай системийн түвшинд холболт хийн тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.




*Зураг 32. Харилцагч Арилжааны банкнуудын QPay QR кодын дизайн*

СЗХ
2023.11.08
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-21
БҮРТГЭВ-03

# 18. Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого

“Инновэйшн Инвестмент” ХХК нь бүх шатны үйл ажиллагаандаа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг 2020 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Үнэт цаас гаргагч нь өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгох; дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагаа явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах; тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.




*Зураг 33. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтууд - 2030*

*Эх сурвалж: НҮБ*




## 18.1. Байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн тухай

“Инновэйшн Инвестмент” ХХК-аас үзүүлдэг QPay үйлчилгээ нь цахим төлбөрийн хэрэгслийг хялбар болгож, QR төлбөр тооцоог хүн бүрд нээлттэй болгон ойртуулсан билээ. Энэхүү үйлчилгээний нөлөөллөөр Хэрэглэгчид банкны урт дараалалд зогсолгүй цахим QR гүйлгээгээр төлбөрөө гүйцэтгэх болсон. Хэрэглэгчийн тоо нэмэгдэх хэрээр цаг хугацаа, шаардлагагүй зардал болон хог хаягдал буурж, бүх талуудын сэтгэл ханамж өсөж байна.

Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл QPay үйлчилгээ нь 5 жилийн хугацаанд зөвхөн төрийн үйлчилгээний хувьд 4,340,000 ширхэг цаас хэмнэснээр 564 мод, 2.1 тонн ус, 13.1м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлснээс хойш доорх хэмнэлтүүдийг бий болгож цахим төлбөр тооцооны шинэ соёлыг нэвтрүүлжээ. Үүнд:

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
6183858
9021031195 СТС2420

Андеррайтер

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Төрийн үйлчилгээнд** | **4,340,000** Ширхэг цаас | **564** Мод | **2,1** тонн Ус | **76,1** m3 CO2 ялгаруулалт |
| **Нийт QPay үйлчилгээнд** | **63,300,000** Ширхэг цаас | **7700** Мод | **32,06** тонн Ус | **2181,2** m3 CO2 ялгаруулалт |

*График 3. QPay үйлчилгээний байгаль, хүрээлэн буй орчинд үүсгэж буй эерэг нөлөөллийн тооцоолол*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

## 18.2. Нийгэм, эдийн засаг дахь нөлөөлөл тухай

8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH
9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE

"Инновэйшн Инвестмент" ХХК нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд дараах хувь нэмрийг оруулжээ.

- Амьдралын хэв маягийг хялбар, аюулгүй болгох: QPay үйлчилгээ нь олон улсын төлбөрийн системүүдтэй холболт хийгдсэнээр гадаад улсад суралцагч оюутан залуус болон аялагч, бизнес эрхлэгч Монгол Улсын иргэд бэлэн мөнгөөр гүйлгээ хийх шаардлагагүй болж бэлэн мөнгөтэй болон мөнгөн гүйвуулгатай холбоотой гарч буй гэмт хэргийн тоог бууруулах боломжийг бүрдүүлсэн.
- Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах хөтөлбөрийг дэмжих: Төрөөс үзүүлж буй бүхий л үйлчилгээний төлбөрийг үйлчилгээг ашиглан шимтгэлгүйгээр, хурдан, хялбараар гүйцэтгэх боломжтой болсон нь иргэд болон төрийн албаны цагийг хэмнэж, ачааллыг бууруулсан шийдэл болсон.
- Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих: Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор стикер QR кодыг ашгийн төлөө худалдалгүй, үнэгүй хэвлэн тарааж өгсөн. Мөн Мерчантууд нь бүртгэлийн хураамжгүйгээр QPay Мерчант аппликэйшн эсвэл вэб хуудаст хандан бүртгүүлэн орлогын мэдээлэл, гүйлгээний түүхээ үзэх боломжтой байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд УИХ-ын сонгуулийн нэр дэвшигчийн хандивын эх үүсвэрийг нээлттэй тодорхойлох боломжтой тусгай QR гүйлгээг нэвтрүүлсэн.

## 18.3. Байгууллагын засаглал

5 GENDER EQUALITY
10 REDUCED INEQUALITIES

"Инновэйшн Инвестмент" ХХК нь байгууллагын засаглалын тогтвортой байдалд дараах үзүүлэлтүүдийг баримталж байна.

- Үнэт цаас гаргагч нь группийн хэмжээнд ажилтнууд жендерийн эрх тэгш харьцаатай байж бие биеийнхээ эрх, үүрэг, харилцааг хүндлэн ажиллах соёлтой байхыг дэмждэг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед хүйсийн харьцаа 50:50 байна.
- Үнэт цаас гаргагч нь засаглалын хүрээнд удирдлагын бүтэц, зохион байгуулалт, бодлого, тогтолцоонуудыг оновчтой, зөв зохистой, болгон бүрдүүлж хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд нэн тэргүүнд үнэн, зөв мэдээллээр удирдлагыг цаг алдалгүй хангаж, шийдвэр гаргалтыг бодитой, оновчтой, шуурхай, зөв зохистой болгох механизмыг бүрдүүлж, ил тод, нээлттэй, өндөр хариуцлагатай гүйцэтгэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгон бэхжүүлэх чиглэлээр сайжруулалт хийн ажиллаж байна.
- Үнэт цаас гаргагч нь цалин, урамшууллын тогтвортой байдлыг хангахын тулд ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмыг бэлтгэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- Мэдээллийн аюулгүй байдлын чанарыг сайжруулж дотоод үйл ажиллагаандаа ISO:27001 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд харилцагчийн мэдээллийг хамгаалах найдвартай байдлыг хангах зорилгоор олон улсын төлбөр тооцооны хэрэгсэлд тавигддаг PCI:DSS стандартыг нэвтрүүлээд байна.

Үнэт цаас гаргагч                    Андеррайтер

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

INNOVATION INVESTMENT

2023-07-20
БҮРТГЭВ-03

## 18.4. Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн цаашдын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь Тогтвортой хөгжил, нийгэм, байгаль орчны нөлөөллийн бодлогын хүрээнд дараах гурван чиглэлийг баримталж, зохих хөтөлбөр, журам, шийдэл хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна:

E – Байгаль орчин:

- Цахим төлбөрийн хэрэгслийн хэрэглээг сурталчлан Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлснээр байгаль орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах;
- Байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилго бүхий төслүүдэд хөрөнгө оруулах, үйл ажиллагааг дэмжих;
- Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хог хаягдлыг ялгах зуршлыг бий болгох;
- Байгууллагын усны хэрэглээг багасгах шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний шийдлийг ашиглах, бусдыг уриалах.

S – Нийгэм, эдийн засаг:

- Нийгэмд чиглэсэн эерэг үйл ажиллагаа болон төслүүдийг дэмжин ажиллах;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажлын байр бий болгох;
- Байгууллагын ажлын байрны тоог тогтвортой өсгөх бодлого баримтлах;
- Төрийн үйлчилгээний төлбөрийн шийдлийг улам хялбар болгох, хэрэглээг нэмэгдүүлэх.

G – Засаглал:

- Байгууллагын ажилтны жендерийн харьцаа болон эрхийн тэгш байдлыг хадгалах;
- Харилцагчид болон түнш байгууллагуудын харилцааг бэхжүүлэх арга хэмжээ авах;
- Байгууллагын тогтвортой хөгжлийн тайлан гаргах

## 18.5 Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл

Үнэт цаас гаргагч нь байгаль орчин нийгэм засаглалын тогтвортой хөгжлийн бодлого болон нийгмийн хариуцлагын хүрээнд 2022 оны 08 дугаар сард Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо болон "Бөмбөрцгийн Сүмбэ Хүүхдийн Байгууллага" төрийн бус байгууллагатай хамтран "АЮУЛЫГ АВДАРЛАЯ" төслийг орон даяар амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн зорилго нь хүн болоод амьтан, ус ургамалд нэвчсээр байгаа хавдар, харшил зэрэг олон өвчний суурь шалтгаан болж аюулын харанга дэлдэж буй байгальд шингэдэггүй тамхины ишний талаарх мэдээллийг хүн бүрд хүргэх, түүний аюулыг багасгахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн. Тамхины хэрэглээнээс гадна бидэнд чимээгүй аюулыг бий болгож буй тамхины ишний хог хаягдлын хор хөнөөлийн талаар тэр бүр иргэд болон байгууллагууд мэддэггүй. Иймээс энэхүү мэдлэгийн түгээх, аюулыг багасгах зорилгоор энэхүү төсөлд "Инновэйшн Инвестмент" ХХК нь ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон. Төслийн хүрээнд 21 аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын газруудаар дамжуулан 330 суманд мэдээлэл болон сурталчилгааны самбаруудыг хүргүүлсэн бөгөөд иргэдийн дунд орчны тамхины ишний хог хаягдлыг бууруулах уралдаан зарлагдаж амжилттай өндөрлөсөн.

Уг уралдааны үеэр нийт 9,012 ширхэг 0.5 эзлэхүүнтэй сав дүүрэн янжуурын ишний хогийг цэвэрлэсэн бөгөөд 0.5л саванд 375 ширхэг янжуурын иш ордог гэж тооцвол 3,379,500 ширхэг ишийг байгаль орчин бохирдохоос сэргийлсэн устгаж чадсан байна. Олон улсын эрдэмтдийн судалгаанаас үзэхэд 1ш иш 1,000л ус бохирдуулдаг гэсэн баримт бий. Үүний дагуу тооцоолбол Үнэт цаас гаргагч нь энэхүү төслийн хүрээнд 3,379,500,000 ( гурван тэрбум гурван зуун далан есөн сая таван зуун мянган) литр усыг бохирдохоос хамгаалсан байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 ... 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Андеррайтер

СЗХ 2023.07.20 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

# 19. Үнэт цаас гаргагчийн эрх зүйн байдал

## 19.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөгддөг хууль тогтоомж

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуулиудыг, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт бичгүүдийг дагаж мөрдөж байна.

Мөн Үнэт цаас гаргагчийн охин компани болох “КKTT” XXK нь төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн хувьд Монголбанкнаас баталсан дараах журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Төлбөрийн системийн журам, 2023
- Төлбөрийн системийн хяналтын бодлого, 2021;
- QR кодын мессежний бүтэц, заавар, 2022;
- Төлбөрийн системийн тайлан гаргах заавар, 2019;
- Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл, 2022;
- Зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл, 2021.

Үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаас буюу хувьцаагаа нийтэд анх удаа санал болгон хувьцаат компани хэлбэртэй болж өөрчлөгдсөн тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-оос батлан гаргасан үнэт цаас гаргагч болон хувьцаат компанийн дагаж мөрдөх холбогдох хуульчилсан актууд, МХБ-ээс батлагдан гарсан холбогдох дүрэм, журам, зааврыг дагаж мөрдөн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

## 19.2. Лиценз, Тусгай зөвшөөрөл

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасыг нийтэд анх удаа санал болгох өдрийн байдлаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан аливаа тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй болно.

Үнэт цаас гаргагчийн охин компани болох “КKTT” XXK-д төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-291 дугаар тушаалаар, хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А-139 дугаар тушаалаар, аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-358 дугаар тушаалаар тус тус олгосон. Хуулийн зөвлөхийн дүгнэлтэд уг тусгай зөвшөөрлүүд нь цуцлагдах үндэслэл байхгүй байна хэмээн дүгнэсэн байна.

Мөн “КKTT” XXK нь өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан “QR code-оор мэдээлэл солилцох программ” нэртэй программ хангамжийн бүтээлийн зохиогчийн эрхийн гэрчилгээг эзэмшдэг болно.

## 19.3. Патент, оюуны өмчийн эрх

Үнэт цаас гаргагч “Инновэйшн Инвестмент” XXK нь Оюуны өмчийн тухай хууль болон түүнд нийцүүлэн батлагдан гарсан Патентийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн хүрээнд оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт эзэшдэггүй болно.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ XXK УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК XXK СТС2420

СЗХ
2023 . 11 сар 6 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

## 19.4. Өр төлбөр

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаа нь татварын холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хууль тогтоомж зөрчсөн, татвар төлөх үүргээ биелүүлээгүй үндэслэлээр эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шаардах хуудас, эсвэл акт, шийтгэврийн хуудас байхгүй, татвар болон нийгмийн даатгалын өр төлбөргүй талаар Хуулийн дүгнэлтэд тусгасан байна.

## 19.5. Гэрээ, хэлцэл

### 19.5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Энэ хэсэгт Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан Компанийн тухай хуулийн 89-р зүйлд заасан сонирхлын зөрчилтэйд тооцогдох хэлцлүүдийг Хуулийн дүгнэлтийг үндэслэн хураангуй байдлаар тусгалаа. Хуулийн дүгнэлтэд сүүлийн 3 жил гэдгийг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон авч дүгнэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь дээрх хугацаанд сонирхлын зөрчилтэйд тооцогдох 5 (таван) хэлцэл байгуулсан ба эдгээр сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журам болон Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ (ХЭХ)-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна. Энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар сонирхлын зөрчилтэй 5 хэлцлийн 1 нь хэрэгжиж дууссан, 4 нь аливаа зөрчил маргаан гаргаагүй, хэвийн хэрэгжиж байна. Уг хэлцлүүдийн тухай голлох ач холбогдол бүхий мэдээллийг дараах хүснэгтэд тусгав.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031185 СТС2420

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 03

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Юнимедиа Солюшнс" ХХК | "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02/10 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажил үйлчилгээг "Пнимедиа Солюшнс" ХХК үзүүлэх, түүнтэй холбоотой хөлс төлөхтэй холбоотой харилцаар зохицуулсан 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 20/26 тоот хамтран ажиллах гэрээ талууд байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 2 | "ККТТ" ХХК | "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/14 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу компанид менежмент, удирдлага, мэргэжлийн зөвлөгөө өгөх, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцаар зохицуулсан Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг "ККТТ" ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 3 | Б.Чулуунсүх | "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/13 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу компанийн нийтэд хувьцаагаа санал болгохтой холбоотой ажилд туслах, зөвлөх, компанийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудалд зөвлөх үйлчилгээтэй холбоотой үүссэн харилцаар зохицуулахаар Зөвлөх үйлчилгээний гэрээг Б.Чулуунсүхтэй 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 4 | "ККТТ"ХХК, "Юнимедиа Солюшнс" ХХК | 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ХЭХ-ын 23/07, 23/04 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу "Опцион эрх шилжүүлэх гэрээ"-г 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж дууссан |
| 5 | Б.Энхболд | "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/15 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу 10,000,000 төгрөгийг 24 сарын хугацаатай зээлэх, зээлийг тогтоосон хугацаанд хүү, шимтгэлийн хамт буцаан төлөхтэй холбоотой харилцаар зохицуулсан Зээлийн гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

*Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл*

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс харна уу.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
2023 11 08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

### 19.5.2. Их хэмжээний хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 87-р зүйлд зааснаар Их хэмжээний хэлцэлд компанийн сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлүүд хамаардаг бөгөөд компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн актив, түүнд ногдох их хэмжээний хэлцлийн үнийн дүн нь дараах байдалтай байна.

- 2020 оны хэлцэл - 581,305,895.25 төгрөгөөс дээш (2019 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 2,325,223,581)
- 2021 оны хэлцэл – 513,570,250 төгрөгөөс дээш (2020 оны санхүүгийн тайлан нийт 2,054,281,000)
- 2022 оны хэлцэл - 808,510,000 төгрөгөөс дээш (2021 оны санхүүгийн тайлан нийт 3,234,040,000)
- 2023 оны хэлцэл – 1,689,021,750 төгрөгөөс дээш (2022 оны санхүүгийн тайлан нийт 6,756,087,000)

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох аливаа гэрээ байгуулаагүй хэмээн хууль зүйн дүгнэлтэд тусгагдсан байна.

## 19.6. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 3 (гурав) удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүнг хууль зүйн дүгнэлтэд заасны дагуу дурдсан байдлаар үзүүлэв.

| № | Улсын бүртгэлийн гэрчилгээ / хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа/ | 2019.03.28-2019.11.13 | 2019.11.14-2019.12.11 | 2019.12.12 - одоог | 2023.06 сараас доош |
|---|---|---|---|---|---|
| | Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөгөөр/ | 1,501,000,000 | 2,501,000,000 | 3,501,000,000 | 3,928,900,000 |
| | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь / төгрөгөөр/ | 75,050,000 | 125,050,000 | 175,050,000 | 196,445,000 |

*Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтүүд, түүний 5 хувьтай тэнцэх дүн*

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ байгуулаагүй хэмээн хууль зүйн дүгнэлтэд тусгагдсан байна.

## 19.7. Үнэт цаас гаргагчийн опцион эрхийн хэлцэл

Үнэт цаас гаргагч нь 2018 онд опцион эрх гаргаж 2023 онд хэрэгжүүлсэн бөгөөд уг үйл ажиллагаатай холбоотойгоор байгуулагдсан гэрээнүүдийн мэдээллийг дор тусгалаа. Гэрээнүүдийн талаар дэлгэрэнгүй дүгнэлттэй Хуулийн дүгнэлтээс танилцана уу.

Үнэт цаас гаргагч нь бизнесээ өргөжүүлэх зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр "Юнимедиа Солюшнс" ХХК-тай хамтрах, компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах тухай гэрээ байгуулсан. Энэхүү гэрээ болон 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан нэмэлт өөрчлөлтийн гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хурлын "Зарласан боловч гаргаагүй хувьцаанаас "Юнимедиа Солюшнс" ХХК-д эзэмшүүлэх опцион нөхцөлийг тогтоох, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай" 22/05 тоот шийдвэрээр Компанийн зарласан боловч гаргаагүй 52,126,000 (тавин хоёр сая нэг зуун хорин зургаан мянга) ширхэг хувьцаанаас "Юнимедиа Солюшнс" ХХК-д 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг хувьцааг ширхэг бүрийг 96.40 (ерэн зургаан төгрөг дөчин мөнгө) төгрөгийн үнээр хэрэгжүүлэх эрх бүхий опцион эзэмшүүлэхээр тохиролцсон.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
INNOVATION INVESTMENT
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

Тус 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг опционыг "Юнимедиа Солюшнс" ХХК нь Компанийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдахаар болж, худалдан авагч тал нь "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн охин компани болох "ККТТ" ХХК болсон ба 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Опцион эрх шилжүүлэх гэрээ"-гээр опционыг шилжүүлэхээр болсон. Энэхүү Опцион эрх хэрэгжүүлэх гэрээгээр опцион эрхийг нэгж хувьцаанд 76.00 (далан зургаа) төгрөг байхаар тохиролцож, нийт 17,116,000 ширхэг опционыг нийт 1,300,816,000 (нэг тэрбум гурван зуун сая найман зуун арван зургаан мянга) төгрөгөөр үнэлсэн.

2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ХЭХ-ын 23/07, 23/04 тоот тогтоолуудаар тус тус "Юнимедиа Солюшнс" ХХК нь өөрийн эзэмшиж буй 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг опционыг нийт 1,300,816,000 (нэг тэрбум гурван зуун сая найман зуун арван зургаан мянга) төгрөгөөр "ККТТ" ХХК-д худалдах, шилжүүлэхийг зөвшөөрч, үүнтэй холбоотой компанийн дүрэмд өөрчлөлт оруулан 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байна.

Тус опцион эрхийг "ККТТ" ХХК нь хэрэгжүүлж, Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/02 дугаартай шийдвэрийн дагуу толгой компанийн нэмж гаргасан 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг хувьцааг эзэмших болсон.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/14 дугаартай шийдвэр, "ККТТ" ХХК хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/03 дугаартай шийдвэрийн дагуу "ККТТ" ХХК нь эзэмшиж эхэлсэн 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг хувьцаанаасаа 9,244,458 (есөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун тавин найм) ширхэг хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн болно.

## 19.8. Үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх зохицуулалт, журмууд

Үнэт цаас гаргагч нь МХБ-ээр дамжуулан өөрийн хувьцаагаа олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд Компанийн тухай хуулийн 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82-р зүйлүүдэд заасан болон СЗХ-ны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн Засаглалын Кодекс"-т заасан хэм хэмжээнүүдийг дагаж мөрдөнө.

### 19.8.1. Компанийн засаглалын кодекс

2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр СЗХ-ны 145 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс" нь компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, жишиг туршлагуудыг нэвтрүүлэх, компани болоод хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгын хүрээнд дагаж мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг юм. Компанийн засаглалын кодекс (цаашид "Кодекс" гэх)-т тусгагдсан үндсэн 9 (ес) зарчмын хүрээнд ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрх зэрэг асуудлуудтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцоо, тэдгээрийг харилцан хянах механизм, түүнчлэн компанийн зорилго, зорилтыг тодорхойлох, үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдүүдийн бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм.

**Компанийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, бодлогыг баримт бичиг:**

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
- Компанийн дотоод журам (Санхүүгийн үйл ажиллагааны тухай);
- Компанийн ногдол ашгийн бодлого;
- Дотоод хяналтын журам;
- Хөдөлмөрийн дотоод журам.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-07-20

Кодексийн хүрээнд компанийн хэлбэрийг "хязгаарлагдмал хариуцлагатай компани"-аас "нээлттэй хувьцаат компани"-ийн хэлбэрт шилжүүлэх замаар үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотойгоор "Инновэйшн Инвестмент" ХХК нь дараах дүрэм, журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02/17 тоот тогтоолоор сайшаан баталсан байна. Үүнд:

1. ХК-ийн дүрэм /төсөл/;
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам /төсөл;
3. ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам /төсөл/;
4. ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам /төсөл/;
5. ХК-ийн Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам /төсөл/;
6. ХК-ийн ногдол ашгийн бодлого /төсөл/;

Үнэт цаас гаргагчийн нээлттэй компани болох ажлын хүрээнд агуулгын хүрээнд сайшаан баталсан эдгээр журам, бодлогын баримт бичгүүдийн төслүүд нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан журам, Компанийн засаглалын кодекст нийцсэн талаар Хуулийн дүгнэлтэд дурджээ.

Хуулийн зөвлөх нь СЗХ-ноос баталсан Компанийн засаглалын кодекст заасны дагуу Шүгэл хүлээх журам, Хүйсийн тэнцвэрийг хангах болон Залгамж халааны бодлогыг цаашид батлан хэрэгжүүлэх, мөн байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан гаргадаг болох нь зүйтэйг Үнэт цаас гаргагчид зөвлөсөн байна.

Компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг зарчмууд, сайн туршлагуудыг нэвтрүүлснээр тухайн компанийн үнэлгээ, нэр хүнд өсөх, санхүүгийн хувьд үр ашигтай ажиллах, засаглалын хувьд урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах зэрэг компанид эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой баримт бичиг юм.

## 19.9. Үнэт цаас гаргагчийн баримталж буй журам

Үнэт цаас гаргагч нь дараах бодлого журмыг баталсан болно.

### 19.9.1 Ногдол ашгийн бодлого

ТУЗ-өөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодексд нийцүүлэх, тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлогыг ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

### 19.9.2 Дотоод хяналтын журам

Үнэт цаас гаргагчийн хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах буюу дотоод хяналтын ажилтны үйл ажиллагаа, ажиллах зарчим, хяналт шалгалтын чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэр, дотоод хяналтын бодлого, үйл ажиллагаанд зайлшгүй анхаарах асуудлыг компанийн онцлог тухайн үеийн байдал, хэтийн төлөвт тулгуурлан тодорхойлж зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Дотоод хяналтын журмыг батлан мөрдүүлж байна.

### 19.9.3 ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Энэхүү журмаар ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хурал хуралдах, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

# 20. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

## 20.1. Нягтлан бодох бүртгэлийн стандарт баримтлал

“Грант Торнтон Аудит” ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг нягталж, хараат бус аудиторын дүгнэлт хийх ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) дагуу зохистой толилуулах болон Нягтлан бодох бүртгэл(НББ)-ийн 19-д зааснаар нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг тогтоох үүрэгтэй. Тус аудитын дүгнэлтээр Үнэт цаас гаргагч нь НББ-ийн тухай хуулийн 19-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг тогтоосон ба нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталсан СТОУС болон СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дагуу бэлтгэсэн байна. Үнэт цаас гаргагч нь зуун хувийн эзэмшил бүхий хоёр охин компанитай бөгөөд тус компаниудтай нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг.

## 20.2. Нэгтгэсэн орлогын тайлангийн шинжилгээ

| Нэгтгэсэн орлогын тайлан | 2019 оны 12 сарын 31 | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|
| | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан |
| Борлуулалтын орлого (цэвэр) | 405.98 | 859.35 | 2,477.69 | 6,341.73 |
| Борлуулалтын өртөг | (170.44) | (270.77) | (485.19) | (1,124.23) |
| **Нийт ашиг (алдагдал)** | **235.53** | **588.58** | **1,992.51** | **5,217.51** |
| Хүүгийн орлого | 19.17 | 11.61 | 24.60 | 96.96 |
| Бусад орлого | 0.005 | - | - | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | (391.39) | (208.74) | (262.54) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (797.30) | (701.86) | (763.97) | (1,291.27) |
| Санхүүгийн зардал | (0.23) | (1.15) | (14.12) | (20.39) |
| Бусад зардал | (274.17) | (43.22) | (1.16) | (33.96) |
| Бусад ашиг (алдагдал) | 37.21 | 59.12 | - | - |
| Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал) | - | - | (1.04) | 159.21 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны олз | - | - | - | 8.65 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(779.77)** | **(478.32)** | **1,028.08** | **3,874.18** |
| Орлогын татварын зардал | (10.30) | (2.38) | (118.92) | (401.17) |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(790.08)** | **(480.70)** | **909.17** | **3,473.01** |

*Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн орлогын тайлан, сая төгрөгөөр, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагч нь бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мерчант байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр QR код, Deeplink технологи болон QPay цахим хэтэвчийн токенжуулалт ашиглан арилжааны банк, финтекийн платформууд хооронд төлбөр, шилжүүлэг гүйцэтгэж, QPay үйлчилгээг хэрэглэж байгаа мерчант байгууллагуудад нэмэлт үйлчилгээ үзүүлдэг.

Үнэт цаас гаргагч　　　Андеррайтер

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ

Иймд, борлуулалтын орлого нь QPay үйлчилгээ ашиглан хийгдсэн гүйлгээ (QPay гүйлгээ)-ний тооноос шууд хамааралтай байна.

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн борлуулалтын орлогын дийлэнх хувийг QPay үйлчилгээний орлого бүрдүүлдэг ба QPay борлуулалтын орлогын бүтцийг доорх байдлаар ангилж байна:

- QR код бүхий наалтыг ашиглан Хэрэглэгч төлбөр шилжүүлэх үед тухайн төлбөрийн шилжүүлгээс олох шимтгэлийн орлого;
- Арилжааны банкнууд болон Мерчант байгууллагуудтай гурван талт гэрээ байгуулсны дагуу QPay системийн холболт гүйцэтгэснээр үүсэх холболтын хураамжийн орлого.

Үнэт цаас гаргагчийн үндсэн орлогын эх үүсвэрүүдийг ангилбал:

- QPay үйлчилгээ нь Арилжааны банк болон Мерчант талуудтай байгуулсан гурван талт гэрээний дагуу тус үйлчилгээний аль нэг модуль, функцийг ашиглан хийгдэж буй бэлэн бус гүйлгээний дүн эсвэл тоо ширхгээс тогтсон хувь хэмжээ эсвэл тогтмол дүнгээр шимтгэл тооцдог. Тус шимтгэл нь "КKTT" ХХК-ийн орлогын гол эх үүсвэр юм.
- Үнэт цаас гаргагч нь мерчантуудад зориулсан нэмэлт үйлчилгээг үзүүлдэг ба тус үйлчилгээнээс олох орлогыг гүйлгээний шимтгэл хэлбэрээр тооцдог. Энэ нь "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн үндсэн орлогын эх үүсвэр юм.

### 20.2.1.Борлуулалтын орлого




*График 4. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн борлуулалтын орлого, орлогын өсөлт , сая төгрөг, хувиар, 2019 – 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын нэгтгэсэн борлуулалтын орлого нь 2019 онд 406 сая төгрөг байсан бөгөөд, өмнөх онтой харьцуулахад 2020 онд 112 хувиар, 2021 онд 188 хувиар, 2022 онд 156 хувиар өсөж 6.34 тэрбум төгрөгт хүрсэн. 2022 оны нийт борлуулалтын 98 орчим хувийг QPay үйлчилгээ болон мерчантуудад үзүүлдэг нэмэлт үйлчилгээний шимтгэлийн орлого бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023 11 08
БҮРТГЭВ
№ 01

INNOVATION INVESTMENT

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03




*График 5. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзэлж буй хувь, Монгол Улсын бэлэн бус гүйлгээний тоо болон үнийн дүнтэй харьцуулах нь, хувиар, 2017 - 2022*

*Эх сурвалж: Монголбанк, Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

2017 оноос 2022 оны хооронд QPay үйлчилгээ ашиглан хийгдэж буй гүйлгээний тооны жилийн дундаж нийлмэл өсөлт 216 хувьтай байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн борлуулалтын орлогын өсөлтөд гол нөлөөг үзүүлсэн байна.

QPay үйлчилгээ нь Хэрэглэгчдийн таалалд нийцсэн төлбөрийн хялбар шийдэл байсаар ирсэн тул Монгол Улсын системийн нөлөө бүхий арилжааны банкнууд болох "Хаан Банк" ХК, "Худалдаа Хөгжлийн Банк" ХК, "Хас Банк" ХК, "Төрийн Банк" ХК болон Төрийн байгууллагууд, Финтекийн компаниуд, Банк бус санхүүгийн байгууллагууд, Онлайн худалдааны байгууллагууд болон Үүрэн холбооны операторууд өөрсдийн үйлчилгээнд идэвхтэй нэвтрүүлж, өдгөө QPay үйлчилгээг төлбөр тооцооны өргөн хэрэглээний дэд бүтэц болгосон нь ийнхүү QPay гүйлгээний тоо хурдтай өсөхөд нөлөөлсөн.

Мөн КОВИД-19 цар тахлын улмаас иргэд бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхээс татгалзаж бэлэн бус хэлбэрээр төлбөр тооцоо хийхийг илүүд үзэх болсон зэрэг Хэрэглэгчдийн хэрэглээнд өөрчлөлтүүд гарсан нь QPay үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэх буюу гүйлгээний тоог нэмэгдүүлж иржээ.




*График 6. Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээний гүйлгээний тоо ба өсөлт, мянган ширхэг, хувиар, 2017 - 2022*

*Эх сурвалж: Монголбанк, Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар QPay гүйлгээ нь Монгол Улсын нийт бэлэн бус гүйлгээний тоо ширхгийн 4.09 хувь, үнийн дүнгийн 0.74 хувийг эзэлж байна. Энэхүү зах зээлд эзлэх хувь хэмжээг 2017 онтой харьцуулахад тус тус 6,429 хувь, 2,596 хувиар өссөн байна. QPay үйлчилгээг ихэвчлэн иргэн-мерчант хооронд (B2C гүйлгээ) гүйлгээ хийхэд ашигладаг тул тоо ширхэг өндөр ч, үнийн дүнгийн хувьд картын болон байгууллагын интернет банкны гүйлгээтэй харьцуулахад бага хувь эзэлдэг.

## 20.2.2 Зардлын бүтэц




*График 7.*
*Борлуулалтын орлогод эзлэх зардлын хувийн жин ба нийт зардлын дүн. сая төгрөг, хувиар,*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг үзэхэд үндсэн зардлуудад 2021 болон 2022 оны дунджаар цалингийн зардал 55 хувь, борлуулалтын өртөгтэй холбоотой мессеж өртөг, мерчантын буцаалт болон программ хангамжтай холбоотой зардал 28 хувь, түрээсийн зардал 2 хувь, борлуулалттай холбоотой зар сурталчилгааны зардал 5 хувь, элэгдлийн зардал 5 хувь, мэргэжлийн үйлчилгээний зардал 6 хувийг тус тус эзэлж байна. Ийнхүү цалингийн зардал нь нийт зардлын ихэнх хэсгийг эзэлж байгаа нь технологийн компани зах зээл дээр байр сууриа бэхжүүлэх, асуудалд шийдэл олох, бусдын бизнест үнэ цэн бий болгохын гол хөшүүрэг нь чадварлаг боловсон хүчин байдагтай холбоотой.

Үнэт цаас гаргагчийн бизнест борлуулалтын орлого нэмэгдэх, үйл ажиллагаа тэлэх, шинэ модулиуд нэвтрүүлэх, гүйлгээний тоо болон үнийн дүнгийн хэмжээ нэмэгдэхийг дагаад зардал шууд хамааралтайгаар өөдөггүй онцлогтой. Иймд, борлуулалтын орлогод эзлэх борлуулалтын өртгийн хувийн жин 2019 онд 42 хувь буюу 170.4 сая төгрөг, 2020 онд 32 хувь буюу 270.8 сая төгрөг, 2021 онд 20 хувь буюу 485.2 сая төгрөг, 2022 онд 18 хувь буюу 1.1 тэрбум төгрөг болж үнийн дүнгийн хувьд өссөн хэдий ч эзэлж буй хувийн жин нь буурсан үзүүлэлттэй байна.

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын нийт зардал нь 2019 онд 1.3 тэрбум байснаас 2022 онд 3.1 тэрбум болж өссөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт зардлын 41 хувийг ерөнхий удирдлагын зардал, 36 хувийг борлуулалтын өртөг, 8 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 1 хувийг санхүүгийн зардал, 1 хувийг бусад зардал, үлдсэн 13 хувийг орлогын татварын зардал тус тус эзэлж байна.

Нэгтгэсэн байдлаар борлуулалтын өртөгт цалингийн зардал 41 хувь, мерчант байгууллагуудад өгөх буцаалт 53 хувь, мессеж өртөг 5 хувь, программ хангамжтай холбоотой зардал болон бусад зардал 1 хувийг тус тус эзэлж байна. Боловсон хүчин, хүний нөөцийн зардал нь нийт зардлын ихэнх хэсгийг дангаараа бүрдүүлж байгаа нь үйл ажиллагааны гол хөшүүрэг нь хүний нөөц гэдгийг харуулж байна.

Нийт борлуулалтын орлогод эзлэх санхүүгийн зардал нь 2019 онд 0.06 хувь, 2020 онд 0.13 хувь, 2021 онд 0.57 хувь, 2022 онд 0.32 хувьтай буюу бага хэмжээтэй байгаа нь Үнэт цаас гаргагч үйл ажиллагаагаа явуулахад зээлийн эх үүсвэрийн хэрэгцээ бага, өөрсдийн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар санхүүжих чадамж сайтайг илэрхийлж байна.




*График 8. Ерөнхий, удирдлагын зардал ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019-2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

2019 - 2022 онуудад нэгтгэсэн ерөнхий удирдлагын зардал дунджаар 888.6 сая төгрөг байна. Түүхэн дунджаар ерөнхий ба удирдлагын зардлын 33 хувийг "ККТТ" ХХК буюу QPay-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой удирдлагын зардлууд болох цалин, мэргэжлийн үйлчилгээний зардал, түрээсийн төлбөр болон бусад зардлууд бүрдүүлж байна. "Инновэйшн Инвестмент" ХХК нь ерөнхий удирдлагын зардлын 58%-ийг, үлдсэн 9%-ийг "Дижитал Мерчант Сервисес" ХХК бүрдүүлж байна. Цалин, мэргэжлийн үйлчилгээний зардлууд дийлэнх хэсгийг бүрдүүлж, борлуулалтын өртгөөс өндөр байгаа нь группийн компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлж, төлбөр тооцооны болон бусад үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, цаашдын зах зээлээ тэлэх боломжийг эрэлхийлж буйтай холбоотой юм.




*График 9.*

*Борлуулалт маркетингийн зардал ба өсөлтийн хувь, сая төгрөг, хувиар, 2019-2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Нийт борлуулалт маркетингийн зардал нь 2020 - 2022 онуудад дунджаар 287.6 сая төгрөг байсан ба тус зардал нь 2020 онд борлуулалтын орлогын 46 хувь, 2021 онд 8 хувь, 2022 онд 4 хувийг тус тус эзэлж байна. Нийт борлуулалт маркетингийн зардлын 99 орчим хувийг QPay үйлчилгээний борлуулалт, маркетингтай холбож тайлбарлаж байна. Үнэт цаас гаргагч нь 2020 оноос QPay бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийт болон томоохон бизнес эрхлэгч, байгууллагуудад танилулах, нэвтрүүлэх зорилгоор маркетинг хөтөлбөрүүд хэрэгжүүлж, идэвхжүүлэлт хийж эхэлсэн нь энэ төрлийн зардлыг нэмэгдүүлсэн.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

## 20.3. Санхүү байдлын нэгтгэсэн тайлангийн шинжилгээ

| Санхүү байдлын нэгтгэсэн тайлан | 2019 оны 12 сарын 31 | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|
| | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан |
| ХӨРӨНГӨ | | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 1,820.75 | 1,411.19 | 2,123.42 | 1,853.36 |
| Дансны авлага | 42.26 | 108.07 | 193.31 | 450.68 |
| Татвар, НДШ-ийн авлага | 1.91 | 5.89 | 18.16 | 1.61 |
| Бусад авлага | 26.52 | 83.85 | 172.10 | 650.40 |
| Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт | - | - | - | 1000.00 |
| Богино хугацаат санхүүгийн хөрөнгө | - | - | - | 1,412.45 |
| Бараа материал | - | 0.62 | 0.62 | 0.15 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 136.50 | 144.73 | 224.25 | 330.84 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **2,027.93** | **1,754.34** | **2,731.85** | **5,699.50** |
| Үндсэн хөрөнгө | 116.60 | 107.13 | 171.29 | 694.48 |
| Биет бус хөрөнгө | 180.17 | 180.06 | 183.47 | 234.05 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | - | 12.75 | 147.44 | 128.06 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **296.76** | **299.94** | **502.19** | **1,056.59** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,324.69** | **2,054.28** | **3,234.04** | **6,756.09** |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | - | - | - | - |
| Дансны өглөг | 36.53 | 210.91 | 278.19 | 346.45 |
| Цалингийн өглөг | - | 21.75 | 27.00 | 20.05 |
| Татварын өр | 9.14 | 6.03 | 85.15 | 111.71 |
| НДШ-ийн өглөг | - | 5.67 | - | 0.94 |
| Ажилчдад өгөх өглөг | - | - | 0.08 | 0.98 |
| Хүүгийн өглөг | - | - | 0.22 | 0.13 |
| Урьдчилж орсон орлого | 0.70 | 0.22 | 5.93 | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 1.76 | 0.03 | 0.85 | 1.05 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **48.14** | **244.62** | **397.41** | **481.31** |
| Урт хугацаат зээл | - - | - | - | - |
| Нөөц / өр төлбөр/ | - - | - | - | - |
| Хойшлогдсон татварын өр | 3.99 | 4.57 | 4.58 | 4.62 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | - | 13.23 | 135.90 | 101.00 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **3.99** | **17.80** | **140.48** | **105.61** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **52.13** | **262.42** | **537.89** | **586.93** |
| Хувьцаат капитал | 3,501.00 | 3,501.00 | 3,501.00 | 3,501.00 |
| Хуримтлагдсан ашиг | (1,228.44) | (1,709.14) | (804.85) | 2,668.16 |
| Эздийн өмчийн дүн | 2,272.56 | 1,791.86 | 2,696.15 | 6,169.16 |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **2,324.69** | **2,054.28** | **3,234.04** | **6,756.09** |

*Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын нэгтгэсэн тайлан, сая төгрөг, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023.11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

### 20.3.1. Хөрөнгө ба эх үүсвэрийн бүтэц




*График 10. Нийт хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Нийт хөрөнгө 2019 - 2022 онуудад 2.3 тэрбум төгрөгөөс 6.8 тэрбум болж дунджаар 43 хувиар өссөн нь үйл ажиллагаа өргөжин, ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой. Түүхэн дунджаар нийт хөрөнгийн 85 хувийг эргэлтийн хөрөнгө, 15 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. 2022 оны байдлаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109 хувиар буюу 3.5 тэрбумаар өссөнд борлуулалтын орлого өмнөх оноос 3.9 тэрбумаар нэмэгдэж үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн урсгал 3 тэрбум төгрөгт хүрсэн нь томоохон нөлөөг үзүүлсэн байна.

QPay үйлчилгээ ашиглах Мерчант байгууллагуудын тоо нэмэгдсэнээр дансны авлага өмнөх онтой харьцуулахад 2021 онд 85.2 сая төгрөгөөр, 2022 онд 257.4 сая төгрөгөөр тус тус өссөн.




*График 11. Эргэлтийн хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021311 95 СТС2420

2019 - 2022 онуудад түүхэн дунджаар нэгтгэсэн эргэлтийн хөрөнгийн 70 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 6 хувийг Мерчант байгууллагуудаас авах авлага буюу дансны авлага, 7 хувийг банканд төлөх QPay шимтгэлийн хуримтлуулан тооцсон дүн болон сар бүр зардалд тохируулан бүртгэх урьдчилгаа төлбөрүүдтэй холбоотой урьдчилж төлсөн зардал тооцоо, 6 хувийг бусад авлага, 11 хувийг бусад эргэлтийн хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

2022 онд эргэлтийн хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 109 хувиар өссөн. Үүнд борлуулалтын орлого өмнөх оноос 156 хувиар буюу 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал 2.2 тэрбум төгрөгөөр өсөж, 3.0 тэрбум төгрөгт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Үнэт цаас гаргагч нь мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийг эргэлтэд оруулах зорилгоор 1.0 тэрбум төгрөгөөр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, 1.4 тэрбум төгрөгийг богино хугацаат банкны хадгаламжид байршуулсантай холбоотойгоор 2022 онд нийт эргэлтийн хөрөнгийн 42 хувийг бусад эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

Ийнхүү мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ өндөр байгаа нь 2019 онд Үнэт цаас гаргагч нь Япон Улсын хөрөнгө оруулагчдаас 2 тэрбум төгрөгийн санхүүжилт амжилттай татан төвлөрүүлсэн, мөн 2021 болон 2022 онуудад үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн урсгал нэмэгдсэнтэй холбоотой.




*График 12. Эргэлтийн бус хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Нэгтгэсэн тайлангаас үзэхэд үндсэн хөрөнгө 2019 онд 296.8 сая төгрөг байсан бол жилд дунджаар 53 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 2022 онд 1.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2022 оны байдлаар эргэлтийн бус хөрөнгийн 66 хувь буюу 694.5 сая төгрөгийн тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл, машин тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгө, 22 хувь буюу 234.1 сая төгрөгийн тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, программ хангамж зэрэг биет бус хөрөнгө, 12 хувь буюу 128.1 сая төгрөгийн түрээсийн дата центрийн үйлчилгээ, физик сервер, мэдээлэл холбоо, оффисын барилга зэрэг ашиглах эрхтэй хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

2022 онд эргэлтийн бус хөрөнгө өмнөх оноосоо 110 хувиар өссөн нь тайлант хугацаанд 485.0 сая төгрөгийн өртөг бүхий мэдээлэл хадгалах сервер, 127.5 сая төгрөгийн компьютер худалдан авсантай холбоотой. Үндсэн хөрөнгийн дийлэнх хувийг мэдээллийн технологийн төхөөрөмж, хэрэгсэл, программ хангамж, сервер бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь Монголбанкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиудад заасан техник, технологийн шаардлагыг хангаж ажилладаг. Үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК нь өөрийн эзэмшиж буй Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрөл болон Төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой процессорын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 8.5 сая төгрөгөөр, QR кодоор мэдээлэл солилцох программын зохиогчийн эрхийг 24.1 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03




*График 13. Эх үүсвэрийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар*

*2019-2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

Нийт эх үүсвэрийн дүн 2019 онд 2.3 тэрбум төгрөг байсан бол жилд дунджаар 43 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 2022 онд 6.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2019 - 2021 онуудад түүхэн дунджаар нийт хөрөнгийг 90 хувийг эздийн өмч, 8 хувийг богино хугацаат өр төлбөр, үлдсэн 2 хувийг урт хугацаат өр төлбөрөөр тус тус санхүүжүүлж байна. 2022 онд нийт эх үүсвэрийн дүн өмнөх оноос 109 хувиар нэмэгдэж 6.8 тэрбум төгрөгт хүрсэн нь Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирч, 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар хуримтлагдсан алдагдал буурч, 2.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажиллаж эхэлсэнтэй холбоотой.




*График 14. Эздийн өмчийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

QPay үйлчилгээ нь зах зээлд 2017 онд нэвтэрсэн бөгөөд 2020 он хүртэл ашигт ажиллагаа нь сөрөг утгатай байсан тул хуримтлагдсан алдагдал 2020 онд 1.7 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ хугацаанд хүний нөөц бүрдүүлэлт, маркетинг борлуулалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд өндөр ач холбогдол өгч ажилласны үр дүнд өмнөх хэсэгт дурдсан борлуулалтын орлогын өндөр өсөлтийг бий болгож, 2021 онд 0.91 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 2022 онд 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдлын хэмжээг бууруулсан. Иймхүү 2022 оноос 2.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажиллаж эхэлсэн. Үнэт цаас гаргагчийн эздийн өмч 2021 онд өмнөх оноосоо 50 хувиар өсөж 2.7 тэрбум төгрөгт, 2022 онд өмнөх оноос 129 хувиар өсөж 6.2 тэрбум төгрөгт хүрсэн нь борлуулалт, цэвэр ашгийн өсөлттэй холбоотой.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03




*График 15. Өр төлбөрийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан*

2019-2022 онуудын түүхэн үзүүлэлтээр нэгтгэсэн санхүү байдлын тайланд өр төлбөр нь нийт эх үүсвэрийн 10 хувийг эзэлж байсан. 2022 онд нийт өр төлбөрийн 59 хувийг буюу 346.5 сая төгрөгийг QPay үйлчилгээний шимтгэлийн орлогоос арилжааны банкнуудад шилжүүлэх төлбөр буюу дансны өглөг бүрдүүлж байна. 17 хувь буюу 101.0 сая төгрөг нь оффис түрээс болон техникийн шаардлага хангасан, захиалгын хуудсанд заасан тоноглолуудыг байршуулах байр, өөрийн дата серверийг хадгалуулах түрээсийн үйлчилгээний төлбөртэй холбоотой Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16-ийн дагуу үүссэн бусад урт хугацаат өр төлбөр байна. Нийт өр төлбөрийн 19 хувь буюу 111.7 сая төгрөгийг татварын өр төлбөр, үлдсэн 5 хувийг бусад өр төлбөрүүд тус тус бүрдүүлж байна.

Өр төлбөрийн дүн 2019 - 2022 онуудад 52.0 сая төгрөгөөс 586.9 сая төгрөг болж, жилд дунджаар 124 хувиар нэмэгдсэн нь борлуулалтын орлогын өсөлттэй холбоотойгоор дансны өглөг 309.9 сая төгрөгөөр, бусад урт хугацаат өр төлбөр 101.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой. QPay үйлчилгээний шимтгэлийн орлого нь арилжааны банкнуудад шилжүүлэх гүйлгээний шимтгэлтэй уялдаатай байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

## 20.3.2. Онцлох харьцаа үзүүлэлтүүд




*График 16. Хөрвөх чадвар ба төлбөрийн чадварын харьцаа, тоо, хувиар, 2019-2022*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь технологид суурилсан тул хангамжийн материал зэрэг бага өртгийн, борлуулах зориулалтын бус зүйлс бараа материалд бүртгэгддэг. Эргэлтийн хөрөнгийн харьцаа болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа зөрүүгүй тооцоологдсон бөгөөд 2019 онд 42.1, 2020 онд 7.2, 2021 онд 6.9, 2022 онд 11.8 байгаа нь богино хугацаат өр төлбөр барагдуулах чадвар сайтай, хэвийн хэмжээнд байна гэж дүгнэж байна. Энэхүү үзүүлэлт нь 2022 онд эргэлтийн хөрөнгөөр эргэлтийн өр төлбөрийг 11.8 дахин барагдуулах чадамжтай байгааг илэрхийлж байна. 2022 оны байдлаар бэлэн мөнгөний харьцаа буюу мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөр эргэлтийн өр төлбөрийг 3.9 дахин барагдуулах чадамжтай байгаа нь хөрвөх чадварын эрсдэл бага байгааг илэрхийлж байна.

Өрийн харьцаа буюу нийт хөрөнгөнд эзлэх өр төлбөрийн дүн 2022 оны байдлаар 8.7 хувьтай байгаа нь төлбөрийн чадварын эрсдэл харьцангуй бага байгааг илэрхийлж байна.




*График 17. Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, хоногоор, 2019-2022*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

Үнэт цаас гаргагч　　　　Андеррайтер

СЗХ 2023 . 11 сар 0 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ EXCHANGE 2023 -07- 20 БҮРТГЭВ 03

2019 - 2022 онуудын санхүү байдлын тайланд шинжилгээ хийж гүйцэтгэхэд Мерчант байгууллагуудаас авлага цуглуулах хугацаа 37 хоногоос 26 хоног, төлбөр барагдуулах дундаж хугацаа 32 хоногоос 20 хоног болж тус тус буурч сайжирсан үзүүлэлттэй байна. Энэ нь мөнгөний удирдлагаа оновчтой хэрэгжүүлж байгааг илэрхийлж байна.




*График 18. Ашигт ажиллагааны харьцааны шинжилгээ, хувиар, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хувьсах зардал харьцангуй бага байдаг тулд борлуулалтын орлого нэмэгдэхийн хирээр нийт ашгийн ахиуц нэмэгдэх төлөвтэй байдаг ба 2019 онд ашгийн ахиуц 58 хувь байсан бол 2022 онд 82 хувьд хүрч нэмэгдсэн байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангаас ашигт ажиллагааны түүхэн үзүүлэлтүүдийг үзэхэд 2020 оныг дуустал алдагдалтай ажилласан ба 2020 онд 2019 оны алдагдлын түвшнийг 39 хувиар бууруулсан гүйцэтгэлтэй байв. 2021 оноос ашигтай ажиллаж эхлэн, 2022 онд цэвэр ашгийн түвшин 55 хувьд хүрсэн байна. Үүнийг бэлэн бус төлбөр тооцооны зах зээл идэвхтэй тэлэх үетэй зэрэгцүүлэн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Мерчант халамжлал, маркетинг борлуулалт болон түншлэлтэй холбоотой бодлогуудыг амжилттай хэрэгжүүлж QPay гүйлгээний тоог хурдацтай өсгөсөнтэй холбон тайлбарлаж болно.

Үр дүнд нь гүйлгээний шимтгэлийн нийт орлого хурдацтай нэмэгдсэн бөгөөд түүнийг даах сервер, хүний нөөцийн чадавх хангалттай байсан тул зардлуудын өсөлт харьцангуй тогтворжсон нь ашигт ажиллагааг дэмжсэн.

2022 онд нэгж өөрийн хөрөнгөөр бий болгох ашиг 0.78 төгрөг, нэгж хөрөнгийг ашиглан 0.70 төгрөгийн ашиг олж байгаа нь ашигт ажиллагааны түвшин хурдан хугацаанд сайжирсныг илтгэж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242903 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 9021031 95 СТС2420

СЗХ 2023 .. 11 .. 08 он сар өдөр БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2023 -07- 20 БҮРТГЭВ-03

## 20.4. Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн шинжилгээ

| Мөнгөн гүйлгээний тайлан/сая төгрөг/ | 2019 оны 12 сарын 31 | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|
| | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан | Аудитлагдсан |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,050.07)** | **(432.21)** | **818.64** | **3,008.00** |
| Мөнгөн орлогын дүн (+) | 498.49 | 1,061.69 | 2,604.33 | 7,322.75 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 454.47 | 994.80 | 2,599.23 | 6,725.33 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0 | 0 | 0.84 | 0.43 |
| Бусад мөнгөн орлого | 44.02 | 66.89 | 4.26 | 596.99 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | (1,548.56) | (1,493.91) | (1,785.69) | (4,314.74) |
| Ажиллагчдад төлсөн | (513.72) | (801.74) | (696.02) | (819.07) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (126.23) | (96.24) | (178.09) | (215.16) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (12.64) | (31.74) | (100.02) | (395.61) |
| Татварын байгууллагад төлсөн | (74.58) | (127.94) | (392.88) | (1,009.48) |
| Бусад | (821.40) | (436.24) | (418.69) | (1,875.43) |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(48.59)** | **(35.10)** | **(105.11)** | **(3,360.08)** |
| Мөнгөн орлогын дүн (+) | 60.68 | 16.90 | 92.06 | 242.93 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.43 | 2.85 | - | 15.15 |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 18.77 | 13.92 | 61.58 | 193.22 |
| Хүлээн авсан хүүгийн орлого | 41.47 | 0.13 | 30.48 | 34.56 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | (109.26) | (52.00) | (197.17) | (3,603.01) |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (42.57) | (46.57) | (128.55) | (762.57) |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - | - | (2,412.45) |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (10.00) | - | - | (26.19) |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | (56.69) | (5.43) | (68.62) | (401.80) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,990.80** | **0.90** | **(0.27)** | **(77.16)** |
| Мөнгөн орлогын дүн (+) | 2,026.59 | 0.90 | - | 0.47 |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 26.59 | 0.90 | - | |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 2,000.00 | - | - | |
| Мөнгөн зарлагын дүн (-) | (35.79) | - | (0.27) | (77.63) |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (35.79) | - | (0.27) | (45.61) |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - | - | (32.02) |
| Валютын ханшийн зөрүү | 36.42 | 56.86 | (1.04) | 159.18 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **928.57** | **(409.55)** | **712.23** | **(270.06)** |

Үнэт цаас гаргагч Андеррайтер

INNOVATION INVESTMENT ХХК УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2023 11 08 он сар өдөр БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **892.18** | **1,820.75** | **1,411.19** | **2,123.42** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,820.75** | **1,411.19** | **2,123.42** | **1,853.36** |

*Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, сая төгрөг, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*




*График 19. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн урсгалын график, сая төгрөг, 2019 - 2022*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Нэгтгэсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал 2019 онд 1.1 тэрбум төгрөгийн, 2020 онд 432.2 сая төгрөгийн үйл ажиллагааны сөрөг мөнгөн урсгалтай байсан бол 2021 оноос эхлэн 818.6 сая төгрөг, 2022 онд 3.0 тэрбум төгрөгийн эерэг мөнгөн урсгалтай байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тэлэлт, борлуулалтын өсөлттэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээнээс орж ирэх мөнгөн урсгал 2019 - 2022 онуудын хугацаанд 6.8 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Нэгтгэсэн хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал 2019 - 2021 онуудад дунджаар 62.9 сая төгрөгийн сөрөг утгатай байгаа нь жил бүр үндсэн хөрөнгөнд хөрөнгө оруулж байсантай нь холбоотой. 2022 онд мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эргэлтэд оруулах зорилгоор 2.4 тэрбум төгрөгийг өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, богино хугацаат хадгаламжид байршуулсантай холбоотойгоор хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал 3.4 тэрбум төгрөгийг сөрөг утгатай гарсан.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал 2019 онд 2.0 тэрбум төгрөгийн эерэг урсгалтай гарсан нь хувьцаа эзэмшигчид 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна.

Нийт цэвэр мөнгөн гүйлгээ нь 2019 онд 928.6 сая төгрөгийн эерэг урсгалтай байсан нь Үнэт цаас гаргагч 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шинэ хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэнтэй холбоотой байсан бол үүнээс хойших үйл ажиллагааны өргөжин 2021 онд бүтээгдэхүүн, үйлчилгээнээс орж ирэх орлогыг өмнөх оноос 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 712.2 сая төгрөг хүрэхэд нөлөөлжээ. 2022 онд үйл ажиллагааны мөнгөн урсгал 3.0 тэрбум төгрөгийн эерэг урсгалтай байсан хэдий ч 762.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.4 тэрбум төгрөгөөр өрийн үнэт цаас болон хадгаламжид хөрөнгө оруулсантай холбоотойгоор цэвэр мөнгөн урсгал 270.1 тэрбум төгрөгийн сөрөг утгатай гарсан байна.

Үнэт цаас гаргагч.　　　　Андеррайтер

# 21. Зорилтот зах зээлийн шинжилгээ

## 21.1. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

### 21.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол улсын нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд 9.8 их наяд төгрөг байсан бол жилд дунджаар 15 хувийн өсөлт үзүүлж, 2022 онд 52.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд уул уурхайн салбарын өсөлт томоохон нөлөө үзүүлдэг ба цаашдын эдийн засгийн нөхцөл байдал нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, уул уурхайн салбарын өсөлт, түүний хөрөнгө оруулалт, бондын дахин санхүүжилтийн боломж, хүрэлцээнээс шууд хамааралтай байна.

2021 онд Монгол Улсын экспортын үндсэн түүхий эдүүдийн үнэ өссөн хэдий ч уул уурхайн салбарын нийлүүлэлт буурсан. Үүнд КОВИД-19 халдварын тархалтын улмаас БНХАУ хилээ хаасан, гадаад худалдааны хязгаарлалт, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, БНХАУ-ын "Тэг Ковид" бодлого, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт зэрэг нөлөөлсөн байна.

2022 оны дундаас эхлэн хилийн боомтууд дээрх хязгаарлалт суларч, нүүрсний тээвэрлэлт сэргэж байгаатай холбоотойгоор 2021 онд уналттай байсан уул уурхайн салбар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, улс орнуудын цар тахлын эсрэг хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэсний үр дүнд эдийн засгийн салбаруудын идэвхжил нэмэгдэн Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 21 хувиар өсөж, 2022 оны байдлаар 52.9 их наяд төгрөгт хүрсэн байна.

Олон Улсын Валютын Сангийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг нэрлэсэн дүнгээр 2023-2027 онуудад дунджаар 14 хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна.




*График 20. Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлт, их наяд төгрөг, 2010 –2022 гүйцэтгэл, 2023– 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо ба Олон Улсын Валютын Сан*

2022 оны жил эцсийн байдлаар Монгол Улсын нийт экспортын 93 хувийг уул уурхайн салбар эзэлж байгаа нь уул уурхайн салбарын үндэсний эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр өндөр байгааг илэрхийлж байна. Иймд зэс болон нүүрсний үнийн хэлбэлзэл манай улсын эдийн засагт томоохон нөлөөлөл үзүүлнэ.

СЭХ 2023.11.08 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ 03



2022 оны эцсийн байдлаар дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ мянган тонн тутам нь 8,375 ам.доллар, нүүрсний үнэ мянган тонн тутам нь 286 ам.доллар байна. Дэлхийн зэсийн эрэлт хэрэгцээ нь цаашид сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон гибрид машин, хотжуулалт, цахилгаанжуулалт, эрүүл мэндийн салбарын өсөлттэй холбоотойгоор 2023 онд тонн тутам нь 11,000 ам.доллар, 2024 онд 12,000 ам.доллар болж жилд дунджаар 20 орчим хувиар өсөх төсөөллийг Goldman Sachs хөрөнгө оруулалтын банкны зүгээс гаргасан байна. Мөн зэсийн эрэлт нь дэлхийн зэсийн үйлдвэрийн талаас их хувийг хэрэглэдэг Хятад улсын эдийн засгаас ихээхэн хамааралтай юм.

2022 онд экспортын нүүрсний дундаж үнэ 353.35 ам.долларт хүрсэн нь өмнөх оноос 172.35 ам.доллароор өндөр ба 2021 оны сүүлээс эхэлсэн эрчим хүчний хямрал ОХУ Украинд түрэмгийлснээр улам өссөн байна. ОХУ-ын нүүрсэнд Европын орнууд хориг тавьсан нь нийлүүлэлтийг чангаруулж, үнийг өсгөж, Өмнөд Африк болон бусад орны нүүрс олборлогчдын орлогыг нэмэгдүүлсэн. Цар тахлын дараах эрэлтийн улмаас нүүрсний үнэ 2021 оны аравдугаар сараас хойш тасралтгүй өсөж байгаа бөгөөд 2022 оны эхэн үетэй харьцуулахад ойролцоогоор гурав дахин өссөн.

Шинжээчид дэлхий нийтийн эдийн засгийн сэргэлт, эрчим хүчний томоохон үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт өсөж дунд хугацаанд нүүрсний үнэ тогтворжино гэж таамаглаж байна. Цаашид Дэлхийн банкны түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын тайланд дурдсанаар инфляцын талаарх түгшүүртэй байдал, тээвэр логистикийн хүндрэл, эдийн засгийн өсөлтийн тодорхойгүй байдал зэрэгтэй холбоотойгоор нүүрсний үнэ тонн тутам нь 2023 онд 42 хувиар, 2023 онд 23 хувиар буурах төсөөлөлтэй байна.




*График 21. Дэлхийн зах зээл дээрх нүүрс болон зэсийн үнэ, ам.доллар, сараар, 2010 –2022*

*Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9011031195 СТС2420

Андеррайтер

СЗХ
2023 11 08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 21.1.2. Гадаад худалдаа

2022 оны эцэст гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5,158 сая ам.доллароор өсөж, 21,245 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 36 хувиар буюу 3,299 сая ам.доллароор, импорт 27 хувиар буюу 1,859 сая ам.доллароор өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,440 сая ам.доллароор өсөж, 3,836 сая ам.долларын ашигтай гарсан байна. Нийт экспортын өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ болон үнийн өсөлт нь голлох нөлөөг үзүүлсэн.

Хилийн хязгаарлалтууд суларч, Оюу Толгойн ил уурхайн үйлдвэрлэлийн агууламж сэргэн, далд уурхайн үйлдвэрлэл 2023 оны сүүл үеэс жигдэрч эхэлбэл экспортын орлогыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлөх төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын нэг хэсэг болох Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд Оюу Толгойн гүний уурхайн олборлолтыг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эхлүүлсэн. Үүгээр Оюу Толгой нь зэсийн баяжмалын үйлдвэрлэлдээ ил уурхайн хүдрээс гадна нэмж газрын гүний 1.3 км-ээс олборлосон хүдрийг ашиглах боломж бүрдэж байна. Гүний уурхай бүрэн ашиглалтад орсноор Монгол Улс дэлхийд дөрөвт эрэмбэлэгдэх өндөр технологийн гүний уурхайтай болж, олон улсын зах зээлд зэсийн томоохон тоглогчдын нэгд тооцогдож эхлэхээс гадна Монгол Улсын эдийн засаг болон улсын төсөвт оруулах үр өгөөж багадаа гурав дахин нэмэгдэх тооцоолол гарсан байна. Оюу Толгойн ил болон гүний уурхай 2028-2036 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр жилд 500 мянган тонн зэс олборлохоор төлөвлөж байна.

Монгол Улсын эдийн засаг түүхий эдийн үнэ, нөгөө талаас экспортын биет хэмжээ хэр байхаас ихээхэн хамаардаг учир хамгийн том худалдааны түнш орон болох БНХАУ-ын эдийн засаг, хилийн хориг саадын нөхцөл байдал ирэх жилүүдэд манай орны эдийн засгийн нөхцөл байдалд шууд нөлөөлөх байна.

Монгол Улсын Засгийн Газрын Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шинээр 3,358 км төмөр зам барьж ашиглалтад оруулан 13 аймагт дэд бүтэцтэй болохыг зорьж байгаа билээ. Уг бодлогын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас дараах 10 төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

| Төмөр замын чиглэл | Хийгдэх ажил | Хугацаа |
|---|---|---|
| Сүхбаатар-Замын Үүд | Төмөр замыг шинэчлэн сайжруулах | 2022-2030 |
| Эрээнцав-Баянтүмэн (238 км) | Төмөр замыг шинэчлэн сайжруулах | 2022-2026 |
| Зүүнбаян-Ханги (226.9 км) | Шинээр барих | 2022-2023 |
| Чойбалсан-ХӨӨТ (192 км) | Шинээр барих | 2022-2024 |
| Хөөт-Бичигт (294.1 км) | Шинээр барих | 2022-2024 |
| Сайншанд-Баруун-Урт (394 км) | Шинээр барих | 2024-2027 |
| Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн (1,255 км) | Шинээр барих | 2022-2026 |
| Тавантолгой-Зүүнбаян (415.9 км) | Шинээр барих | 2022 |
| Тавантолгой-Гашуутсухайт (226.6 км) | Шинээр барих | 2021-2024 |
| Богдхаан (144.6 км) | Шинээр барих | 2021-2024 |

*Хүснэгт 22. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх боомтын сэргэлтийн ажлын төсөл*

*Эх сурвалж: Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн яам*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
СТС2420

Андеррайтер

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Боомтын сэргэлтийн ажлууд хийгдэж, дэд бүтэц хөгжсөнөөр зүүн, баруун бүсэд байрладаг 230 ашигт малтмалын ордуудыг эргэлтэд оруулах, төмөр замаар тээвэр хийх ачааны хэмжээ 100 сая тонн хүрч, экспортын нүүрс тээвэрлэлтээс олсон орлого 5-6 тэрбум ам.долларт хүрч, 13,000 байнгын болон 20,000-30,000 түр ажлын байр бий болгох урьдчилсан таамаглал гарсан байна.2023 онд үндэсний их бүтээн байгуулалт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км хэвтээ тэнхлэгийн төмөр зам ашиглалтад орох ба уг төмөр зам нь Тавантолгойн бүлэг ордын уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ, ОХУ руу экспортлох шинэ гарц бий болгохоос гадна төмөр замын трассын дагуу Цагаасуварга, Хармагтай, Манлай зэрэг нүүрс, төмөр, зэс, цайрын томоохон орд газруудад байрлаж байгаа нь ирээдүйд уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд голлох дэмжлэг үзүүлэх төмөр замын чиглэл болох юм. Зүүнбаян-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилдээ 30-50 сая тонн нүүрс экспортолж, Тавантолгой бүлэг уурхайн олборлолт 2-3 дахин нэмэгдэнэ гэж төсөөлсөн байна.




*График 22. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, сая ам доллар, улирлаар, 2010-2022*
*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
2023.11.06
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 21.1.3. Инфляци

2021 онд Монгол Улсын инфляц 14.8 хувьд хүрсэн ба энэхүү огцом өсөлтөд шатахууны үнийн өсөлт, импортын бараа бүтээгдэхүүний саатал, тээвэрлэлтийн салбар дахь үнийн нэмэгдэл, хорио болон бусад хүндрэлүүд голлох нөлөө үзүүлсэн. Дотоодын хэрэглээний 60 гаруй хувийг импортоор авдаг Монгол Улсад импортын барааны тасалдлаас үүдэж барилгын материал болон бусад бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ хурдацтай өссөн.

2022 оны эцсийн байдлаар инфляц 13.2 хувь байсан нь олон улсын геополитикийн сөрөг нөхцөл байдал, гадаад худалдааны тогтворгүй байдал, хориг арга хэмжээнүүд зэрэг хүчин зүйлсийн нөлөөтэй. Шинжээчид инфляцын түвшнийг 2023 оныг дуустал Монголбанкны зорилтот интервалаас давсан хэвээр байна хэмээн таамаглаж байна. Махны үйлдвэрлэл нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр хүнс, эрчим хүчний үнэ буурч, Монгол Улс Оросын Холбооны Улсаас газрын тосны бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр авах тохиролцоонд хүрсэн зэрэг нь инфляцыг бууруулах боломжтой байна.




*График 23 . Монгол Улсын инфляци, хувиар, сараар, 2018-2022 оны гүйцэтгэл, 2023-2027 оны төсөөлөл*

*Эх сурвалж: Монголбанк*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Андеррайтер

СЗХ
2023-11-08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 21.1.4. Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2022 онд хил гаалийн хязгаарлалт, тээвэр логистикийн асуудалтай холбоотойгоор нүүрс болон үндсэн түүхий эдийн экспорт зорилтот дүндээ хүрээгүйтэй холбоотой 727 сая ам.долларын алдагдалтай гарсан. Улмаар тухайн жилд урсгал дансны алдагдал 2,653.4 сая ам.доллар, хөрөнгө болон санхүүгийн данс нь 2,150.7 сая ам.долларт тус тус хүрсэн байна.




*График 24. Монгол Улсын тэнцэл, сая ам.доллар, жилээр, 2018 – 2022*

*Эх сурвалж: Монголбанк*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 21.1.5. Гадаад өр

2022 оны жилийн эцэст Монгол Улсын Засгийн газрын гадаад өр өмнөх оны мөн үеэс 444.8 сая ам.доллароор буурч, 8,009.4 сая ам.доллар болсон нь олон улсын зах зээлд арилжаалсан зарим бондын үндсэн төлбөрийг төлсөнтэй холбоотой. Монголбанкны гадаад өр 2022 оны жилийн эцэст өмнөх оны мөн үеэс 431.8 сая ам.доллароор буурч, 2,178.2 сая ам.долларт хүрсэн байна.

2023 оны 01 дүгээр улирлын байдлаар Монгол улсын гадаад өр 330.7 сая ам.доллароор буурч 33.6 тэрбум ам.доллар болоод байгаа бол үүний 8.2 тэрбум ам.доллар нь Монгол Улсын Засгийн газрын өр, 2.1 тэрбум ам.доллар нь Монгол банкны, 13.5 тэрбум ам.доллар нь гадаадын шууд хөрөнгө оруулалт эсвэл компани хоорондын зээл байгаа бол үлдсэн 8.2 тэрбум ам.доллар нь компанийн өр зээл байна.

Тэгвэл Монгол улсын Засгийн газраас өрийн удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс олон улсын зах зээл дээр Гэрэгэ болон Хуралдай бондуудад бүтцийн өөрчлөлт хийх тендер саналыг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зарласан. Түүний дагуу Гэрэгэ бондын хөрөнгө оруулагчдаас 109.3 сая ам.долларын хугацаанаас өмнө худалдах, 273.3 сая ам.долларыг шинэ бондоор солих, Хуралдай бондын хөрөнгө оруулагчдаас 49.3 сая ам.долларыг хугацаанаас өмнө худалдах, 295.2 сая ам.долларыг шинэ бондоор солих хүсэлт ирсэн. Харин шинэ бондоор солих саналыг Гэрэгэ бондын хувьд 40 сая доллар буюу 16.98 хувиар, Хуралдай бондын хувьд 160 сая ам.доллар буюу 55.922 хувиар тус тус биелүүлсэн. Ингэснээр хуучин бонд эзэмшигчдээс 200 сая ам.доллар, шинээр ирсэн захиалга 450 сая ам.доллар байсан ба нийт 650 сая ам.долларын 8.65 хувийн хүүтэй 2028 оны 01 дүгээр сарын 19-нд дуусах шинэ бонд олон улсын зах зээлд бий болсон. Тус бондоос босгосон мөнгөөр 2022 оны 05 дугаар сард Гэрэгэ бондын үлдсэн төлбөрийг төлж барагдуулсан.

Шинжээчид Монгол улсын гадаад өр төлбөрийн оргил үеийг 2023-2024 онуудад байна гэж үзэж байна. Учир нь 2023-2024 онуудад “Сэргэн мандалт” евробондын үлдэгдэл 500 сая ам.доллар, “Самурай” бондын үлдэгдэл 235 сая ам.доллар, “Хуралдай” бондын үлдэгдэл 392.56 сая ам.доллар, Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцэл зэрэг төлбөрүүд төлөгдөх хуваарьтай байна. “Самурай” бондоос бусад өр, төлбөрүүдийг гадаад бонд, зээлээр дахин санхүүжүүлэх ба санхүүжилтийн эрсдэл үүсэх тохиолдолд ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ 60.7 хувиас 65.0 хувьд хүрэхээр байгаа нь Засгийн газрын өрийн таазанд тулах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.

Үнэт цаас гаргагч                Андеррайтер

| Үнэт цаас гаргагч | Бонд | Валют | ISIN дугаар | Дуусах огноо | Үндсэн төлбөрийн үлдэгдэл | Купон хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын Засгийн Газар | Mongolia 17/24 (Хуралдай) | ам.доллар | USY6142NAA64 | 2024/03/09 | 600 сая | 8.75% |
| | Mongolia 17/23 (Гэрэгэ) | ам.доллар | USY6142NAB48 | 2023/05/01 | 533 сая | 5.63% |
| | Mongolia 20/26 (Номад) | ам.доллар | USY6142NAC21 | 2026/04/07 | 600 сая | 5.13% |
| | Mongolia 12/22 (Чингис) | ам.доллар | US60937GAB23 | 2022/12/05 | 138 сая | 5.13% |
| | Mongolia 21/27 (Century) | ам.доллар | USY6142NAF51 | 2027/07/07 | 500 сая | 3.50% |
| | Mongolia 21/31 (Century) | ам.доллар | USY6142NAE86 | 2031/07/07 | 500 сая | 4.45% |
| Монгол Улсын Хөгжлийн банк | DBM' 23 (Самурай) | япон иен | | 2023/12/25 | 30 тэрбум | 1.52% |
| | DBM 18/23 (Сэргэн мандалт) | ам.доллар | USY2056PAA40 | 2023/10/23 | 500 сая | 7.25% |
| "МИК ОССК" ХХК | MGMTGE 21/24 (Бөртэ) | ам.доллар | USY6142GAB96 | 2024/02/08 | 250 сая | 8.85% |
| Монголиан Майнинг Корпорэйшн | MMC' 19/24 | ам.доллар | USG61759AA70 | 2024/04/15 | 440 сая | 9.25% |

*Хүснэгт 23. Монгол банкны үндсэн бондын санхүүжилтийн тухай мэдээлэл*

*Эх сурвалж: Монголбанкны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл"*

## 21.1.6. Мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүү

Монголбанк 2020 оноос 2021 оны эхэн үе хүртэл эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг үе шаттайгаар бууруулж, 6 хувьд хүргэсэн боловч гадаад орчинд бий болсон өөрчлөлт, түүнтэй холбоотой логистикийн хүндрэлээс үүдсэн зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын түвшин 2021 оны эцэст улсын хэмжээнд 11.2 хувь болон нэмэгдсэн. Иймд Монголбанк нь инфляцыг бууруулах зорилготойгоор бодлогын хүүг 2022 оны 01 дүгээр сарын 31-нд 0.5 нэгж хувиар, 3 дугаар сарын 24-нд 2.5 нэгж хувиар, 6 дугаар сарын 22-нд 1 нэгж хувиар, 9 дүгээр сарын 20-нд 2 нэгж хувиар, 12 дугаар сарын 16-нд 1 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэн оны эцэст 13 хувьд хүргэсэн.




*График 25. Монголбанкны бодлогын хүү, хувиар, 2007 – 2022, сараар*

*Эх сурвалж: Монголбанк*

Цар тахалтай холбоотойгоор өнгөрсөн оноос дэлхий даяар тээвэр, логистикийн саатал үүсэж, дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх хандлага 2022 онд геополитикийн хямралаас үүдэн эрчимжиж инфляц зорилтот түвшнээс давахад голлон нөлөөлсөн. Эдгээр хүчин зүйлсийн нөлөө ирэх жилүүдэд алгуур саарч, инфляц буурах хүлээлттэй байна. Гэхдээ гадаад орчны нөхцөл байдал, худалдааны түнш орнуудын өндөр инфляц, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд үүссэн саатал хэзээ хэвийн түвшиндээ очих нь тодорхойгүй байгаа тул инфляцын төлөв нэмэгдэх эрсдэлийг бий болгосон хэвээр байна.

### 21.1.7. Гадаад валютын нөөц

2022 оны эхээс Монгол Улсын гадаад валютын албан нөөц нь 3.9 тэрбум ам,долларт хүрсэн бол 06 дугаар сараас аажмаар буурсан байна. Үүнд экспортын орлого буурсан нь болон Монголбанк валютын ханшийг тогтвортой байлгахын тул интервенц ихээр гүйцэтгэсэн нь нөлөөлсөн байна. Сүүлийн жилийн хугацаанд гадаад шокын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарч, инфляц нэмэгдэх нь дотоодод тэнцвэргүй байдал үүсгэсэн ба экспортын орлого буурснаар урсгал дансны алдагдал 2022 оны 06 дугаар сард 2.0 тэрбум ам.долларт хүрсэн.




*График 26. Гадаад валютын албан нөөц, сая доллар, сараар, 2022-2023*
*Эх сурвалж: Монголбанк*

СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 21.1.8. Зээл болон хадгаламжийн хүү

2022 оны 12 дугаар сарын байдлаар арилжааны банкнууд сарын зээлийн хүүгээ 1.05 хувиас 1.25 хувь болгон өсгөсөн байв. Мөн төгрөгийн хадгаламжийн хүү өнгөрсөн оны мөн үеэс 2.0 нэгж хувиар, валютын хадгаламж 0.47 нэгж хувиар тус тус өссөн.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2023 оны 03 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд хуралдаж эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөвийг харгалзан бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах, бодлогын хүүгийн коридорыг бодлогын хүүгээс +/-1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх, банкнуудын 360 хоног хүртэлх хугацаагаар гадаад зах зээлээс шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс түр хугацаанд хасаж тооцох бодлогын шийдвэрийг гаргасан. Геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ болон дэлхийн томоохон төв банкнуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого, нийлүүлэлтийн сүлжээний доголдол бүрэн арилаагүй байгаа нь манай улсын гадаад эрэлтийг голлон тодорхойлогч БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж шинжээчид үзсэн.




*График 27. Жигнэсэн дундаж хүү, хувиар, сараар, 2020-2023*

*Эх сурвалж: Монголбанк*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6483855 9021031195 СТС2420

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
INNOVATION INVESTMENT
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

## 21.2. Дэлхийн бэлэн бус төлбөр тооцооны зах зээл

Сүүлийн жилүүдэд төлбөр тооцооны зах зээлийн олон улсын хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт шийдлүүд бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүд нэвтэрсээр байна.

КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор иргэдийн худалдан авах зан төлөв өөрчлөгдөж бэлэн мөнгөөр худалдан авалт хийхээс илүүтэйгээр зайнаас буюу цахимаар худалдан авалт хийх, бэлэн бус төлбөр тооцооны шийдлүүдийг илүүд үзэх зэрэг өөрчлөлтүүд гарч байна.

Олон улсын валютын сангийн судалгаагаар КОВИД-19 цар тахлын үеэр буюу 2020 онд дэлхийн эдийн засаг 4.5 хувийн уналттай байсан бол Capgemini судалгааны байгууллагын дэлхийн төлбөр тооцооны судалгаагаар дэлхийн бэлэн бус гүйлгээний дүн 2021 онд өмнөх оноосоо 7.8 хувийн өсөлт үзүүлсэн байгаа нь эдийн засгийн уналтын бэлэн бус гүйлгээний дүнд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байсныг илэрхийлж байна.




*График 28. Дэлхийн бэлэн бус гүйлгээний дүн ба өсөлтийн хувь, тэрбум доллар, хувиар, 2016-2026*

*Эх сурвалж: Capgemini судалгааны байгууллага " Дэлхийн төлбөр тооцооны тайлан 2022"*

Дэлхийн бэлэн бус гүйлгээний дүн 2016 – 2022 онуудад жилд дунджаар 15.5 хувийн өсөлттэй байсан бол 2023 – 2026 онуудад жилд дунджаар 16.4 хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна. Улмаар 2022 онд дэлхийн бэлэн бус гүйлгээний дүн 1.2 их наяд доллар байсан бол 2026 онд 2.1 их наяд доллар болж өсөх таамаглалтай байна.

Бэлэн бус гүйлгээний дүнгийн жилийн дундаж өсөлт өнгөрсөн хугацаанд 15.5 хувь байсан ч олон улсын судалгааны байгууллагуудын дунд хугацааны төсөөллөөр жилийн дундаж өсөлт нь түүхэн үзүүлэлтээс 0.9 нэгж хувиар илүү буюу жилд дунджаар 16.4 хувиар өсөх таамаглалтай байгаа нь дэлхий дахинд төлбөр тооцоог бэлэн бусаар гүйцэтгэх хандлага хурдацтайгаар нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Бэлэн бус гүйлгээний мөнгөн дүнгийн 2023 оноос 2026 он хүртэлх өсөлтийн төсөөллийн хувийг бүс нутгаар ангилж үзвэл Ази, Номхон Далайн бүс нутаг хамгийн өндөр өсөлттэй буюу жилд дунджаар 22.2 хувийн өсөлттэй байх хандлагатай байна. Үүний дараа Европ 13 хувь, Ойрх Дорнод ба Африк 12 хувь, Латин Америк 8.3 хувь, Хойд Америк 6.4 хувийн өсөлтүүдийг тус тус үзүүлэх төсөөлөлтэй байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ




*График 29. Ази, Номхон далайн бэлэн бус гүйлгээний дүн , тэрбум ам.доллар, хувиар, 2016 - 2026*

*Эх сурвалж: Capgemini судалгааны байгууллага " Дэлхийн төлбөр тооцооны тайлан 2022"*

2022 онд Ази, Номхон Далайн бүс нутаг дахь бэлэн бус гүйлгээний дүн 553 тэрбум ам.доллар байсан Capgemini судалгааны байгууллагын төсөөллөөр 2023-2026 онуудад уг дүн жилд дунджаар 22.2s хувийн өсөлт үзүүлэн 2026 онд 1.2 их наяд ам.долларт хүрэх төсөөлөлтэй байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 122.8 хувиар өссөн үзүүлэлт байх юм.

2016 онд Ази, Номхон далайн бүс нутгийн бэлэн бус гүйлгээний дүн нь дэлхийн нийт бэлэн бус гүйлгээний 26 хувийг бүрдүүлж байсан бол 2022 онд 48 хувийг бүрдүүлэх болсон. Дунд хугацаанд Ази, Номхон далайн бэлэн бус гүйлгээний өсөлт бусад бүс нутгаас илүү хурдацтай хэвээр байх хандлагатай байгаа бөгөөд 2026 онд дэлхийн нийт бэлэн бус гүйлгээний 58 хувийг бүрдүүлэх төсөөлөлтэй байна.




*График 30. Дэлхийн бэлэн бус төлбөр тооцооны хэлбэрийн бүтэц, тэрбум ам.доллар, хувиар, 2016 - 2025*

*Эх сурвалж: Capgemini судалгааны байгууллага " Дэлхийн төлбөр тооцооны тайлан 2021"*

СЗХ 2023 . . . сар . . өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

Дэлхийн нийт бэлэн бус төлбөр тооцоог хэлбэрээр нь задалж үзвэл 2016 онд карт, чек зэрэг уламжлалт хэрэгсэл 91.2 хувь, цахим мөнгө, хэтэвч, интернэт банк, мобайл банк зэрэг уламжлалт бус бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл 8.8 хувийг эзэлж байлаа. Харин, 2020 онд уламжлалт хэрэгслүүдийн хэрэглээ 85.5 хувь болж буурч, уламжлалт бус хэрэгслийн хэрэглээ нь 14.5 хувь болж 5.7 нэгжээр өссөн байна. 2025 онд нийт бэлэн бус төлбөр тооцооны 74.8 хувийг уламжлалт хэрэгслээр, 25.2 хувийг уламжлалт бус хэлбэрээр гүйцэтгэх төсөөлөлтэй байна (Эх сурвалж: Capgemini судалгааны байгууллага, Дэлхийн төлбөр тооцооны тайлан, 2021 он).

Дэлхийн төлбөр тооцооны үйлчилгээний зах зээлийн орлого 2012 онд 1.3 их наяд ам.доллар байсан ба жилд дунджаар 5.5 хувийн өсөлт үзүүлж 2021 онд 2.1 их наяд ам.долларт хүрсэн байна. 2020 онд КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн идэвхжил буурч, төлбөр тооцооны орлого 1.9 их наяд төгрөг болж буурсан нь 2019 оны дүнтэй харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлэлт байна. Харин 2021 оноос дэлхийн эдийн засаг сэргэж, худалдан авалт болон гүйлгээ нэмэгдэх болсон ба төлбөр тооцооны үйлчилгээний зах зээлийн орлого мөн нэмэгдэж эхэлсэн. 2021 оноос 2026 оны хугацаанд дэлхийн төлбөр тооцооны үйлчилгээний орлого жилд дунджаар 9.0 хувийн өсөлттэй байх төсөөлөлтэй байгаа бөгөөд 2026 онд зах зээлийн нийт орлого 3.3 их наяд ам.долларт хүрэхээр байна.




| Жилийн дундаж нийлмэл өсөлт | | |
|---|---|---|
| | 2012-2021 | 2021-2026 |
| Дэлхий | 5.5 хувь | 9.0 хувь |

*График 31.Дэлхийн төлбөр тооцооны үйлчилгээний зах зээлийн орлого, их наяд ам.доллар, хувиар, 2012-2021 гүйцэтгэл, 2023-2026 төсөөлөл*
*Эх сурвалж: McKinsey "Дэлхийн төлбөр тооцооны тайлан 2022"*

McKinsey компанийн жил бүр нийтэлдэг дэлхийн төлбөр тооцооны тайланд дурдсанаар Австрали улсад "Tap and Pay" хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр 2021 оны 3 дугаар сард цахим хэтэвчээр хийж буй төлбөр тооцоо өмнөх оны мөн үеэс 90 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны өсөлт нь дэлхийн ихэнх улс орнуудад ажиглагдаж байгаа бөгөөд цахим мөнгө, хэтэвч, интернэт банк, мобайл банк зэрэг уламжлалт бус, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслээр хийх гүйлгээ 2020 онд өмнөх оноос Индонези Улсад 39 хувиар, Сингапурт 58 хувиар, Англи Улсад 17 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байсан.

Ийнхүү сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөр тооцооны өсөлттэй холбоотойгоор томоохон технологийн компаниуд мобайл болон цахим төлбөр тооцооны экосистемийг сайжруулахад анхаарах болсон бөгөөд улс орнуудын төв банкнууд болон зохицуулах байгууллагууд бэлэн бус гүйлгээг дэмжих бодлого баримтлах болсноор бэлэн бус төлбөр тооцооны дэд бүтэц боловсронгуй болж байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6163948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420




*График 32. Дэлхийн дижитал төлбөр тооцооны зах зээлийн хэмжээ, тэрбум ам.доллар, хувиар, 2011 - 2027*
*Эх сурвалж: Research and Markets судалгааны байгууллага "Дижитал төлбөр тооцооны зах зээл 2022"*

"Research and Markets" судалгааны байгууллага нь дэлхийн дижитал төлбөрийн зах зээлийн хэмжээ 2021 онд 6.8 их наяд ам.доллароор хэмжигдэж байгаа бөгөөд жилд дунджаар 10.9 хувиар өсөж 2027 онд 12.6 их наяд ам.долларт хүрнэ хэмээн таамаглаж байна.

Дэлхийн бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн гүйлгээний тоо, дүн, хэрэглээ, оролцогч байгууллагуудын орлого өнгөрсөн жилүүдэд тогтмол өсөж, цаашид дундын хугацаанд өсөлтөө хадгалах боломжтой хэмээн олон улсын байгууллагууд таамаглаж байна. (Эх сурвалж: "Capgemini" судалгааны байгууллага, McKinsey, Boston consulting group)

Ийнхүү бэлэн бус, уламжлалт бус төлбөр тооцооны шийдлүүд өргөн хэрэглээнд тархаж буй нь эцсийн хэрэглэгч болох иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, шинэлэг шийдлүүдтэй хурдан дасан зохицож байгаатай холбоотой төдийгүй уламжлалт бус шийдлүүд нь бизнес эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж, тэдгээрийн асуудлыг шийдвэрлэж чадаж буйд оршиж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

Үнэт цаасны танилцуулга

## 21.3. Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээл

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль" 2017 оны 05 дугаар сарын 31-нд батлагдаж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн байдаг.

### 21.3.1. Төлбөр тооцооны үйлчилгээ ба төлбөрийн систем

Төлбөр тооцооны үйлчилгээний зах зээл нь хэрэглэгчийн зардлыг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар төлбөрийн системийн үр ашигтай байдлыг дэмжихэд чиглэсэн.

Төлбөр тооцооны систем гэдэг нь төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага, холбогдох дүрэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл юм.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүдийг нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгож байна.

Монголбанкнаас төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримталсны үр дүнд зах зээлд нэвтэрч буй шинэ төлбөрийн үйлчилгээ, хэрэгслүүд жилээс жилд хурдацтайгаар нэмэгдэж байгаа төдийгүй дэвшилтэт технологийг ашиглан зөвхөн банкнууд төдийгүй банк бус санхүүгийн байгууллагууд, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд энэ салбарт хүч түрэн өрсөлдөж, шинэ төлбөрийн үйлчилгээ, бүтээгдэхүүн, хэрэгслүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын төлбөр тооцооны зах зээл дээр доорх үндсэн оролцогчид байна:

- Монголбанк: Зохицуулалт болон Арилжааны банк хоорондын сеттлемент, клиринг гүйцэтгэнэ.
- Арилжааны банкнууд: Хадгаламж, зээл, санхүүгийн үйлчилгээ, төлбөрийн карт, цахим хэтэвч, банкны төлбөрийн аппликэйшн гэх мэт үйлчилгээ үзүүлж байна.
- Бусад зээлдүүлэгчид болон Финтек платформууд: Уламжлалт болон финтект суурилсан Банк бус санхүүгийн байгууллагууд нь зээл, лайфстайл платформ, цахим хэтэвч, санхүүгийн бүтээгдэхүүнүүд гарган үйлчилж байна. Мөн Buy Now Pay Later үйлчилгээ үзүүлэгчид: Монголбанкнаас цахим мөнгөний зөвшөөрөл авсан Финтек платформ багтаж байна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЕХ 2023.11.08 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03




*Схем 13. Монгол Улсын төлбөр тооцооны зах зээлийн үндсэн оролцогчид*

Улсад ашиглагдаж байгаа төлбөрийн хэрэгсэл болон сувгууд:

- Бэлэн мөнгө;
- Интернэт банк;
- Төлбөрийн даалгавар, нэхэмжлэл;
- Мобайл банк;
- Төлбөрийн карт;
- Мөнгөн гуйвуулга;
- Цахим мөнгө;
- Биллинг.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ... EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 21.3.2. Монгол Улсын бэлэн бус гүйлгээ

Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэгчдийн 2017 – 2022 оны 03 дугаар улирлын тайланг нэгтгэн, хэрэглэгчийн тоог интернэт болон мобайл хандалтын төрлөөр ангилахад интернэт хандалтад суурилан гүйлгээ хийсэн хэрэглэгчдийн тоо жилд дунджаар 20.8 хувиар өсөж 1.4 сая хэрэглэгчээс 3.6 сая хэрэглэгч болж өссөн үзүүлэлттэй байна. Мобайл хандалтын тоо жилд дунджаар 9.9 хувиар буурч, 3.2 саяас 1.9 сая болсон үзүүлэлттэй байгаа нь дэвшилтэт технологийн тусламжтайгаар интернэт хандалтад суурилсан төлбөр тооцооны шийдэл илүү ашиглагдаж байгааг илэрхийлж байна. Интернэт хандалтад интернэт банк болон аппликэйшн ашиглан гүйлгээ хийх нь хамаарна.




*График 33. Хөдөлгөөнт банкны хэрэглэгчдийн тоо, сая хэрэглэгч , 2017 – 2022 оны 03 дугаар улирал*

*Эх сурвалж: Монголбанк*




*График 34. Монгол Улсын бэлэн бус гүйлгээний тоо болон өсөлт, сая ширхэг, хувиар, 2017 –2022 гүйцэтгэл, 2023-2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Монголбанк , Үнэт цаас гаргагчийн төсөөлөл*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03




*График 35. Монгол Улсын бэлэн бус гүйлгээний үнийн дүн болон өсөлт, их наяд төгрөг, хувиар, 2017 – 2022 гүйцэтгэл, 2023-2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Монголбанк, Үнэт цаас гаргагчийн төсөөлөл*

2017 – 2022 онуудын хооронд бэлэн бус гүйлгээний тоо жилд дунджаар 37 хувиар өсөж, 2017 онд 321 сая ширхэг бэлэн бус гүйлгээ хийгдэж байсан бол 2022 онд 1.5 тэрбум ширхэг гүйлгээ хийгдсэн байна. Үнийн дүн нь тухайн хугацаанд жилд дунджаар 37.4 хувиар өсөж, 2017 онд 76 их наяд байсан бол 2022 онд 372 их наяд болж өссөн үзүүлэлттэй байна.

Энэ хугацаанд Монгол Улс дахь банкны данс хоорондын бэлэн бус гүйлгээний тоо 321 саяас 1.5 их наяд хүртэл, үнийн дүн нь 76 их наяд төгрөгөөс 372 их наяд төгрөг хүртэл 5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч нийт гүйлгээний үнийн дүнгийн 20 хувь буюу 30 их наяд төгрөгийг иргэд АТМ-ээс гарган өдөр тутмын худалдан авалт, үйлчилгээнд ашигласан хэвээр байгаа юм. АТМ-ээс бэлнээр гаргасан мөнгийг иргэд хэд хэдэн удаа үйлчилгээнд ашиглан дамжигдсаны эцэст буцаж банканд ирдэг. Бэлэн мөнгөний хэрэглээг бууруулбал бэлэн бус гүйлгээний тоо цаашид өндөр хувиар өсөх боломж их байна.

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын бэлэн бус гүйлгээний зах зээл 2023 - 2027 онуудад жилд дунджаар 13.3 хувийн өсөлт бонд 874 их наяд төгрөгийн бэлэн бус гүйлгээ хийгдэхээр байгаа юм. Энэхүү төсөөллийг Үнэт цаас гаргагчийн шинжээчид олон улсын тренд, Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангийн түүхэн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцоолов.

Иймхүү Монгол Улсын төлбөр тооцооны салбарт дижитал төлбөрийн хэрэгсэл илүү нэвтэрч, хэрэглэгчид бэлэн бусаар төлбөр тооцоо гүйцэтгэх хандлага нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс томоохон нөлөөллийг үзүүлж байна. Үүнд:

- Хэрэглэгчид өдөр тутамдаа ашиглахад хялбар, хурдан, найдвартай төлбөрийн шийдлүүдийг ашиглах сонирхол нэмэгдэж, бэлэн төлбөр тооцооноос бэлэн бус руу шилжих хандлага нэмэгдэж байна.
- КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд иргэд худалдан авах зан төлөвөө өөрчилж, бэлэн мөнгөөр худалдан авалт хийхээс зайлсхийж аппликэйшн ашиглахыг илүүд үзэх болсон.
- Монгол улсад гар утасны хэрэглээ болон 3G, 4G сүлжээ өргөн хэрэглээнд нэвтэрсэн тул иргэд аппликэйшн, интернэт банк ашиглахад хялбар нөхцөл байдал бүрдсэн. Үүнтэй зэрэгцэн бизнес хэрэглэгчид цахим төлбөр тооцоо бүхий шийдлүүдийг санал болгохыг эрмэлзэх болсон.

Үнэт цаас гаргагч.

Андеррайтер

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

- Олон улсын зохицуулах байгууллагууд адил Монголбанк нь төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.
- Бизнес эрхлэгчид төлбөрийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн шийдлийн уян хатан байдалд ач холбогдол өгч, харилцагчдынхаа таашаалд нийцсэн шийдлүүдийг илүү эрэлхийлэх хандлагатай байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
1117242908
6183948
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
6183855
9021031195
СТС2420

СЗХ 2023 .09 сар 08 өдөр БҮРТГЭВ № 01

INNOVATION INVESTMENT 2023-07-20

# 22. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн ерөнхий стратеги нь олон улсын болон дотоодын финтекийн хөгжил, бэлэн бус төлбөр тооцооны зах зээл, цахим шилжилт, интеграцчлалын концепцийн дагуу тодорхойлогдоно. Дэлхийн гэлтгүй дотоодын төлбөр тооцооны шинэчлэл нь түүнийг дагасан шинээр гарах болон гарч буй нэмүү өртөг шингэсэн (value-added services) үйлчилгээнүүдийг бодит бизнес болгоход хамгийн чухал үүргийг гүйцэтгэнэ. Тийм учраас Үнэт цаас гаргагч нь TechFin чиглэлд үйл ажиллагаа явуулах үндсэн стратегийг баримталж ажиллах ба үүний хүрээнд дараах 4 үндсэн зорилгуудыг баримтлан ажиллахаар төлөвлөж байна.

- Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд байр сууриа улам бэхжүүлэх
- Дундын HUB үйлчилгээнүүдээр дамжуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх
- POWER+ стратеги хэрэгжүүлэх
- TechFin хөрөнгө оруулалт

## 22.1. Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бэхжүүлэх

### 22.1.1. Маркетинг, зах зээл дахь байр суурь бэхжүүлэлт

QPay үйлчилгээг нийтэд сайтар таниулах зохистой маркетинг хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлнэ.

Түүнчлэн, одоо бэлэн байгаа зах зээлд нэвтрээд удаагүй үйлчилгээнүүдийг нийтэд шат дараатайгаар танилцуулж, хоногшуулна. Үүнд:

- Subscription/Recurring Payment;
- ЮнионПэй QR кодоор төлбөр төлөх;
- WechatPay;

Үнэт цаас гаргагч нь дангаараа болон мерчант байгууллагууд, түнш байгууллагуудтай хамтран иж бүрэн маркетинг хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### 22.1.2. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, модуль хөгжүүлэлт

Зах зээлд амжилттай нэвтэрсэн QPay үйлчилгээг хэрэглэгчдийн өдөр тутмын сонголт болгохын тул гүйлгээ хийхэд хамгийн хялбар, хурдан, найдвартай байхаар үргэлж сайжруулж, шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлнэ. Бэлэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ тогтмол сайжруулахын зэрэгцээ Үнэт цаас гаргагч нь дараах онцлох шинэ шийдлүүд нэвтрүүлэх зорилготой байна. Үүнд:

- Бизнес хоорондын гүйлгээ (B2B): Байгууллагын интернэт банкны гүйлгээ буюу байгууллагууд deeplink технологид суурилсан QPay гүйлгээг ашиглаж эхэлснээр URL холбоосоор нэхэмжлэх илгээх, хүлээн авсан нэхэмжлэхийг автоматаар шивэх зэрэг боломжуудыг эдлэх ба энэ нь гар ажиллагааг бууруулж хүн цагийг хэмнэсэн шийдэл болох юм.
- Биллинг: Цахим хэтэвч ашиглан токенжуулсан Хэрэглэгчийн картаас автоматаар төлбөр татах боломжтой.
- Олон улсын төлбөр тооцоо: Үнэт цаас гаргагч нь дотоодын зах зээлд Paypal, Apple pay, Samsung Pay зэрэг олон улсын төлбөрийн түншүүдийг бий болгож, Монгол Улсад төлбөрийн олон нэмэлт урсгалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн дотоодод олон улсын төлбөрийн орох урсгалыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч дэлхийд үйл ажиллагаа явуулдаг томоохон онлайн худалдаа, үйлчилгээний платформуудын төлбөрийг хүлээн авдаг томоохон дэд бүтцийг бий болгоно.
- QPay үйлчилгээг нэвтрүүлсэн Мерчантуудад зориулсан урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлж, нэмэлт үйлчилгээний төрлүүдийг олшруулж, илүү боловсронгуй болгоно.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021831195 СТС2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

2023-07-20
БҮРТГЭВ-03




*Схем 14. QPay үйлчилгээний хөгжүүлэлтийн ерөнхий зураглал, төлөвлөгөө*

***B2B**

Нэхэмжлэхийг банкны гар утасны аппликэйшнээр дамжин төлөх боломжтой байсныг байгууллагуудад зориулан банкны интернэт банкаар дамжуулан QPay гүйлгээ хийх боломжийг олгох үйлчилгээ

***Loyalty**

Зөвхөн QPay Merchant харилцагчдад зориулсан QPay хэрэглэгчдийн урамшуулалт хөтөлбөрт тулгуурласан борлуулалтыг дэмжих үйлчилгээ

***Billing Hub**

Монгол Улсын хэрэглээний төлбөрийн нэхэмжлэх, хэрэглээний нэгдсэн санг үүсгэж хэрэглэгчдэд хялбар төлбөрөө төлөх, хэрэглээгээ хянах боломжийг бий болгох цогц платформ юм.

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 22.1.3. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай товч танилцуулга, зах зээлд нэвтрүүлэх зорилтот огноо

**2023.09 – Billing Hub**

Орон сууц, хэрэглээний төлбөр төлөх тооцооны нэгдсэн хялбар, хяналттай, ухаалаг системийг нэвтрүүлнэ.

**2023.12 – Гадаадын улс орнуудад үйлчилгээ нэвтрүүлэх**

Зүүн Өмнөд Азийн зах зээлд гадаадын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, эрхлэх сонирхолтой байгууллагатай хамтран картын токенжуулалт, QR төлбөр тооцоо, цахим болон бусад төлбөр тооцооны чиглэлээр ажиллаж тус зах зээлд нэвтрүүлэн ажиллана.

**2024.02 – AliPay**

Монгол улсын төлбөрийн хэрэгслээр бидний худалдаа, арилжааны хамгийн том түнш болох БНХАУ-д худалдаа, аялал, бизнесийн өдөр тутмын хэрэглээний төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг нэвтрүүлнэ.

**2024.05 – Concept дэлгүүр**

АНУ, БНХАУ гэх дижитал төлбөр тооцоо, цахим хэрэглээ өндөр хөгжсөн орнуудад үйлчилгээний ажилтан, борлуулагчгүй дэлгүүрүүд ихээр нээгдэж байна. Дэлхийн алдартай "Amazon Go" дэлгүүрээс санаа аван Монгол хэрэглэгч нарт зориулан технологийн дэвшил ашигласан анхны дэлгүүрийг бий болгож, Монголд турших, нэвтрүүлэхээр ажиллана.

**2024.08 – BPay үйлчилгээ**

Монголын биллинг үйлчилгээний нэгдсэн санг бий болгож төрийн үйлчилгээ, хувийн хэвшлийн нэхэмжлэх суурьтай төлбөр тооцооны стандартыг бий болгож нийтэд хүртээмжтэй үйлчилгээг олон нийт, бизнесийн байгууллагуудад нэвтрүүлнэ.

**2024.12 – QPay Corporate**

Байгууллага хооронд, Байгууллага иргэн хоорондын цахим төлбөрийн шийдлийг нэвтрүүлж одоо төрийн үйлчилгээ болон цахим бизнест тулгарч буй асуудлыг шийдэж шинэ төрлийн бизнесүүдийг өсч, бойжих боломжийг бий болгоно.

**2025.04 – Split Pay**

Үйлчилгээ, худалдааны газрууд техник, технологийн Internet of Things (IoT) төхөөрөмж ашиглан хэрэглэгчдэдээ илүү хялбар, хурдан үйлчилгээ үзүүлэхээр ашигладаг болсон. Үнэт цаас гаргагч нь тухайн IoT төхөөрөмжүүдтэй интеграци хийж үйлчилгээний төлбөрийг Хэрэглэгч нарын тоонд хуваан төлөх боломжтой шинэ төлбөрийн төрлийг нэвтрүүлнэ.

**2025.08 – PayPal үйлчилгээний албан ёсны түншлэл**

Үнэт цаас гаргагч нь "Пэйпал Холдинг" ХК-ийн албан ёсны түнш болсноор олон улсад хамгийн ихээр ашиглагддаг Paypal төлбөрийн гарцаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа, арилжааны байгууллагууд төлбөр хүлээн авах боломжтой болно.

**2026.12 – Япон / Сингапурт IPO хийх**

Үнэт цаас гаргагчийн 2017 оноос 2021 он хүртэл хийгдсэн ажил, амжилтууд Монголын хөрөнгийн биржид нээлттэй хувьцаат компани болох суурийг тавьсан бол 2022 оноос хойш хийгдэх ажлууд нь Сингапур, Япон Улсын хөрөнгийн биржид хувьцаагаа санал болгож, Монголын компани гадны зах зээлд олон нийтийн компани болох боломжийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн "Инновэйшн Инвестмент" ХХК нь өөрийн хэрэгжүүлэх төслүүдийг дотоодын, удирдлагын болон стратегийн хэмээн ангил хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр тухайн төслүүдэд оролцож ажиллах хэлтэс, хүний нөөц болон төслийг удирдаж хэрэгжүүлэх төслийн удирдагчдыг сонгох, төслүүдийн уялдаа холбоо болон төслийн



INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО ХХК 6183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

эцсийн зорилгыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Судалгаа хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын бодлого тухай дэлгэрэнгүйг холбогдох хэсгээс танилцана уу.

**2027.04 – Олон улс, дотоодын картын төлбөрийн шинэ шийдлийг зах зээлд нэвтрүүлэх**

Энэхүү үйлчилгээг дотоодын зах зээлд нэмэлт төлбөрийн хэрэгсэл болгож, хэрэглэгч төлбөр төлөхдөө гар утас, карт ашиглах шаардлагагүй болгож, илүү хялбар, хурдан, олон боломжит төлбөрийг шийдлийг нэвтрүүлнэ.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9011031195 СТС2420

СЗХ
2023.11.10 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 - 07 - 20
БҮРТГЭВ-03

## 22.2. Дундын HUB үйлчилгээнүүдээр дамжуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх

Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээний хүрээнд хамтран ажилласан Түнш болон Мерчант байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, цаашид Монгол Улсын Төлбөр тооцооны болон TechFin зах зээлүүдэд дижитал дэд бүтэц хөгжүүлэх, шинэ шийдлүүд нэвтрүүлэхэд мөн адил хамтран ажиллах, Түншүүд болон Мерчантуудыг дэмжих зарчим баримтална.

Дундын HUB болж ажиллах бодлого нь энэхүү зарчмаас үүдэлтэй бөгөөд Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш Түнш болон Мерчант байгууллагуудтай эрх тэгш байдлаар хамтран ажиллаж ирсэн.

QPay үйлчилгээ нь бүх харилцагч байгууллагууддаа ижил үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгодгоороо давуу талтай. Ингэснээр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, Мерчантууд болон Хэрэглэгч бүр ижил нөхцөл бүхий QPay үйлчилгээг дурын арилжааны банк, финтекийн платформоор дамжуулан авах нөхцөл бүрдсэн. QPay үйлчилгээ нь дундын HUB буюу олон төрлийн байгууллага, системүүд хоорондоо ойлголцох цэг болж байгаа онцлогтой бөгөөд цаашдын бүтээгдэхүүн хөгжил нь мөн энэ зарчмыг баримтлах юм.

Үнэт цаас гаргагчийн амжилттай QPay үйлчилгээ нь хамтын ажиллагаа, түншлэл дээр бий болсон тул энэхүү түншлэлд суурилж харилцан ашигтай байхыг эрхэмлэдэг байдал нь компанийн соёл, үйл ажиллагааны зарчимд шингэсэн юм.

Тиймээс Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээ Түнш болон Мерчант байгууллагуудад хүртээмжтэй байлгах зорилгоор:

- QPay шинэ үйлчилгээнүүдийг банкны хэрэглэгчдэд хүртээмжтэй байх үүднээс бүх арилжааны банкнуудад нэвтрүүлэх;
- Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) болон сар бүрийн биллингийн төлбөрийн дундын платформыг түншүүдэд нэвтрүүлэх;

Түүнчлэн, Мерчантуудын зардлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ:

- Мерчант төлбөрөө хүлээн авахад зарцуулах зардлыг бууруулж, автоматжуулах;
- Мерчантын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мерчант бүрт зориулсан лоялти платформыг санал болгох;
- Мерчантын нөөцийг зохистой ашиглаж, мерчант, үйлчлүүлэгч, төлбөрийн оролцогч харилцан ашигтай борлуулалтын платформыг нэвтрүүлэх;
- Мерчантын түвшин бүрд тохирсон ухаалаг шийдлүүдийг зах зээлд зогсолтгүй санал болгох

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
6183855
9027031195 СТС2420

Андеррайтер

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 22.3. POWER+ стратеги хэрэгжүүлэх

"Инновэйшн Инвестмент" ХХК нь дунд хугацаанд JP Morgan хөрөнгө оруулалтын банкны жишиг болгож буй POWER+5 мега стратеги буюу Platforms, Online, Wallet, Embedded болон Real time гэх сэдвүүдэд хамаарах 20 гаруй бизнес, үйлчилгээнүүдэд нийцэх дижитал дэд бүтэц хөгжүүлэхээр зорьж байна.

Олон улсын JP Morgan хөрөнгө оруулалтын банкны санхүүгийн судалгааны баг нь 2020 онд дэлхийн төлбөр тооцооны зах зээлд 240 гаруй их наяд ам.доллар эргэлдсэн бөгөөд түүний 54 гаруй их наяд ам.доллар нь энэхүү 5 мега стратегид хамрагдаж буй 20 бизнес, үйлчилгээний хүрээнд хийгдсэн гэж үзжээ (Эх сурвалж: JP Morgan, 2020 он).




*Схем 15. JP Morgan хөрөнгө оруулалтын банкны жишиг болгож буй POWER+5 мега стратегийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн ач холбогдол өгч буй бизнес салбарууд*

*Эх сурвалж: JP Morgan, 2020 он*

Эдгээр бизнес үйлчилгээнүүд нь сүүлийн 5 жилд Монгол Улсын зах зээлд хурдацтайгаар хөгжиж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь одоогийн байдлаар цахим хэтэвчүүд зэрэг цөөнгүй төрлийн бизнесүүдтэй нь хамтарч ажиллаж байна. "Инновэйшн Инвестмент" ХХК нь дунд хугацаанд супер аппликэйшн, онлайн худалдаа, цахим хэтэвч, крипто бирж, IoT-д суурилсан үйлчилгээ, бүтээгдэхүүнүүд болон олон улсын мөнгөн гуйвуулга, шилжүүлгийн үйлчилгээг чухалчилж тус бизнесүүдэд нийцэх дижитал дэд бүтэж хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

СЗХ
2023 . сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

INNOVATION INVESTMENT
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 22.4. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь дунд болон урт хугацаанд Монгол Улс дахь TechFin салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй компани, бизнесийн төслүүдэд өөрийн шалгуур болон Судалгаа хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулж, тус бизнесийн үр ашгаас ашиг хүртэх, үйл ажиллагааг нь өргөжүүлж, бизнесийн синержиг дэмжих байдлаар ажиллахаар төлөвлөж байна.

Үнэт цаас гаргагч нь Зах зээлийн чиг хандлага, Монгол Улсын бизнесийн орчинд үндэслэн дижитал шилжилт шаардлагатай технологийн салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалтыг зохистойгоор оруулж ажиллах бөгөөд уг зорилгын хүрээнд тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс инновацийг эрхэмлэдэг, чадварлаг ажиллах хүчин бүрдүүлэх, түүнд нийцсэн компанийн бүтэц, цалин урамшуулал, нийгмийн халамжийн зохистой бодлого, компанийн соёлыг бий болгохоор ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь цаашид үндсэн бизнес болох TechFin үйлчилгээг нэвтрүүлэхээр өмнөх хэсэгт дурдсан сүүлийн жилүүдэд хамгийн их өсөлттэй байх салбаруудад технологи ашигласан шийдлийг санал болгож, зохистойгоор хөрөнгө оруулалтыг хийж ажиллахаар төлөвлөж байна.

Ингэхдээ Үнэт цаас гаргагч нь дэлхийн зах зээлийн чиг хандлага болон Монголын эдийн засаг дахь салбарын өсөлтийг үндэслэн Стратегийн салбарын матриц боловсруулж, 15-аас дээш оноотой салбаруудад чиглэсэн технологийн компани, бүтээгдэхүүн, үйлчилгээг бойжуулах, хөрөнгө оруулах чиглэлд анхаарч ажиллана.

| Группийн стратегийн салбарууд | | Сүүлийн 5 жилийн дунджаар Монглын ДНБ бүтцэд хамгийн өндөр хувь эзэлсэн салбарууд (sector) | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Үйлчилгээ | Үйлдвэрлэл | Уул уурхай, олборлох | Худалдаа, зочид буудал, зоогийн газар | Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа | Хөдөө аж ахуй | Мал аж ахуй | Боловсруулах | Тээвэр, мэдээлэл, холбоо | Барилга | Бусад |
| Олон улсын 10 тэрбум ам.доллараас илүү үнэлгээтэй болсон гараны компаниуд хамгийн ихтэй салбарууд (industry) | Финтек | | | | | 18 | | | | | | |
| | Онлайн худалдаа | 21 | | | | | | | | | | |
| | Хиймэл оюун ухаан | 20 | 19 | 18 | 17 | 16 | 15 | 14 | 13 | 12 | 11 | |
| | Төхөөрөмж | | | | | | | | | | | |
| | Интернэт үйлчилгээ | 18 | | 16 | 15 | 14 | | | | 10 | 9 | |
| | Жижиглэн худалдаа | 17 | | | | | | | | | | |
| | Дата менежмент, анализ | 16 | 15 | 14 | 13 | 12 | 11 | 10 | 9 | 8 | 7 | |
| | Едтек | | | | | | | | | | | 5 |
| | Эрүүл мэнд | | | | | | | | | | | 4 |
| | Тээвэр, нийлүүлэлт | | | | | | | | | 5 | | |
| | Автомат жолоодлого | | | | | | | | | 4 | | |

*Хүснэгт 24. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны зорилтот стратегийн салбарын матриц, үнэлгээ*

*Эх сурвалж:Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагч нь зөвхөн мөнгөн хөрөнгөөр бус хүмүүн капитал, ноу-хау, технологийн шийдлээр хөрөнгө оруулахыг эрхэмлэх бөгөөд энэ хүрээнд зөвхөн Үнэт цаас гаргагч бус түүний 100 хувийн эзэмшил дахь охин компаниуд мөн хамтарч хөрөнгө оруулах боломжтой юм. Ингэхдээ үндсэн Судалгаа хөгжүүлэлтийн дэмжлэг үзүүлж бойжуулах, хяналтын багц эзэмшин хөрөнгө оруулах, бага хувь эзэмшиж хөрөнгө оруулах гэсэн 3 үндсэн хэлбэрээр хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн болно.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

INNOVATION INVESTMENT LLC
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ

INNOVATION INVESTMENT

# 23. Судалгаа, хөгжүүлэлт болон хөрөнгө оруулалтын бодлого

“Инновэйшн Инвестмент” ХХК нь технологийн салбарт туршлага болоод мэргэжлийн хандлагаар үлгэрлэж, эрх тэгш, хүнлэг ирээдүйг бүтээх хүсэл тэмүүллээр дижитал дэд бүтцийг бий болгох үйлсэд хөрөнгө оруулагч, сайн хамтрагч байх зорилготой. Энэ хүрээнд Үнэт цаас гаргагч нь судалгаа дараах бизнесийн зарчмыг баримтлан судалгаа, хөгжүүлэлтийн бодлого боловсруулж 2022 оноос эхлэн мөрдөж байгаа болно:

| | |
|---|---|
| ТЭМҮҮЛЭЛТЭЙ | - Passionate \| Инновацлаг дэвшилтэт ирээдүйд тэмүүлэгч |
| ХҮНЛЭГ | - Empathy \| Хүнлэг хүртээмжтэй байдлыг бүрдүүлэгч |
| САЙН ХАМТРАГЧ | - Well-Balanced \| Бизнесийн сайн засаглалыг эрхэмлэгч |
| ЭКСПЕРТ | - Expert \| Чадварлаг, ёс зүйтэй, багаар ажиллагч, манлайлагч |

## 23.1. Хөрөнгө оруулалтын багцууд (Investment portfolio)

“Инновэйшн Инвестмент” ХХК нь технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлахыг зорьж ажиллах төлөвлөгөөтэй байна. Үүний тулд ойрын 5 жилийн хугацаанд бид хөрөнгө оруулалтын үндсэн 3 багцыг бүрдүүлнэ. Үүнд:

1. **Стратегийн төслүүд** – Компанийн 33 хувиас доош хэмжээгээр хувьцааг нь худалдан авсан, түншлэлийн гэрээгээр солилцсон Badge авах зорилготой стратегийн хөрөнгө оруулалтын багц байна. Энэхүү багц нь нийт төслийн 10 хувиас ихгүй хувийг эзэлнэ.
2. **Хяналтын төслүүд** - Төсөл болон компанийн 34 хувиас дээш хэмжээгээр хөрөнгө оруулалт хийсэн судалгаа хөгжүүлэлт болон менежментийн тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх төслүүдийн багц байна. Энэхүү багцын эзлэх хувь нийт төслийн 20 хувиас ихгүй байна.
3. **Үндсэн төслүүд** - “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн одоо үйл ажиллагаа явуулж буй охин компаниудаас гадна 100 хувийн хөрөнгө оруулалттай буюу шууд хамаарал бүхий бойжуулж, хөгжүүлэх шинэ төслүүдийн багц байна. Энэхүү багцын эзлэх хувь нийт төслийн 60 хувь буюу түүнээс дээш байна.

## 23.2. Хөрөнгө оруулалтын төрөл

“Инновэйшн Инвестмент” ХХК нь технологийн хөрөнгө оруулалтын компани бөгөөд төслийн онцлогоос хамааран зөвхөн санхүүжилт бус мэргэжлийн зөвлөгөө, удирдлага, инженерийн ажиллах хүчин, шийдэл зэрэг мэдээллийн технологийн салбарт амжилт гаргахад шаардлага бүхий хүмүүн капиталаар хөрөнгө оруулдаг онцлогтой юм.

| VALUE | NATIVE | CONTROL | STRATEGIC |
|---|---|---|---|
| Finance | ✓ | ✓ | ✓ |
| Management | ✓ | ✓ | |
| R&D | ✓ | ✓ | |
| Office | ✓ | | |
| DEI | ✓ | ✓ | |
| Shared value | ✓ | ✓ | ✓ |
| SDG, ESG | ✓ | ✓ | ✓ |

Схем 16. Хөрөнгө оруулалтын хэлбэр, багцын ангиллаар

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023 11 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 ... БҮРТГЭВ-03

## 23.3. Төслийн сонгон шалгаруулалт

“Инновэйшн Инвестмент” ХХК нь хөрөнгө оруулалт хийх төслүүдийг сонгон шалгаруулахдаа Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг мөрдлөг болгоно.

Төслийн сонгон шалгаруулалт дараах үндсэн процедуртай байна. Үүнд:

1. Төслийн сонгон шалгаруулалт хийх судалгааг Гүйцэтгэх захирлын дэргэдэх Судалгаа хөгжүүлэлтийн хорооны гишүүд гүйцэтгэх бөгөөд гишүүд тус бүр дээр гарсан үнэлгээг Төслийн удирдлагын албан дээр нэгтгэнэ.
2. Судалгаа хөгжүүлэлтийн хорооны хурлаар төслийн богино жагсаалтыг (shortlist) гаргана.
3. Богино жагсаалтад орсон төслүүдийг Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Стратеги хөгжлийн хороонд танилцуулна.
4. Төсөл хэрэгжүүлэх эцсийн шийдвэрийг Стратеги хөгжлийн хорооны хуралдсаны үндсэн дээр гаргана.

Хөрөнгө оруулалтын төслүүдэд 3 шатлалт сонгон шалгаруулалтыг хийнэ. Үүнд:

1. **Стратегийн нийцэл (Strategic alignment)** – Хөрөнгө оруулах болон шинээр бойжуулах төслүүд нь Үнэт цаас гаргагчийн стратегийн зорилго зорилтод хэр нийцтэй байгааг харгалзан үзэж, хөрөнгө оруулах эхний шийдвэрийг гаргана.
2. **Үүсэх үнэ цэн (Value)** – Хөрөнгө оруулах болон шинээр бойжуулах төслүүд нь хэр үр өгөөжийг авч ирэх талаар санхүүгийн болон санхүүгийн бус өгөөжийн тооцооллыг олон улсын төслийн удирдлагын “Benefit measurement method”-ийг ашиглан гаргана.
3. **Ач холбогдол болон бэлэн байдал (priority and complexity):** Энэхүү шалгаруулалт нь зөвхөн “Үндсэн төсөл” хөрөнгө оруулалтын багц дээр хийгдэх бөгөөд 100 хувь өөрсдийн бойжуулан гаргах төслүүд дээр төслийн дотоод бэлэн байдлын шалгуур үзүүлэлтүүдийг хэмжин бэлтгэл ажлыг хөрөнгө оруулалттайгаа уялдуулан зохион байгуулна.

Стратегийн нийцэл нь дараах үндсэн үзүүлэлтүүдийг агуулна. Үүнд:

- Алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн эсэх;
- Үнэ цэнийг илэрхийлэх эсэх;
- Дунд хугацааны бизнесийн стратегид нийцсэн эсэх;
- Тогтвортой байдлыг хангах төсөл эсэх
- Урт хугацаанд өгөөж өгөх шинэ салбарын төсөл;
- Нэр хүндийг өргөх, болон илэрхийлэх төсөл;
- Тогтвортой хөгжлийн хүрээнд хийгдэх төсөл;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх төсөл.

## 23.4. Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг тооцох аргачлал

Төслийн өгөөжийг хэмжих (Benefit measurement) аргачлал нь гарах болон орох мөнгөн урсгалын өнөөгийн үнэлгээнд үндэслэн төслийн сонгон шалгаруулалтыг хийх арга юм. Ийнхүү гарах зардлын өгөөжийг тооцоолон бусад төслүүдтэй харьцуулснаар шийдвэр гаргахад ойлгомжтой хялбар болдог. Энэхүү аргачлалд дараах техникийг ашиглана.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

Андеррайтер

2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023 -07- 20
БҮРТГЭВ-03




*Схем 17. Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг тооцох аргачлал*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

**Өгөөж болон зардлын харьцаа (Benefit/cost ratio):** Төслөөс орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг төсөлд оруулах хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнд харьцуулсан харьцаа. Энэ нь төслөөс олох өгөөжийн үнэ цэнэ бөгөөд үүнийг бизнес хөгжлийн менежер болон бизнес хариуцсан захирал тооцооллыг гарган Судалгаа хөгжүүлэлтийн хороонд танилцуулна.

**Эдийн засгийн үнэ цэн (Economic value added):** Төслийн гүйцэтгэлийн бүтээмжийг тооцох хэмжүүр бөгөөд татвар, хөрөнгийн зардлыг хассаны дараах цэвэр ашгаар илэрхийлэгдэнэ. Бизнес хариуцсан захирлын удирдлага доор Бизнес хөгжлийн менежер нь холбогдох тооцооллыг гаргаж, Судалгаа хөгжүүлэлтийн хороонд танилцуулна.

**Төслийн үнэлгээний тооцоолол (Scoring):** Төсөл сонгон шалгаруулахад шаардлагатай бүх үзүүлэлтийг жагсааж, тэдгээрийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн дагуу хувийн жинг Төслийн удирдлагын албанаас тодорхойлдог байна. Уг жингийн үзүүлэлтээр тухайн төсөл нь ямар чиглэлийн хэнд зориулсан төсөл нь тодорхойлогдох бөгөөд нийлбэр дүн хамгийн өндөр төслүүдээс сонгон шалгаруулалтыг хийдэг байна.

**Эргэн төлөгдөх хугацаа (Payback period):** Төсөлд оруулсан нийт хөрөнгийг буцаан олох эцсийн хугацаа буюу ашиг хүртэж эхлэх хугацаа юм.

**Цэвэр өнөөгийн үнэ цэн (Net present value):** Төслөөс орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн болон төсөлд оруулах хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэний зөрүү юм.

**Хорогдуулсан мөнгөн урсгал (Discounted cash flow):** Төсөлд хөрөнгө оруулж буй мөнгөн дүн нь байнга өнөөгийн үнэ цэнээрээ байдаггүй. Иймд төсөл бүрд хөрөнгө оруулж буй мөнгөн дүнг 5 болон 10 жилийн дараах үнэ цэн болон түүний ялгааг тооцож үзнэ. Энэхүү тооцоолол нь хөрөнгө оруулалтын өгөөжийг (ROI) тооцоолоход ашиглагдана.

**Дотоод өгөөжийн хүү (Internal rate of return):** Хөрөнгө оруулалтын орох ба гарах бүх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн нь тэг байх үеийн хүүгийн хувь юм. Өөрөөр хэлбэл ийм хүүтэй үед хөрөнгө оруулагч анхны хөрөнгө оруулалтаа нөхөх боломжтой болно.

**Алдагдсан боломжийн өртөг (Opportunity cost):** Ижил төстэй татгалзсан төслүүдийн өртгийн харьцуулалт. Энэхүү үзүүлэлтэд өртөг багатай төсөл илүү оноог авах бөгөөд онооны хуваарилалтыг Төслийн удирдлагын алба хийнэ.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 рд 6183948

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ
БЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

Андеррайтер

СЗХ
2023 11 08
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-07-20
БҮРТГЭВ-03

## 23.5. Төслүүдийн эрсдэлийн ангилал

Төслийн сонгон шалгаруулалтад зөвхөн сөрөг эрсдэлүүдийг тооцох бөгөөд алдагдалд хүргэх ямар нэгэн хүчин зүйл болон үйл ажиллагааг эрсдэл гэж үзнэ. Төслийн эрсдэлийг дараах 3 төрөлд хуваан үзнэ.

1. Бизнесийн эрсдэл: Бизнесийн харилцаа хамтын ажиллагаа, ашгийн хэмжээ, бүтээгдэхүүний үйлчилгээний зах зээлд эзлэх хувь, дотоод үйл ажиллагаа болон нэр хүндэд учрах эрсдэлүүдийг тооцож үзнэ.
2. Бизнесийн бус эрсдэл: Улс төрийн болон эдийн засгийн тогтворгүй байдлаас үүсэх эрсдэлийг тооцно.
3. Санхүүгийн эрсдэл: Байгууллагад тохиох санхүүгийн алдагдлыг агуулсан эрсдэлүүд байна. Санхүүгийн эрсдэл нь ихэнхдээ хувьцааны үнэ, валют, хүүгийн түвшин гэх мэт хүчин зүйлийн хэлбэлзэл нөлөөлсөн санхүүгийн зах зээлийн алдагдал, тогтворгүй байдлаас үүсэх эрсдэлүүдийг тооцно.

Төсөл бүрд сонгон шалгуулах үзүүлэлт болон арга техник нь ижил байх албагүй бөгөөд дээр заасан арга хэрэгслээс тохирох хэсгүүдийг сонгон авч үнэлгээ дүгнэлтийг гаргана.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2023 .11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

# 24. Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

## 24.1. Орлогын тайлангийн төсөөлөл

| Орлогын тайлан | 2022 оны 12 сарын 31 | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 | 2026 оны 12 сарын 31 | 2027 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|---|---|
| | Аудит лагдсан | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл |
| Борлуулалтын орлого | 6,341.73 | 11,939.78 | 18,083.67 | 23,491.33 | 26,884.75 | 29,673.46 |
| Борлуулалтын өртөг | (1,124.23) | (5,109.12) | (5,763.71) | (6,872.50) | (7,554.41) | (8,189.16) |
| Нийт ашиг (алдагдал) | 5,217.51 | 6,830.66 | 12,319.96 | 16,618.83 | 19,330.34 | 21,484.30 |
| Хүүгийн болон бусад цэвэр орлого | 96.96 | 277.27 | 283.13 | 567.35 | 930.65 | 1,332.73 |
| Борлуулалт, маркетингийн зардал | (262.54) | (636.20) | (585.36) | (682.97) | (759.73) | (877.14) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (1,291.27) | (2,447.71) | (2,941.95) | (3,595.87) | (4,138.19) | (4,810.90) |
| Санхүүгийн зардал | (20.39) | (25.18) | (36.84) | (36.65) | (27.46) | (25.28) |
| Бусад зардал | (17.97) | (14.32) | (25.52) | (32.53) | (40.25) | (43.88) |
| Бусад олз гарз | 151.88 | - | - | - | - | - |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | 3,874.18 | 3,564.37 | 7,855.72 | 10,578.85 | 12,388.85 | 13,694.45 |
| Орлогын татварын зардал | 401.17 | 420.15 | 1,157.70 | 2,259.31 | 2,906.50 | 3,365.38 |
| Татварын дараах ашиг (алдагдал) | 3,473.01 | 3,564.37 | 7,855.72 | 10,578.85 | 12,388.85 | 13,694.45 |
| | | | | | | |
| Борлуулалтын орлогын өсөлт | 156% | 88% | 51% | 30% | 14% | 10% |
| Цэвэр ашгийн өсөлт | 282% | 3% | 20% | 35% | 17% | 11% |
| Нийт ашгийн ахиуц | 82% | 57% | 68% | 71% | 72% | 72% |
| Цэвэр ашгийн ахиуц | 55% | 30% | 43% | 45% | 46% | 46% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 78% | 44% | 56% | 45% | 36% | 29% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 70% | 41% | 53% | 44% | 35% | 28% |

*Хүснэгт 25. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны орлогын тайлангийн төсөөлөл, нэгтгэсэн байдлаар, сая төгрөг, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан, төсөөлөл*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 CTC2420

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

### 24.1.1. Орлогын төсөөлөл




*График 33. Монгол Улсын бэлэн бус гүйлгээний тооны төсөөлөл, мянган ширхэг, хувиар, 2018 - 2027*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны систем дунд хугацаанд улам боловсронгуй болж, 2022 онд бэлэн бус гүйлгээний тоо 1.5 тэрбум ширхэг байсан бол цаашид жилд дунджаар 9 хувийн өсөлт үзүүлэн 2027 онд 2.4 тэрбум ширхэг гүйлгээ бэлэн бусаар хийгдэнэ хэмээн төсөөлж байна. Энэхүү тооцооллыг олон улсын тренд, Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангийн түүхэн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцоолсон болно.

Сүүлийн 2 жилд КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр иргэд бэлэн бусаар буюу цахимаар гүйлгээ хийх, зайнаас худалдан авалт хийх хандлага нэмэгдсэн, мөн QPay үйлчилгээ нь арилжааны банкнууд болон мерчантуудтай хамтран ажиллаж байгаа нь хэрэглээг нэмэгдүүлж байна. Нөгөөтээгүүр, цар тахлын нөхцөл байдал хүмүүсийг дижитал шилжилт рүү богино хугацаанд шилжих томоохон хурдасгуур болж өгсөн нь цаашид бэлэн бус гүйлгээний тоо нэмэгдэхэд томоохон суурь хүчин зүйл болж байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК




*График 34 .QPay үйлчилгээгээр дамжих бэлэн бус гүйлгээний төсөөлөл ба өсөлтийн хувь, сая ширхэг, хувиар, 2018 -2022 оны гүйцэтгэл ба 2023-2027 оны төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

QPay үйлчилгээгээр дамжих гүйлгээний тоо 2019 онд өмнөх оноос 194 хувиар, 2020 онд 190 хувиар, 2021 онд 169 хувиар, 2022 онд 114 хувиар тус тус өссөн. Мөн 2018 онд QPay үйлчилгээгээр 1.3 сая ширхэг гүйлгээ хийгдэж байсан бол 2022 онд 63.3 сая ширхэг гүйлгээ хийгдсэн бөгөөд нэг жилд хийгдэх гүйлгээний тоо 62.0 сая ширхгээр нэмэгдсэн байна. 2018 оноос 2022 оны хооронд QPay үйлчилгээгээр хийгдсэн гүйлгээний тооны жилийн дундаж нийлмэл өсөлт нь 165 хувь байсан.

Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээл дунд хугацаанд мөн тэлэх хандлагатай байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь энэхүү орчинд үргэлж шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэн, Түнш байгууллагуудтайгаа хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд байр сууриа өргөжүүлэх боломжтой байна.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны төсөөлөл гүйцэтгэхдээ QPay үйлчилгээ нь зах зээлд түүчээлэгч байж, Монгол Улсын бэлэн бус гүйлгээний тоо нэмэгдэж зах зээл нь тэлэх ч QPay гүйлгээний тооны өсөлт аажмаар саарч дунд хугацаанд 9.5 хувийн өсөлт дээр тогтворжино гэж үзэв. Улмаар QPay гүйлгээний тоо 2027 онд 294.8 сая ширхэгт хүрэх төсөөлөлтэй байна.

Монгол Улсын бэлэн бус гүйлгээний хувьд:

- Монгол улсын дунд хугацааны гүйлгээний тооны өсөлтийг төсөөлөхдөө Ази-Номхон далайн бүс нутгийн бэлэн бус гүйлгээний үнийн дүнгийн өсөлт буюу 2023 - 2027 онуудад жил дунджаар 19.3 хувийн өсөлт үзүүлэх таамаглалтай байгаагхаргалзан үзэж, гүйлгээний тооны өсөлтийг жигд буурахаар тооцоолсон.
- 2027 онд Монгол улсын бэлэн бус гүйлгээний үнийн дүнгийн өсөлт нь Олон Улсын Валютын Сангийн "Дэлхийн эдийн засгийн төлөв байдал" тайланд дурдсан 2027 оны Монгол Улсын нэрлэсэн ДНБ-ний өсөлтийн төсөөлөлтэй ойролцоо түвшинд буюу 11.8 хувь, гүйлгээний тоо 5.5 хувьд хүрэхээр төсөөлсөн.

QPay-ээр дамжих гүйлгээний хувьд:

- Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээ нь өсөлтийн үе шатанд явж буй тул 2022 онд 114 хувиар өссөн гүйцэтгэлтэй байсан гүйлгээний тооны өсөлт нь бизнесийн онол зарчмаар саарах боломжтой гэж үзвэл 2023 онд 86 хувийн, 2024 онд 55 хувийн, 2025 онд 29 хувийн, 2026 онд 14 хувийн, 2027 онд 9 хувийн өсөлтүүдийг тус тус үзүүлэх боломжтой гэж тооцоолов.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023 11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 07 20 БҮРТГЭВ 03

- Энэхүү өсөлтийн төлөвлөгөөг биелүүлбэл 2022 оны эцэст Монгол Улсын нийт бэлэн бус төлбөр тооцооны 4 хувийг гүйцэтгэж байсан QPay үйлчилгээ нь 2027 онд уг зах зээлийн 12.5 хувийг гүйцэтгэх боломжтой юм. Олон улсын жишигтэй харьцуулахад БНХАУ-ын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн хамгийн том тоглогчид болох Alipay болон Tenpay (Wechat Pay) үйлчилгээнүүд нь 2022 оны 03 дугаар улирлын байдлаар БНХАУ-ын мобайл гүйлгээний 54 болон 42 хувийг тус тус гүйцэтгэж байсан (Alipay Statistics, 2022). Харин 2022 оны 03 дугаар улирлын байдлаар АНУ-ын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 42 хувийг Paypal үйлчилгээ дангаар эзэлж байсан (Paypal Statistics, 2022)




*График 36. QPay үйлчилгээний Монгол Улсын бэлэн бус гүйлгээний зах зээлд эзлэх хувь, хувиар, 2022 – 2027*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Санхүүгийн тайлангийн шинжилгээнд дурдсанчлан Үнэт цаас гаргагчийн үндсэн орлогын эх үүсвэрүүдийг ангилбал:

- QPay үйлчилгээ нь "ККТТ" ХХК, Арилжааны банк болон Мерчант талууд хооронд байгуулсан гурван талт гэрээний дагуу, QPay үйлчилгээний аль нэг модуль ашиглан хийгдэж буй QPay гүйлгээний дүн эсвэл тоо ширхгээс тогтсон хувь хэмжээ эсвэл дүнгээр шимтгэл тооцдог. Тус шимтгэл нь "ККТТ" ХХК-ийн орлогын гол эх үүсвэр болдог.
- QPay үйлчилгээг нэвтрүүлсэн Мерчант нь Үнэт цаас гаргагчийн мерчантуудад зориулсан нэмэлт үйлчилгээ авах тохиолдолд нэмэлт үйлчилгээний төлбөрийг гүйлгээний шимтгэл хэлбэрээр тооцдог. Энэ нь "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн үндсэн орлогын эх үүсвэр юм. Мерчантуудад чиглэсэн үйлчилгээг цаашид улам боловсронгуй болгох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд судалгаанд суурилсан шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүн нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- Үнэт цаас гаргагчийн гүйлгээний шимтгэлийн орлогыг нэгж гүйлгээнээс олсон түүхэн дундаж орлого болон QPay гүйлгээний тоо ширхгийн төсөөллийг ашиглан тооцоолов.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 СТС2420

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01




*График 37. Борлуулалтын орлогын төсөөлөл ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2022 - 2027*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн цэвэр борлуулалтын орлого 2021 онд 188 хувийн, 2022 онд 156 хувийн өсөлттэй байсан бол 2023 - 2027 онуудад төлбөр тооцооны гүйлгээний тооны өсөлттэй холбоотойгоор борлуулалтын орлого жилд дунджаар 26 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2023 онд 11.9 тэрбум төгрөг байхаас 2027 онд 29.7 тэрбум төгрөг болж өсөх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн цаашдын борлуулалтын орлогын өсөлтийн төсөөлөл нь түүхэн хугацааны өсөлттэй харьцуулахад 6 дахин бага үзүүлэлт юм.

Нэгтгэсэн орлогын тайлангийн 2023 - 2027 онуудын төсөөллийн дунджаар нийт орлогын 88 хувийг "ККТТ" ХХК-ийн орлого буюу QPay үйлчилгээний тэлэлт бүрдүүлж, 12 хувийг "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн орлого буюу Мерчантуудад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний тэлэлт болон шинэчлэл бүрдүүлнэ гэж төсөөлөл гаргав.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

### 24.1.2. Зардлын төсөөлөл




*График 38. Борлуулалтын өртгийн төсөөлөл ба борлуулалтын орлогод эзлэх хувийн жин, сая төгрөг, хувиар, 2022 - 2027 Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын өртөг 2022 онд 1.1 тэрбум төгрөг байсан бол дунд хугацаанд жилд дунджаар 49 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 2027 онд 8.2 тэрбум төгрөг болох төсөөлөлтэй байгаа ба дийлэнх зардлыг боловсон хүчний зардалд төсөвлөсөн байна. Харин борлуулалтын өртгийн борлуулалтын орлогод эзлэх хувийн жин 2022 онд 18 хувь байсан бол 2023 - 2027 онуудад борлуулалтын орлогын 32 хувьтай дүйцэх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогод эзлэх өртгийн хувийн жин 2023 оноос эхлэн буурсаар, 2027 онд 28 хувьд хүрэх төсөөлөлтэй байгаа нь борлуулалтын орлого нь борлуулалтын өртөг болон капиталын хөрөнгө оруулалттай шууд уялдаа харьцангуй багатай, мөн нөгөө талаас Үнэт цаас гаргагчийн ажиллах хүчин чадавхжиж буйтай холбоотой.




*График 39. Ерөнхий, удирдлагын зардлын төсөөлөл ба борлуулалтын орлогод эзлэх хувийн жин, сая төгрөг, хувиар, 2022 - 2027*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Андеррайтер

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн ерөнхий удирдлагын зардал 2019 оноос 2022 онуудад дунджаар 888.6 сая төгрөг байсан бол цаашдын 5 жилд жилд дунджаар 18 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2027 онд 4.8 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлсөн байна.

Группийн ерөнхий удирдлагын зардлын төсөөллийг хамаарах компаниар нь авч үзвэл 33 хувийг "Инновэйшн Инвестмент" ХХК, 60 хувийг "ККТТ" ХХК, 6 хувийг "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-д тус тус хуваарилан төсөөлсөн байна. Өнгөрсөн түүхэн үзүүлэлттэй харьцуулбал группийн компаниудын нийт ерөнхий удирдлагын зардалд эзлэх хувийн жин тогтвортой хэмжээнд хадгалагдах хандлагатай байна. Үнэт цаас гаргагч нь одоогийн үндсэн төслүүдээс гадна компанийн тодорхойлсон стратегийн хүрээнд шинэ төслүүдэд хөрөнгө оруулахаар төлөвлөн, тэр хэмжээгээр судалгаа, хөгжүүлэлтийн зардал, мэргэжлийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэхээр төсөөлж байна.




*График 40. Борлуулалт, маркетингийн зардлын төсөөлөл ба эзлэх хувийн жин, сая төгрөг, хувиар, 2022 - 2027*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

2020-2022 онуудын байдлаар нийт борлуулалт маркетингийн зардал дунджаар 287.6 сая төгрөг байсан бол 2023 - 2027 онуудад жилд дунджаар 8 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 877.1 сая төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бэлэн бус төлбөр тооцооны зах зээл дэх байр сууриа бэхжүүлэн тэлэх, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээ нутагшуулах, таниулах, компанийн имиж бүрдүүлэх иж бүрэн маркетингийн бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй холбоотой байна.

Сүүлийн гурван жилийн дундаж борлуулалт, маркетингийн зардал 287.6 сая төгрөгтэй харьцуулахад дунд хугацааны төсөөллийн дундаж зарцуулалт болох 708.3 сая төгрөг нь 2.5 дахин их үзүүлэлт юм. Ийнхүү борлуулалт, маркетингийн зардал өндөр өсөлттэй байгаа нь өнгөрсөн хугацаанд маркетинг, зар сурталчилгааны төсөв харьцангуй бага байсан, нөгөө талаас техник, технологи асар хурдацтай хөгжиж, хэрэглэгчид шинэ зүйлсийг хүлээн авах чадвар нэмэгдэж буйтай холбоотойгоор өрсөлдөгч байгууллагууд гарч ирэх магадлал өндөр байгаа орчинд Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хоногшуулах шаардлага нэмэгдэж буйтай холбоотой. Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь цогц төлбөр тооцооны шийдлийн дэд бүтэц хөгжүүлэгч гэдгээ зөвхөн Хэрэглэгчдэд бус Түнш, Мерчант байгууллагууд болон Хөрөнгө оруулагчдад таниулж, хамтын ажиллагаа болон борлуулалтаа нэмэгдүүлэх зорилготой холбоотой.

ҮЦХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03




*График 41. Цэвэр ашиг, цэвэр ашгийн ахиуцын төсөөлөл, сая төгрөг, хувиар, 2022 - 2027*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн цэвэр ашгийн дүн 2022 онд өмнөх оноосоо 282 хувиар өссөн гүйцэтгэлтэй байсан бол 2023 – 2027 онуудад жил дунджаар 40 хувиар өснө хэмээн тооцоолж байна. Ийнхүү 2027 онд цэвэр ашиг 13.7 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. 2023 онд цэвэр ашиг 3.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 3 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны тайлант хугацаанд борлуулалтын өртөгт шингээгээгүй зардлуудыг 2023 оны төсөөлөлд оруулсантай холбоотой.

Цэвэр ашгийн ахиуц 2023 онд 30 хувь байсан бол жилээс жилд борлуулалт нэмэгдэж, ашигт ажиллагаа сайжирснаар 2027 онд 46 хувьд хүргэхээр төсөөлж байна. Цаашдын таван жилийн төсөөллийн дундаж цэвэр ашгийн ахиуц 42 хувь байна хэмээн тооцоолов.




*График 42. Өөрийн хөрөнгийн өгөөж ба нийт хөрөнгийн өгөөжийн төсөөлөл,, хувиар, 2022 - 2027*
*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

2022 онд бэлэн бус төлбөр тооцооны зах зээл идэвхтэй тэлэх үетэй зэрэгцүүлэн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Мерчант халамжлал, маркетинг борлуулалт болон түншлэлтэй холбоотой бодлогуудыг амжилттай хэрэгжүүлж QPay гүйлгээний тоог хурдацтай өсгөсөнтэй холбоотойгоор ашигт ажиллагаа сайжирч 2022 онд өөрийн хөрөнгийн өгөөж 78 хувь, нийт хөрөнгийн өгөөж 70 хувьд хүрсэн. Цаашид 2023-2027 онуудад Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар 42 хувьтай, нийт хөрөнгийн өгөөж 40 орчим хувьтай байх төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагч Андеррайтер

2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

INNOVATION INVESTMENT

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 24.2. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

| Санхүү байдлын тайлан | 2022 оны 12 сарын 31 | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 | 2026 оны 12 сарын 31 | 2027 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|---|---|
| | Аудит лагдсан | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл |
| ХӨРӨНГӨ | | | | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 1,853.36 | 5,860.12 | 13,131.80 | 24,020.30 | 36,560.22 | 50,604.22 |
| Дансны авлага | 450.68 | 578.39 | 654.91 | 741.14 | 788.31 | 791.46 |
| Татвар, НДШ-ийн авлага | 47.76 | 31.76 | 43.81 | 49.30 | 58.84 | 53.12 |
| Бусад авлага | 604.25 | 566.78 | 568.32 | 570.05 | 572.00 | 574.20 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 2,412.45 | 500.00 | 500.00 | 500.00 | 500.00 | 500.00 |
| Бараа материал | 0.15 | 0.15 | 0.15 | 0.15 | 0.15 | 0.15 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 330.84 | 326.63 | 209.04 | 228.97 | 251.44 | 276.75 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **5,699.50** | **7,863.82** | **15,108.03** | **26,109.91** | **38,730.96** | **52,799.90** |
| Үндсэн хөрөнгө | 822.54 | 837.04 | 1,742.65 | 1,395.02 | 1,331.15 | 926.38 |
| Биет бус хөрөнгө | 234.05 | 226.55 | 221.34 | 217.51 | 214.84 | 212.17 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | 1,727.90 | 1,727.90 | 1,727.90 | 1,727.90 | 1,727.90 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - | - | - | - | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,056.59** | **2,791.49** | **3,691.88** | **3,340.43** | **3,273.89** | **2,866.46** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,756.09** | **10,655.31** | **18,799.91** | **29,450.34** | **42,004.85** | **55,666.35** |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | | | | | |
| Дансны өглөг | 346.45 | 375.13 | 429.60 | 483.09 | 543.35 | 611.26 |
| Цалингийн өглөг | 20.05 | - | - | - | - | - |
| Татварын өр | 111.71 | 80.70 | 98.87 | 109.25 | 119.23 | 119.08 |
| НДШ-ийн өглөг | 0.94 | - | - | - | - | - |
| Хүүний өглөг | 0.13 | - | - | - | - | - |
| Урьдчилж орсон орлого | - | - | - | - | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 2.03 | 1.46 | 1.64 | 1.85 | 2.09 | 2.35 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **481.31** | **457.28** | **530.12** | **594.19** | **664.66** | **732.70** |
| Урт хугацаат зээл | - | - | - | - | - | - |
| Хойшлогдсон татварын өр | 4.61 | 4.61 | 4.61 | 4.61 | 4.61 | 4.61 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 101.00 | 31.98 | 248.03 | 255.54 | 350.71 | 249.74 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **105.61** | **36.59** | **252.64** | **260.15** | **355.32** | **254.35** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **586.93** | **493.88** | **782.76** | **854.34** | **1,019.99** | **987.05** |
| Эздийн өмч | - | - | - | - | - | - |
| Хувийн өмч | 3,501.00 | 3,928.90 | 3,928.90 | 3,928.90 | 3,928.90 | 3,928.90 |
| Хуримтлагдсан ашиг | 2,668.16 | 6,232.53 | 14,088.25 | 24,667.10 | 37,055.96 | 50,750.41 |
| Эздийн өмчийн дүн | 6,169.16 | 10,161.43 | 18,017.15 | 28,596.00 | 40,984.86 | 54,679.31 |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **6,756.09** | **10,655.31** | **18,799.91** | **29,450.34** | **42,004.85** | **55,666.35** |

*Хүснэгт 26. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүү байдлын тайлангийн төсөөлөл, нэгтгэсэн байдлаар, сая төгрөг, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT

Үнэт цаас гаргагч

1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 ТС2420

Андеррайтер

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01



БҮРТГЭВ-03




*График 43. Нийт хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

2022 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө өмнөх оноос 109 хувиар өсөж 6.8 тэрбум төгрөгт хүрсэн бол цаашид жилд дунджаар 51 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2027 оны жил эцсийн байдлаар 55.7 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

2022 онд нийт хөрөнгийн 84 хувийг эргэлтийн хөрөнгө, 16 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байсан бол 2023 болон 2024 онуудад сервер, компьютер тоног төхөөрөмжид нэмж хөрөнгө оруулахаар төлөвлөсөнтэй холбоотойгоор тухайн жилүүдэд нийт хөрөнгийн 74 хувийг эргэлтийн хөрөнгө, 26 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзлэхээр байна. Ийнхүү санхүү байдлын тайлангийн 2027 он хүртэлх цаашдын 5 жилийн төлөвлөгөөнд дунджаар 86 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 14 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлэх төсөөлөлтэй байна.




*График 44 Эргэлтийн хөрөнгийн дүн ба бүтэц, хувиар, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ 2022 онд өмнөх оноос 109 хувиар өсөж, 5.7 тэрбум төгрөгт хүрсэн бол 2023 оноос эхлэн жилд дунджаар 61 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2027 онд 52.8 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй болох төсөөлөлтэй байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтцийг үзвэл 2022 онд 33 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 19 хувийг дансны авлага буюу Мерчант байгууллагуудаас авах авлага болон бусад авлагууд, 42 хувийг өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт болон богино хугацаат хадгаламж, үлдсэн 6 хувийг бусад эргэлтийн бус хөрөнгө тус тус бүрдүүлж байсан. Харин дунд хугацааны төсөөллөөр эргэлтийн хөрөнгийн 89 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 7 хувийг дансны болон бусад авлага, үлдсэн 4 хувийг бусад эргэлтийн хөрөнгө тус тус бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

Дансны авлагын дүн нь борлуулалтын орлогыг даган өсөх хандлагатай байгаа хэдий ч эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувийн жин буурна хэмээн тооцоолсон нь Үнэт цаас гаргагч эргэлтийн хөрөнгийн бодлогодоо өөрчлөлт оруулж, сар бүр тооцоо нийлж тухай бүрд авлага цуглуулах бодлого баримталж эхэлсэнтэй холбоотой байна.




*График 45. Эргэлтийн бус хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

2022 оноос 2027 оны хугацаанд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн нэгтгэсэн дүн жилд дунджаар 22 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2027 онд 2.9 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөж байна. 2023 болон 2024 онуудад эргэлтийн бус хөрөнгийн нэгтгэсэн дүн өмнөх оноосоо 164 болон 32 хувиар тус тус өсөх төсөөлөлтэй байгаа нь QPay үйлчилгээний үйл ажиллагаа тэлж, үндсэн хөрөнгө буюу сервер, тоног төхөөрөмжийн хэрэгцээ нь "ККТТ" ХХК дээр нэмэгдэж буйтай холбоотойгоор үндсэн хөрөнгө худалдан авах шаардлага үүсэх хүлээлттэй байгаатай холбоотой. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд сервер, тоног төхөөрөмжийн хүчин чадал, ажиллагаанд тогтмол хяналт тавьж холбогдох бодлого, журам, стандартуудын дагуу жил бүр зохих худалдан авалт, засвар, шинэчлэлүүдийг зохион байгуулж, тасралтгүй, найдвартай ажиллагааг өндөр түвшинд хангаж ажиллах төлөвлөгөөтэй байна.

СЗХ 2023 . 11 . 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023 -07- 20 БҮРТГЭВ-03




*График 46. Өр төлбөрийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн дүн 2022 онд 586.9 сая төгрөг байсан бол 2023 - 2027 онуудад хэт өндөр өсөлт үзүүлэх хүлээлт бага буюу жилийн дундаж нийлмэл өсөлт нь 19 хувь байна хэмээн төсөөлөв. Бүтцийн хувьд шимтгэлийн орлоготой уялдан дансны өглөг өсөх төсөөлөлтэй байна.




*График 47. Эздийн өмчийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувиар, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК СТС2420

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн хэмжээ 2022 онд өмнөх оноос 129 хувиар өсөж 6.2 тэрбум төгрөгт хүрсэн бол 2027 он хүртэл жилд дунджаар 52 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 2027 оны эцэст 54.7 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлогоос үүдэж борлуулалтын орлогыг дагаж нэмэгдэх зардал харьцангуй бага байгаа нь үүнийг тайлбарлаж болох ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжиж, орлого нэмэгдсэнээр цэвэр ашиг, хуримтлагдсан ашгийн хэмжээ өсөх боломжтой байна.

## 24.3. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл

| Мөнгөн гүйлгээний тайлан | 2022 оны 12 сарын 31 | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 | 2026 оны 12 сарын 31 | 2027 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|---|---|---|
| | Аудитлагдсан | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | 3,008.00 | 3,657.16 | 8,007.11 | 10,639.58 | 12,074.60 | 13,174.40 |
| Мөнгөн орлогын дүн (+) | 7,322.75 | 12,599.78 | 18,983.67 | 25,351.33 | 28,744.75 | 31,533.46 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 4,314.74 | 8,942.62 | 10,976.56 | 14,711.76 | 16,670.14 | 18,359.06 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | (3,360.08) | (93.91) | (765.35) | 236.70 | 456.27 | 871.59 |
| Мөнгөн орлогын дүн (+) | 242.93 | 2,189.73 | 418.41 | 567.35 | 930.65 | 1,332.73 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 3,603.01 | 2,283.64 | 1,183.77 | 330.65 | 474.39 | 461.14 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | (77.16) | 443.51 | 29.92 | 12.22 | 9.05 | (1.99) |
| Мөнгөн орлогын дүн (+) | 0.47 | 444.17 | 29.92 | 12.22 | 9.05 | 0.37 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 77.63 | 0.67 | - | - | - | 2.35 |
| Валютын ханшийн зөрүү | 159.18 | - | - | - | - | - |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | (270.06) | 4,006.76 | 7,271.68 | 10,888.49 | 12,539.92 | 14,044.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,123.42 | 1,853.36 | 5,860.12 | 13,131.80 | 24,020.30 | 36,560.22 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,853.36 | 5,860.12 | 13,131.80 | 24,020.30 | 36,560.22 | 50,604.22 |

*Хүснэгт 27. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл , нэгтгэсэн байдлаар, сая төгрөг, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2023 . 11 . 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023 -07- 20 БҮРТГЭВ-03




*График 48. Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөг, 2022 оны гүйцэтгэл, 2023 - 2027 төсөөлөл*

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог нь орлогын өсөлт өндөр, зардлын хэмжээ харьцангуй тогтвортой буйд оршино. Тиймээс нэгтгэсэн байдлаар цэвэр мөнгөн урсгал 2027 онд 14.0 тэрбум төгрөгт хүрнэ хэмээн тооцоолж байна.

Нэгтгэсэн байдлаар үйл ажиллагааны мөнгөн урсгалын хэмжээ 2023 оноос эхлэн жилд дунджаар 38 хувийн нийлмэл өсөлт үзүүлж, 2027 онд 13.2 тэрбум төгрөгт хүрэхэд Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалт, түншлэл болон маркетингийн бодлого чухал нөлөөтэй. Мөн группийн хэмжээнд зөв зохистой үйл ажиллагааны удирдлага, хүний нөөцийн бодлого, мэдээллийн технологийн бодлого хэрэгжүүлдэг тул үйл ажиллагааны мөнгөн зарлага харьцангуй тогтвортой өсөх хандлагатай байна.

Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал 2023, 2024 онуудад тус тус 93.9 сая төгрөг, 765.4 сая төгрөгийн гарах урсгалтай байгаа нь Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны тэлэлт, мэдээллийн аюулгүй байдал ба үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах зорилгоор байнга үндсэн хөрөнгөд хяналт, сайжруулалт хийн, зохистой бодлогын дагуу худалдан авалт хийх төлөвлөгөөтэй байгаатай холбоотой.

Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн мөнгөн урсгал 2022 - 2027 онуудад дунджаар 98.5 сая төгрөгийн эерэг урсгалтай байх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагч нь ойрын хугацаанд зээл, өрийн санхүүжилт төлөвлөөгүй байна.

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратегийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтуудын дүн, хугацаа болон үр дүнг урьдчилан таамаглах боломжгүй тул дээрх дунд хугацааны санхүүгийн төсөөлөлд тусгаагүй болно.

2023-07-20
БҮРТГЭВ-03



INNOVATION
INVESTMENT

# ҮНЭТ ЦААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ

# 25. Үнэт цаас нэмж олон нийтэд санал болгох тухай

## 25.1. IPO хийх үндэслэл

Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаа гарган анх удаа олон нийтэд санал болгон арилжаалснаар дараах давуу талуудыг бүрдүүлнэ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, бэлэн мөнгө нэмэгдэнэ;
- Төлбөр гүйцэтгэгч эцсийн хэрэглэгчдэд хувьцаа эмшигч болох боломж үүсгэснээр үнэнч хэрэглэгчийн баазыг нэмэгдүүлнэ;
- Үнэт цаас гаргагч болон үндсэн бүтээгдэхүүнүүдийн нэр хүнд өснө;
- Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бататгаж, дунд хугацааны өсөлтийн стратегиа баримтлах хүмүүн капитал болон хөрөнгийн нөөцөө нэмэгдүүлнэ;
- Үндсэн хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, сервер, аюулгүй байдлаа улам сайжруулах худалдан авалтуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх санхүүжилт бүрдүүлнэ;
- TechFin, дижитал дэд бүтэц хөгжүүлэлтийн зах зээлд Qpay үйлчилгээнээс гадна шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх эх үүсвэрээ бүрдүүлнэ;
- Цаашид олон улсын зах зээлд тэлэх боломжийг бүрдүүлнэ.

## 25.2. Үнэт цаас гаргах шийдвэр

### 25.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн ХЭХ-аар 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/14 тоот “Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай” шийдвэр гарган, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрт Үнэт цаас гаргагчийн зарласан хувьцаанаас 27,733,160 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган уг 27,733,160 ширхэг хувьцаа, Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, охин компани болох “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн 9,244,458 ширхэг энгийн хувьцаа, нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн байна. Анх удаа нийтэд санал болгон арилжаалах хувьцаа нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан 184,889,160 ширхэг хувьцааны 20 хувьтай тэнцэх бөгөөд одоогийн хувьцаа эзэмшигчид нь уг хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээсээ татгалзаж, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6-аас багагүй сарын хугацаанд өөрсдийн эзэмшлийн хувьцааг арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээхээр шийдвэрлэжээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Олон нийтэд санал болгох нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалтыг олон нийтэд анх удаа хувьцаа санал болгох (IPO) үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоохыг ТУЗ-д үүрэг болгон шийдвэрлэсэн байна.

### 25.2.2. ТУЗ-ийн хурлын тогтоол

2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №02/16 дугаартай “Нийтэд санал болгон энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлүүдийг тогтоох тухай” тогтоол нь ХЭХ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн №23/14 дугаартай “Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай” тогтоолоор баталсан Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 20 хувь буюу нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох тухай дараах зүйлсийг тогтоосон:

- МХБ-ээр дамжуулан тогтоосон үнийн аргаар санал болгож, нэгж хувьцааны үнийг 225 (хоёр зуун хорин тав) төгрөгөөр тогтоох;
- 36,977,618 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгосноор 8,319,964,050 (найман тэрбум гурван зуун арван есөн сая есөн зуун жаран дөрвөн мянга тавин) төгрөг татан төвлөрүүлэх;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт;

- Татан төвлөрүүлэх дүнгийн 85 (наян тав) хүртэлх хувь буюу 7,071,969,443 (долоон тэрбум далан нэгэн сая есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун дөчин гурав) төгрөг хүртэлх дүнг стратегийн хөрөнгө оруулагчдаас, үлдсэн хувийг олон нийтээс татан төвлөрүүлэх;
- Стратегийн хөрөнгө оруулагчид нь хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй үүрэгтэй байх;
- Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал нэмж гаргаж буй энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгох, анхдагч зах зээлд арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, тус тогтоолд дурдсанаас бусад нэмэлт нөхцөлүүдийг шийдвэрлэх эрх олгох.

## 25.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө

### 25.3.1. Зарласан хувьцаа

Үнэт цаас гаргагчийн компанийн дүрмийн 4.1-т зааснаар "Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 25.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 192,166,000 (нэг зуун ерөн хоёр сая нэг зуун жаран зургаан мянга) ширхэг байна".

### 25.3.2. Гаргасан хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн компанийн дүрмийн 4.1-т зааснаар "Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 25.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 157,156,000 (нэг зуун тавин долоон сая нэг зуун тавин зургаан мянга) ширхэг байна. Иймээс компанийн дүрмээр зөвшөөрөгдсөн Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,928,900,000 (гурван тэрбум есөн зуун хорин найман сая есөн зуун мянга) төгрөг байна.

СЗХ
2023 . 07 . 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 - 07 - 26
БҮРТГЭВ-03

## 25.3.3 IPO өмнөх хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

| Хувьцаа эзэмшигч | Хувьцаа тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Хувьцаат капитал (дүрмийн сан) төгрөгөөр |
|---|---|---|---|
| "Ай Си Ти Групп" ХК | 34,159,320 | 21.74% | 853,983,000 |
| Дамдинсүрэн Даваа | 9,108,747 | 5.80% | 227,718,675 |
| Чойжоохүү Нарангэрэл | 16,597,400 | 10.56% | 414,935,000 |
| "Юнимедиа Солюшнс" ХХК | 15,560,000 | 9.90% | 389,000,000 |
| "Айкор Партнерс" ХХК | 14,028,800 | 8.93% | 350,720,000 |
| "Рентракс" ХК | 10,373,400 | 6.60% | 259,335,000 |
| Батзориг Чулуунсүх | 8,900,267 | 5.66% | 222,506,675 |
| Шаравхорол Эрдэнэбилэг | 8,370,200 | 5.33% | 209,255,000 |
| "Могул" ХХК | 7,482,200 | 4.76% | 187,055,000 |
| Масанори Окоши | 3,945,000 | 2.51% | 98,625,000 |
| "НОБ" ХХК | 2,593,400 | 1.65% | 64,835,000 |
| "Глобал Траст Нетворкс" ХК | 2,593,400 | 1.65% | 64,835,000 |
| Шоичиро Ичитани | 2,593,400 | 1.65% | 64,835,000 |
| Такахиро Ичики | 2,593,400 | 1.65% | 64,835,000 |
| Мөнхчулуун Мөнхбаяр | 1,141,066 | 0.72% | 28,526,650 |
| КKТТ ХХК | 17,116,000 | 10.89% | 427,900,000 |
| **Нийт** | **157,156,000** | **100.00%** | **3,928,900,000** |

*Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, Үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9011031195 СТС2420

СЭХ 2023 11 09 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 25.3.4 IPO дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

| Хувьцаа эзэмшигч | Хувьцаа тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Хувьцаат капитал (дүрмийн сан) төгрөгөөр |
|---|---|---|---|
| "Ай Си Ти Групп" ХК | 34,159,320 | 18.48% | 853,983,000 |
| Дамдинсүрэн Даваа | 9,108,747 | 4.93% | 227,718,675 |
| Чойжоохүү Нарангэрэл | 16,597,400 | 8.98% | 414,935,000 |
| "Юнимедиа Солюшнс" ХХК | 15,560,000 | 8.42% | 389,000,000 |
| "Айкор Партнерс" ХХК | 14,028,800 | 7.59% | 350,720,000 |
| "Рентракс" ХК | 10,373,400 | 5.61% | 259,335,000 |
| Батзориг Чулуунсүх | 8,900,267 | 4.81% | 222,506,675 |
| Шаравхорол Эрдэнэбилэг | 8,370,200 | 4.53% | 209,255,000 |
| "Могул" ХХК | 7,482,200 | 4.05% | 187,055,000 |
| Масанори Окоши | 3,945,000 | 2.13% | 98,625,000 |
| "НОБ" ХХК | 2,593,400 | 1.40% | 64,835,000 |
| "Глобал Траст Нетворкс" ХК | 2,593,400 | 1.40% | 64,835,000 |
| Шоичиро Ичитани | 2,593,400 | 1.40% | 64,835,000 |
| Такахиро Ичики | 2,593,400 | 1.40% | 64,835,000 |
| Мөнхчулуун Мөнхбаяр | 1,141,066 | 0.62% | 28,526,650 |
| "ККТТ" ХХК | 7,871,542 | 4.26% | 196,788,550 |
| Олон нийт | 36,977,618 | 20.00% | 924,440,450 |
| **Нийт** | **184,889,160** | **100.00%** | **4,622,229,000** |

*Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, нэмж хувьцаа гаргасны дараах байдлаар*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 9021031195 СТС2420

СЗХ
2023 . 07 . 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 25.4. Үнэт цаасны үнэ тогтоох үндэслэл

Үнэт цаасны зах зээл оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн байгууллага болох "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон ба үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн. Хараат бус үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тооцоолсон байна.

Үнэлгээний Олон Улсын Стандартын (ҮОУС 2022) дагуу үнэлгээний байгууллага нь зах зээлийн үнэ цэнийг хөрөнгөд суурилсан, зах зээлийн харьцуулалтын болон орлогын хандлагын аргаар үнэлсэн болно.

### 25.4.1. Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхдээ тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тул "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн биет ба биет бус бүх хөрөнгүүд болон өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно. Энэхүү тооцоололоор Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгө нь үнэлгээний өдрийн байдлаар 6.2 тэрбум төгрөг байна. Энэ аргаар "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлоход учир дутагдалуудтай. Учир нь тооцоололд тус компанийн ирээдүйн орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гүүдвил, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүйтэй холбоотой.

Харьцуулан судлах ижил төстэй бизнесийн зах зээлийн мэдээлэл хомс үед Үнэт цаас гаргагчийн ирээдүйнашигт ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх эдгээр биет бус хөрөнгийн үнэ цэнийг тооцоолоход бизнесийн нийт үнэ цэнээс бусад хөрөнгийн үнэ цэнийг хасах зарчим дээр тулгуурлан тооцоолол хийх нь оновчтой байдаг. Энэхүү аргачлал нь үнэлгээний ажлын даалгаварт өгөгдсөн бизнесийн үнэ цэнийг тооцоолох ажилтай давхцаж байгаа тул хөрөнгөд суурилсан аргыг бизнес өмчлөлийн үнэ цэнийг тооцоолоход тохиромжгүй гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзсэн.

### 25.4.2. Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ

Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар МХБ дээр Үнэт цаас гаргагчтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг, үнэлгээнд харьцуулалтаар авч үзэх компани байхгүй байна. Иймд зах зээлийн харьцуулалтын шинжилгээ хийхэд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг компаниуд болон Олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй Үнэт цаас гаргагчтай аль болох ижил төстэй хялбар төлбөрийн шийдлийг эрэлхийлдэг компаниудыг сонгосон.

Олон улсын мэдээллийн технологийн салбарын хувьд Хонг-Конг, Австрали, Нью-Йорк, Насдак хөрөнгийн биржүүд дээр арилжаалагддаг 8 нээлттэй хувьцаат компаниудтай харьцуулалт хийж үнэлгээг гаргасан. Эдгээр компаниудын дундаж Price-to-Earnings (PE) үржүүлэгч 40.82, дундаж Price-to-Sales (PS) үржүүлэгч 2.59, дундаж Price-to-Book (PB) үржүүлэгч 4.23 тус тус гарсан байна.

Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг I болон II ангиллын 30 орчим компаниас 7 компанийг сонгож шинжлэхэд компаниудын дундаж Price-to-Earnings (PE) үржүүлэгч 12.05, дундаж Price-to-Sales (PS) үржүүлэгч 2.15, дундаж Price-to-Book (PB) үржүүлэгч 2.18 тус тус гарсан байна. Мөн өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) болон Price-to-Book (PB) харьцааны регрессийн шинжилгээ хийх замаар хөрөнгө оруулагчдын хүлээлтийг загварчилсан байна.

МХБ дээрх компаниудыг PB харьцаагаар харьцуулан шинжлэхэд Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнэ 46.0 тэрбум төгрөг, PE харьцаагаар 41.8 тэрбум төгрөг байх баримжаа үр дүн гарсан. Зах зээлийн харьцуулалтын аргаар тооцоход үнэлж буй болон харьцуулж буй компаниудын үйл ажиллагаа, санхүүгийн байдал өөр тул зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан гаргасан үнэ цэнээр бизнесийн үнэ цэнийг тогтооход учир дутагдалтай. МХБ дээр нийтэд нээлттэй болсны дараах үеийн хөрөнгө оруулагчдын хүлээлт, хандлагыг баримжаалан тооцоолоход буюу компанийн үнэлгээний дээд, доод хязгаарыг тодорхойлоход түлхүү ашигласан байна. Иймд хөндлөнгийн үнэлгээний компани үнэлж буй компанийн үнэлгээний дүнг тооцохдоо зах зээлийн харьцуулалтын аргаас илүүтэйгээр орлогын хандлагын дүнг чухалчилсан болно.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

INNOVATION INVESTMENT LLC
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
6183855
9021031195 СТС2420

## 25.4.3. Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ

Үнэт цаас гаргагч нь 2021 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2022 онд 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба цаашид ашигт ажиллагаа нь өсөхөөр төсөөлж байна. Бизнесийн онцлогоос хамаарч нэмж хувьцаа гарган анх удаа олон нийтэд санал болгон арилжаалснаар санхүүжилт татах нь бизнесийн тэлэлт, өргөжилтөд үзүүлэх нөлөөлөл, үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэж үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity)-ний загварыг ашигласан.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь борлуулалтын орлогын төсөөллийг гүйлгээний орлогын төсөөлөлтэй уясан. Гүйлгээний тоо 2022 онд 113.8 хувиар өссөн бөгөөд цаашид жилийн өсөлт 2023 онд 86.4 хувь, 2024 онд 55.1 хувь, 2027 онд 9.5 хувиар тус тус өсөж гүйлгээний тоо 294.8 сая хүрэхээр төсөөлсөн. 2027 оны гүйлгээний тооны төсөөлөл нь тухайн оны Үнэлгээний компанийн тооцоолсон бэлэн бусын зах зээлийн 12.5 хувийг эзэлж байгаа нь Үнэт цаас гаргагчийн зах зээл дээрх өнөөгийн байршил (арилжааны банкнууд, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг шууд өрсөлдөгчид, томоохон биллер байгууллагууд) болон олон нийтээс татан төвлөрүүлсэн санхүүжилтээр цаашид хийхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаатай нийцтэй, биелэх боломжтой байна. Урт хугацааны өсөлтийг дунджаар 5.0 хувьтай байхаар төсөөлсөн ба хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувийг The Capital Asset Pricing Model (CAPM) загварыг ашиглан 25.2 хувьтай байхаар тооцоолсон байна.

Охин компаниудаас толгой компанид шилжих аливаа орлого, хөрөнгөд татвар ногдуулдаг. Иймд Үнэт цаас гаргагч буюу толгой компани “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийн тооцоололд татан буулгалтын хөнгөлөлтийг 10 хувь байхаар тооцож, хөнгөлөлтийг охин компаниудын хувь эзэмшилд ногдуулж хорогдуулан бизнес өмчлөлийн үнэ цэнийг 44,795,662,890 (дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерөн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ер) төгрөгөөр тооцоолов.

## 25.4.4. Үнэлгээний үр дүн

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн нийт үнэ цэнийг 44,795,662,890 (дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерөн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ер) төгрөг байхаар тооцоолсон ба энэ нь нэгж хувьцаанд ногдох дүнгээр 242 төгрөг байхаар тооцсон. Үнэт цаас гаргагч болон Андеррайтеруудийн зүгээс зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон жижиг хувьцаа эзэмшигчийн хямдруулалт (minority discount) олгож, 7.13 хувийн хөнгөлөлттэй үнээр буюу 225 төгрөгөөр олон нийтэд санал болгохоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын №02/16 тоот шийдвэрээр шийдвэрлэсэн.

# 25.5. Бизнес төлөвлөгөө болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүрийн 225 төгрөгийн үнэтэй 36,977,618 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 8,319,964,050 төгрөгийг татан төвлөрүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн нэмж гаргасан 27,733,160 ширхэг энгийн хувьцааг арилжаалж татан төвлөрүүлсэн дүн болох 6,239,961,000 төгрөгийг компанийн үйл ажиллагаанд зарцуулж, Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний 100 хувийн эзэмшлийн охин компани болох “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг хувьцааг арилжаалж татан төвлөрүүлсэн 2,080,003,050 төгрөгийг “ККТТ” ХХК-д хувьцааны төлбөрт шилжүүлэхээр тогтоосон байна.

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч, түүний охин компанийн үйл ажиллагаа, тэлэлт, техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтын зорилгоор дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна

| № | Хөрөнгө оруулалтын зориулалт | Эзлэх хувь |
|---|---|---|
| 1 | Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт | 22.5% |
| 2 | Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа | 30% |
| 3 | Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа | 15% |
| 4 | "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг хувьцааг буцаан худалдан авах | 25% |
| 5 | Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах | 7.5% |

*Хүснэгт 30. Хөрөнгө оруулалтын зарцуулалтын төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг энэхүү Үнэт цаасны танилцуулгад заасан нөхцөл журмын дагуу зарцуулах бөгөөд энд тусгасан төлөвлөгөөнөөс гадуур, компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө бий болгох аливаа байдлаар зарцуулахгүй байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь хувьцааг анх удаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болох ажлын хүрээнд үнэт цаас гаргахтай холбоотой гарах зардлыг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс суутган тооцохгүй болно.

### 25.5.1. Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт

Үнэт цаас гаргагч нь дотоодын зах зээлд олон улсын төлбөрийн түншүүдийг бий болгож, Монгол Улсад төлбөрийн олон нэмэлт урсгалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд, дэлхийд үйл ажиллагаа явуулдаг томоохон онлайн худалдаа, үйлчилгээний платформуудын төлбөрийг хүлээн авдаг дэд бүтцийг бий болгоно.

Төлбөрийн зах зээлийн хүрээнд QR, иргэд-мерчант хоорондын цахим төлбөр тооцоог үргэлжлүүлэн гүйцэтгэж, үйлчилгээний модулиудын төрлийг нэмэгдүүлэхээс гадна B2B төлбөр тооцоо, бага дүнтэй гүйлгээний систем зэрэг шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байна (Жишээ нь: BPay үйлчилгээ).

Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 22.5 хувийг бэлэн бус төлбөр тооцооны зах зээл дэх үндсэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зарцуулахаар төлөвлөв.

### 25.5.2. Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь дунд болон урт хугацааны үндсэн стратегийнхаа хүрээнд болон Монгол Улс дахь TechFin болон FinTech салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй компани, бизнесийн төслүүдэд өөрийн шалгуур болон хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулж, тус бизнесийн үр ашгаас ашиг хүртэх, үйл ажиллагааг нь өргөжүүлж, бизнесийн синержиг дэмжих байдлаар ажиллахаар төлөвлөж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд зах зээлийн чиг хандлага, Монгол Улсын бизнесийн орчинд үндэслэн дижитал шилжилт шаардлагатай технологийн салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалтыг зохистойгоор оруулж ажиллана. Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 30.0 хувийг хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд шинэ компани, төсөл хөтөлбөр, бүтээгдэхүүн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийхэд зарцуулах ба хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай магадлан шинжилгээг хийж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээр хойш 2-3 жилийн дотор тухайн хөрөнгө оруулалтуудаа хийхээр төлөвлөж байна.

### 25.5.3. Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь сервер, тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэл хийж олон улсын стандартын дагуу өндөр түвшний найдвартай ажиллагааг (High Availability) бүрэн хангана. Өөрөөр хэлбэл төлбөр тооцооны системийн найдвартай байдлыг 99.99 хувьд хүргэнэ. Мөн гадны кибер халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хамгаалалтын тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагаагаа сайжруулна. Ингэснээр дэд бүтцийн хувьд олон улсын төлбөр тооцооны системүүдтэй интеграц хийгдэх, тэдний бүрдэл хэсэг болж ажиллах боломжийг бүрдүүлнэ. Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 15.0 хувийг дараагийн 2 жилд группийн техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулахад зарцуулна.

СЗХ
2023 .11. 08
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

### 25.5.4 Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн мэдээллийн технологи, бизнесийн дэд бүтцийг олон улсад гаргах, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. Иймд Татан төвлөрүүлэх хөрөнгийн 7.5 хувийг ирээдүйн чадварлаг хүний нөөцийг бэлтгэх,тэдгээрийн менежментийн ур чадварыг сайжруулахад зарцуулахаар төлөвлөв.

### 25.5.5 «КKTT" ХХК-ийн эзэмшиж буй энгийн хувьцааны төлбөр

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг хувьцааг арилжаалж, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25 хувийг хувьцааны төлбөрт шилжүүлэхээр тогтоосон байна.

## 25.6. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

### 25.6.1. Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилалт

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш эхний 5 жилийн хугацаанд гарааны бизнесийн буюу эхэн үе дээрээ байсан тул хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс тус хугацаанд бизнесээ өргөжүүлэх, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниулах, зах зээлд эзлэх байр сууриа олох, технологио сайжруулах зэрэг чиглэлд анхааран, хөрөнгө оруулалт хийн ажиллаж, ногдол ашиг хуваарилахгүй байх бодлого баримталж ирсэн байна.

### 25.6.2. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн №02/04 тоот тогтоолоор баталсан байна. Үнэт цаас гаргагчийн шинээр нэмж гаргаж буй хувьцааг СЗХ болон МХБ-ээс нийтэд санал болгох, үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг тус тус зөвшөөрч, Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болсны дараа ТУЗ-ийн анхдугаар хурлаар хувьцаат компанийн ногдол ашгийн бодлогоо батлуулахаар төлөвлөж байна.

Тус бодлогоор компанийн ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, хуваарилах тухай шийдвэр гаргах болон тэдгээртэй холбогдон гарах аливаа харилцааг зохицуулна.

СЗХ 2023.11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 01



2023-07-20 БҮРТГЭВ-03

### 25.6.3. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг баталсан зарцуулалтын төлөвлөгөөний дагуу зарцуулах ба дунд хугацааны стратеги, бизнес төлөвлөгөө болон ашигт ажиллагааны нөхцөлтэй уялдуулан компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах тухай шийдвэрийг гаргана.

"Инновэйшн Инвестмент" ХХК нь ногдол ашиг хуваарилахад дараах нөхцөлүүдийг хангасан байна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Компани нь тухайн санхүүгийн жилд бусдад төлөх бүх өр, төлбөрийг бүрэн төлсний дараа ашигтай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.

### 25.6.4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, хуваарилах

Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

Үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК болон "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн хүчин төгөлдөр компанийн дүрмүүдийн 8.1-д "Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ" гэж, тус дүрмүүдийн 14-р зүйлд ногдол ашиг хуваарилах эсэх, ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгох эсэх асуудлуудыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал буюу "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тус тус зохицуулсан. Үүнээс үзвэл охин компаниудын ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ гаргахаар байна.

### 25.6.5. Тайлагнах

Үнэт цаас гаргагч нь хувьцаат компанийн хэлбэртэй болсны дараа ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулах ба СЗХ, МХБ-ийн холбогдох журамд заасны дагуу хүргүүлнэ. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хурал өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР 1117242908 6183948



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

# 26. Үнэт цаас гаргах үйл явц

## 26.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журамд тус тус заасны дагуу үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах аяныг зохион байгуулж, анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ээр дамжуулан явуулна. Үнэт цаас гаргагч нь дараах төлөвлөгөөний дагуу үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулан ажиллана.




*Схем 18. Шинээр гаргаж буй үнэт цаасыг зах зээлд байршуулах төлөвлөгөө*

## 26.2. Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авах хувь, хэмжээ, нөхцөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №02/16 тоот тогтоолын дагуу нийт нэмж гаргаж буй хувьцааны 85 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсноор дараах хөрөнгө оруулагчдыг стратегийн хөрөнгө оруулагч хэмээн тооцож анхдагч зах зээлийн арилжаанаас хувьцаа худалдан авах нөхцөлийг санал болгож байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын дүн 200,000,000 (хоёр зуун сая) төгрөг ба түүнээс дээш байх;
- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сараас багагүй хугацаанд тусгаарлуулах.

## 26.3. Зохицуулагч байгууллагын шийдвэр

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасаа нийтэд санал болгох, үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг МХБ болон СЗХ-нд нэгэн зэрэг гаргах бөгөөд уг арилжаа эрхлэх болон зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах болон анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө СЗХ болон МХБ-д мэдэгдэнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, алдаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус

тус олгох тухай албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

## 26.4. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

СЗХ болон МХБ-ээс Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсний дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд нь СЗХ-нд мэдэгдсэний үндсэн дээр үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах аяныг ажлын 10 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулахаас өмнө мэргэжлийн хөрөнгө оруулагч болон стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно.

## 26.5. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №02/16 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгон гаргах хувьцааны нэгжийн үнийг 225 (хоёр зуун хорин тав) төгрөгөөр тогтоосон бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4 дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Тогтоосон үнийн аргаар арилжааг явуулахад хөрөнгө оруулагч нь худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь Биржийн хувьцааны бүртгэлийн 3 дугаар ангиллын шалгуурыг хангаж байгаа тул МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19 дэх хэсэгт тодорхойлсон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаална. Биржийн 3 дугаар ангиллын хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэгч үнэт цаасны компанид бичгээр мэдэгдсэн байна.

## 26.6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах

- Олон нийтэд санал болгох үнэт цаасны худалдан авах захиалгыг МХБ-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.
- Үнэт цаас гаргагчийн харилцагч нь бусад үнэт цаасны компани сонгон үйлчлүүлж, худалдан авах захиалга өгөх бүрэн боломжтой.
- Захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд нь СЗХ-оос шийдвэр гаргасны дараа МХБ-тэй хамтран тогтооно.
- Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг Андеррайтерууд, Үнэт цаас гаргагч болон Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагчдаас тусгайлан авна.
- Үнэт цаасны захиалгын бүртгэлийн ажиллагааг МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны программаар зохион байгуулна.
- Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалгын хугацаанд Үнэт цаас гаргагчийн тогтоосон үнээр тоо ширхэг, нийт үнийн дүнг зааж захиалга өгнө. Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнөх хугацаанд өөрийн харилцдаг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгсөн нөхцөлд уг захиалга нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгын үед арилжааны программд шивэгдэж орно.

## 26.7. Хуваарилалт

- МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч арилжааны журам"-ын 3.3 дахь заалтыг үндэслэн, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын 450 ширхэг хүртэл хувьцааны захиалга бүрэн биелнэ.
- Хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан хувьцааны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тооноос илүү байх тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан хуваарилалт хийх бөгөөд Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авахаар өгсөн захиалгыг хувь тэнцүүлэх хуваарилалтад оруулахгүй болно.
- Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зөвшилцөж олон нийтэд хуваарилах үнэт цаасны худалдан авах захиалгын бүрэн биелэх нөхцөл бүхий хэмжээг тогтоож болох бөгөөд энэ талаар МХБ-д хүргүүлж, Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнө МХБ-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
- Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зөвшилцөж үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг арилжааны захиалга эхлэхээс өмнө МХБ-д хүргүүлнэ.

## 26.8 Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцох тухай

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгох 36,977,618 ширхэг хувьцааг 100 хувь амжилттай борлуулсан тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзнэ.

Өөрөөр хэлбэл анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ 100 хувь биелсэн тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааг амжилттай биелсэнд тооцно.

Анхдагч зах зээлийн арилжаанд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд нийтэд гаргасан хувьцааны 15 хүртэлх хувийг нэмж гаргахгүй буюу Greenshoe хэрэгжүүлэхгүй болно

Андеррайтерууд нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах арилжааг идэвхжүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас 90 сая төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа худалдаж авна. Андеррайтерууд нь үнэт цаасыг нийтэд санал болгосны дараа түүний худалдагдаагүй үлдсэн хэсгийг худалдан авах буюу commitment үүрэг хүлээгээгүй болно.

## 26.9. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч, анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ. Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТХТ) болон МХБ нь уг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр анхдагч зах зээлийн арилжаанаас хувьцаа худалдан авсан хөрөнгө оруулагчид өөрийн эзэмшилд буй хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээгдэнэ. Хэрэв хөрөнгө оруулагч нь хувьцаагаа тусгаарлуулах нөхцөлтэйгөөр худалдан авсан бол хувьцаа тусгаарлуулах хугацаа дуусгавар болсны дараа хувьцаагаа худалдах эрх нь нээгдэхийг анхаарна уу.

## 26.10. Үнэ тогтворжуулах хөтөлбөр

Андеррайтерууд нь Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл үүсгэгчээр хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг гүйцэтгэнэ. Уг хөтөлбөрийг Үнэт цаас гаргагчийн нийтэд анх удаа санал болгосон хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сарын хугацаанд хэрэгжүүлэх ба тус үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ СЗХ болон МХБ-ийн холбогдох журмуудыг баримталж ажиллана.

Андеррайтерууд нь үнэ тогтворжуулахтай холбоотой ажиллагаа дууссанаас хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8.9 дэх хэсэгт заасны дагуу СЗХ болон МХБ-д хүргүүлж ажиллана.

Үнэт цаас гаргагч    Андеррайтер

| № | Нөхцөл | Хязгаарлалт |
|---|---|---|
| 1 | Үнэ анх гаргасан үнээс 15 хувь болон түүнээс дээш хэмжээнд унасан тохиолдолд | Үнэ тогтворжуулах нөхцөл үүссэн гэж үзэж үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. |
| 2 | Багцын арилжаа | Багц арилжааны хэлцэл нь энэхүү хөтөлбөрт хамаарахгүй. |
| 3 | Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжих хугацаа | Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 1 сарын хугацаанд |
| 4 | Үнэ тогтворжуулах ажиллагаа хэрэгжүүлэх үнийн дүн | 500,000,000 (таван зуун сая) хүртэлх төгрөгийн үнийн дүнгээр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. |

*Хүснэгт 31. Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл*

Хувьцааны үнэ тогтворжуулах үйл ажиллагаанаас гарах зардал нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутгагдахгүй бөгөөд Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй.

## 26.11. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

### 26.11.1. Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан хувьцаа эзэмшигчийн дараах эрх эдлэхээс гадна өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжих, захиран зарцуулах, компанийн дүрэмд заасан бусад эрхийг эдэлнэ. Үүнд:

- ХЭХ-д оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компани татан буугдах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу компанийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тодорхойлсон бусад эрхийг эдэлнэ.

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлуудаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компаниас эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй. Үүнд:

- Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;
- Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл байгуулсан;
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

СЗХ
2023 . 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 07 2
БҮРТГЭВ-03



### 26.11.2. Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;
- Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд СЗХ-д хүргэх, нийтэд мэдээлэх;
- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;
- Тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
- Хагас жилийн болон СЗХ-д бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд СЗХ болон МХБ-д хүргүүлэх;
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх;
- ХЭХ-ын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор СЗХ болон МХБ-д хүргүүлэх;
- Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;
- СЗХ-оос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;
- СЗХ-ны холбогдох заавар журмуудыг мөрдөж ажиллах;
- СЗХ-оос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд нийтэд мэдээлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахдаа СЗХ-оос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг дагаж мөрдөх;
- Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

### 26.11.3 Үнэт цаас гаргагчийн болон Үнэт цаас эзэмшигчийн хариуцлага

Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагч болон хувьцаа эзэмшигч нь дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183943

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС24

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

- Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө

## 26.12. Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

### 26.12.1 Үнэт цаасны арилжаанд оролцох заавар

Хөрөнгө оруулагч нь МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах заврын дагуу хувьцаа худалдан авах мөнгөн хөрөнгө байршуулах ба өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалгаа өгнө.




*Схем 19. Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар*

### 26.12.2 Мөнгөн хөрөнгө байршуулах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцож, хувьцаа худалдан авах хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлж буй Үнэт цаасны компаниас өгсөн зааварчилгааны дагуу мөнгөн хөрөнгийг өөрийн дансанд байршуулна.

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ № 01

## 26.13. Үнэт цаас худалдан авахтай холбоотой бусад нөхцөлүүд

### 26.13.1. Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллын шимтгэл багтсан байна. МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

### 26.13.2. Захиалгын үнийг буцаан олгох

Үнэт цаасны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсантай холбоотойгоор хувь тэнцүүлэн хуваарилалт хийсэн тохиолдолд Хөрөнгө оруулагч нь биелэгдээгүй захиалгын үнийн дүнг өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан буцаан авах эрхтэй. Биелэгдээгүй захиалгын үнийн дүнг буцаан авахтай холбоотой тухайн үнэт цаасны компанийн тогтоосон шимтгэл хураамж төлөх шаардлагатай болж болзошгүйг анхаарна уу.

### 26.13.3. Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь Монгол Улсад оршин суугч хувь хүн байх тохиолдолд "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.1.3 дэх заалтад заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 17.1.3 дэх заалтад заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)- оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.5 дахь заалтад заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.2 дэх заалтад заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 18.3 дахь хэсэгт заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.2.1 болон 20.2.5 дахь заалтуудын нөхцөлүүдэд заасан хувь хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд өөрийн харьяалах улс нь Монгол Улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон хэрэв давхар татварын гэрээтэй байх тохиолдолд тухайн гэрээний нөхцөлүүдийг сайтар судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

### 26.13.4. Валют

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

### 26.13.5. Бүхэлчлэх

Зарим мөнгөн дүн болон хувийг тоймлон оруулсан тул зарим хүснэгтэд бүхэл утгаар илэрхийлсэн тоон дүнгүүд нь арифметик бүхэлчлэх аргыг ашигласан дүн болно.

### 26.13.6. Хэл

Энэхүү танилцуулгыг Монгол хэлээр үйлдсэн бөгөөд гадаад хэл рүү орчуулсан орчуулга нь Монгол хувилбараас утга, агуулга, ямар нэгэн байдлаар зөрсөн тохиолдолд энэ Монгол эх хувилбарыг давуу хүчинтэйд тооцно. Танилцуулгад олон улсад тогтсон жишиг, практикийн дагуу нэр томьёоны тайлбарт туссан зарим Англи нэр томьёолол ашиглана.

# 27. Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагууд

Үндсэн Андеррайтер

“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр 25 давхар, 2506 тоот
Утас: (976) 7777 6377
И-мэйл: info@ucc.mn
Веб хуудас: www.ucc.mn

Туслах Андеррайтер

“Инвескор Капитал ҮЦК” ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 13-р хороолол, Парисын гудамж 42, Ай Си Тауэр барилга, 15 давхар, 1503 тоот
Утас: (976) 7755 0077
И-мэйл: info@icapital.mn
Веб хуудас: www.icapital.mn

Аудитын компани

“Грант Торнтон Аудит” ХХК
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж-31, Далай Тауэр, 9 давхар
Утас: (976) 7011 0799
И-мэйл: info@mn.gt.com
Вэб хуудас: www.grantthornton.mn

Хуулийн зөвлөх

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН
Хаяг: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас: (976) 11 330048
И-мэйл: info@mdsa.mn
Вэб хуудас: www.mdsa.mn

Үнэлгээний компани

“Гэрэгэ Эстимэйт” ХХК
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 20-6, Эрдмийн ордон , 1004 тоот
Утас: (976) 7000 5000
И-мэйл: info@geregepartners.mn
Вэб хуудас: www.geregepartners.mn

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03



## 27.1.Үндсэн Андеррайтерийн тухай

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй, МХБ болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, Нью-Йоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн. Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

- 2008 он Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан.
- 2009 он Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан.
- 2010 он Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн.
- 2010 он Bank of China International-тай түншлэв.
- 2011 он Шилдэг брокерын компани
- 2011 он Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн
- 2013 он Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага"
- 2015-2018 он Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх
- 2016 он Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч
- 2018 он МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч
- 2018 он Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шилдэг Мэргэжилтэн"
- 2019-2020 он Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан.
- 2019 он "Ард Кредит ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.
- 2020 он "ЛэндМН" ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер
- 2020 он Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн
- 2020 он МҮОНТ-н "Цагийн хүрдийн баатар"
- 2020 он Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер
- 2021 он Биржийн бус зах зээл (OTC)-ийн анхны гишүүн байгууллага
- 2021 он Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан "Sandbox" төслийн анхны бүтээгдэхүүн болох "Монпэй" бондын андеррайтер

СЗХ
2023 он 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



БҮРТГЭВ-03

- 2021 он Биржийн бус зах зээлийн (OTC)-ийн анхны "БИД" бондын андеррайтер
- 2022 он Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Ашид капитал ББСБ" XXK хаалттай бондын Үндсэн андеррайтер
- 2022 он Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер
- 2022 он МҮОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд хамтрагч компани
- 2022 он "Төрийн банк "ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат болох эхлэлийг тавьсан.
- 2022 он "Сэндли ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер
- 2022 он "ЛэндМН" ХБҮЦ-д хамтрагч андеррайтер
- 2023 он "Сэндли нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер
- 2023 он Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Үйзэн-Ивээлт ББСБ" XXK хаалттай бондын Үндсэн андеррайтер
- 2023 он "БИД ББСБ" XXK-ийн нээлттэй бондыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер
- 2023 он "Бичил 2.0 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер

"Мобифинанс ББСБ", "М-Си-Эс Инвестмент" XXK, "Капитрон банк", "Ай Си Ти групп", "Сүү ХК", "Төрийн банк", "БИД ББСБ" , "Ашид капитал ББСБ", "Монголчех Метал", "ОНДО", "Монголын финтек групп", "Эрхэт Монгол групп", "Бичил глобус финанс ББСБ" гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 250.0 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" XXK |
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, брокер, дилер, номинал дансны үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2007.12.06 |
| Регистрийн дугаар | 5183855 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 |
| Утас | +976 7777-6377 |
| Цахим шуудан | info@ucc.mn |

Хүснэгт 32. Үндсэн андеррайтерийн товч танилцуулга

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ XXK INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК XXK

СЗХ 2023 . сар 08 өдөр БҮРТГЭВ № 01



2023-07-20 БҮРТГЭВ-03

### 27.1.1. Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь "Өлзий энд Ко Капитал" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр АГ-23/17 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээний дагуу Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгон гаргах хувьцааг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх зөвшөөрөл авахад дэмжин ажиллах, баримт бичгүүдийг холбогдох журамд заасны дагуу бэлтгэх, Үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажиллагаанд шаардлагатай зөвлөмжөөр хангах, эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн Үнэт цаасыг нээлттэй хүрээнд стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгох ажлыг зохион байгуулах, Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулж худалдах үүрэгтэйгээр Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээр харилцан тохиролцсон.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь хэсэгт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргаж ажиллана.

Үндсэн андеррайтер нь гэрээгээр тохиролцсон үйлчилгээг үзүүлэхдээ хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх, үзүүлж буй үйлчилгээг аливаа байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах зэрэг үүрэгтэй. Харин Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтерд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай өөрөөс шалтгаалах боломж нөхцөлөөр хангах, Андеррайтерийн шаардсан баримт материал болон үнэт цаас гаргах ажиллагаанд шаардлагатай аливаа зөвшөөрөл, бүх төрлийн мэдээлэл, баримт бичгийг түргэн шуурхай, бүрэн гүйцэт гаргаж өгөх, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон ажиллуулах, мэдээллийг нууцлах, гэрээний үүргээ зөрчсөний улмаас Андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд учирсан хохирлыг хариуцах, үнэт цаас гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны хүрээнд Андеррайтертай хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний дагуу явуулах шаардлагатай бүх нөхцөлийг хангах, стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулга хийх болон үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотойгоор танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан болон шаардлагатай мэргэжилтнүүдийг тодорхойлж, Үндсэн андеррайтертай хамтран ажиллуулах, гэрээнд заасан төлбөр төлөх зэрэг үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Талуудын хооронд байгуулагдсан гэрээнд дотоод мэдээлэл эзэмшигч, дотоод мэдээлэл, нууцлалыг хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх, Үнэт цаас гаргагчийн хувьцааг Биржээр болон гуравдагч этгээдээр дамжуулан худалдан авах, борлуулах, ашиг олох мөн санхүүжилт татах, эрх бүхий этгээдүүд болон Андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг дотоод мэдээлэл эзэмшигчид хориглосон байна. Мөн Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг Андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, түүний улмаас Үнэт цаасны үнэлгээнд нөлөөлөх, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд учирсан хохирлыг өөрөө хариуцахаар зохицуулсан байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6182943

Үнэт цаас гаргагч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Андеррайтер

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 31

INNOVATION INVESTMENT

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-07-20 БҮРТГЭВ-03

## 27.2 Туслах андеррайтерийн тухай

InvesCore CAPITAL

"Инвескор Капитал" ҮЦК ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь үнэт цаасны брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй этгээд бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүйн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олноор багаа бүрдүүлсэн. "Инвескор Капитал" ҮЦК ХХК нь Биржийн болон Биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, харилцагч үйлчлүүлэгчдийг мэргэшсэн зөвлөгөөгөөр хангах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, Mergers and Acquisitions (M&A) болон хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн туршлагатай компани юм.

| | |
|---|---|
| Компанийн нэр | "Инвескор Капитал ҮЦК" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011741137 |
| Регистрийн дугаар | 6317839 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, 13-р хороолол, Парисын гудамж 42, Ай Си Тауэр барилга, 15 давхар, 1503 тоот |
| Утас | (+976) 7755 0077 |
| И-Мэйл | info@icapital.mn |
| Веб хуудас | www.icapital.mn |

Хүснэгт 33. Туслах андеррайтерийн товч танилцуулга

"Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

- 2019 он "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгож, гаргах ажиллагаанд туслах андеррайтераар оролцож нийт 18.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.
- 2021 он Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас "Инвескор Актив ХБҮЦ"-ыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан гаргах ажиллагаанд андеррайтераар ажиллаж нийт 4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Уг үнэт цаас гаргах ажиллагаанд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу хөрөнгө худалдагчаар "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК оролцсон.
- 2021 он Хувийн хэвшлийн анхны өрийн хэрэгслийн хөтөлбөр болох "Инвескор ББСБ" ХК-ийн нийт 20 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Инвескор Бонд өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргасан бөгөөд 100% борлуулсан.
- 2021 он Биржийн Бус Зах Зээлд "Кэй Эй Майнинг" ХХК-ийн нийт 10 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий "Хишиг Бонд 2022 15%" өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, Транч 1 болох 3.2 тэрбум төгрөгийг амжилтай татан төвлөрүүлсэн.
- 2021 он Биржийн бус зах зээлд "Инвескор ББСБ" ХК-ийн 10 тэрбум хүртэлх төгрөгийн хаалттай өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, хөтөлбөрийн хүрээнд нийт 6,740,000,000 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаас гаргагч Андеррайтер

- 2022 он "Шунхлай" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Шунхлай Бонд" идэвхтэй үлдэгдэл бүхий давтамжтай үргэлжлэх холимог хугацаат өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон хөрөнгө оруулагчдад санал болгон гаргахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлж тус өрийн хэрэгслийн хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн хэсэгчлэн гаргах ажиллагааны үр дүнд 23.9 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн;
- 2022 он "Актив Гарден" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Актив Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 6.4 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- 2022 он "Ай Си Рэйт" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Рэйт Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 10 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- 2022 он "Инвескор ББСБ" ХК-ийн биржийн бус зах зээлд "Инвескор Хаалттай Бонд" өрийн хэрэгслийг хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгон гаргаж 10 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- 2022 он "Инвескор ББСБ" ХК-ийн FPO буюу нэмэлт хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 16.7 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- 2022 он Монгол Улсын түүхэн дэх хамгийн томд тооцогдох IPO болох "Голомт Банк" ХК-ийн хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 118.8 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх түүхэн үйл ажиллагаанд үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- 2022 он "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргахаар бүртгүүлсэн нээлттэй бонд болох 50 тэрбум хүртэлх төгрөгийн өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж, 2023 оны 4-р сарын 5-ны өдөр бондын хөтөлбөрийн 3 дахь транчаа амжилттай гаргаж, нийт 30 тэрбум төгрөгийн амжилттай татан төвлөрүүлсэн;
- 2022 он Монгол төрийн компаниудын хувьчлалын эхлэлийг тавьсан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн үнэт цаасыг биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж, 11.9 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх түүхэн үйл ажиллагаанд үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

### 27.2.1 Туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үндсэн андеррайтер нь "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ХАГ_230609/01 дугаартай "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулж, уг гэрээгээр Үнэт цаас гаргагчийн хувьцаа гарган Биржээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох, худалдах үйл ажилагааг амжилттай болгох зорилгын хүрээнд талуудын хийх ажиллагаа, эрх, үүргийг зохицуулжээ.

Гэрээний дагуу Туслах андеррайтер нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, бизнесийн үнэлгээний талаар санал боловсруулах, үнэт цаасны танилцуулга боловсруулах, Хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг гүйцэтгэх үйлчилгээг Үндсэн андеррайтертай хамтран гүйцэтгэхээр тохирсон байна.

СЗХ
2023 .11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 27.3 Аудитын компанийн тухай

Grant Thornton

“Грант Торнтон Аудит” ХХК нь аудитын, татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх цар хүрээгээрээ дэлхийд эхний 6-д тооцогддог компани бөгөөд дэлхийн 140 гаруй оронд ажиллаж буй 62,000 гаруй мэргэжилтнээс бүрдсэн хараат бус зөвлөх үйлчилгээний фирм юм. Монголд 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж байсан “Улаанбаатар Аудит Корпорац” ХХК нь 2017 онд “Грант Торнтон Интернэйшнл” дэлхийн сүлжээ байгууллагын жинхэнэ гишүүн болж, тус сүлжээг Монгол Улсад төлөөж ажиллах бүрэн эрхтэй гишүүн фирмээр хүлээн зөвшөөрөгдөн 2019 оноос эхлэн “Грант Торнтон Аудит” ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байна. “Грант Торнтон Аудит” ХХК нь 2013 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд бөгөөд Аудитын компанийн хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

Даатгал, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч дор дурдсан компаниудын IPO хийх ажиллагаанд аудитораар ажилласан.

- “Үндэсний давхар даатгал” ХК
- “Монголын хөрөнгийн бирж” ХК
- “Мандал Даатгал” ХК
- “Монос Хүнс” ХК
- “Түмэн Шувуут” ХК
- “Бодь даатгал” ХК

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн тусгай зориулалттай компани болох “Омни Актив ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зээлийн багцад шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зээлийн шинжилгээ хийж, аудитын дүгнэлт гаргаж зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан. Мөн

- “Инвескор ББСБ” ХК
- “Ард Кредит ББСБ” ХК
- “Нет Капитал ББСБ” ХХК
- Жэй Траст Интернэшнл ББСБ” ХХК
- “БСБ Финанс ББСБ” ХХК зэрэг банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй компаниудад аудитын үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183548

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

### 27.3.1 Аудитын компанитай байгуулсан гэрээ

"Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 2022/63 тоот "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Аудит нь Үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн тусдаа болон нэгтгэсэн мөн түүний охин компани тус бүрийн нягтлан бодох бүртгэлийн болон СТОУС-ын дагуу бэлтгэсэн 2022 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй зэргийг багтаасан санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийхээр тохиролцсон байна. Аудитын компани нь аудитын үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын хүрээнд аудитын олон улсын стандарт, Үнэт цаас гаргагчийн дотоодод мөрдөгдөж буй стандарт бодлого, горим, журам, аргачлалыг үндэслэн санхүүгийн тайлан дах тоон үзүүлэлтүүдийг нотлох баримтуудаар шалган, удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон голлох чухал гэж тооцсон тооцооллуудыг үнэлсний үндсэн дээр аудитын дүгнэлт гаргах, аудитын явцад илэрсэн дотоод хяналтын сул тал, материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдлуудын талаар зөвлөмж өгөх, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.17-д заасан дүгнэлт гаргаж хүргүүлэхээр харилцан тохиролцсон байна.

"Грант Торнтон Аудит" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 20232/230 тоот "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулж, уг гэрээгээр "Грант Торнтон Аудит" ХХК нь СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.4-т заасан дагуу тодорхойлох захидлыг гаргасан байна.

Гэрээний дагуу "Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, эд хөрөнгүүд бодитоор оршин байгаатай холбоотой бүх нягтлан бодох бүртгэлийн болон бусад баримт мэдээллийг бүрэн хүлээн авч шалгах, үйлчилгээний явцад олж авсан аливаа мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад мэдээлэхгүй, хувийн зорилгоор ашиглахгүй, өмнө нь хийсэн аудитын ажлын баримт, мэдээлэлтэй танилцахаар бусад аудитын хуулийн этгээд, аудиторын шаардсан ажлын баримтыг аль аль нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр танилцуулах, аудит хийх үеэр үүсэн гарсан аливаа асуудлын талаар үйлчлүүлэгчийн гүйцэтгэх ажилтнуудаас тайлбар авч аудитын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, аудитын стандартууд болон ёс зүйн дүрмийг удирдлага болгон олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэх, Үнэт цаас гаргагч нь аудиторт ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой шаардлагатай баримт материал, мэдээллүүдийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх, тэдгээртэй холбоотой тайлбар, тодорхойлолт өгөх, шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлантай холбоотой хүлээн зөвшөөрсөн алдаа, зөрчлийг шуурхай залруулах, аудиторыг ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой нөхцөл боломжоор хангах зэрэг үүргийг хүлээсэн байна. Гэрээний дагуу аудит хийсний үр дүнд Аудитын байгууллага нь үнэн, зөв нотлох баримтад үндэслэсэн, холбогдох хууль, тогтоомж аудитын журам болон аудитын байгууллагын мэргэжлийн жишигт нийцсэн агуулга бүхий тайлан, дүгнэлт бэлтгэх бөгөөд аудитын дүгнэлтийн үнэн зөвийг Аудитын байгууллага нь бүрэн хариуцах үүрэг хүлээсэн байна.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 1



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

## 27.4.Хуулийн зөвлөхийн тухай

MDSKhanLex

""Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал:

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах болон
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 3 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах төслүүд;
- "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах төслүүд;
- "Түмэн Шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл;
- "Сэндли ББСБ" ХК-ийн IPO, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах төсөл;
- "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 2 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;
- "Төрийн Банк" ХК-ийн IPO;
- "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн IPO төсөлд хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог Asia Law сэтгүүлээс "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийг 2021, 2022 оны "Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байдаг.

## 27.4.1 Хуулийн зөвлөхтэй байгуулсан гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-тай 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Д-С1082317 дугаартай "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн опцион эрхийг шилжүүлэхтэй холбоотой шийдвэр, баримт бичгийг хянах, опцион эрх хэрэгжүүлж хувьцаа эзэмшихтэй холбоотой шийдвэрийн төсөл боловсруулах, хянах болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ээс баталсан холбогдох журмууд, Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Үнэт цаас гаргагчийн анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох (IPO) ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон байна.

Гэрээний дагуу Хуулийн зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн өндөр түвшинд, чанартай хийж гүйцэтгэн тогтоосон хугацаанд хүлээлгэн өгөх бөгөөд гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үнэт цаас гаргагчийн нууцыг чандлан хадгалах үүргийг тус тус хүлээсэн байна. Үнэт цаас гаргагч нь хуулийн зөвлөхөд гэрээгээр тохиролцсон үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээ, мэдээлэл, баримт бичгийг үнэн зөвөөр гаргаж өгөх, нууц хадгалах зэрэг үүргийг хүлээжээ.

## 27.5 Үнэлгээний компанийн тухай

"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн компани юм. Үнэлгээний баг нь үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч зэрэг олон чиглэлийн нарийн мэргэжлийг гадаад дотоодын их дээд сургуулиудад эзэмшиж, мэргэжлээрээ ажилласан туршлагатай чадварлаг мэргэжилтнүүдээс бүрддэг. Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний томоохон ажлууд дээр "Гэрэгэ Эстимэйт" ХХК болон "Гэрэгэ Партнерс" ХХК-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан баг ажилладаг. "Гэрэгэ Партнерс" ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь МХБ дээр үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх эрхтэй СЗХ-д бүртгэлтэй компани бөгөөд үнэлгээний багт Монгол Улсын Сангийн яамнаас олгодог мэргэшсэн үнэлгээчин сертификаттай 3 үнэлгээчин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг МХБ дээр анхлан гаргах зориулалтаар хийсэн үнэлгээний багийн ахлагчаар Доноровын Гантулга ажиллав. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институт (RICS)-ийн гишүүн, бизнесийн болон биет бус хөрөнгийн үнэлгээний мэргэшсэн үнэлгээчин ба RICS нь газар, хөрөнгө, дэд бүтэц, байгууламжийн үнэлгээний мэргэшил болон стандарт тогтоодог дэлхийн тэргүүлэх байгууллага юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээчид нийт 20 орчим бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн. Тэрээр 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох "ЛендМН ББСБ" ХК, 2018 онд "Инвескор ББСБ" ХК, 2019 онд "Бодь Даатгал" ХК, 2021 онд "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК, 2022 онд "Сэндли ББСБ" ХК, "Монголын Хөрөнгийн Бирж" ХК, 2023 онд "Монложистикс Холдинг" ХХК зэрэг компаниудын бизнесийн үнэлгээг тус компаниудын хувьцааг хөрөнгийн биржид анхлан гаргах зориулалтаар хийж гүйцэтгэсэн туршлагатай бөгөөд эдгээр компаниудын хувьцаа нь МХБ дээр амжилттай арилжаалагдаж байна.

### 27.5.1 Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний тухай

“Гэрэгэ Эстимэйт” ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр “Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд “Гэрэгэ Эстимэйт” ХХК нь Үнэт цаас гаргагч хувьцаагаа МХБ дээр анх удаа олон нийтэд санал болгох ажиллагааны хүрээнд Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын хүрээнд ҮОУС-ын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэхээр тохиролцжээ.

Гэрээний дагуу үнэлгээний компани нь үнэлгээ хийсэн аргачлал, үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлсийн үндэслэлийг үнэлгээний тайланд нарийн тусгаж, үйлчлүүлэгчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд үнэ төлбөргүйгээр өөрийн хэрэглэсэн аргачлал, үндэслэлийг батлан харуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн мэдээллийг гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 5 жилийн хугацаанд задруулахгүй байх, задруулсан тохиолдолд үйлчлүүлэгчид учирсан хохирлыг үл маргах журмаар нөхөн төлөх, ажил гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн баримт бичиг, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах, аливаа доголдолгүйгээр эргүүлэн өгөх, өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг Үнэт цаас гаргагчийн өмнө бүрэн хариуцах үүргийг хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагч нь ажил гүйцэтгэгчид бичиг, баримтууд болон мэдээллүүдийг шаардлагатай хэмжээгээр хүлээлгэн өгөх, гэрээнд заасан журмын дагуу үйлчилгээний төлбөр тооцоог хугацаанд нь төлж барагдуулах үүрэгтэй байхаар заасан. Үнэлгээний компанийн үнэлгээний үйл ажиллагаа хийх ажилтан нь үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан байх үүрэг хүлээх ба гэрээт ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгээгүй, тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөөгүй, мөн гүйцэтгэсэн ажлын үр дүн нь доголдолтой бол Иргэний хуулийн 352.2 дугаар зүйлд заасны дагуу доголдлыг арилгах болон тийнхүү арилгахтай холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх, ажлын хөлсийг бууруулахаар заажээ. Мөн ажил гүйцэтгэгч дүгнэлт гаргахдаа мэргэжлийн алдаа гаргасныг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан Мэргэжлийн зөвлөл тогтоосон тохиолдолд үнэлгээний компани нь тайланг үнэт цаас гаргагчийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах үүрэг хүлээжээ.

## 27.6 Оролцогч байгууллагуудын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргагчтай холбоотой үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай мэдэгдэл гаргаж, тус тусын тодорхойлох захидал, дүгнэлт тайлангуудад тусгасан болно.

СЗХ 2023 11 08 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

# 28. Гарын үсэг зурах хуудас

Үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК

Д.Лхагваа

ТУЗ-ийн дарга

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Г.Эрдэнэмөнх

Гүйцэтгэх захирал

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Б.Энхболд

Санхүү эрхэлсэн захирал

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК

Б.Өлзийбаяр

Гүйцэтгэх захирал

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Туслах андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК

Л.Билгүүн

Гүйцэтгэх захирал

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

2023 .11 сар 08 өдөр

# ХАВСТРАЛТУУД

"Инновэйшн Инвестмент" ХХК

INNOVATION
INVESTMENT

2023 -07- 20

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

INNOVATION
INVESTMENT

# ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАВСРАЛТ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬЁГ

| Дугаар | Баримт бичгийн нэр |
|---|---|
| 1. | Үндсэн Андеррайтерийн тодорхойлох захидал |
| 2. | Аудитын тодорхойлох захидал |
| 3. | Аудитын тайлан |
| 4. | Үнэлгээний тайлан |
| 5. | Хуулийн дүгнэлт |
| 6. | Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар |
| 7. | Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 8. | Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар |
| 9. | Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдүүдийн шийдвэрүүд: |
| 9.1. | Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/14 дугаартай “Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай” тогтоол |
| 9.2. | Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч болох “ККТТ” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/03 дугаартай “Компанийн эзэмшиж буй “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн хувьцаанаас нийтэд санал болгон гаргах хүсэлт хүргүүлэх тухай” тогтоол |
| 9.3. | Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02/16 дугаартай “Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлүүдийг тогтоох тухай” тогтоол |
| 10. | Үнэт цаас гаргагчийн шинэчилсэн дүрмийн төсөл |
| 11. | Үндсэн Андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 12. | Туслах Андеррайтеруудын улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 13. | Аудитын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 14. | Үнэлгээний компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 15. | Хуулийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 16. | Үнэт цаас хариуцсан эрх бүхий байгууллагатай харилцах этгээдийн мэдээлэл |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
0021031195 CTC2420

00000001

| | |
|---|---|
| 17. | Толгой, охин болон хараат компанийн мэдээлэл, компанийн холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудын хуулбар: |
| 18. | Охин компани болох “ККТТ” ХХК-ийн гэрчилгээ, дүрмийн хуулбар |
| 18.1. | Охин компани болох “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн гэрчилгээ, дүрмийн хуулбар |
| 18.2. | Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга, компанийн үйл ажиллагааг удирдахад шаардагдах хангалттай туршлагатайг нотлох баримт |

ЦЭХ
2023 __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

ULZII & Co CAPITAL InvesCore CAPITAL

2506 тоот, 25 давхар, Си Ти Тауэр, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Утас:77776377 И-мэйл:info@ucc.mn Вебсайт: www.ucc.mn,

2023.06.30 № А-23/143

# АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

"Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК (цаашид "Үндсэн андеррайтер" гэх), "Инвескор капитал ҮЦК" ХХК (цаашид "Туслах андеррайтер" гэх, хамтад нь "Андеррайтерууд" гэх) нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагч болох "Инновэйшн Инвестмент" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулан Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааг нийтэд анх удаа санал болгох (IPO) ажлыг зохион байгуулж, хувьцааг анхдагч зах зээлд байршуулж худалдах чиг үүрэг бүхий андеррайтеруудаар ажиллаж байна.

Андеррайтерууд нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.6-д заасан Андеррайтерийн тодорхойлох захидлыг дараах агуулгын хүрээнд гаргаж байна.

1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр;

2. Үнэт цаасны танилцуулгыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн эсэх талаар дүгнэлт;

3. Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх талаар гаргасан Андеррайтерийн баталгаа.

Андеррайтерууд нь энэхүү Тодорхойлох захидал (цаашид "Захидал" гэх)-ыг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг гаргуулан авч, тэдгээрт үндэслэн холбогдох дүгнэлтийг оруулсан бөгөөд Үнэт цаас гаргагчаас ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, танилцуулга бэлтгэх явцад мэдэгдээгүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд Андеррайтерууд хариуцлага хүлээхгүй болно. Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагч болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамаарал байхгүй бөгөөд бие даасан, хараат бус дүгнэлт, тайлбарыг гаргасан болно.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

СЭХ 2023 .11. 08 өдөр БҮРТГЭВ

2023 -11- 21 БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 225 (хоёр зуун хорин тав) төгрөгийн үнэ бүхий нийт 36,977,618 (гучин зургаан сая есөн зуун далан долоон мянга зургаан зуун арван найм) ширхэг энгийн хувьцааг нийтэд анх удаа санал болгон гаргах замаар стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтээс нийт 8,319,964,050 (найман тэрбум гурван зуун арван есөн сая есөн зуун жаран дөрвөн мянга тавь) төгрөгийн санхүүжилт татахаар үнэт цаасны танилцуулга бэлтгэн олон нийтэд танилцуулах гэж байна. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын Хөрөнгийн Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явагдана.

Андеррайтерууд нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг үнэт цаасыг бүртгэх Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор зохион байгуулах ба олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг ажлын 10 өдөр, хувьцааны захиалгын бүртгэлийг ажлын 5 өдөрт гүйцэтгэнэ. Үнэт цаасыг анхдагч зах зээлд ТОГТООСОН ҮНИЙН АРГААР худалдах ба нийтэд санал болгож буй хувьцааны 85 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 15 ба түүнээс дээш хувийг жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад хуваарилна. Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалгыг Үнэт цаас гаргагчийн Андеррайтерууд болон түүнтэй гэрээ байгуулсан үнэт цаасны компаниуд, олон нийтээс анхдагч зах зээлийн захиалгыг Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан тус тус авна. Стратегийн хөрөнгө оруулагч нь Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх үүрэг хүлээх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, 200,000,000 (хоёр зуун сая) төгрөг ба түүнээс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах хөрөнгө оруулагч байна.

Анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн аргаар, стратегийн хөрөнгө оруулагчид болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад нэг үнийн түвшинд явуулах ба стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг бүтэн дүнгээр биелүүлж, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын худалдах авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд жижиглэнгийн хөрөнгө оруулагч бүрийн 450 ширхэг хүртэл хувьцааны захиалгыг бүрэн биелүүлж, илүү гарсан дүнд хувь тэнцүүлэн хуваарилах аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ХУУЛИЙН НИЙЦЛИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Үнэт цаас гаргагч нь "Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс" ХХН (цаашид "Хуулийн зөвлөх компани" гэх)-тэй 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Д-С1082317 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгүүлсэн. Гэрээний дагуу "Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны тухай хуулийн 10.6 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянаж, дүгнэлт (цаашид "Хуулийн дүгнэлт" гэх) гаргасан байна. Андеррайтерууд нь Үнэт цаасны танилцуулгын хуулийн нийцлийн талаарх дүгнэлтийг гаргахдаа Хуулийн дүгнэлт болон түүнд агуулагдсан мэдээ мэдээллийг ашигласан бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, хувьцаа эзэмшлийн бүтэц, эрх бүхий этгээдийн шийдвэр болон бусад бичиг баримтууд, засаглалын тогтолцоо, үйл ажиллагааны дүрэм, журам, зааварчилгаа, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн цаасан болон цахим хэлбэрийн баримт материалд агуулагдаж буй мэдээллийг судлан үзэж, хөндлөнгийн аудит, үнэлгээ, хуулийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдүүдийн гаргаж өгсөн тайлан, дүгнэлт, түүнд агуулагдсан мэдээ мэдээллийг ашиглан, Үнэт цаасны танилцуулгыг боловсруулсан болно. Танилцуулгад хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллүүдийг тусгахаар зорьсон бөгөөд үнэт цаас гаргах ажиллагаанд Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрөл бүхий "Грант Торнтон Аудит" ХХК болон Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй "Гэрэгэ Эстимейт" ХХК оролцсон ба эдгээр байгууллагууд нь холбогдох хууль болон журмын шаардлагыг хангасан, мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагууд юм.

Үнэт цаас гаргагч нь "Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болох "Грант Торнтон Аудит" ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулжээ. Уг гэрээний дагуу "Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Үнэт цаас гаргагч нь нийтэд анх удаа үнэт цаас санал болгон гаргах ажиллагааны хүрээнд "Грант Торнтон Аудит" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 2023/20 тоот Үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, уг гэрээгээр "Грант Торнтон Аудит" ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.4-т заасан дагуу тодорхойлох захидлыг гаргасан байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх Санхүүгийн Зохицуулах Хорооны бүртгэлтэй "Гэрэгэ Эстимейт" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан. "Гэрэгэ Эстимейт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг Монгол Улсын

00000005

СЭХ
2023 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагууд болон Үнэлгээний олон улсын стандартын дагуу гүйцэтгэсэн байна.

Үнэт цаасны танилцуулгын бүрдлийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5 зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.5 зүйл, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд тус тус заасан мэдээллүүдийг бүрэн агуулсан гэж Андеррайтерууд нь дүгнэлээ. Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлсэн мэдэгдэлд "Үнэт цаас гаргагч нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, хөрөнгө оруулагчдад танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн" хэмээн мэдэгдсэн болно. Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаасны танилцуулгад хавсаргасан аливаа мэдээ мэдээлэл, баримт материалыг үнэн зөвөөр холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд бүрдүүлсэн бөгөөд энэхүү танилцуулгад тусгагдсан мэдээлэл, баримт бичигтэй зөрчилдсөн эсхүл хуурамчаар бүрдүүлсэн ямарваа баримт бичиг байхгүй гэдгийг илэрхийлж энэхүү хариуцлагын мэдэгдлийг гарган баталгаажуулсан байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.14 дэх хэсэгт "Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигт үнэн зөв мэдээлэл тусгах бөгөөд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд уг хохирлыг үнэт цаас гаргагч, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна" гэсэн шаардлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь баталгаа гаргасан, хуульд нийцэлтэй байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх талаар Хуулийн дүгнэлтийн 8 дугаар зүйлд Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна гэж дүгнэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас олон нийтэд санал болгохтой холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хурлын 23/14 тоот "Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай" тогтоол, Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК нь өөрийн эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн хувьцаанаас нийтэд санал болгон гаргах тухай "ККТТ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 23/03 тоот тогтоол болон Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын "Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлүүдийг тогтоох тухай" 02/16 тоот тогтоолуудыг Андеррайтеруудад ирүүлсэн бөгөөд эдгээр тогтоолууд нь хуульд нийцсэн байна гэж Хуулийн зөвлөх компани дүгнэн Хуулийн дүгнэлтийн 1 дүгээр зүйлд тусгасан.

## АНДЕРРАЙТЕРИЙН ГАРГАХ БАТАЛГАА

Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхийн тул Андеррайтерууд нь мэргэжлийн түвшинд хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан, нягталж үзсэн ба Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй гаргах хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн 3 дугаар ангилалд бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжаалах боломжтой бөгөөд нэгж хувьцаанд ногдох үнэлгээ буюу 242

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

төгрөгийн дүнгээс 7.13 хувийн хөнгөлөлттэй тогтоосон ба хувьцаа бүр нь 225 төгрөгийн үнэ бүхий нийт 36,977,618 (гучин зургаан сая есөн зуун далан долоо мянга зургаан зуун арван найм) ширхэг хувьцааг нийтэд анх удаа санал болгон гаргах замаар стратегийн хөрөнгө оруулагчид болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдаас нийт 8,319,964,050 (найман тэрбум гурван зуун арван есөн сая есөн зуун жаран дөрвөн мянга тавь) төгрөгийн санхүүжилт татах боломжтой гэж дүгнэж байна. Андеррайтерууд нь дараах хүрээнд магадлан шинжилгээ гүйцэтгэсэн:

1. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа
2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал
3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө
4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ
5. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд анх удаа санал болгож буй үнэт цаасны үнэ тогтоох үндэслэл
6. Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
7. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн шинжилгээ

## 1. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа

### 1.1. Үндсэн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл болон Санхүүгийн мэдээллийн технологийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй технологийн хөрөнгө оруулалтын компани бөгөөд төслийн онцлогоос хамааран зөвхөн санхүүжилт бус мэргэжлийн зөвлөгөө, удирдлага, ажиллах хүчин, технологийн шийдэл зэргийг дотооддоо боловсруулсан хөрөнгө оруулалтын бодлого, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу санал болгон ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь 2010 онд үүсгэн байгуулагдсан “ККТТ” ХХК болон 2019 онд үүсгэн байгуулагдсан “Дижитал Мерчант Сервисэс” ХХК гэх зуун хувийн эзэмшлийн хоёр охин компанитай байна. 2023 оны 06 дугаар сарын байдлаар Үнэт цаас гаргагчийн санаачлан зах зээлд нэвтрүүлж, охин компаниудаараа дамжуулан хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь TechFin концепцийн хүрээнд багтах бөгөөд доорх 2 ангилалд хамаарч байна.

1. Бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ буюу QPay төлбөрийн шийдэл – Тус үйлчилгээ нь Харилцагч арилжааны банк, мерчант, банк бус санхүүгийн байгууллагууд, финтекийн компаниуд болон эцсийн хэрэглэгчдэд чиглэсэн олон модуль, үйлчилгээний төрлөөс бүрдэх цогц төлбөрийн гарц буюу дижитал дэд бүтцийн шийдэл бөгөөд Үнэт цаас гаргагчийн охин компани болох “ККТТ” ХХК нь тус үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийг эзэмшин, өдөр тутмын үйл ажиллагааг нь удирдан явуулж байна.
2. Мерчант буюу харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, төлбөр хүлээн авагч байгууллагуудад зориулсан үйлчилгээ - QPay үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн үйлчилгээ үзүүлэгч мерчант болон иргэдэд зориулсан нэмэлт үйлчилгээг Үнэт цаас гаргагч нь охин компани “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-аар дамжуулан үзүүлж байна.

## 1.2. Лиценз, тусгай зөвшөөрөл

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох "ККТТ" ХХК нь QPay үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-291 дугаартай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал, Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А-139 дугаартай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал, Төлбөрийн системийн шинэ шийдлийг олон улсын болон дотоодын компаниудаар боловсруулах, худалдан авах болон тэдгээрээс зөвлөх үйлчилгээ авах Аутсорсингийн үйлчилгээ авах эрхийг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-358 дугаартай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын дагуу тус тус эзэмшиж байна. Мөн Монгол Улсын оюуны өмчийн газрын 2016 оны А/51 тоот тушаалаар "ККТТ" ХХК нь "QR кодоор мэдээлэл солилцох программ" нэртэй программ хангамжийн бүтээлийн зохиогчийн эрхийн гэрчилгээг эзэмшдэг болно.

Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын хүрээнд "ККТТ" ХХК нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO27001:2013 стандартыг 2018 оноос, Олон улсын картын гүйлгээний PCI-DSS стандартыг 2020 оноос тус тус нэвтрүүлэн гэрчилгээгээ хугацаанд нь баталгаажуулан шинэчлүүлсээр ирсэн байна.

## 2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал

### 2.1. Олон улс дахь бэлэн бус төлбөр тооцооны зах зээл

Олон улс дахь бэлэн бус гүйлгээний дүн 2016 – 2022 онуудад жилд дунджаар 15.5 хувийн өсөлттэй байсан бол 2023 – 2026 онуудад жилд дунджаар 16.4 хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна. Улмаар 2022 онд дэлхийн бэлэн бус гүйлгээний дүн 1.2 их наяд ам.доллар байсан бол 2026 онд 2.1 их наяд ам.доллар болж өсөх таамаглалтай байна. (Эх сурвалж: *Capgemini судалгааны байгууллага, "Дэлхийн төлбөр тооцооны тайлан", 2022 он*) Өсөлтөөр түүчээлэх бүс нутаг нь Монгол Улсын харьяалагдаж буй Ази Номхон далайн бүс нутаг байх бөгөөд тус бүс нутаг дахь бэлэн бус гүйлгээний дүн 2022 онд 553.0 тэрбум ам.доллар байсан бол 2023 - 2026 онуудад жилд дунджаар 22.2 хувиар өсөж, 2026 онд 1.2 их наяд ам.долларт хүрнэ хэмээн тооцоолсон байна. (Эх сурвалж: *Capgemini судалгааны байгууллага, "Дэлхийн төлбөр тооцооны тайлан", 2022 он*) Тус үзүүлэлтийг 2022 оны дүнтэй харьцуулахад 122.8 хувиар өссөн байна.

2016 онд Ази, Номхон далайн бүс нутгийн бэлэн бус гүйлгээний дүн нь дэлхийн нийт бэлэн бус гүйлгээний 26.0 хувийг бүрдүүлж байсан бол 2022 оноос 48.0 хувийг бүрдүүлэх болсон. Дунд хугацаанд Ази, Номхон далайн бүс нутгийн бэлэн бус гүйлгээний өсөлт бусад бүс нутгуудаас илүү хурдацтай хэвээр байх хандлагатай байгаа бөгөөд 2026 онд дэлхийн нийт бэлэн бус гүйлгээний 58.0 хувийг бүрдүүлэх төсөөлөлтэй байна. *(Эх сурвалж: Capgemini судалгааны байгууллага, "Дэлхийн төлбөр тооцооны тайлан", 2022 он)*

### 2.2. Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээл

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурал нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2017 оны

05 дугаар сарын 31-нд баталж, уг хууль нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа болон банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын төлбөр тооцооны зах зээл дахь үндсэн оролцогчид нь Монголбанк, Арилжааны банкнууд болон бусад зээлдүүлэгчид болон финтекийн платформууд байна. Монголбанк нь зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангах, бэлэн бус төлбөрийн хэрэглээг дэмжих, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримталсны үр дүнд олон төрлийн финтекийн, төлбөрийн шийдлүүд зах зээлд нэвтэрсээр байна.

Монгол Улсад бэлэн бус төлбөр тооцоог интернэт хандалт (интернэт банк, аппликэйшн), мобайл хандалт болон телефон банк гэж гурав ангилдаг. 2017 онд 76 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 321 сая ширхэг бэлэн бус гүйлгээ гүйцэтгэгдсэн бол 2022 онд 372 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 1.5 тэрбум ширхэг гүйлгээ бэлэн бусаар хийгдсэн нь үнийн дүн болон тоо ширхгийн хувьд тус тус 5 дахин өссөн үзүүлэлт юм. 2022 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээгээр 63.3 сая ширхэг гүйлгээ гүйцэтгэгдсэн буюу Монгол Улсын нийт бэлэн бус гүйлгээний 4.1 орчим хувь нь дамжиж байсан.

Монголбанкны түүхэн статистик, олон улсын тренд дээр үндэслэн шинжилгээ гүйцэтгэхэд, Монгол Улсын бэлэн бус гүйлгээний зах зээл 2023 - 2027 онуудад жилд дунджаар 13.3 хувийн өсөлт үзүүлж 2027 онд 3 орчим тэрбум ширхэг гүйлгээ бэлэн бусаар гүйцэтгэгдэх боломжтой хэмээн төсөөлж байна. Гүйлгээний үнийн дүн жилд дунджаар 18.6 хувийн өсөлттэй байх тохиолдолд 2027 онд 874 их наяд төгрөгийн бэлэн бус гүйлгээ хийгдэх төлөвтэй. Энэхүү төсөөллийг Үнэт цаас гаргагчийн шинжээчид олон улс болон Монгол Улсын тренд, Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангийн түүхэн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцоолов.

### 3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулалт буюу үндсэн үйл ажиллагааны доорх гурван чиглэлийг баримталдаг:

- Нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх - Иргэдийн өдөр тутам хэрэглэдэг үйлчилгээг цахимжуулах, найдвартай болон аюулгүй дэд бүтцийг хөгжүүлэх замаар илүү цахим үйлчилгээг хялбар, хүртээмжтэй болгох;
- TechFin салбарыг хөгжүүлэх - TechFin салбар нь технологийн шийдлийг ашиглаж банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг илүү боловсронгуй, хүртээмжтэй болгох;
- Нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих - Аливаа үйлчилгээг цахимжуулж илүү хялбар, хямд, нээлттэй, нийгмийн бүлгүүдэд хүртээмжтэй, мөн байгаль орчинд ээлтэй болгох.

Үнэт цаас гаргагч нь дээрх гурван чиглэл, зарчимд үндэслэн дунд хугацаанд:

- Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл дахь байр сууриа тэлэх;
- Тус зах зээлд дундын HUB буюу дижитал дэд бүтэц хөгжүүлэх замаар түнш, харилцагч байгууллагуудын хамтын хөгжлийг дэмжих;
- Олон улсын JP Morgan хөрөнгө оруулалтын банкны жишиг болгож буй POWER+ стратегийн тодорхойлсон 20 гаруй бизнесийн салбаруудад төлбөр тооцооны шийдэл, дэд бүтэц хөгжүүлэн нутагшуулах;
- TechFin салбарт гарааны бизнес, шинэ санаа, төсөлд санхүүжилт, ажиллах хүчин буюу хүмүүн капитал, технологийн шийдэл, удирдлагын зөвлөгөөгөөр хөрөнгө оруулалт хийх үндсэн дөрвөн стратеги хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Энэ хүрээнд Үнэт цаас гаргагч нь зохих Түншлэлийн бодлого, Байгаль Орчин Нийгэм Засаглалын тогтвортой хөгжлийн бодлого, Хүний нөөцийн бодлого, Маркетингийн бодлого мөн Судалгаа хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулан мөрдөж байна.

### 3.1. Бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд байр сууриа тэлэх, бэхжүүлэх

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд амжилттай нэвтэрсэн QPay үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийн тул үйлчилгээний модиулуудын тоог нэмэгдүүлэх, харилцагч/мерчантуудын халамжлалыг сайжруулах, маркетингийн идэвхжүүлэлт гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн, олон улсын ЮнионПэй, WechatPay, ZeroPay, AliPay-тэй хамтарсан үйлчилгээний модулиуд нэвтрүүлэх, хамтын ажиллагааны санамж бичиг зурах зэргээр QPay үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд биллингийн үйлчилгээ, олон улсын төлбөр тооцоо, мерчантуудад зориулсан лоялти систем, байгууллага хоорондын гүйлгээний үйлчилгээ зэрэг шинэ модиулууд хөгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргасан дагуу судалгаа, хөгжүүлэлт гүйцэтгэн ажиллаж байна.

### 3.2. Дундын HUB үйлчилгээнүүдээр дамжуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх

Үнэт цаас гаргагч нь QPay үйлчилгээг зах зээлд нутагшуулах явц дунд бүрдүүлсэн харилцагч болон мерчантуудыг түнш хэмээн үздэг тул дээрх шийдлүүд болон цаашид хөгжүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь түншүүдийн асуудал, хэрэгцээг шийдвэрлэх дэд бүтцийн буюу хоорондын нь холбох шийдлүүд байх юм.

### 3.3. POWER+ стратеги хэрэгжүүлэх

Үнэт цаас гаргагч нь одоогийн байдлаар цахим хэтэвч, онлайн худалдаа зэрэг бизнес салбаруудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд цаашид олон улсад хамгийн хурдацтай хөгжих бусад салбаруудад үйлчилгээгээ санал болгон нутагшуулах төлөвлөгөөтэй байна.

### 3.4. TechFin хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагч нь дунд болон урт хугацаанд Монгол Улс дахь TechFin салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй компани, бизнесийн төслүүдэд өөрийн шалгуур болон Судалгаа хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын бодлогын дагуу

хөрөнгө оруулж, тус бизнесийн үр ашгаас ашиг хүртэх, үйл ажиллагаагаа нь өргөжүүлж, бизнесийн хамтын ажиллагааг дэмжих байдлаар ажиллахаар төлөвлөж байна.

## 4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ

### 4.1. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн шинжилгээ

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу, охин компани "ККТТ" ХХК болон "Дижитал Мерчант Сервисэс" ХХК хамт нэгтгэсэн санхүүгийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон аудитаар баталгаажуулдаг.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг шинжилбэл нийт хөрөнгийн хэмжээ 2019 - 2022 онуудад 2.3 тэрбум төгрөгөөс 6.8 тэрбум болж 43.0 хувиар өссөн нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжин, ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой бөгөөд нийт хөрөнгийн 85.0 хувийг эргэлтийн хөрөнгө, 15.0 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна.

| | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| *Санхүү байдлын тайлан /сая төгрөгөөр/* | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,820.7 | 1,411.2 | 2,123.4 | 1,853.4 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 207.2 | 343.1 | 608.4 | 3,846.1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,027.9 | 1,754.3 | 2,731.8 | 5,699.5 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 296.8 | 300.0 | 502.2 | 1,056.6 |
| Нийт хөрөнгө | 2,324.7 | 2,054.3 | 3,234.0 | 6,756.1 |
| Богино хугацаат өр төлбөр | 48.1 | 244.6 | 397.4 | 481.3 |
| Өр төлбөрийн дүн | 52.1 | 262.4 | 537.9 | 586.9 |
| Эздийн өмч | 2,272.6 | 1,791.9 | 2,696.1 | 6,169.2 |
| Нийт өр төлбөр, эздийн өмчийн дүн | 2,324.7 | 2,054.3 | 3,234.0 | 6,756.1 |

| *Орлогын нэгтгэсэн тайлан /сая төгрөгөөр/* | **2019** | **2020** | **2021** | **2022** |
|---|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл |
| Цэвэр борлуулалтын орлого | 406.0 | 859.4 | 2,477.7 | 6,341.7 |
| Цэвэр борлуулалтын орлогын өсөлт | - | 111.7% | 188.3% | 156.0% |
| Нийт ашиг | 235.5 | 588.6 | 1,992.5 | 5,217.5 |
| Цэвэр ашиг | (790.1) | (480.7) | 909.2 | 3,473.0 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн түүхэн үндсэн орлогын эх үүсвэрүүдийг ангилбал:

- QPay үйлчилгээ нь арилжааны банк болон мерчант талуудтай байгуулсан гурван талт гэрээний дагуу тус үйлчилгээний аль нэг модуль, функцийг ашиглан хийгдэж буй бэлэн бус гүйлгээний дүн эсвэл тоо ширхгээс тогтсон хувь хэмжээ эсвэл тогтмол дүнгээр шимтгэл тооцдог. Тус шимтгэл нь "ККТТ" ХХК-ийн орлогын гол эх үүсвэр юм.

- Үнэт цаас гаргагч нь мерчантуудад зориулсан нэмэлт үйлчилгээг үзүүлдэг ба тус үйлчилгээнээс олох орлогыг гүйлгээний шимтгэл хэлбэрээр тооцдог. Энэ нь "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн үндсэн орлогын эх үүсвэр юм.

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын нэгтгэсэн борлуулалтын орлого нь 2019 онд 406 сая төгрөг байсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2020 онд 111.7 хувиар, 2021 онд 188.3 хувиар, 2022 онд 156.0 хувиар тус тус өсөж, 2022 оны эцэст 6.3 их наяд төгрөгт хүрсэн. 2022 оны нийт борлуулалтын 98 орчим хувийг QPay үйлчилгээ болон мерчантуудад үзүүлдэг нэмэлт үйлчилгээний шимтгэл бүрдүүлж байна. QPay үйлчилгээ ашиглан хийгдэж буй гүйлгээний тоо 2017 оноос 2022 онуудын жилд дунджаар 216.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн борлуулалтын орлогын өсөлтөд гол нөлөөг үзүүлсэн байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар QPay гүйлгээ нь Монгол Улсын нийт бэлэн бус гүйлгээний тоо ширхгийн 4.09 хувь, үнийн дүнгийн 0.74 хувийг эзэлж байна. Энэхүү зах зээлд эзлэх хувь хэмжээг 2017 онтой харьцуулахад 6,429 хувь, 2,596 хувиар тус тус өссөн. QPay үйлчилгээг ихэвчлэн иргэн-мерчант хооронд (B2C гүйлгээ) гүйлгээ хийхэд ашигладаг тул тоо ширхэг өндөр ч, үнийн дүнгийн хувьд картын болон байгууллагын интернет банкны гүйлгээтэй харьцуулахад бага байдаг.

| | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Гүйцэтгэл |
| **Хөрвөх ба төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд** | | | | |
| Өр төлбөрийн харьцаа | 0.02 | 0.13 | 0.17 | 0.09 |
| Эргэлтийн харьцаа | 42.1 | 7.2 | 6.9 | 11.8 |
| **Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд** | | | | |
| **Нийт ашгийн ахиуц** | 58% | 68% | 80% | 82% |
| **Цэвэр ашгийн ахиуц** | -195% | -56% | 37% | 55% |
| **Өөрийн хөрөнгийн өгөөж** | -35% | -24% | 41% | 78% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагч нь 2019 болон 2020 онуудад бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, чанарт анхаарч ажилласан байна. Нэгтгэсэн санхүүгийн тайлангаас ашигт ажиллагааны түүхэн үзүүлэлтүүдийг үзэхэд 2020 оныг дуустал алдагдалтай ажилласан ба 2020 онд 2019 оны алдагдлын түвшнийг 39.2 хувиар бууруулсан гүйцэтгэлтэй байв. Харин 2021 оноос ашигтай ажиллаж эхэлсэн ба 2021 онд цэвэр ашгийн түвшин 36.7 хувь, 2022 онд 54.8 хувьд хүрсэн байна. Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл идэвхтэй тэлэх үетэй зэрэгцүүлэн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний хөгжүүлэлт, мерчант халамжлал, маркетинг борлуулалт болон түншлэлтэй холбоотой бодлогуудыг амжилттай хэрэгжүүлж QPay гүйлгээний тоог 2021 болон 2022 онуудад өмнөх оноосоо 169.0 хувиар, 114.0 хувиар тус тус өсгөсөн байна.

Үнэт цаас гаргагч нь технологийн компани тул борлуулалтын орлого нэмэгдэх, үйл ажиллагаа тэлэх, шинэ модулиуд нэвтрүүлэх, гүйлгээний тоо болон үнийн дүнгийн хэмжээ нэмэгдэхийг дагаад зардал нь шууд хамааралтайгаар өсдөггүй онцлогтой юм.

Иймд борлуулалтын өртгийн борлуулалтын орлогод эзлэх хувийн жин 2019 онд 42.0 хувь буюу 170.4 сая төгрөг, 2020 онд 33.8 хувь буюу 270.8 сая төгрөг, 2021 онд 19.6 хувь буюу 458.2 сая төгрөг, 2022 онд 17.7 хувь буюу 1.1 тэрбум төгрөг болж үнийн

дүнгийн хувьд өссөн хэдий ч борлуулалтын орлогод ээлж буй хувийн жин нь буурсан үзүүлэлттэй байна.

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын нийт зардал нь 2019 онд 1.3 тэрбум байснаас 2022 онд 3.1 тэрбум болж өссөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт зардлын 41.0 хувийг ерөнхий удирдлагын зардал, 36.0 хувийг борлуулалтын өртөг, 8.0 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 1.0 хувийг санхүүгийн зардал, 1.0 хувийг бусад зардал, үлдсэн 13.0 хувийг орлогын татварын зардал тус тус бүрдүүлсэн байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч үйл ажиллагаагаа явуулахад зээлийн эх үүсвэрийн хэрэгцээ бага, өөрсдийн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар үйл ажиллагааг санхүүжих чадамж сайтай байна.

## 4.2. Дунд хугацааны санхүүгийн төсөөлөл

| | 2022 | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|---|---|
| */сая ширхэг/* | Аудитлагдсан | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл |
| **Монгол улсын бэлэн бус гүйлгээний тоо** | 1,559.1 | 1,776.7 | 1,951.9 | 2,108.2 | 2,239.2 | 2,361.5 |
| **Qpay гүйлгээний тоо** | 236.3 | 118.1 | 183.0 | 236.3 | 269.2 | 294.8 |
| **Зах зээлд эзлэх хувь** | 15.2% | 6.6% | 9.4% | 11.2% | 12.0% | 12.5% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл*

Монгол Улсын бэлэн бус гүйлгээний тоо 2018 – 2022 онуудын хугацаанд жилд дунджаар 31.6 хувиар өсөж, 2022 онд бэлэн бус гүйлгээний тоо 1.5 тэрбум ширхэг байсан бол цаашид жилд дунджаар 8.7 хувийн өсөлт үзүүлэн 2027 онд 2.4 тэрбум ширхэг гүйлгээ бэлэн бусаар хийгдэнэ хэмээн төсөөлж байна. Энэхүү тооцоололыг олон улсын тренд, Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангийн түүхэн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцоолсон. Дунд хугацааны гүйлгээний тооны өсөлтийг төсөөлөхдөө Ази-Номхон далайн бүс нутгийн бэлэн бус гүйлгээний үнийн дүнгийн өсөлт буюу 2023 – 2027 онуудад жил дунджаар 19.3 хувийн өсөлт үзүүлэх таамаглалтай байгааг харгалзан үзэж гүйлгээний тооны өсөлт жигд буурч 2027 онд 5.5 хувийн өсөлттэй байхаар тооцоолсон.

QPay үйлчилгээгээр дамжих гүйлгээний тоо 2019 онд өмнөх оноос 193.7 хувиар, 2020 онд 188.3 хувиар, 2021 онд 170.8 хувиар, 2022 онд 113.8 хувиар өссөн. Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээ нь өсөлтийн үе шатанд явж буй тул 2022 онд 113.8 хувиар өссөн гүйцэтгэлтэй байсан гүйлгээний тооны өсөлт нь бизнесийн онол зарчмаар саарах боломжтой гэж үзвэл 2023 онд 86.4 хувийн, 2024 онд 55.1 хувийн, 2025 онд 29.1 хувийн, 2026 онд 13.9 хувийн, 2027 онд 9.5 хувийн өсөлтүүдийг тус тус үзүүлэх боломжтой гэж тооцоолов. Энэхүү өсөлтийг биелүүлбэл 2022 оны эцэст Монгол Улсын нийт бэлэн бус төлбөр тооцооны 4.1 орчим хувийг гүйцэтгэж байсан QPay үйлчилгээ нь 2027 онд уг зах зээлийн 12.5 хувийг бүрдүүлэх юм. Олон улсын жишигтэй харьцуулахад БНХАУ-ийн бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн хамгийн том тоглогчид болох Alipay болон Tenpay (Wechat Pay) үйлчилгээнүүд нь 2022 оны 03 дугаар улирлын байдлаар БНХАУ-ын мобайл гүйлгээний 54%, 42%-ийг тус тус гүйцэтгэж байсан. (Эх сурвалж: Alipay Statistics, 2022) Харин 2022 оны 03 дугаар улирлын байдлаар АНУ-ын бэлэн бус төлбөр

тооцооны зах зээлийн 42 хувийг Paypal үйлчилгээ дангаар эзэлж байсан байна. (Эх сурвалж: Paypal Statistics, 2022)

Нэгтгэсэн орлогын тайлангийн 2023 - 2027 онуудын төсөөллийн дунджаар нийт орлогын 88.0 орчим хувийг "ККТТ" ХХК-ийн орлого буюу QPay үйлчилгээний тэлэлт бүрдүүлж, 12.0 орчим хувийг "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн орлого буюу мерчантуудад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний тэлэлт болон шинэчлэл бүрдүүлнэ гэж төсөөлөл гаргасан байна.

| | 2022 | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл | Төсөөлөл |
| **Санхүү байдлын нэгтгэсэн тайлангийн төсөөлөл** | | | | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 1,853.4 | 5,860.1 | 13,131.8 | 24,020.3 | 36,560.2 | 50,604.2 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 5,699.5 | 7,863.8 | 15,108.0 | 26,109.9 | 38,731.0 | 52,799.9 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,056.6 | 2,791.5 | 3,691.9 | 3,340.4 | 3,273.9 | 2,866.5 |
| Нийт хөрөнгө | 6,756.1 | 10,655.3 | 18,799.9 | 29,450.3 | 42,004.8 | 55,666.4 |
| Богино хугацаат өр төлбөр | 481.3 | 457.3 | 530.1 | 594.2 | 664.7 | 732.7 |
| Өр төлбөрийн дүн | 586.9 | 493.9 | 782.8 | 854.3 | 1,020.0 | 987.0 |
| Эздийн өмч | 6,169.2 | 10,161.4 | 18,017.2 | 28,596.0 | 40,984.9 | 54,679.3 |
| **Орлогын нэгтгэсэн тайлангийн төсөөлөл** | | | | | | |
| Цэвэр борлуулалтын орлого | 6,341.7 | 11,939.8 | 18,083.7 | 23,491.3 | 26,884.7 | 29,673.5 |
| Цэвэр борлуулалтын орлогын өсөлт | - | 88.3% | 51.5% | 29.9% | 14.4% | 10.4% |
| Нийт ашиг | 5,217.5 | 6,830.7 | 12,320.0 | 16,618.8 | 19,330.3 | 21,484.3 |
| Цэвэр ашиг | 3,473.0 | 3,564.4 | 7,855.7 | 10,578.8 | 12,388.9 | 13,694.4 |
| **Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд** | | | | | | |
| Нийт ашгийн ахиуц | 82.3% | 57.2% | 68.1% | 70.7% | 71.9% | 72.4% |
| Цэвэр ашгийн ахиуц | 54.8% | 29.9% | 43.4% | 45.0% | 46.1% | 46.2% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 56.3% | 35.1% | 43.6% | 37.0% | 30.2% | 25.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл*

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн цэвэр ашгийн дүн 2022 онд өмнөх оноосоо 282.0 хувиар өссөн гүйцэтгэлтэй байсан бол 2023 - 2027 онуудад жилд дунджаар 40.0 хувиар өснө гэж тооцоолж байна. Ийнхүү 2027 онд цэвэр ашиг нь 13.7 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. 2023 онд цэвэр ашиг 3.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 2.6 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны тайлант хугацаанд борлуулалтын өртөгт шингээгдээгүй зардлуудыг 2023 онд төсөөлөлд оруулсантай холбоотой юм. Үнэт цаас гаргагчийн зардлын дийлэнхийг цалингийн зардал бүрдүүлэх хэвээр байгаа бөгөөд дунд хугацаанд өрийн санхүүжилт төлөвлөөгүй тул санхүүжилтийн зардал бага байхаар төсөөлсөн. QPay гүйлгээний тооны өсөлт, харьцангуй тогтвортой зардлын өсөлт нь ашигт ажиллагааг ийнхүү нэмэгдэх үндэслэл болж байна.

Үнэт цаас гаргагч нь 2023-2027 оны төсөөллийн дунджаар өөрийн хөрөнгийн өгөөж 34.2 хувьтай, нийт ашгийн ахиуц 68.1 хувьтай, цэвэр ашгийн ахиуц 42.1 хувьтай байхаар төсөөлсөн байна.

5. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд анх удаа санал болгож буй үнэт цаасны үнэ тогтоох үндэслэл

Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн бизнесийн үнэлгээг "Гэрэгэ Эстимейт" ХХК гүйцэтгэсэн ба бизнесийн үнэлгээг үндсэн 3 аргаар тооцож гаргасан байна.

| Үнэлгээний хандлага | Үнэлгээний арга | Бизнесийн үнэ цэн |
|---|---|---|
| **Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ** | Жишиг хэлцлийн дундаж | 41.8 - 46.0 тэрбум төгрөг |
| **Орлогын хандлагаар хийсэн** | Хорогдуулсан ногдол ашгийн арга | 44.8 тэрбум төгрөг |
| **Хөрөнгөд суурилсан үнэлгээ** | Цэвэр хөрөнгийн үнэлгээний арга | 6.2 тэрбум төгрөг |
| **Эцсийн үнэлгээ** | | **44.8 тэрбум төгрөг** |

*Эх сурвалж: Үнэлгээний тайлан*

Үнэлгээчин нь хөрөнгөд суурилсан үнэлгээ гүйцэтгэхдээ тус үнэлгээнд Үнэт цаас гаргагчийн ирээдүйн орлого олох чадварт өндөр нөлөө үзүүлэх гүүдвил, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг нь биет бус хөрөнгийн нөлөөнд тусаагүй тул хөрөнгөд суурилсан үнэлгээгээр Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг тодорхойлох нь тохиромжгүй хэмээн үзсэн байна. Монгол Улсад Үнэт цаас гаргагчтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг, үнэлгээнд харьцуулах компани байхгүй тул хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг компаниуд болон олон улсын ижил төстэй байгууллагуудын үзүүлэлт ашиглан зах зээлийн харьцуулалтын аргаар үнэлгээ гүйцэтгэсэн бөгөөд тус аргачлалыг Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг тодорхойлохоос илүүтэйгээр үнэлгээний дээд, доод хязгаарыг тодорхойлоход түлхүү ашигласан.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн нийт үнэ цэнийг орлогын хандлагын аргаар хийсэн ба 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх 100 хувь бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 44.8 тэрбум төгрөг байхаар тооцоолсон ба энэ нь нэгж хувьцаанд ногдох дүнгээр 242 төгрөг байхаар тооцсон. Үнэт цаас гаргагч болон Андеррайтеруудын зүгээс зах зээлийн өнөөгийн байдал болон жижиг хувьцаа эзэмшигчийн хямдруулалт (minority discount) буюу 7.13 хувийн хөнгөлөлттэй үнээр буюу 225 төгрөгөөр олон нийтэд санал болгохоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын №02/16 тоот шийдвэрээр шийдвэрлэсэн.

6. Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 22.5 хувийг бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт, 30.0 хувийг дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд, 15.0 хувийг техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаанд, 25.0 хувийг "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн

хувьцааны төлбөр болон 7.5 хувийг олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулахтай холбоотой зардлуудад зарцуулахаар төлөвлөсөн байна.

## 7. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, бизнесийн тасалдал болон системийн зогсолттой холбоотой эрсдэл, хүний нөөцийн эрсдэл, дотоод процессийн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, өрсөлдөөний эрсдэл, эдийн засгийн эрсдэл, бусад салбарт гарах эрсдэл, давтагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл, үнэт цаастай холбоотой эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зардал хэтрэх эрсдэл, борлуулалтын орлогын төсөөлөл биелэхгүй байх, стратегийн эрсдэл, комплаенсын хууль зүйн эрсдэлүүдийг онцлон тодорхойлсон.

Үнэт цаас гаргагч нь мэдээллийн технологийн компанийн хувьд эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал нь онцгой ач холбогдолтой байдаг. Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийг таних, удирдах, бууруулах ажиллагааг группийн бүхий л түвшинд авч хэрэгжүүлж байна. Түүнчлэн эрсдэлийн нөлөөлөл тохиолдох магадлалын хүчин зүйлсийг харгалзуулсан эрсдэлийн удирдлагын матриц баталсан ба тус матрицад заасны дагуу гол эрсдэлүүдийг үзүүлэх нөлөөлөл, тохиолдох магадлалаар нь ангилан авч боломжтой арга хэмжээнүүдийг тогтоон хяналт тавин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээг удирдан зохион байгуулж буй охин компани “ККТТ” ХХК нь өдөр тутмын үйл ажиллагаандаа “Эрсдэлийн удирдлагын журам”-аас гадна “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”, “Галт ханын журам”, “Лог бүртгэл хөтлөх, удирдах журам”, “Хор хөнөөлтэй программаас хамгаалах журам”, “Өөрчлөлтийн менежментийн тухай журам” зэргийг баримталж, гарч болох эрсдэлүүдээс сэргийлэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн QPay төлбөрийн систем нь Олон улсын болон Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагын нууцлал, аюулгүй байдлыг ханган үйл ажиллагаагаа явуулж байна. Охин компани “ККТТ” ХХК нь 2020 оноос эхлэн Олон улсын төлбөрийн картын нууцлал, аюулгүй байдлыг хангах PCI DSS стандартыг нэвтрүүлж, Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын “SISA Information Security” байгууллагаар жил бүр дахин баталгаажилтыг хийлгэдэг. Мөн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2013 стандартыг 2022 оны 02 дугаар сард бүрэн нэвтрүүлж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Юниверсал GmbH байгууллагаар амжилттай баталгаажилтыг хийлгэсэн. Тус стандартын сертификат нь 3 жилийн хугацаатай байдаг ба жил бүр Магадлах аудит хийлгэж, нэг жилээр сунгадаг. Тус байгууллагаас 2023 оны 07 дугаар сард Үнэт цаас гаргагчийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагад Магадлах аудит хийх төлөвлөгөөтэй байна.

Кибер халдлагаас хамгаалах зорилгоор хэрэглэгчийн чухал мэдээллийг зориулалтын төхөөрөмж (Банкууд ашигладаг HSM төхөөрөмж) ашиглан шифрлэлт хийж хадгалдаг. Мөн сүлжээний дэд бүтцийг тусгаарлах (network segmentation), сүлжээний галт ханыг байршуулан халдлагаас хамгаалах арга хэмжээг авсан байна.

Түүнчлэн сервер, системийн хурд гүйцэтгэл, ачааллыг 24 цагийн турш хянах мониторингийн системийг ашигладаг ба тогтвортой ажиллагааг хангах үүднээс нөөц дата баазуудад серверээ хадгалж, серверүүдээ виртуалаар олон болгон үйлчилгээний ачааллыг бууруулдаг байна. Байнгын хяналт мониторинг хийснээр мерчант байгууллага, банкнуудыг сүлжээнд асуудал гарсан даруй тухай бүр асуудлыг шийдвэрлэх процессын дагуу зохих арга хэмжээг авч ажилладаг байна.

## ДҮГНЭЛТ

Андеррайтерууд нь өөрийн судалгаа шинжилгээ, хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын дүгнэлт болон холбогдох бусад баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн анх удаа олон нийтэд санал болгон гаргах хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн 3-р ангилалд бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжаалах боломжтой ба Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 225 төгрөгийн үнэ бүхий нийт 36,977,618 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар санал болгон стратегийн хөрөнгө оруулагчид болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдаас нийт 8,319,964,050 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа, Үнэт цаасны төслийн танилцуулга, холбогдох эрсдэл, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Хүндэтгэсэн,

| Үндсэн андеррайтер | Туслах андеррайтер |
|---|---|
| “Өлзий Энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийн | “Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн |
| Гүйцэтгэх захирал | Гүйцэтгэх захирал |
| Б.Өлзийбаяр | Л.Билгүүн |

GrantThornton

**“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК**
**Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний**
**дэлхийн сүлжээний бие даасан фирм**

**"Грант Торнтон аудит " ХХК**
Далай тауэр, ЮНЕСКО-гийн
гудамж, Сүхбаатар дүүрэг-1,
Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 97670 110744
Ф + 97670 110722

# Үнэт цаасны танилцуулга дахь санхүүгийн мэдээллүүдийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгасан тухай Аудиторын тодорхойлох захидал

**“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд**

Бид “Инновэйшн Инвестмент” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2021, 2022 онуудын 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Компанийн 2019, 2020 онуудын 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг “БДО Аудит” ХХК гүйцэтгэсэн ба “Грант Торнтон аудит” ХХК нь 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхдээ 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдлийг давтан шалгаж, зохих тохируулгыг хийсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс гаргадаг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн ба бид материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлэгдсэн гэж үзэн өөрчлөлтгүй дүгнэлтийг өгсөн.

### *Тодорхойлох захидлын хамрах хүрээ, зорилго*

“Инновэйшн Инвестмент” ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/14 тоот шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02/16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн нээлттэй хувьцаат компани болохоор хувьцаагаа олон нийтэд санал болгож байна.

Энэхүү хувьцаагаа нийтэд санал болгох үйл ажиллагааны хүрээнд бид Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр хүргүүлж буй үнэт цаасны танилцуулга, уг танилцуулгад багтсан нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу хяналт хийлээ.

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 00000018

*Компанийн үүрэг хариуцлага*

Үнэт цаасны танилцуулгад толилуулсан санхүүгийн түүхэн мэдээллүүдийн үнэн зөв байдал болон үнэт цаасны танилцуулгад дурдах шаардлагатай иж бүрэн байдлыг компани хариуцна.

*Аудиторын үүрэг хариуцлага*

Бид Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт - 4400 Тохиролцсон горимоор гүйцэтгэх гэрээт ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан шаардлагуудын дагуу зохих аудитын горимуудыг гүйцэтгэсэн.

Энэхүү гэрээт ажил нь Аудитын олон улсын стандарт, Баталгаажуулах гэрээт ажлын олон улсын стандарт болон Нягтлах гэрээт ажлын олон улсын стандарт шиг баталгаажуулах дүгнэлт өгдөггүй, харин ажлын даалгавар болон дүрэм журмаар шаардсан зүйлсийн хүрээнд аудитын горимуудыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнадаг юм.

*Хараат бус байдал*

Энэхүү Тодорхойлох захидалтай холбогдуулж дараах зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:

- Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Монгол Улсын Аудитын тухай хуулиар аудитын үйлчилгээнд тавигддаг ёс зүйн шаардлагууд болон манай компанийн Чанарын удирдлагын гарын авлагад заасан ёс зүйн шаардлагын дагуу тус компаниас хараат бус, сонирхлын зөрчилгүй гэдгээ баталгаажуулж, хараат бус байх үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.
- Бид үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК болон бусад мэргэжлийн оролцогч нартай аливаа сонирхлын зөрчилгүй бөгөөд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

*Гүйцэтгэсэн горимуудын тайлбар*

Үнэт цаасны танилцуулгын 20 дугаар бүлэгт Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээгээр үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ, харьцааны үзүүлэлтүүдийг харуулсан байна. Тухайлбал:

- Үнэт цаасны танилцуулгын 20 дугаар бүлэгт Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээллүүд, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь дараах мэдээллүүдээс бүрдэж байна.
  - Нэгтгэсэн орлогын тайлангийн шинжилгээ (Хуудас 125)
  - Борлуулалтын орлого (Хуудас 126)
  - Зардлын бүтэц (Хуудас 128-129)
  - Санхүү байдлын нэгтгэсэн тайлангийн шинжилгээ (Хуудас 130)

- Хөрөнгө ба эх үүсвэрийн бүтэц (Хуудас 131-134)
- Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд (Хуудас 135-136)
- Мөнгөн урсгалын тайлангийн шинжилгээ (Хуудас 137)

Санхүүгийн түүхэн мэдээллүүд дээрээ үндэслэн дараах графикуудыг оруулсан байна. Үүнд:

- График 4. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн борлуулалтын орлого, орлогын өсөлт (Хуудас 126)
- График 7. Борлуулалтын орлогод эзлэх зардлын хувийн жин ба нийт зардлын дүн (Хуудас 128)
- График 8. Ерөнхий удирдлагын зардал (Хуудас 129)
- График 9. Борлуулалт маркетингийн зардал ба өсөлтийн хувь (Хуудас 129)
- График 10. Нийт хөрөнгийн дүн ба бүтэц (Хуудас 131)
- График 11. Эргэлтийн хөрөнгийн дүн ба бүтэц (Хуудас 131)
- График 12. Эргэлтийн бус хөрөнгийн дүн ба бүтэц (Хуудас 132)
- График 13. Эх үүсвэрийн дүн ба бүтэц (Хуудас 133)
- График 14. Эздийн өмчийн дүн ба бүтэц (Хуудас 133)
- График 15. Өр төлбөрийн дүн ба бүтэц (Хуудас 134)
- График 16. Хөрвөх чадвар ба төлбөрийн чадварын харьцаа (Хуудас 135)
- График 17. Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд (Хуудас 135)
- График 18. Ашигт ажиллагааны харьцааны шинжилгээ (Хуудас 136)
- График 19. Мөнгөн урсгалын тайлангийн шинжилгээ (Хуудас 138)

- Хүснэгт 20-д харуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дээр үндэслэж дараах санхүүгийн шинжилгээнүүдийг тооцож, гаргасан байна. (Хуудас 135-136) Үүнд:
  - Хөрвөх чадвар ба төлбөрийн чадварын харьцаа
  - Өрийн харьцаа
  - Үйл ажиллагааны харьцаа
  - Ашигт ажиллагааны харьцаа

Бид Үнэт цаасны танилцуулгад багтсан дээрх санхүүгийн түүхэн мэдээллүүд, эдгээр мэдээллүүд дээр үндэслэж хийсэн график дүрслэл болон харьцааны шинжилгээнүүд нь үнэн зөв тооцогдсон эсэхийг хянасан. Харьцааны болон санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцсон байна. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүнтэй тохирч байна.

Үүнтэй холбоотой бид дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэт цаасны танилцуулгад дурдсан санхүүгийн тайлангийн мэдээллийг аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тоо мэдээтэй тулгасан.
- Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн тооцоолсон компанийн борлуулалтын орлого, зардлын бүтэц, хөрөнгө эх үүсвэрийн бүтэц болон график мэдээллүүдийг давтан шалгасан.
- Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн гаргасан ашигт ажиллагааны харьцааны үзүүлэлтүүдийг давтан тооцоолсон.



00000020

### *Үнэт цаасны бүртгэлийн журмаар шаардсан бусад асуудал*

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үр ашигтай байдлыг хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг гүйцэтгэсэн.

Бидний дүгнэлтээр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг компанийн удирдлага тогтоосон ба 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм, журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна гэж дүгнэсэн.

Дотоод хяналтыг шалгах аудитын горимын үр дүнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр ашигтай байдлыг хангаж байна гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналт, үүнд хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл болон харилцаа, мониторинг зэргийн талаар ойлголт олж авсан ба эдгээр хяналтуудын талаар даган мөшгөх сорил гүйцэтгэсэн.
- Эдгээр горимын үр дүнд компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дотоод хяналтад томоохон сул тал илрээгүй ба сайжруулах шаардлагатай зарим нэг асуудлын талаар компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

### *Гүйцэтгэсэн аудитын горимуудтай холбоотой хязгаарлалтууд*

- Үнэт цаасны танилцуулгыг хянаж дүгнэлт гаргах эдгээр аудитын горимууд нь зөвхөн санхүүгийн түүхэн мэдээллийг хамарсан ба дунд хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө болон санхүүгийн хэтийн төсөөллийг хамраагүй болно.
- Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойших дараа үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгээгүй учир уг өдрөөс хойш энэхүү захидал гарах хүртэлх санхүүгийн мэдээллийг аудитлаагүй болно.
- Дээр дурдсан горимууд нь хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм журмын шаардлагын хүрээнд хийгдсэн ба эдгээр горимуудаар бид үнэт цаасны танилцуулгатай холбоотой бүх асуудлуудыг илрүүлэх шаардлагагүй бөгөөд танилцуулгад орсон бүх мэдээллүүд нь үнэн зөв эсэхэд ямар нэгэн баталгаа өгөхгүй.

Grant Thornton

- Эдгээр горимын үр дүнд бидний анхааралд өртсөн зөрүүтэй илэрхийлэл илрээгүй боловч үнэт цаасны танилцуулгад дурдсан хяналт хийгдээгүй бусад мэдээллүүд нь бидний хяналт хийсэн санхүүгийн мэдээлэл болон холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа гэдэгт итгэж байна.
- Энэхүү тайланг зөвхөн үнэт цаас гаргахтай холбоотой андеррайтерийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгоор бэлтгээгүй болно.

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**

Улаанбаатар, Монгол улс
Огноо: 2023 оны 6 дугаар сарын 30

2023 .11. 08

2023 -07-
БҮРТГЭВ-03

# Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

## "Инновэйшн Инвестмент" ХХК

2022 оны 12 дугаар сарын 31

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

00000023

# Агуулга


| | |
|---|---|
| Хараат бус аудиторын дүгнэлт | 5 |
| Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан | 11 |
| Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 12 |
| Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 13 |
| Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 14 |
| Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд | 16 |



MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

2023 .11. 08

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК
00000024

# Группийн талаарх мэдээлэл

| | | |
|---|---|---|
| **Компанийн нэр:** | "Инновэйшн Инвестмент" ХХК | |
| **Үүсгэн байгуулах шийдвэр:** | 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. | |
| **Гэрчилгээ ба лиценз** | 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 6183948 тоот регистр бүхий 9019097177 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан. | |
| **Төлөөлөн удирдах зөвлөл** | Дарга | У.Наранбаатар |
| | Гишүүн | Б.Чулуунсүх |
| | Гишүүн | Д.Даваа |
| | Гишүүн | Ж.Цогтсанаа |
| | Гишүүн | Хосокава Масахико |
| | Гишүүн | М.Золжаргал |
| | Гишүүн | Б.Дондовдорж |
| **Удирдлагын баг:** | Гүйцэтгэх захирал | Г.Эрдэнэмөнх |
| | Санхүү эрхэлсэн захирал | Б.Энхболд |
| | "КKTT" ХХК-ийн захирал | Г.Эрдэнэмөнх |
| | "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн захирал | С.Гүржав |
| **Хаяг:** | Групп нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-дүгээр хороо Элчингийн гудамж, Шүрэн оффис 1-р давхарт 6 тоот | |
| **Регистрийн дугаар:** | 6183948 | |
| **Үйл ажиллагаа:** | Группийн үндсэн үйл ажиллагаа нь мэдээлэл технологи, программ хангамж, мэдээ боловсруулах болон техник хангамжийн үйл ажиллагаа болно. | |
| **Ажиллагсадын тоо:** | 33 | |
| **Аудитор:** | "Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага | |

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
00000025

# Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн ТУЗ-ийн дарга У.Наранбаатар, Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх болон Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд бид энэхүү тайлангийн 3-40 дүгээр хуудсанд үзүүлсэн группийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх группийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

| | | |
|---|---|---|
| ---------------------- | ---------------------- | ---------------------- |
| У.Наранбаатар | Г.Эрдэнэмөнх | Б.Энхболд |
| ТУЗ-ийн дарга | Гүйцэтгэх захирал | Санхүү эрхэлсэн захирал |
| Огноо: | Огноо: | Огноо: |

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

# Хараат бус аудиторын дүгнэлт

**"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

## *Зөрчилгүй дүгнэлт*

Бид "Инновэйшн Инвестмент" ХХК, түүний охин компаниуд (цаашид "групп" гэх)-ын 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад (цаашид "Нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан,
- Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр "Инновэйшн Инвестмент" ХХК, түүний охин компаниудын 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

## *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

## *Хараат бус байдал*

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус группээс хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

## Аудитын аргачлалын хураангуй

| | |
|---|---|
| **Аудитын гол асуудлууд** | • Орлого нь группийн санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт бөгөөд "QPAY" системээр үзүүлж буй үйлчилгээний хүрээнд зарим харилцагч арилжааны банк болон компани хоорондын тооцооллыг автоматжуулаагүй, гэрээний нөхцөлийн дагуу гарсан зарим гүйлгээнээс өөрт ногдох орлогыг тодорхойлохдоо гар аргаар тооцоолол хийж байгаа зэргийг харгалзаж аудитын гол асуудалд тусгав. |
| **Аудитын цар хүрээ** | • Энэхүү аудитын цар хүрээнд тус компанийн охин компаниуд болох "КKTT" ХХК, "Дижитал Мерчант Сервисэс" ХХК болон "Фесис Тех" ХХК багтсан болно. |
| **Материаллаг байдал** | • Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 193,708.9 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо татварын өмнөх ашгийн 5%-иар тооцсон.<br>• Группийн голлох бизнесийн үйл ажиллагаа нь ашиг орлого олох бөгөөд санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах үзүүлэлт учир татвар төлөхийн өмнөх ашгийг материаллагийн суурь үзүүлэлтээр сонгосон.<br>• Гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт материаллаг байдлын дүнгийн 75 хувиар буюу 145,281.7 мянган төгрөгөөр тогтоосон нь Группийн дотоод хяналтын орчныг дунд гэж үнэлсэнтэй холбоотой. |

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Эдгээрт залилангаас үүдсэн материаллаг буруу тайлагналын эрсдэлийг багтаасан нөлөө бүхий эрсдэлүүдийг хамруулдаг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд доорх асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн. Доорх хураангуй хүснэгтэд эдгээр эрсдэлд авсан аудиторын хариу арга хэмжээг харуулав. Бид эдгээр асуудалтай холбоотойгоор дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

| Орлогыг хүлээн зөвшөөрөх тооцооллын хүндрэлтэй асуудал | Эрсдэлд авсан хариу арга хэмжээ |
|---|---|
| Группийн үндсэн үйл ажиллагааны орлого нь QR код бүхий наалтыг ашиглан эцсийн хэрэглэгчээс шилжүүлсэн төлбөрийн шимтгэлийн орлого юм.<br><br>Тухайн QR код бүхий наалтыг ашиглан худалдан авагч төлбөр шилжүүлэх үед группийн харилцагч байгууллагууд болох мерчант байгууллагууд, арилжааны банкууд, бусад харилцагч нартай байгуулсан гэрээний нөхцөлөөс хамааран шимтгэлийн орлого группийн харилцах дансанд шууд болон дараа тооцоо хэлбэрээр шилжиж, орж ирсэн үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.<br><br>Орлого нь группийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд "QPAY" систем нь зарим харилцагч арилжааны банк болон компани хоорондын тооцооллыг автоматжуулаагүй, гэрээний нөхцөлийн дагуу гарсан гүйлгээнээс өөрт ноогдох орлогыг тодорхойлохдоо гар аргаар тооцоолол хийж байгаа зэргийг харгалзаж аудитын гол асуудалд тусгав.<br><br>Орлогын тодруулгыг энэхүү тайлангийн **Тодруулга 20-д** толилуулсан. | Бид группийн орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой процессийн талаар ойлголтоо баримтжуулж, энэ процесстэй холбоотой дотоод хяналтын гол элементүүдийг тодорхойлсон.<br><br>Орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>• Орлого хүлээн зөвшөөрөлт болон холбогдох тооцоолол, шийдэл зэргийг хамруулсан бүртгэлийн бодлогыг шалгасан.<br>• QR код бүхий наалтыг ашиглан худалдан авагч төлбөр шилжүүлэх үед харилцагч байгууллагууд болох арилжааны банкууд бусад харилцагч нартай байгуулсан гэрээний заалтын дагуу тооцоолсон удирдлагын тооцооллыг шалгах нарийвчилсан тестүүдийг гүйцэтгэсэн,<br>• СТОУС 15 *"Харилцагчтай хийсэн гэрээний орлого"*-н хэрэгжүүлэлттэй холбоотой хяналтын загварчлал болон хэрэгжүүлэлтийг үнэлсэн,<br>• Гэрээний орлогын дүнг түүвэрлэн давтан тооцоолсон.<br>• Орлоготой холбоотой тооцоолold ашигласан өгөгдлийн бүрэн байдлыг шалгасан. |



БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭЛ ЭНД КО
00000028

## *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээнэ. Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн нэгтгэсэн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бусад мэдээллийн талаарх аливаа баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

## *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Группийн удирдлага эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг зохистой данс бүртгэлд тулгуурлан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Түүнчлэн нэгтгэсэн санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг бүрдүүлэх нь группийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ группийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

## *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

## *Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар*

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн ул итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус

Grant Thornton

байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

## *СЗХ-ноос шаардсан бусад дүгнэлтийн шаардлага*

**Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт**

Бид "Инновэйшн Инвестмент" ХХК, түүний охин компаниудын санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналтыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн тухай хуулийн 19-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхийг шалгасан.

Группийн удирдлага нь НББ-ийн тухай хуулийн 19-д заасан шаардлагыг биелүүлэх, санхүүгийн тайлагналын дотоод хяналтыг үр дүнтэй байлгах, санхүүгийн тайлангийн дотоод хяналтын үр нөлөөг үнэлэх үүрэгтэй.

Бидний үүрэг бол аудитын үндсэн дээр санхүүгийн тайлагналын талаарх группийн дотоод хяналтын талаар дүгнэлт гаргах явдал юм.

Бид аудитаа АОУС-ын дагуу хийсэн. Эдгээр стандартууд нь бид санхүүгийн тайлангийн үр ашигтай дотоод хяналтыг бүх материаллаг зүйлсийн хувьд хангасан эсэхэд үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Бидний аудитад санхүүгийн тайлангийн дотоод хяналтын талаарх ойлголтыг олж авах, материаллаг сул тал байгаа эрсдэлийг үнэлэх, үнэлэгдсэн эрсдэлд үндэслэн дотоод хяналтын загвар, үйл ажиллагааны үр нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай гэж үзсэн бусад процедурыг хэрэгжүүлэх зэрэг багтсан. Бидний хийсэн аудит бидний дүгнэлт гаргах үндэслэлтэй гэж бид үзэж байна.

НББ-ийн тухай хуулийн 19-р зүйлд заасанаар нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг группийн удирдлага тогтоох бөгөөд СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангийн найдвартай байдал, санхүүгийн тайланг гадны хэрэглэгчдэд зориулан үнэн зөв бэлтгэх хяналтыг ТУЗ болон түүнээс томилогдсон гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх үйл явц юм.

Группийн санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- группийн хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээ, хөрөнгийн зарцуулалтыг үндэслэлтэй, үнэн зөв, шударгаар тусгасан бүртгэл хөтлөхтэй холбоотой бодлого, горимууд байгаа эсэх,
- СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай ажил гүйлгээг бүртгэх, группийн орлого, зарлагыг зөвхөн группийн удирдлагын зөвшөөрлийн дагуу хийж байгаа гэсэн үндэслэлтэй баталгааг хангах;
- санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй группийн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй олж авах, ашиглах, захиран зарцуулахаас урьдчилан сэргийлэх, цаг тухайд нь илрүүлэх талаар үндэслэлтэй баталгаа гаргах.

2023 11 08

Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналтын уламжлалт хязгаарлалтад хуйвалдах болон удирдлагын хяналтыг давах зэрэг боломжууд байдаг тул аливаа алдаа, залилангаас үүдэлтэй материаллаг буруу тайлагналаас урьдчилан сэргийлэх, цаг тухайд нь илрүүлэх боломжгүй байдаг.

Мөн санхүүгийн тайлагналын дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаарх аливаа үнэлгээний төсөөлөл нь нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хяналт хангалтгүй болох эсвэл бодлого, журмын хэрэгжилтийн түвшин сулрах эрсдэлтэй.

Бидний дүгнэлтээр НББ-ийн тухай хуулийн 19-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг группийн удирдлага тогтоосон ба энэхүү дүгнэлтийн аудитын гол асуудалд дурдсан орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой дотоод хяналтын асуудлыг эс тооцвол 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг бүх талаараа баримталж ажиллаж байна.

### *Аудитын тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн группийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон Гэрээт ажлын партнер нь Н.Эрдэнэцог болно.

GRANT THORNTON AUDIT LLC

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**

Огноо: 2023.03.15

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК



00000031

# Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

| **Мянган төгрөгөөр** | **Тодруулга** | **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| *Эргэлтийн хөрөнгө* | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 7 | 1,853,360 | 2,123,419 |
| Дансны ба бусад авлага | 8 | 1,102,693 | 383,571 |
| Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт | 9 | 1,000,000 | - |
| Богино хугацаат санхүүгийн хөрөнгө | 10 | 1,412,454 | - |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 11 | 330,842 | 224,245 |
| Бараа материал | 12 | 150 | 615 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **5,699,499** | **2,731,850** |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | | | |
| Үндсэн хөрөнгө | 13 | 694,476 | 171,285 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 14 | 128,061 | 147,438 |
| Биет бус хөрөнгө | 15 | 234,051 | 183,467 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **1,056,588** | **502,190** |
| **Нийт хөрөнгө** | | **6,756,087** | **3,234,040** |

# Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан *(үргэлжлэл)*

| Мянган төгрөгөөр | Тодруулга | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| Өр төлбөр болон эзэмшигчдийн өмч | | | |
| *Эргэлтийн өр төлбөр* | | | |
| Дансны ба бусад өглөг | 16 | 480,267 | 390,628 |
| Түрээсийн өр төлбөр | 17 | 1,047 | 853 |
| Урьдчилж орсон орлого | 18 | - | 5,926 |
| **Эргэлтийн өр төлбөрийн дүн** | | **481,314** | **397,407** |
| *Эргэлтийн бус өр төлбөр* | | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 28.1 | 4,615 | 4,580 |
| Түрээсийн өр төлбөр | 16 | 100,997 | 135,904 |
| **Эргэлтийн бус өр төлбөрийн дүн** | | **105,612** | **140,484** |
| **Өр төлбөрийн дүн** | | **586,926** | **537,891** |
| *Эзэмшигчдийн өмч* | | | |
| Хувьцаат капитал | 19 | 3,501,000 | 3,501,000 |
| Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | | 2,668,161 | (804,851) |
| **Эздийн өмчийн дүн** | | **6,169,161** | **2,696,149** |
| **Нийт өр төлбөр болон эзэмшигчдийн өмч** | | **6,756,087** | **3,234,040** |

Тайлангийн 17-аас 40 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Уг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр батлав:

У.Наранбаатар
ТУЗ-ийн дарга

Г.Эрдэнэмөнх
Гүйцэтгэх захирал

Я.Оюунханд
Ерөнхий нягтлан бодогч

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

# Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мянган төгрөгөөр | Тодруулга | 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|---|
| Орлого | 20 | 6,341,734 | 2,477,692 |
| Өртөг | 21 | (1,124,229) | (485,186) |
| **Нийт ашиг/(алдагдал)** | | **5,217,505** | **1,992,506** |
| Борлуулалт, маркетингийн зардал | 22 | (262,537) | (208,738) |
| Ерөнхий удирдлагын зардал | 23 | (1,291,265) | (763,967) |
| Бусад зардал | 24 | (33,959) | (1,161) |
| Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал) | 25 | 159,213 | (1,037) |
| **Үндсэн үйл ажиллагааны үр дүн** | | **3,788,957** | **1,017,603** |
| Санхүүгийн орлого | 26 | 96,960 | 24,596 |
| Санхүүгийн зардал | 26 | (20,388) | (14,116) |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны олз | 27 | 8,649 | - |
| **Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)** | | **3,874,178** | **1,028,083** |
| Орлогын татварын зардал/(буцаалт) | 28 | (401,167) | (118,915) |
| **Тайлант жилийн ашиг/(алдагдал)** | | **3,473,011** | **909,168** |

Тайлангийн 17-с 37 дугаар хуудсан дахь тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
00000034

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

# Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Мянган төгрөгөөр | Хувьцаат капитал | Хуримтлагдсан ашиг /алдагдал | Нийт |
|---|---|---|---|
| **2021 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл** | **3,501,000** | **(1,714,019)** | **1,786,981** |
| Тайлант жилийн алдагдал / (ашиг) | - | 909,168 | **909,168** |
| **2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **3,501,000** | **(804,851)** | **2,696,149** |
| Тайлант жилийн алдагдал / (ашиг) | - | 3,473,012 | **3,473,012** |
| **2022 оны 12 дугаар 31-ний үлдэгдэл** | **3,501,000** | **2,668,161** | **6,169,161** |

Тайлангийн 17-с 40 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО АУДИТ ХХК
9021031195 CTC3420
00000035

СЗХ 2023.11.0 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

# Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| ***Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **7,322,747** | **2,604,327** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого | 6,725,328 | 2,599,232 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 433 | 836 |
| Бусад мөнгөн орлого | 596,986 | 4,259 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **4,314,744** | **1,785,685** |
| Ажиллагчдад төлсөн | 819,074 | 696,015 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 215,158 | 178,085 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 395,607 | 100,015 |
| Ашиглалтын зардалд төлсөн | - | 788 |
| Хүүний төлбөрт төлсөн | - | 38 |
| Татварын байгууллагад төлсөн | 1,009,479 | 392,879 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 2,865 | - |
| Бусад мөнгөн зарлага | 1,872,560 | 417,865 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **3,008,004** | **818,643** |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **242,930** | **92,057** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 15,150 | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 193,218 | 61,580 |
| Хүлээн авсан хүүний орлого | 34,562 | 30,477 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **3,603,007** | **197,166** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 762,567 | 128,550 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 26,186 | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 2,412,454 | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 401,800 | 68,617 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(3,360,077)** | **(105,109)** |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC

УЛААНБААТАР ХОТ ... ХХК 00000036

# Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан *(үргэлжлэл)*

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| ***Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **471** | **-** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 471 | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | **77,634** | **272** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 45,613 | 272 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 32,021 | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(77,163)** | **(272)** |
| Валютын ханшийн зөрүү | 159,178 | (1,037) |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(270,058)** | **712,225** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,123,419** | **1,411,194** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,853,360** | **2,123,419** |

# Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Инновэйшн Инвестмент" ХХК нь 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Группийн үндсэн үйл ажиллагаа нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа, программ хангамжийн үйл ажиллагаа, мэдээ боловсруулах үйл ажиллагаа болон техник хангамжийн үйл ажиллагаа болно.

Групп нь дараах тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/291 дүгээр тушаалын дагуу охин компани болох "ККТТ" ХХК-ийн нэр дээр "Төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий процессорын үйл ажиллагаа эрхлэх" аж ахуйн үйл ажиллагааны 05 тоот тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.
- Монгол банкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрий н А-139 тоот тушаалын дагуу" Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа" эрхлэх зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай авсан.

***Группийн бүтэц***

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд багтсан гол охин компаниудыг доор харуулбал:

| Охин компаниудын нэрс | Үүсгэн байгуулагдсан улс орон | Үндсэн үйл ажиллагаа | 2022 оны 12 сарын 31-нээрх эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| "ККТТ" ХХК | Монгол улс | Программ хангамжийн үйл ажиллагаа явуулах | 100% |
| "Дижитал Мерчант Сервисэс" ХХК | Монгол улс | Мэдээллийн технологийн үйл ажиллагаа явуулах | 100% |

## 2. Монголын бизнесийн орчин

Монгол Улсын улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, хууль эрх зүй, татвар, хууль тогтоох тогтолцооны хөгжил тасралтгүй үргэлжлэх шинж чанартай байгаа ба Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил нь эдгээр өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг.

Ковид 19 цар тахлын улмаас эдийн засагт гарч буй хямрал, олон улсын цэрэг улс төрийн хурцадмал байдал, дэлхий нийтийг хамарсан тээвэр ложистикийн хүндрэл манай улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлсээр байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай холбоотой хямралын дараа Монголын эдийн засаг тогтвортой сэргэх үе шатанд орсон.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2022 онд 4.8 хувьд хүрсэн бөгөөд энэхүү өсөлтөд КОВИД-19 цар тахалтай холбоотой хязгаарлалтуудыг цуцалсан, хөдөө аж ахуйн салбар эрчтэй сэргэсэн, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зэрэг Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ болон өрхийн хэрэглээний өсөлт нь дотоод эрэлтэд эергээр нөлөөлж байна. Бизнесийн орчныг сайжруулах, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг

нэмэгдүүлэх, эдийн засгийг нэн тэргүүнд сэргээн босгож хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын хүчин чармайлт, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны өргөтгөсөн төлөвлөгөө нь Монголын эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилд зохих хувь нэмэр оруулах төлөвтэй байна.

## 3. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн бэлтгэсэн болно.

Эдгээр санхүүгийн тайланг Групп нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын удирдлага баталсан.

## 4. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

### *4.1. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд*

Компанид хамааралтай дараах стандарт болон нэмэлт өөрчлөлт нь 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлсэн ба тэдгээр нь байгууллагын санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна. Үүнд:

- СТОУС 3 *"Бизнесийн нэгдэл"*-д орсон нэмэлт өөрчлөлт - Суурь үзэл баримтлалын хүрээний зөвлөмж
- СТОУС 16 "*Түрээс*"-д орсон нэмэлт өөрчлөлт - Ковид 19-тэй холбоотой 2021 оны 6 сарын 30-наас хойш үйлчлэх Түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлт
- НББОУС 16 "*Үндсэн хөрөнгө*"-д орсон нэмэлт өөрчлөлт-Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого
- НББОУС 37 *"Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө"*-д орсон нэмэлт өөрчлөлт - Алдагдалтай гэрээ: Гэрээг биелүүлэх өртөг
- Жил бүрийн сайжруулалтууд (2018-2020 оны мөчлөг):
    - СТОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт-анх удаа хэрэгжүүлсэн охин компани
    - СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл – Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох '10' -тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест
    - СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт - Түрээсийн урамшуулал
    - НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Бодит үнэ цэний хэмжилт дэх татвар

### *4.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд*

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУСЗ-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Байгууллага нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Удирдлага нь тухайн бүх өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусган мөрдөж эхлэхээр төлөвлөж байна.

Удирдлага нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалан санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлэхийг урьдчилан тооцоолоогүй бөгөөд тэдгээрийг доор үзүүлэв.

- СТОУС 17 *"Даатгалын гэрээ"*
- СТОУС 17 *"Даатгалын гэрээ"*-нд оруулсан нэмэлт өөрчлөлт (СТОУС 17 ба СТОУС 4-д оруулсан нэмэлт өөрчлөлт)
- НББОУС 1 *"Санхүүгийн тайлангийн толилуулга"*-д орсон нэмэлт өөрчлөлт - Өр төлбөрийн богино болон урт хугацааны ангилал
- НББОУС 1 *"Санхүүгийн тайлангийн толилуулга"*-д орсон нэмэлт өөрчлөлт – НББОУСЗ-өөс 2021 оны 2-р сард НББОУС 1 болон СТОУС-ын практик мэдэгдэл 2 *"Материал байдлын талаар үнэлэмж гаргах"*-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг сайжруулах зорилготой юм.
- НББОУС 12 *"Орлогын татвар"* -т орсон нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар
- НББОУС 8 *"Нягтлан бодох бүртгэлийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа"*-д орсон нэмэлт өөрчлөлт - 2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 8-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтөөр тайлагнагч байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс хэрхэн ялгах ёстойг илүү тодорхой болгож өгсөн.

## 5. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

### *5.1. Бүртгэлийн суурь*

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнээр хэмжсэн зарим санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогыг дор харуулав.

### *5.2. Нэгтгэлийн суурь*

Групп нь толгой компани болон түүний охин компаниудын 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангуудыг нэгтгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахад компани хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ болон дотоодын ажил гүйлгээнээс үүссэн аливаа хэрэгжээгүй олзыг устгана. Компани хоорондын хөрөнгө борлуулалтаас үүссэн хэрэгжээгүй алдагдлыг группийн нэгтгэлээс устгахад, группийн тайлагналын зорилгоор тухайн хөрөнгөнд үнэ цэнэ бууралтын шинжилгээ хийнэ. Охин компаниудын баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь группийн бодлогоос зөрүүтэй бол группийн бодлогод нийцүүлэх тохируулга хийнэ.

Шинээр худалдан авсан болон борлуулсан охин компанийн ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогыг худалдан авалт эсвэл борлуулалт хүчин төгөлдөр болсон өдрөөр хүлээн зөвшөөрнө.

Групп нь охин компаниудын нийт дэлгэрэнгүй орлого болон алдагдлыг эзэмшлийн хувьд уялдуулан эзэмшигчид болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

### *5.3. Бизнесийн нэгдэл*

Нягтлан бодох бүртгэлийн худалдан авалтын аргыг групп охин компани худалдаж авахад ашиглана. Охин компанийн хяналтыг авахад төлсөн нийт төлбөрт худалдан авалтын өдрөөрх шилжүүлсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ, холбогдох өр төлбөр болон группийн өмчийн хэсэг болон хөрөнгө болон өр төлбөрийн болзошгүй тохиролцоог хамруулж тооцно. Худалдан авалтын зардлыг гарсан дүнгээр нь зардлаа хүлээн зөвшөөрнө. Худалдан авсан хөрөнгө болон өр төлбөрийг худалдан авалтын өдрөөрх зах зээлийн үнээр хэмжинэ.

### *5.4. Хараат болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт*

Өмчийн аргын дагуу хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Хараат компани болон хамтарсан үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ нь тэдгээрийн ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын группт хамаарах хувиар өсч эсвэл буурч, мөн нягтлан бодох бүртгэлийн аливаа ялгаатай бодлогын тохируулгыг хийснээр бүртгэгдэнэ. Хараат компани болон хамтарсан үйлдвэрлэлтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн бодит бус олзыг группийн оруулсан хөрөнгө оруулалтын эсрэг устгана.

### *5.5. Гадаад валют хөрвүүлэлт*

**Үйл ажиллагааны болон толилуулгын валют**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг ба толгой компанийн үйл ажиллагааны валюттай ижил юм.

**Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,444.60 төгрөг байв *(2021 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,848.80 төгрөг)*

Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

### *5.6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө*

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол групп нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

## 5.7. Санхүүгийн хэрэглүүр

### *Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт*

Групп нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дахь гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

### *Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт*

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэхээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд группт БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна. Ангиллыг тодорхойлохдоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнийн бууралтыг бусад зардлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт**

*Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө*

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэний бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэний бууралтын хасагдуулаг болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)**

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэний өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал компани/групп дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэний өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэний өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно.

Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ



00000042

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдөх шаардлагагүй. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд банк сонгож болох хувилбар юм.

**Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)**

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

### Дансны болон бусад авлагын үнэ цэний бууралт

Групп нь дансны болон бусад авлагын үнэ цэний бууралтыг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Эдгээр нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны аль ч үед төлбөр төлөгдөхгүй (дефолт) болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм.

Групп нь дансны авлагын үнэ цэний бууралтыг тооцохдоо хугацаа хэтэрсэн өдрүүдээр нь бүлэглэн зээлийн эрсдэлийн шинж чанарт ангилан үнэлнэ.

### Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт

Группийн санхүүгийн өр төлбөрт зээл, дансны болон бусад өглөг, бусад санхүүгийн хэрэглүүрүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэний олз гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэний өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

### *5.8. Бараа материал*

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг жинлэсэн дунджийн зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасаж тооцно.

### *5.9. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо*

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

### *5.10. Үндсэн хөрөнгө*

Тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэглүүр болон бусад тоног төхөөрөмжүүд зэрэг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүдийг барилга болон компьютер дагалдах хэрэглүүрийн адил бүртгэнэ.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

| | | |
|---|---|---|
| Тавилга, эд хогшил | - | 10 жил |
| Компьютер дагалдах тоног төхөөрөмж | - | 2 жил |
| Бусад | - | 10 жил |

## 5.11. *Бусад биет бус хөрөнгө*

**Анхны хэмжилт**

Компани нь худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан хорогдлыг хассан дүнгээр тайлагнана.

Биет бус хөрөнгөөс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөжид тухайн аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын орлого, өртөг зардлын хэмнэлт буюу хөрөнгийн ашиглалтаас үүсэх бусад үр өгөөж хамаарч болох юм. Жишээлбэл: үйлдвэрлэлийн процесст оюуны өмчийг ашиглах нь ирээдүйн орлогыг нэмэгдүүлэх биш, харин ирээдүйн үйлдвэрлэлийн зардлыг бууруулж болох юм.

**Дараа үеийн хэмжилт**

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан программ зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэний бууралтын тест хийнэ.

Группийн биет бус хөрөнгөд компьютерын программ хангамж, тусгай зөвшөөрөл зэрэг багтана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдалд тусгана.

| | | |
|---|---|---|
| Программ хангамж | - | 2 жил |
| Тусгай зөвшөөрөл | - | Хүчин төгөлдөр байх хугацаанд (4 жил) |

Капиталжуулж буй хөгжүүлэлт нь дуусаагүй программ хангамжийг хорогдуулахгүй боловч үнэ цэнэ бууралтын тест хийнэ.

Хорогдуулгын зардлыг санхүүгийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, үнэ цэнэ бууралтын дансанд бүртгэнэ.

Программ хангамжтай холбоотой дараа үед гарах засварын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг борлуулснаас үүсэх олз, гарзыг борлуулалтын үнэ болон дансны үнийн зөрүүгээр хүлээн зөвшөөрч, бусад орлого болон зардлын дансанд ашиг болон алдагдлаар бүртгэнэ.

## 5.12. *Биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тест*

Хөрөнгүүдийг үнэ цэний бууралтын зорилгоор тусдаа мөнгөний урсгалд (мөнгө бий болгогч нэгж)-д суурилан боломжит хамгийн жижиг бүлгүүдэд хуваадаг. Үүний үр дүнд зарим хөрөнгийн үнэ цэний бууралт дангаараа хийгддэг бол зарим хөрөнгүүд мөнгө бий болгогч нэгжийн түвшинд үнэлэгддэг.

Үнэ цэний бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо

удирдлага нь мөнгө бий болгогч нэгж бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцохын тулд зохих дискаунтын түвшнийг тодорхойлдог.

Мөнгө бий болгогч нэгжид үнэ цэнэ бууралтын гарзыг хуваарилахдаа тухайн нэгжид хамаарах гүүдвилийн үлдэгдлийг хамгийн эхэнд бууруулна. Үлдсэн гарзыг нь мөнгө бий болгогч нэгжид хамаарах хөрөнгүүдэд тэнцүүлсэн хэмжээгээр хуваарилна.

Хөрөнгийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэний бууралтын алдагдал цаашид байхгүй болох шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлдэг. Хөрөнгийн болон бэлэн мөнгө үүсгэх нэгжийн нөхөгдөх үнэ нь түүний дансны үнээс давсан тохиолдолд үнэ цэний бууралтын алдагдлыг буцаана.

## *5.13. Түрээс*

Оффисын түрээсийн гэрээг сунгах нөхцөлтэйгөөр 3 жилийн хугацаагаар хийдэг. Групп нь борлуулаад, буцаан түрээслэх нөхцөлтэй хэлцэл хийдэггүй. Бүх түрээсийн гэрээг өөр өөр нөхцөлтэйгөөр байгуулсан.

Тухайн гэрээ нь түрээс эсэх, эсвэл түрээсийг агуулсан эсэхийг групп нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлнэ. Хэрэв гэрээ нь төлбөрийн хариуд тухайн тодорхойлсон хөрөнгийн ашиглалтыг хянах эрхийг шилжүүлдэг бол уг гэрээ нь түрээс болно, эсвэл түрээсийг агуулсан байна.

**Түрээслэгчийн түрээсийн хэмжилт болон хүлээн зөвшөөрөлт**

Түрээс эхлэх өдрөөр групп нь санхүүгийн байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхийн хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба энэ нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилт, группийн зарцуулсан аливаа шууд зардал, түрээсийн хугацааны эцэст хөрөнгийг буулгах, нураахтай холбоотой тооцоолсон зардал болон түрээс эхлэх өдрөөс өмнө хийгдсэн урьдчилгаа төлбөрийн нийлбэр юм.

Групп нь ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхийн хөрөнгөнд үнэ цэнэ буурах нөхцөл бүрдсэн бол үнэ цэнийг бууруулна. Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо групп нь ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүгийн төвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн төвшнийг) ашиглан дискаунтчилан тооцно.

Түрээсийн өр төлбөрийн тооцоололд тогтмол төлбөрүүд, индекс эсвэл ханш дээр суурилсан хувьсах төлбөрүүд, гэрээт хугацааны эцэст төлөх нь тодорхой болсон бусад төлбөрүүд хамаарна.

Дараа үеийн хэмжилтийн үед өр төлбөр нь төлсөн төлбөрөөр буурч, тооцоолсон хүүгээр өснө. Өр төлбөр нь гэрээлсэн тогтмол төлбөрт өөрчлөлт орох үед болон аливаа бусад төлбөрийн тооцоололд өөрчлөлт орох үед дахин тооцоологдоно. Түрээсийн өр төлбөр дахин тооцоологдоход түүнд хамаарах ашиглах эрхийн хөрөнгөнд тохируулга хийгдэх ба хэрэв ашиглах эрхийн хөрөнгө үлдэгдэлгүй болсон бол ашиг алдагдалд тохируулга хийгдэнэ.

Групп нь богино хугацааны түрээс, бага өртөг бүхий хөрөнгийн түрээсийг өөрийн практик туршлагад үндэслэн ангилан бүртгэнэ. Тэдгээр хөрөнгүүдийг ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөр гэж бүртгэхгүй ба харин холбогдох төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр, түрээсийн өр төлбөрийг дансны болон бусад өглөгөөр илэрхийлнэ.

**Дараа үеийн хэмжилт**

Ашиглах эрхтэй хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчилнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### *5.14. Өмч, нөөц, ногдол ашгийн төлбөр*

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Халаасны хувьцаа нь групп гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно. Хувьцаа гаргахтай холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталаас хасна.

### *5.15. Орлого хүлээн зөвшөөрөлт*

Орлогыг хүлээн зөвшөөрөхдөө компани нь дараах 5 алхмыг мөрддөг.

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хуваарилах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Группийн орлого нь шимтгэлийн орлого, холболтын хураамжийн орлогоос бүрддэг.

Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Шимтгэлийн орлогыг QR код бүхий наалтыг ашиглан эцсийн хэрэглэгч төлбөр шилжүүлэх үед тухайн төлбөрийн шилжүүлгээс шимтгэлийн орлого орох үед хүлээн зөвшөөрдөг.

Холболтын хураамжийн орлогыг арилжааны банкнууд болон мерчант байгууллагуудтай гурвалсан гэрээ хийсний дагуу QPAY системийн холболт болон QR код бүхий наалтыг байршуулсны дараа холболтын хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрнө.

### *5.16. Өртөг зардал*

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба үйл ажиллагааны зардлууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно.

Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулна.

### *5.17. Ажилчдын богино хугацааны тэтгэмж*

**Богино хугацааны ажилчдын тэтгэмж**

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид хамаарах амралтын мөнгө зэрэг тэтгэмжийг тэтгэмж болон бусад үүргийн дансанд дискаунтчлаагүй дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахыг багтаана. Үүнд:

- цалин урамшуулал;
- ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- мөнгөн бус тэтгэмжүүд

**Цалинтай чөлөө**

Цалинтай чөлөө хэлбэрээр олгох ажилчдын богино хугацааны тэтгэмжийн хүлээгдсэн өртгийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:



00000046

ҮХ
2023 .11 08
БҮРТГЭВ
№ 31



2023 -07- 28
БҮРТГЭВ-03

(a) ажилчдын үзүүлж буй үйлчилгээ ирээдүйд цалинтай чөлөө авах эрхийг нэмэгдүүлж байгаа үед хуримтлуулсан цалинтай чөлөөгөөр.
(b) Чөлөө авах үед хуримтлуулаагүй цалинтай чөлөөгөөр

### 5.18. *Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр*

Шүүхийн маргаан, алдагдалтай гэрээ, зэрэг бусад төлбөрийг үүрэг өнгөрсөн үйл явдлыг үр дүнд бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай бөгөөд мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжтой болсон үед нөөцөөр зөвшөөрнө.

Нөөцийг тайлангийн өдрөөр мэдэгдэж буй хамгийн найдвартай нотолгоонд үндэслэсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зардлын мэдээлэлд суурилан тооцно. Хэд хэдэн ижил тестэй үүрэг үүссэн үед, үүрэг хариуцлагын төрлөөр нь тэдгээрийг барагдуулахад шаардлагатай гарах урсгалын магадлалыг тооцдог. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөө үзүүлэхүйц бол нөөцийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчлан тооцдог.

Группийн гуравдагч талаас авах нь тодорхой болсон нөхөн олговрыг тусад нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь бага дүнтэйгээс бусад үүссэн нөхцөлийг болзошгүй өр төлбөрөөр санхүүгийн тайланд тодруулна.

### 5.19. *Засгийн газрын буцалтгүй тусламж*

Засгийн газрын буцалтгүй тусламжийг уг тусламжийн нөхцөлийг компани биелүүлэх ба тусламжийг хүлээж авна гэсэн үндэслэлтэй баталгаа бий болох хүртэл хүлээн зөвшөөрөхгүй.

Эргэлтийн бус хөрөнгийг худалдаж авах, барьж байгуулах эсвэл эзэмших шаардлагыг хангах гэсэн үндсэн нөхцөлтэй засгийн газрын буцалтгүй тусламжийг санхүү байдлын тайланд урьдчилж олсон орлогоор хүлээн зөвшөөрч холбогдох хөрөнгийн ашиглах хугацааны турш системтэй, оновчтой сууриар ашиг, алдагдал руу шилжүүлнэ.

Бусад засгийн газрын буцалтгүй тусламжийг системтэй сууриар холбоотой зардлыг харгалзан нөхөх байдлаар уг зардлыг хэрэгжих тайлангийн үеудэд орлогоор хүлээн зөвшөөрнө. Компанид өмнө нь учирсан гарз, хохирол буюу гарсан зардлыг нөхөн олгохоор тооцож авлага үүсгэсэн буцалтгүй тусламж болон ирээдүйн зарлагын санхүүжүүлэх зорилгогүйгээр яаралтай тусламж болгон өгсөн засгийн газрын буцалтгүй тусламжийг авлага үүссэн тайлант үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### 5.20. *Орлогын албан татвар*

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвиллийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ болон татварын хуульд үндэслэн тухайн өр

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ УПК ХХК



00000047

СЗХ
2023 .11 сар 01
БҮРТГЭВ
№ 01

2023 -07- 20
БҮРТГЭВ-03

төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст компани хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

### *5.21. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шүүн тунгаалтыг ашиглах нь*

Санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбогдуулж удирдлага нь хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагыг хэмжиж, хүлээн зөвшөөрөхдөө зарим мэргэжлийн шийдэл, тооцоолол, таамаглалуудыг ашигладаг. Удирдлагын шийдэл, тооцоолол, таамаглал нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

**Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал**

Групп нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

**Дотооддоо хэрэгжүүлсэн программ хангамжийг капиталжуулах**

Программ бүтээхтэй холбоотой судалгаа болон хөгжүүлэлтийн үе шатыг ялган, хөгжүүлэлтийн зардлыг капиталжуулах шаардлага хангагдсан эсэхийг тодорхойлоход удирдлагын шүүн тунгаалд ашигладаг. Группийн удирдлага капиталжуулалтын дараа үнэ цэнийн бууралт хийх нөхцөл үүссэн эсэх, мөн капиталжуулалтын шаардлага хангагдсаар байгаа эсэхэд хяналт тавьдаг.

**Элэгдэх хөрөнгийн ашиглагдах жил**

Удирдлага нь элэгдэх хөрөнгөнд ашиглагдах жилийг хөрөнгийн ашиглалттай уялдуулан тайлант хугацаа бүрд тооцдог. Компьютер дагалдах хэрэглүүртэй холбоотой үүсэж болзошгүй технологийн хоцрогдол нь тус тооцооллыг тодорхойгүй болгож болно.

**Түрээс – түрээсийн өр төлбөрийг хэмжих дискаунтын хувийн тодорхойлолт**

Групп нь гуравдагч талтай түрээсийн гэрээ байгуулсан бөгөөд түрээслүүлэгчийн нуугдмал хүүгийн түвшнийг тодорхойлох боломжгүй байсан. Иймээс групп нь түрээс эхлэх өдрөөр түрээсийн өр төлбөрийг бүртгэхдээ өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн түвшнийг дискаунтын хувь болгох ашигласан. Өсөн нэмэгдэх хүүгийн түвшин нь групп нь өөр ижил төстэй зээл авахад төлөх хүүгийн түвшин юм.

## 6. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр

### *6.1. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ангилал*

**Тодруулга 5.7-д** санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн ангилал бүрийн тайлбар, холбогдох бүртгэлийн бодлогыг тодруулсан. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь ангилал тус бүрээр дараах байдалтай байна. Үүнд:

| | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | | | |
|---|---|---|---|---|
| **Мянган төгрөгөөр** | **Хорогдуулсан өртөг** | **Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр** | **Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжууланбодит үнэ цэнээр** | **Нийт** |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,853,360 | - | - | 1,853,360 |
| Дансны болон бусад авлага | 913,531 | - | - | 913,531 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 1,412,454 | - | - | 1,412,454 |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | **4,179,345** | **-** | **-** | **4,179,345** |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
00000048

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | |
| Дансны болон бусад өглөг | 367,614 | - | - | 367,614 |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | **373,114** | **-** | **-** | **373,114** |

| Мянган төгрөгөөр | 2021 оны 12 сарын 31-ний байдлаар | | | |
|---|---|---|---|---|
| | Хорогдуулсан өртгөөр | Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр | Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр | Нийт |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | |
| Дансны ба бусад авлага | 339,402 | - | - | **339,402** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 2,123,419 | - | - | **2,123,419** |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | **2,462,821** | **-** | **-** | **2,462,821** |
| | | | | |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | |
| Дансны ба бусад өглөг | 305,482 | - | - | 305,482 |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | **305,482** | **-** | **-** | **305,482** |

* Дансны болон бусад авлага, өглөгт зөвхөн санхүүгийн хөрөнгийг толилуулсан.

## 7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараахаас бүрдэнэ:

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 789 | 6,085 |
| *Банкин дахь харилцах данс* | | |
| - Төгрөг | 1,045,354 | 1,095,676 |
| - Ам.доллар | 520,048 | 2,807 |
| *Богино хугацаатай хадгаламж* | | |
| - Төгрөг | 287,169 | 273,513 |
| - Ам.доллар | - | 745,338 |
| | | |
| **Дүн** | **1,853,360** | **2,123,419** |

## 8. Дансны болон бусад авлага

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Дансны авлага (1) | 450,683 | 193,312 |
| Ажиллагсдаас авах авлага (2) | 342,296 | 81,537 |
| НӨАТ-ын авлага | 1,609 | 15,664 |
| НДШ-ийн авлага | - | 2,500 |
| Бусад авлага | 308,105 | 90,558 |
| | | |
| **Дүн** | **1,102,693** | **383,571** |

(1) Дансны авлага нь 257,371.0 мянган төгрөгөөр өссөн нь мерчант байгууллагууд өссөнтэй холбоотой байна.



00000049

(2) Ажилчдаас авах авлага 260,759.0 мянган төгрөгөөр өссөн ажилчдад урт хугацааны зээл олгосноос хамаарсан байна.

## 9. Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| - ККТТ ХХК | 500,000 | |
| - Дижитал мерчант сервисес ХХК | 500,000 | |
| **Дүн** | **1,000,000** | - |

Дижитал Мерчант Сервисес ХХК нь Биржийн бус зах зээлийн арилжааны платформоор дамжуулан хаалттай хүрээнд "Инвескор Бонд Транч 3" бондыг Инвескор ББСБ ХК-тай 2022 оны 10 сарын 24-ны өдрийн БХХАГ-221024/01 тоот бонд худалдах, худалдан авах гэрээг байгуулж доорх нөхцөлөөр, ККТТ ХХК нь 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн В22/13 тоот өрийн бичгийн санхүүжилтийн гэрээг Жи Эс Би капитал ББСБ ХХК-тай байгуулж доорх нөхцөлөөр өрийн бичиг худалдан авсан байна.

| Мянган төгрөгөөр | Бондын (Инвескор 3) | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Эзэмших хугацаа | Хүү (жилийн) | Тоо, ширхэг | Нэгж үнэ | Нийт үнийн дүн |
| Инвескор Бонд Транч 3 | 1 жил | 18% | 500 | 1000 | 500,000 |
| Жи Эс Би капитал ББСБ ХХК | 1 жил | 20% | 500 | 1000 | 500,000 |
| **Дүн** | | | **1,000** | **2,000** | **1,000,000** |

## 10. Богино хугацаат санхүүгийн хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| *Богино хугацаат Банкны хадгаламж* | | |
| - ККТТ ХХК | 500,001 | - |
| - Инновэйшн Инвестмент ХХК | 912,453 | - |
| **Дүн** | **1,412,454** | - |

## 11. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал (1) | 330,842 | 224,245 |
| **Дүн** | **330,842** | **224,245** |

(1) Банкинд төлөх QPAY шимтгэлийн хуримтлуулан тооцсон дүн болон сар бүр зардалд тохируулан бүртгэх урьдчилгаа төлбөрүүдээс бүрдсэн байна.



СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
00000050

*Урьдчилж төлсөн зардал/ тооцооны хөдөлгөөн дараах байдалтай байна:*

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 224,245 | 144,731 |
| Нэмэгдсэн | 2,823,883 | 930,333 |
| Хасагдсан *(зардлаар хүлээн зөвшөөрсөн)* | 2,070,650 | (824,892) |
| Хасагдсан *(хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн)* | 646,636 | (25,927) |
| **Эцсийн үлдэгдэл** | **330,842** | **224,245** |

## 12. Бараа материал

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс | 150 | 615 |
| **Дүн** | **150** | **615** |

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд туссан бараа материал дансны үлдэгдэл нь хангамжийн материалын үлдэгдлийг илэрхийлнэ.

## 13. Үндсэн хөрөнгө

| Мянган төгрөгөөр | Машин, тоног, төхөөрөмж | Тавилга, эд хогшил | Компьютер, дагалдах хэрэгсэл | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| *Өртөг* | | | | |
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **20,000** | **18,742** | **156,731** | **195,473** |
| Нэмэгдсэн | 77,000 | 6,364 | 41,347 | 124,710 |
| Хасагдсан | - | - | 4,650 | 4,650 |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **97,000** | **25,106** | **193,428** | **315,534** |
| Нэмэгдсэн (1) | - | 34,117 | 612,519 | 646,636 |
| Хасагдсан | - | 354 | 84,793 | 85,147 |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **97,000** | **58,868** | **721,155** | **877,023** |
| *Хуримтлагдсан элэгдэл* | | | | |
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **1,671** | **3,367** | **83,308** | **88,346** |
| Нэмэгдсэн | 7,801 | 2,217 | 50,533 | 60,551 |
| Хасагдсан | - | - | 4,650 | 4,650 |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **9,473** | **5,583** | **129,192** | **144,248** |
| Нэмэгдсэн | 9,695 | 4,493 | 84,329 | 98,516 |
| Хасагдсан | - | 81 | 60,136 | 60,217 |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **19,167** | **9,995** | **153,385** | **182,547** |
| *Үлдэгдэл өртөг* | | | | |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **87,527** | **19,522** | **64,236** | **171,285** |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **77,833** | **48,873** | **567,770** | **694,476** |

(1) Охин компани болох КТТТ ХХК-нд 485,026.0 мянган төгрөгийн мэдээлэл хадгалах сервер, 100,906.0 мянган төгрөгийн суурин болон зөөврийн комьютер, Инновэйшн Инвестмент ХХК-нд 26,587.0 мянган төгрөгийн суурин болон зөөврийн компьютерыг тус тус худалдан авсан байна.

## 14. Түрээс

### *14.1. Ашиглах эрхтэй хөрөнгө*

| **Мянган төгрөгөөр** | **Оффис** | **Тоног төхөөрөмжийн байр** | **Нийт** |
|---|---|---|---|
| *Дансны үнэ* | | | |
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **-** | **17,232** | **17,232** |
| Нэмэгдсэн | 170,688 | 28,303 | 198,991 |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **170,688** | **45,535** | **216,223** |
| | | | |
| Нэмэгдсэн | 76,895 | 6,444 | 83,339 |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **247,583** | **51,979** | **299,562** |
| | | | |
| *Хуримтлагдсан элэгдэл* | | | |
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **-** | **4,479** | **4,479** |
| Нэмэгдсэн | 47,413 | 16,936 | 64,349 |
| Хасагдсан | - | (43) | (43) |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **47,413** | **21,372** | **68,785** |
| | | | |
| Нэмэгдсэн | 85,065 | 17,858 | 102,924 |
| Хасагдсан | (208) | - | (208) |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **132,271** | **39,230** | **171,501** |
| | | | |
| **Дансны үнэ - 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **123,275** | **24,163** | **147,438** |
| **Дансны үнэ - 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **115,312** | **12,749** | **128,061** |



00000052

Дараах хүснэгтэд группийн түрээсийн үйл ажиллагаар ашиглах эрхтэй хөрөнгийн төрөл тус бүрээр харуулав:

| Ашиглах эрхтэй хөрөнгө | Түрээсэлсэн хөрөнгийн тоо | Түрээсийн хугацаа | Хугацааг сунгах сонголттой түрээсийн тоо |
|---|---|---|---|
| Дата центр үйлчилгээ | 1 | 3 жил | 1 |
| Физик сервер | 1 | 2 жил | 1 |
| Мэдээлэл холбоо | 1 | 2 жил | 1 |
| Шүрэн оффис | 1 | 3 жил | 1 |

## 15. Биет бус хөрөнгө

| Мянган төгрөгөөр | Програм хангамж | Зохиогчийн эрх | Тусгай зөвшөөрөл | Бусад биет бус хөрөнгө | Нийт |
|---|---|---|---|---|---|
| ***Өртөг*** | | | | | |
| **2021 оны 01 дүгээр сарын 01** | **146,100** | **24,091** | **10,000** | **-** | **180,191** |
| Нэмэгдсэн | - | - | 10,000 | - | 10,000 |
| **2021 оны 12 дугаар сарын 31** | **146,100** | **24,091** | **20,000** | **-** | **190,191** |
| Нэмэгдсэн | 26,138 | - | - | 31,764 | 57,902 |
| Хасагдсан | 1,032 | - | - | - | 1,032 |
| **2022 оны 12 дугаар сарын 31** | **171,206** | **24,091** | **20,000** | **31,764** | **247,060** |
| | | | | | |
| ***Хуримтлагдсан хорогдуулга*** | | | | | |
| **2021 оны 01 дүгээр сарын 01** | **135** | **-** | **-** | **-** | **135** |
| Нэмэгдсэн | 110 | - | 6,479 | - | 6,589 |
| Үнэ цэнийн бууралт * | - | - | - | - | - |
| **2021 оны 12 дугаар сарын 31** | **245** | **-** | **6,479** | **-** | **6,724** |
| Нэмэгдсэн | 1,289 | - | 4,997 | - | 6,285 |
| **2022 оны 12 дугаар сарын 31** | **1,533** | **-** | **11,476** | **-** | **13,009** |
| | | | | | |
| ***Үлдэгдэл өртөг*** | | | | | |
| **2021 оны 12 дугаар сарын 31** | **145,855** | **24,091** | **13,521** | **-** | **183,467** |
| **2022 оны 12 дугаар сарын 31** | **169,672** | **24,091** | **8,524** | **31,764** | **234,051** |

*Тусгай зөвшөөрөл:*

Групп нь Төв банк/Монголбанкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/291 тоот тушаалаар охин компани болох "КТТ" ХХК-ийн нэр дээр төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой процессорын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон Монгол банкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-139 тоот тушаалаар хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

*Зохиогчийн эрх:*

Монгол улсын оюуны өмчийн газрын даргын 2016 оны А/51 тоот тушаалаар QR кодоор мэдээлэл солилцох программын зохиогчийн эрхийг бүртгэлд тусгасан байна.

Охин компани болох КТТ ХХК-нд 5,400.0 мянган төгрөгийн Смартложик санхүүгийн программ, 31,764 мянган төгрөгийн серверийн лиценз, Инновэйшн инвестмент ХХК-нд 7,672.0 мянган төгрөгийн хүний нөөцийн программ худалдан авсан байна.

СЭХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 16. Дансны ба бусад өглөг

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Дансны өглөг (1) | 346,453 | 278,190 |
| Цалингийн өглөг | 20,052 | 27,000 |
| ААНОАТ - ын өглөг | 54,633 | 39,552 |
| ХХОАТ - ын өглөг | 671 | 3,224 |
| НӨАТ - ын өглөг | 56,406 | 42,370 |
| НДШ - ийн өглөг | 943 | - |
| Хүүгийн өглөг | 128 | 215 |
| Ажилчдад өгөх өглөг | 981 | 77 |
| **Дүн** | **480,267** | **390,628** |

(1) Групп нь арилжааны банктай хийсэн гэрээний дагуу QPAY шимтгэлийн орлогоос арилжааны банканд өгөх хувийг гэрээний холбогдох нөхцөл, заалтын дагуу тооцоолон бүртгэсэн байна.

## 17. Түрээсийн өр төлбөр

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| ***Богино хугацаат түрээсийн өр*** | ***1,047*** | ***853*** |
| - Ай Түүлс ХХК | 516 | 395 |
| - Мобинэт ХХК | 531 | 458 |
| | | |
| ***Урт хугацаат түрээсийн өр*** | ***100,997*** | ***135,904*** |
| - Ай Түүлс ХХК | 1,050 | 10,449 |
| - Мобинэт ХХК | 8,173 | 14,132 |
| - Шүрэн оффис ХХК | 87,796 | 110,715 |
| - Мэдээлэл холбооны сүлжээ ХХК | 3,978 | 608 |
| | | |
| **Дүн** | **102,044** | **136,707** |

## 18. Урьдчилж орсон орлого

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 5,926 | 225 |
| Нэмэгдсэн | 2,831,661 | 1,167,362 |
| Хасагдсан (орлогоор хүлээн зөвшөөрсөн) | (2,837,588) | (1,161,661) |
| | | |
| **Дүн** | **-** | **5,926** |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК



00000054

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## 19. Капитал ба нөөц

### 19.1. Хувьцаат капитал

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Нийт энгийн хувьцаа (ширхэгээр) | 140 040 000 | 135 000 |
| Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ | 0.025 | 26 |
| | | |
| **Дүн** | **3,501,000** | **3,501,000** |

2022 оны 12 сарын 31-ний байдлаар группийн хувьцаат капитал нь нэг бүр нь 25 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 140,040,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Группийн хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг доорх хүснэгтэд харуулллаа. Гаргасан ба энгийн хувьцаа нь бүрэн төлөгдсөн. Энгийн хувьцаа тус бүр нэг саналын эрхтэй.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

| Мянган төгрөгөөр | Харьяалал | Эзэмшлийн хувь | Хувьцаат капитал |
|---|---|---|---|
| ***Дотоодын хувьцаа эзэмшигчид:*** | | | |
| "Ай Си Ти Групп" ХК | Монгол улс | 17.04% | 596,465 |
| "Могултехнологи" ХХК | Монгол улс | 5.34% | 187,055 |
| "Юнимедиа Солюшнс" ХХК | Монгол улс | 11.11% | 389,000 |
| | | *33.49%* | *1,172,520* |
| | | | |
| Д.Даваа | Монгол улс | 14.27% | 499,500 |
| Ч.Нарангэрэл | Монгол улс | 11.85% | 414,935 |
| Б.Чулуунсүх | Монгол улс | 6.76% | 236,770 |
| Ш.Эрдэнэбилэг | Монгол улс | 5.98% | 209,255 |
| | | *38.86%* | *1,360,460* |
| **Дүн** | | **72.35%** | **2,532,980** |
| | | | |
| ***Гадаадын хувьцаа эзэмшигчид:*** | | | |
| "Алеско вентурис Өү Юү" ХХК | Эстони улс | 10.02% | 350,720 |
| "Рэнтракс" ХХК | Япон улс | 7.41% | 259,335 |
| "НОБ" ХХК | Япон улс | 1.85% | 64,835 |
| "Глобал Траст Нетворкс" ХК | Япон улс | 1.85% | 64,835 |
| | | *21.13%* | *739,725* |
| | | | |
| Масанори Окоши | Япон улс | 2.82% | 98,625 |
| Шоичиро Ичитани | Япон улс | 1.85% | 64,835 |
| Такахиро Ичики | Япон улс | 1.85% | 64,835 |
| | | *6.52%* | *228,295* |
| **Дүн** | | **27.65%** | **968,020** |
| **Нийт дүн** | | **100%** | **3,501,000** |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК



00000055

### *19.2. Хуримтлагдсан ашиг*

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал юм. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэнэ.

## 20. Орлого

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| QPAY шимтгэлийн орлого | 6,258,468 | 2,428,874 |
| Холболтын хураамж | 83,266 | 48,818 |
| **Дүн** | **6,341,734** | **2,477,692** |

Тайлант хугацаанд QPAY ашиглах мерчант байгууллагын тоо нэмэгдсэнээс үүдэн шимтгэлийн орлого 3,829,594.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## 21. Өртөг

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Цалин хөлс | 410,230 | 321,241 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 51,135 | 37,210 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 8,480 | 14,606 |
| Элэгдэл, хорогдлын зардал | - | 30,297 |
| Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал | - | 4,220 |
| Бусад зардал (1) | 654,384 | 77,612 |
| **Дүн** | **1,124,229** | **485,186** |

(1) QPAY шимтгэлийн орлого олохтой холбоотой тусгай дугаарын мессеж үйлчилгээний зардал болон мерчант байгууллагуудад ногдох шимтгэлийн зардал өссөнөөс шалтгаалж 576,772.0 мянган төгрөгөөр өссөн байна.

## 22. Борлуулалт, маркетингийн зардал

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Шуудан холбооны зардал | 1,007 | - |
| Ажилчдын цалингийн зардал | 171,454 | 126,613 |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | 21,158 | 14,495 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 20,350 | 165 |
| Маркетинг идэвхижүүлэлтийн зардал | 48,567 | 67,465 |
| **Дүн** | **262,537** | **208,738** |

## 23. Ерөнхий ба удирдлагын зардал

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Ажилчдын цалингийн зардал | 395,142 | 395,489 |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | 49,655 | 45,830 |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | 3,033 | 665 |
| Бичиг хэргийн зардал | 4,861 | 3,843 |
| Шуудан холбооны зардал | 5,135 | 3,788 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 416,477 | 160,341 |
| Лицензийн төлбөр | 12,180 | 801 |
| Сургалтын зардал | 10,043 | - |
| Даатгалын зардал | 2,813 | 2,109 |
| Засварын зардал | 8,615 | 350 |
| Ашиглалтын зардал | - | 273 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 207,517 | 96,269 |
| Түрээсийн зардал | 18,687 | 19,431 |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | 2,967 | 1,045 |
| Хүлээн авалтын зардал | 68,914 | 5,301 |
| Маркетинг идэвхижүүлэлтийн зардал | 32,116 | - |
| Хангамжийн материалын зардал | 6,172 | 1,426 |
| Ажилчдын нийгмийн халамжийн зардал | 11,250 | 2,414 |
| Ажилчдын хоолны зардал | 25,483 | 14,358 |
| Хүний нөөцийн үйл ажиллагааны зардал | 3,919 | - |
| Банкны шимтгэлийн зардал | 779 | 1,001 |
| Бусад зардал | 1,908 | 5,757 |
| Шагнал урамшууллын зардал | 3,600 | 3,475 |
| **Дүн** | **1,291,265** | **763,967** |

## 24. Бусад зардал

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 4,616 | - |
| Хангамжийн материалын зардал | 155 | - |
| Алданги, торгуулийн зардал | 500 | - |
| Тестийн гүйлгээ, бусад | 198 | - |
| Баримтаар нотлогдохгүй байгаа зардал | 279 | - |
| Хүлээн авалтын зардал | 9,590 | - |
| Бусад зардал | 18,117 | 1,161 |
| Маркетинг идэвхижүүлэлтийн зардал | 504 | - |
| **Дүн** | **33,959** | **1,161** |



00000057

## 25. Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Ханшийн зөрүүний бодит олз | 35 | - |
| Ханшийн зөрүүний бодит бус олз | 159,178 | 822 |
| Ханшийн зөрүүний гарз | - | (1,859) |
| **Дүн** | **159,213** | **(1,037)** |

## 26. Санхүүгийн орлого, зардал

*Санхүүгийн зардал нь дараахаас бүрдэж байна:*

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Санхүүгийн түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал | 20,388 | 14,116 |
| **Дүн** | **20,388** | **14,116** |

*Санхүүгийн орлого нь дараахаас бүрдэнэ:*

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлээс олсон хүүгийн орлого | 96,960 | 24,596 |
| **Дүн** | **96,960** | **24,596** |

## 27. Үндсэн хөрөнгө борлуулсаны олз

"КKTT" ХХК-нд бүртгэлтэй үлдэх өртөггүй серверийг 3,500.0 мянган төгрөгөөр "Инновэйшн Инвестмент" ХХК-нд бүртгэлтэй 5,877.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй компьютер тоног төхөөрөмжийг 11,300.0 мянган төгрөгөөр борлуулсан, КKTTХХК-нд бүртгэлтэй 88.9 мянган төгрөг, Дижитал мерчант Сервисес ХХК-нд бүртгэлтэй 184.7 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассан гарз үүссэн ба зөрүүгээр 8,649.0 мянган төгрөгийн олз хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

## 28. Орлогын татварын зардал

2022 онд компани нь Монгол улсын Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу тайлант жилийн 6 тэрбум төгрөг (2020: 3 тэрбум) хүртэлх татвар ногдуулах орлогоос 10%-иар, 6 тэрбум төгрөгөөс (2020: 3 тэрбум) дээших татвар ногдуулах орлогын дүнд 25%-иар орлогын албан татвар ногдуулж төлөх үүрэгтэй.

Бодит татварын зардлын хувь болон тайлант жилийн ашгаас хүчин төгөлдөр татварын хувь хэмжээгээр тооцоолсон зөрүүний тооцоо дараах байдалтай байна.

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Тайлант жилийн ашиг | 3,473,011 | 909,168 |
| Орлогын татварын зардал | 401,167 | 118,915 |
| **Татварын өмнөх ашиг** | **3,874,178** | **1,028,083** |
| Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох орлого | 96,961 | 24,596 |
| Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал | 42,692 | 19,612 |

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдлыг бууруулах дүн | 223,758 | 7,282 |
| **Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого** | **3,652,185** | **1,025,784** |
| Татварын хувь хэмжээ | 10% | 10% |
| **Тайлант үеийн татварын зардал** | | |
| Татварын 10%-ийн түвшингээр тооцсон орлогын татвар (10%) | 439,472 | 118,416 |
| Тусгайлсан хувь хэмжээтэй татварын зардал- 10% | 9,696 | 2,460 |
| Татварын хөнгөлөлт | (48,001) | (1,961) |
| **Хойшлогдсон татварын зардал** | | - |
| **Нийт орлогын албан татварын зардал** | **401,167** | **118,915** |

### 28.1. *Хойшлогдсон татварын өр төлбөр*

Хойшлогдсон татварын бүх зөрүүгийн хувьд 10%-ийн (2021: 10%) татварын хувийг ашиглан өр төлбөрийн аргын дагуу тооцоолсон.

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 4,615 | 4,580 |
| **Дүн** | **4,615** | **4,580** |

## 29. Холбоотой талын ажил гүйлгээ

Тухайн групп нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн группийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн групп нь өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурьдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоорх холбоотой талууд гэж тодорхойлдог.

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно. Групп нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм.

| .Холбоотой талуудын нэр | Харьяалал | Хамаарал | Гол үйл ажиллагааны төрөл |
|---|---|---|---|
| "ККТТ" ХХК | Монгол улс | Охин компани | Хөрөнгө оруулалт хоорондын тооцоо |
| "Дижитал Мерчант Сервисэс" ХХК | Монгол улс | Охин компани | Хөрөнгө оруулалт хоорондын тооцоо |
| "Юнимедиа Солюшнс" ХХК | Монгол улс | Хувьцаа эзэмшигч | Худалдан авалт |
| "Ай Си Ти Групп" ХК | Монгол улс | Хувьцаа эзэмшигч | - |
| "Могултехнологи" ХХК | Монгол улс | Хувьцаа эзэмшигч | - |
| "Ай Ти Зон" ХХК | Монгол улс | Хувьцаа эзэмшигчтэй хамаарал бүхий этгээд | Худалдан авалт |
| Д.Даваа | Монгол улс | Хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал |
| Б.Чулуунсүх | Монгол улс | Хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүн | Цалин урамшуулал |



00000059

| Холбоотой талуудын нэр | Харьяалал | Хамаарал | Гол үйл ажиллагааны төрөл |
|---|---|---|---|
| Ш.Эрдэнэбилэг | Монгол улс | Хувьцаа эзэмшигч | - |
| Б.Дондовдорж | Монгол улс | ТУЗ-ийн гишүүн | |
| М.Золжаргал | Монгол улс | ТУЗ-ийн гишүүн | - |
| У.Наранбаатар | Монгол улс | ТУЗ-ийн дарга | - |
| Ж.Цогтсанаа | Монгол улс | ТУЗ-ийн гишүүн | - |
| "Алеско Вентурис Өү Юү" ХХК | Эстони улс | Хувьцаа эзэмшигч | - |
| "Рэнтракс" ХХК | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |
| "НОБ" ХХК | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |
| Хосокава Масахико | Япон улс | ТУЗ-ийн гишүүн | |
| "Масанори Окоши | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |
| "Глобал Траст Нетворкс" ХХК | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |
| Шоичиро Ичитани | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |
| Такахиро Ичики | Япон улс | Хувьцаа эзэмшигч | - |

### *29.1. Хяналтын харилцаа*

Группийг тус компанийн ТУЗ-ийн дарга У.Наранбаатар хянадаг. Группийн толгой компани нь Монгол улсад хуулийн этгээдэд бүртгэгдэж СБД, 1 дүгээр хороо Элчингийн гудамж, "Шүрэн" ХХК-ийн оффисын 1 давхарт байрлах "Инновэйшн Инвестмент" ХХК бөгөөд санхүүгийн тайлангаа олон нийтэд зориулан гаргадаггүй байна.

### *29.2. Толгой компанитай хийсэн ажил гүйлгээ*

Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар охин компани болох "ККТТ" ХХК болон "Дижитал Мерчант Севисэс" ХХК, "Фэсис Тех" ХХК-иудтай хоорондын тооцоогоорх үлдэгдэлтэй байгаа ба дараах ажил гүйлгээнүүд хийгдсэн байна. Үүнд:

"ККТТ" ХХК нь толгой компанид өгөх 841,069.4 мянган төгрөгийн өглөгийг бүрэн төлсөн мөн "Фэсис Тех" ХХК-аас авах 700.0 мянган төгрөгийн авлага хаагдсан, "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-иас авах 5,500.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Мөн "Дижитал Мерчант Сервисэс" ХХК-иас үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2022 онд нийт 60,000.0 мянган төгрөгийн орлого хүлээн авсан байна.

Дээрх ажил гүйлгээнүүдийг СТОУС-ын дагуу группийн нэгтгэсэн тайланд тусгахдаа устгах бичилт хийсэн.

### *Удирдлага болон тэдний ойр дотны гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ*

Голлох удирдлагад ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдний гэр бүлийн гишүүд хамаарна. Голлох удирдлагын тайлант оны цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад тэтгэмжийн зардал дараах байдалтай байна:

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Цалин урамшуулал | 216,857 | 187,188 |
| Шагнал урамшуулал | - | 30,000 |
| | **216,857** | **217,188** |

## 30. Болзошгүй өр төлбөр

Тайлант хугацаанд группийн эсрэг хуулийн зарга маргаантай холбоотой болзошгүй өр төлбөр байхгүй байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
00000060

## 31. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг **тодруулга 4 болон 7-д** дэлгэрэнгүй харуулсан болно.

Групп нь санхүүгийн хэрэглүүрийн идэвхтэй арилжаанд оролцдоггүй. Группийн өртөж болох томоохон санхүүгийн эрсдэл нь доорх байдалтай байна.

### *31.1. Зах зээлийн эрсдэл*

Группийн санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болох хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаггүй байна.

### *31.2. Хөрвөх чадварын эрсдэл*

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь групп хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Группийн бодлого нь олон улсын стандартад нийцсэн төлбөрийн гарцыг (payment gateway) бүхий л төрийн болон хувийн байгууллагуудад үзүүлж орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Группийн хөрвөх чадварын эрсдэл ялангуяа мөнгөний эх үүсвэр, дансны авлагыг үнэлэх, удирдахад санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг авч үздэг. Группийн мөнгөний эх үүсвэр нь эргэлтийн мөнгөн урсгалын шаардлагаас бага байна

Группийн хөрвөх чадварын эрсдэл нь арилжааны банктай байгуулсан гэрээний дагуу арилжааны банктай тооцоо нийлж чададгүй, зарим арилжааны банканд QPAY системийн шууд холболт хийгээгүйгээс шалтгаалан арилжааны банканд өгөх өглөгийг тодорхой болгож чадахгүй байгаа нь ирээдүйд группийн дансны болон бусад өр төлбөрийг өсгөх эрсдэлтэй байна.

## 32. Бодит үнэ цэнийн хэмжилт

Групп нь бодит үнэ цэнийг ажиглан зэргээр нь 1-3 түвшинд хуваан бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд ашигладаг санхүүгийн хэрэглүүрийн шинжилгээг хийдэг. Эдгээр түвшин нь:

Түвшин 1: - Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан тодорхойлно;

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;

Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэний түвшинг ашигладаг.

### *32.1. Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэний хэмжилт*

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэний шатлалын түвшинг дараах хүснэгтээр харуулав:

| **2022 оны 12 сарын 31** | **Түвшин 1** | **Түвшин 2** | **Түвшин 3** | **Нийт** |
|---|---|---|---|---|
| **Үндсэн хөрөнгө:** | | | **694,476** | **694,476** |
| – Барилга | - | - | - | - |
| – Бусад хөрөнгө | - | - | 694,476 | 694,476 |
| **2021 оны 12 сарын 31** | **Түвшин 1** | **Түвшин 2** | **Түвшин 3** | **Нийт** |
| **Үндсэн хөрөнгө:** | | | **531,755** | **531,755** |
| – Барилга | - | - | - | - |
| – Бусад хөрөнгө | - | - | 531,755 | 531,755 |



00000061

Удирдлага нь тайлангийн өдөр болон худалдан авах өдрийн байдлаарх бодит үнэ цэнэд материаллаг өөрчлөлт гараагүй гэж үзсэн.

## 33. Капиталын удирдлагын бодлого, журам

Группийн капиталын удирдлагын бодлогын зорилго нь Групп цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадавхийг хангах юм

Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний холбогдох эрсдэлийн түвшинг үндэслэн тэдгээрийн үнийг оновчтой тогтоох замаар хувьцаа эзэмшигчдэд зохистой өгөөжийг хүртээх юм.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага группийн капиталын шаардлагыг үнэлнэ. Групп капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан тохируулга хийдэг.

Капиталын бүтцийг бий болгож, тохируулахын тулд групп хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашгийн дүнд залруулга хийж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг буцаах, шинээр хувьцаа гаргах, эвсэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулах зэрэг арга хэмжээ авна.

Группийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

| **Мянган төгрөгөөр** | **2022 оны 12 сарын 31** | **2021 оны 12 сарын 31** |
|---|---|---|
| Нийт эздийн өмч | 6,169,161 | 2,696,149 |
| Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1,853,360 | (2,123,419) |
| **Капитал** | **4,315,801** | **572,730** |
| | | |
| Нийт эздийн өмч | 6,169,161 | 2,696,149 |
| Нэмэх: Зээл | - | - |
| Нэмэх: Түрээсийн өр төлбөр | 102,044 | 136,757 |
| **Бүх санхүүжилт** | **6,271,205** | **2,832,906** |
| | | |
| **Капитал, санхүүжилтийн харьцаа** | **69%** | **20%** |

## 34. Тайлагналын үеийн дараах үйл явдал

Тайлагналын өдөр буюу 2022 оны 12 дугаар сарын 31 болон энэхүү тайланг баталгаажуулсан өдөр хоорондын хугацаанд ямар нэгэн залруулагдах эсвэл үл залруулагдах томоохон гүйлгээ гараагүй болно.

## 35. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

## 36. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2022 оны 12 дугаар сарын 31-нээрх (харьцуулагдах мэдээллийн хамт) дуусвар болсон санхүүгийн тайланг группийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр батлав.

| | | |
|---|---|---|
| У.Наранбаатар<br>ТУЗ-ийн дарга | Г.Эрдэнэмөнх<br>Гүйцэтгэх захирал | Я.Оюунханд<br>Ерөнхий нягтлан бодогч |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 1

INNOVATION INVESTMENT

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

# ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК

# INITIAL PUBLIC OFFERING (IPO)

## ХАРААТ БУС БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар Дүүрэг, 8-р Хороо
Сүхбаатарын талбай 20-6
Эрдэм товер, 1004 тоот
Утас: +976 7000 5000
Имэйл: gantulga@geregepartners.mn

Үнэлгээний өдөр
2022.12.31

Тайлангийн өдөр
2023.06.29

2023 11 08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

Инновэйшн Инвестмент ХХК -ийн Удирдлагад

Элчингийн гудамж, Шүрэн оффис, 6 тоот
Сүхбаатар Дүүрэг 1-р Хороо
Улаанбаатар, Монгол улс

2023 оны 6-р сарын 29-ны өдөр

Үнэлгээний үр дүнг хүргүүлэх тухай

Танай компанитай байгуулсан “Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу бид Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 44,795,662,890 (Дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерэн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ерэн) төгрөг байхаар тооцоолж үнэлгээний үр дүнг хүргүүлж байна.

Энэхүү үнэлгээний ажил нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход тус компанийн хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Бид өмнө нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн болно.

Үнэлгээний ажилтай холбоотой асуулт, тодруулга байвал бидэнтэй холбоо барихыг хүсье.

Хүндэтгэсэн,

Гэрэгэ Эстимэйт ХХК-г төлөөлж:

УЛААНБААТАР ХОТ
ГЭРЭГЭ-ЭСТИМЭЙТ ХХК

Д. Ганбаатар, MMY
Мэргэшсэн үнэлгээчин
Гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS
Мэргэшсэн үнэлгээчин
Үнэлгээ хариуцсан захирал

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

0000006

СЭХ
2023 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
АГУУЛГА 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023 -07- 20
БҮРТГЭВ-03


1. ЕРӨНХИЙ ТОЙМ ... 4
2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД ... 7
3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ ... 9
Макро эдийн засгийн төлөв байдал ... 9
4. ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН КОМПАНИЙН ТУХАЙ ... 14
ККТТ ХХК ... 14
Дижитал Мерчант Сервисэс ХХК ... 16
Инновэйшн Инвестмент ХХК ... 17
5. ҮНЭЛГЭЭ ... 19
Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ ... 19
Олон улсын компаниудын үнэлгээний харьцаанууд ... 19
Харьцуулсан үнэлгээ ... 22
Дотоодын компаниудын үнэлгээний харьцаа ... 23
Дүгнэлт ... 25
Хөрөнгөд суурилсан үнэлгээ ... 25
Охин компаниудын цэвэр хөрөнгийн үнэ цэнэ ... 26
Инновэйшн Инвестмент ХХК-ийн тусдаа компанийн хөрөнгө ... 27
Цэвэр хөрөнгө ... 28
Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ ... 28
Үнэлгээний үндсэн орц, төсөөллүүд ... 29
Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл ... 34
Үнэлгээний үр дүн ... 37
Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ ... 39
Мэдрэмжийн шинжилгээ ... 40
6. ХАВСРАЛТ ... 42


ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК


00000065

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1: ДНБ-ний өсөлт бууралт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр.....9
Зураг 2. ROE болон PB харьцааны регрессийн үр дүн.....24
Зураг 3: Монгол Улсын бэлэн бус гүйлгээний зах зээлийн төсөөлөл, мянган ширхэг, 2023-2027.....30
Зураг 4: Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний тооны төсөөлөл, мянган ширхэг, 2023-2027.....31


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл.....9
Хүснэгт 2: Технологийн сектор, софтвэйрийн салбарын үнэлгээний гол үржүүлэгчид.....11
Хүснэгт 3: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд, 2019-2022 он.....17
Хүснэгт 4: Нэгтгэсэн санхүүгийн үндсэн харьцаанууд, 2019-2022 он.....18
Хүснэгт 5: Олон улсын компаниудын үнэлгээний үндсэн харьцаанууд.....23
Хүснэгт 6: Дотоодын компаниудын үнэлгээний үндсэн харьцаанууд.....24
Хүснэгт 7. Үндсэн ба биет бус хөрөнгийн үнэлгээ.....26
Хүснэгт 8. Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ.....27
Хүснэгт 9. Өр төлбөр.....27
Хүснэгт 10. Инновэйшн Инвестмент ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ.....27
Хүснэгт 11. Инновэйшн Инвестмент ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ.....28
Хүснэгт 12: Зах зээлийн төсөөлөл, 2023 – 2027.....30
Хүснэгт 13: Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний төсөөлөл, 2023 – 2027.....31
Хүснэгт 14: Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөлөл, 2023 – 2027.....32
Хүснэгт 15: Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөлөл, 2022 – 2026.....34
Хүснэгт 16: Харьцуулсан баримжаа үнэлгээний үр дүн, сая төгрөг.....39


## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ДМС – | Дижитал Мерчант Сервисэс ХХК |
| ДНБ – | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| ИИ – | Инновэйшн Инвестмент ХХК |
| МХБ – | Монголын Хөрөнгийн Бирж |
| ОУВС – | Олон Улсын Валютын Сан |
| ҮОУС – | Үнэлгээний Олон Улсын Стандарт |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХХК
6183855
9021031195 CTC2420



00000066

## 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

| | |
|---|---|
| Тайлангийн өдөр | 2023 оны 6-р сарын 29-ны өдөр |
| Үйлчлүүлэгч | Инновэйшн Инвестмент ХХК. Тус компани болон түүний охин компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв. |
| Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис, 6 тоотод хаягт бүртгэлтэй Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100%-ийн бизнес өмчлөл |
| Үнэлгээний өдөр | 2022 оны 12-р сарын 31-ний өдөр |
| Үнэлгээний стандартын нийцэл | Үнэлгээний Олон Улсын Стандарт 2022 (ҮОУС 2022) |
| Тайлангийн зорилго / Үнэлгээний ажлын заавар | Инновэйшн Инвестмент ХХК Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тооцоолох |
| Ашигласан үнэ цэнийн суурь | Зах зээлийн үнэ цэнэ |
| Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэнэ | Үнэлгээний өдрийн байдлаарх бизнес өмчлөлийн нийт үнэ цэнэ 44,795,662,890 (Дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерэн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ерэн) төгрөг. |

Бидний үнэлгээ дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд:

- Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх зэрэг Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;
- Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;
- Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.

Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно.

| | |
|---|---|
| Өмнө нь хийж гүйцэтгэсэн бизнесийн үнэлгээний тухай | Бид өмнө нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн болно. |
| Таамаглал | <u>Тооцооны нэгж</u>: Инновэйшн Инвестмент ХХК нь охин компаниуд болох КСТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-иар дамжуулан QR кодонд суурилсан цахим |



00000067

төлбөрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагуудад орлого хүлээн авах, төлбөр шилжүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний өдрийн байдлаарх Инновэйшн Инвестмент ХХК-ийн засаглал, дотоод зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагааны бодит нөхцөл байдалтай уялдуулан Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэлгээг тус компанийн охин компаниудын үйл ажиллагааг нэгтгэсэн үзүүлэлтэд үндэслэн хийж гүйцэтгэв.

Хэдийгээр үнэлгээнд ирэх жилүүдийн төсөөллийн тооцооллыг охин компани бүрийн хувьд хийсэн боловч энэ нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн охин компаниудыг бие даасан байдлаар хийсэн үнэлгээ биш болохыг анхаарна уу.

Нэмэлт санхүүжилт: Инновэйшн Инвестмент ХХК нь МХБ дээр өөрийн энгийн хувьцааны 20%-тай тэнцэх үнийн дүн бүхий хувьцааг олон нийтэд санал болгож нэмэлт санхүүжилт татах ба үүнээс үндсэн үйл ажиллагааны тэлэлтэд 22.5%-ийг, дунд хугацааны төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалтад 30%-ийг, техник тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийн сайжруулалтад 7.5%-ийг, хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулахад 10%-ийг, ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөрт 25.0%-ийг тус тус зарцуулахаар төлөвлөж байна. Энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт татаж дээрх зориулалтаар ашиглагдах тохиолдолд хамаарах буюу Post-Money Valuation болно.

Тасралтгүй байдал: Инновэйшн Инвестмент ХХК болон охин компаниуд нь цаашид бизнесийн үйл ажиллагааг бизнес төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

| | |
|---|---|
| Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт | Бид Үйлчлүүлэгчийн бизнестэй танилцах, мэдээлэл авах уулзалтуудыг 2022 оны 1,2-р сар болон 2023 оны 6-р сард хийсэн бөгөөд холбогдох бусад мэдээллийг үнэлгээний ажлын явцад цахим шуудангаар авч үнэлгээнд ашиглав. |
| Стандартаас гажсан эсэх | Гажаагүй |
| Үнэлгээчид | Үнэлгээчид нь Үйлчлүүлэгчээс өгсөн даалгаврын дагуу энэ төрлийн бизнесийн үнэлгээг хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна.<br>- Үнэлгээчин Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институтын (RICS) гишүүн, бизнес болон биет бус хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн үнэлгээчин бөгөөд бизнесийн үнэлгээний ажлыг удирдаж, үнэлгээний тайланг бэлтгэсэн болно. |


00000068

СЗХ
2023 оны 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

- Үнэлгээчин Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал бөгөөд Хөрөнгөд суурилсан үнэлгээний хандлагын аргын багийн ахлагчаар ажиллав.
- Үнэлгээчин Л.Халиун нь АССА буюу олон улсын Мэргэшсэн нягтлан бодогч үнэлгээний ажлын Зах зээлийн хандлагын аргын багийн ахлагчаар ажиллав.

Үнэлгээчдийн сертификатын хуулбарыг Хавсралт 3-д үзүүлэв.

| | |
|---|---|
| Ашиг сонирхлын зөрчил | Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно. |
| Тайлангийн хэрэглэгчид / Нууцлал | Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно. |
| Тайлангийн хэрэглээ | Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.<br><br>Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн болон Үнэлгээчдийн нэрсийг дурдахыг хориглоно.<br><br>Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна. |
| Мэргэжлийн хариуцлагын даатгал | Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 26-р зүйлд заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан болно. |
| Бусад | Тайланг Монгол хэл дээр бэлтгэсэн бөгөөд нэмэлт материалыг үндсэн эхийн хуулбар байдлаар хавсралтад үзүүлэв. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР



00000069

## 2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

Үнэлгээний үр дүнг ашиглахаас өмнө үнэлгээнд ашигласан дараах үндсэн таамаглал болон өгөгдөлүүдтэй танилцахыг зөвлөж байна.

**Тооцооны нэгж:** Инновэйшн Инвестмент ХХК нь охин компаниуд болох ККТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-иар дамжуулан QR кодонд суурилсан цахим төлбөрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагуудад орлого хүлээн авах, төлбөр шилжүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Охин болон хараат компаниудад хувь эзэмшдэг толгой компани буюу холдинг компанийн үнэ цэнэ нь үндсэндээ охин болон хараат компаниудын үнэ цэнийн нийлбэр дүнд үндэслэн тогтдог. Инновэйшн Инвестмент ХХК нь ККТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшдэг бөгөөд нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай ажилладаг.

ККТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-иуд нь Төлөөлөн Удирдах Зөвлөлгүй, толгой компанийн шууд удирдлага дор ажиллаж байна. Инновэйшн Инвестмент ХХК-ийн бизнесийн энэхүү бодит нөхцөл байдалд үндэслэн орлогын хандлагын аргаар хийсэн бизнесийн үнэлгээг тус компанийн нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтэд үндэслэн хийсэн болно.

**Нэмэлт санхүүжилт:** Инновэйшн Инвестмент ХХК нь МХБ дээр өөрийн энгийн хувьцааны 20%-тай тэнцэх үнийн дүн бүхий хувьцааг олон нийтэд санал болгож нэмэлт санхүүжилт татах ба үүнээс үндсэн үйл ажиллагааны тэлэлтэд 22.5%-ийг, дунд хугацааны төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалтад 30%-ийг, техник тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийн сайжруулалтад 7.5%-ийг, хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулахад 10%-ийг, ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөрт 25.0%-ийг тус тус зарцуулахаар төлөвлөж байна. Энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт татаж дээрх зориулалтаар ашиглагдах тохиолдолд хамаарах буюу Post-Money Valuation болно.

Хэдийгээр ирэх жилүүдийн төсөөллийн тооцооллыг охин компани бүрийн хувьд хийсэн болович энэ нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн аль нэг охин компанийг бие даасан байдлаар хийсэн үнэлгээ биш болохыг анхаарна уу.

Дүгнэхэд, үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний өдрийн байдлаарх Инновэйшн Инвестмент ХХК-ийн засаглал, дотоод зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагааны бодит нөхцөл байдалтай уялдуулан Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэлгээг тус компанийн охин компаниудын үйл ажиллагааг нэгтгэсэн үзүүлэлтэд үндэслэн хийж гүйцэтгэв.

**Тасралтгүй байдал:** Инновэйшн Инвестмент ХХК нь цаашид бизнесийн үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

**Мэдээллийн найдвартай байдал:** Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Үйлчлүүлэгч компаниас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн болович өөрсдийн зүгээс аудитын шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

**Үнэлгээний үр дүнгийн найдвартай байдал:** Аливаа бизнесийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын найдвартай байдал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь тус компанийн ирээдүйн ашигт ажиллагааны талаарх худалдагч болон худалдан авагчийн төсөөлөл зөрөх, хүлээж байгаа эрсдэлийн түвшин ялгаатай байх зэргээс хамаарч бизнес өмчлөлийн үнэ цэнэ нь талуудад өөр өөр байх боломжтой юм.

Цаашилбал, бизнесийн өмчлөлийн үнэ цэнэ нь ирээдүйд болох үйл явдлуудаас, тухайлбал зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, инфляцын өөрчлөлт, макро эдийн засгийн үзүүлэлтүүд зэргээс хамаарч өөрчлөгддөг онцлогтой.

Үнэлгээний тайлангийн өдрийн байдлаар Орос Украйны дайн нь ирэх жилүүдэд дэлхийн эдийн засгийн төсөөлөлд ихээхэн хэмжээний тодорхойгүй байдлыг бий болгож байна. Энэ дайн нь дэлхийн эдийн засагт дараах үндсэн 3 сувгаар дамжин нөлөөлөх боломжтой. Үүнд Орос улсад тавьсан санхүүгийн хоригийн нөлөө, ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг орно.[1]

Хэдийгээр Инновэйшн Инвестмент ХХК болон түүний охин компаниудын үйл ажиллагаа нь дайны шууд нөлөөлөлд орох салбарт хамаарахгүй боловч нийт эдийн засгийн тодорхойгүй байдлаар дамжин дам нөлөөнд орох нь гарцаагүй.s

**Үнэлгээний аргачлал, орц, таамаглал:** Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, орц, таамаглалууд нь үнэлгээний өдрийн байдлаар үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

**Тайлангийн хэрэглээ:** Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараах, Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь үнэлгээний ажлын зориулалтаас өөр зориулалтаар олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна.

[1] https://www.eiu.com/n/global-economic-implications-of-the-russia-ukraine-war/

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

# 3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## Макро эдийн засгийн төлөв байдал

### Дотоодын эдийн засаг

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2015 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 6 жилийн хугацаанд өөрчлөлт багатай буюу ойролцоогоор 23-28 их наяд төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. ДНБ-ний бодит өсөлт 2018 онд 7.6%-д хүрч байсан болович Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд -4.4%-д хүртэл буурч, 2021 оноос эргэн сэргэж 1.4%, 2022 онд 4.8% өссөн байна.

ДНБ-ний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон дүн болон өсөлт, бууралтыг доор үзүүлэв.[2]

**Зураг 1: ДНБ-ний өсөлт бууралт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр**




Олон Улсын Валютын Сан (ОУВС)-аас Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг үнэлгээний өдрийн байдлаар дараах байдлаар төсөөлж байна.[3]

**Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн төсөөлөл**

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| ДНБ оны үнээр, тэрбум төг | 58,275.7 | 68,124.0 | 77,677.6 | 87,640.5 | 97,975.6 |
| ДНБ бодит өсөлт, % | 5.0% | 7.0% | 6.0% | 5.5% | 5.0% |
| Инфляци, % | 10.1% | 8.9% | 7.5% | 7.0% | 6.0% |
| Ажилгүйдлийн түвшин, % | 5.7% | 5.1% | 5.0% | 5.0% | 5.0% |
| Засгийн газрын өр, тэрбум төг | 45,754.1 | 51,300.5 | 58,241.6 | 66,326.3 | 74,852.6 |

[2] Үндэсний Статистикийн Хороо, www.1212.mn
[3] https://www.imf.org/en/Publications/WEO/weo-database/2022/October



00000072

2022 оны ДНБ-ний өсөлтийн бүрэлдэхүүнийг зарим салбараар авч үзвэл уул уурхай, олборлох салбар -11.9%-иар буурч, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 1.3%-иар өсөж, барилга 7.9%-иар, тээвэр агуулахын үйл ажиллагаа 3.0% тус тус өсжээ.[2]

Үнэлгээний өдрийн байдлаарх ОУВС-ийн судалгаагаар 2023 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 5.0%, 2024 онд 7.0% байх ба цаашид буурч 2027 он гэхэд 5.0% байхаар таамаглажээ.

ОУВС-гийн мэдээлснээр тайлангийн өдрийн байдлаар 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.42% гэж төсөөлж байсныг 2.8% болгон бууруулсан ба 2024 онд 3.0% болохоор таамаглаж байна. Учир нь 2020 онд КОВИД-19-ээс үүдэлтэй хямрал, 2009 онд дэлхийн санхүүгийн хямралаас үүдэн дэлхийн хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт 1 хувиас доош болж байсан бөгөөд 2023 онд Украинд үргэлжилж байгаа дайн сунжирснаас үүдэн санхүүгийн нөхцөл байдал муудаж, гео-эдийн засгийн хуваагдал үүсэж байгаатай холбоотой гэж үзжээ.[4]

Ойрын хугацаанд инфляцийн түвшин буурах төлөвтэй байгаа бөгөөд, хөгжингүй орнуудын хувьд дундаж инфляцийн түвшин 2023 онд 3.3%, хөгжиж буй орнуудын хувьд 8.1% байхаар байна.[4]

**Гадаад зах зээл**

2022 онд хөрөнгийн зах зээлийн хувьд хямралтай жил байсан бөгөөд S&P 500 нийт дүнгээрээ бараг 20%-иар буурчээ. Үүнээс Dow jones-ын технологийн салбарын индекс 35%-иас илүү буурсан үзүүлэлттэй гарсан байна. Мөн технологид төвлөрсөн индекс болох NASDAQ 33 гаруй хувиар унасан байна. Энэ нь 2022 он Орос, Украины хоорондох дайнаас үүдэн нефтийн үнэ, инфляци өсч, ажилчдын цалингийн өсөлт буурч, зээлийн хүү нэмэгдэж эдийн засгийн хямрал эхлэхээс олон нийт эмээж байсантай холбоотой. Эдгээр бүх хүчин зүйлүүд нь технолигийн салбарын хувьцааны үнийг буулгахад хүргэсэн. Мөн NASDAQ-ын үнэлгээ дөрвөн улирал буурсан анхны жил байлаа. Энэ нь 2008 оноос хойшхи технологийн салбарын хувьд гурав дахь хамгийн муу жил болж өнгөрчээ.[5]

Дэлхийн нийт хувьцааны зах зээлд эзлэх улс орнуудын хувийг авч үзвэл АНУ нийт зах зээлийн 58.4 хувийг, Ази тивийн 4 улс 13.1 хувийг, Европ тивийн 4 улс 11.5 хувийг, Канад улс 2.7 хувийг, Австрали улс 2.2 хувийг тус тус эзэлж байна. АНУ дангаараа нийт хувьцааны зах зээлийн 58.4 хувийг эзэлж байгаа нь зах зээлийн дундаж үржүүлэгч бусад улс орнуудыг бодвол илүү тогтвортой байх боломжтой.[6]

Технологийн салбар тэр дундаа үнэлгээнд хамрагдсан компанитай ижил төстэй технологийн софтвэйр, дэд бүтцийг хөгжүүлдэг технологийн компаниудыг судалж үзлээ. Софтвэйрийн салбар гэдэгт мэдээлэл технологийн үйлчилгээ, софтвэйр-аппликэйшн, софтвэйр-дэд бүтэц гэсэн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг багтаасан бөгөөд үнэлгээний үндсэн үржүүлэгчид болох PE, PS, PB, EV/EBITDA харьцааг доорх хүснэгтэд гол бүс нутгуудаар хувааж үзүүлэв.

4 https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2023/04/11/world-economic-outlook-april-2023
5 https://www.forbes.com/sites/qai/2023/01/19/why-were-tech-stocks-down-in-2022-and-how-long-will-the-slump-last/?sh=527f4dae7f16
6 https://www.statista.com/statistics/710680/global-stock-markets-by-country/



00000073

Хүснэгт 2: Технологийн сектор, софтвэйрийн салбарын үнэлгээний гол үржүүлэгчид

| Улс, тив | PE | PS | PB | EV/EBITDA |
|---|---|---|---|---|
| АНУ | 34.02 | 2.87 | 3.40 | (0.56) |
| Канад | | 2.63 | 3.07 | (2.78) |
| Их Британи/Ирланд | 29.95 | 2.60 | 2.75 | 10.27 |
| Европ | 22.33 | 1.76 | 2.71 | 7.40 |
| Ази | 22.33 | 2.70 | 2.94 | 8.93 |
| Энэтхэг | 27.47 | 2.74 | 2.07 | 9.60 |
| Далайн улсууд | | 2.24 | 2.78 | 4.24 |
| Латин Америк | 27.67 | 2.52 | 1.09 | 8.84 |
| Африк | 22.75 | 1.22 | 1.30 | 6.72 |

Үнэлгээнд хамрагдсан компани Инновэйшн Инвестмент ХХК болон түүний охин компаниуд нь софтвэйр-дэд бүтэц гэсэн салбарт багтаж байна. Ази тивийн хувьд PE, PS, PB харьцаанууд бусад улс орнуудаас харьцангуй бага байна. Дэлхийн нийт хувьцааны зах зээлийн 58.4 хувийг эзэлдэг АНУ-ын хувьд PE үржүүлэгч 34.02, PS үржүүлэгч 2.87, PB үржүүлэгч 3.4 байна.[7]

## Бэлэн бус гүйлгээний зах зээл

### Дэлхий болон бүс нутгийн зах зээл

Дэлхий даяар төлбөрийн шилжүүлэг бэлэн бус төлбөр тооцоонд шилжиж байна. 2013 – 2018 онд Хятад болон Ази, Номхон далайн (APAC) хөгжиж буй орнууд бэлэн бус гүйлгээний тоогоор хамгийн өндөр өсөлтийг үзүүлжээ. Энэ хугацаанд бэлэн бус гүйлгээний тоо 29 тэрбумаас 116 тэрбум болсон ба жилийн дундаж нийлмэл өсөлт (CAGR) 32.0% байсан байна.[8]

Цаашид, Хятад улс бэлэн бус гүйлгээний хувьд бусад бүс нутгуудаас илүү хурдацтай хөгжих төлөвтэй байна. Учир нь цахим худалдааны өсөлттэй холбоотойгоор хэрэглэгчид онлайн захиалганд илүү амархан дасан зохицож, бэлэн мөнгөнөөс бэлэн бус төлбөр тооцоо руу шилжих хүсэл эрмэлзэл нэмэгдэж байна. Нөгөөтэйгүүр томоохон технологийн компаниуд цахим төлбөрийн экосистемийг сайжруулж, бэлэн бус гүйлгээг дэмжих төрийн бодлого зэргээс шалтгаалан бэлэн бус төлбөрийн дэд бүтэц илүү боловсронгуй болж байна.

Хятад улсад бэлэн бус төлбөрийн зах зээлийн нийт гүйлгээний хэмжээ (сангийн шилжүүлгийг эс тооцвол) 2013 онд 67.5 их наяд юань байсан бол 2019 онд 279.2 их наяд юань болж, жилийн дундаж нийлмэл өсөлт (CAGR) 26.7%-д хүрсэн байна. 2023 онд Хятадын бэлэн бус төлбөрийн зах зээлийн нийт гүйлгээний хэмжээ 408.3 их наяд юань болж өсөх төлөвтэй байгаа нь CAGR 10.0%-д хүрч байгааг харуулж байна.[8]

### Дотоодын зах зээл

Монгол Улсын өрхийн сарын дундаж орлого, зарлага нэмэгдэж байгаа нь илүү боловсронгуй санхүүгийн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж байна. Мөн санхүүгийн үйлчилгээний зах зээлийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч байх төлөвтэй байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2022 онд Монгол Улсын өрхийн сарын дундаж орлого 1.86 сая төгрөг, харин сарын зарлага 1.83 сая төгрөг байна.

[7] https://www.gurufocus.com/industry_overview.php?industry=Software&region=USA
[8] PBOC, Payment and Clearing Association of China, China Union Pay, Oliver Wyman analysis



СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ 2023-07-21 БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
00000074

Өрхийн дундаж орлого




Өрхийн дундаж зарлага




### Хөдөлгөөнт интернет хэрэглэгчдийн тоо

Монгол улсын нийт хүн ам 3.5 сая, түүнээс 70.1% нь хот, суурин газар амьдарч байна. Үүрэн утас хэрэглэгчдийн тоо тогтмол өсч 2022 онд идэвхитэй үүрэн утас хэрэглэгчид давхардсан тоогоор 4.8 сая байна. Интернетийн хэрэглэгчдийн тоо мөн хурдацтай өсч 2022 онд 4.2 саяд хүрсэн байна. Үүрэн холбооны хөдөлгөөнт интернет хэрэглэгчдийн тоо нэмэгдэж 2022 онд 3.6 саяд хүрсэн байгаа нь Монгол улсад дижитал төлбөр тооцоо болон дижитал санхүүжилтийн өсөлтийг бий болгохын зэрэгцээ бизнесүүдийг дижитал болгох хэрэгцээг нэмэгдүүлж байна.

**Интернет хэрэглэгчдийн тоо** *(сая)*




**Хөдөлгөөнт интернет хэрэглэгчдийн тоо** *(сая)*




### Бэлэн бус гүйлгээний зах зээл

2018-2022 оны хооронд бэлэн бус гүйлгээний тоо 520 саяас 1.6 их наяд хүрч, үнийн дүн 159 их наяд төгрөгөөс 373.1 их наяд төгрөг хүрч өссөн үзүүлттэй байна.[9]

Төлбөрийн салбарт дижитал төлбөрийг илүү нэвтрүүлэх томоохон боломжийг бий болгодог олон хүчин зүйл байна. Үндсэндээ:

- Хэрэглэгчид: өдөр тутмын онлайн болон офлайн үйл ажиллагаандаа ашиглахад хялбар, хурдан, найдвартай төлбөрийн шийдлүүд байгаа эсэх,
- Бизнесүүд: төлбөрийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн аргын уян хатан байдал, хэрэглэгчийн таашаалд нийцсэн шийдэл байгаа эсэх зэрэг нь гоплох хүчин зүйл болдог байна.

[9] https://stat.mongolbank.mn

Гэсэн хэдий ч нийт гүйлгээний үнийн дүнгийн 20% буюу 30 их наяд төгрөгийг иргэд АТМ-ээс гарган өдөр тутмын худалдан авалт, үйлчилгээнд ашигласан хэвээр байгаа юм. АТМ-ээс бэлнээр гаргасан мөнгийг иргэд хэд хэдэн удаа үйлчилгээнд ашиглан дамжигдсаны эцэст буцаж банкинд ирдэг. Цаашид бэлэн мөнгөний хэрэглээ буурвал бэлэн бус гүйлгээний тоо мөнгөний үржигдэхүүний нөлөөгөөр өссөн дүнгээр нэмэгдэх боломжтой.

Хэрэглэгчдийн хувьд цаашид бэлэн бусаар төлөх дадал улам нэмэгдэж байгаа бөгөөд байгууллагууд түүнд нийцсэн шинэ үйлчилгээнүүдийг ихээр бий болгож зах зээл нилээд тэлэх төлөвтэй байна.

## 4. ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН КОМПАНИЙН ТУХАЙ

Инновэйшн Инвестмент ХХК нь ККТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-уудын бизнес өмчлөлийг 100% эзэмшдэг толгой компани болно.

### ККТТ ХХК

ККТТ ХХК нь цахим гүйлгээ, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, цахим хэтэвч хөгжүүлэх, бусад төлбөрийн зах зээлд шаардлагатай дэд бүтэц хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.

Банкны дэд бүтэц дээр суурилсан Монгол улсын бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэгч байгууллагуудын анхдагчдын нэг, цахим төлбөр тооцооны хамгийн том хувийг эзэлдэг QPay үйлчилгээг 2017 оноос нэвтрүүлэн ажиллаж байна.

**Хамтран ажиллагч байгууллагууд**

- Монгол банк болон арилжааны банкууд

Монголбанк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк, Чингис хаан банк, Ариг банк, Транс банк, Капитрон банк, Богд банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк гэсэн арилжааны банкууд QR код ашиглан төлбөр төлөх системд бүрэн холбогдсон. 2022 оны 9 дүгээр сард М Банк-тай QPay үйлчилгээний гэрээг байгуулан хамтран ажиллаж эхэлсэн. Мөн Голомт банктай хамтран ажиллах бэлтгэл ажлуудыг хийж байгаа ба 2023 онд багтаан олон нийтэд танилцуулах төлөвлөгөөтэй байна. Ингэснээр бүх арилжааны банкуудтай хамтран ажиллана.

- Хамтрагч финтек байгууллагууд

Финтек банк бус санхүүгийн байгууллагууд QR код ашиглан зээлийн эргэн төлөлтийг төлүүлэх, SMS нэхэмжлэх илгээх зэрэг үйлчилгээнүүдийг ашиглаж байна. Үүнээс гадна цахим мөнгөний зөвшөөрөлтэй дараах финтекүүд нь QR код уншуулан төлбөр тооцоонд хамтран оролцож байна. Мост Мони, Покет, Ард Кредит, МонПэй, Супер апп, Монгол чат зэрэг банк бус санхүүгийн байгууллагууд QPay төлбөр тооцоонд нэгдээд байна.

- Төрийн байгууллагууд

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа цахимжиж байгаатай холбоотой төрийн байгууллагуудын төлбөр тооцоог мөн QR код ашиглан шийдэж байна. И-Монголиа, яам тамгын газрууд, Улсын бүртгэлийн ерөнхий газар, цагдаагийн байгууллагууд, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагууд QR код ашиглан төлбөр тооцоогоо гүйцэтгүүлж байна.

- Худалдаа, үйлчилгээний байгууллагууд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид

Мобиком, Юнител, Скайтел, Жи Мобайл, Ондо зэрэг үүрэн телефоны оператор компаниуд, кабель телевиз, интернет нийлүүлэгч компаниуд, бүх даатгалын компаниуд, кино театр, супермаркетууд, Номин, И-март, BSB, Shoppy зэрэг онлайн дэлгүүрүүд QPay төлбөр тооцоо хийх боломжоор худалдан авагчдыг хангаж байна.

- QR код ашиглан данс хоорондын гүйлгээ хийх

Данс хоорондын гүйлгээг QR кодын тусламжтайгаар хялбаршуулж дансны дугаар, дансны нэр, гүйлгээний утга гэх мэт зүйлсийг гараас оруулахгүйгээр гүйцэтгэдгээрээ онцлог юм.

- Төлбөрийн нэхэмжлэхийг QR кодын тусламжтайгаар биелүүлэх

Мерчант буюу худалдагч тал төлбөрийн нэхэмжлэл үүсгэж, энэхүү дүнг худалдан авагч тал QR кодын тусламжтайгаар шилжүүлнэ. Төлбөр төлөгдсөн даруйд мерчантууд дансны хуулгаа шалгахгүйгээр төлбөр шууд төлөгдсөн гэдгийг тэр дор нь мэдэгдэх боломжтой болсон тул мерчант болон төлбөр төлөгч хоёр талд давуу байдал олгодог. Том онлайн дэлгүүр, Финтек аппликэйшн, гар утас, интернетийн оператор компаниуд зэрэг өдөр тутам маш олон гүйлгээ хийгддэг, их худалдан авагчтай мерчантууд QPay-ийг төлбөрийн системдээ нэвтрүүлснээр тэдний ажил хөнгөвчлөгдөж байна. Иймд, цаашид энэ төрлийн үйлчилгээг авах мерчантуудын тоо өснө гэж таамаглаж байна.

Шууд автоматжуулсан төлбөрийн баталгааг хийхийн тулд банкнаас дата авах зөвшөөрөл хэрэгтэй болдог бөгөөд, Монголд энэхүү зөвшөөрлийг Голомт банкнаас бусад банкуудаас авсан цорийн ганц компани нь ККТТ компани юм. Иймд, энэ зах зээлд түрүүлж байршсан гэдэг утгаараа цаашид ижил төстэй бизнесүүд гарч ирлээ гэхэд өрсөлдөөнд ялах магадлал өндөр гэж харж байна.

- Картны 3DS үйлчилгээнүүд

Олон улсын Unionpay, Visa, Mastercard гэх мэт компаниудын карт баталгажуулах системийн стандартыг ашиглан дараах үйлчилгээнүүдийг гаргаад байгаа билээ. Үүнд:

1. Картыг токенжуулан виртуал хувилбарт шилжүүлэх: Картын дугаар, CVV, картын хүчинтэй хугацаа зэрэг мэдээллийг токенжуулан дижитал хэлбэрт оруулж, энэ нь тогтмол давтамжтай төлбөр тооцоо хийхэд амар хялбар байдлыг үүсгэж өгдөг.
2. Олон улсад хамгийн олон карт гаргаж зах зээл дээр нийлүүлсэн Unionpay картын брэндтэй хамтран олон улсын харилцагчдад Монгол улс дахь төлбөр тооцоог QR кодын тусламжтайгаар шууд хийх боломжийг үүсгэж өгсөн. Мөн Unionpay карт ашиглан дэлхийн 30 гаруй улсын 20 сая гаруй худалдаа, үйлчилгээний байгууллагын QR төлбөр тооцоог шимтгэлгүй хийх боломжтой.

- Deeplink аргачлал ашиглан онлайн төлбөр тооцоог хялбарчлах

Энэ үйлчилгээ нь QPay-ийн линк үүсгэж QPay-ийн тусламжтайгаар шуурхай төлбөрөө хийх нөхцлийг бүрдүүлж өгдөг Deeplink технологийг ашигласан үйлчилгээ юм. Жишээ нь ямар нэгэн мерчант (Мобиком) руу онлайнаар төлбөр төлөх, нэгж худалдан авах зэрэг үйлчилгээ нь QPay-ийн Deeplink-ээр дамжин төлөгддөг гэсэн үг юм.

Мерчантуудын ККТТ-д төлдөг шимтгэлийн дүн нь олон улсын карт болох Visa, Mastercard болон төлбөр тооцооны дэлхийн том компани болох PayPal-ийн шимтгэлээс 3 орчим хувиар бага тул бага зардлаар төлбөр тооцоогоо гүйцэтгэх боломжийг мерчантуудад олгодог давуу талтай.


00000078

Deeplink-ийг мерчантууд ашиглах бас нэг давуу тал нь бүх банктай холболт хийсэн явдал юм. Мерчантууд 1 банктай холболт хийхэд ойролцоогоор 1.5 сая төгрөг төлдөг бол Deeplink-тэй холболт хийхэд үнэ төлбөргүй. Иймээс, мерчантууд Deeplink-тэй холболт хийх нь илүү зардал багатай тул энэ төлбөр тооцооны системийг сонгож байна.

- SMS нэхэмжлэхийн дагуу төлбөр төлөх

Төлбөрийн линк хэрэглэгчийн гар утсан дээр ирснээр хэрэглэгч төлбөрөө цаг тухайд нь шуурхай төлөх боломжтой.

- ЮнионПэй

Дэлхийн томоохон карт гаргагч банкнуудтай хамтрагч ЮнионПэй үйлчилгээний системтэй холболт хийж олон улсын ЮнионПэй аппликэйшн ашиглагч гадаад улсын иргэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын мерчант байгууллагуудад байршуулсан (static, dynamic) QR кодыг уншуулан олон улсын гүйлгээ хийх боломжийг хамтран нэвтрүүлсэн. Мөн Монгол Улсын банкнуудын гаргасан олон улсын ЮнионПэй карттай Монгол Улсын иргэд гадаад улсад ЮнионПэй стандартын QR кодыг уншуулан олон улсад гүйлгээ хийх боломжтой болсон.

- WeChat компанитай хамтран Хятад, Монголын хоорондох төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх

Хятад улсын төлбөр тооцооны том компаниудын нэг Wechat-тай хамтран Хятад, Монголын хоорондох бизнес, хувь хүмүүсийн төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэхээр гэрээ байгуулан, 2022 оны 05 сарын 06-ны өдөр зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Төлбөр тооцооноос гадна Монголын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах мини дэлгүүрүүдийг дижитал хэлбэрээр нээхээр хөгжүүлэлт хийгдэж байгаа болно.

## Дижитал Мерчант Сервисэс ХХК

Дижитал Мерчант Сервисэс ХХК нь мерчант байгууллагуудад чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлэн ажилладаг бөгөөд мерчант тус бүрийн шаардлага, нөхцөл байдалд нийцэх найдвартай, хялбар, хурдан шийдэл санал болгохыг эрхэмлэдэг. Харилцагчаа халамжлах үйлчилгээг тогтмол үзүүлж, оновчтой шийдвэр санал болгосноор Мерчантуудын бизнесийн өсөлтөд эергээр нөлөөлж ажилладаг.

Цаашид мерчантуудад зориулсан урамшуулал, лоялти систем хөгжүүлэхээр ажиллаж байна. Мөн мерчант байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх хэрэглээний хялбар, аюулгүй байдлын судалгаанд суурилсан бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилготой ажиллаж байна.

Түүнчлэн, QPay Мерчантуудад систем болон Харилцагчийн үйлчилгээний төв (Customer care center) үүсгэж Network Operation Center (NOC), System Operation Center (SOC)-ийн буюу систем болон сүлжээний асуудал хариуцсан 24/7 горимд ажиллах дуудлагын төвийн үйлчилгээг үзүүлж, Мерчантууд болон харилцагч байгууллагуудын асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж ажиллаж байна.



00000079

2023.11.08

## Инновэйшн Инвестмент ХХК

Инновэйшн Инвестмент ХХК нь өнөөг хүртэл ККТТ ХХК болон Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн зах зээлд байр сууриа эзлэх, түүнтэй холбоотой санхүүжилт, үйл ажиллагааны менежментэд зохистой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр ирсэн. Цаашид банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон Монгол банктай түншлэлийн хүрээнд хамтран ажиллах, группийн стратеги хэрэгжүүлэлтийг хангах, хянах үүрэгтэй ажиллах төлөвлөгөөтэй.

### Хүний нөөц

Группийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт 32 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 онд давхардсан тоогоор нийт 45 ажилтантай болохоор төлөвлөж байна.

Технологийн компани зах зээл дээр байрших, асуудалд шийдэл олох, бусдын бизнест үнэ цэнэ бий болгох, өрсөлдөгчдөөсөө түрүүлж алхахын хамгийн гол түлхүүр бол хүний нөөц байдаг. Компанийн үүсгэн байгуулагч Д.Даваа нь ШУТИС-ийн бакалавр зэрэгтэй, Цагдаагийн ерөнхий газрын технологийн хэлтсийн дарга, Инновэйшн Инвестмент ХХК-ийн захирлын албан тушаалыг хашиж байсан бөгөөд одоогоор Ай Си Ти Групп ХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажиллаж байна. Мөн үүсгэн байгуулагч Б.Чулуунсүх нь Япон улсын Акаши технологийн коллежид мэдээлэл холбооны чиглэлээр бакалавр, магистр зэрэг эзэмшсэн бөгөөд Японы томоохон компаниудын нэг болох NTT софтвэйр компанид инженерээр, Инновэйшн Инвесмент ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан туршлагатай.

Компанийн Технологи хариуцсан захирал Д.Жанчив нь компанийг үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид тогтвор суурьшилтай ажиллана гэдэгт компанийн удирдлагууд итгэлтэй байна. Компанийн гүйцэтгэх захирлаар Г.Эрдэнэмөнх, санхүү хариуцсан захирлаар Б.Энхболд нар тус тус ажиллаж байна.

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Групп компанийн 2019, 2020, 2021 болон 2022 оны жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан нэгтгэсэн санхүүгийн тайланд тойм шинжилгээ хийв.

Борлуулалтын цэвэр орлого 2019 онд 406 сая төгрөг, ерөнхий удирдлагын болон бусад зардал 1.1 тэрбум төгрөг байсан бол 2020 онд борлуулалтын цэвэр орлого 2 дахин өсч, зардал 2019 онтой ижил түвшинд байсан. 2020 оноос эхлэн компани өөрийн үйл ажиллагааны зардлыг борлуулалтын орлогоороо нөхөн ажиллах бүрэн боломжтой болсон. 2021 оноос эхлэн компани цэвэр ашигтай ажиллаж эхэлсэн ба 2021 онд 909.2 сая төгрөгийн 2022 онд 3,473.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Компани нь банк болон банк бус санхүүгийн байгууллагаас авсан ямар нэгэн зээлгүй.

**Хүснэгт 3: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд, 2019-2022 он**

| Санхүүгийн үзүүлэлт, сая төгрөг | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,821 | 1,411 | 2,123 | 1,853 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,028 | 1,754 | 2,732 | 5,699 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 297 | 300 | 502 | 1,057 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 48 | 245 | 397 | 481 |
| Өр төлбөрийн нийт дүн | 52 | 262 | 538 | 587 |

INNOVATION INVESTMENT LLC



0000080

СЭХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

| | | | | |
|---|---|---|---|---|
| Эздийн өмчийн дүн | 2,273 | 1,792 | 2,696 | 6,169 |
| Цэвэр борлуулалтын дүн | 406 | 859 | 2,478 | 6,342 |
| Нийт ашиг | 236 | 586 | 1,993 | 5,218 |
| Цэвэр ашиг | -790 | - 481 | 909 | 3,473 |

Санхүүгийн гол харьцаануудыг харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ өндөр тул хөрвөх чадварын үзүүлэлт сайн байна. Түүнчлэн, зээлээр үйл ажиллагаагаа санхүүжүүлээгүй тул өр төлбөр эздийн өмчийн харьцаа сайн байна. Нийт ашгийн маржин жил бүр өсөн нэмэгдэж байна. Цэвэр ашгийн маржин 2021 онд 36.7%, 2022 онд 54.8% байна. 2022 оны байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж 56.3% байгаа нь үнэлгээний өдрийн байдлаарх МХБ дээр хувьцаа нь идэвхитэй арилжаалагдаж байгаа компаниудын дундажаас 6.9 дахин өндөр үзүүлэлт юм.

**Хүснэгт 4: Нэгтгэсэн санхүүгийн үндсэн харьцаанууд, 2019-2022 он**

| Санхүүгийн харьцаанууд | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| Хөрвөх чадварын үзүүлэлт | | | | |
| Эргэлтийн харьцаа | 42.13 | 7.17 | 6.87 | 5.85 |
| Бэлэн мөнгөний харьцаа | 37.83 | 5.77 | 5.34 | 0.66 |
| Өр төлбөрийн харьцаа | | | | |
| Өр-Эздийн өмчийн харьцаа | 0.01 | 0.15 | 0.20 | 0.10 |
| Ашгийн харьцаа | | | | |
| Нийт ашгийн маржин | 58% | 68% | 80% | 82% |
| Цэвэр ашгийн маржин | -195% | -56% | 37% | 55% |
| Өгөөжийн үзүүлэлт | | | | |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | -34.8% | -26.8% | 33.7% | 56.3% |
| Нийт хөрөнгийн өгөөж | -34.0% | -23.4% | 28.1% | 51.4% |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК
00000081

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-31
БҮРТГЭВ-03

## 5. ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагыг авч үзэв.

ҮОУС-д заасан үнэлгээний мэргэжлийн нэр томъёо, тодорхойлолтыг Хавсралт 2-т үзүүлэв.

### Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээг Монгол улсын зах зээл болон олон улсын зах зээл гэсэн хоёр үндсэн бүлэгт авч үзлээ.

Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байхгүй тул бид хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг компаниудтай харьцуулах, мөн өөрийн хөрөнгийн өгөөжтэй нь харьцуулсан регрессийн шинжилгээ хийх зэргээр дүн шинжилгээ хийв.

Олон улсын зах зээл дээрээс Үйлчлүүлэгч компанитай аль болох ижил төстэй хялбар төлбөрийн шийдлийг эрэлхийлдэг компаниудыг сонгож авч шинжилгээнд хамруулав.

### Олон улсын компаниудын үнэлгээний харьцаанууд

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээнд хамрагдсан компаниудын тойм мэдээллийг доор үзүүлэв.

#### Yeahka

Yeahka компани нь Хятад улсад үйл ажиллагаа явуулдаг компани бөгөөд Qpay-ийн шийдэлтэй адил QR кодын тусламжтайгаар хэрэглэгчид болон мерчантуудад төлбөрийн хялбар шийдлийг олгодог. Хятад улс асар том эдийн засагтай, өдөр тутамд маш их гүйлгээ хийгддэг ч Монгол улсын төлбөрийн экосистем нь Хятад улсынхтай их төстэй байна. Монгол Улсын иргэн бүр халамжаа дансаар хүлээн авдагтай холбогдуулан хүүхэд төрсөн цагаасаа эхлэн өөрийн гэсэн данстай болдог бөгөөд үүнээс улбаалан данснаас данс руу шилжүүлэх дижитал олон үйлчилгээ хөгжсөн гэж үзэж болно.

Yeahka компани нь 2019 онд Хонг Конгийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжиж олон нийтийн компани болсон. Yeahka компани нь 2019 оны байдлаар гүйлгээний дүнгээр зах зээлийн 17.5 хувийг эзэлж байсан.[10]

Yeahka нь худалдаа эрхлэгчдэд олон төрлийн сувгаар төлбөр хүлээн авах боломжийг олгоход анхаарлаа хандуулж ажилладгаараа онцлог юм. Харин, WeChat Pay, Alipay, China UnionPay Merchant Services зэрэг төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг компаниуд нь зах зээлд томоохон байр суурь эзэлдэг хэдий ч нэгд, зөвхөн өөрсдийн цахим түрийвчнээсээ төлбөр хүлээн авдаг, хоёрт, голчлон өөрсдийн холбоотой банкны гүйлгээнд анхаарлаа төвлөрүүлэн ажилладгаараа Yeahka компаниас ялгаатай гэж үзэж болно.

[10] *Yeahka, Global Offering,* https://www1.hkexnews.hk/listedco/listconews/sehk/2020/0519/2020051901060.pdf

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК



00000082

Yeahka компанийн орлогын эх үүсвэр нь төлбөр тооцооны гүйцэтгэлээс авах шимтгэл бөгөөд шимтгэлийн хувь нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт дээр тулгуурладаг. Үйлчилгээний шимтгэл нь төлбөр хийхэд ашигласан картын төрөл, төлбөр тооцооны горим зэргээс хамаарч тодорхойлогддог.

Yeahka болон Qpay-ийн ижил төстэй тал нь зөвхөн нэг хамаарал бүхий банк болон худалдаа эрхлэгчийн төлбөр тооцоог гүйцэтгэхээсээ илүү олон тооны банк, худалдаа эрхлэгчдийг багтаасан QR төлбөрийн гүйлгээний системийг бий болгохыг зорьж байгаа явдал юм. QPay-ийн Yeahka-гаас ялгаатай нэг зүйл нь Qpay одоогоор зах зээлийн дийлэнхи хувийг эзэлж байгаа бол Yeahka нь зах зээлийн 17%-ийг эзэлж байна. Цаашид Yeahka нь төлбөрийн үйлчилгээгээр дамжуулан харилцагчийн хүрээгээ тэлэх, технологи дээр суурилсан бизнесийн үйлчилгээнүүдээ сайжруулж, өргөжүүлэх, дэд бүтэц, технологи, аналитик болон хиймэл оюун ухаанд үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийх, хүний нөөцдөө түлхүү анхаарч ажиллах гэсэн стратегитэй байна.

### Adyen N.V.

Adyen N.V. нь 2006 онд байгуулагдсан бөгөөд төв оффис нь Нидерландын Амстердам хотод байрладаг, дэлхий даяар 27 оффистой үйл ажиллагаагаа явуулж байна. Европ, Хойд Америк, Ази Номхон далай, Латин Америк болон бусад олон улсад төлбөрийн платформ ажиллуулдаг. Энэхүү платформ нь нэг цогц системийн тусламжтайгаар бизнес эрхлэгчдэд төлбөрөө хүлээж авах, төлбөр төлөх, орлогоо хамгаалах, санхүүгээ хянах боломжийг олгодгоороо давуу талтай. API (application programming interface) интерфэйсийн тусламжтайгаар онлайн төлбөр тооцоог гүйцэтгэх, дэлгүүр доторх ПОС машин дээр бүх төрлийн картаар, Wechat-аар төлбөр гүйцэтгэх боломжтой. Платформын үйлчилгээ нь төрөл бүрийн худалдаа эрхлэгчдийг Visa, Mastercard болон бусад төлбөрийн хэлбэрүүдтэй шууд холбож өгдөг.

Суурилуулалтын хураамж төлөхгүй, олон банкны данстай холбосон, платформ дахь бүх хэрэгсэлд хандах боломжтой, гүйлгээ тутмаас бага хэмжээний тогтмол хураамж болон төлбөрийн төрлөөс хамаараад гүйлгээний үнийн дүнгээс 1-12%-ийн шимтгэл авдаг.

### Global Payments

Тус компани нь 1967 онд байгуулагдсан бөгөөд төв оффис нь АНУ-ын Жоржиа мужийн Атланта хотод байрладаг. Дэлхийн 100 гаруй орны 3.5 сая үйлчлүүлэгчтэй, олон улс дахь и-коммерсийн төлбөрийн дэд бүтцийг бүрдүүлж, төлбөр тооцоог хялбарчлах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Одоогийн байдлаар 24,000 гаруй экспертүүд 80 орны, 16 төрөлх хэлээр ярьж хэрэглэгчдэд тусалдаг. Жижиглэн худалдаа эрхлэгчид, ресторан, эрүүл мэнд, санхүүгийн үйлчилгээ, боловсрол, тоглоом, ашгийн бус байгууллага, энтертэйнмэнт, шатахуун түгээх станц, эвент зэрэг салбаруудад үйлчилгээ үзүүлдэг. Онлайн болон мобайл төлбөр тооцоо, ПОС-оор төлбөр тооцоо хийх, нэгдсэн төлбөр тооцоо, мерчант портал, хүний нөөц болон цалинг үүлэн технологи ашиглан удирдах, бизнес зээл авах зэрэг зөвхөн төлбөр тооцооны үйлчилгээнээс гадна нэгдсэн тооцоо, онлайн тайлангийн үйлчилгээг санал болгодог.

### PayPal Holdings

PayPal Holdings, Inc нь 1998 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд төв нь Калифорни мужийн Сан Хосе хотод байрладаг. 2000 онд eBay онлайн худалдааны сайтын гол төлбөр тооцоо

гүйцэтгэгч болсноор хэрэглэгчдийн тоогоо 1 сая хүргэж чадсан байдаг. Насдак хөрөнгийн бирж дээр 2015 онд хувьцаагаа арилжиж олон нийтийн компани болсон бөгөөд улс хоорондын төлбөр тооцоог илүү бага зардлаар, илүү хялбар аргаар шилжүүлдэг технологийг нэвтрүүлсэн. Visa Inc компанитай хамтран ажиллах гэрээг 2016 онд байгуулснаар цаашид олон улсад төлбөрийн карт гаргасан, төлбөр тооцоо гүйцэтгэдэг 40-өөд том компаниудтай хамтран ажиллах гэрээг амжилттай байгуулж чадсан. 2018 оноос худалдаа эрхлэгчдэд зориулсан онлайн, мобайл, ПОС төлбөр тооцоо, эрсдэлийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээг үзүүлэх болсон. Одоогийн байдлаар 416 сая үйлчлүүлэгч, худалдаа эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлдэг, сүүлийн 12 сарын байдлаар нийт 1.2 триллион долларын гүйлгээ хийсэн, нэг минутанд 36,987 гүйлгээ хийгддэг, 27,000 ажилтантай.

Тус компанийн төлбөрийн платформ нь хэрэглэгчдэд төлбөр илгээх, хүлээн авах, банкны данс руугаа мөнгө татах, PayPal дансандаа янз бүрийн валютаар үлдэгдэл хадгалах боломжийг олгодог. Түүнчлэн, худалдаа эрхлэгчдэд кредит эсвэл дебит карт, мөн дижитал түрийвчээр онлайнаар төлбөр хүлээн авах боломжийг олгодог үйлчилгээг санал болгодог.

## Square, Block Inc

Тус компани нь өмнө нь Square, Inc гэсэн нэртэй байсан бөгөөд 2021 оны 12-р сард нэрээ Block, Inc. болгон өөрчилсөн. Block, Inc. нь 2009 онд байгуулагдсан бөгөөд төв оффис нь Калифорни мужийн Сан Франциско хотод байрладаг. АНУ, Канад, Япон, Австрали, Их Британи улсуудад үйлчилгээ явуулдаг.

Жижиглэн худалдаа эрхлэгчид, хоол болон ундааны зах зээл, гоо сайхан, эрүүл мэнд, засвар үйлчилгээ гэх мэт мэргэжлийн үйлчилгээнүүд, том бизнес эрхлэгчидтэй хамтран ажилладаг. Вебсайт, ПОС, сошиал медиа-гаар дамжуулан төлбөр тооцоо хийх, маркетинг, мессеж илгээх, лоялти хөтөлбөр хэрэгжүүлэх, зээлийн үйлчилгээ, хүний нөөцийн цагийн бүртгэл, цалингийн төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Мөн Cash app, Spiral, Tidal, TBD54566975 гэсэн крипто валют болон блокчейн технологид суурилсан төлбөр тооцооны бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж нийтэд санал болгож эхэлсэн. Cash app-ийн тусламжтайгаар хэн ч мөнгөө хувьцаа эсвэл Bitcoin-д хялбархан хувиргах, зарцуулах, хөрөнгө оруулах боломжтой. Спираль (өмнө нь Square Crypto) нь үнэгүй, нээлттэй эх үүсвэртэй Bitcoin төслүүдийг санхүүжүүлдэг бол TIDAL нь уран бүтээлчид, бизнес эрхлэгчдийг олонд таниулах, шүтэн бишрэгчидтэйгээ илүү гүнзгий холбогдоход нь тусладаг.

## StoneCo Ltd

Тус компани нь 2000 онд байгуулагдсан бөгөөд төв оффис нь Кэймэн арлын Жорж Таун хотод байрладаг, 3000 гаруй ажилтантай. StoneCo Ltd нь Бразил улсад үйл ажиллагаа явуулдаг. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан ПОС-ийн үйлчилгээ, жижиглэн худалдаа эрхлэгчдэд зориулсан онлайн төлбөр тооцооны үйлчилгээ, дижитал бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор худалдагч, худалдан авагчдыг холбосон нэгдсэн системийн үйлчилгээ, санхүүгийн менежментийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээнүүдийг технологийн шийдлээр дамжуулан хүргэдэг. Санхүүгийн менежментийн үйлчилгээ гэдэг нь бизнес эрхлэгчид StoneCo Ltd-ийн порталийг хэрэглэснээр борлуулалт, авлага гэх мэт санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар бүртгэх, шинжилгээ, дүгнэлт хийх боломжтой болдог. Төрөл бүрийн брэндүүдтэй хамтарч ажилласнаар борлуулалтаа өсгөх боломжийг мөн нэг үйлчилгээгээрээ дамжуулан хүргэдэг. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар тус компани нь 652,600 орчим үйлчлүүлэгчдэд үйлчилсэн ба дэлхийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, дижитал зах зээл,

нэгдсэн програм хангамж үйлдвэрлэгч зэрэг 260 нэгдсэн түншүүдтэй хамтарч ажилласан байна.

### Tyro Payments

Tyro Payments Limited нь 2003 онд байгуулагдсан бөгөөд Австралийн Сидней хотод байрладаг. Тус компани нь бизнес эрхлэгчдэд төлбөр тооцоо, бизнесийн зээл болон бусад банкны бүтээгдэхүүнүүдийг санал болгон ажилладаг. Австрали улсдаа ETFPOS үйлчилгээг үзүүлдэг тав дахь том нийлүүлэгч, 480 ажилтантай, 2020 онд 20.1 тэрбум долларын гүйлгээг хийж гүйцэтгэсэн, 2015 оноос 2020 оны хооронд гүйлгээний хэмжээ CAGR 24% өссөн байна. Өнөөг хүртэл 58,000 бизнес эрхлэгчдэд бизнесийн зээл олгосон байна. Австралийн хөрөнгийн бирж дээр 2019 онд IPO хийсэн бөгөөд зах зээлийн үнэлгээгээрээ хамгийн өндөр IPO-г хийсэн компани болсон юм. Alipay-тэй хамтарч нэгдсэн төлбөр тооцооны шийдлийг Австрали улсад 2019 онд нэвтрүүлсэн бөгөөд анхдагч нь болсон. Түүнчлэн, гар утасны төлбөрийн хэрэгсэл болох Tyro Go аппликэйшн, аюулгүй байдал, залилан мэхлэлтээс хамгаалах Tyro Connect гэдэг платформийг нэвтрүүлсэн.

### Worldline SA

Тус компани нь өмнө нь Atos Worldline S.A.S. гэдэг нэртэй байсан бөгөөд 2014 оны 4-р сард нэрээ Worldline SA болгон өөрчилсөн. Worldline SA нь 1973 онд байгуулагдсан бөгөөд төв оффис нь Франц улсын Безонс хотод байрладаг. Worldline SA нь Европ, Америк, Ази Номхон далайн орнуудын санхүүгийн байгууллага, худалдаа эрхлэгчид, корпорациуд болон засгийн газрын агентлагуудад цахим төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. Дэлхийн 50 гаруй улсад үйлчилгээгээ үзүүлдэг, 1 сая гаруй мерчантуудтай хамтарч ажилладаг, 1000 гаруй банк, финтек, төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг компаниудыг системдээ багтаасан, 1200 гаруй санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажилладаг компани юм.

Тус компани нь мерчантад зориулсан үйлчилгээ, терминал шийдэл, санхүүгийн үйлчилгээ болон мобайл болон онлайн шилжүүлэг зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлдэг. Мерчант үйлчилгээний сегмент нь худалдан авалт, терминал, бүх сувгаар төлбөр хүлээн авах, хувийн шошготой, лоялти карт гаргах, дижитал жижиглэнгийн худалдаа зэрэг үйлчилгээг санал болгодог. Санхүүгийн үйлчилгээний сегмент нь боловсруулах, хүлээн авах, дижитал болон мобайл банк, дансны төлбөр, захиалгын удирдлага, санхүүгийн мэдээллийн үйлчилгээ, залилангийн эрсдэлийн удирдлага, ATM менежмент, итгэмжлэгдсэн баталгаажуулалт, төлбөрийн програм хангамжийн шийдлүүдийг хүргэж үйлчилдэг.

### Харьцуулсан үнэлгээ

Харьцуулсан компаниудын санхүүгийн үндсэн харьцаануудыг хамгийн сүүлийн үеийн боломжит санхүүгийн мэдээлэлд тулгуурлан тооцоолов.[11]

| Санхүүгийн харьцаанууд | Yeahka | Adyen N.V | Global Payments | PayPal | Block | StoneCo | Tyro | Worldline |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өр төлбөрийн харьцаа | | | | | | | | |
| Өр-Өмчийн харьцаа | 1.66 | 2.16 | 1.00 | 2.88 | 0.82 | 2.26 | 1.57 | 1.07 |
| Ашгийн харьцаа | | | | | | | | |
| Нийт ашгийн маржин | 30.2% | 14.9% | 57.9% | 50.1% | 34.2% | 70.4% | 47.3% | 55.6% |

[11] https://finance.yahoo.com/quote/WLN.PA/balance-sheet?p=WLN.PA

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашгийн маржин | 4.5% | 6.3% | 1.2% | 8.8% | -3.1% | -5.8% | -9.1% | 6.9% |

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн харьцаагаар Adyen, PayPal, StoneCo зэрэг компаниуд өндөр байгаа нь мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаатай холбоотой. Харин Global Payments, Yeahka, Worldline зэрэг компаниудын харьцаа бага байгаа нь эдгээр компаниудын төлбөр тооцооны үйл ажиллагаа давамгайлдагтай холбоотой. Үйлчлүүлэгч компанийн хувьд энэ харьцаа 0.1 байна.

Нийт ашгийн маржингийн үзүүлэлтээр StoneCo компани бусдаас харьцангуй өндөр байгаа бол PayPal компанийн цэвэр ашгийн маржин 8.8% болж харьцуулалтад буй компаниуд дотроо 2022 онд хамгийн үр ашигтай ажиллажээ. Харьцуулсан компаниудын дундаж нийт ашгийн маржин 47.4%, цэвэр ашгийн маржин 6.4%, харин үнэлж буй компанийн маржин харгалзан 82% ба 54% байгаа нь харьцуулсан компаниудын дундажаас өндөр байна.

Харьцуулсан компаниудын үнэлгээний үндсэн харьцаануудыг 2022 оны эцсийн байдлаар тооцоолж доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 5: Олон улсын компаниудын үнэлгээний үндсэн харьцаанууд**

| Компаниуд | P/E | P/S | P/B |
|---|---|---|---|
| Yeahka | 48.34 | 2.83 | 3.48 |
| Adyen N.V. | 70.77 | 4.47 | 16.55 |
| Global Payments | 234.36 | 2.91 | 1.16 |
| PayPal Holdings | 38.81 | 3.41 | 4.63 |
| Square, Block Inc | | 2.15 | 2.19 |
| StoneCo Ltd | | 0.33 | 0.23 |
| Tyro Payments | | 2.25 | 4.59 |
| Worldline SA | 34.40 | 2.36 | 0.98 |
| Хамгийн бага | -69.73 | 0.33 | 0.23 |
| Хамгийн их | 234.36 | 4.47 | 16.55 |
| **Дундаж** | 40.82 | **2.59** | **4.23** |
| Медиан | 36.61 | 2.60 | 2.81 |

Харьцуулж буй компаниуд нь Хонг-Конг, Австрали, Нью-Йорк, Насдак зэрэг хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байна. Эдгээр компаниудын дундаж PE үржүүлэгч 40.82, дундаж PS үржүүлэгч 2.59, дундаж PB үржүүлэгч 4.23 тус тус гарч байна.

## Дотоодын компаниудын үнэлгээний харьцаа

Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж буй ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байхгүй тул бид эхлээд хувьцаа нь харьцангуй идэвхтэй арилжаалагддаг компаниудыг сонгож дүн шинжилгээ хийв. Ингэснээр дотоодын хөрөнгийн зах үнэлгээний өдрийн байдлаар компанийн үнэлгээг хэрхэн тогтоож байгаа талаарх баримжаа, хөрөнгө оруулагчдын хүлээлтийг олж тогтоохыг зорьсон болно.

2022 онд МХБ дээр арилжаалагдсан хувьцааны ширхэг болон үнийн дүнгээрээ идэвхтэй ажилласан I болон II ангиллын 30 орчим компаниас АПУ ХК, ЛэндМН ББСБ ХК, Мандал



СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
00000086

даатгал ХК, Түмэн шувуут ХК, Монос хүнс ХК, Ард Кредит ББСБ ХК, Инвескор ББСБ ХК зэрэг 7 компанийг сонгон шинжилсэн болно.

**Хүснэгт 6: Дотоодын компаниудын үнэлгээний үндсэн харьцаанууд**

| Компаниуд | ROE | P/E | P/S | P/B |
|---|---|---|---|---|
| АПУ | 19.7% | 12.71 | 1.89 | 2.51 |
| ЛэндМн ББСБ | 22.8% | 4.47 | 1.22 | 1.02 |
| Мандал даатгал | 13.9% | 12.98 | 0.75 | 1.81 |
| Түмэн шувуут | 19.4% | 9.79 | 1.53 | 1.90 |
| Монос хүнс | 18.4% | 16.00 | 1.81 | 2.95 |
| Ард кредит ББСБ | 11.6% | 17.11 | 3.18 | 1.99 |
| Инвескор ББСБ | 27.3% | 11.27 | 4.68 | 3.08 |
| Хамгийн бага | 11.6% | 4.47 | 0.75 | 1.02 |
| Хамгийн их | 27.3% | 17.11 | 4.68 | 3.08 |
| **Дундаж** | **19.0%** | **12.05** | **2.15** | **2.18** |
| Медиан | 19.4% | 12.71 | 1.81 | 1.99 |

Сонгогдсон компаниудын дундаж PE харьцаа 12.05, дундаж PS харьцаа 2.15, дундаж PB харьцаа 2.18 байна. Эдгээр компаниудын өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт өөр байгаа тул харьцуулсан үнэлгээнд шууд ашиглах нь тохиромжгүй юм.

Учир нь ***Хүснэгт 4: Нэгтгэсэн санхүүгийн үндсэн харьцаанууд, 2019-2022 он***-д үзүүлсний дагуу Инновэйшн Инвестмент ХХК-ийн ROE харьцаа 2022 онд 56.3%-тай байсан бол харьцуулсан компанийн ROE үзүүлэлт 11.6% - 27.3% хооронд байна. Иймд ROE болон PB харьцаануудын хоорондын хамаарлын регрессийн шинжилгээ хийж үнэлгээнд ашиглав.

**ROE ба PB харьцааны регрессийн шинжилгээ**

Түүврийг сонгохдоо МХБ-ийн I болон II ангиллын нийт 63 компаниас мэдээлэл нь бүрэн 36 компанийг сонгож, 2022 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээс ROE болон PB харьцаануудыг тооцоолж регрессийн шинжилгээнд хэрэглэв. Өгөгдөлд завсарын квартилыг (interquartile range) ашиглан тухайн түүврээс ихээхэн ялгаатай өгөгдөл (outlier) хасах замаар цэвэрлэгээ хийсэн болно.

**Зураг 2. ROE болон PB харьцааны регрессийн үр дүн**



Регрессийн шинжилгээгээр ROE болон PB харьцаанууд хоорондоо эерэг хамаарлыг үзүүлж, ROE-ийн коэффициент нь 4.2 байгаа нь ROE нэг хувиар өсөхөд PB харьцаа 0.67 нэгжээр өсөх дундаж тооцоолол гарсан. Стандарт алдаа 0.075 байгаа нь тухайн загварт нийцэл сайн байгааг харуулна. Вариац шинжилгээ (ANOVA)-г доор үзүүлэв.

| *Soucre of variance* | *Degree of freedom (df)* | *Sum of Squares (SS)* | *Mean Square (MS)* | *F-statistic* | *Significance F* |
|---|---|---|---|---|---|
| Regression | 1 | 0,075051532 | 0,075051532 | 13,93544457 | 0,000691015 |
| Residual | 34 | 0,183112357 | 0,005385658 | | |
| Total | 35 | 0,258163889 | | | |

Регрессийн ач холбогдлын түвшин (significance level) 0.05-аас бага, p-0,00069 утгатай F-статистик нь 13.93 байна. Үүнээс бид тэг (null) таамаглалыг үгүйсгэж, ROE болон PB хооронд мэдэгдэхүйц шугаман хамаарал байна гэж дүгнэж болно.

Регрессийн тэгшитгэл нь: *P/B харьцаа = 0.6715 + 4.2364 * ROE*

Инновэйшн Инвестмент ХХК-ийн 2022 оны эцсийн байдлаарх ROE харьцаа 56.3% байгаа нь PB үржүүлэгч 3.06 байх үр дүнг өгч байна.

R квадрат 0.29 утга нь загвар өгөгдөлд хангалттай нийцэж байгааг харуулж байгаа боловч PB харьцааны өөрчлөлтийг тайлбарлах бусад хүчин зүйлүүд байж болохыг үгүйсгэхгүй болно.

## Дүгнэлт

Үнэлж буй болон харьцуулж буй компаниудын үйл ажиллагаа, санхүүгийн байдал өөр тул зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан гаргасан үнэ цэнээр бизнесийн үнэ цэнийг тогтооход учир дутагдалтай. Зах зээлийн харьцуулалтын аргын үндсэн зорилго нь тухайн компани МХБ дээр нийтэд нээлттэй болсны дараах үеийн хөрөнгө оруулагчдын хүлээлт, хандлагыг баримжаалан тооцоолоход оршино. Иймд зах зээлийн харьцуулалтын аргыг компанийн үнэлгээний дээд, доод хязгаарыг тодорхойлоход түлхүү ашиглав.

## Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Инновэйшн Инвестмент ХХК-ийн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно.

Холдинг компанийн онцлогоос хамаарч Инновэйшн Инвестмент ХХК тусдаа компанийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав.

Үнэлгээнд хамрагдсан компаниудын хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хувааж үнэлэв. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгө:
   - Үндсэн хөрөнгө


ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20
00000088
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC

- Биет бус хөрөнгө

2. Эргэлтийн хөрөнгө:
   - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
   - Авлага
   - Бараа материал
   - Урьдчилж төлсөн зардал
3. Өр төлбөр:
   - Дансны өглөг болон бусад өглөг
   - Урьдчилж орсон орлого

2022 оны эцсийн байдлаар Инновэйшн Инвестмент ХХК-ийн охин компаниуд болон группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Грант Торнтон компани аудитын дүгнэлт хийсэн байна. Инновэйшн Инвестмент ХХК болон түүний охин компанийн хөрөнгүүд нь санхүүгийн тайланд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад тодорхойлсон *"Бодит үнэ цэнэ"*-ээр туссан болохыг аудитын дүгнэлтээр баталгаажуулжээ.

Тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ҮОУС 2020-ийн *Зах зээлийн үнэ цэнэ* нь СТОУС 13-д тодорхойлсон *"Бодит үнэ цэнэ"*-ийн шаардлагыг хангана гэж үздэг.

Үнэлгээчдийн хийсэн шинжилгээний үр дүнд Инновэйшн Инвестмент ХХК болон түүний охин компанийн санхүүгийн тайланд туссан хөрөнгүүдийн бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнэ цэнээс материаллаг зөрүү багатай гэж дүгнэсэн болно. Иймд энэхүү үнэлгээний ажлын зорилготой уялдуулан Инновэйшн Инвестмент ХХК-ийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг санхүүгийн тайланд туссан дүнгээр авч цэвэр хөрөнгийн дүнг тооцоолоход ашиглав.

### Охин компаниудын цэвэр хөрөнгийн үнэ цэнэ

Инновэйшн Инвестмент ХХК-ийн охин компаниуд болох ККТТ ХХК, Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн үндсэн болон биет бус хөрөнгийн үнэлгээний өдрийн байдлаарх үнэлгээг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 7. Үндсэн ба биет бус хөрөнгийн үнэлгээ**

| Компаниуд | Дүн, төгрөгөөр |
|---|---:|
| ККТТ ХХК | 833,124,454 |
| ДМС ХХК | 128,824,953 |
| **Нийт** | **961,949,407** |

Инновэйшн Инвестмент ХХК-ийн охин компаниудын үндсэн ба биет бус хөрөнгүүдийн нийт үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 961,949,407 төгрөгөөр тооцоолов.

Бусад эргэлтийн бус хөрөнгөд санхүүгийн хөрөнгүүд, хойшлогдсон татварын хөрөнгө зэрэг хөрөнгүүд багтана. 2022 оны эцсийн аудитын тайланд орсон дүнгээр тус компаниудын бусад эргэлтийн бус хөрөнгө байхгүй буюу тэг дүнтэй байна.

2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх аудитлагдсан санхүүгийн тайланд тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 4,212,126,020 төгрөг байхаар туссан байна.

**Хүснэгт 8. Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ**

| Компаниуд | Дүн, төгрөгөөр |
|---|---|
| ККТТ ХХК | 3,317,689,967 |
| ДМС ХХК | 894,436,053 |
| **Нийт** | **4,212,126,020** |

Инновэйшн Инвестмент ХХК-ийн охин компаниудын нийт өр төлбөр 569,442,872 төгрөг байна.

**Хүснэгт 9. Өр төлбөр**

| Компаниуд | Дүн, төгрөгөөр |
|---|---|
| ККТТ ХХК | 456,179,466 |
| ДМС ХХК | 113,263,407 |
| **Нийт** | **569,442,872** |

## Инновэйшн Инвестмент ХХК-ийн тусдаа компанийн хөрөнгө

Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав. Цэвэр хөрөнгийн үнэлгээнд тус компанийн тусдаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг ашигласан ба хөрөнгө болон өр төлбөрийн дүнгээс охин компаниудтай холбоотой ажил гүйлгээг хасаж цэвэрлэн цэвэр хөрөнгө болон өр төлбөрийн дүнг тодорхойлов.

**Хүснэгт 10. Инновэйшн Инвестмент ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ**

| Үзүүлэлт | Дүн | Холбоотой талуудын гүйлгээ | Цэвэр дүн |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 422,033,090 | | 422,033,090 |
| Бусад авлага | 158,387,326 | | 158,387,326 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 912,452,908 | | 912,452,908 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,492,873,324 | | 1,492,873,324 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө | 80,177,073 | | 80,177,073 |
| Биет бус хөрөнгө | 14,460,466 | | 14,460,466 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 11,000,000 | 11,000,000 | - |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 105,637,539 | | 94,637,539 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,598,510,864 | | 1,587,510,864 |
| ӨР ТӨЛБӨР | | | |
| Богино хугацаат өр төлбөр | | | |

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ 2023-07-20

| | | |
|---|---|---|
| Дансны өглөг | 13,400,000 | 13,400,000 |
| Цалингийн өглөг | 4,398,195 | 4,398,195 |
| Татварын өр | 517,016 | 517,016 |
| НДШ-ийн өглөг | 52,500 | 52,500 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 18,367,711 | 18,367,711 |
| Урт хугацаат өр төлбөр | | - |
| Хойшлогдсон татварын өр | 4,614,664 | 4,614,664 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 4,614,664 | 4,614,664 |
| Өр төлбөрийн нийт дүн | 22,982,376 | 22,982,376 |
| Эздийн өмч | | |
| Хувийн өмч | 3,501,000,000 | |
| Хуримтлагдсан ашиг | (1,925,471,512) | |
| **Эздийн өмчийн дүн** | **1,575,528,488** | **1,564,528,488** |

Инновэйшн Инвестмент ХХК (тусдаа)-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 1,564,528,488 төгрөг байхаар тооцоолов.

### Цэвэр хөрөнгө

Хөрөнгөд суурилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолов.

**Хүснэгт 11. Инновэйшн Инвестмент ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ**

| Компаниуд | Дүн, төгрөгөөр |
|---|---|
| ККТТ ХХК | 3,694,634,955 |
| ДМС ХХК | 909,997,600 |
| ИИ ХХК, тусдаа | 1,564,528,488 |
| **Нийт** | **6,169,161,043** |

Дээрх тооцооллоор Инновэйшн Инвестмент ХХК-ийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 6,169,161,043 төгрөг болж байна. Энэ аргаар Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлоход учир дутагдалуудтай. Учир нь тооцоололд тус компанийн ирээдүйн орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гоодвилл, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүйтэй холбоотой.

### Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ

Инновэйшн Инвестмент ХХК нь группийн хэмжээнд 2021 онд 909.2 сая төгрөгийн, 2022 онд 3,473.0 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity)-ний загварыг ашиглав.

Энэ арга нь өмчийн эздэд хамаарах ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр бизнес өмчлөлийн үнэ цэнийг илэрхийлдэг.

Энэхүү аргаар үнэлгээг тооцоолоход дараах 2 хүчин зүйлээс хамаарч бизнесийн үнэ цэнэ хэр зэрэг үнэн бодитой гарах эсэх нь шалтгаална. Үүнд:

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ


00000031

СЭХ
2023 . 11 . 08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

- Ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл болон төсөөлж буй хугацааны эцэст үлдэх өртөг буюу Терминал үнэ цэнэ,
- Хорогдуулалтын хувийг оновчтой сонгох зэрэг орно.

Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүд болон үндсэн тооцооллыг доор тайлбарлав.

### Үнэлгээний үндсэн орц, төсөөллүүд

#### Бэлэн бус гүйлгээний зах зээлийн ирээдүйн төсөөлөл

Бэлэн бус гүйлгээний зах зээлд интернет банк, мобайл банк, картын гүйлгээг хамруулж үзэв.

Дэлхийн дижитал банкны зах зээл 2019 онд 3.95 тэрбум ам.доллараар үнэлэгдэж байсан ба 2020 – 2027 онд жилд дундажаар (CAGR) 13.6% өсөж 2027 он гэхэд 10.87 тэрбум ам.долларт хүрэхээр, харин Ази Номхон Далайн улсуудын хувьд 2027 он хүртэл хамгийн өндөр өсөлттэй буюу жилийн дундаж өсөлт (CAGR) 15.4% буюу дэлхийн дундажаас 1.13 дахин өндөр өсөхөөр төсөөлж байна.[12]

2023 - 2027 оны хооронд дэлхийн дижитал банкны нийт гүйлгээ жилд дундажаар (CAGR) 11.80% өсөхөөр төсөөлж байна.[13] Дээрх харьцааг ашиглан тооцвол Ази Номхон Далайн улсуудын хувьд 2023 - 2027 онд жилийн дундаж өсөлт 13.4% байна гэж үзэж болно.

Монгол Улсын интернет болон мобайл банкны нийт гүйлгээний дүн 2018 оноос 2022 оны хооронд жилд дундажаар (CAGR) 28.0%, 2022 онд 58.6% өсөж 321.8 их наяд төгрөг болжээ. 2022 онд интернет болон мобайл банкны гүйлгээний нийт тоо 845.4 сая ширхэг, нэгж гүйлгээний дундаж дүн 380.7 мянган төгрөг байсан.[14]

Энэхүү өсөлт ирэх 5 жилд дундажаар бүс нутгийн буюу Ази Номхон Далайн улсуудын дундажтай ижил байна, өөрөөр хэлбэл ам.доллараар 13.4% буюу төгрөгөөр 19.3%-иар өснө, ингэхдээ 2022 оны өндөр өсөлт аажмаар жигд буурч 2027 онд тогтворжиж нийт эдийн засгийн өсөлт буюу нэрлэсэн ДНБ-ний өсөлтийн төсөөлөл болох 11.8%-тай ижил болно гэж Үнэлгээчид төсөөлөв.

2022 онд Монгол Улсад картын нийт 713.7 сая ширхэг гүйлгээгээр 51.3 их наяд төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна. Картын гүйлгээний дүн 2021 онд 15.6%, 2022 онд 19.2% тус тус өссөн байна.[9] Картын гүйлгээний дүн 2023 онд өмнөх 2 жилийн дундаж буюу 17.4%-иар өсөх, цаашид өсөлт жигд буурч 2027 онд ДНБ-ний өсөлттэй ижил буюу 11.8%-д очихоор төсөөлөв.

Бэлэн бус гүйлгээний нэгж гүйлгээний ирээдүйн дүнг 2022 оны дундаж нэгж гүйлгээний дүнг Монгол Улсын ирээдүйн инфляцийн төсөөллөөр нэмэгдүүлж авсан ба гүйлгээний тоог нийт гүйлгээний дүнг нэгж гүйлгээний дүнд харьцуулах замаар төсөөлөв.

Картын гүйлгээний өсөлтийг интернет болон мобайл банкны өсөлттэй ижил байхаар төсөөлөв. Төсөөллийн үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

12 https://www.alliedmarketresearch.com/digital-banking-platforms-market
13 https://www.statista.com/outlook/dmo/fintech/digital-payments/worldwide
14 https://stat.mongolbank.mn

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

**Хүснэгт 12: Зах зээлийн төсөөлөл, 2023 – 2027**

[1]Төсөөлөл

| Үзүүлэлтүүд | 2022 | 2023[1] | 2024[1] | 2025[1] | 2026[1] | 2027[1] |
|---|---|---|---|---|---|---|
| Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөг | 50,167.7 | 58,275.7 | 68,124.0 | 77,677.6 | 87,640.5 | 97,975.6 |
| Өсөлт, % | 15.2% | 16.2% | 16.9% | 14.0% | 12.8% | 11.8% |
| Инфляци, ХҮИ-ээр тооцсон, % | 14.2% | 10.1% | 8.9% | 7.5% | 7.0% | 6.0% |
| **Интернет болон мобайл банкны гүйлгээний ирээдүйн төсөөлөл** | | | | | | |
| Гүйлгээний дүн, тэрбум төгрөг | 321,799.7 | 425,710.5 | 520,975.3 | 610,445.0 | 695,703.9 | 777,745.2 |
| Өсөлт | 58.6% | 32.3% | 22.4% | 17.2% | 14.0% | 11.8% |
| Нэгж гүйлгээний дүн, мян.төг | 380.7 | 419.1 | 456.4 | 490.6 | 525.0 | 556.5 |
| Гүйлгээний тоо, мян.ширхэг | 845,387.8 | 1,015,774.5 | 1,141,490.4 | 1,244,208.5 | 1,325,218.0 | 1,397,636.8 |
| **Картын гүйлгээний ирээдүйн төсөөлөл** | | | | | | |
| Гүйлгээний дүн, их наяд төгрөг | 51,263.6 | 60,177.6 | 69,799.7 | 79,983.8 | 90,534.9 | 101,211.3 |
| Өсөлт, % | 19.2% | 17.4% | 16.0% | 14.6% | 13.2% | 11.8% |
| Нэгж гүйлгээний дүн, мян.төг | 71.8 | 79.1 | 86.1 | 92.6 | 99.1 | 105.0 |
| Гүйлгээний тоо, мян.ширхэг | 713,708.5 | 760,955.6 | 810,494.9 | 863,954.0 | 913,946.6 | 963,890.9 |

Монгол Улсын нэрлэсэн ДНБ болон хэрэглээний үнийн индексээр (оны эцсээр) тооцсон инфляцийн төсөөллийг ОУВС-ийн тооцоолсноор[15] авав.

Монгол Улсын интернет банк, мобайл банк, картын нийт гүйлгээ буюу бэлэн бус төлбөрийн гүйлгээний тооны өнгөрсөн онуудын гүйцэтгэл болон дээр дурдсан төсөөллүүдийг ашиглан хийсэн ирэх жилүүдийн төсөөлсөн дүн, өсөлтийн хувийг дараах графикаар үзүүлэв. Бэлэн бусын нийт гүйлгээний тоо 2022 онд 1.6 тэрбум орчим байсан бөгөөд энэ үзүүлэлт 2027 он гэхэд 2.4 тэрбум болж өсөх, ингэхдээ жилийн өсөлтийн хурд цаашид жигд буурч 2027 онд жилийн өсөлт 5.5% болох харьцангуй болгоомжтой төсөөлөл хийсэн болно.

**Зураг 3: Монгол Улсын бэлэн бус гүйлгээний зах зээлийн төсөөлөл, мянган ширхэг, 2023-2027**




Төлбөрийн гүйлгээний дүнг ДНБ-д харьцуулсан харьцааг зах зээлийн шинжилгээний нэг үзүүлэлт болгон авч үздэг (тухайлбал McKinsey Report 2020[16]) бөгөөд энэ харьцуулалтаар Монгол Улсын бэлэн бусын гүйлгээний дүн 2022 онд ДНБ-ээс 7.44 дахин өндөр байсан бол Үнэлгээчдийн төсөөллөөр 2027 онд 8.97 болж өсөж байна. Энэ нь Монгол Улсын бэлэн бус

[15] IMF: World Economic Outlook (WEO) Database, October 2022
[16] https://www.mckinsey.com/



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
00000093

төлбөрийн зах зээл ирэх жилүүдэд илүү тэлнэ, үүнийг дагаад бизнесийн боломж нэмэгдэнэ гэж төсөөлсөнтэй ижил утгыг агуулна.

**Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний тооны төсөөлөл**

Инновэйшн Инвестмент ХХК-ийн QPay төлбөрийн системээр хийж гүйцэтгэсэн гүйлгээний тоо 2018 оноос хойш тасралтгүй өсөж 2022 онд нийт 63,323.3 мянган ширхэг гүйлгээ хийж гүйцэтгээд байгаа бөгөөд энэ нь бэлэн бусын зах зээлийн 4.1%-ийг эзэлж байна.

Гүйлгээний тоо 2022 онд 113.8% өссөн бөгөөд цаашид жилийн өсөлт 2023 онд 86.4%, 2024 онд 55.1% болох зэргээр буурч 2027 онд 9.5% болох, гүйлгээний тоо 294,784 мянгад хүрэхээр төсөөлж байна. Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний тооны 2027 оны төсөөлөл нь тухайн оны Үнэлгээчдийн тооцоолсон бэлэн бусын зах зээлийн 12.5%-г эзэлж байгаа нь тус компанийн зах зээл дээрх өнөөгийн байршил (арилжааны банкууд, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг шууд өрсөлдөгчид, томоохон биллер байгууллагууд) болон IPO санхүүжилтээр цаашид хийхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаатай нийцтэй, биелэх боломжтой төсөөлөл гэж Үнэлгээчид дүгнэсэн болно. Төсөөллийг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 13: Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний төсөөлөл, 2023 – 2027**

*[1]Төсөөлөл*

| Үзүүлэлтүүд | Нэгж | 2022 | 2023[1] | 2024[1] | 2025[1] | 2026[1] | 2027[1] |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйлгээний тооны төсөөлөл | | | | | | | |
| Гүйлгээний тоо | мян.ширхэг | 63,323 | 118,050 | 183,048 | 236,310 | 269,234 | 294,784 |
| Гүйлгээний тоо, өсөлт | хувь | 113.8% | 86.4% | 55.1% | 29.1% | 13.9% | 9.5% |
| 2022 оны дүнтэй харьцуулалт | харьцаа | | 1.9 x | 2.9 x | 3.7 x | 4.3 x | 4.7 x |
| Өмнөх онтой харьцуулалт | харьцаа | 2.1 x | 1.9 x | 1.6 x | 1.3 x | 1.1 x | 1.1 x |
| Бэлэн бусын зах зээлд эзлэх | хувь | 4.1% | 6.6% | 9.4% | 11.2% | 12.0% | 12.5% |

Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний тооны төсөөллийг доор үзүүлэв.

**Зураг 4: Инновэйшн Инвестмент ХХК-ийн гүйлгээний тооны төсөөлөл, мянган ширхэг, 2023-2027**



## Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөлөл

2022 онд ККТТ ХХК-ийн нэгж гүйлгээний дундаж орлого 87 төгрөг, ДМС ХХК-ийн нэгж гүйлгээний дундаж орлого 13 төгрөг байсан. Ирэх жилүүдэд компани бүрийн хувьд нэгж гүйлгээний дундаж орлого буурч 2027 онд ККТТ ХХК-ийн дундаж орлого 80 төгрөг, ДМС ХХК-ийн дундаж орлого 12 төгрөг болно гэж төсөөлсөн нь энэхүү үнийн бодлого ирэх жилүүдэд гүйлгээний тоог нэмэгдүүлж зах зээлд эзлэх хувиа өсгөх стратегитэй нийцэж байна. Тайлангийн өдрийн байдлаар Wechat Pay үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд энэ үйл ажиллагаанаас орлогыг Удирдлагын багийн төсөөллөөр нэмж тусгав. Үр дүнг үзүүлбэл:

**Хүснэгт 14: Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөлөл, 2023 – 2027**

[1]Төсөөлөл

| Орлогын төсөөлөл | Нэгж | 2022 | 2023[1] | 2024[1] | 2025[1] | 2026[1] | 2027[1] |
|---|---|---|---|---|---|---|---|
| ККТТ | сая төг | 5,517.6 | 10,433.4 | 15,833.2 | 20,586.0 | 23,574.6 | 26,049.2 |
| ДМС | сая төг | 824.1 | 1,506.4 | 2,250.5 | 2,905.3 | 3,310.1 | 3,624.3 |
| Нийт орлого | сая төг | 6,341.7 | 11,939.8 | 18,083.7 | 23,491.3 | 26,884.7 | 29,673.5 |

## Инновэйшн Инвестмент ХХК-ийн зардлын төсөөлөл

Инновэйшн Инвестмент ХХК-ийн зардлын төсөөлөлд Үнэлгээчид шинжилгээ хийсэн ба тус компанийн Удирдлагын багийн хийсэн зардлын төсөөлөл нь компанийн бизнес төлөвлөлтөд нийцсэн, харьцангуй бодит, биелэх боломжтой гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

***Ерөнхий ба удирдлагын зардал***

2022 онд Инновэйшн Инвестмент ХХК-ийн ерөнхий ба удирдлагын зардал нь жилийн нийт зардлын 47.5% хувийг эзлэх бөгөөд үүний 35 орчим хувийг цалингийн зардал, 16 орчим хувийг элэгдэл хорогдлын зардал, 32 орчим хувийг мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал тус тус эзэлж байна. Үйлчлүүлэгч компанийн удирдлага нь зардлын өсөлтийг харьцангуй өндрөөр төсөөлж байна. Тухайлбал 2022 оны байдлаар ажилчдын сарын дундаж цалин 2.5 сая орчим төгрөг байгаа бөгөөд цаашид цалин жил бүр 10% өсөхөөр төсөөлж үнэлгээний тооцоололд тусcан болно.

***Борлуулалтын өртөг***

2022 онд Инновэйшн Инвестмент ХХК-ийн борлуулалтын өртөг 1,124.2 сая төгрөг байгаа нь борлуулалтын орлогын 17.7%-ийг эзэлж байсан. 2023 онд тус компани нь хуримтлагдсан борлуулалтын өртгийг төлж барагдуулахаар төлөвлөн ажиллаж байгаа тул нийт 5,109.1 сая төгрөгийн зардал гаргах, 2024 оноос эхлэн жилийн борлуулалтын орлогын 30 орчим хувийн борлуулалтын өртөг гарахаар тооцоолж байна. Борлуулалтын зардлаас мерчантын буцаалт, утасны мессежийн үйлчилгээний төлбөр зэрэг зардлуудыг шууд зардал, бусад зардлыг шууд бус зардал байхаар тодорхойлж зардлын шинжилгээ хийв. Бидний хийсэн шинжилгээний үр дүнд Үйлчлүүлэгчийн шууд зардал нь борлуулалтын орлогын 70 орчим хувийг эзэлж байна.

***Борлуулалт маркетингийн зардал***

2022 онд борлуулалт маркетингийн зардал нь Үйлчлүүлэгчийн жилийн нийт зардлын дундажаар 10 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 73 орчим хувийг цалингийн зардал,


00000095

23 хувийг сурталчилгааны зардал ээлж байна. Дээр дурдсанчлан Үйлчлүүлэгч нь цалингийн зардлыг жилд 10% өсгөхөөр төлөвлөж байна.

***Хөрөнгийн зардал***

Үйлчлүүлэгч нь QPay төлбөрийн системийн хэвийн найдвартай ажиллах дэд бүтцийн төлөвлөлт, архитекторыг нийт 4 хувилбараар боловсруулж сервер, тоног төхөөрөмж болон програм хангамжийн лицензийн шаардлагыг гаргаад байна. Сервер, тоног төхөөрөмжүүдийн техник үзүүлэлт, багтаамж ирэх 5 жилийн хэрэгцээ шаардлагыг хангах, мөн эрсдэлийн үед бие биенээ нөхөн ажиллах (High Availability) боломжтой байдлаар төлөвлөсөн.

Бусад зардлын хэмжээ (эсвэл хувийг) Инновэйшн Инвестмент ХХК-ийн Удирдлагын багийн тооцоолсноор авч үнэлгээнд ашиглав.

**Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь**

Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн тооцоололлыг өргөтгөсөн Капитал хөрөнгийн үнэлгээний CAPM загварыг ашиглан хийж гүйцэтгэв. Харин CAPM аргыг шууд хэрэглэхэд манай улсын хөрөнгийн зах зээлийн мэдээлэл хангалттай биш тул хөгжиж байгаа орнуудад элбэг хэрэглэгддэг арга буюу хөгжсөн зах зээлтэй харьцуулж үнэлдэг аргыг хэрэглэв.[17] Аргыг товч тайлбарлавал:

$$k_e = R_f + \beta_e MMERP + \lambda_e CDS + SRP + CSRP + CRP$$

энд,

| | |
|---|---|
| $k_e$ - | cost of equity capital |
| $R_f$ - | risk-free reference rate in a developed country |
| *MMERP* - | mature market equity risk premium |
| $\beta_e$ - | exposure to market risk |
| *CDS* - | country's credit default spread |
| $\lambda_e$ - | exposure to country risk |
| *SRP* - | Size risk premium |
| *CSRP* - | Company specific risk premium |
| *CRP* - | Currency risk premium |

Хөрөнгө оруулагчийн шаардах өгөөжийг 25.2% байхаар дараах байдлаар тооцоолов.

Эхлээд өргөтгөсөн CAPM загварын тусламжтайгаар ам.доллараар илэрхийлсэн хорогдуулах хувийн суурь дүнг ерөнхий байдлаар тооцоолов.

| Хэмжигдэхүүн | Утга | Тайлбар |
|---|---|---|
| *Rf =* | 4.11% | 10 year US Treasury[18] |
| *MMERP =* | 5.94% | USA Equity risk premium[19] |
| *βe =* | 1.40 | Beta in Information services, USA[20] |
| *CDS =* | 7.95% | Credit default swap of Mongolia[21] |

17 https://scielo.conicyt.cl/scielo.php?script=sci_arttext&pid=S0719-04332016000100006#n6
18 https://home.treasury.gov/
19 http://pages.stern.nyu.edu/~adamodar/
20 http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/Betas.html
21 http://pages.stern.nyu.edu/~adamodar/



00000036

| | | |
|---|---|---|
| $\lambda e$= | 0.7 | Medium exposure to country risk[22] |
| ke(usd) = | 18.02% | |

Монголын Хөрөнгийн Бирж дээрх компаниудын хувьцааны үнийн өөрчлөлтийг компаниудын нийт хөрөнгөтэй харьцуулан авч үзсэн бидний шинжилгээгээр Инновэйшн Инвестмент ХХК-ийн компанийн хэмжээний эрсдэлийн нэмэлтийг 2.58% байхаар тооцоолсон болно.

Монгол төгрөг ба ам.долларын ханшийн эрсдэлийн нэмэгдлийг Худалдааны Чадварын Харьцаа (PPP)-г ашиглан инфляцийн зөрүүгээр тохируулга хийж ингэхдээ Монгол Улсын урт хугацааны инфляцийг 6%, АНУ-ын урт хугацааны инфляцийг 2%-иар тус тус авч тооцоолов. Үр дүнд ханшийн эрсдэлийн нэмэгдлийг 4.63% байхаар тооцоолов.

Суурь хувь дээр үнэлгээнд хамрагдсан компанийн хэмжээний эрсдэл, ханшийн эрсдэлийг нэмж тооцоолсноор Инновэйшн Инвестмент ХХК-ийн хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувийг 25.2% байхаар тооцоолж үнэлгээнд ашиглав.

Энэ дүн нь 2021 оны эцсийн байдлаар бидний өмнө нь хийсэн тооцоололтой харьцуулахад өндөр байгаа шалтгаан нь нэгд, зээлийн хүүний суурь түвшин өссөн, хоёрт, Монгол Улсын эрсдэлийн нэмэгдэл өссөнтэй холбоотой байна.

**Урт хугацааны өсөлтийн хувь**

Урт хугацааны орлогын өсөлтийн хувь нь өсөлтийн бодит хувь болон инфляцийн төсөөллийн нийлбэртэй тэнцэнэ. Бизнесийн үнэлгээнд урт хугацааны өсөлтийн хувийг тухайн улсын урт хугацааны ДНБ-ний өсөлтийн хувиас хэтрүүлэхгүй авахыг зөвлөдөг.[23] Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн бодит өсөлт 10-аад жилийн өмнө дунджаар 7% байсан бол 2020 онд 5% болон буурч цаашид 2050 он гэхэд 2.5% болно гэж төсөөлж байна.[24] 1980 оноос хойших дэлхийн бүх улсуудын дундаж инфляци 2019 онд 2.15%, 2020 онд 1.94% байсан.[25]

Үнэлгээнд Инновэйшн Инвестмент ХХК-ийн цэвэр орлогын урт хугацааны өсөлтийн хувийг 2028 оноос хойш жилд дундажаар 5.0 % байхаар авч ашиглав.

**Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл**

Инновэйшн Инвестмент ХХК-ийн ирээдүйн 5 жилийн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийн үндсэн хувилбарыг дараах байдлаар тооцоолов.

**Хүснэгт 15: Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөлөл, 2022 – 2026**

[1]*Төсөөлөл*

| Орлогын үзүүлэлтүүд | 2022 | 2023[1] | 2024[1] | 2025[1] | 2026[1] | 2027[1] |
|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 6,341.7 | 11,939.8 | 18,083.7 | 23,491.3 | 26,884.7 | 29,673.5 |
| Борлуулалтын өртөг | 1,124.2 | 5,109.1 | 5,763.7 | 6,872.5 | 7,554.4 | 8,189.2 |
| Хүүгийн орлого | 97.0 | 277.3 | 283.1 | 567.4 | 930.7 | 1,332.7 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 262.5 | 636.2 | 585.4 | 683.0 | 759.7 | 877.1 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,291.3 | 2,447.7 | 2,942.0 | 3,595.9 | 4,138.2 | 4,810.9 |

22 https://archive.nyu.edu/bitstream/2451/26918/2/wpa99021.pdf
23 https://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/valquestions/stablegrowthrate.htm
24 https://www.oecd.org/economy/lookingto2060long-termglobalgrowthprospects.htm
25 https://www.macrotrends.net/countries/WLD/world/inflation-rate-cpi



СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
00000037

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн зардал | 20.4 | 25.2 | 36.8 | 36.6 | 27.5 | 25.3 |
| Бусад зардал | 18.0 | 14.3 | 25.5 | 32.5 | 40.2 | 43.9 |
| Бусад олз гарз | 151.9 | | | | | |
| Татварын өмнөх ашиг алдагдал | 3,874.2 | 3,984.5 | 9,013.4 | 12,838.2 | 15,295.4 | 17,059.8 |
| Орлогын татвар | 401.2 | 420.1 | 1,157.7 | 2,259.3 | 2,906.5 | 3,365.4 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | 3,473.0 | 3,564.4 | 7,855.7 | 10,578.8 | 12,388.9 | 13,694.4 |

| | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|
| Эздийн өмч | 6,169.2 | 10,161.4 | 18,017.2 | 28,596.0 | 40,984.9 | 54,679.3 |
| ROE | 56.3% | 35.1% | 43.6% | 37.0% | 30.2% | 25.0% |

Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгалын загвар (Free Cash flow Equity Model)-т мөнгөн бус гүйлгээ болох элэгдэл хорогдолын зардал болон ажлын капиталын өөрчлөлт (Changes in non-cash working capital)-ийн тохируулга хийв. Элэгдэл хорогдолын зардлыг Үйлчлүүлэгчийн төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд үндэслэн тооцоолсон болно. СТОУС 16-гийн шаардлагын дагуу бүртгэсэн санхүүгийн зардлын тохируулгыг хийв.

Үйлчлүүлэгчийн дансны өглөгийн дийлэнх хувийг банкуудад өгөх өглөг бүрдүүлдэг ба Үйлчлүүлэгч нь цаашид банкуудтай сар бүр тооцоо нийлж явах бодлого барих, ингэснээр дансны өглөгийг бууруулахаар төлөвлөж байна.

**Үйл ажиллагааны бус хөрөнгө**

Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар бизнесийн үнэ цэнийг тооцоолоход тухайн бизнесийн үйл ажиллагаанд үл ашиглагдах хөрөнгүүдийн үнэ цэнийг нэмэлтээр тооцох шаардлагатай байдаг. Энэ хөрөнгөд илүүдэл бэлэн мөнгө, цэвэр мөнгөн урсгалын тооцоололд ороогүй хөрөнгийн болон мөнгөний захаас худалдан авсан хөрөнгө оруулалтууд, бизнесийн үйл ажиллагаанд үл ашиглагдах газар, үл хөдлөх хөрөнгө зэрэг орно.

Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьд охин компаниуд дээрх илүүдэл бэлэн мөнгө (Cash surplus) нь үйл ажиллагааны бус хөрөнгө болно.

ККТТ ХХК, ДМС ХХК-ийн 2022 оны эцсээрх нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нийт 1,431,327,195 төгрөг байна. Удирдлагын баг нь 2023 оны 1-р сараас эхлэн сар бүрийн хувьд группийн нэгтгэсэн үзүүлэлтээр мөнгөн урсгалын дутагдалд орохгүй гэж төлөвлөж байна.

Харин Үнэлгээчид аливаа бизнесийн бэлэн мөнгөний нөөцийг тодорхой тооны сарын үйл ажиллагааны зардлыг төлөх чадвартай байвал зохистой гэдэг[26] баримжаалсан дүрмийг баримтлан илүүдэл бэлэн мөнгөний дүнг тооцоолов. Инновэйшн Инвестмент ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны онцлог, өнгөрсөн хугацааны гүйцэтгэлд үндэслэн бэлэн мөнгөний нөөцийг 1 сарын үйл ажиллагааны зардалтай тэнцүү дүнгээр авч группийн хэмжээний илүүдэл мөнгийг үнэлгээний өдрийн байдлаар 1,328,954,866 төгрөг байхаар тооцоолов.

| Охин компаниуд | Бэлэн мөнгө 2022.12.31 | Үйл ажиллагааны зардлын төсөв, 2023 оны 1-р сар | Илүүдэл бэлэн мөнгө |
|---|---|---|---|
| Нийт | 1,431,327,195 | 102,372,329 | 1,328,954,866 |

[26] https://www.thebalancemoney.com/how-much-cash-should-your-business-have-on-hand-5202651



00000098

СЗХ 2023.11.08 сар өдөр БҮРТГЭВ № 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ БҮРТГЭВ-03

Дээрх тооцооллуудад үндэслэн Инновэйшн Инвестмент ХХК-ийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 47,591,230,560 төгрөг байхаар тооцоолов.

Тооцооллыг үзүүлбэл:

## Эздийн Өмчийн Чөлөөт Мөнгөн Урсгалын Загвар (Free Cash flow to Equity Model)

| | |
|---|---|
| *Cost of equity* | *25.2%* |
| *Stable growth rate* | *5.0%* |

*MNT million*

| **Free Cash Flow to Equity** | **2023** | **2024** | **2025** | **2026** | **2027** | **2028** |
|---|---|---|---|---|---|---|
| Net income | 3,564.4 | 7,855.7 | 10,578.8 | 12,388.9 | 13,694.4 | 14,379.2 |
| Non-cash expenses | | | | | | |
| Depreciation and amortization | 77.3 | 226.2 | 396.5 | 520.9 | 655.4 | |
| IFRS 16 adjustment (Financial cost) | 25.2 | 36.8 | 36.6 | 27.5 | 25.3 | |
| Changes in non-cash working capital | (1,818.4) | (100.3) | 49.3 | 10.6 | (43.1) | |
| Capital expenditure | 394.6 | 1,133.3 | 305.6 | 436.7 | 444.4 | |
| Net borrowings | - | - | - | - | - | |
| Free cash flow to Equity | 5,090.7 | 7,085.8 | 10,657.1 | 12,489.9 | 13,973.8 | |
| Terminal value | | | | | 71,081.8 | |
| Total | 5,090.7 | 7,085.8 | 10,657.1 | 12,489.9 | 85,055.7 | |

| | | |
|---|---|---|
| NPV of FCFF | | 46,705,638,914 |
| Cash Surplus | | 1,328,954,866 |
| **Total Value** | **MNT** | **48,034,593,780** |

### Цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээ

Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав.

Инновэйшн Инвестмент ХХК (тусдаа)-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг **Хүснэгт 10. Инновэйшн Инвестмент ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ**-д үзүүлсний дагуу үнэлгээний өдрийн байдлаар 1,564,528,488 төгрөг байхаар тооцоолов.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК

00000099

## Үнэлгээний үр дүн

Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход тус компанийн хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар хийгдэж байгаа үнэлгээний үр дүнг тодорхойлов.

### 1. Татан буулгалтын хөнгөлөлт

Охин компаниудаас толгой компанид шилжих аливаа орлого, хөрөнгө нь татвар ногдох орлогод хамаарна. Ийм төрлийн ажил гүйлгээнд охин компаниас толгой компанид шилжүүлэх ногдол ашгийн орлого, охин компанийн хувьцааг бүтнээр болон хэсэгчлэн зарж борлуулснаас олсон орлого, охин компани татан буугдах тохиолдлын орлого, хөрөнгийн шилжүүлэг зэрэг ажил гүйлгээнүүд багтана.

Хөрөнгийн зах зээл хөгжсөн улсуудад охин компаниас толгой компанид шилжих ногдол ашгийн орлого татвараас чөлөөлөгддөг, харин бусад төрлийн орлого болон хөрөнгө шилжүүлэхэд татвар ногдуулдаг туршлага элбэг байна. Харин Монгол Улсын хувьд үнэлгээний өдрийн байдлаар охин компаниас толгой компанид шилжих дээр дурдсан бүх төрлийн орлого болон хөрөнгөд татвар ногдуулж байна.

Иймд Инновэйшн Инвестмент ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийн тооцоололд татан буулгалтын хөнгөлөлтийг 10% байхаар авав. Энэ хөнгөлөлт нь зөвхөн охин компанийн хувь эзэмшилд хамаарах бөгөөд үр дүнд Инновэйшн Инвестмент ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 44,795,662,890 төгрөг байхаар тооцоолов.

| | | |
|---|---|---|
| **NPV of FCFE** | **төгрөг** | **48,034,593,780** |
| Татан буулгалтын хөнгөлөлт | хувь | 10% |
| Хөнгөлөлтийн дараах цэвэр үнэ цэнэ | төгрөг | 43,231,134,402 |
| Инновэйшн Инвестмент ХХК-ийн цэвэр хөрөнгө | төгрөг | 1,564,528,488 |
| **100% бизнес өмчлөлийн үнэ цэнэ, ИИ ХХК** | **төгрөг** | **44,795,662,890** |

### 2. Хяналтгүйн хувь оролцооны болон борлуулах чадварын хөнгөлөлт

Компанийн бизнесийн үнэлгээнд, ялангуяа холдинг компанийн үнэлгээнд хяналтгүйн хувь оролцооны хөнгөлөлт болон борлуулах чадварын хөнгөлөлтийг авч үздэг. Эдгээр хөнгөлөлтийн хувь хэмжээг үнэлгээчний тооцоололд үндэслэн тогтоохоос илүүтэй IPO хийх үеийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулах тогтоох нь элбэг байна.

Иймд Инновэйшн Инвестмент ХХК-ийн IPO зориулалтаар тооцоолсон тус бизнесийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийн дүгнэлтэд хяналтгүйн хувь оролцооны болон бусад хөнгөлөлт ороогүй болохыг анхаарна уу.

Хөнгөлөлтийн хувь хэмжээг IPO хийх үеийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлттэй уялдуулан Үнэт цаас гаргагч болон Андеррайтер хоорондоо зөвшилцөж шийдэх нь илүү тохиромжтой гэж Үнэлгээчид үзсэн болно.

## 3. Үнэлгээний дүгнэлт

Энэхүү үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсэний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно.

Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 44,795,662,890 (Дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерэн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ерэн) төгрөг байхаар тооцоолов.

Энэхүү ажлын үнэлгээний өдөр буюу үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр бөгөөд энэ нь үнэлгээний тайлангийн өдрөөс өөр өдөр болохыг анхаарна уу. ҮОУС-д заасны дагуу үнэлгээний дүгнэлт нь зөвхөн үнэлгээний өдрийн байдлаарх нөхцөл байдал, мэдээлэлд үндэслэхийг шаарддаг.

Үнэлгээний өдрөөс хойш үнэлгээний тайлан гарах өдрийн хооронд Орос Украйны дайн сунжирснаас үүдэлтэйгээр дэлхийн улс төрийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдал цаг тутам өөрчлөгдөж байна. Үүнтэй уялдан Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж үнэлгээний өдрөөс хойш өөрчлөгдөх боломжтойг анхаарна уу.

Инновэйшн Инвестмент ХХК-ийн ирэх жилүүдийн гүйлгээний тооны төсөөлөл нь үнэлгээний өдрийн байдлаарх тус компанийн зах зээл дээр байршсан бодит нөхцөл байдал, Монголбанкны зохицуулалтын хүрээнд харьцангүй бодит, биелэх боломжтой төсөөлөл гэж Үнэлгээчид үзсэн болно.

Иймд үнэлгээний үр дүнг хэрэглэхдээ үнэлгээний өдрөөс хойших цаг үеийн нөхцөл байдлын өөрчлөлтийг, ялангуяа хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж болон Монголбанкны зохицуулалтын өөрчлөлтийг харгалзан авч үзэхийг Үнэлгээчид зөвлөж байна.

## 4. Өмнө нь хийсэн үнэлгээний дүгнэлттэй харьцуулалт

Бид өмнө нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг IPO зориулалтаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн болно.
Энэ үнэлгээний ажилд ашигласан үнэлгээний аргачлал нь өмнөх үнэлгээний аргачлалтай ижил бөгөөд ямар нэг өөрчлөлт ороогүй болно.

Инновэйшн Инвестмент ХХК 2022 онд нийт 63,323 мянган ширхэг гүйлгээ хийсэн нь өмнөх үнэлгээний төсөөлөл болох 58,984 мянган ширхэг гүйлгээнээс 7.4%-иар давсан гүйцэтгэл болсон байна. Үүнтэй уялдаад 2022 оны борлуулалтын орлогын гүйцэтгэл төсөөллөөс 21.6%-иар илүү гарсан байна. Харин 2022 оны цэвэр ашиг 3.5 тэрбум төгрөг орчим буюу төсөөллөөс 2 дахин давсан нь зардлын хэмнэлт болон хуримтлагдсан борлуулалтын өртгийн дүнтэй холбоотой байна.

2023 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр Инновэйшн Инвестмент ХХК-ийн борлуулалтын орлого болон цэвэр ашгийн бодит гүйцэтгэл нь 2021 оны эцсийн байдлаар хийсэн үнэлгээнд ашигласан төсөөллөөс харгалзан 38.5% болон 28.9%-ийн өндөр үзүүлэлттэй гараад байна.

Дүгнэхэд, Инновэйшн Инвестмент ХХК-ийн бодит гүйцэтгэл бидний өмнө нь хийсэн үнэлгээний төсөөллөөс давж биелж байгаатай холбоотойгоор тус компанийн мөнгөн урсгалын ирээдүйн төсөөлөл сайжирсан, үүнээс үүдэн тус компанийн бизнесийн үнэ цэнэ өмнөх оны үнэлгээний дүгнэлт болох 39.0 тэрбум төгрөгөөс 14.9%-иар өсөж 44.8 тэрбум төгрөг болсон.

Бизнесийн үнэ цэнийн энэхүү өсөлт нь өмнөх төсөөлөл болон бодит гүйцэтгэлийн зөрүүний өсөлтөд хүрэхгүй байгаа үндсэн шалтгаан нь хорогдуулах хувь буюу эздийн өмчийн шаардах өгөөжийн хувь энэ үнэлгээнд 25.2% болж өмнөх үнэлгээнд тооцоолсон дүнгээс 3.1%-иар өссөнтэй холбоотой. Энэ нь 2021 оны эцсийн нөхцөл байдлыг 2022 оны эцэстэй харьцуулахад нэгд, зээлийн хүүний суурь түвшин өссөн, хоёрт, Монгол Улсын эрсдэлийн нэмэгдэл өссөнтэй холбоотой гэж үзэж болно.

### Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээгээр тооцоолсон үнэлгээний үржүүлэгчийг ашиглан хийсэн үнэлгээний дүнгүүдийг доор үзүүлэв.

| Инновэйшн Инвестмент ХХК | Дүн, сая төгрөг |
|---|---|
| Эздийн өмч, Pre-Money | 6,169.2 |
| Эздийн өмч, Post-Money | 8,879.3 |
| Цэвэр ашиг, 2022.12.31 (гүйцэтгэл) | 3,473.01 |

Дээрх үржүүлэгчдэд харгалзах үнэлгээний баримжаа дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 16: Харьцуулсан баримжаа үнэлгээний үр дүн, сая төгрөг**

| Үзүүлэлтүүд | PB | | PE | |
|---|---|---|---|---|
| | Ratio | Value, Post-Money | Ratio | Value at 2022.12.31 |
| Гадаадын компаниуд | 4.23 | 63,588.8 | 40.82 | 141,756.51 |
| Дотоодын компаниуд* | 3.06 | 45,994.5 | 12.05 | 41,843.87 |

** ROE үзүүлэлтээр тохируулсан PB харьцаа*

Үнэлгээний цэвэр ашгийн харьцаа (PE)-г ашиглан тооцоолсон үнэлгээ нь эздийн өмчийн харьцаа (PB) харьцааг ашиглан тооцоолсон үнэлгээнээс өндөр гарч байгаа нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн ашигт ажиллагаа бусад компаниудтай харьцуулахад илүү сайн байгааг илэрхийлнэ.

Инновэйшн Инвестмент ХХК-ийг МХБ дээрх компаниудтай харьцуулсан шинжилгээний PB харьцаагаар тус компанийн үнэ цэнэ 45,994.5 сая төгрөг, PE харьцаагаар 41,843.8 сая төгрөг байх баримжаа үр дүн гарч байна. Инновэйшн Инвестмент ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийг 44,795.7 сая төгрөг байхаар тооцоолсон нь зах зээлийн харьцуулалтын шинжилгээ үнэлгээний үр дүнтэй нийцтэй байна гэж Үнэлгээчид дүгнэв.



00000102

## Мэдрэмжийн шинжилгээ

Инновэйшн Инвестмент ХХК-ийн бизнесийн үнэлгээний үр дүнгийн мэдрэмжийн шинжилгээг үнэлгээний тооцооллын үндсэн төсөөллүүд болох Гүйлгээний тоо, Үйл ажиллагааны зардал, Хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувьд хийж гүйцэтгэв.

### 1. Гүйлгээний тоо

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 90% | 39.30 | -12.3% |
| Хувилбар 2 | 95% | 42.05 | -6.1% |
| Суурь хувилбар | 100% | 44.80 | 0.0% |
| Хувилбар 3 | 105% | 47.55 | 6.1% |
| Хувилбар 4 | 110% | 50.30 | 12.3% |

Үнэлгээний үр дүн нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн орлогын төсөөллийн үндсэн үзүүлэлт болох гүйлгээний тооны өөрчлөлтөд өндөр мэдрэмжтэйгээр өөрчлөгдөж байна. Тухайлбал, үнэлгээний суурь хувилбарт 2027 онд 294.8 сая ширхэг гүйлгээ хийхээр төсөөлсөн ба энэ дүн 5%-иар буурахад үнэлгээний үр дүн 6.1%-иар буурч 42.05 тэрбум төгрөг болох, 5%-иар өсөхөд үнэлгээний үр дүн 6.1%-иар өсөж 47.55 тэрбум төгрөг болох тооцоолол гарч байна.

### 2. Үйл ажиллагааны зардал

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 90% | 46.62 | 4.1% |
| Хувилбар 2 | 95% | 45.71 | 2.0% |
| Суурь хувилбар | 100% | 44.80 | 0.0% |
| Хувилбар 3 | 105% | 43.88 | -2.0% |
| Хувилбар 4 | 110% | 42.97 | -4.1% |

Зардлын мэдрэмжийн шинжилгээнд борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардлыг хамруулж үзэв. Үнэлгээний үр дүн нь нийт зардлын өөрчлөлтөд харьцангуй бага буюу дундажаар 0.41 мэдрэмжтэйгээр өөрчлөгдөж байна. Тухайлбал, зардал 5%-иар өсөхөд (буурахад) үнэлгээний үр дүн 2.0%-иар буурч (өсөж) байна.

### 3. Хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 23.5% | 49.30 | 10.1% |
| Хувилбар 2 | 24.0% | 47.91 | 7.0% |
| Суурь хувилбар | 25.2% | 44.80 | 0.0% |
| Хувилбар 3 | 26.0% | 43.03 | -3.9% |
| Хувилбар 4 | 26.5% | 41.96 | -6.3% |

Хорогдуулах хувийг 1.2%-иар бууруулж 24.0%-иар авахад үнэлгээний үр дүн 7.0%-иар өсөж 47.91 тэрбум төгрөг, 23.5%-иар авахад 10.1%-иар өсөж 49.30 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд харин 0.8%-иар өсгөж 26.0% болгоход үнэлгээ 3.9%-иар буурч 43.03 тэрбум төгрөг болж байна. Үнэлгээний үндсэн хувилбарт Инновэйшн Инвестмент ХХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийг 25.2% байхаар тооцоолсон ба энэ дүнд тус

компанийн хэмжээний эрсдэлтэй уялдуулан суурь тооцооллыг 2.58%-ийг нэмэгдүүлж авсан дүн багтсан болно.

**Мэдрэмжийн шинжилгээний дүгнэлт**

Инновэйшн Инвестмент ХХК-ийн үнэлгээний үр дүн нь тус компанийн ирээдүйд хийж гүйцэтгэх гүйлгээний тоо, эздийн өмчийн шаардах өгөөжийн өөрчлөлтүүдэд өндөр мэдрэмжтэй, харин зардлын өөрчлөлтөд харьцангуй бага мэдрэмжтэй байна. Үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний суурь хувилбарт мэдрэмж өндөртэй үзүүлэлтүүдийг үнэлгээний өдрийн байдлаар харьцангуй болгоомжтой хандлага барьж авсан болно.

# 6. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1: Үйлчлүүлэгч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарууд

ХАВСРАЛТ 2: Тодорхойлолт ба үнэлгээний аргачлал

ХАВСРАЛТ 3: Үнэлгээчдийн сертификатын хуулбар

## ХАВСРАЛТ 1: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАРУУД

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000205542

2017.05.10 / бүртгэсэн он,сар,өдөр /

9019097177 / Хувийн хэргийн дугаар /

6183948 / Регистрийн дугаар /

Инновэйшн инвестмент — Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол / шийдвэрийн нэр / 01 / дугаар / 2017.04.20 / он, сар, өдөр /

6209 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
6201 Програм хангамжийн үйлчилгээ
/ Код / / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа / 13 / эзэмшигчийн тоо / 3,501,000.00 / хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, гудамж-5 Аюуд Тауэр 1503 тоот, Утас1: 76102211, Утас2: 99179240, Факс: / хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар / Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 06 сар 22 өдөр

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Дамдинсүрэн овогтой Давaa-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2020.06.22 | Г.Алтай |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2020.06.22 | Г.Алтай |
| 3 | Батзориг овогтой Чулуунсүх-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.02.01 | Э.Эрдэнэбилэг |
| 4 | Хувьцаа эзэмшигч 2 нэмэгдэж 2 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 13 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.08.31 | Э.Эрдэнэбилэг |
| 5 | Эцсийн өмчлөгч бүртгэв. | 2021.08.31 | Э.Эрдэнэбилэг |
| 6 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 14 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.01.20 | М.Монголжин |
| 7 | Гомбодорж овогтой Эрдэнэмөнх-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.02.09 | М.Монголжин |
| 8 | Дүрмийн 4.3-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв. | 2022.06.08 | М.Монголжин |
| 9 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Элчингийн гудамж - 14, "Шүрэн оффис, 1 давхар, 6 тоот Утас1: 76102211, Утас2: 99179240, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2022.06.08 | М.Монголжин |
| 10 | Урлнасан овогтой Наранбаатар-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.06.16 | М.Монголжин |
| 11 | Гишүүн 6 нэмэгдэж ТУЗ-ийн Гишүүний тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.06.16 | М.Монголжин |
| 12 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2022.06.27 | М.Монголжин |
| 13 | Хувьцаа эзэмшигч 2 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 15 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2023.06.19 | С.Мөнхсанчир |
| 14 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2023.06.19 | Б.Бэртэ |
| 15 | Дамдинсүрэн овогтой Давaa-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2023.06.19 | Б.Бэртэ |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



00000106

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 70 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000003662

2010.07.28
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011244113
/Улсын бүртгэлийн дугаар/

5395305
/Регистрийн дугаар/

ККТТ — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол — 01 — 2010.07.28
/Шийдвэрийн нэр/ /дугаар/ /он, сар, өдөр/

722000 — Программ хангамжийн үйл ажиллагаа
/код/ /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

723000 — Мэдээ боловсруулах үйл ажиллагаа

721000 — Техник хангамжийн үйл ажиллагаа

/код/ /Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй — 2 — 1,000.0
/хугацаа/ /гишүүдийн тоо/ /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Чингэлтэй, 6-р хороо, 6-р хороолол, 42 - 30, утас1:99102202, утас2:99098647, факс:
/хуулийн этгээдийн хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/бүртгэсэн байгууллагын нэр/

## Харилцах банкны бүртгэл:

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| ХХБ Картын төв | Төгрөгийн | 495047274 | Н.Оюунхүү |
| ХХБ Картын төв | Валютын | 495047875 | Н.Оюунхүү |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Огноо | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| 1 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 2 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2014.05.30 | В.Хандсурэн |
| 2 | Намсрай овогтой Адъяахүү -г Захирал-р томилсныг бүртгэв. | 2014.06.04 | В.Хандсурэн |
| 3 | Батаа овогтой Дондовдорж -г гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2016.09.05 | О.Шижирнямаа |
| 4 | Хувь нийлүүлэгчээс 5 нэмэгдэж, 2 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2017.06.30 | С.Мөнхсайхан |
| 5 | Хувь нийлүүлэгчээс 0 нэмэгдэж, 4 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2018.04.18 | Д.Гэрэл |
| 6 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, ... тоот, Утас1 70102211, Утас2 99111633, Факс хаягийг шинээр бүртгэв. | 2019.03.29 | Ж.Намдорж |
| 7 | Дамдинсүрэн овогтой Дэваа -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2019.03.29 | Ж.Намдорж |
| 8 | Гамбодорж овогтой Эрдэнэмөнх -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2019.07.04 | С.Мөнхсайхан |
| 9 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2023.06.26 | П.Өлзийцэцэг |
| 10 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, ... Шангри-Ла оффис 6 тоот Утас1: 70102211, Утас2: 99111633, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.06.26 | П.Өлзийцэцэг |

Энэхүү гэрчилгээг хууран мэхлэх зорилгоор үйлдэн ашигласан этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

МОНГОЛ УЛС

МОНГОЛБАНК

## ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

20 19 оны 11 сарын 29 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 20 19 оны 11 сарын 29 өдрийн А-291 дугаар тушаалаар ККТТ ХХК -д төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.

*Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй!*

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

СЗХ 2023 08 БҮРТГЭВ № 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ 2023-07-20 БҮРТГЭВ-03

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 06 сарын 11 өдөр Дугаар А-139

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааны зөвшөөрөл олгох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ККТТ” ХХК-д хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

14 0836
Tushaal 2021.doc

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT УЛААНБААТАР ХОТ



00000108

МОНГОЛ УЛС
**МОНГОЛБАНК**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3. Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71, http://www.mongolbank.mn

2022.12.28 № А-7/1337
танай ______ -ны № ______ -т

"ККТТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭРДЭНЭМӨНХ ТАНАА

**Зөвшөөрлийн тушаал хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр №220623/01 тоот албан бичгээр ирүүлсэн аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийн хүсэлтийг хянаж үзлээ.

Албан бичгийн хавсралтаар ирүүлсэн баримт бичгүүд нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкнаас баталсан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд заасан шаардлагуудыг хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-358 дугаар тушаалаар танай байгууллагад аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаатай олгосныг мэдэгдье.

Хавсралт 1 хуудастай.

ТӨЛБӨР ТООЦООНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ Э.АНАР

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр Дугаар А-358 Улаанбаатар хот

**Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох тухай**

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-266 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."ККТТ" ХХК-д аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

СЗХ 2023.11 сар 08 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ 2023-07-20 БҮРТГЭВ-03

00000109

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав

МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000188029

2019.07.05
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011740108
/ Хувийн хэргийн дугаар /

6450164
/ Регистрийн дугаар /

Дижитал мерчант сервисэс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2019.06.28 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6209 Мэдээллийн технологийн үйл ажиллагаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6201 Компьютер програмчлалын үйл ажиллагаа
4610 Гадаад худалдаа

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 1 | 10,000.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 5, Аюуд тауэр 1503 тоот, Утас1: 76102211, Утас2: 99099040, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Санжсурэн овогтой Гуржав-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2019.07.05 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2023.06.28 | П.Оюунцэрэн |
| 3 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, эгчинхийн, Шүрэн оффис 6 тоот Утас1: 76102211, Утас2: 99099040, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.06.28 | П.Оюунцэрэн |
| 4 | 4610 Гадаад худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2023.06.28 | П.Оюунцэрэн |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

## ХАВСРАЛТ 2: ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

### Тодорхойлолтууд

Үнэлгээний зарим нэр томьёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томьёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

Идэвхитэй зах зээл [СТОУС 13] – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

Үнэ цэн [ҮОУС 2022] – ҮОУС 104 Үнэ Цэнийн Сууриуд - д заасан үнэ цэнийн сууриудын аль нэгэнд нийцүүлэн тухайн тооцоолсон дүнгийн талаар үнэлгээчнийн гаргасан шүүн тунгаалтын илэрхийлэл.

Үнэ цэнийн суурь [ҮОУС 2022] – Тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүд.

Өртгийн хандлага [ҮОУС 2022] – Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлага нь үнэ цэнийн үзүүлэлтийг тооцон гаргадаг.

Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ [СТОУС 13] – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

Бодит үнэ цэн [СТОУС 13] – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ юм.

Хамгийн сайн ашиглалт [СТОУС 13] – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бус хөрөнгө ашиглалт.

Орлогын хандлага [СТОУС 13] – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

Орц-мэдээлэл [СТОУС 13] – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

(a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба

(b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.

Орц мэдээлэл нь бэлэн олдоцтой буюу ажиглагдах эсвэл үл ажиглагдах байж болно.

Хөрөнгө оруулалтын зориулалттай өмч [Улаан ном 2020] – Доорх (а), (б)-оос бусад зорилгоор капиталын үнэ цэнийг өсгөх, эсвэл түрээсийн орлого олох, эсвэл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй өмч (газар, барилга, эсвэл барилгын хэсэг, эсвэл аль аль нь

(a) бараа үйлчилгээний үйлдвэрлэлт, нийлүүлэлт болон захиргааны зорилгоор ашиглаж байгаа эсвэл

(b) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах зориулалттай.

Нэгдүгээр түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Аж ахуйн нэгжийн хэмжилт хийж буй өдрөөр ашиглах боломжтой, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг (тохируулаагүй ) үнэ.

Хоёрдугаар түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөртэй холбоотой шууд ба шууд бусаар гаргаж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл.

Гуравдугаар түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө ба өр төлбөрийн талаарх үл ажиглагдах орц мэдээлэл.

Зах зээлийн хандлага [ҮОУС 2022] – Тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох (өөрөөр хэлбэл төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтээр хангадаг.

Зах зээлээр баталгаажсан мэдээлэл [СТОУС 13] – Корреляци болон бусад аргын тусламжтайгаар зах зээлд бэлэн байгаа мэдээллээр баталгаажсан буюу түүнээс гаргаж авсан орц мэдээлэл.

Зах зээлийн түрээсийн төлбөр [ҮОУС 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа түрээслүүлэгч ба түрээслэгчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр зохих түрээсийн нөхцөлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог түрээслэвэл зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Зах зээлийн үнэ цэн [ҮОУС 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө буюу өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Бэлэн олдох орц мэдээлэл [СТОУС 13] – Тодорхой үйл явдал, ажил гүйлгээний талаар олон нийтэд нээлттэй байгаа мэдээлэл гэх мэт зах зээлийн тоон мэдээг ашиглан боловсруулсан орц мэлээллийг хэлэх бөгөөд үүнд хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохын тулд зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг тусгана.

Үндсэн зах зээл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хамарсан хамгийн өндөр дүнтэй болон хамгийн олон арилжаа хийгдсэн зах зээл юм.

Үл хөдлөх өмчийн хувь оролцоо [ҮОУС 2022] – Газар ба барилгын өмчлөл, хяналт, ашиглалт буюу эзэмшлийн эрх.

Тусгай төсөөллүүд [Улаан ном 2022] – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй төсөөлөл эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.

Тусгай үнэ цэн [Улаан ном 2022] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэн.
Өргөжилтийн хэмнэлтийн үнэ цэн [ҮОУС 2022] – Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл хувь оролцоог нэгтгэн нийлүүлсэн бөгөөд уг нэгдсэн үнэ цэн нь тэдгээрийн тус тусын үнэ цэнүүдийн нийлбэрээс илүү байх зөрүү үр дүн.

Худалдах зориулалт бүхий өмч [Улаан ном 2022] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэн нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.

Эрсдэлийн шагнал [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн "эрсдэлийн залруулга" хэмээн нэрэлдэг.

Тооцооны нэгж [СТОУС 13 ] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд уг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижигрүүлэх СТОУС-ын хэмжүүр.
Үл ажиглагдах орц мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.

Үнэлгээний өдөр [Улаан ном 2022]– Үнэлгээчний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.

Үнэлгээний тайлангийн өдөр [Улаан ном 2022] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

**Бодит болон зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт**

*СТОУС 13 Бодит Үнэ Цэнийн Хэмжилт-д Бодит үнэ цэн* гэдэгт хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь ҮОУС-д *Бодит үнэ цэн*-ийг тодорхойлсноос ялгаатай бөгөөд тэрхүү тодорхойлолтыг санхүүгийн тайлагналаас бусад зорилгоор нийтлэг хэрэглэдэг.

СТОУС-д тодорхойлсон *бодит үнэ цэн* нь ҮОУС-д тодорхойлсон *зах зээлийн* үнэ цэн-ийн ойлголттой ерөнхийдөө нийцдэг. Иймд тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох



СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
2023-07-20 БҮРТГЭВ-03
00000112

бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ихэнх практик ажилд ҮОУС-ийн *зах зээлийн үнэ цэн* нь СТОУС 13-д тодорхойлсон *бодит үнэ цэн*-ийн шаардлагыг хангана гэж үздэг.

*Зах зээлийн үнэ цэн* гэдэгт хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүнг ойлгоно.

*Зах зээлийн үнэ цэн* нь хөрөнгийн хамгийн сайн ашиглалтыг тусгасан байна. Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тухайн хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Хөрөнгийн одоогийн ашиглалт эсвэл өөр хувилбарт ашиглалтын аль нь ч хамгийн сайн ашиглалт байж болно. Энэ нь зах зээлийн оролцогч хөрөнгийн үнийг тооцоолохдоо өөртөө төсөөлж байгаа тэр ашиглалтаар тодорхойлогдоно.

**Үнэлгээний арга зүй**

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагуудад:

(а) Зах зээлийн хандлага,
(б) Орлогын хандлага,
(в) Өртгийн хандлага.

Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.
ҮОУС 2020-ын 105 Үнэлгээний хандлага болон аргууд бүлэгт зааснаар хөрөнгийн хувьд үнэлгээний хандлага болон аргуудыг сонгох зорилго нь тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох явдал байдаг. Боломжит нөхцөл байдал бүрд тохирох нэг арга гэж байдаггүй. Сонголтын процесст наад зах нь дараах хүчин зүйлсийг харгалзан авч үзвэл зохино:

(а) үнэлгээний гэрээт ажлын нөхцөлүүд болон зорилгоор тодорхойлогдох үнэ цэнийн тохиромжтой суурь (сууриуд) ба үнэ цэнийн урьдчилсан нөхцөл (нөхцөлүүд),
(б) үнэлгээний боломжит хандлагууд ба аргуудын тус тусын давуу ба сул талууд,
(в) хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзсэнээр тогтоосон арга тус бүрийн тохиромжтой байдал ба хамаарах зах зээлд оролцогчдын ашиглах хандлагууд буюу аргууд, ба
(г) тухайн аргыг (аргуудыг) хэрэглэхэд шаардлагатай найдвартай мэдээллийн бэлэн, олдоцтой байдал.

Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний гэрээт ажлын бодит байдал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт өндөр түвшний итгэлтэй байгаа тохиолдолд нэгээс олон арга ашиглахыг үнэлгээчнээс шаарддаггүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай орцууд байхгүй тохиолдолд үнэлгээчин нь найдвартай дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудын хэрэглээг, мөн түүнчлэн үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахдаа харгалзан үзвэл зохистой ба ашиглаж болох нэгээс олон хандлага буюу аргыг авч үзвэл зохино. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээн дэх олон аргуудыг ашигласан тохиолдолд тэдгээр олон хандлагууд ба/буюу аргуудад үндэслэсэн үнэ цэнийн дүгнэлт нь ул үндэслэлтэй байвал зохистой бөгөөд үнэлгээчин нь тэдгээр өөр өөр үнэ цэнүүдийг дундажлахгүйгээр, харин шинжилж, тохируулах замаар нэг дүгнэлтэд хүргэсэн үйл явцаа үнэлгээний тайланд тусган илэрхийлбэл зохино.

Өөр өөр хандлагууд ба/буюу аргууд нь үнэ цэнийн ихээхэн ялгаатай үзүүлэлтүүдийг гаргах тохиолдолд үнэ цэнийн хоёр буюу хэд хэдэн ялгаатай үзүүлэлтүүдийг хялбархнаар дундажлан жинлэх нь ерөнхийдөө тохиромжтой биш тул үнэлгээчин нь яагаад уг үнэ цэнийн үзүүлэлтүүд өөр өөр байгааг ойлгохын тулд горимуудыг гүйцэтгэвэл зохино. Ийм тохиолдолд тэдгээр хандлагууд/аргуудын нэг нь үнэ цэнийн илүү сайн буюу найдвартай үзүүлэлтээр хангах эсэхийг тодорхойлохын тулд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийг дахин харгалзан үзвэл зохино.

Үнэлгээчин нь гурван хандлагуудын хувьд холбогдох зах зээлийн ажиглалтын мэдээллийн хэрэглээг хамгийн их байлгавал зохино. Үнэлгээнд ашигласан орцууд болон төсөөллүүдийн эх сурвалжаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орцууд ба төсөөллүүдийг, түүнчлэн үнэлгээний зорилгод тэдгээрийн тохиромжтой байдлыг үнэлэхийн тулд зохих шинжилгээг гүйцэтгэх ёстой.

### Зах зээлийн хандлага

*Зах зээлийн хандлага* нь тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтийг тодорхойлдог.

Дараах нөхцөл байдалд зах зээлийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино:

(а) Тухайн үнэ цэнийн суурийн дагуу харгалзан үзэхэд тохиромжтой тийм ажил гүйлгээгээр уг үнэлж буй хөрөнгийг саяхан борлуулсан байх,

(б) Үнэлж буй хөрөнгийг эсвэл түүнтэй ихээхэн ижил төсөөтэй хөрөнгийг нийтэд идэвхтэй арилжаалдаг байх,

(в) Ихээхэн ижил төстэй хөрөнгийн хувьд байнга эсвэл сүүлийн үед гарсан ажиглаж болох ажил гүйлгээнүүд байх.

Зах зээлийн хандлагыг ашиглах эсвэл жигнэхдээ илүү ач холбогдол өгөх хэрэгтэй тохиолдлыг дээр дурдсан. Зах зээлийн хандлагыг ашиглах, жигнэхдээ илүү ач холбогдол өгч болох нэмэлт тохиолдлуудыг доор дурдав. Доор дурдсан тохиолдолд зах зээлийн хандлагыг ашиглаж байгаа тохиолдолд үнэлгээчин нь зах зээлийн хандлагыг ашиглан тодорхойлсон үнэ цэнийг бататгах зорилгоор өөр хандлагыг ашиглан үнэлэх, мөн жигнэж болох эсэхийг бодолцох хэрэгтэй. Үүнд:

(а) Зах зээл дэх хэлбэлзэл болон идэвхийн түвшнийг харгалзан үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь ойрын хугацаанд арилжаанд ороогүй бол

(б) Үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь олон нийтэд нээлттэй борлогддог, гэхдээ идэвхитэй биш бол

(в) Зах зээлийн мэдээллийн олдоцтой, гэвч харьцуулж буй хөрөнгө нь үнэлгээний хөрөнгөөс мэдэгдэхүйц ялгаатай, их хэмжээгээр тохируулга хийх шаардлагатай бол

(г) Ойрын хугацааны арилжааны мэдээлэл нь найдвартай биш бол

(д) Хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг нь түүний нөхөн сэргээх өртөг эсвэл орлого бүрдүүлэх чадвар бус зах зээл дээр хүрч болох үнэ бол

***Жиших ажил гүйлгээний арга***

Зэрэгцүүлэх ажил гүйлгээний арга гэж бас нэрлэгдэх жиших ажил гүйлгээний арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй хөрөнгөтэй холбоотойгоор гарсан ажил гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг ашигладаг.

*Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга*

Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй, нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн талаарх мэдээллийг ашигладаг.

### Орлогын хандлага

*Орлогын хандлага* гэдэгт тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно.

Дараах нөхцлүүд биелж байвал орлогын хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

(а) Хөрөнгийн орлого олох чадвар нь оролцогчийн талаас авч үзэхэд хөрөнгийн үнэ цэнд нөлөөлөх маш чухал элемент байх

(б) Үнэлж буй хөрөнгийн хувьд түүний ирээдүйн орлогын дүн ба хугацааны талаар ул үндэслэлтэй прогнозыг хийх боломжтой, харин холбогдох зах зээлийн жиших хөрөнгө цөөхөн байх

*Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга*

Энэ аргын дагуу, тухайн прогнозчилсон мөнгөн гүйлгээг үнэлгээний өдөр рүү буцаан хорогдуулах бөгөөд үр дүн нь уг хөрөнгийн өнөөгийн үнэ цэн болно.

Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг тогтооход дараах элементүүдийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

(а) Түрээсийн ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолох

(б) Тухайн мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг илэрхийлэх мөнгөн гүйлгээний дүн болон цаг хугацаанд гарч болзошгүй өөрчлөлтийн талаарх дүгнэлт

(в) Хөрөнгө эзэмшигч талд цаг хугацааны хувьд тодорхойгүй байдал үүсдэггүй бөгөөд гэрээ зөрчигдөх эрсдэл тулгарахгүй бол үргэлжлэх хугацаа ба дуусгавар өдөр нь мөнгөн зарлагын гүйлгээний хугацаанд

эрсдэлгүй мөнгөн хөрөнгийн хувь хэмжээ (өөрөөр хэлбэл эрсдэлгүй хүүний түвшин)-ээр илэрхийлэгдсэн мөнгөний цаг хугацааны үнэ цэн

(г) Мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг давж гарах үнэ (өөрөөр хэлбэл эрсдлийн шагнал)

(д) Тухайн нөхцөл байдалд зах зээлд оролцогчдын анхаарч үзэх бусад хүчин зүйлс зэрэг орно.

*Орлогын капиталжуулалтын арга*

Урт хугацаанд ашиглах буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай хөрөнгийн зарим нөхцөл байдалд хорогдуулсан мөнгөн гүйлгээ нь төсөвлөсөн тодорхой хугацааны эцэс дэх уг хөрөнгийн үнэ цэнийг илэрхийлэх терминал үнэ цэнийг багтаасан байж болно. Зарим нөхцөл байдалд төсөвлөсөн тодорхой хугацаагүйгээр зөвхөн терминал үнэ цэнийг ашигласнаар хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж болдог бөгөөд үүнийг орлогын капиталжуулалтын арга гэдэг.

**Өртгийн хандлага**

Энэ хандлага нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэнэ.

Дараах нөхцөл байдлуудад өртгийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

(а) Оролцогчид нь зохицуулалтын буюу хуулийн саад хязгаарлалтгүйгээр үнэлж буй хөрөнгөтэй бараг ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг дахин бий болгох боломжтой байх бөгөөд үнэлж буй хөрөнгийг нэн даруй ашиглах боломжит байдлын төлөө мэдэгдэхүйц урамшуулал төлөхгүйгээр тухайн хөрөнгийг маш хурдан дахин бий болгох боломжтой байх

(б) Хөрөнгө нь орлогыг шууд бий болгодоггүй бөгөөд тухайн хөрөнгийн өвөрмөц онцлог нь орлогын хандлага эсвэл зах зээлийн хандлагыг ашиглах ямар ч боломжгүй болгодог байх

(в) Хэрэглэж буй үнэ цэнийн суурь нь орлуулалтын үнэ цэн гэх мэт орлуулалтын өртөгт үндсэндээ суурилсан байх

СЗХ
2023.11.08
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

## ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАР

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

### ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 051100154

Иргэний ургийн овог: [illegible]

Иргэний овог,нэр: [illegible]

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: [illegible]

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг 1-р хороо 18 10 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2012/12/0[illegible] -ны өдрийн 255 тоот тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ................ / Ч.УЛААН /

УЛААНБААТАР ХОТ

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.15. оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.15. оны 12.-р сарын 18.-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.БОЛОР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20.18. оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.18. оны 12.-р сарын 19.-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420



00000116

СЭХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

Gantulga Donorov

on

31 October 2018

**WAS ELECTED A PROFESSIONAL MEMBER OF THE ROYAL INSTITUTION OF CHARTERED SURVEYORS**

6824290

**MEMBERSHIP NUMBER**

Christopher Brooke

**PRESIDENT OF RICS**

RICS

This diploma is held from year to year subject to the provisions of the bye-laws of the Institution.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855
9021031195 СТС2420



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

# ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 101200188

Иргэний ургийн овог: Хошууд

Иргэний овог,нэр: Доноров овогтой Ганбаатар

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: ОО77112572

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо хужир булан А-111 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 7 тоот тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад шилжүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ............ Б.ЧОЙЖИЛСҮРЭН /

УЛААНБААТАР ХОТ

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 2019 оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2019 оны 12-р сарын 17-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Н.ХҮРЭЛБААТАР /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

0000296

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
9021031195 СТС2420
00000118

СЭХ
2023.11.08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-07-20
БҮРТГЭВ-03

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 121200001

Иргэний ургийн овог: Сахьяа

Иргэний овог,нэр: Лхагва овогтой Халиун

Иргэний үнэмлэхний дугаар: ЧР 79091761

Иргэний бүртгэлийн дугаар:

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: УБ Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу 37-61 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2012/12/07-ны өдрийн 255 тоот тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ............ Ч.УЛААН

УЛААНБААТАР ХОТ

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.05.09

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

| | |
|---|---|
| Регистрийн дугаар : | **чр******61** |
| Нэр : | **ХАЛИУН** |

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

| | |
|---|---|
| Авсан огноо : | **2021-12-18** |
| Дуусах огноо : | **2024-12-18** |
| Хүчинтэй эсэх : | **Хүчинтэй** |
| Тусгай зөвшөөрлийн нэр : | **ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ** |

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгуурууд ханасан эсэхээс хамааран өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ТЕК ХХК
6183855
9021031195 СТС7420
00000119

СЗХ
2023 он 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

MDSKhanLex

**"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХХК-ИЙН ХУВЬЦААГАА АНХ УДАА НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР**

**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

| | |
|---|---|
| **Хаана:** | **"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХХК-д** |
| **Хаяг:** | **Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис 1 давхар 6 тоот** |
| **Утас/Факс:** | **(976) 76102211** |
| **Хаанаас:** | **"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН** |
| **Хаяг:** | **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот** |
| **Утас/Факс:** | **(976-11) 330048, (976-11) 330049** |
| **Огноо:** | **2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр** |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2023 .11. 08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

2023.06.30 № Д-23/170

"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХХК-
ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НАР ТАНАА

# "ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХХК-ИЙН ХУВЬЦААГАА АНХ УДАА НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Тус "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**МДСХ**" гэх) нь "Инновэйшн Инвестмент" ХХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх)-ийн хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх талаар энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа тоон мэдээлэл, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ зэрэг тусгай мэргэжлийн хүрээний мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерийн судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
7. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;
8. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

МДСХ нь Дүгнэлтэд өөрөөр тусгаагүй бол Компанийн үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан ач холбогдол бүхий гэрээ, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн хувь

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC

нийлүүлсэн хөрөнгийн 5% ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцлүүд, дүрэм журмыг 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хянасан бөгөөд түүнээс бусад дүрэм, журам, байгуулагдсан гэрээ энэхүү Дүгнэлтэд хамрагдаагүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

"Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасныг удирдлага болгон үндсэн андеррайтер "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтер "Инвескор капитал ҮЦК" ХХК, үнэлгээний компани "Гэрэгэ эстимейт" ХХК, аудитын компани "Грант Тронтон Аудит" ХХК болон Үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. Хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон гаргахтай холбогдуулан "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн болон түүнтэй гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу та бүхний мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдүүдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан бид нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй болно.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

СЗХ 2023.11.08 он сар өдөр БҮРТГЭВ № 01

MDSKhanLex

2023-07-20 БҮРТГЭВ-03

**АГУУЛГА**

Удиртгал ........ 5

1. **Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх** ........ 7

2. **Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл** ........ 11

3. **Үнэт цаас гаргагчийн дотоод, дүрэм журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмын төсөл СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх** ........ 20

4. **Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх** ........ 24

5. **Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх** ........ 30

6. **Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх** 33

7. **Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх** ........ 34

8. **Үнэт цаас бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх** ........ 36

9. **Компанийн толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох** ........ 38

10. **Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх** ........ 40

11. **Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх** ........ 43

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ ХХК 00000123

СЗХ
2023 . 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**МДСХ**", эсхүл "**Бид**" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Инновэйшн Инвестмент" ХХК (Регистрийн дугаар: 6183948), (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү Хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байна.

Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23.1-т "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 4.3-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу Компани нь хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар компанийн хэлбэрийг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна. Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэгт заасны дагуу нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй байна. Тус Компани Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйл (Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу нэмж хувьцаа гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид "**МХБ**" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Хангагдсанд тооцох нөхцөл**

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;



00000124

6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгаажсан;
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;
11. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж компанийн хэлбэрээ өөрчилсний улмаас хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулсан гэрээ, хэлцэл, баталсан журмууд нь хүчингүй болох үндэслэл болохгүй гэж үзсэн.

Энэхүү үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн ТӨХК-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

СЗХ-ноос 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексыг шинэчлэн баталсан бөгөөд дагаж мөрдөх шилжилтийн хугацааг тогтоогоогүй байна. Шинээр батлагдсан кодексын шаардлагыг хангахын тулд Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнуудаас тодорхой хугацаанд бэлтгэх шаардлагатай байна. Тухайлбал, Шинэчилсэн кодексын 1.2 (залгамж халааны бодлого), 1.4 (хүйсийн тэнцвэрийг хангах), 1.5 (чиглүүлэх сургалт), 5.3 (байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан) зэрэг асуудлыг үйл ажиллагаандаа тусгаж, Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлан гаргаж, үе шаттайгаар хангах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:

СЭХ
2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

Компани нь Компанийн тухай хуулийн дагуу анх гурван гишүүнтэй (Монгол Улсын иргэн Б.Дондовдорж РД: ЙЮ71022676, Д.Даваа РД: ТА81110919, Б.Чулуунсүх РД: ТБ82033073)-гээр үүсгэн байгуулагдаж "Инновэйшн Инвестмент" ХХК нэрээр 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн (Хавсралт 1.3, 1.5).

Компанийн үүсгэн байгуулагч гурван гишүүн нь анх Компанийн энгийн хувьцаа, хувьцаагаар гэрчлэгдсэн бүх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дараах байдлаар эзэмшиж байсан (Хавсралт 1.6).

| № | Үүсгэн байгуулагч гишүүн | Хувь эзэмшил |
|---|---|---|
| 1 | Б.Дондовдорж | 24% |
| 2 | Д.Даваа | 51% |
| 3 | Б.Чулуунсүх | 25% |

2017 оноос хойш Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэлд хэд хэдэн удаагийн өөрчлөлт орж Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 16 хувьцаа эзэмшигч (Монгол Улсын хуулийн этгээд 5, Япон Улсын хуулийн этгээд 3, Монгол Улсын иргэн 5, Япон улсын иргэн 3), гурван тэрбум есөн зуун хорин найман сая есөн зуун мянга төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн мэдээлэл:
*Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар*: 000205542;
*Улсын бүртгэлийн дугаар:* 9019097177;
*Регистрийн дугаар*: 6183948;
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* "Инновэйшн Инвестмент" Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани;
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл:* Мэдээлэл технологийн үйл ажиллагаа, Программ хангамжийн үйлчилгээ;
*Хугацаа:* Хугацаагүй;
*Гишүүдийн тоо:* 16;
*Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ* (мянган төгрөгөөр): 3,928,900;
*Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:* Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис 1 давхар 6 тоот;
*Гэрчилгээ олгосон огноо:* 2020.06.22;
*Гүйцэтгэх захирал:* Г.Эрдэнэмөнх.

Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн, 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр дахин олгогдсон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000205542, Улсын бүртгэлийн дугаар 9019097177, Регистрийн дугаар 6183948) (Хавсралт 1.3, Хавсралт 1.4) бүхий "Инновэйшн Инвестмент" ГХОХХК нь Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

***Үнэт цаас гаргах тухай шийдвэрийн талаар.***

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн ХЭХ-ын 22/03 дугаар Хувьцаа хуваах, зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай тогтоол (Хавсралт 1.7)-оор 700,200 ширхэг хувьцааг 200 хуваах, зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэн 192,166,000 ширхэг хувьцаатай болжээ. Ийнхүү тогтоолын 6-д "Компанийн зарласан боловч гаргаагүй хувьцаанаас 35,010,000 ширхэг хувьцааг олон нийтэд

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242508 6183948



КАПИТАЛ ХЕЛ
00000126

санал болгох замаар эргэлтэд оруулахыг дурдсугай" гэжээ. Энэхүү шийдвэрийн дагуу хүчин төгөлдөр Компанийн дүрэмд зааснаар компани нь 35,010,000 ширхэг зарласан хувьцаатай байна.

"Инновэйшн инвестмент" ХХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/14 дугаар тогтоол (Хавсралт 1.9)-оор Компаниас хувьцаагаа олон нийтэд анх удаа зарласан хувьцаанаас нэмж гаргах болон Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний охин компани болох "ККТТ" ХХК-ийн хувьцаанаас олон нийтэд санал болгох, Компанийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх, татан төвлөрүүлэх хөрөнгө, зарим нөхцөлийг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Компанийн нийт зарласан 192,166,000 ширхэг энгийн хувьцааны 27,733,160 ширхэг хувьцааг нэмж гаргах;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшлийн "Инновэйшн инвестмент" ХХК-ийн 17,116,000 ширхэг энгийн хувьцаанаас 9,244,458 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох;
- Компанийн нийт гаргасан хувьцааны 20 хувьтай тэнцэх буюу нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэн олон нийтэд нээлттэй арилжаалах;
- Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь хувьцааны хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээх;
- Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны зах зээлийн үнийг IPO хийх үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоохыг ТУЗ-д үүрэг болгох;
- Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь Компанийн нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхгүй буюу татгалзах;
- Компанийн нэмж гаргасан хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд санал болгох нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг батлахыг ТУЗ-д үүрэг болгохоор тус тус шийдвэрлэсэн байна

Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгохтой холбогдуулан өмнө гаргасан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23/03 дугаартай "Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох, компанийн хэлбэр өөрчлөх тухай", Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 22/04 дугаартай "Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох, компанийн хэлбэр өөрчлөх тухай" тогтоолыг тус тус хүчингүй болгосон байна (Хавсралт 1.7, 1.8, 1.9).

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөн оролцох хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэл ХЭХ-ын шийдвэр гарах үеийн байдлаар хүчин төгөлдөр байна (Хавсралт 1.15).

"ККТТ" ХХК-ийн цор ганц хувьцаа эзэмшигч "Инновэйшн инвестмент" ХХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/12 тоот тогтоол (Хавсралт 1.11)-оор опцион эрх хэрэгжүүлэх болон, уг эрхийг хэрэгжүүлснээр эзэмших хувьцаанаас нийтэд санал болгон гаргахтай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх эрхийг "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Гомбодорж овогтой Эрдэнэмөнхөд олгосон. Тус бүрэн эрхийн үндсэн дээр Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/03 дугаартай шийдвэр (Хавсралт 1.13)-ээр ККТТ" ХХК нь өөрийн эзэмшлийн "Инновэйшн инвестмент" ХХК-ийн 17,116,000 ширхэг энгийн хувьцаанаас 9,244,458 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгохыг Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрч шийдвэрлэжээ.

"Инновэйшн инвестмент" ХХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд үнэт цаас гаргагчийн охин компани "ККТТ" ХХК саналын эрхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс хасаж тооцсон нь Компанийн тухай хуулийн 6.10-д "Энэ



00000127

хуулийн 6.9-д заасны дагуу охин компанийн эзэмшиж байгаа толгой компанийн хувьцаа нь саналын эрхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг тооцохдоо охин компанийн эзэмшиж байгаа хувьцааг хасаж тооцно" гэж заасантай нийцэж байна.

"Инновэйшн инвестмент" ХХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/14 дугаар тогтоолын 2 болон 5 дугаарт " Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны зах зээлийн үнийг IPO хийх үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоох, Компанийн нэмж гаргасан хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд санал болгох нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай" гэж тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын "Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлүүдийг тогтоох тухай" 02/16 тоот тогтоолын дагуу дараах шийдвэрийг гаргажээ (Хавсралт 1.14). Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох асуудлыг шийдвэрлэсэнтэй холбогдуулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан тогтоосон үнийн аргаар нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 225 (хоёр зуун хорин таван) төгрөгөөр тогтоох;
2. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гаргаж байгаа 27,733,160 ширхэг болон Компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшлийн 9,244,458 ширхэг энгийн хувьцаа, нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 20 хувьтай тэнцэх энгийн хувьцааны татан төвлөрүүлэх дүнг 8,319,964,050 (найман тэрбум гурван зуун арван есөн сая есөн зуун жаран дөрвөн мянга тавин) төгрөгөөр тогтоох;
3. Татан төвлөрүүлэх хөрөнгийн 85 (наян тав) хувь хүртэлх дүн буюу 7,071,969,443 (долоон тэрбум далан нэгэн сая есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун дөчин гурав) төгрөг хүртэлх дүнг Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгож, үлдсэн хувийг олон нийтэд санал болгох.
4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
   Инновэйшн Инвестмент ХХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компани, түүний охин компанийн үйл ажиллагаа, тэлэлт, техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтын зорилгоор дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн. Үүнд:

| № | Хөрөнгө оруулалтын зориулалт | Эзлэх хувь |
|---|---|---|
| 1 | Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт | 22.5% |
| 2 | Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа | 30% |
| 3 | Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа | 15% |
| 4 | Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах | 7.5% |
| 5 | ККТТ ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр | 25% |

"Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай" ХЭХ-ын тогтоол нь Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1, 38.6, 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйл 42.1, 42.2 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай



СЗХ 2023 .. 08 өдөр БҮРТГЭВ № 01
MDSKhanLex
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
INNOVATION INVESTMENT LLC
00000128

хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан, "Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлийг тогтоох тухай" ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 55.2, 55.6 дахь хэсэг, 76.1.6 дахь заалтад заасан бүрэн эрх болон хуульд нийцсэн байна.

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодект заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 14.1-д зааснаар Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Ерөнхий Нягтлан бодогч, ТУЗ-ийн дарга, гишүүн нь тус Компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна” гэсэнтэй нийцсэн байна.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын 23/08 тоот тогтоол (Хавсралт 2.1)-оор Компанийн ТУЗ-ийг нийт 7 бүрэлдэхүүнтэйгээр сонгосон. 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар ТУЗ-ийн дарга, гишүүдийг эрх барих этгээдээр бүртгэсэн байна (Хавсралт 1.3).

Д.Даваа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 02/05 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор ТУЗ-ийн даргаар, Э.Амаржаргал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 02/07, 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 02/18 тоот тогтоол (Хавсралт 2.12)-оор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дахин томилогдон ажиллаж байна. Сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| Ердийн гишүүд: | | | |
| 1. | Уртнасангийн Наранбаатар (Хавсралт 2.3) | 1998 онд ШУТИС-ийн КТМС-ийн Бизнесийн удирдлагын бакалавр. | 2000–2007 онд Хасбанкны МТ-д Газрын захирал;<br>2007-2009 онд Крафт Силикон -д Чанарын удирдлагын захирал;<br>2009 оноос одоог хүртэл Ай Ти Зон ХХК-д Гүйцэтгэх захирал |
| 2. | Хосокава Масахико (Хавсралт 2.4) | Хоккайдогийн их сургуулийн Инженер мэргэжлээр бакалавр. | 1990-1999 онд Fuji Heavy Industries Ltd-ийн Aerospace Material engineer, Quality engineer;<br>1999-2016 онд Ichitaka Co.Ltd.-д Corporate staff, Business Development Manager, Auditing Director;<br>2004-2006 онд UniGas LLC-д Executive Officer;<br>2010 – 2015 онд UniGas LLC-д Deputy CEO, Board member;<br>2016 оноос хойш Юнимедиа Солюшнс ХХК-д Гүйцэтгэх захирал. |
| 3. | Ганболдын | 1999-2002 онд ШУТИС-ийн | 2007-2009 онд “Лайфтайм |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ БЛЭНД ЭНД КО КАПИТАЛ ҮЦК



00000130

| | | | |
|---|---|---|---|
| | Лхамсүрэн<br><br>(Хавсралт 2.5) | Хөнгөн үйлдвэрийн менежментийн бакалавр | Инвестмент" ХХК-д Дэд захирал;<br>2009-2010 онд "Хера холдинг" ХХК-д Бизнес хөгжил, Маркетингийн албаны дарга;<br>2011-2013 онд "Айтүүлс" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн;<br>2011-2018 онд "Стандарт Инвестмент" ХХК-д Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга;<br>2013-2023 онд "Ай Си Ти групп" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга. |
| 4. | Батзоригийн Чулуунсүх (Хавсралт 2.6) | 2009 онд Япон улсад Цахилгаан холбооны их сургуулийг Мэдээлэл холбооны магистр. | 2009-2013 онд Япон улсын NTT Software компанид систем инженер;<br>2013-2016 онд Монгол Улсын Дайэй Пробис Монгол ХХК-д менежер;<br>2016-2021 онд Монгол Улсын ККТТ ХХК-д Гүйцэтгэх удирдлага. |
| 5. | Дамдинсүрэнгийн Даваа (Хавсралт 2.7) | 2002 онд Компьютерын ухааны инженерийн бакалавр. | 2001-2014 онд Цагдаагийн ерөнхий газарт төлөөлөгч, ахлах төлөөлөгч, тасгийн дарга, хэлтсийн дарга, төвийн дарга;<br>2014-2016 онд Дайей Пробис монгол ХХК-д менежер;<br>2016-2020 онд ККТТ ХХК-д бизнес хариуцсан захирал;<br>2020-2021 онд Инновэйшн Инвестмент ХХК-д дэд захирал, захирал;<br>2021-2023 .06 сард АйСиТи групп ХХК-д дэд захирал. |
| 6. | Адилбишийн Баттамир (Хавсралт 2.8) | 1998-2003 онд ШУТИС-ийн Программ хангамжийн бакалавр;<br><br>2018-2019 онд ШУТИС-ийн Компьютерийн ухааны магистр. | 2002-2009 онд Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвд Программист;<br>2009-2011 онд Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх;<br>2011-2012 онд Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх;<br>2013-2023 онд "Ай Си Ти групп" ХК-д Хамтран үүсгэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, 2011-2023 онд "Айтүүлс" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн. |
| 7. | Баянмөнхийн Анхболд (Хавсралт 2.9) | 2000-2004 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын Бакалавр;<br>2004-2006 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын Магистр. | 2006-2012 онд Абим Консалтинг ХХК-д менежментийн зөвлөх;<br>2012-2015 онд Шунхлай Группт Дэд ерөнхийлөгч;<br>2016-Одоог хүртэл Инвескор ББСБ ХК-д ТУЗ-ийн дарга;<br>2016-Одоог хүртэл Эс Ай Би Жэй Капитал ХХК-д Гүйцэтгэх захирал. |

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 9.2-д "ТУЗ-ийн дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудит болон эрсдэлийн, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх, Стратеги хөгжлийн хороод ажиллана" гэж заасны дагуу ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тогтоол (Хавсралт 2.10)-оор ТУЗ-ийн дэргэд а/ Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр Б.Анхболд, У.Наранбаатар, Б.Чулуунсүх б/ Аудит болон эрсдэлийн хорооны гишүүнээр Б.Анхболд, М.Хосокава, Д.Даваа, в/ Стратеги хөгжлийн хорооны гишүүнээр А.Баттамир, Д.Даваа, Г.Лхамсүрэн нарыг томилон ажиллаж байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 81.1-д зааснаар Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно" гэж заасны дагуу Үнэт цаас гаргагч ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийг томилжээ.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| **КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэрс/Шаардлага** | **Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх** | **Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** |
| 1. | **Д.Даваа** (ТУЗ-ийн гишүүн, дарга) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм |

СЗХ 2023 . 11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | /2022.06.06-ны өдөр, Дугаар 0132054/<br><br>(Хавсралт 2.25) | |
| 2. | **У.Наранбаатар** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2010.06.30-ний өдөр/<br><br>(Хавсралт 2.19) | Тийм |
| 3. | **Х.Масахико** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2022.06.27-ны өдөр/<br><br>(Хавсралт 2.33) | Тийм |
| 4. | **Г.Лхамсүрэн** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2014.05.30-ны өдөр, Дугаар 0430290/<br><br>(Хавсралт 2.23) | Тийм |
| 5. | **Б.Чулуунсүх** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2022.06.06-ны өдөр, Дугаар 0132051/<br><br>(Хавсралт 2.24) | Тийм |
| 6. | **А.Баттамир** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2014.05.10-ны өдөр, 0430243/<br><br>(Хавсралт 2.26) | Тийм |
| 7. | **Б.Анхболд** (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм<br><br>/2016.08.25-ны өдрийн Дугаар 0930282/<br><br>(Хавсралт 2.20) | Тийм |



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

00000133

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8. | **Э.Амаржаргал** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2020.06.19-ний өдөр, Дугаар 0731136/ (Хавсралт 2.21) | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Хязгаарлагдмал хариуцлагатай компани ТУЗ-тай байж болох тухай Компанийн тухай хуулийн 75.5-д заасны дагуу тус компанийн ТУЗ нь 7 ердийн гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Компанийн тухай хуулийн 75.4-д зааснаар хувьцаат компани нь 9-оос доошгүй ТУЗ-ийн гишүүнтэй, ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байх шаардлага тавьсан байдаг. Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал нь хувьцаат компани болж хэлбэрээ өөрчлөх анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуульд заасан шаардлага хангасан ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн сонгох асуудлыг авч үзэхээ бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангаж, компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

***Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан***

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх нь 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 02/02 тоот тогтоол (Хавсралт 2.11)-оор, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Амаржаргал нь 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 02/07, 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 02/18 тоот тогтоол (Хавсралт 2.12)-оор, Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд нь 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Гүйцэтгэх захирлын 01/01 тоот тушаал (Хавсралт 2.13)-аар, Ерөнхий нягтлан бодогч Я.Оюунханд нь 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн Гүйцэтгэх захирлын 1912/26 тоот тушаал (Хавсралт 2.14)-аар (2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн жинхэлсэн), Бизнес хөгжил хариуцсан захирал О.Хонгор, Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал Ц.Гомбодорж, Технологи хариуцсан захирал Д.Жанчив, Технологи хариуцсан зөвлөх Д.Даваа, Судалгаа хөгжүүлэлт хариуцсан захирал Б.Чулуунсүх нарыг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А22/0101 тоот тушаал (Хавсралт 2.27)-аар, Үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Хүрэлтогоо 2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн Гүйцэтгэх захирлын А22/0405 тоот тушаал (Хавсралт 2.28)-аар тус тус томилогдон ажиллаж байна. Эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагыг авч үзвэл:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| 1. | **Гомбодожийн Эрдэнэмөнх** (Гүйцэтгэх захирал ) (Хавсралт 2.15) | 2013 онд Австрали улсын Сиднэй хотын Charles Sturt University сургуулийн бизнесийн удирдлагын мэргэжлээр бакалавр; 2016 онд Австрали улсын Сиднэй хотын Macquarie University сургуулийн олон улсын бизнес менежмент | 2014 онд Швейцарын хөгжүүлэлтийн агентлагийн Бизнесийн шинжээч; 2015-2016 онд Reed exhibitions-ын эвент төлөвлөлт, арга хэмжээ хариуцсан Мэргэжилтэн; 2015-2017 онд Австрали улсын Сиднэй хотын Macquarie |



00000134

| | | | |
|---|---|---|---|
| | | мэргэжлээр магистр;<br>2016 онд Австрали улсын Сиднэй хотын Macquarie University сургуулийн олон улсын харилцаа мэргэжлээр магистр. | University сургуулийн Судлаач;<br>2017-2019 онд Моником Экспресс ХХК-ийн Гүйцэтгэх захирал;<br>2019 онд ККТТ ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал;<br>2019 оноос одоог хүртэл ККТТ ХХК-ийн Гүйцэтгэх захирал;<br>2022 оноос одоог хүртэл Инновэйшн Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал. |
| 2. | **Энхболдын Амаржаргал** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) (Хавсралт 2.16) | 2005 онд Соёл-Эрдэм дээд сургуулийг Олон улсын харилцааны сэтгүүлч мэргэжлээр бакалавр. | 2005-2006 онд Жуулчин ХК-д Япон зах зээлийн менежер;<br>2007-2013 онд Бютик-Монгол ХХК-д 3D модел инженер;<br>2013 оны 06 сараас Юнимедиа Солюшнс ХХК-д захиргаа, хүний нөөцийн менежер. |
| 3. | **Баатарсүрэнгийн Энхболд** (Санхүү эрхэлсэн захирал) (Хавсралт 2.17) | 2010 онд Санхүү эдийн засгийн их сургуульд санхүүгийн менежментийн бакалавр. | 2010 - 2014 онд Худалдаа хөгжлийн банкны Санхүүгийн шинжээч;<br>2014 – 2020 онд Худалдаа хөгжлийн банкны Санхүүгийн ахлах шинжээч;<br>2020 оны 10 сарыг дуустал Худалдаа хөгжлийн банкинд Ахлах дилер. |
| 4. | **Ядамсүрэнгийн Оюунханд** (Ерөнхий нягтлан бодогч) (Хавсралт 2.18) | 2003 онд ОУСД сургуулийн гадаад харилцааны бакалавр;<br>2006 онд Удирдлагын академийн бизнесийн удирдлагын магистр;<br>2014 онд Мандах бүртгэл дээд сургуулийн нягтлан бодогч. | 2007 - 2013 онд Техник технологийн дээд сургуулийн тооцооны нягтлан бодогч, хүний нөөцийн менежер, ерөнхий нягтлан бодогч;<br>2013 – 2019 онд Мибостар ХХК-д нягтлан бодогч;<br>2019 оноос одоог хүртэл Инновэйшн Инвестмент ХХК-д ерөнхий нягтлан бодогч. |
| 5. | **Дашзэвэгийн Хүрэлтогоо** (Үйл ажиллагаа хариуцсан захирал) (Хавсралт 2.29) | 2005 онд Монгол Улсын Шинжлэх Ухаан, технологийн их сургуулийг эдийн засгийн математик загварчлал чиглэлээр бакалавр;<br>2018 онд Сингапурт International institute for learning-ийг төслийн удирдлага чиглэлээр. | 2005-2008 онд Ньюком Системс ХХК-д Системийн шинжээч;<br>2008-2009 онд Интерактив ХХК-д Төслийн менежер;<br>2009-2012 онд Интерактив ХХК-д Төсөл хариуцсан захирал;<br>2012-2015 онд Интерактив ХХК-д Төсөл хариуцсан захирал; |

СЗХ
2023 .11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2012-2015 онд Оюу-толгой ХХК-д төслийн ахлах менежер;<br>2015-2022 онд Голомт банкинд Төслийн удирдлагын хэлтсийн ахлах. |
| 6. | **Отгонболдын Хонгор** (Бизнес хөгжил хариуцсан захирал) (Хавсралт 2.30) | 2007 онд Оросын Холбооны Улсын Эрхүү хотын БГУЭП чиглэлээр;<br>2009 онд Эм Ай Ю дээд сургуулийг Бизнесийн удирдлага. | 2012-2014 онд Страйп Пэймент ХХК-д Байгууллагын менежер;<br>2014-2017 онд Нэгдүн ХХК-д Борлуулалт, олон улсын харилцаа, гаалийн бүрдүүлэлт;<br>2017 оноос КKTT ХХК-д Бизнес хөгжил хариуцсан захирал. |
| 7. | **Цэрэнчимэдийн Гомбодорж** (Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал) (Хавсралт 2.31) | 2002-2006 онд Монгол Улсын Багшийн сургуулийн Компьютер, мэдээллийн технологийн сургуулийг бакалавр. | 2008 онд MCP /Microsoft Certified Professional/;<br>2008 онд MCP /Microsoft Certified Professional/ ;<br>2012 онд Ази Номхон Далайн бүс нутгийн IPv6 сүлжээний сургалт /APNIC IPv6/;<br>2013 онд Майкрософтын сертификаттай шийдлийн инженер /MCSE: Server Infrastructure Microsoft Certified Solution Expert/;<br>2016 онд Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалт /IP: Information Technology Passport Examination/;<br>2018 онд ТЕГ-ын Үндэсний Тагнуулын Академийн курс;<br>2019 онд Картын төлбөрийн системийн Аюулгүй байдлын хэрэгжүүлэгч /Payment Card Industry Security Implementer/;<br>2021 онд ISO 27001 Ахлах аудитор. |
| 8. | **Дашцэрэн Жанчив** (Технологи хариуцсан захирал) (Хавсралт 2.32) | 2013 онд Монгол Улсын Шинжлэх Ухаан, технологийн их сургуулийг программ хангамжийн инженер мэргэжлээр бакалавр. | 2012-2016 онд Интерактив ХХК-д программ хөгжүүлэгч, ахлах программ хөгжүүлэгч;<br>2017 оноос хойш КKTT ХХК-д ахлах программ хөгжүүлэгч, технологи хариуцсан захирал. |



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
00000136

| | | | |
|---|---|---|---|
| 9. | **Дамдинсүрэнгийн Даваа** (Технологи хариуцсан зөвлөх) (Хавсралт 2.7) | *Хавсралт 2.7-оос дэлгэрэнгүй харна уу.* | *Хавсралт 2.7-оос дэлгэрэнгүй харна уу.* |
| 10. | **Батзоригийн Чулуунсүх** (Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөх) (Хавсралт 2.6) | *Хавсралт 2.6-аас дэлгэрэнгүй харна уу.* | *Хавсралт 2.6-аас дэлгэрэнгүй харна уу.* |

"ККТТ" ХХК-ийн ажилтан О.Хонгор, Ц.Гомбодорж, Д.Жанчив нар нь Компанид дээр дурдсан албан тушаалд цалин, хөлсгүйгээр зэрэгцсэн хөдөлмөр эрхэлдэг ба нийгмийн даатгалын шимтгэлийг "ККТТ" ХХК дээр төлдөг болохыг Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| № | Нэрс/Шаардлага | Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)* | Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3) |
|---|---|---|---|---|
| 9 | **Г.Эрдэнэмөнх** (Гүйцэтгэх захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |
| 10 | **Б.Энхболд** (Санхүү хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |
| 11 | **Я.Оюунханд** (Ерөнхий нягтлан бодогч) | Үгүй | Үгүй* | Тийм |
| 12 | **Д.Хүрэлтогоо** (Үйл ажиллагаа хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |
| 13 | **О.Хонгор** (Бизнес хөгжил хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |



СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
00000137

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | **Ц.Гомбодорж** (Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |
| 15 | **Д.Жанчив** (Технологи хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх (Хавсралт 2.22) нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан ба компанийн засаглалын болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулах талаар зохих мэдлэг туршлагатай.

Дүгнэвэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

Түүнчлэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд анкет, мэдэгдэл, баталгаа, тохиромжтой этгээдийн асуулгад үндэслэн СЗХ-ноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын 2.1.2-д заасан "мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх, гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх, бизнесийн болон ёс зүйн зөрчилгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх" шаардлага хангасан гэж дүгнэв.

### 3. Үнэт цаас гаргагчийн дотоод, дүрэм журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмын төсөл СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх

***"Инновэйшн инвестмент" ХХК-ийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн тогтоолоор баталж, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулж Улсын бүртгэлд бүртгүүлсэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн дүрэм (цаашид "**Дүрэм**" гэх)-ийг (Хавсралт 1.4) хүчин төгөлдөр мөрдөж байна. Дүрэм нь нийт 18 бүлэгтэй бөгөөд Нийтлэг үндэслэл, Компанийн үйл ажиллагаа явуулах хугацаа, үйл ажиллагааны чиглэл, Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, Компанийн эрх, үүрэг, хариуцлага, Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, Компанийн удирдлага, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Компанийн дотоод хяналт, шалгалт, Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн хариуцлага, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлан, Ногдол ашиг хуваарилах, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Энэхүү Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн болно.

**Компанийн засаглалын журмууд**

Компанийн дүрэм, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан журамд нийцсэн байна. Үүнд:

| № | Журмын нэр | Баталсан этгээд | Огноо | Дугаар | Тайлбар | Хавсралт № |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Компанийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, бодлогыг баримт бичиг** | |
| **1.** | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам | Төлөөлөн удирдах зөвлөл | 2020.08.20 | - | Энэхүү ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хурал хуралдах, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1, 80.4, Компанийн засаглалын Кодексын 5.1.4, 5.2.2-т заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байна. | Хавсралт 3.1 |
| **2.** | Компанийн дотоод | Гүйцэтгэх захирал | 2019.12.03 | 19/1203 | Энэхүү журмаар Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын "Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа"-г нийтэд нь зохицуулах, баримтжуулах, тайлагнах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үйл явцыг зохион байгуулах харилцааг | Хавсралт 3.2 |



СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-09-20 БҮРТГЭВ 0000139

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | журам *(Санхүүгийн үйл ажиллагааны тухай)* | | | | зохицуулсан. Компанийн санхүүгийн дотоод журмын 2.10.3-д "Төлөвлөлтөөс гадна нийт 30.000.000 (гучин сая ) буюу түүнээс дээш төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ /хөрөнгийн худалдан авалт, томоохон хэмжээний гэрээ хэлцэл г.м /-ний мөнгөн зарцуулалтыг "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр тус тус шийдвэрлэж холбогдох баримтын бүрдүүлэлтийг холбогдох ажилтнууд Монгол Улсын Санхүү, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад бодлого, журмын дагуу хийсэн байна" гэж заажээ. | |
| **3.** | Компанийн ногдол ашгийн бодлого | Төлөөлөн удирдах зөвлөл | 2022.03.04 | 02/04 | Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодексд нийцүүлэх тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна | Хавсралт 3.3 |
| **4.** | Дотоод хяналтын журам | Төлөөлөн удирдах зөвлөл | 2022.03.04 | 02/04 | Компанийн хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах буюу дотоод хяналтын ажилтны үйл ажиллагаа, ажиллах зарчим, хяналт шалгалтын чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэр, дотоод хяналтын бодлого, үйл ажиллагаанд зайлшгүй анхаарах асуудлыг Компанийн онцлог тухайн үеийн байдал, хэтийн төлөвт тулгуурлан тодорхойлж зохицуулахаар зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Дотоод хяналтын журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоол, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна. | Хавсралт 3.4 |
| **5.** | Хөдөлмөрийн дотоод журам | Гүйцэтгэх захирал | 2022.01.05 | A22/01 01 | Компанийн Гүйцэтгэх захирал нь хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогч нарын хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, хөдөлмөрийн сахилга хариуцлагын тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх, ажилтнуудын ажлын бүтээмжийг дээшлүүлэхтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэх, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох, ажил олгогч, ажилтны эрх, үүрэг, ажил, амралтын цаг, ээлжийн амралт, түүний хугацаа, ээлжийн амралт олгох, цалин хөлс, нэмэгдэл, ажилтанд олгох тэтгэмж, урамшуулал, хөдөлмөрийн | Хавсралт 3.5 |



СЗХ 2023.11.08
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ 03
0000140
ИННОВЭЙШИН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сахилга, эд хөрөнгийн хариуцлага, нийгмийн даатгалд даатгуулах, дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зохицуулсан.<br><br>Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна. Компанийн тухай хуулийн 83.1, Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байх ба энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.10 дахь заалт, 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байна. | |

***Компани хувьцаат компани болсны дараа хэлэлцэж батлахаар төслөөр сайшаасан компанийн засаглалын журмууд***

Компанийн хэлбэрийг "хязгаарлагдмал хариуцлагатай компани"-аас "нээлттэй хувьцаат компани"-ийн хэлбэрт шилжүүлэх замаар үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотойгоор "Инновэйшн Инвестмент" ХХК нь дараах дүрэм, журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 02/17 тоот тогтоолоор сайшаасан байна (Хавсралт 3.6). Үүнд:

1. ХК-ийн дүрэм /төсөл/
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам /төсөл/
3. ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам /төсөл/
4. ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам /төсөл/
5. ХК-ийн Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам /төсөл/
6. ХК-ийн ногдол ашгийн бодлого /төсөл/

Компанийн нээлттэй компани болох ажлын хүрээнд агуулгын хүрээнд сайшаан баталсан эдгээр журам, бодлогын баримт бичгүүдийн төслүүд нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан журам, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

***Охин компанийн ногдол ашгийн бодлого.***

Үнэт цаас гаргагчийн охин компани "КKTT" ХХК, "Дижитал мерчант сервисэс" ХХК нарын хүчин төгөлдөр Компанийн дүрмийн 8.1-д *"Компанийн ХЭХ-ийн бүрэн эрхийг "Инновэйшн Инвестмент ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ"* гэж, тус дүрмийн 14-р зүйлд ногдол ашиг хуваарилах эсэх, ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгох эсэхийг асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал буюу "Инновэйшн Инвестмент ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тус тус зохицуулсан (Хавсралт 7.1, 7.2, 7.3, 7.4) нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76.1.12-д тус тус нийцсэн байна.

Дүгнэвэл, дээр дурдсан Үнэт цаас гаргагчаас баталж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа дотоод, дүрэм журам болон Компани хувьцаат компани болсны дараа хэлэлцэж батлахаар төслөөр сайшаасан компанийн засаглалын журмууд төсөл нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан Компанийн засаглалын кодекст нийцсэн байна. МДСХ нь СЗХ-ноос баталсан Компанийн засаглалын кодекст заасны дагуу



СЗХ 2023 . 11 сар 08 өдөр БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 20 БҮРТГЭВ
00000141

Шүгэл хүлээх журам, Хүйсийн тэнцвэрийг хангах болон Залгамж халааны бодлогыг цаашид батлан хэрэгжүүлэх, мөн байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан гаргадаг болох нь зүйтэйг Үнэт цаас гаргагчид зөвлөв.

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 1

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03 00000142

2023.11.08

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20

### 4. Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, ээлийн зарцуулах үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

***Онцгой нөхцөл бүхий Гүйцэтгэх захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээ*.** Г.Эрдэнэмөнх нь 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02/02 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол (Хавсралт 2.11)-оор Компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон ба Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.7-д заасны дагуу 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Хөдөлмөрийн контрактын гэрээ байгуулж, улмаар тус гэрээний хугацаа дууссан тул 2023 онд "Онцгой нөхцөл бүхий Гүйцэтгэх захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээ" (Хавсралт 4.1)-г Компанитай байгуулсан байна. Энэхүү гэрээг гурван жилийн хугацаатай байгуулсан бөгөөд гэрээгээр гэрээний зүйл, гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, цалин олгох, ажил дүгнэх, шагнах, урамшуулах нөхцөл, нууцлал, гэрээг дуусгавар болгох, цуцлах, хариуцлага тооцох болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ нь 2022 оны 01-р сарын 01-ээс хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарах тул тус зохицуулалтад тавьсан шаардлагад нийцсэн байна.

***Хувьцаа эзэмшигчдийн хоорондын гэрээ.*** (Хавсралт 4.2) 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн хоорондын гэрээгээр Компанийн хувьцаа эзэмшигчийн хувиар эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлох, Компанид цаашид хөрөнгө оруулах, Компанийн үйл ажиллагааг явуулах, удирдан зохион байгуулах харилцааг зохицуулсан.

Компани нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 16 хувьцаа эзэмшигчтэй байх ба нийт 16 хувьцаа эзэмшигчдийн хооронд хувьцаа эзэмшигчдийн хоорондын гэрээг байгуулсан нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2018 онд баталсан Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журмын 6.3-д заасан гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх баримт бичигт хавсаргах "хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран байгуулсан бол хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ"-тэй байх шаардлагыг хангаж байна.

***Опцион хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ.*** Инновэйшн инвестмент ХХК болон Юнимедиа Солюшнс ХХК нарын хооронд Компанийн бизнесийг өргөжүүлэх үүднээс хамтрах, Компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах тухай гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хурлын "Зарласан боловч гаргаагүй хувьцаанаас Юнимедиа Солюшнс ХХК-д эзэмшүүлэх опцион нөхцөлийг тогтоох, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай" 22/05 тоот шийдвэрээр Компанийн зарласан боловч гаргаагүй 52,126,000.00 (тавин хоёр сая нэг зуун хорин зургаан мянга) ширхэг хувьцаанаас "Юнимедиа Солюшнс" ХХК-д 17,116,000.00 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг хувьцааг опцион хөтөлбөрөөр шилжүүлэхээр тохиролцсон (Хавсралт 4.3).

*<u>Опцион эрх шилжүүлэх гэрээ</u>*

"Юнимедиа Солюшнс" ХХК нь Инновэйшн инвестмент ХХК-ийн 17,116,000.00 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг опционыг Компанийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу "КТТТ" ХХК-д шилжүүлэх, түүнтэй холбоотой опционы төлбөрийг хүлээн авах харилцааг зохицуулсан "Опцион эрх шилжүүлэх



00000143

СЗХ
2023 он 11 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20

гэрээ"-г 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр КKTT XXK болон Үнэт цаас гаргагчтай байгуулсан байна. (Хавсралт 4.3)

Опцион эрх шилжүүлэх гэрээгээр дараах нөхцөлийг харилцан тохиролцсон байгаа нь Иргэний хуульд нийцсэн байна. Үүнд:

- "Юнимедиа Солюшнс" XXK өөрийн Инновэйшн инвестмент XXK-ийн 17,116,000.00 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг опционыг нийт XXX төгрөгөөр КKTT XXK-д худалдах, шилжүүлэхийг зөвшөөрсөн;
- "Юнимедиа Солюшнс" XXK болон Инновэйшн инвестмент XXK-ийн хооронд байгуулсан 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах гэрээ, 2022 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн "Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах тухай 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр байгуулагдсан 18-0022 тоот гэрээний нэмэлт өөрчлөлт" гэрээг тус тус дуусгавар болсонд тооцсон.

Опцион эрх шилжүүлэхтэй холбоотойгоор 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Инновэйшн инвестмент XXK-ийн ХЭХ-ын 23/07, 23/04 тоот тогтоолоор тус тус "Юнимедиа Солюшнс" XXK өөрийн Инновэйшн инвестмент XXK-ийн 17,116,000.00 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг опционыг нийт XXX төгрөгөөр КKTT XXK-д худалдах, шилжүүлэхийг зөвшөөрч, үүнтэй холбоотой компанийн дүрэмд өөрчлөлт оруулан 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байна.

*<u>Опцион эрх хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ</u>*

"КKTT" XXK-ийн цор ганц хувьцаа эзэмшигч "Инновэйшн инвестмент" XXK-ийн 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/12 тоот тогтоол (Хавсралт 1.11)-оор опцион эрх хэрэгжүүлэх болон, уг эрхийг хэрэгжүүлснээр эзэмших хувьцаанаас нийтэд санал болгон гаргахтай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх эрхийг "Инновэйшн Инвестмент" XXK-ийн Гүйцэтгэх захирал Гомбодорж овогтой Эрдэнэмөнхөд олгосон. Тус бүрэн эрхийн үндсэн дээр Үнэт цаас гаргагчийн охин компани болох "КKTT" XXK-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/02 дугаартай шийдвэр (Хавсралт 4.11)-ээр опцион эрх хэрэгжүүлэх, "Инновэйшн Инвестмент" XXK-ийн 17,116,000 ширхэг хувьцааг гаргахаар шийдвэрлэжээ.

Ийнхүү "Инновэйшн Инвестмент" XXK болон КKTT XXK-ийн нарын хооронд хувьцаа захиалгын гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ 2023 оны 6 сарын 21-ний өдөр байгуулсан байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Дүрмээс харвал КKTT XXK нь "Инновэйшн Инвестмент" XXK-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн байна (Хавсралт 1.4).

***Зээлийн гэрээнүүд:***

Компани нь гуравдагч этгээдээс авсан зээл, зээлийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн аливаа гэрээ байхгүй ба энэ талаар Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаанаас үзвэл аливаа зээлийн үлдэгдэлгүй (Хавсралт 4.10) байна.

***Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ байгуулсан эсэхэд дүн шинжилгээ хийлээ.



INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
XXK
00000144

Компани нь энэ хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 3 удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүнг дараах байдлаар тооцож, тийм дүн бүхий гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлтийг дор дурдсанаар тодорхойлов. Үүнд:

*Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл.*

| № | Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа/ | 2019.03.28-2019.11.13 | 2019.11.14-2019.12.11 | 2019.12.12 – 2023.06 | 2023.06 сараас одоог |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөгөөр/ | 1,501,000,000 | 2,501,000,000 | 3,501,000,000 | 3,928,900,000 |
| 2. | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь /төгрөгөөр/ | 75,050,000 | 125,050,000 | 175,050,000 | 196,445,000 |
| 3. | Нийт байгуулсан гэрээ | 0 | 0 | 0 | 0 |
| 4. | Хэрэгжиж байгаа гэрээ | 0 | 0 | 0 | 0 |

Ийнхүү Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ байгуулаагүй байна (Хавсралт 12.1).

***Түрээсийн гэрээ:***

***Түрээсийн гэрээ.*** (Хавсралт 4.4) Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Дижитал мерчант сервисэс" ХХК нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол /14210/, Элчингийн гудамж-14, Шүрэн барилга, 1-р орц, 1 давхар, 6 тоот хаягт байрлах барилгын 1 давхрын нийт 211.7 мкв талбайг 3 жилийн хугацаатайгаар түрээслэх зорилгоор Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд "Шүрэн Хаус" ХХК-тай 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Түрээсийн гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээгээр ерөнхий нөхцөл, түрээсийн төлбөр, талуудын эрх, үүрэг, хариуцлага, түүнээс чөлөөлөх, маргаан шийдвэрлэх журам зэргийг зохицуулсан байна. Түрээсийн гэрээний 5.3-т дамжуулан түрээслэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ба "Түрээслэгч нь түрээсийн байрыг бүхэлд нь буюу түүний аль нэг хэсэг, түрээсийн байртай холбогдох ашиг сонирхлыг дор дурдсанаас бусад тохиолдолд энэхүү Түрээсийн гэрээний тал болоогүй этгээдэд хөлслүүлэх буюу бусад ямар нэгэн байдлаар шилжүүлэхгүй. Үүнд: Түрээслэгч нь хоёр буюу түүнээс дээш харилцан хамаарал бүхий хуулийн этгээд байх тохиолдолд ........" гэжээ. Үүнээс харвал энэхүү гэрээг Үнэт цаас гаргагчийн охин компанитай байгуулсан хэдий ч Үнэт цаас гаргагч уг түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой, Уг Түрээсийн гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд нийцсэн байна.

***Түрээсийн гэрээ.*** (Хавсралт 4.13) Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Дижитал мерчант сервисэс" ХХК нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол /14210/, Элчингийн гудамж-14, Шүрэн барилга, 1-р орц, 1 давхар, 7 тоот хаягт байрлах барилгын 1 давхрын нийт ***80*** м.кв талбайг 2022 оны 03-р сарын 22-ны өдрөөс 2024 оны 01-р сарын 29-ний өдрийг дуустал хугацаатайгаар түрээслэх зорилгоор Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд "Шүрэн Хаус" ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 22/5 тоот "Түрээсийн гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээгээр ерөнхий нөхцөл, түрээсийн төлбөр, талуудын эрх, үүрэг, хариуцлага, түүнээс чөлөөлөх, маргаан шийдвэрлэх журам зэргийг зохицуулсан байна. Түрээсийн гэрээний 5.3-т дамжуулан түрээслэхтэй холбоотой харилцааг зохицуулсан ба "Түрээслэгч нь түрээсийн байрыг бүхэлд нь буюу түүний аль нэг хэсэг, түрээсийн байртай холбогдох ашиг сонирхлыг дор дурдсанаас бусад тохиолдолд энэхүү Түрээсийн гэрээний тал



00000145

болоогүй этгээдэд хөлслүүлэх буюу бусад ямар нэгэн байдлаар шилжүүлэхгүй. Үүнд: Түрээслэгч нь хоёр буюу түүнээс дээш харилцан хамаарал бүхий хуулийн этгээд байх тохиолдолд ........" гэжээ. Үүнээс харвал энэхүү гэрээг Үнэт цаас гаргагчийн охин компанитай байгуулсан хэдий ч Үнэт цаас гаргагч уг түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой, Уг Түрээсийн гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд нийцсэн байна.

***Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:***

***Хөдөлмөрийн гэрээний загвар***. (Хавсралт 4.5) "Инновэйшн Инвестмент" ХХК болон ажилтантай байгуулах Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хууль болон, компанийн дотоод журмыг үндэслэн боловсруулжээ. Энэхүү гэрээгээр Ажилтан болон Ажил олгогчоос олгосон албан тушаалын хүрээнд түүний заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр энэхүү гэрээ болон гэрээний хавсралт болох Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн дотоод журам, дүрэмд заасан ажил үүргийг гүйцэтгэх, Ажил олгогч нь Ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин, хөлс олгохтой холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулсан байна.

***Үнэт цаас гаргахтай холбоотой бусад гэрээ:***

***Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ.*** Инновэйшн инвестмент ХХК-ийн бизнесийн үнэлгээг тус компанийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр анх удаа олон нийтэд санал болгох зориулалтаар Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын хүрээнд Үнэлгээний олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэх харилцааг "Инновэйшн Инвестмент" ХХК болон "Гэрэгэ-Эстимэйт" ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.6)-ээр зохицуулсан байна. Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээнд бизнесийн үнэлгээний зориулалт, үнэлгээний зүйл, талуудын эрх үүрэг, бизнесийн үнэлгээний хөлс, бизнесийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгасан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.16 дахь заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 6.3 дахь хэсэгт нийцсэн байна.

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02/11 тоот тогтоол (Хавсралт 4.6)-ын дагуу гэрээ байгуулсан нь аливаа хууль зүйн зөрчилгүй байна.

***Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** "Инновэйшн Инвестмент" ХХК"-ийн гаргах үнэт цаасны танилцуулгад аудит хийх, тодорхойлох захидал гаргах аудитын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг "Грант Торнтон Аудит" ХХК (http://www.frc.mn/o/101)-тай 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан 2022/30 дугаар "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.7-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хамрах хүрээ, гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөл, үр дүнг хүлээлгэн өгөх, нууцлал, давагдашгүй хүчин зүйл, гэрээг дуусгавар болгох, маргаан шийдвэрлэх журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

***Үйлчилгээ үзүүлэх гэрээ /аудит/ (Хавсралт 4.14).*** "Инновэйшн инвестмент" ХХК-ид IPO гаргахтай холбоотой тодорхойлох захидал гаргахтай холбоотой харилцааг "Грант Тронтон Аудит" ХХК (РД: 2577542, тусгай зөвшөөрлийн дугаар: 020-1999, http://www.frc.mn/o/101)-тай 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан 2023/20 дугаар "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6 дахь хэсэг, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.17-д заасан "үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн тайлан үнэн зөв эсэх"



00000146

талаар дүгнэлт, тодорхойлох захидал гаргаж өгөх ажил үйлчилгээг үзүүлэхээр тохиролцсон нь холбогдох журамд нийцсэн байна.

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02/10 тоот тогтоол (Хавсралт 4.14)-ын дагуу гэрээ байгуулсан нь аливаа хууль зүйн зөрчилгүй байна.

***Андеррайтерийн үйлчилгээний гэрээ /үндсэн андеррайтер/ (Хавсралт 4.8).*** Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржид анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулах, андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан АГ-23/17 тоот "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-г 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК (тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 3/42 дугаар http://www.frc.mn/#/sct/org-detail/9011125147 , 5183855 регистрийн дугаартай)-тай байгуулсан. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигч, түүний үүрэг, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн 9 бүлгээс бүрдэж байна.

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд "Андеррайтер"-аар хамтран ажиллахаар тохиролцсон. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.5 дахь хэсэг, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь Үнэт цаас гаргагчтай холбогдох этгээд биш байна.

***Хамтын ажиллагааны гэрээ /туслах андеррайтер/ (Хавсралт 4.15).*** Үнэт цаасны зах зээлийн тухай 41.5 дэх хэсэг, СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.6 дахь хэсэг, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч, үндсэн андеррайтер нь туслах андеррайтераар "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийг сонгож, үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагааг хамтран хэрэгжүүлж зөвшөөрч, тохиролцсон байна.

Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн өөрийн эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэрт заасан нөхцөлөөр энгийн хувьцаа гарган, МХБ-р дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох, худалдах үйл ажиллагааг амжилттай болгох зорилгоор Үндсэн Андеррайтерийн зүгээс Туслах Андеррайтертай хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх үүсэх харилцааг зохицуулсан 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ХАГ_230613/01 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г "Инвескор Капитал ҮЦК" ХХК (РД:6317839, тусгай зөвшөөрлийн дугаар: 301/113 http://www.frc.mn/#/sct/org-detail/9011741137 ) -тай байгуулсан байна.

Энэхүү гэрээнд үндсэн болон туслах андеррайтерийн хүлээх үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа, анхдагч зах зээлд нийтэд санал болгон гаргах хувьцааны захиалгыг бүрдүүлэх аргачлал, хөрөнгө оруулагчдад хэрхэн сурталчлах, хувьцааг хуваарилах зарчим, андеррайтерийн үйлчилгээний төлбөр хуваарилалт зэргийг тусгасан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэг, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02/12 тоот тогтоол (Хавсралт 4.16)-оор үндсэн андеррайтераар "Өлзий энд Ко капитал ҮЦК", туслах андеррайтераар "Инвескор капитал ҮЦК" ХХК-ийг сонгож, түүний дагуу гэрээ байгуулсан нь аливаа хууль зүйн зөрчилгүй байна.

***Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ*** (Хавсралт 4.17). Үнэт цаас гаргагч нь 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдөр СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8-р зүйлд заасныг баримтлан Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгаа хувьцааны үнийг тогтворжуулах харилцааг зохицуулах зорилгоор ҮТГ_230628/01 дугаар "Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ"-г үндсэн андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК, туслах андеррайтер "Инвескор капитал ҮЦК" ХХК-тай байгуулжээ. Энэхүү гэрээгээр үнэ тогтворжуулах ажиллагааг Үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцсон нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1, 8.2-д нийцсэн байна.

***Ажил гүйцэтгэх гэрээ*** (Хавсралт 4.9). 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн ТУЗ-ийн 02/19 дугаар тогтоолын үндсэн дээр хувьцаагаа анх удаа нийтэд санал болгохтой холбоотойгоор маркетингийн зөвлөх үйлчилгээ авахаар "Бат солюшн партнерс" ХХК-ийг сонгон 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр талуудын эрх, үүрэг, гүйцэтгэх ажил, хугацаа, төлбөр тооцоо, ажил хүлээлцэх, уран бүтээлийн ажлын онцлог ба зохиогчийн эрх, талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх харилцааг зохицуулсан 2022/01 дугаар Ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд нийцсэн байна.

## 5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд байгуулсан дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | “Юнимедиа Солюшнс” ХХК | “Инновэйшн инвестмент” ХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02/10 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажил үйлчилгээг Юнимедиа солюшнс ХХК үзүүлэх, түүнтэй холбоотой хөлс төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 20/26 тоот хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.1) талууд байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 2. | КKTT ХХК | “Инновэйшн инвестмент” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/14 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу компанид менежмент, удирдлага, мэргэжлийн зөвлөгөө өгөх, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.2)-г “КKTT” ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 3. | Б.Чулуунсүх | “Инновэйшн инвестмент” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/13 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу компанийн нийтэд хувьцаагаа санал | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болгохтой холбоотой ажилд туслах, зөвлөх, компанийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудалд зөвлөх үйлчилгээтэй холбоотой үүссэн харилцааг зохицуулахаар Зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.3)-г Б.Чулуунсүхтэй 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна. | | | |
| 4. | КKТТ ХХК, "Юнимедиа Солюшнс" ХХК | 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Инновэйшн инвестмент ХХК-ийн ХЭХ-ын 23/04 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу "Опцион эрх шилжүүлэх гэрээ"-г 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр (Хавсралт 4.3) байгуулсан. *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс харна уу.)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж дууссан |
| 5. | Б.Энхболд | "Инновэйшн инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/15 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу 10,000,000 төгрөгийг 24 сарын хугацаатай зээлэх, зээлийг тогтоосон хугацаанд хүү, шимтгэлийн хамт буцаан төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан Зээлийн гэрээ (Хавсралт 5.4)-г 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 5 хэлцэл байгуулсан бөгөөд дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гаргаагүй байна (Хавсралт 12.1). Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журам болон Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ (ХЭХ)-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна. Эдгээр 5 хэлцлээс Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 4 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа, бусад нь хэрэгжиж дууссан байна

***Их хэмжээний хэлцлийн талаар:***

Компанийн тухай хуулийн 87-д зааснаар их хэмжээний хэлцэл нь сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% буюу Компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн актив, түүнд ногдох их хэмжээний хэлцлийн үнийн дүн дараах байдлаар байна:

- 2020 оны хэлцэл - 581,305,895.25 төгрөгөөс дээш (2019 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 2,325,223,581)

- 2021 оны хэлцэл – 513,570,250 төгрөгөөс дээш (2020 оны санхүүгийн тайлан нийт 2,054,281,000)
- 2022 оны хэлцэл - 808,510,000 төгрөгөөс дээш (2021 оны санхүүгийн тайлан нийт 3,234,040,000)
- 2023 оны хэлцэл – 1,689,021,750 төгрөгөөс дээш (2022 оны санхүүгийн тайлан нийт 6,756,087,000)

Компани сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).



00000151

2023 11 08

## 6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бий эсэх

***Тусгай зөвшөөрөл.***

"Инновэйшн Инвестмент" ХХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар аливаа байдлаар аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байна (Хавсралт 12.1).

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК нь төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар Монголбанкны 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-291 дугаар Ерөнхийлөгчийн тушаалаар (Хавсралт 6.1), хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг 4 жилийн хугацаатайгаар Монголбанкны 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А-139 дугаар Ерөнхийлөгчийн тушаалаар (Хавсралт 6.2), аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг тус тус олгосон. Мөн "ККТТ" ХХК нь өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан "QR code-оор мэдээлэл солилцох програм" нэртэй программ хангамжийн бүтээлийн зохиогчийн эрхийн гэрчилгээ өмчлөгч (Хавсралт 6.3) байна.

Монголбанкны 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Б-10/544 тоот албан бичиг (Хавсралт 6.7)-т тусгаснаар Монголбанкнаас "ККТТ" ХХК-д дараах гурван төрлийн зөвшөөрлийг олгосон байна.

1. Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл хугацаагаар 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр олгосон байна.
2. Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаагаар 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр олгосон байна.
3. Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 2026 оны 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл хугацаагаар 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр олгосон байна.

Мөн "ККТТ" ХХК нь зөвшөөрөл эзэмшиж байх хугацаандаа хууль тогтоомж зөрчиж хариуцлага хүлээж байгаагүй байна.

***Оюуны өмч.***

2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан (https://publish.ipom.mn/) (Хавсралт 6.4), зохиогчийн эрхийн хайлтын систем (http://copyright.ipom.mn/) -с тус тус хайлт хийхэд "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдэг, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй (Хавсралт 12.1) бөгөөд Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой нөлөөлж болох, эсхүл бусдын эрхээр хязгаарлагдсан нөхцөл илрээгүй болно.

***Домэйн нэр.*** Компанийн www.i-investment.mn домэйн нэр нь 2024 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хүчинтэй байна (Хавсралт 6.5, 12.1).

Дээр дурдсаны дагуу Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэггүй ба аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээх зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бий болоогүй байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК
00000152

7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх

*Хувьцаа:*

Компани нь дараах компанийн хувьцааг эзэмшдэг ба аливаа өөр үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус Компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1). Үүнд:

| **"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХХК** | | | |
|---|---|---|---|
| **№** | **Компанийн нэр** | **Хувь хэмжээ** | **Зээлийн гэрээний дагуу барьцаалагдсан эсэх** |
| **ОХИН КОМПАНИ** | | | |
| 1. | **"ККТТ" ХХК**<br>/РД: 5395305, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Компанийн дүрэм, 000003662 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ/<br>(Хавсралт 7.1, Хавсралт 7.2) | 100% | - |
| 2. | **"Дижитал мерчант сервисэс" ХХК**<br>/РД: 6450164, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Компанийн дүрэм, 000188029 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ/<br>(Хавсралт 7.3, Хавсралт 7.4) | 100% | - |

***Үнэт цаас, өрийн хэрэгсэл***

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1164 тоот албан бичиг (Хавсралт 7.9)-т тусгаснаар "Инновэйшн Инвестмент" ХХК нь 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар гуравдагч компанийн аливаа үнэт цаас эзэмшээгүй, сүүлийн 3 жилд арилжаа эрлэх байгууллагад болон Арилжаа эрхлэгчдийн холбооны биржийн бус зах зээлд бүртгүүлэн гаргасан хаалттай болон нээлттэй өрийн хэрэгсэл, бусад үнэт цаас байхгүй болно.

***Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө*** (Хавсралт 7.5)

2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар хөдлөх эд хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгө барьцаалсан бүртгэл байхгүй байна.

***Тээврийн хэрэгсэл.*** 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 591 тоот Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаанаас (Хавсралт 7.6) үзвэл Компани нь 203 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар тээврийн хэрэгсэл өмчлөөгүй байна.

***Газар эзэмших эрх.*** Үнэт цаас гаргагч нь газар өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл авсан эсэх тухай лавлагаа хүсэхээр Компанийн Гүйцэтгэх захирал 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр



СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
00000153

2023/04 тоот албан бичиг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн байна (Хавсралт 7.7). Дүгнэлт гарах өдрийн байдлаар лавлагааны хариу ирээгүй байна. Компанийн Гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 12.1)-ээс үзвэл Компани нь аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй болно.

4.2. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

4.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмших хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Үнэ /төгрөгөөр/ | | |
| | | | Нэгжийн үнэ | Бүгд | |
| 1 | "Ай Си Ти Групп" ХК | 34,159,320 | 25 | 853,983,000 | 21.74% |
| 2 | Дамдинсүрэн Даваа | 9,108,747 | 25 | 227,718,675 | 5.80% |
| 3 | Чойжоохүү Нарангэрэл | 16,597,400 | 25 | 414,935,000 | 10.56% |
| 4 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 15,560,000 | 25 | 389,000,000 | 9.90% |
| 5 | "Айкор Партнерс" ХХК | 14,028,800 | 25 | 350,720,000 | 8.93% |
| 6 | "Рентракс" ХК | 10,373,400 | 25 | 259,335,000 | 6.60% |
| 7 | Батзориг Чулуунсүх | 8,900,267 | 25 | 222,506,675 | 5.66% |
| 8 | Шаравхорол Эрдэнэбилэг | 8,370,200 | 25 | 209,255,000 | 5.33% |
| 9 | "Могул" ХХК | 7,482,200 | 25 | 187,055,000 | 4.76% |
| 10 | Масанори Окоши | 3,945,000 | 25 | 98,625,000 | 2.51% |
| 11 | "НОБ" ХХК | 2,593,400 | 25 | 64,835,000 | 1.65% |
| 12 | "Глобал Траст Нетворкс" ХК | 2,593,400 | 25 | 64,835,000 | 1.65% |
| 13 | Шоичиро Ичитани | 2,593,400 | 25 | 64,835,000 | 1.65% |



242

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | Такахиро Ичики | 2,593,400 | 25 | 64,835,000 | 1.65% |
| 15 | Мөнхчулуун Мөнхбаяр | 1,141,066 | 25 | 28,526,650 | 0.72% |
| 16 | ККТТ ХХК | 17,116,000 | 25 | 427,900,000 | 10.89% |
| | **Нийт дүн** | **157,156,000** | **25** | **3,928,900,000** | **100.00%** |

/Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлын 23/13 тоот тогтоолоор өөрчлөн найруулав/

4.4. Дүрмийн 4.1-д заасан зарласан боловч гаргаагүй хувьцаанаас дараах зориулалтаар эргэлтэнд гаргаж болно. Үүнд:

4.4.1. Олон нийтэд санал болгох зориулалттай зарласан хувьцааны тоо 35,010,000.00 (гучин таван сая арван мянга) ширхэг;

4.5. Дүрмийн 4.3-т заасан талуудын хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бичгэн шийдвэрийн дагуу өөрчлөгдөж болно.

4.6. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуульд заасан арга хэлбэрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулж болно.

4.7. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд компанийн гүйцэтгэх захирал ийнхүү багассан шалтгааныг судлан дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багасгах (хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар) тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

4.8. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

4.9. Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахдаа хувьцаа эзэмшигчтэй харилцан тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

## 5. КОМПАНИЙН ЭРХ

5.1. Компани нь үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тамга тэмдэг, компанийн логотой байна.

5.3. Компани үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд явуулах эрхтэй.

5.4. Компани нь өөрийн тусгайлсан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ.

5.5. Компани нь шүүхийн өмнө нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд болж оролцох эрхтэй.

5.6. Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу хараат болон охин компани байгуулах эрхтэй.

5.7. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай боловсон хүчнийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийг тогтоох эрхтэй.

5.8. Компани хууль тогтоомжоор хамгаалагдсан байгууллагын нууцад хамаарах мэдээллийг нууцлах эрхтэй.

## 6. КОМПАНИЙН ҮҮРЭГ

6.1. Компани нь энэхүү дүрмийн 3-р зүйлийн 3.1-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэх үүрэгтэй.

СЗХ 2023.11.08

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ

INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

00000184

6.2. Компани нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" , "Аудитын тухай хууль"-д заасны дагуу нягтлан бодохын болон анхан шатны дэлгэрэнгүй бүртгэлийн хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулах үүрэгтэй.

6.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулиудын дагуу орлого татвараа тодорхойлж, сайн дураар төлөх үүрэгтэй.

6.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжоор шаардагдсан шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.

6.5. Компани нь өөрийн ажилчдын өмнө хууль тогтоомжоор болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

6.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

6.7. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтүүдийг танилцуулах үүрэгтэй.

6.8. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулж, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

## 7. КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

7.2. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд зөвхөн өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

7.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 85-р зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

7.4. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

## 8. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

8.1.1. Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

8.1.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;

8.1.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;

8.1.4. Компаниас нэмж гаргах буюу бусад хувьцаа эзэмшигчдийн худалдах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;

8.1.5. Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээллэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах;

8.1.6. Компанийн хувьцаа эзэмшигч нь хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тодорхойлсон бусад эрхийг эдэлнэ;

8.2. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

8.2.1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр мэдэгдэх;

8.2.2. Компанийн нууцад хамаарах мэдээллийг хадгалах;

00000185

СЭХ
2023.11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-07-20

8.2.3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцааг зөвхөн компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж буй хувьцаатай нь хувь тэнцүүлэн худалдах буюу шилжүүлэх үүрэгтэй. Ийнхүү худалдах буюу шилжүүлэх талаар хувьцаа эзэмшигчид харилцан тохиролцож чадаагүй бол саналын эрх бүхий хувьцааны дийлэнх олонхи буюу гуравны хоёроос дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн тохиолдолд хувьцааг гуравдагч этгээдэд шилжүүлж болно. Саналын эрх бүхий хувьцааны дийлэнх олонхийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид зөвшөөрөөгүй тохиолдолд хувьцааг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно;

8.2.4. Хууль тогтоомжоор болон энэхүү дүрмээр хүлээсэн бусад үүрэг;

## 9. КОМПАНИЙН УДИРДЛАГА

9.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "**ХЭХ**" гэх) байна.

9.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

9.2.2. Компанийг нийлэх, нэгдэх хуваах, тусгаарлах хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

9.2.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох

9.2.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;

9.2.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

9.2.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

9.2.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

9.2.8. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

9.2.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

9.2.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

9.2.11. Компанийн тухай хууль, компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал;

9.2.12. Энэхүү дүрмийн 9.2.1-9.2.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ; /Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын 23/10 тоот тогтоолоор өөрчлөн найруулав/

9.2.13. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцсэн бусад асуудлыг Компанийн тухай хууль ба Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, компанийн дүрэмд заасан журам нөхцөлийн дагуу шийдвэрлэнэ;

## 10. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

10.1. Хувьцаа эзэмшигч нь өөрөө биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулж ХЭХ-д оролцоно. Төлөөлөгчөөрөө дамжуулж оролцож байгаа тохиолдолд хуулийн дагуу олгосон итгэмжлэлтэй байна.

10.2. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ:

10.2.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ

00000186

10.2.2. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;

10.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;

10.2.4. Хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллээр хангах;

10.3. Компанийн ХЭХ нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

10.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулна.

10.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө хурал хуралдах огноо, цаг, газар болон хурлаар хэлэлцэх асуудлын дэлгэрэнгүй мэдээллийг монгол хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн байна.

10.6. ХЭХ хуралдуулахтай холбоотой гарсан бүх зардлыг компани хариуцна.

10.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон шийдвэрийг Монгол хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдийн хурал болсноос хойш хуанлийн 10 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч бүх хурлын тэмдэглэл, шийдвэрт гарын үсэг зурна. Хэрэв хурлын шийдвэрт санал нийлэхгүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд 10 хоногийн дотор үндэслэл бүхий тайлбарын хамт тэмдэглэл, шийдвэрийг буцаана. Тайлбарыг авснаас хойш 20 хоногийн дотор санал нийлэхгүй асуудлаар дахин нэг удаа хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах бөгөөд хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэлд гишүүн гарын үсэг зурахаас дахин татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

10.8. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид хурлын тэмдэглэл, шийдвэр нь үнэн зөв бол хүлээн зөвшөөрч гарын үсэг зурна. Үнэн зөв шийдвэр, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан хувьцаа эзэмшигч нь татгалзсан үндэслэл, шалтгаанаа тэмдэглэлд бичнэ.

10.9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахад Компанийн тухай хуулийн 61-р зүйлд заасан журмыг баримтална.

10.10. Компанийн саналын эрх бүхий хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын ердийн олонх (биечлэн, телеконференц буюу видео конференцийн хэлбэрээр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан) оролцсоноор хурлын ирц хүчинтэйд тооцогдоно.

10.11. Хуульд өөрөөр заагаагүй бол ХЭХ-аар шийдвэрлэх аливаа асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын ердийн олонхи дэмжсэнээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байна.

## 11. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

11.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэнэ/ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хорооны чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн

00000187

засаглалын кодексийн зарчимд нийцсэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ-ийн хурлаар батлан мөрдүүлнэ.

11.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт долоон (7) гишүүнтэй байна.

11.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа тав (5) жил байна.

11.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг ТУЗ томилно.

11.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дийлэнх олонхи гишүүд хуралд ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэй гэж үзнэ.

11.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

11.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

11.7.1. Компанийн үндсэн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоож, компанийн бизнес төлөвлөгөөг батлах;

11.7.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

11.7.3. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх болон түүний бүрэн эрхийг тогтоох;

11.7.4. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

11.7.5. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

11.7.6. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

11.7.7. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

11.7.8. Компани нь охин компани, хараат компани, салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

11.7.9. Бусад компанид хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

11.7.10. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

11.7.11. Монгол Улсын компанийн тухай хуулийн 11-р бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх, 12-р бүлэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

11.7.12. Компанийн тухай хууль, компанийн дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх;

11.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг (1) удаа хийх ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн аль нэгний болон гүйцэтгэх удирдлагын санаачилгаар ээлжит бус хурлыг хэзээ ч зарлан хуралдуулж болно.

11.9. Төлөөлөн удирдах зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно.

11.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82-р зүйлд заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

## 12. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

12.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

12.2. Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, гэрээ байгуулна.

12.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ, түүнийг төлөөлж ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

12.4. Гүйцэтгэх удирдлага нь өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

12.4.1. Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

12.4.2. Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, албан тушаалтантай харилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах;

12.4.3. Шүүх төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, бусад аливаа этгээдийн өмнө компанийг төлөөлөх;

12.4.4. Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

12.4.5. Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, биелэлтийг хангах;

12.4.6. Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бараа материал, ажил үйлчилгээг худалдан авах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах;

12.4.7. Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зөвшөөрөл, гэрчилгээ зэргийг хууль тогтоомжийн дагуу авах ажлыг зохион байгуулах;

12.4.8. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулж ТУЗ-ийн хуралд танилцуулах;

12.4.9. Монгол Улсын хууль тогтоомж болон ХЭХ-ын шийдвэрийн биелэлтийг хариуцан зохион байгуулах;

12.4.10. Компани, түүний бүтэц, зохион байгуулалт, цалингийн сангийн хэмжээний талаар санал боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдыг авч ажилуулах;

12.4.11. Компанийн хөрөнгө устгах, үрэгдэх, алдагдал, дутагдалд орох зэргээр аливаа хөрөнгийн эрсдэлээс боломжит бүх арга хэрэгслийг ашиглан сэргийлэх;

12.4.12. Хувьцаа эзэмшигчдийг компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах;

12.4.13. Компанид бий болсон үйл ажиллагааны болон санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал, эрсдэл, зөрчлийг хувьцаа эзэмшигчдэд нэн даруй хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;

12.4.14. Монгол Улсын хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан бусад эрх, үүргүүд;

12.5. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас бичгээр олгогдсон зөвшөөрөлгүйгээр компанийн болон бусад хуулийн этгээдийн удирдах дээд байгууллагын гишүүнээр сонгогдох, ажиллах эрхгүй.

## 13. КОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

13.1. Компанийн санхүүгийн тооцоонд компанийн дотоод хяналтын алба/ажилтан хяналт тавина.

13.2. Дотоод хяналтын албаны дарга/ажилтан болон гишүүдийг ТУЗ-өөс 3 жилийн хугацаатай томилно.

13.3. Дотоод хяналтын алба/ажилтныг хувьцаа эзэмшигчдийн ажилтнуудаас сонгох ба тэдгээр нь компанийн эрх барих байгууллагуудын удирдах албан тушаалтан байж болохгүй.

13.4. Дотоод хяналтын алба/ажилтнаас хийх шалгалт нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

СЭХ 2023.11.08

2023-07-20

INNOVATION INVESTMENT LLC

00000189

242

13.5. Дотоод хяналтын алба/ажилтан нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд жилд нэг удаа ээлжит шалгалт хийнэ. Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр дотоод аудитын алба нь ээлжит бус шалгалтыг хийж болно.

13.6. Дотоод хяналтын алба/ажилтан нь компанийн албан тушаалтнуудаас шаардлагатай бүх материалуудыг үүнд нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн баримтууд, тайлан тооцоо, албан бичиг гэх мэтийг шаардан гаргуулах эрхтэй.

13.7. Дотоод хяналтын алба/ажилтан нь өөрийн хийсэн шалгалтын үр дүнгийн талаар ТУЗ-ийн хуралд танилцуулах үүрэгтэй.

13.8. Компанийн эрх ашигт хохирол учруулах нөхцөл байдал үүссэн болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс эрх мэдлээ урвуулах буюу хэтрүүлсэн ашигласан үйлдэл илэрсэн тохиолдолд дотоод хяналтын алба/ажилтан нь энэ асуудлаар ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах эрхтэй.

13.9. Дотоод хяналтын алба/ажилтан нь компанийн жилийн тайланд дүгнэлт гаргана.

## 14. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙГ ХАРИУЦЛАГА

14.1. Дараах этгээдүүд нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Үүнд:

- Гүйцэтгэх захирал
- Санхүү эрхэлсэн захирал
- Ерөнхий нягтлан бодогч
- ТУЗ-ийн дарга, гишүүн

14.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй.

14.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурал /эсхүл ТУЗ-ийн хурал/-аас баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх;

14.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал /эсхүл ТУЗ-ийн хурал/-аас зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гурав дахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;

14.2.3. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судлах;

14.2.4. Шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

14.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

14.3. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

14.4. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 14.2-т заасан үүргийг хүлээнэ.

14.5. Албан тушаалтан энэ дүрмийн 14.2-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

14.5.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
14.5.2. Хувьцаа эзэмшигч, ТУЗ, зээлдүүлэгч болон бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;
14.5.3. Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
14.5.4. Компанийн тухай хуулийн 97-р зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

14.6. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

14.7. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 15. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ, ТАЙЛАН

15.1. Компани нь Монгол Улсын хуулиар тогтоосон журам болон олон улсын стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

15.2. Компанийн санхүүгийн тайлан үнэн зөв байдалд Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч нар хариуцлага хүлээнэ.

15.3. Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тооцоог монгол хэлээр үйлдэх ба шаардлагатай тохиолдолд гадаад хэлээр үйлдэж болно.

15.4. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01-р сарын 01-ний өдөр эхэлж, 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

15.5. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

15.6. Санхүүгийн тайланд дараах мэдээллийг заавал тусгасан байна.
15.6.1. Санхүүгийн байдлын тайлан;
15.6.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан;
15.6.3. Мөнгөн гүйлгээний тайлан;
15.6.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
15.6.5. Санхүүгийн тайлангийн тодруулга;
15.6.6. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;
15.6.7. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр ;
15.6.8. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна;

15.7. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03
INNOVATION INVESTMENT LLC
00000191
242

15.8. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн хурлын зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

15.9. Компанийн гүйцэтгэх захирал нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитын дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ.

15.9.1. Компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт;

15.9.2. Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн;

15.9.3. Компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт;

## 16. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

16.1. ТУЗ нь санхүүгийн тайланг санхүүгийн жил дуусcанаас хойш 50 хоногийн дотор хэлэлцэж, ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргана. ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгож болно.

16.2. Компани бусдад төлөх бүх өр, төлбөрийг бүрэн төлсний дараа ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилах ба ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байна.

16.3. ТУЗ-өөс гаргах ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийн хэмжээтэй холбоотой шийдвэрийг ТУЗ-ийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

16.4. Компани эргүүлэн худалдан авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

## 17. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

17.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн тухай хуульд заасны дагуу компанийг өөрчлөн байгуулж байгуулж болно.

17.2. Дараах үндэслэлээр компанийг татан буулгана.

17.2.1. Компани алдагдалтай ажилласны улмаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон буюу дампуурсан;

17.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн;

17.2.3. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр;

17.3. Компанийг татан буулгах комиссыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно.

17.4. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасан эрхийг эдлэхээс гадна дараах үйл ажиллагааг хариуцан явуулна.

17.4.1. Компанийг татан буулгаж байгаа тухай, нэхэмжлэл гаргах журам, татан буулгах нөхцөлийн талаар өдөр тутмын сониноор олон нийтэд мэдээлнэ;

17.4.2. Компанийн бэлэн байгаа эд хогшил, хөрөнгийг үнэлж зээлдүүлэгч нартай эцсийн тооцоог хийнэ;

17.4.3. Компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хогшил, хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хувь хэмжээтэй нь тэнцүүлэн хуваарилах;

## 18. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

18.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор баталж, Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

18.2. Дүрмийг Монгол хэл дээр 4 (дөрөв) хувь үйлдэнэ.

СЗХ
2023 . 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-07-2

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

242
00000192

18.3. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 18.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

Энэхүү дүрмийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 4-р сарын 29-ний өдөр батлав.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:**

"Ай Си Ти Групп" ХК-ийг төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч А.БАТТАМИР

Д.ДАВАА

Ч. НАРАНГЭРЭЛ-ийг төлөөлж
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Г.ЛХАМСҮРЭН

"Юнимедиа Солюшнс"ХХК-ийг төлөөлж
Гүйцэтгэх захирал
ХОСОКАВА МАСАХИКО

"Айкор Партнерс"ХХК-ийг
төлөөлж, Гүйцэтгэх захирал
Б.АНХБОЛД

Б.ЧУЛУУНСҮХ

"Рентракс "ХК-ийг
төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЧУЛУУНСҮХ

"Могул" ХХК-ийг
төлөөлж, Гүйцэтгэх захирал
У.НАРАНБААТАР

МАСАНОРИ ОКОШИ-г төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЧУЛУУНСҮХ

"НОБ" ХХК-ийг төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЧУЛУУНСҮХ

СЗХ
2023.11.08

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

"Глобал Траст Нетворкс" ХК-г төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЛХАМ-ЯНЖИН

ШОИЧИРО ИЧИТАНИ-г төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЧУЛУУНСҮХ

ТАКАХИРО ИЧИКИ-г төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч
Б.ЧУЛУУНСҮХ

Ш.ЭРДЭНЭБИЛЭГ

М.МӨНХБАЯР

ККТТ ХХК-г төлөөлж,
Гүйцэтгэх захирал
Г.ЭРДЭНЭМӨНХ

242

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
тойргийн нотариатч Б.Туяажаргал би
Үйлчилгээний ... төгрөг авсан.

ИННОВЭЙШН
ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION
INVESTMENT
LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК

00000194

Инновэйшн Инвестмент ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Элчингийн гудамж Шүрэн оффис 6 тоот
Утас: 976-7610-1111, Имэйл:info@qpay.mn

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 6 сар 21 өдөр　　　　Дугаар 23/14　　　　Улаанбаатар хот

**Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай**

Энэхүү тогтоол гаргах өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан "Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолын дагуу Улсын бүртгэлийн газар дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэнэ гэж үзсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.6, 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, 62.1.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Компанийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус удирдлага болгон, "Инновэйшн инвестмент" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зарласан хувьцаанаас 27,733,160 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, түүнчлэн тус Компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд охин компани болох ККТТ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 23/03 дугаартай шийдвэрт дурдсан түүний эзэмшиж буй тус Компанийн 9,244,458 ширхэг энгийн хувьцаа, нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгүүлэн олон нийтэд нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсүгэй.

2. Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны зах зээлийн үнийг IPO хийх үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоохыг ТУЗ-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын дагуу нэмж гаргаж буй 36,977,618 ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 184,889,160 ширхэг энгийн хувьцааны 20 хувьтай тэнцэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигч болон олон нийтийн эзэмших хувь дор дурдсанаар өөрчлөгдөхийг баталгаажуулсугай.

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | IPO хийхээс өмнө | | IPO хийсний дараа | |
|---|---|---|---|---|---|
| | | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| 1 | "Ай Си Ти Групп" ХК | 34,159,320 | 21.74% | 34,159,320 | 18.48% |
| 2 | Дамдинсүрэн Даваа | 9,108,747 | 5.80% | 9,108,747 | 4.93% |

00000195

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Чойжоохүү Нарангэрэл | 16,597,400 | 10.56% | 16,597,400 | 8.98% |
| 4 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 15,560,000 | 9.90% | 15,560,000 | 8.42% |
| 5 | "Айкор Партнерс" ХХК | 14,028,800 | 8.93% | 14,028,800 | 7.59% |
| 6 | "Рентракс" ХК | 10,373,400 | 6.60% | 10,373,400 | 5.61% |
| 7 | Батзориг Чулуунсух | 8,900,267 | 5.66% | 8,900,267 | 4.81% |
| 8 | Шаравхорол Эрдэнэбилэг | 8,370,200 | 5.33% | 8,370,200 | 4.53% |
| 9 | "Могул" ХХК | 7,482,200 | 4.76% | 7,482,200 | 4.05% |
| 10 | Масанори Окоши | 3,945,000 | 2.51% | 3,945,000 | 2.13% |
| 11 | "НОБ" ХХК | 2,593,400 | 1.65% | 2,593,400 | 1.40% |
| 12 | "Глобал Траст Нетворкс" ХК | 2,593,400 | 1.65% | 2,593,400 | 1.40% |
| 13 | Шоичиро Ичитани | 2,593,400 | 1.65% | 2,593,400 | 1.40% |
| 14 | Такахиро Ичики | 2,593,400 | 1.65% | 2,593,400 | 1.40% |
| 15 | Мөнхчулуун Мөнхбаяр | 1,141,066 | 0.72% | 1,141,066 | 0.61% |
| 16 | ККТТ ХХК | 17,116,000 | 10.89% | 7,871,542 | 4.26% |
| 17 | Олон нийт | - | - | 36,977,618 | 20.00% |
| | **Нийт дүн** | **157,156,000** | **100.00%** | **184,889,160** | **100.00%** |

4. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь хувьцааны хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээхийг дурдсугай.

5. Компанийн нэмж гаргасан хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд санал болгох нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

6. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь Компанийн нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхгүй буюу татгалзсан болохыг дурдсугай. р

7. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23/03 дугаартай "Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох, компанийн хэлбэр өөрчлөх тухай" тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

8. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэн, арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Даваа/ , Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: ____________ / Д.ДАВАА /

ИННОВЕЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 ☎ 6183948

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 0000196

"КKТТ" ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис 6 тоот
Утас: (976)7610-2211, И-мейл: support@qpay.mn
Веб: www.qpay.mn

Хамгийн өргөн сүлжээтэй төлбөрийн гарц

# "КKТТ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 21-ний өдөр Дугаар 23/03 Улаанбаатар хот

**Компанийн эзэмшиж буй "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн хувьцаанаас нийтэд санал болгон гаргах хүсэлт хүргүүлэх тухай**

Толгой компани болох "Инновэйшн инвестмент" ХХК-ийн "Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 23/13 дугаар тогтоолын Улсын бүртгэлийн газар бүртгэнэ гэж үзсэний үндсэн дээр, Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", "КKТТ" ХХК /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тус компанийн эзэмшиж буй "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн 17,116,000 (арван долоон сая нэг зуун арван зургаан мянга) ширхэг энгийн хувьцаанаасаа 9,244,458 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй санал болгох хүсэлтээ "Инновэйшн Инвестмент" ХХК-д хүргүүлсүгэй.

2. Энэхүү тогтоолын нэгд дурдсанаар нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоох учрыг дурдсугай.

3. Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар санал болгож буй тус компанийн эзэмшлийн 9,244,458 ширхэг энгийн хувьцааг худалдахтай холбоотой хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурах, баталгаажуулах, уг үйл ажиллагаанд оролцох эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ____________ /Г.ЭРДЭНЭМӨНХ/

СЗХ
2023 . 11 . 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20

INNOVATION Investment

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Элчингийн гудамж Шүрэн оффис 6 тоот
Утас: 976-7610-1111, Имэйл:info@qpay.mn

№02/16

2023 оны 6 сар 28 өдөр

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

**Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ болон бусад нөхцөлүүдийг тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, 55.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалт, "Инновэйшн инвестмент" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн №23/14 тоот "Нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох тухай" тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн №23/11 тоот "Эрх олгох тухай" тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Компанийн дүрмийн холбогдох хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд охин компани болох "ККТТ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 23/03 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нэмж хувьцаа гарган олон нийтэд анх удаа санал болгох асуудлыг шийдвэрлэсэнтэй холбогдуулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан тогтоосон үнийн аргаар нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 225 (хоёр зуун хорин тав) төгрөгөөр тогтоосугай.
2. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гаргаж байгаа 27,733,160 ширхэг болон Компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшлийн 9,244,458 ширхэг энгийн хувьцаа, нийт 36,977,618 ширхэг энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 20 хувьтай тэнцэх энгийн хувьцааны татан төвлөрүүлэх дүнг 8,319,964,050 (найман тэрбум гурван зуун арван есөн сая есөн зуун жаран дөрвөн мянга тавин) төгрөгөөр тогтоосугай.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242508 рд 6183948

00000198

3. Татан төвлөрүүлэх хөрөнгийн 85 (наян тав) хувь хүртэлх дүн буюу 7,071,969,443 (долоон тэрбум далан нэгэн сая есөн зуун жаран есөн мянга дөрвөн зуун дөчин гурав) төгрөг хүртэлх дүнг Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгож, үлдсэн хувийг олон нийтэд санал болгосугай.
4. Стратегийн хөрөнгө оруулагчдад хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээхийг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын 2-т дурдснаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
6. Энэхүү тогтоолын 2-т дурдсан энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, үнэт цаасны анхдагч зах зээлд арилжах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бусад асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.............................................. Д.ДАВАА

СЗХ
2023 .11. 08
БҮРТГЭВ
№ 01

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06-р сарын*

*28-ны өдрийн 02/16 тоот тогтоолын хавсралт*

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 рд. 6183948

## ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Инновэйшн Инвестмент ХХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компани, түүний охин компанийн үйл ажиллагаа, тэлэлт, техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтын зорилгоор дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.”

| № | **Хөрөнгө оруулалтын зориулалт** | **Эзлэх хувь** |
|---|---|---|
| 1 | Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт | 22.5% |
| 2 | Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа | 30.0% |
| 3 | Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа | 15.0% |
| 4 | Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах | 7.5% |
| 5 | “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр | 25.0% |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
1117242908 рд. 6183948

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
00000200

СЗХ
2023 оны 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХК болж өөрчлөгдсөний дараа болох Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02/17 тоот тогтоолын
1 дүгээр хавсралтаар агуулгын хувьд сайшаав.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

# "ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. "Инновэйшн Инвестмент" (цаашид "*Компани*" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм (цаашид "*Дүрэм*" гэх)-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах хувьцаат компани (цаашид "*ХК*" гэх) мөн.

1.2. Компани нь өөрийн бэлгэдэл, тогтоосон журмын дагуу хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.3. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрнийхээ дараа "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.4. Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.

1.5. Компани нь охин буюу хараат компани байгуулж болох бөгөөд Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар буюу төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

1.6. Энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмууд нь Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмаар тусгайлан зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

1.7. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд тус хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

1.8. Компани нь өөрийн болон охин компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжүүлж болно.

### 2. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг

2.1. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр "Инновэйшн Инвестмент" Хувьцаат компани товчилсон нэрийг "ИИ" ХК гэнэ.

2.2. Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн оффис, 6 тоот
Харилцах утас: 76102211
Цахим шуудан: erdenemunkh.g@qpay.mn
Цахим хаяг: www.i-investment.mn

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195 СТС2420
00000201

СЭХ
2023.11.09
он сар өдөр
БҮРТГЭВ

**3. Компанийн эрхэм зорилго**

3.1. Бид технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл**

4.1. Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:

4.1.1. Мэдээлэл технологийн үйл ажиллагаа (үндсэн эрхлэх үйл ажиллагаа);

4.1.2. Программ хангамжийн үйлчилгээ.

4.2. Компани нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

**5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа**

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэнд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь **25** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **184,889,160.00** ширхэг гаргасан хувьцаанд хуваагдах бөгөөд хувьцааны нийт нэрлэсэн үнийн дүн буюу хувь нийлүүлсэн хөрөнгө нь **4,622,229,000.00** төгрөг байна. Компанийн зарласан хувьцаа нь нийт **192,166,000.00** бөгөөд Компанийн зарласан боловч гаргаагүй хувьцааны тоо **7,276,840.00** ширхэг болно.

5.3. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.

5.4. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.

5.5. Компани зарласан боловч гаргаагүй хувьцааг дахин/нэмж гаргаж болно.

**6. Компанийн хувьцаа эзэмшигч**

6.1. Хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

**7. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага**

7.1. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

7.2. Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
ХХК
00000202

7.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр компанийн эрсдэл, хариуцлага хүлээнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

### 8. Хувьцаа эзэмшигчдийн хурал

8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

8.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

8.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

8.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;

8.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

8.3.4. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;

8.3.5. аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

8.3.6. компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.

8.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:

8.4.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

8.4.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.4.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.4.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;

8.4.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

8.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

8.4.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

8.4.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;

8.4.9. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.4.10. төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
2023-07-20
INNOVATION INVESTMENT LLC
00000203

8.4.11. төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

8.4.12. хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

8.4.13. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

8.4.14. төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

8.4.15. Хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудал;

8.4.16. ХЭХ, ТУЗ-аас шаардлагатай гэж үзсэн болон хууль тогтоомжид заасан бусад.

8.5. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталне. Үүнд:

8.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;

8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.5.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;

8.5.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

8.5.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;
8.5.6. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
8.5.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
8.5.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх эсэх,

8.6. Энэхүү дүрмийн 8.5-д зааснаас болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхи дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.

8.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох 9 гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана.

8.8. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгнө. Энэ тухай зааврыг Компанийн тухай хууль, СЗХ-ны журмыг баримтлан тухайн хурлын санал авах хуудсанд тусгана.

8.9. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

8.10. Хуралд оролцох журам:

8.10.1. Хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэхтэйгээ ирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тодорхойлсон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган бүртгүүлж хуралдаа оролцоно. Хэрэв хуралд биеэр оролцох боломжгүй бол өөрийгөө төлөөлүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдэд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулж болно.

00000204

8.10.2. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.

8.10.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрэмд заасны дагуу тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.

8.10.4. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах ба тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

8.10.5. Компанийн саналын эрх бүхий хувьцааны олонхийн санал эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

8.10.6. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

8.10.7. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; компанийн хэлбэрийг өөрчлөх; компанийг татан буулгах; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.11. Компанийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.

8.12. Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох:

8.12.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргахдаа тогтооно.

8.12.2. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтооно. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.

8.12.3. Санал авах хуудсанд (ТУЗ болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

СЗХ
2023 оны 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ

2023 -07- 20

8.12.4. Компани цахимаар санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хүлээнэ. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг компанид хүлээлгэж өгнө.

8.13. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.

8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

8.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон бусад тэмдэглэлтэй холбоотой харилцааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

## 9. Төлөөлөн удирдах зөвлөл

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хуульд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

9.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна.

9.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 5 (таван) жил байна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноос хойш 5 жилийн дараа болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.

9.4. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.5. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.6. ТУЗ нь Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

9.6.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөг батлах;

9.6.2. компанийн үнэт цаасыг гаргах;

9.6.3. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

9.6.4. компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд арилжааны эх үүсвэр татан төвлөрүүлэх;

9.6.5. гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох;

9.6.6. компанийн гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

INNOVATION INVESTMENT LLC

00000206

СЭХ
2023.11.08
БҮРТГЭВ
№

2023-07-20

9.6.7. компанийн хөндлөнгийн Аудитын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хөндлөнгийн аудитыг сонгож, гэрээ байгуулах;

9.6.8. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;

9.6.9. гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтоох;

9.6.10. байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;

9.6.11. компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;

9.6.12. компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;

9.6.13. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

9.6.14. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

9.6.15. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

9.6.16. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

9.6.17. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг батлах;

9.6.18. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.6.19. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.6.20. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.6.21. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

9.6.22. Өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй өрийн бичгийг гаргах;

9.6.23. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, энэхүү дүрэмд заасан бусад үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэр гаргах;

9.6.24. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад буюу ТУЗ шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

9.8. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар нэмэлт хурал хуралдуулж болно.

9.9. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.

9.10. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

9.11. Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

9.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК

00000207

9.13. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

9.13.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

9.13.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;

9.13.3. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

## 10. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

10.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхийн саналаар сонгоно.

10.2. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.

10.3. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

## 11. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэн сонгох

11.1. ТУЗ нь цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороотой байна.

11.2. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулж ХЭХ-д нэр дэвшүүлнэ.

## 12. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн

12.1. ТУЗ нь хараат бус гишүүнтэй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:

12.1.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

12.1.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

12.1.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

12.1.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй;

12.1.5. компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

12.1.6. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

12.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

12.2.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс

00000208

СЗХ
2023 .11 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;

12.2.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

12.2.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;

12.2.4. компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;

12.2.5. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.

12.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:

12.3.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

12.3.2. Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

12.3.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

## 13. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга

13.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

13.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.

13.3. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.

13.4. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

13.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулна.

13.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

13.7. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

## 14. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороо

14.1. ТУЗ нь Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо, Стратеги ба хөгжлийн хороо гэсэн байнгын хороодтой байна.

14.2. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

00000209

14.3. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажилуулж болно.

14.4. Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

14.4.1. компанийн эрсдлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;

14.4.2. компанийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;

14.4.3. компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдлийн түвшинд хяналт тавих.

14.5. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

14.5.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

14.5.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

14.5.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

14.5.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

14.5.5. компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

14.6. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна :

14.6.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

14.6.2. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ дүрэм болох Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

14.6.4. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

14.6.5. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

14.6.6. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

14.6.7. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

14.6.8. компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

00000210

14.6.9. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

14.6.10. компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

14.7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

## 15. Гүйцэтгэх удирдлага

15.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

15.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.

15.3. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.

15.4. ТУЗ-өөс зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.

15.5. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

15.6. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

15.7. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах эрхтэй.

15.8. Гүйцэтгэх удирдлага нь Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрсдлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах зохион байгуулах зарчмыг баримталж ажиллана.

15.9. Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, энэхүү дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, жил бүрийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-ийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайланг ТУЗ, Хувьцаа эзэмшигчид болон холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

15.10. Гүйцэтгэх захирал болон шаардлагатай тохиолдолд удирдлагын багийн гишүүд нь ажлаа ТУЗ-д тайлагнана.

15.11. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.

## 16. Дотоод хяналт

16.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

16.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос санал болгосноор гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

2023.11.08

INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
00000211

16.3. Дотоод хяналтын алба/ажилтан нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-аас баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

16.4. Дотоод хяналтын ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

**17. Хөндлөнгийн аудит**

17.1. Аудитын тухай хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.

17.2. ТУЗ–ийн дэргэдэх аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөндлөнгийн аудитын талаар баримтлах бодлогын дагуу СЗХ-нд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.

17.3. Дараах этгээдийг компанийн хөндлөнгийн Аудитоор сонгон ажиллуулахыг хориглоно:

17.3.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаалтан,

17.3.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсвэл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг,

17.3.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь дотоод аудитороор ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

17.4. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.

17.5. Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

17.6. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

17.7. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компани болон хувь эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд компани өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

**18. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан**

18.1. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.

18.2. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан хамтран хариуцна.

18.3. ТУЗ нь компанийн санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлад танилцуулна.

18.4. Компани Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
2023-07-20
INNOVATION INVESTMENT LLC
00000212

СЗХ
2023 .11.08
БҮРТГЭВ

2023 -07- 20
БҮРТГЭВ-03

## 19. Их хэмжээний хэлцэл

19.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:

19.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/,

19.1.2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

19.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

19.3. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

19.4. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

## 20. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

20.1. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох Компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг тусдаа журмаар зохицуулна. Уг журмыг ТУЗ батална.

20.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.

20.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

20.4. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.

20.5. Компани тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

## 21. Компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага

21.1. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Технологи хариуцсан захирал, Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал, Бизнес хөгжил хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.

21.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

21.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

INNOVATION INVESTMENT LLC

00000213

21.2.2. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгнө;

21.2.3. Компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

21.2.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

21.2.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

21.2.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.

21.3. Эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн туршид энэ Дүрмийн 21.2.3-д заасан үүргийг хүлээнэ.

21.4. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

21.5. Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 21.2.5-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

21.6. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД

### 22. Үнэт цаас худалдах, эргүүлэн авах

22.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.

22.2. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

22.3. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.

22.4. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

### 23. Ногдол ашиг хуваарилан олгох

23.1. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

23.2. Ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна.

23.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

23.4. Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ
2023-07-20
INNOVATION INVESTMENT LLC
00000214

23.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

23.6. Компани нь хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.

23.7. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

23.8. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

23.9. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

23.10. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

23.11. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

23.12. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

## 24. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

24.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компанийн тухай" хууль, энэ дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

24.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан журмаар татан буулгана.

24.2.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

24.2.2. ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхи зөвшөөрсөн;

24.2.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

24.3. Компанийг татан буулгах тухай шийдвэрийг ТУЗ нь Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

## 25. Дүрэм хүчин төгөлдөр болох

25.1. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

25.2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

~oOo~

INNOVATION INVESTMENT LLC
00000215

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дүгээр тушаалаар батлав.

СТХ БҮРТГЭВ № 01

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000218951

2007.12.06
/ Бүртгэсэн он.сар.өдөр /

9011125147
/ Хувийн хэргийн дугаар /

5183855
/ Регистрийн дугаар /

Өлзий энд КО капитал ҮЦК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 001 | 2007.12.06 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 4610 | Гадаад худалдаа |
| 6419 | Брокер , дилер , андеррайтер /-/ |
| 64200 | Номинал дансны үйл ажиллаг аа |

| Хугацаагүй | 1 | 1,300,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, 5-р давхар. Утас1: 99103838. Утас2: 11310262. Факс: 976-11310262
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тэмдэг/ Г.БАТМӨНХ /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон 2021 он 03 сар 18 өдөр*

00000218

СЭХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Болд овогтой Өлзийбаяр-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2020.05.18* | *Г.Хулан* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2021.03.18* | *Г.Батмөнх* |

УЛСЫН БҮРТГЭГЧ 529

Энэхүү гэрчилгээг журамчаар үйлдсэн этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183856
9021131195 СТС2420

00000217

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/42

2007 оны 04 сарын 18 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 04 сарын 18 өдрийн 86 дугаар тогтоолоор

"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК -д

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

00000218

СЗХ
2023 . 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 20
БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/42 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

ТУ32072 9026... 6043239
ТЭМДЭГ

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Брокер | 2007.04.18 | №86тогтоол | |
| 2. | Дилер | 2007.04.18 | №86тогтоол | |
| 3. | Андеррайтер | 2007.04.18 | №86тогтоол | |
| 4. | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах | 2014.11.05 | №393 тогтоол | |
| 5. | Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого , зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх | 2020.03.11 | №105 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 ... 6183848

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
... 9021031195 ... СТС2420 ...

00000219

"Нортенсек ҮЦК" ХХК-ийн оноосон нэрийг "Ард капитал групп ҮЦК" ХХК болгон өөрчлөхийн зөвшөөрөв. 2011.11.17 №183 тушаал
"Ард капитал групп ҮЦК" ХХК-ийн оноосон нэрийг "Өлзий энд КО капитал ҮЦК" ХХК болгон өөрчлөхийн зөвшөөрөв. 2021.03.15 №75 тушаал

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, бага тойруу, Сити центр, 10 давхар, 1003 тоот | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | | | 1,300,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

2023.11.08 БҮРТГЭВ №01

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

00000220

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Бум Ард Консалтинг"ХХК | | 1,300,000,000 | 100% | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ 5183855 CTC2420
00000221

СЗХ
2023.11.08

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

00000222

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000171085

2018.06.08
*/ Бүртгэсэн он,сар,өдөр /*

9011741137
*/ Хувийн хэргийн дугаар /*

6317839
*/ Регистрийн дугаар /*

Инвескор капитал ҮЦК Хязгаарлагдмал хариуцлагатай компани
*/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /*

Дүрэм
*/ Үүсгэн байгуулах баримт бичиг /*

| Шийдвэр | 01 | 2018.06.07 |
|---|---|---|
| */ шийдвэрийн нэр /* | */ дугаар /* | */ он, сар, өдөр /* |

| 6612 | Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа |
|---|---|
| */ код /* | */ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /* |

| | |
|---|---|
| */ код /* | */ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /* |

| Хугацаагүй | 1 | 1,300,000.0 |
|---|---|---|
| */ хугацаа /* | */ гишүүдийн тоо /* | */ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /* |

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, сөүл, Твин тауэр 1, 402 тоот, Утас1: 77090077, Утас2: 99906231, Факс
*/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /*

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
*/ бүртгэсэн байгууллагын нэр /*

*Гэрчилгээ дахин олгосон 2018 он 10 сар 8 өдөр*

СЗХ 2023.11.20 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20

2023.06.27 он сар өдөр Бүртгэлийн № 5102
Нийслэлийн тойргийн нотариатч Д.Отгоннасан би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Нотариатч

00000223

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Равжир овогтой Мөнхтөр-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2018.07.06 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2018.10.08 | Ж.Оюумаа |
| 1 | Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, , сөүл, , гудамж Твин тауэр 1, 13-н давхар тоот, Утас1 77090077, Утас2 99906231, Факс хаягийг шинээр бүртгэв. | 2018.10.08 | Ж.Оюумаа |
| 2 | Гончигдорж овогтой Уянгахишиг -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2019.01.18 | Х.Түвшинтөр |
| 3 | 64990 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.04.17 | Д.Гангамөрөн |
| 4 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.08.27 | Э.Мөнхзаяа |
| | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30000 мян.төг-р нэмэгдэж нийт 1330000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2021.12.21 | Г.Батмөнх |
| 11 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.12.21 | Г.Батмөнх |
| 12 | 64300 Хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.12.21 | Г.Батмөнх |
| 13 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, жамьян гүний, 18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот Утас1: 77090077, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2022.05.02 | Н.Энхтуяа |
| 14 | Лхагваа овогтой Билгүүн-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.10.12 | Л.Хишигжаргал |
| 15 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2022.10.19 | Н.Энхтуяа |
| 16 | Гончигдорж овогтой Уянгахишиг-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.10.19 | Н.Энхтуяа |
| 17 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1400000 мян.төг-р нэмэгдэж нийт 2730000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2023.05.30 | Ш.Очирсүрэн |
| 18 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13 хороолол, парисын, гудамж 42 Ай Си Тауэр барилга 15 давхар, 1503 тоот Утас1: 77550077, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.06.09 | Ш.Очирсүрэн |

INNOVATION INVESTMENT LLC
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
* 0 0 0 1 7 1 0 8 5 *
00000224

СЗХ
2023.11.06

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/113

2018 оны 09 сарын 26 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 09 сарын 26 өдрийн 315 дугаар тогтоолоор

**"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК** -д

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ**

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"тамга"

МОНГОЛ УЛС

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC

*Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй*

2023 06 21 он сар өдөр Бүртгэлийн № 5104
Нийслэлийн тойргийн нотариатч Д.Отгоннасан би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Нотариатч

СЗХ
2023 оны 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-20
БҮРТГЭВ-03

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/113 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Брокер | 2018.09.26 | №315 тогтоол | |
| 2. | Дилер | 2018.09.26 | №315 тогтоол | |
| 3. | Андеррайтер | 2018.09.26 | №315 тогтоол | |
| 4. | Хөрөнгө оруулалтын зөвлөх | 2021.10.28 | №475 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

МОНГОЛ УЛС
MONGOLIA
406
МОНГОЛ УЛС

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ

00000226

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, холбогдох өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Твин тауэр-1, 13 давхар. | 77090077, 99906231 | |
| 2. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жамьян гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот. | 77090077 /2/ | 2022.04.27 5/ 1545 албан тоот |
| 3. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Парисын гудамж 42, Ай Си тауэр барилга, 15 давхар, 1503 тоот. | | 2023.05.31 5/2242 албан тоот |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2018.09.26 | №315 | 1,300,000,000 |
| 2. | 30,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.10.20 | №280 | 1,330,000,000 |
| 3. | 1,400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2023.05.17 | №289 | 2,730,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛС MONGOLIA 406

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ... ХХК 00000227

СЗХ
2023 он 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

1.5. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн нэр:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Хаяг | Харилцах утас |
|---|---|---|---|---|
| 1 | “Инновэйшн Инвестмент” ХХК | 6183948 | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Элчингийн гудамж, “Шүрэн оффис”, 6 тоот | 99179204 |

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

1.6. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр эрхлэн явуулна.

## 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.1.1. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
2.1.2.Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
2.1.3. Программ хангамжийн үйл ажиллагаа

2.2. Монгол Улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

## 3. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

3.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь **10,000** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **1,000** (нэг мянга) ширхэг гаргасан болон зарласан энгийн хувьцаанд хуваагдах бөгөөд хувьцааны нийт нэрлэсэн үнийн дүн буюу хувь нийлүүлсэн хөрөнгө нь **10,000,000 (арван сая) төгрөг** байна.

3.2. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмших хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Үнэ /төгрөгөөр/ | | |
| | | | Нэгжийн үнэ | Бүгд | |
| 1 | “Инновэйшн Инвестмент” ХХК | 1,000 | 10,000 | 10,000,000 | 100% |
| | **Нийт дүн** | **1,000** | | **10,000,000** | **100%** |

3.4. Дүрмийн 3.3-т заасан талуудын хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бичгэн шийдвэрийн дагуу өөрчлөгдөж болно.

3.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн тухай хуульд заасан арга хэлбэрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулж болно.

3.6. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд компанийн гүйцэтгэх захирал ийнхүү багассан шалтгааныг судлан дүгнэлт гаргаж, дахин хөрөнгжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багасгах (хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар) тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.7. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

3.8. Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахдаа хувьцаа эзэмшигчтэй харилцан тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

## 4. КОМПАНИЙН ЭРХ

4.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.2. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тамга тэмдэг, компанийн логотой байна.

4.3. Компани үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд явуулах эрхтэй.

4.4. Компани нь өөрийн тусгайлсан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ.

4.5. Компани нь шүүхийн өмнө нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд болж оролцох эрхтэй.

4.6. Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу хараат болон охин компани байгуулах эрхтэй.

4.7. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай боловсон хүчнийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийг тогтоох эрхтэй.

4.8. Компани хууль тогтоомжоор хамгаалагдсан байгууллагын нууцад хамаарах мэдээллийг нууцлах эрхтэй.

## 5. КОМПАНИЙН ҮҮРЭГ

5.1. Компани нь энэхүү дүрмийн 2-р зүйлийн 2.1-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэх үүрэгтэй.

5.2. Компани нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" , "Аудын тухай хууль"-д заасны дагуу нягтлан бодохын болон анхан шатны дэлгэрэнгүй бүртгэлийн хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулах үүрэгтэй.

5.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулиудын дагуу орлого татвараа тодорхойлж, сайн дураар төлөх үүрэгтэй.

5.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжоор шаардагдсан шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.

5.5. Компани нь өөрийн ажилчдын өмнө хууль тогтоомжоор болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

5.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

5.7. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтүүдийг танилцуулах үүрэгтэй.

5.8. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулж, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

## 6. КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

6.2. Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн хариуцлагыг хүлээхгүй ба компани хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 85-р зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

6.4. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

## 7. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

7.1.1. Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх

7.1.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах

7.1.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх

7.1.4. Компаниас нэмж гаргах буюу бусад хувьцаа эзэмшигчдийн худалдах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах.

7.1.5. Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээллэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах

9.6. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө хурал хуралдах огноо, цаг, газар болон хурлаар хэлэлцэх асуудлын дэлгэрэнгүй мэдээллийг хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн байна.

9.7. ХЭХ хуралдуулахтай холбоотой гарсан бүх зардлыг компани хариуцна.

9.8. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон шийдвэрийг Монгол хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдийн хурал болсноос хойш хуанлийн 10 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч бүх хурлын тэмдэглэл, шийдвэрт гарын үсэг зурна. Хэрэв хурлын шийдвэрт санал нийлэхгүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд 10 хоногийн дотор үндэслэл бүхий тайлбарын хамт тэмдэглэл, шийдвэрийг буцаана. Тайлбарыг авснаас хойш 20 хоногийн дотор санал нийлэхгүй асуудлаар дахин нэг удаа хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах бөгөөд хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэлд гишүүн гарын үсэг зурахаас дахин татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

9.9. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид хурлын тэмдэглэл, шийдвэр нь үнэн зөв бол хүлээн зөвшөөрч гарын үсэг зурна. Үнэн зөв шийдвэр, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан хувьцаа эзэмшигч нь татгалзсан үндэслэл, шалтгаанаа тэмдэглэлд бичнэ.

9.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахад Компанийн тухай хуулийн 61-р зүйлд заасан журмыг баримтална.

9.11. Хувьцаа эзэмшигчдийн ердийн олонх (биечлэн, телеконференц буюу видео конференцийн хэлбэрээр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан) нь оролцсоноор хурлын ирц хүчинтэйд тооцогдоно.

9.12. ХЭХ-аар шийдвэрлэх аливаа асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэснээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байна.

## 10. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.2. Гүйцэтгэх захирлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж, гэрээ байгуулна.

10.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хуралтай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.4. Гүйцэтгэх удирдлага нь өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

 10.4.1. Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

 10.4.2. Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, албан тушаалтантай харилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах

 10.4.3. Шүүх төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, бусад аливаа этгээдийн өмнө компанийг төлөөлөх

 10.4.4. Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох

 10.4.5. Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, биелэлтийг хангах

2023.11.08
INNOVATION INVESTMENT LLC
00000256

10.4.6. Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бараа материал, ажил үйлчилгээг худалдан авах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах

10.4.7. Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зөвшөөрөл, гэрчилгээ зэргийг хууль тогтоомжийн дагуу авах ажлыг зохион байгуулах

10.4.8. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах

10.4.9. Монгол Улсын хууль тогтоомж болон ХЭХ-ын шийдвэрийн биелэлтийг хариуцан зохион байгуулах

10.4.10. Компани, түүний бүтэц, зохион байгуулалт, цалингийн сангийн хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдыг авч ажилуулах

10.4.11. Компанийн хөрөнгө устгах, үрэгдэх, алдагдал, дутагдалд орох зэргээр аливаа хөрөнгийн эрсдэлээс боломжит бүх арга хэрэгслийг ашиглан сэргийлэх

10.4.12. Хувьцаа эзэмшигчдэд компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах

10.4.13. Компанид бий болсон үйл ажиллагааны болон санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал, эрсдэл, зөрчлийг хувьцаа эзэмшигчдэд нэн даруй хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх

10.4.14. Монгол Улсын хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан бусад эрх, үүргүүд.

10.5. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас бичгээр олгогдсон зөвшөөрөлгүйгээр компанийн болон бусад хуулийн этгээдийн удирдах дээд байгууллагын гишүүнээр сонгогдох, ажиллах эрхгүй.

## 11. КОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

11.1. Компанийн санхүүгийн тооцоонд компанийн дотоод аудитын алба хяналт тавина.

11.2. Дотоод аудитын албаны дарга болон гишүүдийг ХЭХ-аас 3 жилийн хугацаатай томилно. Дотоод аудитын алба нь дарга болон 2 орон тоо бүхий гишүүдээс бүрдэнэ.

11.3. Дотоод аудитын албаны гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ажилтнуудаас сонгох ба тэдгээр нь компанийн эрх барих байгууллагуудын удирдах албан тушаалтан байж болохгүй.

11.4. Дотоод аудитын албанаас хийх шалгалт нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

11.5. Дотоод аудитын алба нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд жилд нэг удаа ээлжит шалгалт хийнэ. Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр дотоод аудитын алба нь ээлжит бус шалгалтыг хийж болно.

11.6. Дотоод аудитын алба нь компанийн албан тушаалтнуудаас шаардлагатай бүх материалуудыг үүнд нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн баримтууд, тайлан тооцоо, албан бичиг гэх мэтийг шаардан гаргуулах эрхтэй.

11.7. Дотоод аудитын алба нь өөрийн хийсэн шалгалтын үр дүнгийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах үүрэгтэй.

11.8. Компанийн эрх ашигт хохирол учруулах нөхцөл байдал үүссэн болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс эрх мэдлээ урвуулах буюу хэтрүүлсэн ашигласан үйлдэл илэрсэн тохиолдолд дотоод аудитын алба нь энэ асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах эрхтэй.

11.9. Дотоод аудитын алба нь компанийн жилийн тайланд дүгнэлт гаргана.

## 12. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙГ ХАРИУЦЛАГА

СЗХ 2023 оны 11 сарын 01 өдөр БҮРТГЭВ №1
2023-07-20
INNOVATION INVESTMENT LLC
00000257

12.1. Гүйцэтгэх захирал, менежер, ерөнхий санхүүч, ерөнхий инженер, ахлах мэргэжилтнүүдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

12.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй.

12.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх

12.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх

12.2.3. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судлах

12.2.4. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх

12.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдэс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх

12.3. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ХЭХ-ын нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

12.4. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 12.3-т заасан үүргийг хүлээнэ.

12.5. Албан тушаалтан энэ дүрмийн 12.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

12.5.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан

12.5.2. Хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн

12.5.3. Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй

12.5.4. Компанийн тухай хуулийн 97-р зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй

12.6. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

12.7. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ, ТАЙЛАН

13.1. Компани нь Монгол Улсын хуулиар тогтоосон журам болон олон улсын стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

13.2. Компанийн санхүүгийн тайлан үнэн зөв байдалд Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч нар хариуцлага хүлээнэ.

00000258

13.3. Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тооцоог монгол хэлээр үйлдэх ба шаардлагатай тохиолдолд гадаад хэлээр үйлдэж болно.
13.4. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01-р сарын 01-ний өдөр эхэлж, 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.
13.5. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.
13.6. Санхүүгийн тайланд дараах мэдээллийг заавал тусгасан байна.
13.6.1. Баланс
13.6.2. Орлогын үр дүнгийн тайлан
13.6.3. Мөнгөн гүйлгээний тайлан
13.6.4. Хуримтлагдсан ашгийн тайлан
13.6.5. Нэмэлт тайлбар тодруулга
13.6.6. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт
13.6.7. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр
13.6.8. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
13.7. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторийг томилон ажиллуулж болно.
13.8. Санхүүгийн тайланг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитийн байгууллагаар хянуулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.
13.9. Компани Монгол Улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна.
13.10. Компанийн гүйцэтгэх захирал нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ.
13.10.1. Компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт
13.10.2. Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн
13.10.3. Компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт

## 14. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

14.1. ХЭХ нь санхүүгийн тайланг дараа оны 4-р сарын 30-ны дотор хэлэлцэж, ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргана. ХЭХ-ийн шийдвэрээр ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгож болно.
/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21 өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/
14.2. Компани бусдад төлөх бүх өр, төлбөрийг бүрэн төлсний дараа ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

14.3. ХЭХ-аас гаргах ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийн хэмжээтэй холбоотой шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна. /Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

14.4. Компани эргүүлж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

## 15. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

15.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн тухай хуульд заасны дагуу компанийг өөрчлөн байгуулж байгуулж болно.

15.2. Дараах үндэслэлээр компанийг татан буулгана.

15.2.1. Компани алдагдалтай ажилласны улмаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон буюу дампуурсан

15.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн

15.2.3. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр

15.3. Компанийг татан буулгах комиссыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно.

15.4. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасан эрхийг эдлэхээс гадна дараах үйл ажиллагааг хариуцан явуулна.

15.4.1. Компанийг татан буулгаж байгаа тухай, нэхэмжлэл гаргах журам, татан буулгах нөхцлийн талаар өдөр тутмын сониноор олон нийтэд мэдээллэнэ.

15.4.2. Компанийн бэлэн байгаа эд хогшил, хөрөнгийг үнэлж зээлдүүлэгч нартай эцсийн тооцоог хийнэ.

15.4.3. Компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хогшил, хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хувь хэмжээтэй нь тэнцүүлэн хуваарилах.

## 16. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

16.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын ердын олонхиор баталж, Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

16.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 16.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

Энэхүү дүрмийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 6 сарын 21-ний өдөр батлав.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:**

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийг төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.ЭРДЭНЭМӨНХ

2023 .11. 08 он сар өдөр БҮРТГЭВ № 01

2023 -07- 20

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

2023 06 29 он ... сар ... өдөр Бүртгэлийн № ...
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч Б.Туяажаргал би энэ хуулбарыг үнэн зөв ... Үйлчилгээний хөлсөнд ... төгрөг хураав
Нотариатч ...

242

00000260

СЭХ
2023 .11. 08
БҮРТГЭВ
№: 1

2023 -07- 20

“Дижитал мерчант сервисис” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
23/01 дугаар тогтоолын хавсралтаар
нэмэлт, өөрчлөлтийн хамт баталгаажуулав.

# “ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

(*Шинэчилсэн найруулга*)

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар 9011740188
2023 оны 06 сарын 28 өдөр

## 1. Нийтлэг үндэслэл

1.1. “Дижитал Мерчант Сервисэс” компани нь Монгол Улсын компанийн тухай хуулийн 3-р зүйлийн 3.5-дахь хэсэгт заасан хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх) мөн.

1.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын Иргэний Хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр зохицуулна.

1.3. Компанийн албан ёсны оноосон нэр нь

Монгол хэлээр: “Дижитал Мерчант Сервисэс” ХХК
Англи хэлээр: “Digital Merchant Services ” LLC

1.4. Компанийн албан ёсны хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, “Шүрэн оффис”, 6 тоот
Утас: 7610-2211, 99099040
И-мэйл: gurjav.s@qpay.mn

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

1.5. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн нэр:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Хаяг | Харилцах утас |
|---|---|---|---|---|
| 1 | “Инновэйшн Инвестмент” ХХК | 6183948 | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Элчингийн гудамж, “Шүрэн оффис”, 6 тоот | 99179204 |

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

1.6. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр эрхлэн явуулна.

## 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.1.1. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
2.1.2.Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
2.1.3. Программ хангамжийн үйл ажиллагаа

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

ЭЛЗИЙ ЭНЭ КАПИТАЛ ХХК
242
00000261

2.2. Монгол Улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагаагаа эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

## 3. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

3.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь **10,000** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **1,000** (нэг мянга) ширхэг гаргасан болон зарласан энгийн хувьцаанд хуваагдах бөгөөд хувьцааны нийт нэрлэсэн үнийн дүн буюу хувь нийлүүлсэн хөрөнгө нь **10,000,000 (арван сая) төгрөг** байна.

3.2. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмших хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Үнэ /төгрөгөөр/ | | |
| | | | Нэгжийн үнэ | Бүгд | |
| 1 | "Инновэйшн Инвестмент" ХХК | 1,000 | 10,000 | 10,000,000 | 100% |
| | **Нийт дүн** | **1,000** | | **10,000,000** | **100%** |

3.4. Дүрмийн 3.3-т заасан талуудын хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бичгэн шийдвэрийн дагуу өөрчлөгдөж болно.

3.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн тухай хуульд заасан арга хэлбэрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулж болно.

3.6. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд компанийн гүйцэтгэх захирал ийнхүү багассан шалтгааныг судлан дүгнэлт гаргаж, дахин хөрөнгжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багасгах (хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар) тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.7. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

3.8. Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахдаа хувьцаа эзэмшигчтэй харилцан тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

## 4. КОМПАНИЙН ЭРХ

4.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.2. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тамга тэмдэг, компанийн логотой байна.

4.3. Компани үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд явуулах эрхтэй.

4.4. Компани нь өөрийн тусгайлсан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ.

4.5. Компани нь шүүхийн өмнө нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд болж оролцох эрхтэй.

4.6. Компани нь Компанийн тухай хуульд заасны дагуу хараат болон охин компани байгуулах эрхтэй.

00000262

4.7. Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай боловсон хүчнийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийг тогтоох эрхтэй.

4.8. Компани хууль тогтоомжоор хамгаалагдсан байгууллагын нууцад хамаарах мэдээллийг нууцлах эрхтэй.

## 5. КОМПАНИЙН ҮҮРЭГ

5.1. Компани нь энэхүү дүрмийн 2-р зүйлийн 2.1-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэх үүрэгтэй.

5.2. Компани нь Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” , ”Аудын тухай хууль”-д заасны дагуу нягтлан бодохын болон анхан шатны дэлгэрэнгүй бүртгэлийн хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулах үүрэгтэй.

5.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулиудын дагуу орлого татвараа тодорхойлж, сайн дураар төлөх үүрэгтэй.

5.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжоор шаардагдсан шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.

5.5. Компани нь өөрийн ажилчдын өмнө хууль тогтоомжоор болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

5.6. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

5.7. Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтүүдийг танилцуулах үүрэгтэй.

5.8. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулж, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

## 6. КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

6.2. Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн хариуцлагыг хүлээхгүй ба компани хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 85-р зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

6.4. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

## 7. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

7.1.1. Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх

7.1.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах

7.1.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх

7.1.4. Компаниас нэмж гаргах буюу бусад хувьцаа эзэмшигчдийн худалдах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах.

7.1.5. Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээллэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ № 01

9.6. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө хурал хуралдах огноо, цаг, газар болон хурлаар хэлэлцэх асуудлын дэлгэрэнгүй мэдээллийг хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн байна.

9.7. ХЭХ хуралдуулахтай холбоотой гарсан бүх зардлыг компани хариуцна.

9.8. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон шийдвэрийг Монгол хэлээр үйлдэж, хувьцаа эзэмшигчдийн хурал болсноос хойш хуанлийн 10 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч бүх хурлын тэмдэглэл, шийдвэрт гарын үсэг зурна. Хэрэв хурлын шийдвэрт санал нийлэхгүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд 10 хоногийн дотор үндэслэл бүхий тайлбарын хамт тэмдэглэл, шийдвэрийг буцаана. Тайлбарыг авснаас хойш 20 хоногийн дотор санал нийлэхгүй асуудлаар дахин нэг удаа хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах бөгөөд хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэлд гишүүн гарын үсэг зурахаас дахин татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

9.9. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид хурлын тэмдэглэл, шийдвэр нь үнэн зөв бол хүлээн зөвшөөрч гарын үсэг зурна. Үнэн зөв шийдвэр, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан хувьцаа эзэмшигч нь татгалзсан үндэслэл, шалтгаанаа тэмдэглэлд бичнэ.

9.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахад Компанийн тухай хуулийн 61-р зүйлд заасан журмыг баримтална.

9.11. Хувьцаа эзэмшигчдийн ердийн олонх (биечлэн, телеконференц буюу видео конференцийн хэлбэрээр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан) нь оролцсоноор хурлын ирц хүчинтэйд тооцогдоно.

9.12. ХЭХ-аар шийдвэрлэх аливаа асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэснээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байна.

## 10. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.2. Гүйцэтгэх захирлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж, гэрээ байгуулна.

10.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хуралтай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.4. Гүйцэтгэх удирдлага нь өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- 10.4.1. Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 10.4.2. Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, албан тушаалтантай харилцаж, гэрээ хэлэлцээр байгуулах
- 10.4.3. Шүүх төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгж, бусад аливаа этгээдийн өмнө компанийг төлөөлөх
- 10.4.4. Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох
- 10.4.5. Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, биелэлтийг хангах

INNOVATION INVESTMENT LLC
00000264

10.4.6. Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бараа материал, ажил үйлчилгээг худалдан авах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах
10.4.7. Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зөвшөөрөл, гэрчилгээ зэргийг хууль тогтоомжийн дагуу авах ажлыг зохион байгуулах
10.4.8. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах
10.4.9. Монгол Улсын хууль тогтоомж болон ХЭХ-ын шийдвэрийн биелэлтийг хариуцан зохион байгуулах
10.4.10. Компани, түүний бүтэц, зохион байгуулалт, цалингийн сангийн хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдыг авч ажилуулах
10.4.11. Компанийн хөрөнгө устгах, үрэгдэх, алдагдал, дутагдалд орох зэргээр аливаа хөрөнгийн эрсдэлээс боломжит бүх арга хэрэгслийг ашиглан сэргийлэх
10.4.12. Хувьцаа эзэмшигчдэд компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах
10.4.13. Компанид бий болсон үйл ажиллагааны болон санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал, эрсдэл, зөрчлийг хувьцаа эзэмшигчдэд нэн даруй хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх
10.4.14. Монгол Улсын хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан бусад эрх, үүргүүд.

10.5. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас бичгээр олгогдсон зөвшөөрөлгүйгээр компанийн болон бусад хуулийн этгээдийн удирдах дээд байгууллагын гишүүнээр сонгогдох, ажиллах эрхгүй.

## 11. КОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

11.1. Компанийн санхүүгийн тооцоонд компанийн дотоод аудитын алба хяналт тавина.
11.2. Дотоод аудитын албаны дарга болон гишүүдийг ХЭХ-аас 3 жилийн хугацаатай томилно. Дотоод аудитын алба нь дарга болон 2 орон тоо бүхий гишүүдээс бүрдэнэ.
11.3. Дотоод аудитын албаны гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ажилтнуудаас сонгох ба тэдгээр нь компанийн эрх барих байгууллагуудын удирдах албан тушаалтан байж болохгүй.
11.4. Дотоод аудитын албанаас хийх шалгалт нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.
11.5. Дотоод аудитын алба нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд жилд нэг удаа ээлжит шалгалт хийнэ. Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр дотоод аудитын алба нь ээлжит бус шалгалтыг хийж болно.
11.6. Дотоод аудитын алба нь компанийн албан тушаалтнуудаас шаардлагатай бүх материалуудыг үүнд нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн баримтууд, тайлан тооцоо, албан бичиг гэх мэтийг шаардан гаргуулах эрхтэй.
11.7. Дотоод аудитын алба нь өөрийн хийсэн шалгалтын үр дүнгийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах үүрэгтэй.
11.8. Компанийн эрх ашигт хохирол учруулах нөхцөл байдал үүссэн болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс эрх мэдлээ урвуулах буюу хэтрүүлсэн ашигласан үйлдэл илэрсэн тохиолдолд дотоод аудитын алба нь энэ асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах эрхтэй.
11.9. Дотоод аудитын алба нь компанийн жилийн тайланд дүгнэлт гаргана.

## 12. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙГ ХАРИУЦЛАГА

СЭХ 2023 … БҮРТГЭВ №
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20 БҮРТГЭВ
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР
00000265

12.1. Гүйцэтгэх захирал, менежер, ерөнхий санхүүч, ерөнхий инженер, ахлах мэргэжилтнүүдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

12.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй.

12.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх

12.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх

12.2.3. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судлах

12.2.4. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх

12.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдэс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх

12.3. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ХЭХ-ын нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

12.4. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 12.3-т заасан үүргийг хүлээнэ.

12.5. Албан тушаалтан энэ дүрмийн 12.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

12.5.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан

12.5.2. Хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн

12.5.3. Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй

12.5.4. Компанийн тухай хуулийн 97-р зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй

12.6. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

12.7. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ, ТАЙЛАН

13.1. Компани нь Монгол Улсын хуулиар тогтоосон журам болон олон улсын стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

13.2. Компанийн санхүүгийн тайлан үнэн зөв байдалд Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч нар хариуцлага хүлээнэ.

СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01
2023-07-20
INNOVATION INVESTMENT LLC
00000266

13.3. Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тооцоог монгол хэлээр үйлдэх ба шаардлагатай тохиолдолд гадаад хэлээр үйлдэж болно.

13.4. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01-р сарын 01-ний өдөр эхэлж, 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

13.5. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

13.6. Санхүүгийн тайланд дараах мэдээллийг заавал тусгасан байна.

13.6.1. Баланс

13.6.2. Орлогын үр дүнгийн тайлан

13.6.3. Мөнгөн гүйлгээний тайлан

13.6.4. Хуримтлагдсан ашгийн тайлан

13.6.5. Нэмэлт тайлбар тодруулга

13.6.6. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт

13.6.7. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр

13.6.8. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

13.7. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторийг томилон ажиллуулж болно.

13.8. Санхүүгийн тайланг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитийн байгууллагаар хянуулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

13.9. Компани Монгол Улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна.

13.10. Компанийн гүйцэтгэх захирал нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ.

13.10.1. Компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт

13.10.2. Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн

13.10.3. Компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт

## 14. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

14.1. ХЭХ нь санхүүгийн тайланг дараа оны 4-р сарын 30-ны дотор хэлэлцэж, ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргана. ХЭХ-ийн шийдвэрээр ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгож болно.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

14.2. Компани бусдад төлөх бүх өр, төлбөрийг бүрэн төлсний дараа ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

14.3. ХЭХ-аас гаргах ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийн хэмжээтэй холбоотой шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна. /Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023.06.21-ний өдрийн 23/01 тоот тогтоолоор өөрчлөлт оруулав/

14.4. Компани эргүүлж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

## 15. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

15.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн тухай хуульд заасны дагуу компанийг өөрчлөн байгуулж байгуулж болно.

15.2. Дараах үндэслэлээр компанийг татан буулгана.

15.2.1. Компани алдагдалтай ажилласны улмаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон буюу дампуурсан

15.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн

15.2.3. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр

15.3. Компанийг татан буулгах комиссыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно.

15.4. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасан эрхийг эдлэхээс гадна дараах үйл ажиллагааг хариуцан явуулна.

15.4.1. Компанийг татан буулгаж байгаа тухай, нэхэмжлэл гаргах журам, татан буулгах нөхцлийн талаар өдөр тутмын сониноор олон нийтэд мэдээллэнэ.

15.4.2. Компанийн бэлэн байгаа эд хогшил, хөрөнгийг үнэлж зээлдүүлэгч нартай эцсийн тооцоог хийнэ.

15.4.3. Компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хогшил, хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хувь хэмжээтэй нь тэнцүүлэн хуваарилах.

## 16. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

16.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын ердын олонхиор батлаж, Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

16.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 16.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

Энэхүү дүрмийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 6 сарын 21-ний өдөр батлав.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:**

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийг төлөөлж,
итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.ЭРДЭНЭМӨНХ

СЭХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ

2023.06.29 өдөр Бүртгэлийн № 7895
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн тойргийн нотариатч Б.Түвшинжаргал би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Үйлчилгээний хөлсөнд ...... төгрөг хураав.
Нотариатч ......

# 8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 03/2020 тоот тогтоолоор ТУЗ нь 7 ердийн гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 23/08 тоот тогтоолын дагуу дараах байдлаар томилогдон ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Монгол Улсын болон Япон Улсын мэдээллийн технологи, банк, санхүүгийн салбаруудад 10 - 30 гаруй жил ажилласан инженер, бизнес удирдлагаар мэргэшсэн арвин туршлага бүхий гишүүдээс бүрддэг. ТУЗ-ийн гишүүд нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед мэргэжлийн дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд, Гүйцэтгэх удирдлагын зөвлөх болон Монгол Улсын нөлөө бүхий технологийн компаниудын гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа чадварлаг боловсон хүчин юм.

## ТУЗ-ИЙН ДАРГА Д.ДАВАА

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын нэг Д.Даваа нь 2002 онд ШУТИС-ийн Компьютерын ухааны инженерийн бакалаврын зэрэг хамгаалсан бөгөөд мэдээллийн технологийн салбарт болон төрийн албанд 20 гаруй жил ажилласан туүхтэй.

Д.Даваа нь 2001 оноос 2008 он хүртэл Эрүүгийн цагдаагийн газарт төлөөлөгч, ахлах төлөөлөгч, 2008 оноос 2014 он хүртэл Цагдаагийн Ерөнхий Газарт тасгийн дарга, хэлтсийн дарга болон төвийн даргын албан тушаал хашсан. 2014 оноос 2016 он хүртэл "Дайэй Пробис Монгол" ХХК-д менежер албан тушаал хашсан.

Д.Даваа болон Б.Чулуунсүх нар нь 2016 оноос цахим төлбөр тооцооны QPay үйлчилгээг санаачлан "ККТТ" ХХК-иийн үйл ажиллагааг эхлүүлсэн. 2017 онд Үнэт цаас гаргагч "Инновэйшн Инвестмент" ХХК-ийг хамтран үүсгэн байгуулж, 2020 оноос 2021 онуудад Үнэт цаас гаргагчийн Технологи хариуцсан захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирлаар ажилласан. 2021 оноос 2023 он хүртэл "Ай Си Ти Групп" ХК-ийн Технологи хариуцсан захирлын албан тушаал хашсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Д.Даваа нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дарга, Технологи хариуцсан зөвлөхөөр ажиллаж байна.





## ТУЗ-ИЙН ГИШҮҮН У.НАРАНБААТАР

Наранбаатар нь Монгол Улсын банк санхүү, мэдээллийн технологийн салбарт 20 гаруй жил удирдлагын түвшинд ажилласан туршлагатай. Тэрээр 1998 онд ШУТИС-ийн харьяа КТМС-ийг Мэдээллийн технологийн менежмент, Бизнесийн удирдлагын бакалавраар төгссөн. 2000 оноос хойш "Хасбанк" ХХК-ийн Мэдээлэл технологийн газрын захирлаар 7 жил, 2007 - 2009 онд Африк тивийн Кени Улсад "Крафт Силикон" ХХК-ийн Чанарын удирдлагын захирлаар 2 жил ажиллаж байсан. 2009 - 2017 онуудад "Ай Ти Зон" ХХК-ийн Дэд захирал, 2017 оноос хойш Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

У.Наранбаатар нь ТУЗ-ийн 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлын 02/06 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байсан 2023 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

2023 . 11 сар 08 өдөр БҮРТГЭВ
00000269

СЗХ 2023 11 08 БҮРТГЭВ № 11

INNOVATION INVESTMENT

2023-07-20 БҮРТГЭВ-03



## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Б.ЧУЛУУНСҮХ

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчдын нэг Б.Чулуунсүх нь 2005 онд Япон Улсын Акаши хот дахь Акаши техникийн коллеж төгссөн. 2007 онд Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургуульд бакалавр, 2009 онд Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургуульд магистрын зэрэг хамгаалсан.

2009 - 2013 онуудад Б.Чулуунсүх нь Япон Улсын "ЭнТиТи Софтвэйр" компанид системийн инженерээр ажилласан ба 2013 онд Монгол Улсад буцаж ирэн "Дайэй Пробис Монгол" ХХК-д 2016 он хүртэл 3 жил менежерийн албан тушаал хашсан. Энэ хугацаанд Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид онлайн худалдаа, тээврийн чиглэлээр төслүүд хамтран хэрэгжүүлж 2016 оноос финтекийн салбарт хөл тавьж QPay төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2017 онд "Инновэйшн Инвестмент" ХХК-ийг үүсгэн байгуулж Б.Чулуунсүх нь 2018 - 2019 онуудад Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал, 2020 - 2021 онуудад Технологи хариуцсан захирал, 2021 - 2022 онуудад ахин Гүйцэтгэх захирлаар томилогдон ажилласан.

Б.Чулуунсүх нь 2022 оноос "Инновэйшн Инвтестмент" ХХК-ийн Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөхөөр ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН ХОСОКАВА МАСАХИКО



Хосакава Масахико нь 1990 онд Япон Улсын Саппоро хотын Хоккайдо Их Сургуульд инженерийн бакалаврын зэрэг хамгаалсан ба инженер, санхүүгийн чиглэлээр 30 жил, Монгол Улсад удирдлагын түвшинд 8 жил ажилласан түүхтэй. 1990 - 1999 онуудад Япон Улсын "Фужи Хэви Индастрис" ХХК-д агаарын хөлгийн материалын инженер, чанарын инженерээр ажиллаж 1999 - 2016 онуудад Япон Улсын "Ичитака" ХХК-ийн Монгол Улс дахь салбарт бизнес хөгжлийн менежер, Аудитын захирлаар томилогдон ажиллаж байсан.

Хосакава нь "Юнигаз" ХХК-д 2004 - 2006 онуудад Гүйцэтгэх захирал, 2010

- 2015 онуудад Гүйцэтгэх захирлын орлогч, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан.

Тэрээр 2016 оноос хойш Япон Улсын мэдээллийн технологи, сурталчилгааны групп компани "Юнимедиа" ХХК-ийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газарт Ерөнхий менежер, түүний охин компани болох "Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна

INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

00000270

СЗХ
2023 .11. 09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE





## ТУЗ-ИЙН ГИШҮҮН А.БАТТАМИР

ТУЗ-ийн гишүүн А.Баттамир нь 2003 онд ШУТИС-ийн харъяа КтМС-д Программ хангамжийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалж, 2019 онд ШУТИС-ийн харъяа ХоМТС-д Компьютерийн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

А.Баттамир нь 2002-2009 онуудад Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвд Программист, 2009-2011 онуудад Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх, 2011-2012 онуудад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд Дэлхийн банкны төслийн дотоодын зөвлөх, 2011-2023 онуудад "АйТүүлс" ХК-д хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, 2013-2023 онуудуд "Ай Си Ти Групп" ХК-д хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Г. ЛХАМСҮРЭН

Г.Лхамсүрэн нь 2002 онд ШУТИС-д Хөнгөн үйлдвэрийн менежментийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2007-2009 онуудад "Лайфтайм Инвестмент" ХХК-д Дэд захирал, 2009-2010 онд "Хера Холдинг" ХХК-д Бизнес хөгжил, Маркетингийн албаны дарга, 2011-2018 онуудад "Стандарт Инвестмент" ХХК-д Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, 2011-2013 онуудад "Айтүүлс" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, 2013-2023 онуудад "Ай Си Ти Групп" ХК-д Хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед Г.Лхамсүрэн нь "Ай Си Ти Групп" ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Мөн Г.Лхамсүрэн нь 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
00000271

СЭХ 2023. 11. 08 БҮРТГЭВ №01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-03

## ТУЗ-ИЙН ГИШҮҮН Б.АНХБОЛД



Б.Анхболд нь 2004 онд Япон Улсын Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр, 2006 онд Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан бөгөөд бизнесийн салбарт 15 гаруй жил ажилласан түүхтэй.

Тэрээр 2006 оноос 2012 оныг хүртэл Япон Улсын "Abeam Консалтинг" ХХК-д Менежментийн зөвлөх, 2012 оноос 2015 оныг хүртэл "Шунхлай Групп" ХХК-д Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан бөгөөд 2016 оноос хойш одоог хүртэл "Эс Ай Би Жэй Капитал" ГХОХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Б.Анхболд нь 2023 оноос эхлэн "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.АМАРЖАРГАЛ

Э.Амаржаргал нь 2005 онд Монгол Улсын Соёл Эрдэм Дээд Сургуулийг Олон улсын харилцааны сэтгүүлчийн мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2005 - 2006 онуудад "Жуулчин" ХК-д Япон зах зээлийн менежерээр, 2007 - 2013 онуудад "Бютик Монгол" ХХК-д 3D модел инженерээр ажилласан туршлагатай. 2013 оноос хойш "Юнимедиа Солюшнс" ХХК-ийн Захиргаа хүний нөөцийн менежерээр ажиллаж байна.

2020 онд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC

ХХК 6183655 9021031195 СТС2420 00000272

# 10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТАНИЛЦУУЛГА



## Г. ЭРДЭНЭМӨНХ
## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2016**
Австрали Улсын Сиднэй хотын Macquarie Их Сургууль - Олон улсын харилцаа, Магистр;

**2016**
Австрали Улсын Сиднэй хотын Macquarie Их Сургууль - Олон улсын бизнес менежмент, Магистр;

**2013**
Австрали Улсын Сиднэй хотын Charles Sturt Их Сургууль - Бизнесийн удирдлага, Бакалавр;

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
“Инновэйшн Инвестмент“ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2019-оноос**
“ККТТ“ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2019**
“ККТТ“ ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал

**2017-2019**
“Моником Экспресс“ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2015-2017**
Австрали Улсын Сиднэй хотын Маквайри (Macquirie) Их Сургуульд Судлаач

**2015-2016**
Reed Exhibitions – Эвент төлөвлөлт, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн

**2014**
Швейцар Улсын Хөгжүүлэлтийн Агентлагийн Бизнесийн шинжээч

00000273

СЭХ 2023.11.08 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-СЭ



## Б.ЭНХБОЛД
## САНХҮҮ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2010**
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль - Санхүүгийн менежмент, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2021 оноос**
“Инновэйшн Инвестмент“ ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал

**2020-2021**
“Худалдаа Хөгжлийн Банк“ ХХК
Ахлах дилер

**2014-2020**
“Худалдаа Хөгжлийн Банк“ ХХК
Ахлах шинжээч

**2010-2014**
“Худалдаа Хөгжлийн Банк“ ХХК
Шинжээч

## Я.ОЮУНХАНД
## ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

### БОЛОВСРОЛ

**2014 он**
Мандах Бүртгэл Дээд Сургууль – Нягтлан бодогч

**2006**
Удирдлагын Академи – Бизнесийн удирдлага, Магистр

**2003**
Олон Улс Судлалын Дээд Сургууль – Гадаад харилцаа, Бакалавр;

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2019 оноос**
“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

**2013-2019**
“Мибостар” ХХК-ийн Нягтлан бодогч

**2007-2013**
Техник, Технологийн Дээд Сургуулийн Ерөнхий нягтлан бодогч, хүний нөөцийн менежер, тооцооны нягтлан бодогч



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ INNOVATION INVESTMENT LLC 1117242908 6183948

00000274

СЭХ
2023 оны 11 сарын 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



## Д.ХҮРЭЛТОГОО
## ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2005**
ШУТИС – Эдийн засгийн математик загварчлал, Бакалавр

**2008**
International Institute for Learning - Төслийн удирдлага, Магистр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
2022 оноос "Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал

**2015-2022**
"Голомт Банк" ХХК-ийн Төслийн удирдлагын хэлтсийн ахлах

**2012-2015**
"Оюутолгой" ХХК-ийн Төслийн менежер

**2008-2012**
"Интерактив" ХХК-ийн Төсөл хариуцсан захирал

**2005-2008**
"Ньюком Системс" ХХК-ийн Төслийн менежер

## Ц. ГОМБОДОРЖ
## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



### БОЛОВСРОЛ

**2006 он**
МУБИС-ийн харьяа Компьютер мэдээллийн технологийн сургууль – Багш, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал

**2019-оноос**
Мэдээллийн аюулгүй байдлын ахлах инженер, МАБ

**2016-2019**
Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газрын Ахлах ажилтан

**2009-2016**
ЦЕГ – системийн ахлах инженер

**2007-2009**
"Инфокон" ХХК-ийг Техникийн орчуулагч

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
5183855
9021031195
СТС2420
00000275

СЭХ
2023 .11. 06
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН Б...
2023 07 26
БҮРТГЭВ-03



## Д. ЖАНЧИВ
## ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2013 он**
ШУТИС-ийн харъяа КТМС – Программ хангамжийн инженер, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан захирал

**2017-оноос**
"ККТТ" ХХК-ийн Ахлах программ хөгжүүлэгч, Технологи хариуцсан захирал

**2013-2017**
"Интерактив" ХХК-ийн Ахлах программ хөгжүүлэгч

## О. ХОНГОР
## БИЗНЕС ХӨГЖИЛ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2008 он**
БНХАУ-ын Бээжин хот дахь Яни ЖиЯао Технологийн Дээд Сургууль – Хятад хэл

**2007 он**
ОХУ-ын Байкальский государственный университет экономи и права – Орос хэл

**2006 он**
Монгол Олон Улсын Дээд Сургууль (MIU) – Бизнесийн удирдлага, Бакалавр



### АЖЛЫН ТУРШЛАГА

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал

**2017-2022**
"ККТТ" ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер, Бизнес хөгжил хариуцсан захирал

**2014-2017**
"Нэгдүн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2012-2014**
"Страйп Пэймэнт" ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер

ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
1117242908 6183948

УЛААНБ...
ӨЛЗИЙ КАПИТАЛ ХХК
9021031... 5183855

СЗХ 2023 11 08 өдөр БҮРТГЭВ № 01

INNOVATION INVESTMENT

БҮРТГЭВ-03



## С. ГҮРЖАВ

## "ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

### БОЛОВСРОЛ

**2002 он**
Отгонтэнгэр Их Сургууль – Эдийн засагч, Бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА

**2019 оноос**
"Дижитал Мерчант Сервисэс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2018-2019**
"ККТТ" ХХК-ийн Байгууллага хариуцсан менежер

**2003-2018**
Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсийн Байцаагч, Тасгийн дарга

**2001-2003**
"Ти Эл Зэт" ХХК-ийн Менежер

УЛААНБААТАР ХОТ ӨНДӨР ЭНДЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

00000277

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

БҮРТГЭВ-03

INNOVATION INVESTMENT

## 10.1. Үнэт цаас гаргагчийн мэргэжлийн зөвлөхүүд



### ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ Д.ДАВАА

**БОЛОВСРОЛ**

**2002 он**
2002 – ШУТИС – Компьютерын ухааны инженер, Бакалавр

**АЖЛЫН ТУРШЛАГА**

**2021 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан зөвлөх

**2021-2023 он**
"Ай Си Ти Групп" ХК-ийн Технологи хариуцсан захирал

**2019-2021 он**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Технологи хариуцсан захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирал

**2014-2016 он**
"Дайэй Пробис Монгол" ХХК-д Менежер

**2008-2014 он**
Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын Тасгийн дарга, Хэлтсийн дарга, Төвийн дарга

**2001-2008 он**
Монгол Улсын Эрүүгийн Цагдаагийн Газар – Төлөөлөгч, Ахлах төлөөлөгч

### ХАМТРАН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ Б. ЧУЛУУНСҮХ

**БОЛОВСРОЛ**

**2009 он**
Япон Улсын Цахилгаан холбооны их сургууль – Мэдээлэл холбоо, Магистр

**2007 он**
Япон Улсын Цахилгаан Холбооны Их Сургууль – Мэдээлэл холбоо, Бакалавр

**2005 он**
Япон Улсын Акаши хот дахь Акаши техникийн коллеж

**АЖЛЫН ТУРШЛАГА**

**2022 оноос**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Судалгаа хөгжүүлэлт хариуцсан зөвлөх

**2018-2019; 2021-2022 он**
"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**2020-2021 он**
Инновэйшн Инвестмент ХХК-ийн Технологи хариуцсан захирал

**2013-2016 он**
Дайэй Пробис Монгол ХХК-ийн Менежер;

**2009-2013 он**
Япон Улсад "ЭнТиТи Софтвэйр" ХХК-ийн Систем инженер.



00000278

СЗХ 2023.11.06 БҮРТГЭВ № 01

БҮРТГЭВ-03

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ



## МАСАНОРИ ОКОШИ

Япон Улсын иргэн Масанори Окоши нь 1987 оноос хойш андеррайтер, хөрөнгө оруулалт, санхүү, борлуулалт, менежмент чиглэлээр 30 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн QPay үйлчилгээг 2016 онд хөгжүүлж эхлэхээс эхлэн санхүү, удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үүрэг гүйцэтгэж ирсэн. Түүний амжилтуудаас дурдвал, "Вако" (Мизүхо) ҮЦК-д андеррайтераар ажиллах хугацаанд гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийх, бойжуулах төслүүдийг удирдан ажилласан. Үүний дараа, 1998 онд өнөөдөр Viber аппликэйшнээр олон нийтэд танигдсан "Ракутен" ХК-ийн IPO-г хариуцан ажиллаж эхэлсэн ба 2000 онд амжилттай гүйцэтгэж 49.5 тэрбум иений хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. Түүнчлэн, "Ракутен" ХК-ийн Борлуулалтын газрыг үүсгэн байгуулж хариуцсан захирлаар нь ажиллаж, Захирлын алба болон Аудитын албаны даргын үүрэг гүйцэтгэх хугацаандаа бизнесийн хамтын ажиллагаа, M&A үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан туршлагатай.

Масанори Окоши нь "Ракутен" ХК-ээс 2007 онд гарж, тухайн жилдээ нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийн бизнесийг үүсгэн байгуулсан ба 2020 онд бизнесээ амжилттай үнэлэн зарсан.

2007 онд "Эксперт Аллайнс Даатгалын Бэлтгэл" ХХК (Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй)-д зөвлөх болон хувийн хөрөнгө оруулалт хийсэн. 2008 онд "Ракүтэн" ХК-д Амь насны даатгалын бизнесийг санал болгож, Эксперт Аллайнс Даатгалын бизнес (Аирио Амь насны даатгал)-ийг 100% амжилттай худалдсан ба түүний дараа тус компани нь "Ракүтэн Лайф Иншюранс" ХХК болж нэрээ өөрчилсөн.

## БОЛОВСРОЛ

**1987 он**
**Япон Улсын Чиёода хотын Нихон Их Сургууль**

## АЖЛЫН ТУРШЛАГА

**2021 оноос**
**Япон Улсын "Конверш Технологи" ХХК-ийн Хараат бус ТУЗ-ийн гишүүн бөгөөд Менежментийн зөвлөгөө өгч ажилладаг**

**2020 оноос**
**Япон Улсын "ИСи Сервис" ХХК-д Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Борлуулалт, харилцагч хариуцсан захирал**

**2016 оноос**
**"ККТТ" ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан зөвлөх**

**2010 оноос**
**Япон Улсын "Сатера" ХХК-ийн Хараат бус ТУЗ-ийн гишүүн, зөвлөх**

**2007-2020 он**
**Япон Улсын "Фул Корпораци" ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал**

**1998-2007 он**
**Япон Улсын "Ракүтэн" ХК (хуучин "ЭмДиЭм" ХХК байсан)-ийн Борлуулалт хариуцсан захирал, Захирлын, албаны дарга, Аудитын албаны дарга**

УЛААНБААТАР ХОТ
6183855
9021031195 СТС2420

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК

00000279

СЗХ
2023.11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-10-19
БҮРТГЭВ-03

# ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

**Үнэлгээний ажил:** Инновэйшн Инвестмент ХХК-ийн IPO зориулалтаар хийсэн хараат бус бизнесийн үнэлгээний тайлан

**Тайлангийн огноо:** 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдөр

**Үнэлгээчин:** Гэрэгэ Эстимэйт ХХК

Эрдэм товер 1004 тоот
Сүхбаатарын талбай 20-6
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол Улс

Утас: 70005000
Имэйл: gantulga@geregepartners.mn, ganbaatar@geregepartners.mn
Вебсайт: www.geregepartners.mn

2023 оны 10-р сарын 19-ний өдөр

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

УЛААНБААТАР ХОТ
БЭЙЗИН ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-10-19
БҮРТГЭВ-03

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

"ӨЛЗИЙ ЭНД КО ҮКЦ" ХХК-Д

2023 оны 10-р сарын 19-ний өдөр

**Үнэлгээний тайланд нэмэлт тайлбар, тодруулга хүргүүлэх тухай**

Танай компанийн хүсэлтийн дагуу бид Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 5/3991 тоотоор ирүүлсэн тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Бид өмнө нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг тус компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдөр хүргүүлсэн билээ.

Энэхүү нэмэлт тайлбар, тодруулга нь дээр дурдсан үнэлгээний тайлангийн нэмэлт хавсралт бөгөөд тайлбарыг өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Нэмэлт тайлбартай холбоотой асуулт, тодруулга байвал бидэнтэй холбоо барихыг хүсье.

Хүндэтгэсэн,

Д. Ганбаатар
МУ-ын мэргэшсэн үнэлгээчин
Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS
МУ-ын мэргэшсэн үнэлгээчин
Зөвлөх үнэлгээчин

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
Үнэт цаас гаргагч
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
Андеррайтер
5183855
9021031195 СТС2420



000281

СЗХ 2023.11.08 өдөр БҮРТГЭВ №31

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-10-19 БҮРТГЭВ-03

# НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

## 1. БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

Инновэйшн Инвестмент ХХК-тай байгуулсан 2023 оны ГЭ-07/23 дугаар "Бизнесийн үнэлгээ хийх гэрээ"-ний ажлын даалгаврын дагуу Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагч компанийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар IPO зориулалтаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Бид Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний хүрээнд тус компанийн бүх хөрөнгийн санхүүгийн тайланд тусгагдсан үнэ нь бодит үнэ цэнээс өөрчлөлттэй эсэх, энэхүү өөрчлөлт нь бизнес өмчлөлийн үнэ цэнийн тооцоололд материаллаг нөлөө үзүүлэх эсэхийг шинжилсэн болно.

Харин Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээт ажлын даалгаварт Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд тусаагүй аливаа биет бус хөрөнгийн үнэ цэнийг тусгайлан тооцоолох ажил ороогүй болно. Түүнчлэн IPO зориулалтаар хийсэн бизнесийн үнэлгээний үр дүнг тооцоолоход хөрөнгөд суурилсан үнэлгээний үр дүнг ашиглаагүй тул биет бус хөрөнгийн үнэ цэнийг тусгайлан тооцоолох шаардлага үүсээгүй болно.

Инновэйшн Инвестмент ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалж эхэлснээр тус компанийн хувьцааны буюу бизнес өмчлөлийн үнэ цэнэ хөрөнгийн захын үнээр тодорхойлогдоно. Иймд Инновэйшн Инвестмент ХХК-ийн биет бус хөрөнгийн үнэ цэнийг МХБ дээрх тус компанийн зах зээлийн үнэ (market capitalization)-тэй уялдуулан тооцоолж санхүүгийн тайланд тусгах боломжтой.

## 2. ГҮЙЛГЭЭНИЙ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТИЙН ТООЦООЛЛЫН ТАЛААР

Монгол Улсын интернет болон мобайл банкны нийт гүйлгээний дүн 2018 оноос 2022 оны хооронд жилд дундажаар (CAGR) 28.0%, 2022 онд 58.6% өсөж 321.8 их наяд төгрөг болсон байна. 2022 онд интернет болон мобайл банкны гүйлгээний нийт тоо 845.4 сая ширхэг, нэгж гүйлгээний дундаж дүн 380.7 мянган төгрөг байсан.[1]

Хөдөлгөөнт банкны 2022 оны 58.6%-ийн өсөлт ирэх 5 жилд дундажаар бүс нутгийн буюу Ази Номхон Далайн улсуудын дундажтай ижил байна, өөрөөр хэлбэл ам.доллараар 13.4% буюу төгрөгөөр 19.3%-иар өснө, ингэхдээ 2022 оны өндөр өсөлт аажмаар гөлгөр байдлаар жигд буурч 2027 онд тогтворжиж нийт эдийн засгийн өсөлт буюу нэрлэсэн ДНБ-ний өсөлтийн төсөөлөл болох 11.8%-тай ижил болно гэж Үнэлгээчид төсөөлсөн болно.

[1] https://stat.mongolbank.mn

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948

Үнэт цаас гаргагч

Аудитор

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420



000282

СЗХ
2023 .11.08 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-10-19
БҮРТГЭВ-03

Эдийн засаг, санхүүгийн тооцооллын зах зээлийн тэлэлт, ханалт (market maturity)-ыг төсөөлөлд Tornquist функцыг өргөн ашигладаг. Жишээ[2]-г үзүүлэв.

Хөдөлгөөнт банкны гүйлгээний дүнгийн 2022 онд 58.6% буюу өндөр өсөлтөөс 2027 онд 11.8% буюу богино хугацаанд харьцангүй бага өсөлтөд хүрч зах зээл тогтворжино гэж төсөөлсөн тул өсөлтийн тооцоололд y = a/(x+b) + c Tornquist функцыг ашиглан холбогдох коэффициентүүдийг дараах байдлаар тооцоолж үнэлгээнд ашигласан.

| | | | |
|---|---|---|---|
| a = | 0.7 | b = | 0.21 |
| Goal seek | 0 | by changing c = | 0.5% |

Дээрх мэдээлэл нь 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр СЗХ-нд цахимаар хүргүүлсэн *Valuation_Innovation investment_Value.xlsx* эксел файлын *Calculations* хуудасны тооцоолол хэсэгт орсон болно.

Тооцооллын үр дүнд Монгол Улсын хөдөлгөөнт банкны зах зээлийг дараах байдлаар тооцоолсон болно.

| | Нэгж | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйлгээний дүнгийн өсөлт | *хувь* | 58.6% | 32.3% | 22.4% | 17.2% | 14.0% | 11.8% |
| Нэгж гүйлгээний дүн | *мянган төгрөг* | 380.7 | 419.1 | 456.4 | 490.6 | 525.0 | 556.5 |
| Гүйлгээний дүн | *тэрбум төгрөг* | 321,799.7 | 425,710.5 | 520,975.3 | 610,445.0 | 695,703.9 | 777,745.2 |
| Гүйлгээний тоо | *мянган ширхэг* | 845,387.8 | 1,015,774.5 | 1,141,490.4 | 1,244,208.5 | 1,325,218.0 | 1,397,636.8 |
| Өсөлт | *хувь* | 53.3% | 20.2% | 12.4% | 9.0% | 6.5% | 5.5% |

Монгол Улсад 2022 онд картын нийт 713.7 сая ширхэг гүйлгээгээр 51.3 их наяд төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна. Картын гүйлгээний дүн 2021 онд 15.6%, 2022 онд 19.2% тус тус өссөн байна.[1] Картын гүйлгээний дүн 2023 онд өмнөх 2 жилийн дундаж буюу 17.4%-иар өсөх, цаашид өсөлт жигд буурч 2027 онд ДНБ-ний өсөлттэй ижил буюу 11.8%-д очихоор төсөөлсөн.

Картны гүйлгээний дүнгийн өсөлт 2022 онд 19.2% буюу 2027 оны төсөөлөл болох 11.8%-тай харьцангүй ойролцоо байгаа тул бууралтыг шулуун байдлаар авсан болно. Учир нь эхний бөгөөд эцсийн утга ойролцоо үед Tornquist функц нь шугаман функцтай ойролцоо үр дүн өгдөг.

Тооцооллын үр дүнд Монгол Улсын хөдөлгөөнт банкны зах зээлийг дараах байдлаар төсөөлсөн болно.

| | Нэгж | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гүйлгээний дүн | *тэрбум төгрөг* | 51,263.6 | 60,177.6 | 69,799.7 | 79,983.8 | 90,534.9 | 101,211.3 |
| Өсөлт | *хувь* | 19.2% | 17.4% | 16.0% | 14.6% | 13.2% | 11.8% |
| Гүйлгээний тоо | *мянган ширхэг* | 713,708.5 | 760,955.6 | 810,494.9 | 863,954.0 | 913,946.6 | 963,890.9 |
| Өсөлт | *хувь* | 22.3% | 6.6% | 6.5% | 6.6% | 5.8% | 5.5% |
| Нэгж гүйлгээний дүн | *мянган төгрөг* | 71.8 | 79.1 | 86.1 | 92.6 | 99.1 | 105.0 |

2 https://www.researchgate.net/figure/Toernquist-function-demand-schedule-analyzed-in-the-context-of-the-needs-in-financial_fig1_269831858

Үнэт цаас гаргагч

Андеррайтер



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 6183948

УЛААНБААТАР ХОТ
ЭЗЭН ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

000283

Үнэт цаас гаргагчийн мөнгөн бус зардал, мөнгөн бус ажлын капиталын өөрчлөлт, капитал зарцуулалт болон бусад үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө өнгөрсөн жилүүдийн гүйцэтгэлтэй уялдуулдан шинжилгээ хийсний үндсэн дээр үнэлгээнд авч ашигласан болно. Инновэйшн Инвестмент ХХК нь толгй компани учир охин компаниуд болон толгой компанийн хоорондох гүйлгээг нэгтгэсэн санхүүгийн тайланд цэвэрлэж тохируулга хийсэн болно. Тохируулгыг үзүүлбэл:

| Орлогын үзүүлэлтүүд | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 95% | 89% | 86% | 79% | 80% | 81% |
| Хүүгийн болон бусад цэвэр орлого | 62% | 30% | 24% | 10% | 13% | 17% |
| Борлуулалт, маркетингийн зардал | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Санхүүгийн зардал | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Бусад зардал | 42% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| Бусад олз гарз | 60% | | | | | |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | 98% | 100% | 100% | 80% | 79% | 78% |
| Орлогын татвар | 100% | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **98%** | **100%** | **100%** | **77%** | **75%** | **74%** |

Дээрх үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр СЗХ-нд цахимаар хүргүүлсэн *Valuation_Innovation investment_Value.xlsx* эксел файлын *Financials_IS* хуудаснаас танилцах боломжтой.

## 3. СЗХ-НЫ 2012 ОНЫ 122-Р ТОГТООЛЫН 3.1.4, САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН 2011 ОНЫ 274/240 ТОГТООЛЫН 2.6.1 ДЭХ ЗААЛТУУДЫН МӨРДӨЛТИЙН ТУХАЙ

СЗХ-ны 122 дугаар тогтоолоор баталсан "Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар"-ын 3.1.4-д шинээр болон нэмэлт хувьцаа гаргаж байгаа тохиолдолд бизнесийн үнэлгээг хөрөнгө оруулалт хийхээс өмнөх болон хийсний дараах 2 үеэр хийж ирүүлэхээр заасан байна.

Үнэлгээнд мөнгө орж ирэхээс өмнөх болон дараах үеийн үнэлгээг авч үзсэн болно. Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 44,795,662,890 (Дөчин дөрвөн тэрбум долоон зуун ерэн таван сая зургаан зуун жаран хоёр мянга найман зуун ерэн) төгрөг байхаар тооцоолсон нь нэмэлт санхүүжилт орж ирсэний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно.

Хөрөнгө оруулалт хийхээс өмнөх болон хийсний дараах үнэлгээний зөрүү нь IPO-оор татах шинэ мөнгөний дүнтэй ижил буюу дараах байдлаар тодорхойлогдоно.

| | | |
|---|---|---|
| **Олон нийтээс хөрөнгө татахаас өмнөх үнэлгээ = (Pre-Money valuation)** | **Олон нийтээс хөрөнгө татсаны дараах үнэлгээ - (Post-Money valuation)** | **Шинэ мөнгө буюу компанийн эздийн өмчийг нэмэгдүүлэх хөрөнгийн дүн (New money)** |

Үнэт цаас гаргагч

Андеррайтер



СЗХ 2023.11.08 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-10-19 БҮРТГЭВ-03
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК INNOVATION INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ 1117242908 6183948
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420
000284

Үнэт цаас гаргагч нь IPO хөрөнгө оруулалтаар нийт хувь эзэмшлийн 20%-ийг олон нийтэд санал болгох тул хөрөнгө оруулалт хийхээс өмнөх үеийн үнэлгээ нь 35,836,530,312 төгрөг болно.

Хөрөнгө оруулалт хийхээс өмнөх болон хийсний дараах 2 үеийн үнэлгээний аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Харвардын Бизнесийн Сургуулийн "A Note on Pre-Money and Post-Money Valuation"[3] хэвлэлээс танилцах боломжтой.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 274/240 тоот тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын 2.6.1-д бизнесийн үнэлгээг хийхдээ хяналттайн нэмэгдүүлэг, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулгыг тооцохоор заасан байна.

Гэрэгэ Эстимэйт ХХК нь 100 хувь өмчлөлийн үнэлгээ ба хувьцаатай холбоотой (хөрвөх чадварын, minority shareholder) хямдруулалтууд үнэлгээнд тооцогдоогүйгээр 44.8 тэрбум буюу нэгж хувьцааны үнэ 242 төгрөг байхаар тооцоолсон. Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, компанийн хувьцаа эзэмшлийн бүтэц болон олон улсын зах зээлийн нөхцөл байдалд үндэслэн хяналтгүйн хувь оролцоонд зориулан 7.13 хувийн хөнгөлөлт үзүүлэн 225 төгрөгөөр санал болгохоор шийдвэрлэсэн. Үүнд:

1. **Хяналтгүйн оролцоонны хорогдуулга**

Minority discount буюу discount for lack of control (DLOC) болон бусад төрлийн хорогдуулга, нэмэгдүүлэг бизнесийн үнэ цэн тооцоход ашиглаж болдог. Discount for lack of control нь товчхондоо жижиглэнгийн хувьцаа эзэмшигч нь тухайн компанид хяналт тогтоох чадваргүйн улмаас түүний хувьд компанийн үнэлгээ хямдралтайгаар санал болгогддог байна. Дараах хүчин зүйлсээс хяналт тогтоох чадваргүй, тухайн хөрөнгө оруулагчийн хувьд хямдралтай үнэлгээтэй байдаг байна.

1. ТУЗ-ийн гишүүн дангаар сонгох чадваргүй
2. Удирдлагын баг томилох чадваргүй
3. Ногдол ашгийн бодлогод нөлөөлөх чадваргүй
4. Цалин, урамшууллалд нөлөөлөх боломжгүй
5. Компанийн стратегид нөлөөгүй
6. Компанийн хөрөнгө зарж борлуулахад нөлөөгүй
7. Компани нэгтгэх, нийлүүлэх, тусгаарлах, татан буулгах, хэлбэрийг өөрчлөх болон бусад байдлаар өөрчлөн байгуулах чадваргүй
8. Компанийн дүрмийн өөрчлөлтөд нөлөөгүй
9. Их хэмжээний хэлцэлд нөлөөгүй
10. Компанийн ирээдүйн цэвэр ашигт нөлөөлөх боломжгүй
11. Компанийн ирээдүйн өсөлтөд нөлөөлөх боломжгүй зэргээс үүдэн жижиг хувьцаа эзэмшигчид санал болгоход хувьцааны үнэлгээнд хямдруулалт тогтоодог байна.

Энэ хямдруулалтыг тогтоох нь ихэвчлэн majority shareholder-тэй буюу нөлөө бүхий том хувьцаа эзэмшигчтэй нээлттэй компанийн хувьд тогтоодог эмпирик судалгаа бий (Graham and

[3] http://languageofbusiness.biz/wp-content/uploads/2015/09/Note-on-Pre-Money-and-Post-Money-Valuation-A.pdf



Үнэт цаас гаргагч ____ Андеррайтер ____

000285

Lefanowicz, 1997). Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн нэмэгдүүлэг буюу majority shareholder premium нь хяналтгүйн оролцооны хямдруулалтын эсрэг ойлголт ба энэхүү хямдруулалт, нэмэгдүүлгийн зөрүү 15—20%-тай байдаг байна (Aswath Damodaran, 1993). Мөн minority discount-ийг inverted control premium буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эсрэг ойлголт гэж үздэг байна (Pratt, 2009; Schweihs, 2010; CFA Insitute, 2018). Minority discount-ийн хямдруулалтын хувь нь олон улсад 7%-аас (Bajaj et al., 1990-1995) 48.67% хүртэл байдаг байна (Willamette Management Associates, 1891-1984).

## 2. Монгол улсын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал ба хөрөнгө оруулагчдын хүлээлт

2022 оноос эхлэн олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгосон компаниуд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцооны хямдруулалтыг 1%-10% хооронд санал болгосон байна. Иймд санал болгосон хямдруулалтын хувь нь зах зээлд санал болгосон хямдруулалтын хувиудын хүрээнд багтахаар байна.

| | Хувьцаат компанийн нэр | Бүртгэгдсэн огноо | Үнэлгээ | Санал болгосон үнэ | Minority discount | Хяналтын багц эзэмшигч |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Хас банк" ХК | 6/6/2023 | 667 | 667 | Байхгүй | Tenger Financial Group- 94.9% |
| 2 | "Худалдаа хөгжлийн банк" ХК | 5/24/2023 | 32,268.0 | 33,000* | 2.27% | Global Investment&Development- 61% |
| 3 | "Газар шим үйлдвэр" ХК | 4/1/2023 | 54.3 | 53 | -2.43% | Хувь хүн-42.64% |
| 4 | "Хаан Банк" ХК | 4/19/2023 | 859.4 | 959 | 12% | HS Holding-41% |
| 5 | "Монголын Хөрөнгийн Бирж" ХК | 1/2/2023 | 104.9 | 100 | -4.60% | Сангийн яам-66% |
| Х 6 | "Голомт Банк" ХК | 12/5/2022 | 1,298 | 1,285 | -1.00% | Golomt Financial Group- 77% |
| 7 | "Төрийн Банк" ХК | 10/10/2022 | 659 | 590 | -10.50% | Сангийн яам-49%, Хадгаламж даатгалын корпораци-45% |
| 8 | "Сэндли ББСБ" ХК | 7/26/2022 | 153 | 150 | -1.60% | Монгол финтек групп-56% |

*- суурь үнэлгээнээс тооцсон

Үнэт цаас гаргагч



Андеррайтер

000286

## 3. Компанийн хувьцаа эзэмшлийн бүтэц

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтцэд хяналтын багц эзэмшигч байхгүй, хувьцааны эзэмшлийн төвлөрөл бага төдийгүй гадаад болон дотоодын хуулийн этгээд болон хувь хүн зэрэг 16 орчим этгээд эзэмшиж байна. Тус хувьцаа эзэмшигчдийн мөн жижиглэнгийн хувьцаа эзэмшигч гэж үзэж болох буюу аль ч тохиолдолд majority shareholder байхгүй байгаа тул minority shareholder discount үзүүлэх шаардлаггүй ч байж болохоор байсан боловч Үнэт цаас гаргагч тус хямдруулалттай шинэ хувьцаа эзэмшигчиддээ санал болгож байгаа.

| | Хувьцаа эзэмшигчдийн нэр | |
|---|---|---|
| 1 | "Ай Си Ти Групп" ХК | 18% |
| 2 | Дамдинсүрэн Даваа | 5% |
| 3 | Чойжоохүү Нарангэрэл | 9% |
| 4 | "Юнимедиа Солюшнс" ХХК | 8% |
| 5 | "Айкор Партнерс" ХХК | 8% |
| 6 | "Рентракс" ХК | 6% |
| 7 | Батзориг Чулуунсүх | 5% |
| 8 | Шаравхорол Эрдэнэбилэг | 5% |
| 9 | "Могул" ХХК | 4% |
| 10 | Масанори Окоши | 2% |
| 11 | "НОБ" ХХК | 1% |
| 12 | "Глобал Траст Нетворкс" ХК | 1% |
| 13 | Шоичиро Ичитани | 1% |
| 14 | Такахиро Ичики | 1% |
| 15 | Мөнхчулуун Мөнхбаяр | 1% |
| 16 | ККТТ ХХК | 4% |
| 17 | Олон нийт | 20% |
| | Нийт | 100% |

Үнэт цаас гаргагч

Андеррайтер



000287

СЗХ
2023.11.08
БҮРТГЭВ

# ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА - 2

**Үнэлгээний ажил:** Инновэйшн Инвестмент ХХК-ийн IPO зориулалтаар хийсэн хараат бус бизнесийн үнэлгээний тайлан

**Тайлангийн огноо:** 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдөр

**Үнэлгээчин:** Гэрэгэ Эстимэйт ХХК

Эрдэм товер 1004 тоот
Сүхбаатарын талбай 20-6
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол Улс

Утас: 70005000
Имэйл: gantulga@geregepartners.mn, ganbaatar@geregepartners.mn
Вебсайт: www.geregepartners.mn

2023 оны 10-р сарын 30-ны өдөр

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

000288

**"ӨЛЗИЙ ЭНД КО ҮКЦ" ХХК-Д**
Улаанбаатар хот, СБД, Сити тауэр
25 давхар, 2506 тоот

2023 оны 10-р сарын 30-ны өдөр

**Үнэлгээний тайланд нэмэлт тайлбар, тодруулга хүргүүлэх тухай**

Бид өмнө нь Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг тус компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдөр хүргүүлсэн билээ.

Түүнчлэн Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр томилогдсон Шинжээчдийн 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ШД318/23 тоот дүгнэлттэй холбоотой Үнэлгээний ажлын нэмэлт тайлбар, тодруулгыг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн болно.

Энэхүү Үнэлгээний ажлын нэмэлт тайлбар, тодруулга 2 нь нь дээр дурдсан үнэлгээний тайлангийн нэмэлт хавсралт бөгөөд үнэлгээний тайлангийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно. Энэ тайлбарыг өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Нэмэлт тайлбартай холбоотой асуулт, тодруулга байвал бидэнтэй холбоо барихыг хүсье.

Хүндэтгэсэн,

Д. Ганбаатар
МУ-ын мэргэшсэн үнэлгээчин
Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS
МУ-ын мэргэшсэн үнэлгээчин
Зөвлөх үнэлгээчин

*Хувийг Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр томилогдсон Шинжээчдийн багт хүргүүлэв.*

СЗХ
2023 .11 он 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023 ... 0..
БҮРТГЭВ-02

# НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА -2

2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

2023 оны 10 дугаар сарын 19-ны өдөр хүргүүлсэн Үнэлгээний ажлын нэмэлт тайлбар, тодруулга нь 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн "Бизнесийн үнэлгээний тайлан"-гийн салшгүй хэсэг бөгөөд үнэлгээний тайланд нэмэлт хавсралтаар орсон тул тус тайланд туссан гэж үзэж байна.

Шинжээчдийн багт дараах нэмэлт тайлбар, тодруулгыг хүргүүлж байна.

## 1. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ТУСГАХ

Инновэйшн Инвестмент ХХК нь МХБ дээр өөрийн энгийн хувьцааны 20%- тай тэнцэх үнийн дүн бүхий хувьцааг олон нийтэд санал болгож нэмэлт санхүүжилт татахаар төлөвлөж байсан бөгөөд мөнгөн дүнг бизнесийн үнэлгээнийн үр дүнд үндэслэн Үнэт цаас гаргагч тогтоосон болно.

Иймд үнэлгээний тайлангийн өдрийн байдлаар Үнэлгээчдэд мэдэгдэж байсан мэдээлэл нь IPO санхүүжилтээр татах хөрөнгийн зарцуулалт зөвхөн хувь хэмжээгээр үнэлгээний тайланд орсон болно.

Үнэлгээний тайлангийн 35 дугаар хуудсанд орсон Инновэйшн Инвестмент ХХК-ийн ирэх жилүүдийн эздийн өмчийн дүнд IPO санхүүжилт ороогүй дүн болно.

Энэхүү нэмэлт мэдээлэл бэлдсэн өдрийн байдлаар IPO санхүүжилтын дүн тодорхой болсон тул дараах мэдээллийг хүргүүлж байна. Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүрийн 225 төгрөгийн үнэтэй 36,977,618 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 8,319,964,050 төгрөгийг татан төвлөрүүлнэ. Тус дүн нь нийт IPO санхүүжилтийн дүн ба 25 хувь нь одоо байгаа хувьцаа эзэмшигчийн төлбөрт, 75 хувь нь шинээр гаргаж буй энгийн хувьцааны санхүүжилт буюу эздийн өмчийг нэмэгдүүлэх дүн байхаар байна. Тодруулбал, Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох ККТТ ХХК-ийн эзэмшиж буй 25% буюу 9,244,458 ширхэг энгийн хувьцааг нийт 2,080,003,050 төгрөгийг хувьцааны төлбөрт шилжүүлэх бол нэмж гаргах 27,733,160 ширхэг энгийн хувьцааг арилжаалж татан төвлөрүүлэх 6,239,961,000 төгрөг нь эздийн өмчийг нэмэгдүүлэхээр байна.

Үнэт цаас гаргагчийн ирэх жилүүдийн эздийн өмчийг IPO санхүүжилт орж ирэхээс өмнөх болон орж ирсний дараах байдлаар доор үзүүлэв.

| | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|
| Эздийн өмч, Pre money | 6,169.2 | 10,161.4 | 18,017.2 | 28,596.0 | 40,984.9 | 54,679.3 |
| New money | | 6,240.0 | | | | |
| Эздийн өмч, Post money | | 16,401.4 | 24,257.2 | 34,836.0 | 47,224.90 | 60,919.3 |

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХХК
INNOVATION INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
1117242908 ☎ 6183948



000298

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

## 2. МӨНГӨН ЗАРЦУУЛАЛТЫН НӨЛӨӨЛЛИЙГ ЖИЛ БҮРЭЭР, ТАЙЛБАРТАЙГААР ТУСГАХ

Үнэт цаас гаргагчийн IPO санхүүжилтын зарцуулалтын мэдээллийг доор үзүүлэв.

Үнэт цаас гаргагчийн нэмж гаргасан 27,733,160 ширхэг энгийн хувьцааг арилжаалж татан төвлөрүүлсэн дүн болох 6,239,961,000 төгрөгийг компанийн үйл ажиллагаанд зарцуулж, Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний 100 хувийн эзэмшлийн охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг хувьцааг арилжаалж татан төвлөрүүлсэн 2,080,003,050 төгрөгийг "ККТТ" ХХК-д хувьцааны төлбөрт шилжүүлэхээр тогтоосон байна.

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч, түүний охин компанийн үйл ажиллагаа, тэлэлт, техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтын зорилгоор дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.

### 1. Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт

Үнэт цаас гаргагч нь дотоодын зах зээлд олон улсын төлбөрийн түншүүдийг бий болгож, Монгол Улсад төлбөрийн олон нэмэлт урсгалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд, дэлхийд үйл ажиллагаа явуулдаг томоохон онлайн худалдаа, үйлчилгээний платформуудын төлбөрийг хүлээн авдаг дэд бүтцийг бий болгоно.

Төлбөрийн зах зээлийн хүрээнд QR, иргэд-мерчант хоорондын цахим төлбөр тооцоог үргэлжлүүлэн гүйцэтгэж, үйлчилгээний модулиудын төрлийг нэмэгдүүлэхээс гадна B2B төлбөр тооцоо, бага дүнтэй гүйлгээний систем зэрэг шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байна (Жишээ нь: BPay үйлчилгээ).

Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 22.5 хувийг бэлэн бус төлбөр тооцооны зах зээл дэх үндсэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зарцуулахаар төлөвлөв.

Хөрөнгө оруулалт хийх ерөнхий бизнесүүдийг нарийвчлан үзвэл:

#### 1.1 B2B төлбөр тооцоо

Дотоодын зах зээлд бизнесийн байгууллагуудын бага дүнтэй худалдан авалт төлбөрийн картаар, өндөр болон сар бүрийн тогтмол төлбөрүүд ихэвчлэн Банкны бага дүнд, их дүнтэй гүйлгээний системээр нэхэмжлэхэд суурилсан хэлбэртэйгээр явж байна. Бидний хувьд цахим орчинд бизнесийн байгууллагууд B2B төлбөр төлөх боломжийг нэвтрүүлэхийг зорьж байгаа юм. Ингэснээр ААН-үүд өөрсдийн ашигладаг банкны онлайн сувгаар цаг алдалгүй, нэхэмжлэх, ибаримт шивэлт хүлээлгүй төлбөр төлөх боломж бүрдэх юм. Энэхүү гүйлгээнээс мерчант буюу үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас шимтгэлийн орлого олох шинэ боломж бий болох юм.

#### 1.2. BPay үйлчилгээ

Монгол улсад биллингийн нэгдсэн санг үүсгэх, нэхэмжлэх суурьтай сар бүрийн хэрэглээний төлбөрийн төлөлт, хэрэглээний мониторинг, хэрэглэгч үйлчилгээг холбосон коджуулалтыг хийх



000791

боломжтой цогц биллинг үйлчилгээг бий болгож СӨХ, контор, улсын биллер байгууллага, хувийн ААН-үүдтэй хамтран ажиллана.

### 1.3. QPay QR үйлчилгээний тэлэлт

Хөдөө, орон нутагт QPay үйлчилгээний борлуулалтыг идэвхижүүлэх, QPay системээр дамждаг олон улсын UnionPay, WeChat (удахгүй AliPay) үйлчилгээнүүдийн мерчант борлуулалтыг улс даяар нэмэгдүүлэх. Мөн QPay sign буюу QPay-р ЭНД ТӨЛЖ БОЛНО гэсэн тэмдэглэгээнүүдийн өнцөг булан бүрт наалгах ажлыг эхлүүлэх.

### 1.4. Шинэ төлбөрийн функцууд

Монгол улсын бусад бэлэн бус төлбөрийн хэрэгсэл буюу картын төлбөр, тооцооны хэрэгсэлтэй өрсөлдөх үүднээс IoT-д суурилсан төлбөрийн системийг нэвтрүүлэх зорилготой ажиллаж байгаа болно. Энэхүү бизнес нь төхөөрөмжид суурилсан тул тодорхой хэмжээний R&D, нэмэлт хөгжүүлэлт, төхөөрөмжийн хөрөнгө оруулалт шаардах юм.

## 2. Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь дунд болон урт хугацааны үндсэн стратегийнхаа хүрээнд болон Монгол Улс дахь TechFin болон FinTech салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж буй компани, бизнесийн төслүүдэд өөрийн шалгуур болон хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулж, тус бизнесийн үр ашгаас ашиг хүртэх, үйл ажиллагааг нь өргөжүүлж, бизнесийн синержиг дэмжих байдлаар ажиллахаар төлөвлөж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд зах зээлийн чиг хандлага, Монгол Улсын бизнесийн орчинд үндэслэн дижитал шилжилт шаардлагатай технологийн салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалтыг зохистойгоор оруулж ажиллана.

Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 30.0 хувийг хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд шинэ компани, төсөл хөтөлбөр, бүтээгдэхүүн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийхэд зарцуулах ба хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай магадлан шинжилгээг хийж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээр хойш 2-3 жилийн дотор тухайн хөрөнгө оруулалтуудаа хийхээр төлөвлөж байна.

## 3. Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь сервер, тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэл хийж олон улсын стандартын дагуу өндөр түвшний найдвартай ажиллагааг (High Availability) бүрэн хангана. Өөрөөр хэлбэл төлбөр тооцооны системийн найдвартай байдлыг 99.99 хувьд хүргэнэ. Мөн гадны кибер халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хамгаалалтын тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагаагаа сайжруулна. Ингэснээр дэд бүтцийн хувьд олон улсын төлбөр тооцооны системүүдтэй интеграц хийгдэх, тэдний бүрдэл хэсэг болж ажиллах боломжийг бүрдүүлнэ.
Иймд, Үнэт цаас гаргагч нь нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 15.0 хувийг дараагийн 2 жилд группийн техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулахад зарцуулна.

**4. Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах**

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн мэдээллийн технологи, бизнесийн дэд бүтцийг олон улсад гаргах, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. Иймд, татан төвлөрүүлэх хөрөнгийн 7.5 хувийг ирээдүйн чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, тэдгээрийн менежментийн ур чадварыг сайжруулахад зарцуулахаар төлөвлөж байна.

**5. "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй энгийн хувьцааны төлбөр**

Үнэт цаас гаргагчийн охин компани болох "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг хувьцааг арилжаалж, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25 хувийг хувьцааны төлбөрт шилжүүлэхээр тогтоосон байна.

Дээрх төлөвлөгөөний дагуу Үнэт цаас гаргагч нь IPO санхүүжилтын төлөвлөгөөг дараах байдлаар тооцоолж байна.

| № | Хөрөнгө оруулалтын зориулалт | Татан төвлөрүүлэх мөнгөн дүн | Зарцуулалтын хуваарь |
|---|---|---|---|
| 1 | Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт | 1,871,991,911 | 2023 - 2026 он |
| 2 | Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа | 2,495,989,215 | 2023 - 2026 он |
| 3 | Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа | 1,247,994,608 | 2023 - 2025 он |
| 4 | "ККТТ" ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр | 2,080,003,050 | 2023 он |
| 5 | Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах | 623,985,266 | 2023 - 2026 он |
| | **НИЙТ** | **8,319,964,050** | |

Энэхүү мөнгөн зарцуулалтын төлөвлөгөө нь Эздийн Өмчийн Чөлөөт Мөнгөн Урсгалын Загвараар тооцсон үнэлгээний үр дүнд дараах үндэслэлээр материаллаг нөлөө үзүүлэхгүй болно.

1. IPO хөрөнгө оруулалтын санхүүжилт нь Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний дагуу зарцуулагдах тул компанийн цэвэр мөнгөн урсгалд нөлөө үзүүлэхгүй,
2. IPO хөрөнгө оруулалтын санхүүжилтын зарцуулалт нь цаг хугацааны хувьд тухайн үеийн бизнесийн болон зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж 2023 оноос эхлэн зарцуулагдах боломжтой тул мөнгөн хөрөнгийг өөр хөрөнгө оруулалт хийж өгөөж олох



000293

хувилбарыг нэмэлтээр авч тооцоогүй бөгөөд энэ нь үнэлгээний ажлын зорилгод нийцтэй гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

## 3. ДЭЭРХ ӨӨРЧЛӨЛТИЙГ, МӨН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ИРҮҮЛСЭН НЭМЭЛТ ТАЙЛБАР, ТОДРУУЛГЫГ БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТУСГАХ

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн "Үнэлгээний ажлын нэмэлт тайлбар, тодруулга болон энэхүү Үнэлгээний ажлын нэмэлт тайлбар, тодруулга 2 нь 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн Инновэйшн Инвестмент ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг тус компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар боловсруулсан үнэлгээний тайлангийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.